



хайрт бошиглогч минь



PENCERELER
YAYINEVI

Prof. Dr. RAMAZAN AYVALLI

Çınar Matbaacılık.
Yuzyıl Mah. Matbaacılar Cad. Atahan No: 34
Kat: 5 Bağcılar - ISTANBUL - TURKEY
Tel: 0212 628 96 00

Доктор профессор Рамазан Айвалли

**Хоёр ертөнцийн гэгээ болсон
МУХАММЕД -ЫН (Алейхиссалам)
АМЬДРАЛЫН
ЗАМНАЛ**

Улаанбаатар хот. 2021 он

Доктор пропессор Рамазан Айвалли
Орчуулсан: Одхүүгийн.Ерболат
“Мармара” их сургуулийн шашин судлалын дацан
Турк улс Истанбул хот

“Хакикат” хэвлэлийн газрын зөвшөөрөлгүйгээр дахин хэвлэх,
электрон хэлбэрээр хуулбарлахыг хориглоно.

Хэвлэлийн хуудас: 25 х/х
Хэвлэсэн тоо: 5000 ш
Цаасны хэмжээ: А5

“КИТАБ” ХХК-д хэвлэв.
Улаанбаатар 2011 он

ОРШИЛ

Аллах эзэндээ талархан мөн бидэнд хайрласан хэмжээлшгүй их буян заяанд нь баярлан өchie... Түүний хайрт элч, хүн төрөлхтөний хамгийн дээд, хамгийн сайн нь болох Мухаммед алейхиссальламд мөн түүний гэгээн царайг харсанаар бүхий л хүмүүсийн дээд нь болсон Асхабуудад цөмд нь мөн тэднийг дагагсадад залбирал ба мэнд хүргэе...

Түүхэн “Жахил үе” ба харанхуй бүдүүлэг үе гэх нэгэн үе бий. Энэ үед Араб нутгийнхан цөм гараараа үйлдсэн шавар бурхадад мөргөн залбирч адгийн муу муухай үйлдэл архи, дарс, мөрийтэй тоглоом газар авч, хүчтэйчүүд нь хүчгүй ядуусаа нохойноос доор үзэж, эмс охидод үнэ цэн гэж үгүй болж тэднийг нэгэн бараа таваар адил худалдан солилцож, охидоо амьдаар нь газар булж байлаа. Зөвхөн Араб нутагд ч биш бүхий л дэлхийг ийм харанхуй бүдүүлэг нүүрэлсэн цөвүүн цаг байв. Мэдээж энэ бүхнийг үзэн ядсан эсэргүүцсэн ухаант хүмүүс бага ч атугай байсан. Тэд энэ муу муухайг алга болгохын тулд Аллах эзэнд залбирдаг байв.

Хүн төрөлхтөний энэ өрөвдөлтөй байдалыг харсан Аллах эзэн өөр өөр цаг үед өөр өөр отог аймагуудад олон пайгамбар, элч нараа илгээж байсанчлан сүүлчийн элч болох гэгээн Мухаммедыг ч (салаллаху алейхи уа сальлам) мөн энэ хар сүүдэрийг үлдэн хөөж гэрэл гэгээг хүмүүст бэлэглүүлэхээр илгээжээ.

Аллахын хайр ивээлээрээ бидэнд түүний (элчийн) үммет (дагалдагсад) болох хувь заяаг олгожээ. Түүнд (салаллаху алейхи уа сальлам) итгэн даган сүсэглэх хэрэгтэй болохыг ил тодоор харуулжээ. Аллах эзэндээ энэ буян хишигийн төлөө хичнээн баярлан талархсан ч багадаа биз.

Эхли сүннет эрдэмтэд ийн айлджээ:

“Бүх элчүүд өөрийн цаг хугацаандаа, өөрийн нутаг орондоо, өөрийн ард түмэндээ бүхнээс хамгийн дээд юм. Харин Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) бүхий л хугацаанд бүхий л улс оронд, өөрөөр хэлбэл, хорвоо дэлхий туурьвагдсан цагаас эхлэн киямет (дахин амилах өдөр) хүртэл ирсэн мөн ирэх бүхий л хүн төрөлхтөнөөс бүх талаараа эрхэм хамгийн дээд нь юм. Хэн ч юугаараа ч түүнээс илүү байж чадаагүй юм.”

Аллах эзэн юуг ч туурвиагүй байхдаа Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) ариун туяаг тууриджээ. Куран Керим сударт элчид хандан: “Бид чамайг хорвоо ертөнцөд энэрэл болгон илгээлээ” хэмээн айлджээ. Хадис-и Кудси (утга нь Аллахаас, үг нь Пайгамбараас болсон арин үгс)-д “Хэрвээ чи байгаагүйсэн бол, чи байгаагүйсэн бол бүхнийг тууривахгүй байлаа” хэмээжээ.

Иман (итгэл үнэмшлийн) гол шаардлага нь - Хубб-и Филлах вэ Бугд-и Филлах, өөрөөр хэлбэл, Аллахын үнэнч боолуудыг хайрлаж, дайсануудыг нь үл хайрлах явдал юм. Ийм итгэл үнэмшилгүй бол ямар ч мөргөл залбирал хүлээн зөвшөөрөгдөхгүй юм. Тиймээс хорвоогийн эрхэм ноёныг чин сэтгэлээсээ хайрлах нь үүрэг болж, мөн түүний ариун хайрыг зүрхэндээ хоногшуулж, түүний сайхан зан авираар занших нь захирагджээ.

Энэ хайрыг үргэлжлүүлэхийн тулд хэдэн зууны өмнөөс элчийн ариун амьдрал, замналыг харуулсан олон тооны ном бичигдсэн юм, бичигдсээр ч байгаа. Түүнийг гэх хайр зүрхэнд маань дүүрэн булиглуулахын тулд Эхл-и сүннетиин (мусульманчуудын 73 бүлгийн зөв зам) эрдэмтэдийн номуудыг сайтаар судлаж шинжилсэний үндсэн дээр хорвоогийн энэрэл болсон Аллахын элчийн (салаллаху алейхи уа сальлам) амьдралын замнал, түүхийг бичихийг оролдлоо.

Аллах эзэн маань бид бүхний зүрхийг элч Мухаммедын (салаллаху алейхи уа сальлам) хайраар дүүргэж, биднийг Эхли сүннет эрдэмтэдийн заасан зөв замаар замнуулаг. Амин!

*Доктор профессор
Рамазан Айвалли*

ХОЁР ЕРТӨНЦИЙН ГЭГЭЭ БОЛСОН АГУА МУХАММЕДИЙН АМЬДРАЛ ЭЛЧИЙН АРИУН ТУЯА

Мухаммед (саллаллаху алейхи уа сальлам): Аугаа Аллахын хайр, энэрэл болсон энэ хүн бол бүх хүн төрлөхтний хийгэд бүхий л бий бологсодын дээд нь билээ. Аллахын магтаж сайшаасан бас хүн төрөлхтөн ба жинүүдэд (буг) элч болгон илгээсэн, сүүлчийн болоод хамгийн дээд элч мөн билээ. Тэрбээр хорвоо ертөнцийн энэрэл болон илгээгдхийн сацуу бүхий л зүйлс тэрний элбэрлийн төлөө туурвигджээ. Түүний алдар нэр нь хэмжээлшгүйгээр магтан сайшаагдсан гэсэн утагтай Мухаммед гэсэн үг юм. Басхүү Ахмед, Махмуд, Мустафа гэсэн нэрүүд ч бас түүнийх. 571 оны раббиул эввэл (4-р)сарын 12 ны даваа гаригынн үүрээр Мекке-и Мүкерремре хотод мэндэлсэн.

Түүнийг ертөнцөд мэндэлхээс хэдэн сарын өмнө эцэг нь Абдулла, 6 настайд нь эх нь Амина нас нөгчсөн юм. Тиймээс ч Пайгамбарыг (элч) маань (салаллаху алейхи уа сальлам) “Дүрри етим” (хорвоогийн хэвлий дэх хамгаас үзэсгэлэнтэй сүвд) хэмээн нэрийджээ. 8 нас хүртлээ өвөө нь болох Абдулмутталибын асрамжинд хүмүүжиж, түүнийг нас барсны дараагаар авга ах нь болох Абу Талиб халамжлагч нь болов. 25 настайдаа Хадижетүл Кубра эхтэй гэр бүл болжээ. Энэ эхнэрээс нь төрсөн ууган хүүг нь Касим гэдэг байв. Арабууд хүний нэрийг ууган хүүгийнх нь эцэг гэх нэрээр нэрийддэг ёс заншилтай билээ. Тийм учираас Пайгамбарыг маань “Абу-л Касим” буюу “Касимын эцэг” гэдэг байлаа.

Аллах түүнийг 40 настайд нь хүмүүн төрлөхтөн ба жин(буг)-үүдэд элч болгон тунхаглжээ. Үүний дараа 3 жил нууцлагдмал байсны эцэст хүмүүсийг исламд нээлттэй уриалан дуудаж эхэлжээ. 52-тойдоо Мираж (Аллахын урилгаар болон ер бусын гайхам ид шидийн хүчээр 7 давхар тэнгэр огторгуй ба түүний чанд дахь олон ертөнцөөр аялсан шөнө)гарчээ. 622 онд буюу 53 настайдаа Мекке хотоос Мединерүү нүүжээ. Энэхүү нүүдэлийг хижржэт гэнэ. 27 удаа дайнд оролцож 632 онд таалал төгсжээ.

Аугаа Аллах Тэала бүхий л элчүүдээ нэрээр нь дууддаг байсан атал түүнийг “Хабибим” (хайрт) хэмээн өргөмжилдөг байлаа. Аллах эзэн Куран сударт нэгэнтээ: “Чамайг хорвоо

ертөнцөд хайр, энэрэл болгон илгээлээ”¹ хэмээжээ. Бас нэгэн хадис-и Кудсидээ “Хэрвээ чи байгаагүйсэн бол, чи байгаагүйсэн бол би хорвоо ертөнцийг бүтээхгүй байх байсан юм”² гэжээ.

Бүхий л элчүүд өөр өөрийн цаг хугацаандаа, өөрийн нутагтаа, өөрийн ард түмэндээ бүхий л талаараа эрхэм билээ. Харин манай Пайгамбар Мухаммед (салаллаху алейхи уа сальлам) бол дэлхий туурвигдсан өдрөөс эхлэн сөнөх хүртлэх бүхий л цаг хугацаанд, бүх газар нутагт, өнгөрсөн бас ирээдүй дэх бүхий л зүйлээс буянтай, эрхэм дээд нь билээ. Хэн ч аль ч талаараа түүнээс эрхэм байж чадахуй. Учир нь Аллах түүнийг ийм хүндтэйгээр тууриджээ.

Ариун туяа нь туурвигдахуй

Аллах Тэала бүх зүйлс, ер нь юуг ч туурвихаасаа өмнө бидний элч Мухаммед алейхиссальламын ариун туяаг нь туурвижээ. Тебсир (Кураны тайлбарлал) ба хадис (Мухаммедын сургааль үгс) ухааны эрдэмтэд: “Эгнэшгүй эзэн Аллах өөрийнхөө туяанаас гайхамшигт маш том нэгэн үндэсийг тууриваад тэрхүү үндэснээсээ орчлон ертөнцийг ээлж дараалан бүтээжээ. Бүхий л сүнс ба бодгальсуудын эх болсон үндэс нь энэ юм. Үүнийг “Нури Мухаммед” буюу Мухаммедын туяа гэдэг.

Асхаб кирамын (анхдагч мусульманууд) нэг болох Жабир бин Абдуллах нэгэн өдөр: “Аяа Пайгамбар минь! Аллах эзэн бүхнээс түрүүлж юуг тууригдсан юм бээ?-гэж асуухад нь: “Тэр хамгаас түрүүлж чиний пайгамбар болох миний туяаг өөрийн туяанаас тууригдсан. Тэр үед лавх (хувь заяаны самбар), калем (үзэг), диваажин, там, сахиусан тэнгэрүүд, тэнгэр огторгуй, газар дэлхий, нар, сар, хүн төрөлхтөн ба буг чөтгөрүд ч хүртэл үгүй байсан бөлгөө” хэмээжээ.

Нур-и Мухаммедыг анхны хүн болох Адам алейхиссальламын ариун дүр төрх ба цогцос бүтээгдсний дараагаар түүний хоёр хөмсөгнийх нь хооронд байрлуулжээ. Адам (aleyхиссальлам) амилсныхаа дараагаар магнай дээр нь гэрэлт од мэт гэрэлтэх нэгэн туяа буйг мэдэрчээ.

Адам алейхисальлам амилахдаа Аллах түүнийг Эбу Мухаммед буюу Мухаммедын эцэг хэмээн нэрийдснийг нь

1 эл-Энбияа 107.

2 Сүюүто, эл-Леалил-Мануса I,272: Аслуно, Кешфи-л Хафа,II,164:Али эл-Каро, Шерху ш-Шифа I,6.

зүрх сэтэглээрээ мэдэрч: "Аяа эзэн минь! Намайг яагаад Эбу Мухаммед гэж нэрэлсэн юм бэ?" хэмээн асуухад нь Аллах Тэала: "Хее, Адам, толгойгоо өргө" гэв. Адам толгойгоо өргөн мэлмийгээ нээвээс тэнгэрт туяагаар бичигдэн, гэрэл цацруулан буй Ахмед гэсэн нэрийг олж харав. Тэгээд: "Аяа, Эзэн минь, энэ хэний нэр бэ?" гэж асуулаа. Аллах: "Энэ бол чиний үр удмаас төрөх нэгэн элч билээ. Тэрний нэр алдар нь тэнгэр огторгуйд Ахмед, газар дэлхийд Мухаммед байх болно. Хэрвээ тэр байгаагүйсэн бол чамайг бас хорвоо ертөнцийг туурвихгүй байх байлаа"³ хэмээжээ.

Магнай дахь туяа ариун удам угсаагаар дамжин ирэх нь

Адам (алейхиссальлам) эцэг туурвигдахад магнайд нь энэрэлийн элч Мухаммедын (салаллаху алейхи уа сальлам) ариун туяа заяагдан гэрэлтэж эхэлсэн билээ. Куран сударт айлдсанчилан Адамаас эхлээд цэвэр ариун удам угсааны эцэг, эхүүдээр дамжин Пайгамберд (элч Мухаммед) иржээ. Энэ тухай Аллах Тэала Кураны нэг аетэд (өгүүлбэр) ийнхүү айлджээ: "Чи, өөрөөр хэлбэл, чиний туяа дандаа сажде(газар мөргөх) үйлдэгсэдэд тээгдсээр чамд хүрсэн билээ"⁴

Хадис-и шерифт (Мухаммедын сургааль үг): «Аллах эзэн хүн төрөлхтнийг тууригдсан. Харин намайг хүмүүсийн хамгийн ариун удам угсаагаар дамжуулсан. Дараа нь энэ удам угсаануудын хамгийн сайныг нь (араб болгон) төлөөлүүлсэн. Намайг ч эднээр дамжуулсан, дараа нь гэр бүлүүдээс сайныг нь сонгон, намайг тэр гэр бүлээс гаргасан. Тийм болхоор миний сүнс, бие маань бүхнээс хамгийн ариун нь юм. Миний өвөг дээдсүүд бол өнгрөгч үеийн хамгийн ариун хүмүүс билээ" хэмээн айлджээ.

Бас нэгэн хадист: «Аугаа Аллах бүх зүйлийг огт үгүйгээс бүтээн тууригдсан. Энэ бүхнээс хүсүүсийг илүүд хайралсан, бас алдаршуулсан. Хүмүүсийн дотороос ч сонгосонуудаа арабт нутагшуулсан. Араб дахь сонгогдсон хүмүүсээс ч намайг сонгон, намайг бүхий л цаг хугацааны сонгогдсон ариун хүмүүсийн дундаас гаргасан болхоор намайг хүндэлдэг хүмүүсийг хайрлах нь намайг хайралсан мэт, тэдний дайсан бологсод ч надад

3 Ибн Асвир, Тариху Димашик VII, 437: Хайсемо, Межмагу 3-Зевад VIII, 198.

4 Эш-Шугра 26/219.

дайсагнасан мэт болно” гэжээ.

Анхны хүн болох Адамын (алеихиссальлам) биед Мухаммедийн (салаллаху алейхи уа сальлам) үндэс нь байсан болхоор түүний магнай дээр Мухаммедийн туяа гэрэлтэн байсан. Уг үндэс нь Хавва (анхны эмэгтэй) эхэд, түүнээс Шитэд (Адамын дараах пайгамбар) өргөгдсөн гэх мэтчлэн ариун эрчүүдээс ариун эмэгтэйчүүдэд, ариун эмэгтэйчүүдээс ариун эрчүүдэд өгөгдөн дамжсаар байжээ. Мухаммед(а.с)-ын туяа энэ үндэстэйгээ хамтаар өврөөс өвөр дамжисаар Мухаммедэд (салаллаху алейхи уа сальлам) хүрчээ.

Адам (алеихиссальлам) таалал төгсгийнхөө өмнө хүү Шитдээ: «Миний хүү, энэ магнай дээр чинь гэрэлтэх туяа бол сүүлчийн элч болох Мухаммедийн туяа юм шүү. Энэнийг мумин (итгэл үнэмшилт) бас ёс суртхуунт, цэвэр ариун явдалт эмэгтэйд өгөөрэй, хүүдээ ч гэсэн энхүү гэрээслэлийг хэлээрэй” гэжээ. Мухаммед элчид (салаллаху алейхи уа сальлам) ирэх хүртэл бүх эцэгүүд хүүдээ энэ гэрээслэлийг хэлсэн гэдэг. Бүгдээрээ энэ гэрээслэлийг аминчлан биелүүлж хамгаас цэвэр ариун журамтай эмэгтэйчүүдтэй гэрэлснээр энэ туяа цэвэр ариунаараа олгогдох эзэндээ хүрчээ. Бүхий л хугацаанд Мухаммедийн өвөг болох хүнийг түүний нүүрэн дээрхи туяанаас мэддэг ба тэр хүний гаралтай отог овог нь бусдаасаа илүү дээд илүү цэвэр ариун нь байдаг байлаа.

Элч Мухаммед (салаллаху алейхи уа сальлам) нэгэнтээ:”Миний өвөг дээдэс хэзээ ч шалиг завхай явдал үйлдэж байгаагүй. Аллах намайг цэвэр ариун аавуудаас, ариун журамт эхүүдээр дамжуулан ертөнцөд илгээсэн билээ. Хэрэв өвөг дээдсийн маань 2 хүү байсансан бол би тэр хоёрын хамгийн сайнаас нь гарсан” гэжээ.

Адамаас (алеихиссальлам) нааш үрээс үрд дамжсан энэхүү туяа Тарухд, тэрнээс хүү Ибрахим алейхисальламд, түүнээс хүү Исмайл алейхиссальламд өгөгджээ. Тэрний магнай дахь нар адил гэрэлтэх туяа хүү Аднанд, тэрнээс Мзадад, тэрнээс Низард бэлэглэгджээ. Низарыг мэндэлхэд аав Мзад нь хүүгийнхээ магнайд гэрэлийн туяаг харсан даруйдаа маш нижгэр найр хийж “Миний хүүгийн төлөөх энэ найр бол өчүүхэн зүйл” хэмээн баярлан өгүүлсэнд хүүг нь Низар буюу өчүүхэн зүйл хэмээн нэрэлжээ. Үүнээс хойш энэ туяа үр удам дамжин явсаар жинхэнэ эзэн нь болох Мухаммедэд (салаллаху алейхи

уа сальлам) хүрчээ.

Пайгамбарын маань (салаллаху алейхи уа сальлам) хүндэт өвөг дээдсийн нэр алдар нь ийн бөлгөө: Мухаммед (алейхиссальлам), Абдулла, Абдулмутталиб, Хашим, Абду Менаф (Мүгирэ), Кусай (Зайд), Килаб, Мүррэ, Каб, Лүай, Галиб, Фихр, Малик, Надр, Кинане, Хузейма, Мүдрике (Амир), Илияс, Мудар, Низар, Мэад, Аднан.

Эрхэм элч (салаллаху алейхи уа сальлам) нэгэнтээ: "Би бол Абдулла, Абдулмутталиб, Хашим, Абду Менаф, Кусай, Килаб, Мүррэ, Каб, Лүай, Галиб, Фихр, Малик, Надир, Кинане, Хузейма, Мүдрике, Илияс, Мудар, Низар, Мэад, Аднаны хүү Мухаммед билээ. Дурдсан өвөг дээдсүүд маань хэрвээ хоёр хуваагдсан бол Аллах намайг тэдний хамгийн сайнуудаас нь гаргах байсан ..." ⁵ хэмээжээ.

Бас нэгэн хадист (ариун сургааль): «Аллах эзэн Ибрахимын хөвгүүдээс Исмайлыг сонгосон. Исмайлын хөвгүүдээс Кинанег сонгосон. Кинанегийн хөвгүүдээс Курэйшийг сонгосон. Курэйш овогос Хашим хөвгүүдийг сонгосон. Хашим хөвгүүдээс Абдулмутталибыг сонгосон. Абдулмутталибын хөвгүүдээс намайг сонгосон» ⁶ хэмээн айлджээ.

Хазрети (гэгээн) Абдулмутталиб өвөө

Эрхэм пайгамбар (салаллаху алейхи уа сальлам) Курэйш овогийн Хашим хөвгүүд овогийн хүн юм. Эцэг нь Абдулла, түүний эцэг нь Шэйбе юм. Мухаммедийн (салаллаху алейхи уа сальлам) өвөө Шэйбе нь Медине хотод төржээ. Шэйбегийн эцэг Хашим нас барихад тэр хүүхэд байлаа. Нэгэн өдөр Шэйбе хүү авга ах нарынхаа гэрийн өмнө хүүхдүүдтэй сум харваж тоглож байлаа. Тэдний тоглохыг нь ажиглаж суусан өвгөд хөгшид Шэйбе хүүгийн магнайд гэрэлтэх туяаг хараад тэрнийг нэр хүндтэй хүн болохыг гадарлаж байлаа. Нум харвах ээлж Шэйбед ирхэд түүний харвасан сум нь байныхаа голд нь онов. Шэйбе ч баярлан: "Би Хашимын хүү юм чинь мэдээж миний сум ононо" гэж дуу алдахыг нь сонссон өвгөд Мекке дахь Хашимын хүү болохыг ойлгожээ. Хашим тэр үед нас барсан байлаа. Абдуменаф хүү нарын нэг Меккед буцаж ирэхдээ Мутталибд: "Медине хотод байгаа авга дүү Шэйбе чинь маш ухаалаг нэгэн, бас тэрний магнай дээр

5 Ибн Сагд, эт-Табакет I, 55-56.

6 Ибн Сагд, эт-Табакет I, 20.

бусдыг гайхшруулсан нэг туяа цацран байна. Ийм нэг хүүхдийг хажуунаасаа холдуулах чинь болож байгаа юм уу?” гэжээ. Үүнийг сонссон Мутталиб даруй Медине рүү очиж Шэйбег аваад бууцжээ. Меккегийн гудамжинд таарсан хүмүүс “Энэ хүү хэн бэ?” гэж асуухад нь: “Энэ бол миний боол” гэж хариулдаг байлаа. Энэ өдрөөс хойш Шэйбегийн нэр Мутталибын боол гэсэн утагтай Абдулмутталиб болон үлджээ⁷.

Абдулмутталиб авга ах Мутталибыгаа нас бартал түүний асрамжинд байв. Абдулмутталибын биенээс анхилуун үнэр сэнгэнэж, магнай дээр нь Аллахын элч Мухаммедийн (салаллаху алейхи уа сальлам) туяа гэрэлтэн эгнэшгүй хайр, буян хишгийн дунд умбан байлаа. Хэзээ л Мекке хотод бороогүй ган болохын цагт хүмүүс Абдулмутталибын гараас нь хөтлөн Савр ууланд очин Аллахаас хур гуйн залбирахыг хүсдэг байлаа. Аллахын элч Мухаммедийн (салаллаху алейхи уа сальлам) туяа түүнд бий болохоор Аллах Абдулмутталибын хүсэлтийг биелүүлж хур бороогоо хайралдаг байлаа. Ийнхүү Абдулмутталибын нэр алдар өдрөөс өдөрт өсөн дэвжиж Мекке хотынхон тэрнийг тэргүүнээрээ сонгожээ. Тухайн үеийн хаан нь хүртэл Абдулмутталибыг шударга нэгэн болохыг нь хүлээн зөвшөөрдөг байлаа. Зөвхөн Ираны хаадууд тэрэнд атаархаж дайсагнадаг байлаа. Абдулмутталиб ханиф шашиныг шүтдэг байлаа, өөрөөр хэлвэл, мусульман байсан. Энэ шашин бол Ибрахим элчийн түгээсэн үнэн шашин байлаа. Тийм учираас хэзээ ч хүний гараар бүтээгдсэн шавар бурхадад сүсэглэж байсангүй. Зөвхөн ариун Каабын өмнө Аллах эзэнд залбирч сүсэглэн бишэрдэг байв.

Нэгэн шөнө тэрний зүүдэнд нэгэн дуу: “Хөөе, Абдулмутталиб, бос, Таиббег (ариун газар) ух” гээд алга болжээ. Маргааш өдөр нь мөн адил зүүдэнд нь “бос, Беррег (цэвэр газар) ух” гэв. Гурав дахь шөнө ч гэсэн нөгөө хүн ирж “бос Маднунааг ух” гэж тушаажээ.

Учир битүүлэг энэ зүүдээ тайлж эс чадсан тул дөрөв дэхь өдөр зүүдэнд нь нөгөө хүн дахин ирж: “Хөөе, Абдулмутталиб, бос, Земзем худагыг ух” гэхэд “Земзем гэж юу вэ?” гэж асуув. Тэр хүн: «Земзем бол хэзээ ч дундрашгүй, хэзээ ч ширгэшгүй ус юм. Дэлхийн 4 өнцөгөөс ирсэн хажууд энэ уснаас ханаж цадатлаа ундаалдаг, Жабрайл (сахиусан тэнгэр) далавчаараа цохин ундаргасан, Аллахын Исмайл пайгамбарын (алейхисальлам) төлөө гаргасан ус юм. Энэ худагны нүд нь тахил өргөгсөд

тахилынхаа илүүдэл хог хаягдлаа хаядаг тэр газар бий. Чамайг тэр газар очихын цагт улаан далавчтай нэгэн хон хэрээ газар ухаж эхэлнэ. Түүний хажууд шоргоолжны үүр үзэгднэ. Тэр үүр л земзем худаг мөн”⁸ гэжээ.

Абдулмутталиб эртлэн босоод Харис хүүгээ дагуулан Каабын (ариун сүм) зүг очин сэтгэл догдлон хүлээж эхлэв. Гэнэт хаа нэгтэйгээс зүүдэнд нь хэлсэнчилэн нэгэн улаан далавчит хон хэрээ нисэн ирж, хошуугаараа газар ухаж эхлэв. Тэр доороос нь шоргоолжны үүр гарах нь тэр. Абдулмутталиб ч хүүтэйгээ цуг даруйхан тэр газарыг ухаж эхлэв. Хэсэг ухсаны дараа худагны амсар үзэгдэхэд Абдулмутталиб баярласандаа “Аллаху акбар, Аллаху акбар (Аллах агуу хүчит)” гэж дуу алдаж эхлэв.

Тэдний худаг малтах үйлийг эхнээс нь ажиж зогссон Курайш овгийнхоны нэг нь: «Хөөе, Абдулмутталиб, энэ манай өвөг болох Исмайл пайгамбарын худаг байна. Энэнийг ухах нь зөвхөн чиний ч биш бидний ч гэсэн үүрэг тиймээс бид ч бас малтацгай” гэв. Абдулмутталиб үүнийг эсэргүүцэн: “Үгүй энэ ажилыг зөвхөн надад даалгасан болхоор миний үүрэг” гэж хариулахад нь арабууд Абдулмутталиб руу дайрч, давшилж эхлэв. Абдулмутталиб ганцаардаж байгаага тэр үед ойлгон алгаа дэлгэн: “Аяа, эзэн минь! Надад 10 хүү хайрлаач. Хэрвээ чи миний энэ хүсэлтийг минь биелүүлвэл би тэднээс нэгийг нь ариун Каабд тахил болгон өргөө”⁹ гэж залбирчээ.

Абдулмутталиб энэ маргалдааны эцэс маш том зодоон, дайсагналын эх үүсвэр болож болохыг ухааран тэдэнтэй хэлэлцээр хийхийг оролдов. Энэ асуудлыг шүүхээр шийдүүлэх хүсэлтэй байгаагаа өчив. Сүүлдээ Шам хот дахь нэгэн мэргэн хүн л энэ асуудлыг нэг тийш нь болгон шийдэж чадна гэгцгээнэ. Курейш овгийнхноос нэг бүлэг хүмүүс Шам хотыг зорин замд гарцгаав. Тэр үеэр нар маш халуунаар шарж, тэд бүх усаа барсан тул хатаж үхэх аюулд хүрэв. Ганц хүсэл нь ус олж уух байлаа. Гэвч зах хязгааргүй энэ их элсэн цөлийн хаанаас ус олох билээ...

Бүх хүмүүс итгэлээ алдан үхлээ хүлээж байхуйд гэнэт Абдулмутталиб: “Хөөе, хүмүүсээ, нааш ирцгээ, нааш ирцгээ. Та нарт бас та нарын унаа хөсөгт ч хүрэлцэх ус оллоо” хэмээн хашгирав. Гэгээн Мухаммедийн (салаллаху алейхи уа сальлам)

8 Ибн Исхак, Эс-Соре,с, I, 144-145: Ибн Хишам Эс-Соре I, 143: Ибн Сагд, эт-Табакет I, 83-84.

9 Ибн Хишум Эс-СореI, 144-145: Ибн Сагд, эт-Табакет I, 88.

туяааг өөртөө тээж буй Абдулмутталиб ус хайж явах үед түүний тэмээний хөл дор тээгэлсэн чулууны дороос гэнэт ус ундарч эхлэх нь тэрээ. Хүмүүс гүйдэн ирцгээн тэр уснаас ханаж цадатлаа ууцгаав.

Абдулмутталибын энэхүү гайхам үйлийг үзээд өөрсдийнхөө бусармаг санаанаас ичсэн Курейш овгийнхон: “Аяа, Абдулмутталиб! Үнэндээ биднийх буруу байжээ. Земзем худагийг ухаж гаргахад чи л яг тохирох хүн юм байна. Тиймээс ахиж бид чамд саад болохгүй. Тийм болхоор Шам руу очихын хэрэг юун. Гэр лүүгээ буцацгаая” гэгцгээв. Ийнхүү Абдулмутталиб Земзем худагийг ухаж гаргаснаар эгнэшгүй хүндлэлийг олжээ¹⁰.

Абдуллахаар тахил өргүүлэхийг хүссэн нь

Абдулмутталиб Земзем худагийг ухасныхаа дараагаар маш их нэр хүндтэй болсон байлаа. Аллах эзэн түүний хүү хүсэн залбирсан гуйлтыг нь биелүүлж, түүнд Харисээс гадна 10 хүү 6 охин өгчээ. Хөвгүүдийнх нь нэр: Кусем, Хажл, Мукаввим, Дирар, Зүбэйр, Эбу Талиб, Абдуллах, Хамза, Аббас, Эбу Лахеб нар юм. Охидынх нь нэр: Сафия, Атике, Үммү Хаким, Бейда, Берре, Үмэймэ, Эрва нар юм. Абдулмутталиб хөвгүүдийнхээ дундаас Абдуллах хүүдээ маш их хайртай байлаа. Ягаад гэвэл, магнай дээрхи Мухаммедын (салаллаху алейхи уа сальлам) туяа түүний магнайд гэрэлтэж эхэлсэн байлаа.

Абдулмутталибын зүүдэнд нэгэн удаа “Хөөе, Абдулмутталиб, амалсан амлалтаа биелүүл” гэж хэлжээ. Өглөө босонгуут Абдулмутталиб хуцаар тахил өргөв. Тэр оройн зүүдэнд “энэнээс ч том тахил өргө” гэв. Маргааш нь нэг үхэрээр тахил өргөсөн боловч тэр оройн зүүдэнд нь мөн адил “энэнээс ч том тахил өргө” гэв. Абдулмутталиб “энэнээс ч том юу байх билээ гэж” асуухад нь: “хөвгүүдийнхээ нэгнэр нь тахил өргөнө гэж хэлээгүйсэн билүү? Тэр үгээ гүйцэтгэ” гэжээ. Маргааш өглөө нь Абдулмутталиб бүх хөвгүүдээ цуглуулаад, хэдэн жилийн өмнө Аллахаас хүссэн залбиралаа яриж өгөв. Тийм учираас та нараас хэн нэгнийг нь тахих ёстой болоод байна гэж хэлэв. Хөвгүүдээс нь хэн нь ч дургүйцэж зугтаасангүй, харин ч “Аав минь, хэрвээ амалсан бол биелүүлэх учиртай. Та хүссэнээ хийж болно” гэгцгээв. Абдулмутталиб тэдэн дундаас нэр суглаж хэн нь тахил болохыг

10 Ибн Хишүм Эс-Сопел, 144-145: Ибн Сагд, эт-Табакет.1, 81-88.

нь сонгов. Гэвч энэ сонголтонд Абдулмутталибын хамгаас хайрт хүү Абдуллахын нэр суглагдсан байв. Абдулмутталиб машид цочирдон нүдэнд нь нулимас цийлэгнэв. Хэдийгээр энэнийг хийх хэцүү боловч Аллахын зарилгийг биелүүлэх л ёстой байлаа. Нэг гартаа хутга, нөгөө гартаа хайрт хүү Абдуллахаа хөтлөөд Аллахт амалсан амлалтандаа хүрэхийн тулд Кааб руу очив. Аав нь уйлан хайлан байж Абдуллахыг тахиx бэлтгэлээ дууслаа.

Энэ үед Курайш овгийнхон гайхмаар энэ явдалыг нүд салгалгүй алмайран харж байв. Тэдэн дундаас нагац нь “Абдулмутталиб, зогс бид чамайг энэ хүүгээрээ тахил өргөж байгааг хараад зогсож чадахгүй. Хэрвээ чи энэнийг хийх юм бол Курейш овгийнхон бүгдээрээ чиний энэ үйлийг уламжилал болгож аваад хүн бүр хүүгээ тахиж эхлэх болно. Ийм муухай зүйлийн эхлэлийг тавихаа болиооч. Чи Аллахыг өөр нэг зүйлээр баярлуул... Нэг мэргэн хүн бий түүнээс асууя тэр бидэнд нэг зам зааж өгнө” гэв.

Абдулмутталиб ч энэ үгийг хүлээн зөвшөөрч Хайбер хот дахь Кутбе гэгч мэргэн хүнд очиж болсон бүх үйл явдалыг эхнээс нь дуустал тайлбарлан ярив. Мэргэн хүн “танай нутагт нэг хүний үнэ ханш хэд вэ?” гэж асуухад нь: “10 тэмээ” гэв. “Тэгвэл 10 тэмээ ба хүү хоёрынхоо хооронд нэр сугал, хэрвээ хүүгийн чинь нэр гарвал 10 тэмээн дээрээ дахиж тэмээ нэм, ийнхүү суглаад л бай хэзээ л сугалаа тэмээнд гарнав тэр цагт зогсоогоод тэр тэмээнүүдээрээ тахил өргө” гэжээ.

Абдулмутталиб даруйхан Мекке хот руугаа буцаад мэргэн ухаантны хэлсэнчилэн хийж эхлэв. 10 дээр 10 тэмээ нэмэж сугалсаар л байлаа. Сугалаа дандаа Абдуллах гэж гарч байв. Тэмээнүүд 100 хүрэхэд сая нэг суглаа тэмээнд гарав. Абдулмутталиб “Аллаху акбар(Аллах агуу) Аллаху акбар” гэж баярлан 100 тэмээгээр тахил өргөөд бүх махыг нь ядууст тарааж өгөв¹¹.

Адам (алейхиссальам) эцэгээс өдгөө хүртэл Исмайл пайгамбарыг тахиx тухай бас нэгэн үйл явдал байдаг. Мухаммед элч Исмайл алейхиссальамын үр удамаас гаралтай болхоор “би хоёр тахигчын хүү”¹² хэмээн айлдсан байдаг.

11 Ибн Исхак, Эс-Соре,с,10-17: Ибн Хишүм Эс-СореI, 151-154: Ибн Сагд, эт-Табакет I, 88-94.

12 Ибн Исхак, Эс-Соре,с, 10-18: Хүким, эл-Мүстедрак II,604,609: Аклуно, Кешфү-л Хафа I,199,230.

Гэгээн Абдуллах эцэг

Хоёр ертөнцийн хайр энэрэл, гэгээн элч Мухаммедийн (aleyхиссальлам) ариун туяаг магнайд тээсэн Абдуллах хүүг төрөхөд христиан ба жүүдийн шашины эрдэмтэн мэргэд нэг нэгэндээ “ертөнцийн төгсгөл өдрийн элч, сүүлчийн элчийн эцэг нь Мекке хотод мэндэлжээ” гэж ам дамжин яригдаж байлаа.

Израйлд нэгэн ноосоор нэхэгдсэн гоёмсог дээл байлаа. Энэ дээл бол Яхия пайгамбарын (aleyхиссальлам) бусдад хорлогдон нас барах үедээ өмсөж байсан дээл юм. Цусанд будагдсан энэхүү дээлийг Израйлийн ихэс дээдэс хэдэн зуун жилээр хадгалж байгаа билээ. Тэдний судар номонд “хэзээ л энэ дээлний хатсан цус шингэрч дусалж эхэлнэв тэр үед хамгийн сүүлчийн элчийн эцэг хорвоод мэндлэх болно” гэж бичигдсэн байдаг. Тэд энэ цус дуслаж эхэлхийг харангуутаа Абдуллахыг мэндлэснийг хэдийнээ ойлгожээ. Гэвч тэд атаархан хэд хэдэн удаа Абдуллахын амийг бүрлэхийг завдсан болов ч Аллах Абдуллахыг түүний магнай дээрхи туяаны төлөө хамгаалж байлаа.

Абдуллах эрийн цэнд хүрэхийн цагт өнгө төрх, царай зүсээрээ ч бусдыгаа өөртөө татсан сайхан сэтгэлтэй онцгой нэгэн болсон байлаа. Хол ойрын хэн ч болов энэ сайхан залуутай охиноо гэрлүүлэхийн тулд гүйлддэг байлаа. Зөндөө олон ихэс дээдэс Абдулмутталибт ирж хүү Абдуллах тай нь охиноо ураг барилдуулах санал тавьж байлаа. Гэвч Абдулмутталиб аль альныг нь ч хүлээн зөвшөөрсөнгүй.

Абдуллах 18 нас хүрхэд түүний үзэсгэлэнт царай, сайхан сэтгэлийн талаархи цуу яриа тарсан байлаа. Үнэндээ ч тэрбээр бүхнийг өртөө татсан сайхан залуу болжээ. Тэрний магнай дээрх гэрэлтэх туяаг харсан охид, бүсгүйчүүд нүдээ унаган гүйлддэг байлаа. Тэрний нэр алдар нь хаа холын Египет хүртэл цуурайтсан болхоор 100 гаруй охид бүсгүйчүүд Египетээс ирж түүнтэй гэр бүл болох санлыг тавьж байв. Абдулмутталиб хүүдээ тухайн үеийн язгууртан угсааны ариун журамт гэр бүлээс гаралтай царайлаг хийгээд ухаалаг бас Ибрахим (aleyхиссальлам) элчийн шашиныг мөрдөн дагдаг ханеф шашинтай нэгэн бүсгүйг хайж байлаа.

Судар номонд нь дурдагдсан сүүлчийн элч өөрсдийнх нь нутгаас төрөөгүйд атаархсан Израйлчууд Абдуллахыг үгүй хийх төлөвлөгөө зохион 70 зэвсэгт цэрэгийг Мекке хотын зүг хөдөлгөв

тэд ч Мекке хотод ирсэн даруйдаа довтлох боломж хүлээн нэгэн газар нуугдан отож эхлэв. Нэгэн өдөр Абдуллах хотын зайдуу ууланд гархаар явах үед Израйл цэрэгүүд энэ боломжыг ашиглан Абдуллах руу довтлов. Яг энэ үед Абдуллахын хамаатан садан болох Вехиб бин Абду Менафын хамтаар хэдэн залуус ойр хавьд нь ан хийж яваад Абдуллах руу дайрах цэрэгүүдийг үзэн туслахыг завдсан боловч тэд маш бага харин дайсны хүмүүс олон байгааг ойлгон эргэсэн зогсов. Гэнэт илбийн юм шиг гайхмааар зүйл боллоо. Хаа нэгтэйгээс урьд өмнө үзэгдэж байгаагүй энэ хорвоод юутай ч төсөөгүй бараан зүсмийн морь унсан, хоёр сэлэм эргүүлсэн нэлээн хэдэн хүн гэнэт гарч ирэх нь тэр. Тэдний “Аллаху акбар” гэж такбир хэлэх нь уул хадыг цуурайтуулж байлаа. Тэд нүд ирмэх зуур Израйл цэргүүдийг цавчин хөнөгөөд алга болохыг нь хараад мэл гайхан цэл хөхөрсөн Вехиб ба түүний найзууд нь Абдуллахыг хэрхэн хамгаалж буйг бас Аллахын хувьд ямар үнэ цэнтэй хүн болохыг нь ойлгов. Гэртээ ирэнгүүтээ эхнэртээ үзсэн харсан үйл явдлаа нэг нэгэнгүй ярихад хоёулаа Амина охиныхоо нөхөр болож чадах хүн нь Абдуллах болохыг ухаарав. Тэгээд Амина охиноо түүнд өгөхөөр шийдэв.

Абдулмутталиб ч гэсэн Бени Зүхрэ овогийн тэргүүлэгч болох Вехибийн охин Аминааг ариун явдалт, цэвэрч нямбай, үзэсгэлэнт төгснэгэн болохыг дуулсан байлаа. Тиймээс ч Абдуллах хүүтэйгээ цуг Амина охиныг нь гуйхаар очив. Абдулмутталиб Вехибийн охиныг хүүдээ гуйхаар ирэснийг ойлгосон Вехиб “Аяа, Абдулмутталиб минь! Бид дуртайяа зөвшөөрч байна” гэж хэлээд үзсэн гайхамшигтай явдалыг хүүрнэн өгүүлжээ. Бас ийм нэгэн зүйлийг дурдав. “Амина охины ээж нь зүүдэндээ гэрээр нь дүүрэн цацарсан нэгэн туяа орж ирэн, гэрийг нь гэрэлтүүлж байна гэж зүүдэлжээ. Мөн тэр шөнө ч гэсэн би зүүдэндээ Ибрахим алейхиссальамаыг үзсэн. Тэр надад ирснээ: “Абдулмутталибын хүү Абдуллахтай охиноо гэрлүүл, тэдний гэрлэлтийг би батлаж байна” гэж байна гэж зүүдээлсэн билээ. Өнөө өглөөжингөө энэ зүүдээ тайлах гэж гайхан сууна хэмээжээ. Вехибийн энэхүү үгүүдийг сонссон Абдулмутталиб “Аллаху акбар, Аллаху акбар” хэмээн уулга алдав. Тун удалгүй нижгэр хурим найр хийж, Абдуллах Амина хоёрыг гэрлүүлэв¹³.

Мухаммедийн туяа эхэд нь өгөгдсөн нь

Хорвоогийн энэрэл болсон Пайгамбарын маань(салаллаху алейхи уа сальлам) ариун туяа эхэд нь өгөгдөх үед ан амьтад, шувууд хүртэл “хорвоогийн эрхэм хүн мэндлэх хугацаа ойртлоо, тэрээр газар дэлхийд амар амгаланг бэлэглэж, цаг хугацааг гийгүүлэгч мөнөөсөө мөн” хэмээн шуугилдаж байлаа. Тэр өдөр Каабд байсан бүх шавар бурхад газар унаж хагарч байлаа. Тэр жилийн зун Мекке хотод хэдэн жилээр үргэлжилсэн ган гачиг нүүрлэн усгүй хатаж гандсан модод уйлж буй чимээ гарган шаналж байв. Мухаммед элчийн гэгээн туяа ааваас нь ээжид нь өгөгдөх тэр үед маш их бороо хур орж цэлгэр сайхан цаг ирж, адгуусан амьтад хүртэл баярлаж буй нь илт байв. Тэр жилийг “налгар жил” гэж нэрэлсэн билээ.

Амина эх бие давхар байх үед нөхөр Абдуллах нь Шам хот руу наймаа хийхээр яваад буцах замдаа хүндээр өвдөж, авга ах Нежжарын хөвгүүдийн хажууд нас нөгчив. Энэ гашуун гунигт мэдээг дуулсан Мекке хотынхон гашуудан уйлцгааж байлаа¹⁴. Пайгамбарын (салаллаху алейхи уа сальлам) эцэг нь хүүгээ мэндэлхээс нь өмнө нас барсанд харамсасан сахиусан тэнгэрүүд “Аяа, Аллах минь, элч өнчин боллоо шүү дээ” гэхэд Аллах: “тэрний туслагч бас хамгаалагч нь би байх болно” гэж айлджээ.

Фил (заан) түүх

Энэрэлт Мухаммед (салаллаху алейхи уа сальлам) хорвоод мэндэлхэд хоёрт сар гаруй хугацаа үлдсэн байлаа. Энэ үед фил(заан) түүх эхэлсэн юм. Их хөлийн газар болсон Кааб руу аянчин, мөргөлчид, наймачидын хөл тасардаггүй байлаа. Энэнд атаархсан Емен хотын амбан захирагч Абрэхааа нь Визант их гүрний тусламжтайгаар Шам хотод нэгэн том христийн шашны сүм бариулжээ. Учир нь ариун Кааб руу тасралтгүй холхих хүмүүсийг энэ сүмдээ татахыг хүсжээ. Гэвч арабуудын хувьд эрт дээр үеэс Каабдаа ирж залбирдаг байсан учираас Абрэхаагын барьсан сүмийг хархыг ч хүссэнгүй.

Нэгэнт баригдсан сүм нь ариун Каабаас илүүд болож чадаагүйд ууралсан Абрэхаа Мекке хотыг дайлаар мордов. Абрэхаагын цэргүүд Мекке хотод ойртохдоо Курейш овгийнхны

14 Ибн Сагд, эт-Табакет I, 99-100.

адуу малыг хүнсэндээ идэж эхэлцгээв. Абдулмутталибын 200 тэмээг ч гэсэн тэд авчээ. Үүнийг сонссон Абдулмутталиб даруйхан Абрэхаа рүү очин тэмээгээ нэхэмжилэв. Абрэхаа “би танай ариун Каабыг чинь нураахаар явж байна, гэтэл чи тэрнийгээ харамлах бус хэдэн тэмээнийхээ араас хөөцөлдөж явдаг” гэж ёжлон инээв. Абдулмутталиб: “би бол тэмэнүүдийн эзэн нь, харин Каабын эзэн нь Аллах. Тийм болхоор Тэр Каабыг хамгаална ” гэв. Абрэхаа “надаас хэн ч тэрнийг хамгаалж чадахгүй” гэж хэлээд Абдулмутталибт тэмээнүүдийг нь буцааж өгөв. Тэгээд цэргүүдээ Мекке хотын зүг хөдөлгөв. Абрэхаагын цэргүүдийн хамгийн урд нь Мамут нэртэй нэгэн нүсэр биет заан байлаа. Энэ заанаар дайруулан цэргүүд нь араас нь орох нь тэдний дайны төлөвлөгөө байлаа. Гэтэл тэр заан нь Кааб дөхөх тусам явж чадахаа байж хэвтчихдэг хэрнээ эргүүлээд Емен хотын зүг харуулхад гүйн зугтааж байв.

Ийнхүү явсаар Меккед ойртож довтолхоор зэхэж байхуйд Аллах эзэн Абрэхаагын цэргүүдрүү Эбавил нэртэй шувуун сүргүүдийг илгээжээ. Энэ гайхмаар шувууд буурцагны дайтай 3 чулууг тээж иржээ. Нэгийг нь амандаа зуун нөгөө хоёрыг нь хөлөгдөө барьжээ. Энэ чулуугаа Абрэхаагын цэргүүд рүү шидэлхэд оногдсон хүн бүр тэр дороо үхэж байв Куран сударт айлдлсанчилан Абрэхаагын цэрэгүүд идэгдсэн ургамлын навчис мэт болон нүднийх нь өмнө сүйрч буйг хараж зогссон Абрэхаа үхтэлээ айн зугтаахыг завдсан ч чадсангүй. Учир нь мөндөр мэт орж буй чулуун борооны жинхэнэ бай нь тэр байлаа. Зугтаах тусам биенийх нь мах нь хэсэг хэсэгээр тасран унах нь түүний гэсгээл байлаа. Энэ явдалын тухай Куран сударт ийн өгүүлжээ: “(Аяа элч минь! Каабыг сүйтгэхийг хүсэгч) зааны эздийг (заанаар тоноглогдсон Абрэхагын цэргүүдийг) Аллах эзэн чинь яаж гэсгээснийг харав уу? Тэдний (Каабыг сүйтгэх гэсэн бодол) зорилгийг нь үгүй хийгээгүй гэж үү? Тэдэн рүү сүрэг шувуу явуулж, тэр шувуунууд галаар улайссан шавар чулууг шидлээ. Аллах тэднийг дотор нь идэгдсэн ургамалын навчис мэт болгосон билээ”¹⁵.

15 Ибн Исхак, Эс-Соре,с, 38-44: Ибн Хишүм Эс-Соре I,43-56: Ибн Сагд, эт-Табакет I, 55-56,92,108: Сүхейл , эр-Равзүл-Үнф.с.I,269-270.

Баярт мэдээнүүд

Энэрэлт элч Мухаммедийн (салаллаху алейхи уа сальлам) ирэх нь Адам элчээс авхуулаад бүхий л элч ба тэднийг дагалдагсадад мэдэгдсэн байдаг. Хорвоод мэндлэх нь дөхөх тусам ер бусын гайхам явдалууд олон гарч байв. Муса (а.с) элчид илгээгдсэн Теврат нэрт сударт ийн айлдагджээ: “Тэр бол хамгаас энэрэнгүй нэгэн, энэрэл элбэрэл нь үнэнхүү их ба бүхнээс төгс, тэр хамгаас үзэсгэлэнтэй бас цэвэрхэн. Машид өрөвчхөн аталаа буруу номтонуудад хатуурахдаг. Бичиг үсэг тайлагдаагүй. Гэвч түүнд Аллах бүхнийг засан. Муухай зан, хатуу зүрхгүй, угаал үйлдэн намаз (мөргөл) үйлддэг, Меккед төрж, Мединегээс Шам хот хүртэлх газар түүний захирамжинд орох болно. Түүний нэр Мухаммед ч түүнд Мүтэвеккил гэж нэр өгөх болно. Тэр эвдэрсэн шашинуудыг түлхэн унгааж чин үнэн шашин түгээж эхлэх болно, тэр жинхэн бурхан руу дуудаж, зөв замруу хөтлөх болно. Түүний хар энэрлээр сохорсон хүмүүс хараа орж, дүлийрсэн хүмүүс сонсож эхлэн зүрхний хирээсээ ангижирна...”

Дауд элчид (алейхисальлам) илгээгдсэн Зебур сударт ийн өгүүлжээ: “Тэр бүхнээс өглөгч, харамлах сэтгэл түүнд үгүй, хэзээ ч ууралдаггүй, маш нинжин сэтгэлтэй, үзэсгэлэнт царайтай, сайхан яриатай, туяа гэрэлтсэн нүүртэй, төрөлхийн сайхан бас ухаалаг, бүхнийг өөртөө татах сайхан сэтгэл ба ухаалаг үгс түүнийх...Аяа, хайрт элч минь, чамд өгөгсөн ер бусын хүчинд бүхий л кафирууд (буруу номтонууд) толгой бөхийх болно. Чи ухаалаг бас энэрэнгүй үгсээр намайг хорвоод алдаршуулна. Чиний хурц сэлэмний дор бүхий л кафирууд (буруу номтонууд) толгой бөхийх болно...” гэжээ.

Иса элчид илгээгдэн хожимоо хүчингүй болсон Инжил сударт: “тэрбээр бүхнээс цэвэрхэн, харамч сэтгэлээс ангид, илбэ үзүүлдэггүй, хэнийг ч муулдаггүй, маш тайван, залхуурах сэтгэлгүй агаад хэзээ ч худлаа хэлдэггүй шудрага нэгэн билээ...”

¹⁶Гэжээ.

16 Ибн Исхак, Эс-Соре,с,119-124: Ибн Хишүм Эс-Соре I,232-233: Ибн Сагд, эт-Табакет I. 360-363.

Харанхуй бүдүүлэг цаг үе

Энэрэлт элч Мухаммедыг (салаллаху алейхи уа сальлам) мэндэлхээс өмнө хорвоо ертөнц оюуны түнэр харанхуйн шалбаагт живж байлаа. Харгислал, муу муухай бүхэн үүрлэж, хүмүүс чин үнэн, шудрага ёс ариун үйл гэгчийг умартан, хөгжил дэвшилээс ангид бузар булгай бүдүүлэг зэрлэг амьдралын шаварт шигдэн байв. Хүн төрөлхтөн бүтээгч эзэн Аллахыг умартан, буруу номлолын салхинд туугдан өөрийн гараар бурхан урлан түүндээ мөргөн залбирах явдал газар авсан байлаа. Муса элчийн шашин уг үндэсээрээ өөрчлөгдөн эвдэрч ариун судар Теврат нь хүртэл өөрчлөгджээ, Иса элчийн (алейхисальлам) түгээсэн нэг бурханд итгэн сүсэглэх шашин нь христос болон хувирч энэ төдий нэгэн үлгэр домог болон үлджээ. Иса элчийн (алейхисальлам) авч ирсэн Инжил судар уг үндсээрээ өөрчилөгдхийн сацуу шашины зан үйл нь тэр чигээрээ мартагдан үгүй болжээ.

Египедэд өөрчилөгдсөн Теврат судар, Византын их гүрэнд христос шашины эхлэл (өөрчлөгдсөн инжилийн зарчимууд), Иранд гал, усанд мөргөн залбирах бөөгийн шашин байсан төдийгүй 1000 жилээр унтраалгүй мансан галаа шүтэх ёсон байв. Хятадад Конфуцигийн сургааль, өмнөд Ази болох Энэтхэгийн нутгаар Буддын шашин гэх мэт төөрөгдөл дэлхийд ноёрхон байх цөвүүн цаг байлаа.

Арабын нутагт харгислал дэндэж адгуусан амьтдаас ч долоон дор болж, Аллахын ариун болгож мутралсан Кааб дотор 360 шавар (баримал) бурхад байрлуулжээ. Үнэндээ Кааб бол тэнгэр огторгуйд Мелекүүдийн (сахиусан тэнгэрүүд) тойрон мөргөдөг “Бейтү Мамуурын” яг адил хэмжээтэй газар дээрхи нэгэн үлгэрлэл нь билээ. Хэн Каабыг эс хүндлэн бузаралнав Аллах түүнийг даруйхан цээрлүүлдэг байв.

Жүрхүм гэдэг нэгэн овгийнхон садар самуун, шалиг завхай явдал ихдэж ичгүүр сонжуургүй явдал газар авчээ. Энэ үед толгойлогчид нь: “Хөөе, Жүрхүмийн иргэдээ! Аллахын ариун болгосон Каабын нэрийг бодож өөрсдийгөө засаж, залруулцгаа муу муухайгаа орхиж, буян үйлдэж нүглээ наминчалцгаа, урдын элч Худ, Салих, Шугайб (алейхиссальлам) пайгамбаруудын үед амьдрагсад өөрсдийн буруу үйлээс болон яаж гэсгээн цээрлүүлэгдсэнийг та нар мэдэж байгаа бус уу? Аллахын тийм гэсгээлээс бид бүгдээрээ хорогдон айдаг атал та нар юунд ингэж

эвдэрцгээнэв?! Нэг нэгнээ буянт үйлд уриалан, нүгэлээс хорин холдуулцгаа! Үнэндээ харанхуй мунхаг амьдрал хүмүүсийн гэсгээл хүртэх шалтгаан болдог бус уу!” хэмээн айлдав.

Гэвч тэд энэ бүхнийг соссонгүй, сонсохыг ч хүссэнгүй. Тиймээс ч Аллах тэднийг энэ хийсэн нүглийнх нь төлөө үр удамаар нь гэсгээн газрын хөрснөөс арчисан билээ...

Яг ийм харанхуй бүдүүлэг үер үерлэн байлаа. Аллахын гэр болох Каабын дотор Лат, Узза, Менат, гэх мэтийн шавар бурхадаар дүүрсэн байлаа. Тэдний энэ бодолгогүй явдал нь нийгэмд соёлгүй бүдүүлэгийг авч ирээд зогсохгүй, ихэс дээдсээ энэрэн хүндлэхээ больж, нэг нэгэндээ туслан дэмжих гэсэн ухагдхуун алга болон, хүчтэй нэгэн нь хүчгүйгээ дээрэлхэн, хүчтэй нь хоолтой, хүчгүй нь ядуу өлсгөлөн ийм л нийгэм оршин тогтнож байв. Арабууд нэг зүйлд маш их автан шунаж хөгжүүлдэг байлаа. Энэ нь уран зохиол ба шүлэг байв. Тиймээс ч яруу найрагчид олширно. Хүн бүр л сайхан шүлэгний төлөө нүдээ ч ухаж өгөхөөс ч буцдаггүй байв. Сайхан шүлэг бичигсэд олоны дунд нэр хүнд магтаалын эзэд болдог байлаа. Шүлэг яруу найрагийн уралдаан болж, хүмүүс аль болох сайхан бичигдсэн шүлэгүүдээ ариун Каабын хаанд хадаж хамгийн алдартай 7 шүлэгийг “Эл Муаллактус сабга” буюу “хадгалсан долоо” гэж нэрэлдэг байлаа.

Тэр үеийн Арабуудын итгэл үнэмшил нь ч гэсэн өөр өөр байв. Зарим нэг нь огт юунд ч итгэдэггүй зөвхөн өөрийн хүссэнээр л амьдархыг илүүд үздэг байсан бол, зарим нь хойд ертөнцийн амьдрал ба Аллах бурханд итгэдэггүй байлаа. Зарим нь Аллахд итгэдэг ч хойд насны амьдралд үл итгэдэг байв. Өөр бас нэг хэсэг нь Аллахд огт итгэдэггүй агаад өөрсдийн гараар бурхад зохион бүтээгээд түүнээ бурхан хэмээн итгэн залбирдаг байлаа.

Өөр бас нэг хэсэг нь Ибрахим элчийн түгээсэн “Ханеф” шашинтнууд байлаа. Энэ шашинд итгэгчид Аллах эзэнд итгэн, шавар бурхадаас хол байдаг байв. Мухаммед элчийн(алейхиссальлам) маань эцэг Абдуллах, өвөө Абдулмутталиб, ээж Амина нар бас бусад хүмүүс энэ шашинд бат итгэгчид байв.

Тухайн үед Ханеф шашинтнуудаас бусад бүх сүсэг бишрэл цөм нэгэн төөрөгдөл буюу эндүүрэл байлаа.

ХОРВООД МОРИЛСОН НЬ (Мэндлэх нь)

Хорвоо дахь амьдрал соёлгүй бүдүүлэг, нэгэн харанхуйд умбан Аллах эзнээ ч умартан чулууг сийлж, модыг зорж, шавраар нааж үйлдсэн өөр өөрсдийн бурхадуудаа шүтэн гэгээрэл, энэрэл гэгчийг ор тас мартжээ. Хорвоо ертөнц, сэтгэл санаа гунигт автан баяр хөөр алгаа болжээ. Бүхний дээд нь болсон хүн төрөлхтөнийг хойд насанд нь тамын галаас аврах элч Мухаммедын (салаллаху алейхи уа сальлам) хорвоод мэндлэх нь ойртсон байлаа. “Макам Махмууд” ба Махмуудын олбогын эзэн болсон, мэргэн ухаан, нинжин сэтгэлтнүүдийн дээд нь болсон, бүхий л элчүүдийн тэргүүн нь болсон, хорвоо ертөнц түүний хайранд бүтээгдсэн их эзэний хайрт элч Мухаммед ирж айсуй...(саллаллаху алейхи вэ сальлам)

Долоон давхар газар шороо, долоон давхар тэнгэр огторгуй товчхондоо хорвоо ертөнц нэг л баяр баясгалантай, учир нь Сейидүл Мүрсалын (илгээгдсэдийн ноён), Хатэмүл Энбия (элчүүдийн сүүлч), Хабиби Худаа (их эзэнтний хайрт) элчийг хүлээж буй. Бүхий л зүйлс өөрсдийн хэлээр “тавтай морил, аяа, Аллахын элч минь” гэхэд зэхэж байлаа. Хижраагийн тооллоос 53 жилийн өмнө “филийн явдлаас” 2 сарын дараа Раббиүл эввэл сарын 12-ны шөнө даваа гаригийн үүрээр, Меккед Хашимын хөвгүүд дүүрэгт, Сафа толгодын хажууханд нэгэн гэрт хорвоогийн санан санан тэмүүлэн хүлээсэн Мухаммед Мустафа(саллаллаху алейхи вэ сальлам) мэндлэв. Түүнийг хорвоод морилсноор дэлхий ертөнц дахин амилж, түнэр харанхуй бусинан саринаж эхэлжээ¹⁷.

“Медарижүлнүбүввэ”хэмээх нэгэн номонд: “Үнэ хүндлэлийн дээд нь болсон элчүүдийн хамгийн азтай эх хазрети Амина бие давхар байх үеээ ийн дурджээ: “Би элчийг хэвлийдээ тээж байх үед хэзээ ч анган цангаж бас өлсөж байсангүй, өөрийгөө жирэмсэн болхоо ч мэдэхгүй шахам хөнгөн шингэн байсан. 6 сартай жирэмсэн байхад зүүдэнд минь хэн нэгэн надад ирж “Чи хэнийг тэжээж яваагаа мэдэх үү?” гэж асуулаа. “Мэдэхгүй” гэж хариулахад “чи сүүлчийн элчийг тээж яваагаа мэд!” гэж айлдлаа. Төрөх дөхөх үед нөгөө хүн л ахин зүүдэнд ирж “хөөе, Амина хүүхэд төрсний дараа тэрнийг Мухаммед гэж нэрлэ” гэж хэллээ.

17 Ибн Сагд, эт-Табакет I, 100-103.

Хазрети Амина эх төрөх үеэ ийн өгүүлж байна. Төрөх цаг ирхэд сүрт нэгэн дуу хоолой сонсогдлоо. Намайг энэ дуунаас айж эхэлхүйд нэг цагаан шувуу ирж далавчаараа намайг илбэхэд айдас минь алга болж тайвшрав. Тэр үед ангаж цанган, маш их халууцаж байлаа. Хажууд минь байх нэг аяга цагаан сүү адил уух зүйл байлаа. Тэрнийг уухад амт нь ер бусын сайхан агаад хүйтэн ундаа байв. Гэнэт нэгэн туяа цацарч гэрийн дотор тэр чигээрэ туяаран солонгорхоор нь би юу ч үзэж чадахгүй болов.

Тэр үед надад туслаж, эх барьж авах ер бусын эмэгтэйчүүдийг харлаа. Тэд гэрэл цацарсан цагаан нөмрөгтэй агаад царай нь наран адил гэрэлтсэн ер бусын энэ эмэгтэйчүүд Абду Менаф овгийн эмэгтэчүүдтэй адил байлаа. Эдний нэг нь: “би Фараоны эхнэр Асия байна” гэв. Нэг нь: “би Имраны охин, Иса элчийн эх Мариям байна, энэ хүүхнүүд бол диважингийн Хури (эмэс охид) гэв. Гэв гэнэт тэнгрээс газар хүртэл татагдах торгон нэгэн хөшиг буухад тэрнээр “хүмүүсийн нүдийг хаалхалцгаа” гэж айлдав. Гэнэт нэгэн шувуу гарч ирлээ. Тэр шувууны хошуу нь бадмаараг харин далавч нь эрдэнэсийн чулуугаар бүрэгдсэн байлаа. Би маш айж хөлөрхөд газар унсан дусал бүрээс анхилуун үнэр тархаж байлаа. Яг тэр үед миний мэлмийг нээх шиг болход газар дэлхийг тэр аяараа сахиусан тэнгэрүүд бүрсэн байлаа.

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) мэндэлсэн даруйдаа толгойгоороо газар мөргөн шахадат буюу тангаргийн хуруугаа өргөхөд тэнгрээс түүнийг бүрхэх цав цагаан нэгэн үүлний тасархай буулаа. Энэ үед нэг дуу хоолой: “Түүнийг наран мандах зүгээс наран жаргах зүг хүртэл бүхий л газар дэлхийгээр тойрон аялуул, хорвоо дэлхий түүний нэр алдар, бие мах бодь, ариухан царайг нь таниг” гэж айлдан нөгөө цагаан үүл алга болов. Мухаммедийг (салаллаху алейхи уа сальлам) цагаан, ногоон даавуунд өлгийдсөн байлаа. Гэнэт цагаан царайтай 3 хүн гарч ирэв. Нэгнийх нь гарт мөнгөн данх, нөгөөгийнх нь гарт хаш чулуун цагаан түмпэн байхад нөгөө нэг хүн нь зөөрхөн торгон алчуур гартаа барьжээ. Энэ гурван хүн Мухаммед элчийг (салаллаху алейхи уа сальлам) энэ түмпэндээ хийж мөнгөн данхтай ариун усаараа толгой хөлийг нь угааж торгон алчуураараа арчиж дараа нь ногоон өнгийн даавуугаараа өлгийдөн баглаад алга болов.

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) мэндлэх үед Амина эхийн хажууд нь байсан Абдуррахман бин Аффаны ээж Шифа хатан байлаа. Мөн Осман бин Абу-л Асын эх Фатима

хатан бас Мухаммед алексальламын авга эгч болох Сафие хатан нар байлаа. Эд ч Амина эхийн хэлсэнчилэн харсан туяа болоод болоод өнгөрсөн энэ ер бусын үйл явдалыг харснаа ярьж байлаа.

Шифа эх ийн ярьсан нь: “би Амина эхийг төрөх тэр орой түүний хажууд нь байсан юм. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) мэндлэнгүүтээ сүсэглэн залбирч буйг нь харлаа. Хаа нэгтэйгээс “Эзэн чинь чамайг хайр ивээлдээ аваг” гэж дуугархыг нь сонслоо. Дараа нь гэрэл цацран гарахуйд газар дэлхий цав цагаан болон хэдий шөнө байсан ч өдөр мэт гэрэлтэн байлаа.”

Шифа эх энэ бүхнийг нүдээрээ үзсэн тул хэзээ л Мухаммед элчид (салаллаху алейхи уа сальлам) элчийн үүрэг өгөгдсний дараагаар огт эргэлзэлгүйгээр иман (итгэл үнэмшилтэй) болсон анхдагч хүмүүсийн нэг нь би байсан» хэмээн хэлжээ.

Сафие эх хэлэхдээ: “Мухаммед (салаллаху алейхи уа сальлам) төрөхүйд бүх газар дэлхий гэгээн туяагаар бүрхэгдлээ. Тэр эхээсээ мэндэлсэн даруйдаа толгойгоороо газар мөргөн “Лаа илаха иллаллах, инний расулуллах (Аллахаас өөр бурхан үгүй, би түүний элч нь билээ)” гэж хэлэв. Би тэрнийг угаах гэтэл хаа нэгтэйгээс нэгэн дуу хоолой “бид түүнийг цэвэрхэн болгож төрүүлсэн” гэв. Түүний хүй нь бас хөвч нь таслагдсан байх нь гайхмаар. Тэрээр намдуухан нэгэн дуугаар “Үмметий үмметий! (дагагсад минь, дагагсад минь)” гэж залбирч байлаа.

Хайрт пайгамбар маань хорвоод мэндлэх үед өвөө Абдулмутталиб ариун Каабын өмнө Аллах эзэндээ залбирч байхуйд баярт мэдээг дуулгав. Мухаммед (салаллаху алейхи уа сальлам) мэндлэх өдөр ер бусын зөндөө зүйлс үзсэн тул “Энэ хүүгийн минь нэр алдар нь мандан бадрах болно”¹⁸ хэмээв.

Энэ баярт явдлыг тэмдэглэхээр 7 хоногийн дараа 3 өдөр их найр хийж Мекке хотын өнцөг булан бүрт тэмээгээр тахил өргөн махыг нь ядууст тарааж, буян үйлдсэн нь түүний ирээдүйн элчийн төлөө хийсэн нэгэн томоохон хүндэтгэл байлаа. Энэ найрны үер Абдулмутталибаас: “Шинэ төрсөн ачдаа ямар нэр өгсөн бэ?” гэж асуухад: Мухаммед гэдэг нэр өглөө” гэв. “Ягаад өвөг дээдсүүдийнхээ нэгнийх нь нэрийг эс өгөв?” гэж асуухад нь: “Аллах эзэн ба хүн төрөлхтөн түүнэр бахархаж, магтаг гэж бодоод энэ нэрийг өгсөн юм” гэж хариулав. Бас нэгэн яриагаар бол Мухаммед гэсэн нэрийг Амина эх нь өгсөн гэсэн байдаг.

18 Ибн Сагд, эт-Табакет I, 100-103.

Мэндлэх үед болсон гайхамшигууд

Хүндэт элч (салаллаху алейхи уа сальлам) мэндлэхээс өмнө ба мэндлэх үед элч болох шинж тэмдэг нь болох ер бусын гайхмаар зүйл маш их болсон. Тэр үеийн алдартай хүмүүс сүүлчийн элчийг хорвоод мэндэлхээс нь өмнө зүүдэндээ тэрнийг харжээ. Тэгээд зүүд тайлагч эрдэмтэн, мэргэдэд очиж хэлхэд тэд Мухаммедыг (салаллаху алейхи уа сальлам) ирэх цаг нь дөхсний мэдээ гэж тайлбарлаж байв. Элчийн өвөө Абдулмутталиб би нэг удаа маш сонин зүүд зүүдлээд цочин сэрлээ. Тэгээд энэ зүүдийг тайлбарлаж чадах нэг мэргэн ухаантантай уулзахаар очиход тэр намайг харангуутаа “Аяа, Курейш овгийн ахлагчаа, юу болоов? Таны нүднээс айдас сандрал хараж байна” гэхэд нь би: “Тийм ээ, би нэгэн зүүд зүүдэллээ, энэ зүүдний учирьг тайлж өгөөч” гээд зүүдээ түүнд ярила. “Энэ шөнө зүүдэнд маань нэгэн том мод зүүдлэгдлээ. Тэр модны өндөр нь тэнгэр багандсан агаад салгар мөчрүүд нь наран мандах ба жаргах зүгрүү тарахжээ. Энэ мод нарнаас ч хурц туяатай бөгөөд заримдаа үзэгдэж заримдаа үл үзэгдэж байлаа хүмүүс тэрэн лүү зүгэлхэд гэрэл туяа нь хурцаас хурц болон тодорч байлаа.

Курейш овгийн нэг залуу хүн тэр модны мөчирөөс бариж байхад зарим нь мөчирийг нь тайрхыг оролдож байх юм. Энэ мод үнэхээр үзэсгэлэнтэй бөгөөд түүнээс гарах анхилуун үнэр дэлхийгээр нэг тархаж байх юм. Би тэр модны нэг мөчирөөс нь барихыг хүсэн гараа сарвасан ч гар минь хүрсэнгүй гэлээ”. Намайг ярьж дуусхад мэргэн хүний царай нь цонхийж айдаст автаснаа: “Чи тэрэнд хүрэх хувьгүй юм байна” гэв. Би “Тэгвэл хэн нь хувьтай юм бэ?” гэж асуухад тэр “Тэр модны мөчирөөс баригсад хувьтай” гэв. Чиний үр удамаас нэгэн Пайгамбар (элч) төрөх болно. Түүний нэр алдаршиж бүхий л зүгт цуурайтах болно. Хүмүүс түүний шашинд орох болно” гэснээ миний хажууд байсан Эбу Талиб хүү рүү минь харснаа, “энэ хүн түүний авга ах нь болно” гэв. Эбу Талиб энэ явдалыг Мухаммедэд (салаллаху алейхи уа сальлам) элчийн үүрэг өгөгдсөний дараа ярьж өгчээ. Зүүдэд үзэгдсэн тэр сагалгар мод бол Эбу-л Касим, Эл-Амин Мухаммед алейхиссальлам байлаа. Хайрт пайгамбар Мухаммед (салаллаху алейхи уа сальлам) хорвоод мэндэлдэг тэр шөнө нэгэн шинэ од тэнгэрт гэрэлтэж эхэлжээ. Энэ одыг ажиглсан Жүүд эрдэмтэн мэргэд Мухаммед хорвоод ирсэнийг хэдийнээ

ойлгосон байлаа. Асхаб кирамаас Хасан бин Сабит өгүүлрүүн: “намайг 8 настай байхад нэгэн өглөө жүүд хүн “хөөе, Жүүдүүдээ” хэмээн сөөнгө хоолойгоор орилон сандарсан байдалтай байлаа. Жүүдүүд “яасан бэ? Юунд орилоов?” гэж хажууд нь цугларцгаав. “Мэдэж авцгаа, сонсоцгоо! Ахмедийн од энэ орой гялалзлаа. Ахмед энэ орой хорвоод мэндэллээ” гэж хэлжээ.

Гэгээн пайгамбар (элч) маань(салаллаху алейхи уа сальлам) мэндэлсэн тэр орой Каабын дотор байсан бүх шавар бурхад түрүүлгээ харан ойчсон байлаа. Уруэтуб-нуз Зүбейр ийн өгүүлрүүн: “Курейшийн нэг бүлгийн нэгэн шавар бурхан байсан. Жилдээ нэг удаа тэр бурханаа тойрон залбирч тэмээгээр түүндээ тахил өргөж, архи уун найралдаг байсан. Яг ийм нэгэн өдөр бурхныхаа хажууд очиход нөгөө бурхан нь түрүүлгээ харан унсан байхыг харав. Түүнийг босгож тавьсан ч унаад байв. Тэгэхэр нь доор нь сайтар чулуу тавьсан боловч энэ удаа нэгэн дуу хоолой “нэгэн хүн мэндэллээ, дэлхий дээр бүх зүйл хөдөлгөөнд орж хичнээн л шавар бурхан байна бүгдээрэ газар унсан байлаа. Хаад ноёдууд айсандаа зүрх нь чичэрч байв.» Энэ явдал яг Мухаммед элч мэндэлсэн тэр шөнө болжээ.

Медайн хот дахь Ираны Кисра (эрх баригч түшмэдүүд) ордны 14 багана хугарсан их дуу чимээнээр цочиж сэрсэн Кисра түшмэдүүд ба тэнд байгсад айж эмээсэндээ зүрх нь амаар нь гарах нь холгүй байлаа. Энэ явдал нь зүгээр нэг энгийн зүйл биш ер бусын мэдээний дохио болохыг ойлгосон байв.

Мөн тэр шөнө галд мөргөн залбирагчидын унтраагүй 1000 жилийн настай шүтдэг гал нь гэнэт унтарчээ. Энэ явдал Кисрагийн ордны багана нурж ундаг тэр шөнө болжээ.

Энэ шөнө ариун догшин гэгддэг Саве нуур ширгэж нэг л хоромд ус нь татагдаж алга болжээ.

Шам хотын зүгт орших 1000 жил ус нь огт урсаагүй ширэгсэн Семаве гол гэв гэнэт ундаргаа авч, урдын адил мяралзан урсаж эхэлжээ.

Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) төрсөн өдрөөс эхлэн шайтан (чөтгөр), жинүүд(буг) Курейш овгийн мэргэч төлөгчидөд тусалхаа больж, төөрөгдөл алга болжээ.

Хорвоогийн энэрэл болсон сүүлчийн элчийн мэндэлсэн энэ өдөр ер бусын гайхмаар зүйлс дэлхийд олонтой болсон нь дэлхийн сүүлчийн элч болох Мухаммедийн (салаллаху алейхи уа сальлам) хорвоод мэндлэхийн шинж тэмдгүүд байлаа¹⁹.

19 Ибн Кесор, эл- Бидэйн II, 211-212.

Мевлид өдөр буюу пайгамбарын төрсөн өдөр

Пайгамбарын маань (салаллаху алейхи уа сальлам) хорвоод мэндэлсэн өдрийг мевлид өдөр гэнэ. Энэ өдөр нь “төрөх хугацаа” гэсэн утагтай. Кадир шөнийн дараах хамгийн ариун шөнө юм. Энэ шөнө Пайгамбарийн маань (салаллаху алейхи уа сальлам) мэндэлхэд юу болж өнгөрсөнийг, ямар гайхамшигтай үйл явдал тохиосонг сонсож бусдад яриж өгөх нь маш их буян хураах үйл юм. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) өөрөө энэ талаар бишгүйдээ их ярьдаг байжээ.

Асхаб (анхдагч мусульманууд) энэ өдөр цуглан, энэ өдрийг сангалзаж нэг нэгэндээ ярьдаг байлаа. Дэлхийн өнцөг булан бүрт байгаа мусульманууд энэ өдрийг Мевлид шөнө хэмээн нэрийдэж баяр жаргалтайгаар цэнгэлдэн өнгөөдөг билээ. Ямар ч пайгамбарын дагагсад нь өөрийн элчийнхээ төрсөн өдрийг нэгэн баяр болгож тэмдгэлдэг. Энэ өдөр нь тэгвэл мусульманчуудын баярын өдөр болжээ. Юутай их аз завшаан бэ...

Сүүн эхэд нь өгөгдхүй

Амина эх туяа цацруулсан хүүгээ тэврэхдээ нөхөр Абдуллахыгаа үгүйлэн сангалзсан сэтгэлээ тайвшруулдаг байлаа. 9 хоног хүүгээ хөхүүлсний дараагаар Эбү Лехебийн татвар эм болох Сувейбэ эзэгтэй хэсэг хугацаанд сүүн эх болсон. Сувейбэ эх тэрнээс урд хазрети Хамзааг, дараа нь Эбү Селемээг хөхүүлж байжээ. Хафиз ибн Жезри ийн өгүүлрүүн: “Эбү Лехебийг зүүдэндээ үзээд ямархуу байгааг нь асуулаа. Тэр би булшний гэсгээл хүртэж байна, гэвч Раббиүл Эввэл сарын арван хоёрны өдөр миний энэ тамлал жаахан хөнгөрдөг. Хурууны завсраас гарсан шүүсээ ууж цангаагаа дарж байна. Нэгэн орой Сувейбэ гэдэг татвар эм маань над дээр гүйн ирж “Мухаммед төрлөө гэж” баярт мэдээ дуулагсанд би ихэд баярлан түүнийг татвар эмээс чөлөөлж, Мухаммедын (салаллаху алейхи уа сальлам) сүүн ээж болох үүрэг өгсөн билээ. Тийм болхоор л энэ сарын арван хоёрны өдөр миний булшны тамлал жаахан нимгэрдэг гэв.

Мекке хот маш халуун уур амьсгалтай болхоор, бүгчим байх нь нярай хүүхэд бойжход маш хэцүү байдаг байлаа. Тиймээс хотоос зайдуу сэрүүн бас сайхан агаартай газар нярайг

сүүн ээжид өгч хэсэг хугцаанд бойжуулах нь Мекке хотынхны ёс заншил байв. Агаар сайтай сэрүүн газраас хэсэг эмэгтэйчүүд ирж, Меккегээс хөхүүлэх хүүхдээ авч одож хэсэг хугацааны дараа эргүүлэн гэр бүлд нь өгөхдөө маш их мөнгө, бэлэг сэлт хүндэтгэл олгодог байв. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) мэндэлсний дараахан зусланд байх Бени Сагд овгийн хэсэг эгтэйчүүд сүү эх болхоор Мекке хотод ирцгээн хөхүүлэх нэг нэг хүүхэд олж авав. Бени Сагд гэгдэх энэ овог нь Мекке хотын ойролцоох овгуудаас хамгийн нэр хүндтэй цэвэр ариун овог байлаа. Тиймээс ч хүмүүс энэ овгийнхонд хүүхдээ өгч хөхүүлхийг их хүсдэг байв. Тэр жил энэ овгийн нутаг ган гачигтай байлаа. Энэ овгийн Халима бүсгүй ийн өгүүлрүүн:

“Тэр жил хөдөө газар очиж жимс түүдэг байв. Эннийхээ төлөө Аллах эзэнд баярлаж талархахаа мартаагүй. Заримдаа 3 хонгоор юу ч идэлгүй өнгөрсөн үе бий. Яг энэ хэцүү өдрүүдэд би нэг хүхэдтэй болсон юм. Өлсгөлөн, хүүхэд хоёр намайг зовоож байлаа. Нэг шөнө зүүдэндээ нэгэн хүн намайг сүүнээс ч цагаан нэг голын эрэг дээр авч ирсэнээ “эндээс уу” гэж хэлэв. Хэзээ ч амсаж байгаагүй балын амтат энэ ундааг би шуналтайгаар залгиж эхлэв. Хэсэг хугацааны дараа намайг зогсоон “их сүүтэй бол, Халима, намайг танив уу?” гэж асуухад нь “үгүй” гэж хариулсаныг дуулаад “чи зовж байгаа ч Аллахт талархсан учираас чамд Аллах баярлаж байна. Мекке хотод оч тэндээс нэг байлирсэг туяаг найзаа болго, чиний хишиг буян чинь ихдэж сайхан амьдрах болно.” Энэ зүүдээ хэнд ч битгий хэл гээд алга болжээ.

Амьдрал маш хэцүү байсан тул цалинтай хүүхэд хөхүүлж, мөнгө олох гэж Мекке хотод ирэгсэд жил жилүүдийнхээс маш их ирсэн байлаа. Бүгд аль болох баян айлын хүүхэд авах гэж уралдацгааж байв. Меккед ирэгсэд нэг нэг хүүхэд олж авцгаажээ. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) өнчин байсан болхоор нэг их мөнгө өгөгдөхгүй гэж бодоцгоож, түүнийг авахыг хүсэхгүй байлаа. Энэ эмэгтэйчүүд дотроос ариун явдалд, шударга, цэвэрч нямбай, бас нинжин сэтгэлээрээ олны танил болсон Халиме эзэгтэй байлаа. Тэрний унсан илжиг нь туранхай байсан болхоор Меккед бусдаасаа хоцорч ирэв. Ийн хоцрох нь тэрний хувьд илүү ихийг олох завшаан болохыг тэрээр яахан мэдэх билээ. Нөхөртэйгээ хүүхэд хайн Мекке хотоор хэсэг явав. Баян айлын бүх хүүхдүүд сонгогдсон болхыг харсан ч гар хоосон буцхыг хүссэнгүй.

Халима эзэгтэй нүүрэндээ гэгээ татуулсан нүдэд маш

дулаахан нэгэн өвөөтэй тааралдсан нь Абдулмутталиб байлаа. Тэрэнтэй уулзаж учир явдлаа ярилцаад, Абдулмутталиб өөрийн ач болох Мухаммед хүүгээ сүүн ээждээ өгөхийг санал болгов. Халима эзэгтэй ч зөвшөөрөн тэр хоёр Аминагийн гэрт очлоо.

Халима эзэгтэй ийн өгүүлж байна: “Мухаммед хүүгийн хажууд нь очиход цав цагаан өлгийд өлгийдсөн ногоон өнгөтэй даавуун олбог дээр үнэгчилэн унтаж байлаа. Түүнээс миск (анхилуун үнэрт) түгэх нь хажуу хавиаа гоё үнэртэй болгож байлаа. Би машид гайхан түүнд татагдаж эхлэв. Сэрээхийг хүсээгүй ч цээжин дээр нь гараа тавихад минь тэр сэрээд над руу харан мишээхэд нь миний хайсан хүү энэ байна гэдгийг хэдинээ ухаарлаа. Ээжтэй нь ярьхад хүүг нь авч хөхүүлэх болсноо дуулангуутаа хүүг тэврэн нүүрийг нь даавуугаар бүрхээд баруун хөхөө өглөө хүү дуртайяа хөхөж эхлэв. Зүүн хөхөө өгхөд хүү юу ч хөхсөнгүй Абдулмутталиб “баяр хүргэе бусад эмэгтэйчүүдийн дотроос чам шиг азтай хүн олсонгүй дээ” гэв. Амина эх надад хайртай хүүгээ өгөхдөө баяртай байлаа. Тэгээд: “Аяа, Халима, 3 хоногийн өмнө чиний хүүд сүү өгөх хүн Бени Сагд овгийн Эбү Зүейб овогтой хүн гэсэн нэг дуу сонссон” гэв. Тэр хүн нь би байлаа, би Бени Сагд овгийн Эбү Зүейбийн охин билээ.

Би Амина эхэд зүүдэлсэн зүүдээ яриж өгөхөд тэрбээр “миний хүүгийн сүүн эхээр чамайг сонгожээ” гэж хэллээ. Би энэ эзэгтэйг, бас энэ хүүг нь урьдаас таньдаг бас хайртай байсан мэт байлаа. Халима эзэгтэй Мухаммед хүүг аваад нөхөр дээрээ очлоо. Нөхөр маань тэвэрт минь байгаа хүүг харснаа уулга алдан “Халима минь, энэ өдрийг хүртэл ийм хөөрхөн хүүг үзсэнгүй” гэв. Энэ хүүг авсан даруйдаа буян хишигтэйг нь хараж эхэлсэн болхоор нөхөр маань “Аяа, Халима, чи агуу хувь заяатай, зүгээргүй нэгэн хүүхэд авчээ”²⁰ гэв. “Би Аллах эзнээс нэгэн ийм хүү хүсэж байтал тэрнийгээ олло” гэж хариулсан билээ.

Халима эзэгтэй нөхөртэйгөө хамт Мухаммед хүүг (салаллаху алейхи уа сальлам) аваад гэрлүүгээ буцахдаа тэр хүүгийн ер бусийн байдалыг үзэж эхлэв. Учир нь тэдний унсан луус нь ирэхдээ арай ядан ирсэн атал буцахдаа давхих шахам хөнгөн явдалтай болсон байлаа. Тэр бүү хэл аль хэдийнээ урд нь яваа хэсэг аялагчидыг гүйцэснээр барахгүй тэднийг ч ардаа орхин урагшиллаа. Тэднийг Бени Сагд овогтоо ирснийхээ дараагаар ер бусын буян хишиг ихсэж, элбэг дэлбэгээр бялхаж

20 Сүхейл, эр-Равзүл-Үнф.с.1, 144-145:Касталано, эл- Мэвэхибүл-Энбие,с, 37.

эхлэх нь гайхмаар байлаа. Сүү бага гардаг малынх нь хөхөнд сүү орон, дундрашгүй мэт болох нь хүүгийн ирсэнтэй холбоотой гэж бодож байлаа.

Тэр зун маш их гантай байсан тул Аллахаас бороо хур гуйн залбирхаар ууланд гарцгаав. Мухаммед хүүг ч хажуудаа авч дагуулан гардаг байлаа. Залбирал бараг дуусаагүй байхад л тэнгрээс бороо хувингаар цутгах мэт асгардаг байв.

Пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) сүүн эх Халима эзэгтэйн баруун хөхийг нь хөхөөд зүүн хөхийг нь хөхдөггүй байлаа. Тэр зүүн хөхний сүүг нь сүүн дүүдээ үлдээдэг байлаа. Гурван сартайдаа мөлхөж, 4 сартайдаа юм түшиж явж эхлэв, 5 сартайдаа чөлөөтэй явж, 6 сартайдаа гүйж байлаа, 7 сартайдаа хүссэн бүх зүйлдээ хүрч чадхаар явдаг болсон байв. 8 сартайдаа хэлд орж эхэлсэн ба 9 сартайдаа чөлөөтэй ярьж байлаа. 10 сартайдаа өөрт нь тааруулагдсан нум сумаар харваж эхэлжээ. Халима эзэгтэйн хэлсэнчлэн Мухаммед (салаллаху алейхи уа сальлам) хэлд орохдоо хамгийн түрүүлж хэлсэн үг нь “Лаа илааха иллаллаху валлаху акбар, Вэлхамдү лиллахи раббил ааламин(Аллахаас өөр бурхан гэж үгүй, Аллах агуу бас ертөнцийн эзэн Аллахдаа гялаалаа)” гэж хэлсэн. Тэр өдрөөс эхлэн хүнд юм өгөхдөө Аллахын нэрийг дуудалгүйгээр өгдөггүй байлаа. Хэзээ ч зүүн гараараа юм авч иддэггүй бас тоглож байгаа хүүхдүүдээс зайдуухан зогсоод “би энэний төлөө илгээгдээгүй” гэж хэлдэг байлаа. Өдөр бүр түүнийг наран адил цацарсан туяа бүрхэн авснаа буцаад нээгддэг байлаа.

Халима эзэгтэй ийн хүүрэн байна: “Мухаммедыг 2 настай болход нь би хөхнөөсөө гаргасан. Тэгээд нөхөртэйгээ цуг түүнийг эхэд нь буцааж өргөхөөр Мекке хот руу явав. Тэрэнд бид үнэхээр дассан байсан болхоор түүнээс салхад маш хэцүү байлаа. Амина эхэд Мухаммедын гайхмаар явдалуудыг яриж өгөхөд тэрбээр: “Миний хүү нэр алдартай хүн болох хувьтай” гэж хариуулжээ. Бид “Аллахын нэрээр андгайлъя урьд өмнө нь бид энэ шиг гэгээн хүнийг үзээгүй билээ” гэж хэлээд Халима эзэгтэй шалтаг тоочин хүүг нь ахиад хэсэг хугацаанд хажуудаа байлгамаар байгаагаа хэлж гуйхад нь Амина эх тэднийг гомдоолгүй зөвшөөрснөөр Мухаммедыг (салаллаху алейхи уа сальлам) аван гэртээ буцацгаав. Ингэснээр Халима эзэгтэй буян хишгээр бялхаж, хот хороо нь малаар дүүрч, идээ ундаа нь бялхан хэмжээгүй бурханы хишгийг хүртсэн билээ²¹.

21 Ибн Исхак, Эс-Сопе,с,25-28: Ибн Хишүм Эс-Сопе I,158-167: Ибн Сагд,

Ариун цээж нь задрахуй

Халима эзэгтэй ийн айлдруун: «Мухаммед (салаллаху алейхи уа сальлам) нэг өдөр “Өдрөөр найзууд маань ягаад алга байгаа юм бэ?” гэж надаас асуухад нь: “хонь хариулхаар явцгаасан, орой л гэртээ ирцгээх байхаа” гэж хариулхад: “би ч бас хонь хариулмаар байна, намайг бас тэдэнтэй цуг явуулаач” гэж гуйхад нь би зөндөө шалтаг тоочин түүнээс уучлал гуйлаа. Гэвч түүнийг баярлуулахын тулд “за” гэж зөвшөөрөв.

Маргааш өглөө нь ариун толгойг нь самнаж, хувцасыг нь өмсгөж өгөөд, сүүн дүүтэй нь хамтаар хонь хариулхаар явуулав. Ийн явсаар хэсэг хоногийн дараа нэг өдөр сүүн дүү Шейма ганцаараа малын бэлчээрээс буцаж ирхэд нь би маш их айн “Миний хүү Мухаммед хаана байна?” гэж асуухад: “бэлчээрт хонины хажууд байгаа” гэж хэнэг ч үгүй хариулав. “Чи дүүгээ орхин яаж ирж чадваа?!” гэж зэмэллээ. “Ээж минь, тэрэнд ямар ч муу зүйл болохгүй. Ягаад гэвэл түүний дээр нэгэн үүл үргэлж дагаж явдаг. Тэр үүл түүнийг наршхаас хамгаалж, сэрүүцүүлж тэр хаана л явна, үүл нь хадагдсан юм шиг үргэлж дагна хэзээ ч хоолдохгүй” гэж хариулав. Би тэрнээс ам тангараг авч байж л сая нэг итгэн тайвшрав. Нэгэн өдөр сүүн дүү нь болох Абдуллах над дээр сандран гүйж ирэв: “Ээжээ, хурдлаарай, шалавларай!.. Мухаммед надтай хонь хариулж явтал ногоон хувцастай 3 хүн ирээд түүнийг аваад уулын орой руу явчихлаа. Тэгээд дээш нь харуулж хэвтүүлээд хутгаар цээжийг нь яраж байхыг нь харангуутаа би айн тань руу гүйж ирлээ. Тэрэнд юу болсныг мэдэхгүй хурдлаарай!” гэж сандран уйлж байлаа. Үүнийг сонссон миний толгойд цус харвах мэт болж айсандаа хөдөлж ч чадхааргүй хэсэг зогссоноо сая ухааран Мухаммедын (салаллаху алейхи уа сальлам) зүг гүйлээ. Бид хамаг хурдаараа гүйсээр ирхэд Мухаммед дээш харан тэр газраа унтаж байлаа. Би түүнийг тэврэн толгой нүдийг нь үнсэн уйлж: “Нүдний минь цөцгий болсон хайрт хүү минь, юу болов? Чамд юу тохиолдов?” гэж асуухад тэр: “Өглөө намайг эрээс гархад гэрэл цацарсан царайтай, ногоон хувцас өмссөн хоёр хүн намайг хүлээн зогслоо. Нэг нь гартаа мөнгөн данх, нөгөөх нь гартаа ногоон өнгийн хаш чулуун түмпэн барьсан харагдав. Тэр түмпэнд цаснаас ч цагаан нэгэн шингэн зүйл дүүрэн харагдав. Намайг уулын оройд дагуулан

авч одлоо. Нэг нь намайг дээш нь харуулан хэвтүүлж, намайг харж байхад цээжнээс минь хүйс хүртэл зүслээ ингэж зүсэж байхад би ямар ч өвдөлт, зовлон мэдэрсэнгүй. Тэд миний дотор гараа оруулаад дотор эрхтэнийг минь гаргаад, түмпэн дотроо хийж цагаан шингэн зүйлээр угаагаад дотор нь буцаагаад хийв. Нэг нь нөгөөдөө: “Бос, одоо миний хийх ажил үлдлээ” гэж гараа миний дотор оруулаад миний зүрхийг гаргалаа. Тэгээд зүрхийг минь хоёр зүсэж мах бас нэг хар өнгийн булчирхай мэт нэг зүйлийг гаргаж хаяснаа “Чиний бие дэхь Шайтааны (чөтгөрийн) хорлол энэ байсныг гаргаж хаялаа. Аллахын хайрт элч минь! Чамайг хууралт ба төөрөгдлөөс ангид болголоо” гэж хэллээ. Дараа нь зүрхийг минь данхандаа байсан зөөлхөн нэг зүйлээр дүүргээд туяа цацарсан тамгаар тамгаллаа. Одоо болтол тэр тамгын хүйтэн нь мэдрэгдсээр байна. Тэдний нэг нь зүсэлт хийсэн газар гараа тавихад тэр даруйхан эдэглээ. Тэгээд бүгдээрээ миний гар, хацрыг минь үнслээ, тэгээд намайг энд үлдээгээд, алга боллоо” гэж хэлэв. Зүсэлт хийсэн газар нь соривтой байлаа²².

Элчид тохиолдсон энэ гайхмаар зүйлийн талаар Куран сударт Инширах нэртэй сүре(бүлэг)-нд “Шакк-и садр” ба «цээж задрах» гэж нэрэлдэг.

Асхабуудын (анхдагч мусульманууд) зарим нь: “Аяа, Расулуллах (Аллахын элч), бидэнд өөрийнхөө тухай яриаач?” гэж хүсхэд нь: “Би өвөг-дээдэс Ибрахимийн залбирал, дүү Иса алейхиссальямын баярт мэдээ, ээжийн маань зүүд. Тэр бие давхар байхдаа Шам хотын орднуудыг ч гэрэлтүүлсэн нэг туяа өөрөөс нь гархыг үзсэн... Би Саад бин Бекирийн хөвгүүдийн (овог) хажууд хөхүүлэгдэж өссөн хүү билээ” хэмээжээ.

Мухаммедыг (салаллаху алейхи уа сальлам) 4 настайд нь Халима эзэгтэй түүнийг Меккед ээжид нь хүлээлгэн өгөв. Өвөө Абдулмутталиб Халимаад маш их бэлэг сэлт өгч, хүндэтгэл үзүүлэв. Халима тэрнийг Меккед үлдээгээд буцахдаа “Миний амь, сэтгэл хоёр маань тэрэнтэй үлдлээ дээ” хэмээн уйлсаар буцсан билээ.

22 Ахмед бин Ханбел, эл-Мүснэд III,212: Ибн Хишам Эс-Соре I,164-165: Сүхейл, эр-Равзүл-Үнф.с.II, 167.

Гэгээн эхээсээ хагацсан нь

Хайрт пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) 6 нас хүртлээ эхийнхээ хажууд бойжжээ. Түүнийг 6 настайд нь эх Үммү Эймен гэх шивэгчин хүүхэнтэйгээ цуг төрхөмөө бас нөхөр Абдуллахынхаа шарилыг эргэхээр Медине хот руу замд гарав. Мединед нэг сар гаруй байв. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) Мединед Нежжарын хөвгүүд овогийн усан санд сэлж сурав. Энэ үед нэгэн Жүүд хүн түүний элчийн тэмдэгийг нь үзээд, түүний хажууд нь очоод, нэрийг нь асуув. “Ахмед” гэж хэлхэд нь “энэ хүү сүүлчийн элч байна” гэж орилов. Тэнд байсан Жүүд эрдэмтэд ч түүний элчийн бэлэг тэмдэг болсон тамгийг үзэцгээн, хоорондоо энэ бол сүүлчийн элч яг мөн байна гэж ярилцаж байхыг нь сонссон Үммү Эймен хазретти Амине эхэд очиж хэлэв. Амине эх хүүд нь ямар нэгэн муу зүйл тохиолдох вий гэж эмээн даруй Мекке хотруу буцацгаав. Замд Эбуа гэдэг газар ирхэд Амине эхэд хүнд өвчин туссан байлаа. Өвчин нь хүндэрч, үе үе ухаан алдаж унаж байлаа. Толгойг нь түшиж суусан хайрт хүү Мухаммед рүү харж: “Аяа, хүү минь, үхлийн аюулт сумнаас Аллах эзэний хайр энэрэл бас түүний тусламжтайгаар 100 тэмээний өртөгөөр аврагдсан агуа хүний үр минь! Аллах чамайг хишэгтэн болгог. Хэрвээ зүүд минь биелвэл чи Эзний зарлиг бас цээрлэлийг нь хүмүүст түгээхийн тулд илгээгднэ. Аллах чамайг бас чиний дагагсадтай чинь хамтаар гараар бүтээгдсэн бурхдаас, бас тэдэнд залбирагчидаас хамгаалах болно” гэж хэлээд нас баржээ. Амине эх хорвоог орхихдоо 20 настай байлаа.

Үммү Эймен Мухаммедыг аваад, хэдэн хоногийн дараа Мекке хотод ирж, өвөө Абдулмутталибт түүнийг өгөв²³.

Өвөөгийн өвөрт

Хорвоогийн энэрэл болсон элчийн эцэг-эх нь Ибрахим пайгамбарын(салаллаху алейхи уа сальлам) шашиныг шүтдэг байв. Өөрөөр хэлвэл, Мүмин (чин сүсэгтэн) байлаа²⁴.

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) 8 нас хүртлээ өвөөгийнхөө халамжинд өсөж торинов. Меккед хүндлэгдсэн янз бүрийн ажилыг зохион байгуулсан, сүр жавхлантай, тэвчээртэй,

23 Ибн Хишам Эс-Сопе1, 168: Ибн Сагд, эт-Табакет I, 116.

24 Касталано, эл- Мэвэхибүл-Энбие,с, I, 652.

соёлтой, шудрага бас өглөгч нэгэн болон өсөн торнисон байлаа. Ядуусыг хооллон, цанган өлссөн амьтадад энэрэнгүй хандан өвс, усыг нь өгдөг байлаа. Муу муухайгаас хол, харанхуй бүдүүлгээс холуур тойрч явдаг. Мекке хотод болдог шударга бус зүйлийн эсрэг зогсож, ирсэн зочидыг хүлээн авч дайлдаг байлаа. Рамазан сард Хира ууланд гарч хүмүүсээс хол ганцаараа Аллахын агуу сүр хүчний талаар бодон бясалган суух нь түүхий амьдралын нэг хэв маяг болсон байлаа. Абдулмутталиб хамгаас хайрт ач хүү Мухаммедээс хором ч холдохгүй, үргэлж хажуудаа авч явдаг байлаа. Ариун Каабын (сүм) сүүдэрт өөрийн олбог дээрээ Мухаммедтэй (салаллаху алейхи уа сальлам) хамт суугаад түүнд төвөг удагсадаг: “Түүнийг тайван орхи, тэр ер бусын хүү”²⁵ гэж хэлдэг байлаа. Үммү Эймен ийн өгүүлрүүн: “Мухаммед хүүг өлсөж, цангаж байна гэж хэлж байхыг нь нэг ч удаа дуулаагүй билээ. Өглөө нэг аяга земзем ус уудаг байв. Түүнд хоол унд өгөхийг завдахад тэр “Үгүй, би өлсөөгүй, цатгалан байна” гэж хэлдэг байсан. Абдулмутталиб унтаж байхдаа, эсвэл өрөөндөө ганцаараа байхдаа Мухаммедээс өөр хэнийг ч өрөөндөө оруулхыг хориглодог байлаа. Түүнийг тэвэрч үнэрлэн эрхлүүлдэг ба тэрний хийсэн үйдлэл болгонд нь баярлан суудаг байжээ. Хамгийн сайхан, амттай бүхнийг түүнд зориуулдаг ба тэрнийг суугаагүй байхад хоол идхээр ширээнд суудаггүй байлаа.

Нэг удаа Мекке хотод ган гачиг болжээ. Абдулмутталиб зүүдэндээ айлдагдсны дагуу Мухаммед хүүгээ дагуулан Эбу Кубэйс ууланд гарч “Аяа, Аллах минь, энэ хүүгийн төлөө хур бороогоо хайрла” гэж залбирав. Энэ залбирал нь биелэгдэн, их бороо хур орж, ган гачиг тайлагдав. Тэр үеийн яруу найрагчид энэ явдлыг шүлэг болгон бичжээ.

Нежраны пастр (хамба лам)

Абдулмутталиб нэг өдөр ариун Каабын өмнө суухуйд Нежран хотын нэгэн пастр (хамба лам) хажууд нь ирж түүнтэй ярилцаж эхлэв. Тэгээд “Бид Израйлд хамгийн сүүлчийн элч болох хүний шинж тэмдэг нь судар номонд бичигдсэн байхыг уншлаа. Энэ газар (Мекке) бол түүний мэндлэх газар юм. Тэр элчийн шинж тэмдэг нь ийм ийм” хэмээн тоочиж гарав. Яг энэ үед Мухаммед хүү (салаллаху алейхи уа сальлам) тэдний

хажууд ирж суув. Нежраны пастр тэрнийг маш хянамгай ажиглаж эхлэв. Тэгээд түүний хажууд очоод толгой, нуруу, хөлийг нь ажиж харснаа “Тэр элч энэ байна. Энэ хүү чиний үр удамын хүү юу?” гэв. Абдулмутталиб “Миний хүү” гэв. Пастр: “номд бичигдсэнээр бол тэрний эцэг нас барсан байх ёстой” гэхэд нь Абдулмутталиб: “Энэ бол миний хүүгийн хүү. Тэрнийг төрхөөс нь өмнө эхийн хэвлийд байхад эцэг нь нас барсан юм” гэв. Пастр: “Чи одоо л үнэн ярилаа” гэв. Абдулмутталиб хөвгүүддээ: “Абдуллахын хүү Мухаммедийн талаар ярьж байгааг сонсоцгоо. Түүнийг сайн халамжилж, хамгаалж бай” гэж захив.

Өвөөгийнх нь үхэл

Абдулмутталиб нас бархынхаа өмнө хөвгүүдээ цуглуулаад: “Миний нөгөө ертөнц рүү мордох цаг минь ирлээ. Ганц санаа зовж байгаа зүйл бол энэ өнчин хүү (Мухаммед). Нас минь урт байгаад энэ хүүг халамжилах ажилаа үргэлжлүүлсээр байсан бол энэнээс илүү жаргал надад үлдсэн билүү. Гэвч одоо яая гэхэв, үхэл нэгэнт иржээ. Энэ хүүг би та нарын нэгэнд чинь даатгаж өгмөөр байна. Хэн энэ хүүг өөрийн хүү шигээ халамжилж өсгөж, хүмүүжүүлж чадах бэ?” гэж асуув. Эбү Лехеб өвдөг сөхрөн “Аяа, арабуудын толгойлогч минь ээ! Хэрвээ энэ хүүг өгөх хүнээ та өөрөө сонгосон бол юу гэхэв. Хэрвээ сонгоогүй бол би энэ ажилыг хийхэд бэлэн байна” гэв. Абдулмутталиб түүнд хандан: “Чиний мал их, гэвч чи хатуу сэтгэлтэй энэрэнгүй биш хүн. Өнчин зүрх шархтай, бас эмзэг байдаг. Гомдох нь амар” гэв. Бусад хөвгүүд нь ч Эбү Лехебийн адилаар хүүг надад өг гэж асууцгаав. Абдулмутталиб тэдний зан аашыг нь хэлж, янз бүрийн шалтгаан тоочин хэнд нь ч өгсөнгүй. Энэ үед Эбү Талиб хүү нь гаднаас орж ирэв. Тэгээд: “Би таа нараас илүү Мухаммедийг авхыг хүсэж байна. Гэвч ах нар минь байхад урьтаж гуйх нь зүй бус билээ. Би ядуу мал багатай хүн, гэвч миний итгэл үнэмшил бусад ах дүү нараас минь илүү гэж бодном” гэв. Абдулмутталиб: “Тийм ээ, энэ ажилыг зөвхөн чи л хийж чадна. Тиймээс ч би ямар нэгэн ажил хийхдээ түүнтэй зөвлөлддөг билээ. Хүү маань таа нараас хэнийг чинь сонговол тэрэнд хүүгээ өгнө” гэв. Тэгээд Мухаммед хүүд (салаллаху алейхи уа сальлам) хандаж: “Хүү минь, миний хойд ертөнц рүү явах цаг боллоо, чи энэ авга ах нараасаа нэгийг нь сонго. Тэр хүн чамайг өөртөө авч халамжлах болно”

гэв. Мухаммед хүү босож, Эбү Талибын хүзүүгээр нь тэврэн, өвдгөн дээр ирж суув. Абдулмутталиб хүүгийн сонголтонд машид баярлан: “Аллах эзэндээ баярлалаа. Миний хүсэл ч бас энэ байсан юм” гэж хэлэв. Тэгээд Эбү Талибд: “Эбү Талиб хүү минь! Энэ сувд мэт хүү бол эх, эцэгийн халамж, хайрыг цадталаа амсаж чадаагүй билээ. Тийм болхоор өөрийн хүү шигээ түүнийг хайрла. Чамайг би бусад хөвгүүдээсээ илүүд үздэг билээ. Энэ том бас үнэт эрдэнэсийг чамд л найдаж даатгаж чадах байна. Түүнийг өөрийнхөө амь мэт хамгаалж, энэ гэрээслэлийг минь хүлээж ав” гэж захив. “Ойлголоо, ааваа, би зөвшөөрч байна” гэхэд нь Абдулмутталиб Мухаммед хүүг тэврэн толгой, нүдийг нь үнсэн үнэрлэв. Тэгснээ: “Та бүгд гэрч болцгоо! Би хэзээ ч энэнээс анхилуун үнэр үнэрлэсэнгүй, бас энэнээс ч царайлаг зүс үзээгүй билээ” гэж хэлэв²⁶.

Эбу Талибын асрамжинд

Өвөө нь нас барсны дараа, өөрөөр хэлвэл, 8 настайдаа Мухаммед элч авга ах Эбү Талибын гарт очиж, түүний халамжинд амьдарч эхэлжээ. Эбү Талиб бол Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) эцэг Абдуллах шиг Мекке хотод шударга ариун явдалтайгаараа олны танил болсон Меккегийн толгойлогч нарын нэг байлаа. Тэрбээр Мухаммедыг (салаллаху алейхи уа сальлам) маш их хүндлэн харж ханддаг байлаа. Түүнийг өөрийнхөө хүүхдүүдээс ч илүү хайрлан, хажууд нь байхгүй л бол унтаж чаддаггүй, бас тэрэнгүйгээр хаашаа ч явдаггүй бөгөөд, түүнийг гараа сунгаагүй л бол хоолоо идэж эхэлдэггүй байлаа. Эбү Талибынх мал цөөхөнтэй бас олон хүүхэдтэй айл юм. Мухаммед хүүг (салаллаху алейхи уа сальлам) асрах болсноос хойш буян хишиг нь аривжин бялхаж эхэлсэн билээ²⁷.

Бахире пастр

Хайрт пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) 12 настайдаа Эбү Талибийг замд гархаар зэхэж буйг хараад, өөрийгөө ч гэсэн дагуулаад явахыг гуйв. Эбү Талиб дагуулхыг хүсэхгүй байгааг нь сонсоод: “Намайг хэнд даатгаж үлдээж
26 Ибн Исхак, Эс-Соре,с, 45-48: Ибн Хишам Эс-Соре I.169-178: Ибн Сагд, эт-Табакет I, 117: Сүхейл, эр-Равзүл-Үнф.с.I,188.
27 Ибн Хишүм Эс-СореI, 179: Ибн Сагд, эт-Табакет I, 119.

байгаа юм бэ? Надад эцэг, бас намайг халамжлах хүн танаас өөр хэн байна...” гэж гоморхов. Энэ үгийг дуулсан Эбү Талиб түүнийг хамт авч явхаас өөр аргагүй байдалд оров. Тэдний жингийн цуваа нэлээд зам туулсны дараа Бусра хотод христийн шашинтнууд амьдардаг нэгэн дүүрэгт сүмийн хажууханд буудаллав. Энэ сүмд Бахира гэдэг нэгэн пастр (шашины номлогч) байдаг аж. Урьд өмнө нь Жүүдийн эрдэмтэнүүдийн нэг байснаа сүүлдээ христийн шашинд орсон энэ хүн маш их эрдэм мэдлэгтэй юм. Түүнд нэгэн судар байлаа. Курейш овгийн жингийн цуваа урьд өмнө энэ хотоор дайрч өнгөрч байсныг мэдэх боловч хэзээ ч тэдэнтэй уулзаж ярилцдаггүй байсан. Өглөө болгон Арабаас аянчидын зүг харж, ямар нэгэн юм хүлээж байгаа мэт ажиглан зогсдог байлаа. Нэгэн өдөр Бахире Курейшийн зүгээс ирж буй энэ жингийн цувааны чанх дээр нь нэгэн үүл даган ойртож буйг ажиглав. Энэ үүл бол Мухаммед элчийг (салаллаху алейхи уа сальлам) төрснөөс нь хойш сүүдэрлэж, салалгүй дагаж байгаа үүл билээ. Бахира энэ аянчидыг хүлээж авхаар зэхэн маш их хоол унд бэлдэн зочины ширээ засав. Тэгээд нэг зарцаа явуулан Курейшийн жингийн цуваанд хамт ирсэн бүх аянчидыг хоолонд урив. Тэд Мухаммедыг (салаллаху алейхи уа сальлам) тэмээ ачаагаа харж бай гэж үлдээгэд өөрсдөө Бахире пастрынд морлив. Бахира ирсэн хүмүүс рүү шинжин харж байснаа “Хөөе, Курейшийн аянчидаа, та нар дотроос хоолонд ирэлгүй үлдсэн хүн байгаа юу?” гэж асуув. “Тиймээ, нэг хүн ирэлгүй үлдсэн” гэцгээв. Учир нь энэ хүмүүс ирхэд үүл нь дагаж ирэлгүй тэмээнүүдийнхээ хажууд үлдсэн билээ. Бахире пастр “тэр үлдсэн хүмүүсийг ч энд ирүүл” гэж гуйв. Тэр хүүг ирэнгүүт Бахире маш болгоомжтойгоор ажиглан судлаж эхлэв. Эбү Талибт хандаж: “Энэ хүү чиний хүү юу?” гэж асуув. Эбү Талиб “Тиймээ, миний хүү” гэхэд нь Бахира “Энэ хүүгийн эцэг нь нас барсан байх ёстой гэж судар номонд бичигдсэн байна, энэ чиний хүү биш” гэв. Эбү Талиб “энэ бол миний ахын хүү юм” гэхэд нь “Эцэг нь яасан юм бэ?” гэж асуув. “Эцэг нь энэ хүүгээ мэндэлхээс нь өмнө нас нөгчсөн юм” гэв. “Эх нь яасан юм бэ?” гэж асуухад нь: “Тэр бас нас барсан” гэв. Энэ бүхнийг сонссон Бахире Мухаммед (салаллаху алейхи уа сальлам) хандаж шавар бурхадын нэрийг барьж, тангаргалхад Мухаммед (салаллаху алейхи уа сальлам): “Шавар бурхадын нэрийг барьж битгий тангараг өргө, надад дэлхий дээр тэднээс илүү дайсан үгүй, би тэднийг жигшдэг” гэж хариулав.

Тэгтэл Бахира Алладын нэрээр тангаргалав. Тэгснээ “Одоо яаж унтдаг вэ?” гэхэд Мухаммед “нүд минь унтсан ч, зүрх минь унтахгүй” гэв. Бахира хэд хэдэн асуулт асууж хариултыг нь авч байлаа. Хариулт болгон нь нөгөө номонд бичигдсэнтэй яг цав нийцэж байхыг хараад Мухаммед хүүгийн нүд рүү нь ширтэж байснаа “Энэ улаан толбо чиний нүдэнд үргэлж байдаг юм уу?” гэв. “Тиймээ, үргэлж байсан” гэхэд Бахира энэ тэмдэгийг харснаа яг таг итэгхийн тулд Мухаммедээс (салаллаху алейхи уа сальлам) элчийн тамгийг хархыг хүсэв. Мухаммед (салаллаху алейхи уа сальлам) нуруугаа үзүүлхийг хүссэнгүй. Эбү Талиб “Хүү минь, тэрний хүссэн зүйлийг нь үзүүлчих” гэв. Мухаммед (салаллаху алейхи уа сальлам) ариун нуруугаа гаргаж “элчийн тамга (мэнгэ)”-ийг үзүүллээ. Бахира хантлаа тэр тамгийг хантлаа илж үнслээ. Нүднээс нь нулимас гарч, баярласандаа уйлж байлаа: “Би чамайг Алладын элч болохыг гэрчилж байна.” гэснээ дуугаа өргөн “Энэ хорвоо ертөнцийн ноён... Энэ бол ертөнцийн эзэний элч... Энэ бол Алладын хорвоод энэрэл болгон илгээх агуа элч...” гэв. Энэ бүхнийг сонсож байсан Курейшийнхан “Мухаммедыг энэ пастр ямар их хүндлэнэ вэ?” гэгцгээв.

Бахира Эбү Талибт хандан: “Энэ хүү бол сүүлчийн бөгөөд хамгаас дээд элч мөн байна. Энэний түгээх шашин дэлхий ертөнцөөр тархаж, урдын шашингууд хүчингүй болно. Тийм болхоор Израйлчууд энэ хүнд дайсанган ямар нэг муу юм хийж магад” гэж хэлэв. Эбү Талиб “Ягаад?” гэхэд нь “Аллах бүх элчүүдээ мөн сүүлчийн элч (Исааг алейхиссальлам) ч гэсэн дагагсаддаа сүүлчийн элч ирнэ гэж мэдэгдхийг зарлигласан” гэв.

Эбү Талиб Бахирагийн энэ үгнүүдийг сонсоод, замаа үргэлжлүүлж цааш Шам хот руу явхаас татгалзав²⁸. Авч явсан бараа хөсөгөө Бусраад зараад Мекке рүү буцав. Бахираагаас сонссон энэ зүйлүүдийг үхэн үэхтлээ мартсангүй бөгөөд, даруй Мухаммедэд (салаллаху алейхи уа сальлам) илүү их хайртай болсноор барахгүй насан өөд болтлоо түүнийг хамгаалж, түүнд тус дэм болсон билээ.

Бүхий л талаараа хүмүүсээс хамгийн төгс нь болсон агуа элч (салаллаху алейхи уа сальлам) эрийн цээнд хүрч 17 настай болсон байлаа. Авга ах Зубейр Емен хотруу наймаанд явахдаа Мухаммедыг (салаллаху алейхи уа сальлам) хамт авч

28 Ибн Исхак, Эс-Соре,с, 53-58: Ибн Хишам Эс-Соре I,180-182: Ибн Сагд, эт-Табакет I, 76,154-156: Сүхейл , эр-Равзүл-Үнф.с.II,216-220 Ибн Кесир, эл- Бидэе III, 283-286.

явдаг байлаа. Учир нь тэрэнтэй хамт явахад буян хишиг нь ихдэн наймаа арилжаа нь ч сансанчилан саадгүй бүтдэг байлаа. Ингэж явахдаа маш ер бусын явдалуудтай учирсанаа Мекке хотод ирэхдээ ярьсан тул Курейш овгийнхон “энэ хүү агуу хүн болго” нэж ярьцгаадаг байв²⁹.

ЗАЛУУ НАС БА ХУРИМАА ХИЙСЭН НЬ

Аль ч талаараа хүн төрөлхтний хамгийн дээд нь болсон Мухаммед (салаллаху алейхи уа сальлам) идэр насандаа Мекке хотынхонд сайн чанраараа танигдсан байлаа. Боловсон харьцаа, хурц мэргэн ухаан, ямар ч алдаа эндэгдэлгүй ухаарах оюун билэг, эргэлзээгүй шийдэмгий байдал, хөдөлмөрч зан чанар ба хэнийг ч хуурч мэхэлдэггүй шударга байдлаараа олонд танигдсан агаад түүнийг “Ал-Амин” буюу “итгэлт хүн” гэж нэрлэдэг байв. Мухаммедыг (салаллаху алейхи уа сальлам) залуу байхуй үеийн Арабууд харанхуй бүдүүлэг нийгэмд амьдарч байлаа. Бурхангүй үзэл, арихдалт, мөрийтэй тоглоом, завхай зайдан явдал гэх мэт муу муухай бүхэн газар авсан цаг үе байв. Мухаммед элч энэ бүхнийг үзэн яддаг ба үргэлжид холуур явдаг байлаа. Меккегийн хүмүүс бүгдээрээ Мухаммедын (салаллаху алейхи уа сальлам) энэ ариун чанарыг мэддэг бас гайхан шагширдаг байлаа. Шавар бурхадыг жигшдэг байсан болхоор хэзээ ч ойртдоггүй байв. Өөрийн гэсэн хэсэг хонь малтай байсан тул тэрнийгээ хариулдаг байв. Тэрбээр нэгэнтээ Асхаб Кирамд (анхдагч мусульмаанууд): “Хонь хариулаагүй нэг ч элч байхгүй” хэмээжээ.

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) 20 настайд нь Мекке хотод эмх цэгц гэж үгүй болж, чин үнэн, шудага ёс, хөгжил дэвшилээс ангид бузар булгай, бүдүүлэг зэрлэг амьдралын шаварт шигдэн байв. Нэгэн удаа наймаа арилжаа хийхээр Мекке хотод ирсэн Емен хотын нэгэн наймаачны мөнгө, үнэт эдлэлийг нь Ас бин Веил гэдэг хүн дээрэмдэн авчээ. Дээрэмдүүлсэн эд зүйлсээ буцаан авч чадхаа больсон наймаачин Эбу Кубэйс ууланд гарч өшөөг нь авч өгөхийн төлөө отог овогоосоо тусламж хүсчээ. Гэмт хэрэг ихдэж энэ мэтийн зүйл энгийн явдал болтлоо хүмүүс дөжирсөн байлаа. Хашим бас Зүхрэгийн хөвгүүд нэртэй хоёр овгийн толгойлогч нар хуурал хийж, суурин бас гадны иргэдийн аюулгүй байдал ба гэмт хэрэгт өртөгсөдийн хэргийг

шийдэж, шударгаар хохиролгүй болгох ёстой гэсэн шийдвэрт хүрчээ. Ийм зорилготой нэг бүлгэм байгуулжээ³⁰. Мухаммед (салаллаху алейхи уа сальлам) ч гэсэн энэ бүлгэмд элсэн, маш үр далайцтай ажил хийлээ. Энэ бүлгэмийн нэрийг “Хилфүл фүдүл” гэж нэрлэжээ. Энэ бүлгэм гэмт хэргийг багасгаж, шудрага ёс тогтоон бас Мекке хотыг эмх цэгцтэй болгож байлаа. Хэсэг хугцаанд энэ ажил нь их үр дүнгээ өгчээ³¹.

Арилжаа наймаа хийж эхэлсэн нь

Мекке хотынхон дээр үеээс л наймаа арилжаа хийж амь зуудаг байлаа. Пайгамбарын авга ах Эбу Талиб ч наймаачин нэгэн байв. Мухаммед (салаллаху алейхи уа сальлам) 25 настай байхуйд Мекке хотын хүмүүсийн амьдрал хүндхэн болсон байлаа. Тийм болхоор Мекке хотынхон Шам хот руу наймаанд явхаар маш том жингийн цуваа бэлдэв. Эбу Талиб Мухаммедэд (салаллаху алейхи уа сальлам) ирж: “Хайрт дүү минь, Мекке хотод ядуурал газар авч, ган гачиг болсон энэ хэцүү үед амьдрал маш хэцүү байна. Гарт байгаа мал, ноос, ногоогоо зарж наймаа хийхээр Шам хотыг зорихоос өөр аргагүй боллоо. Курейш овог жингийн цуваагаа бэлдлээ. Хадиже эзэгтэй ч гэсэн манай цуваанд хэсэг мал дайж байгаа. Энэ наймааг нь хийж ирэх итгэлтэй хүн хайж байна. Чамаас илүү найдвартай шударга нэгэн бидний дунд алга билээ. Хадижетэй очиж ярилцацгая, чамайг тэрний ачаа барааг хариуцан явах боллоо гэж хэлье. Үнэндээ бол би чамайг Шам руу явуулхыг хүсэхгүй байна. Учир нь тэнд байгаа жүүдүүд чамд ямар нэгэн гэм хор учруулж магад гэж айж байна. Гэвч өөр арга алга даа” гэв. Мухаммед (салаллаху алейхи уа сальлам): “Та юу гэж шийднэ, би таны хэлсэнийг дагах болно” гэж хэлэв.

Хадиже эзэгтэй тэрбээр царай зүс, ариун явдал, мал хөрөнгө, ичхүүр, бас соёлч харьцаагаараа Мекке хотод танигдсан хүндтэй нэгэн эмэгтэй байлаа. Тийм болхоор тэрэнтэй сүй тавьж, эхнэрээ болгохыг хүсэгчид маш олон байлаа. Гэхдээ тэр хэнийг нь ч сонгосонгүй учир нь тэр нэгэн удаа зүүдэндээ тэнгэрт байсан сар газардаж тэрний өвөрт нь орж, тэр өвөрөөс бүх зүйлийг гэрэлтүүлж байна гэж зүүдэлжээ. Энэ зүүддээ хамаатан

30 Сүхейл , эр-Равзүл-Үнф.с.1,91.

31 Ибн Хишам Эс-Сопел, 133: Ибн Сагд, эт-Табакет I, 82. Сүхейл , эр-Равзүл-Үнф.с.1,91:Ибн Хабоб, эл-Мухаббер,с,167: 220 Ибн Кесир, эл- Бидэие III, 290-293.

салан болох эрдэмт хөгшин Варака бин Невфелд хэлхэд нь тэр: “Ертөнцийн төгсгөл өдрийн элч болох хүн мэндэлжээ. Тэр хүн чамтай хуримлаж хамт амьдрах болно. Тэр үед түүнд элчийн үүрэг өгөгднө. Түүний түгээх шашин нь хорвоо ертөнцөөр нэг тархах болно. Хамгийн түрүүнд шашинд нь орох хүн нь чи байх болно. Тэр элч курейш овгийн Хашимийн хөвгүүдийн нэгэн юм” гэв. Хадиже эзэгтэй ч гэсэн энэ зүүднийхээ учирьг ойлгон сүүлчийн элч, бас өөрийн ирээдүйн нөхрөө хүлээж эхэлжээ.

Хадиже наймаа хийдэг ба итгэлтэй хүнтэй хамтран ажилдаг байлаа. Эбу Талиб Хадижед хамтран наймаа хийх талаар ярилцахад, Хадиже эзэгтэй түүний наймааг хариуцан явах хүн болох Мухаммедтэй (салаллаху алейхи уа сальлам) ярилцахыг хүсэн гэртээ Мухаммед (салаллаху алейхи уа сальлам) ба Эбу Талиб хоёрыг урьжээ. Тэднийг Хадижегийн гэрт ирцгээхэд машид хүндлэн зочлов. Мухаммед алейхисальламын үзэсгэлэнтэй царай, соёлч байдлыг нь хараад гайхан бишрэв. Тэгээд Мухаммедэд (салаллаху алейхи уа сальлам) хандан: “Шударга зан, итгэлт байдал, сайхан ааш зантайг тань би бишгүйдээ сонссон билээ. Энэ ажилын цалинг би хэнд ч өгч байгаагүйгээр ихийг таньд өгөхөд бэлэн байна” гэж хэлээд энэ ажилд өмсөх хувцас, гутал бас бусад зүйлийг Мухаммедэд (салаллаху алейхи уа сальлам) өгөөд хүндэтгэлтэйгээр гэрээсээ үдэн гаргав. Хадиже эзэгтэй Варака бин Невфэлээс сүүлчийн элчийн зан байдал ямар байх талаар асууж мэдсэн нь Мухаммедтэй (салаллаху алейхи уа сальлам) яв цав таарч байв. Тиймээс ч өөрийн боол болох Мейсэрэд “жингийн цуваа Меккегээс гархын алдад тэмээний бурантагийг Мухаммедэд атгуул. Мекке хотынхон ямар нэг хов жив ярьж магад, хотоос зайдуу гарч нүдээс далд орсны дараагаар энэ үнэт хувцасыг түүнд өмсгө” гэж захив. Тэгээд тэмээнүүдийнхээ хамгийн сайныг нь ноёдын тэмээний адилаар тоноглож янзлав. Мейсэрэд: “Мухаммедийг энэ тэмээнд хүндэтгэлтэйгээр мордуул, тэгээд чи хөтлөж яв. Чи тэр хүний ажилчин нь болоод түүний хэлсэн бүхнийг хийгээрэй, тэрний зөвшөөрөлгүйгээр юу ч хийж болохгүй шүү. Аюул учирхад тэрнийг амь биеэ үл хайрлан хамгаалаарай. Очсон газраа их удаж болохгүй, хурдан буцаарай. Хэрвээ миний энэ заасан зүйлийг ёсчлон биелүүлвэл, чамайг боолоос чөлөөлж мал, мөнгө өгнө” гэж хэлэв.

Аянчид замд гархад бэлэн болов. Мекке хотынхон төрөл

саданаа гаргаж өгөхөөр цугалсан байв. Хашийн хөвгүүд овгийн тэргүүнүүд ч хүртэл гэнд ирцгэсэн байлаа. Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) авга эгч нь Мухаммедын (салаллаху алейхи уа сальлам) ажилчиний хувцас өмсөөд, тэмээний бурантаг барьсан байхыг хараад машид өрөвдөн, өвдөг сөхрөн гаслан уйлав. “Аяа, Абдулмутталиб, аяа зөмзөм худгыг малтаж гаргасан гэгээн өвөө минь, аяа Абдуллах дүү минь, толгойгоо өндийлгөн наашаа нэг харцгаагаач дээ, энэ хүүгийнхээ байдлыг ажаач, өрөвдөөч” хэмээн орь дуу тавин уйлав. Эбу Талиб ч гэсэн яг тийм гаслан ба өвдөлтийг мэдэрч байлаа. Мухаммед (салаллаху алейхи уа сальлам): “Яг одоогийн намайг битгий мартаарай, харийн нутагт зовлон, зүдгүүр үзсэнээ дурсгал болгоё доо!” хэмээн нулимас дуслуулан байв. Энэ үгийг дуулсан хүн бүр уйлав. Тэнгэр дахь Мелек (сахиусан тэнгэрүүд) ч уйлж шаналж байв. Тэд “Аяа, эзэн тэнгэр минь, энэ бол чиний хайрт элч, элчүүдийн дээд нь болсон Мухаммед биш гэж үү? Энэ юу болоод байна?” гэж асууцгаав. Аллах эзэн тэдэнд: “Тиймээ! Тэр бол миний хайрт элч, та нар хайрын нууцаас юу ч мэдэхгүй. Хайрлах хайруулах хоёрын нууцыг мэдэхгүй, энэ зүйлийг хэн ч мэдэхгүй. Энэ нууц зүйлээс хэн ч юу ч олгохгүй” хэмээн айлджээ.

Жингийн цуваа замд гаран Мекке хотоос холдон, нүднээс далд орход Мэйсэрэ боол захисны дагуу үнэт хувцасуудыг Мухаммедэд өмсүүлж, янз янзын даавуугаар хучигдсан тоногдсон сайхан тэмээнд түүнийг мордуулан тэмээний бурантагийг гартаа авч хөтлөв.

Энэ аянд жинчид бүгдээрээ хайрт элч Мухаммедээс (салаллаху алейхи уа сальлам) огт салахгүй даган сүүдэрлэж яваа хэсэг үүл, бас замд гархаас эхлээд буцах хүртэл шувуу адил гэрэл цацруулсан хоёр Мелекүүд (сахиусан тэнгэр) даган явхыг харсан билээ³². Замд гарахгүйгээр цуваанаас хоцорч эхэлсэн хоёр тэмээний хөлийг нь Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) илхэд тэмээнүүд гүйх шахам хүчтэй болж, түрүүлж эхэлсэн гэх мэт ер бусын явдалуудыг харсан хүмүүс түүнийг маш ихээр хайрлан хүндэлж зүгээргүй нэгэн болохыг ухаарчээ. Бусра гэдэг газар ирж үдлэхдээ нөгөө христийн сүмийн ойролцоо буудллажээ. Мухаммедын (салаллаху алейхи уа сальлам) элч болхыг нь мэдсэн эрдэмтэн Пастр Бахира нас баран тэрний

32 Касталано, эл- Мэвэхибүл-Энбие,с, 41.

оронд Настура гэдэг пастр хамба нь болсон байлаа. Настура Курейшийн жингийн цувааг ажиглан зогсохдоо нэг хэтэж үхсэн модны дор нэгэн суухуйд нөгөө мод нүднийх нь өмнө цэцэглэн нахиалж буйг харснаа: “Энэ модны дор сууж байгаа хүн хэн бэ?” гэж асуув. Мейсэрэ “энэ бол Меккегийн ардаас Курейш овгийн нэг нь” гэж хариулхад Настура: “түүний нүдэнд жаахан улаан толбо байгаа юу” гэж асуув. Мейсэрэ “Тийм, байгаа, тэр нь хэзээ ч арилдаггүй юм” гэв. Настура: “Иса элчид илгээгдсэн Инжил сударт айлдснаар бол энэ хүн сүүлчийн элч болох учиртай. Би тэр хүнийг элч болон байхад амьд байхыг маш их хүснэм” гэв...

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) Бусра хотын барааны захад Хадиже эзэгтэйн барааг зарж байхад нь нэгэн жүүд хүн ирж наймаа хийж байснаа үл итгэлцэл болж жүүд: “Лад ба Узза бурханы нэрээр андгайла” гэв. Мухаммед (салаллаху алейхи уа сальлам): “Би энэ шавар бурхадын нэрийг барьж хэзээ ч тангаргалахгүй, тэр бүү хэл би тэр шавар бурхадын чинь хажуугаар явахдаа нүүр буруулдаг билээ” гэв.

Мейсэрэ Мухаммед алейхисальламаас үзсэн энэ гайхамшигт явдалуудыг цээжилж байлаа. Бас түүний хүнлэг зан чанарт нь гайхан цаг хугцаа өнгөрөх тусам түүнийг хүндлэн хайрлах сэтгэл нь улам их нэмэгдэж байлаа. Тиймээс ч түүнд дуртаяа туслаж, ажиллаж байлаа. Түүний хэлсэн энгийн жаахан ажилыг ч чин зүрхнээсээ үйлдэж байлаа.

Наймаа арилжаа нь бүгд зарагдаж, Мухаммедын (салаллаху алейхи уа сальлам) буян хишгээр урьд урьдийнхаасаа олон дахин илүү ашиг хонжоо олж, жинчид нутаг буцацгаав. Мекке хотод ойртон ирхэд Мейсэрэ Мухаммедэд “баярт мэдээг дуулга” гэж санал тавив. Мухаммед (салаллаху алейхи уа сальлам) ч үүнийг зөвшөөрөн Мекке хот руу жингээс түрүүлэн давхив.

Нефисе бинти Мүнийе эзэгтэй ийн ярьжээ: “Жингийн цуваа ирэх цаг ойртоход Хадиже эзэгтэй гэрийнхээ дээвэр дээр гаран, цуваа ирэх зүг харуулдан хүлээдэг байлаа. Нэг өдөр Хадиже ийн харуулдан зогсохуйд гэнэт тэмээтэй хүн элсэн толгодын цаанаас гарч ирэв. Түүн дээр нэгэн үүл даган нүүж явлаа, бас шувуу мэт хоёр Мелек түүнийг сүүдэрлэн нисэн явааг хараад Хадиже эзэгтэй тэр хүн нь Мухаммед (салаллаху алейхи уа сальлам) болохыг даруй ойлгон баярласнаа нуухыг хичээн: “Энэ халуун өдөр ирж яваа тэр хүн хэн байж болох бэ?” гэж зарц нараасаа асуув. Тэд “Энэ хүн Мухаммедтэй адил юм байна гэгцгээв. Тиймээ, энэ бол

Мухаммед алейхиссалам байлаа. Тэр Меккед ирж Хадижед баярт мэдээг дуулгав.

Хэсэг хугацааны дараа Мекке хотруу наймаачидын жингийн цуваа оржирэв. Мейсэрэ Хадижед замд тохиолдсон гайхамшигтай явдалууд ба Настура пастрын хэлсэн үг, туранхай тэмээ хэрхэн хүчтэй хурдан явж эхэлсэн гэх мэт зүйлүүдийг бүгдийг нь ярьж өгөв. Мухаммедыг сайн хүн болхыг Хадиже мэддэг байсан ч энэ бүхнийг сонсоод түүнд илүү их дурлаж байла. Тэгээд Мейсэрэд: “Энэ бүх үзсэн зүйлээ хэнд ч битгий хэлээрэй” гэж захив³³.

Хадиже дуулсан бүхнээ Варака бин Нэвфэлд ярьж өгөв. Варака: “Хадиже минь, хэрвээ энэ ярьсан бүхэн чинь үнэн бол Мухаммед элч болох хувьтай хүн” гэв.

Пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) 12 настайдаа авга ах Эбу Талибийг даган Бусра хот хүртэл наймаанд явсан ба 17 настайдаа авга ах Зүбейрийн хамтаар Емен хүртэл, 20 настайдаа Шам хот руу, 25 настайдаа Хадиже эзэгтэйн бараа таваар зархын тулд ахин Шам хот руу наймаанд явсан нь 4 удаа холын замд гарч байжээ. Энэ аялалаас өөр хаашаа ч аялаж байгаагүй бөлгөө.

Гэгээн Хадижтэй гэрлэсэн нь

Хадиже эзэгтэй Варака бин Нэвфэлийн ярсанчилан Мухаммедыг (салаллаху алейхи уа сальлам) үнэнхүү сайхан хүн болохыг нь хараад түүний эхнэр болхыг сангалзаж эхэлжээ. Ийн бодлоор өөрийн шивэгчин Нефисе гэдэг эмэгтэйг Мухаммед элчийн өмнө бараалхуулжээ: “Аяа, Мухаммед, гэрлэхэд тань юу саад болов? Гэрлэхгүй байгаагийн учир юу сан билээ?” гэж асуув. Мухаммед: “Гэр бүл болхын тулд хүрэлцэх хөрөнгө мөнгө надад алга” гэв. Нефисэ: “Аяа, Мухаммед, хэрвээ ариун явдалт бас нэр хүндтэй, үзэсгэлэнтэй нэг хүнтэй гэр бүл болохыг хүсвэл би таньд хэзээд тусалхад бэлэн” гэв. Мухаммед алейхиссалам: “тэр эмэгтэй чинь, хэнсэн билээ” гэж асуухад нь: “Хувейлидийн охин Хадиже” гэв. Мухаммед: “Хэн бидний хооронд зуучлах билээ?” гэж асуухад, би та хоёрын хооронд зуучилна” гэж хэлэв. Ингээд Хадижед ирж баярт мэдээг дуулгахад Хадиже хамаатан нь болох Амр бин Есед, Варака бин Нэвфэл хоёрыг гэртээ дуудан явдал учирьг хэлэв. Бас Мухаммедэд урилга илгээж,

гэртээ зочилхыг урив. Эбу Талиб ба ах дүү нар нь бэлтгэл хийж Мухаммедийн хамтаар тэднийд зочилцгоов.

Хадиже эзэгтэй гэр орноо цэвэрлэн гялалзуулж, энэ баярт өдрийн тэмдэг болгон бүхий л үнэт эмэг зүүлтээ шивэгчин хүүхнүүдэд тараан өгчээ. Тэднийг бүгдийг нь боолын үүргээс чөлөөлж, эрх чөлөөт хүн болгожээ. Гэгээн элч (салаллаху алейхи уа сальлам) ах Эбу Талиб ба авга ах нарынхаа хамтаар Хадиже эзэгтэйн гэрт зочлов. Эбу Талиб: "Биднийг Ибрахим пайгамбарын хөвгүүд дотроос Исмайл пайгамбарын үр удам болгон заяасан, хүн төрөлхтний ариун сүм, хорвоо дээрх хамгийн ариун газар болох Каабын харуул нь болгон томилсон Аллах эзэндээ талархнам. Миний дүү Абдуллахын хүү болох Мухаммед бол Курейш овгийнхоны дотор хамгийн агуу хүн билээ. Хэнтэй ч түүнийг харьцуулашгүй. Мухаммедэд (салаллаху алейхи уа сальлам) мал баялаг гэж бараг үгүй, гэвч малаар түүнийг үнэлэшгүй билээ. Учир нь баялаг бол сүүдэр адил нэг л удаад алга болчихно. Харин миний дүүгийн сайхан сэтгэл, нэр алдар, сайхан бүхэн нь бидний баялаг билээ. Тиймээс Хувейлидийн охин Хадиже та хичнээн тооны мехир (инж) авч Мухаммедтэй гэрлэх вэ?" гэв. Варака бин Нэвфэл: "Энэ бүхнийг хүлээн зөвшөөрөв. Хадижэ эзэгтэйн авга ах Амр бин Есед "Та бүхэн гэрч болцгоо, Хадижээг Мухаммедэд (алейхиссальлам) өглөө" гэв. Ийн ярилцасний эцэст хуримлахаар тохирцгоов. Нэгэн яриагаар бол инж нь 400 цэн алтан зоос, бас нэгэн яриагаар бол 500 цэн алтан зоос, бас нэгэн яриагаар бол 20 тэмээ байсан гэлцдэг³⁴.

Эбу Талиб нэг том тэмээ төхөөрч урьд өмнө хийж байгаагүй том цайлага хийжээ. Хуримийн ёслол ч болжээ. Гэгээн Хадижэ эзэгтэй өөрийн бүх эд хөрөнгөө нөхөр Мухаммедэд өгчээ. "Энэ бүх хөрөнгө энэ мөчөөс эхлэн танийх боллоо, би ч гэсэн таны ачыг бодож танд өөрийгөө зориулж байна" гэв.

Гэгээн Хадижэ насан туршдаа Мухаммедийн (салаллаху алейхи уа сальлам) хайрт хань нь байж, түүний төлөө бүхнээ зориулсан билээ. Тэр хоёр 25 жил хамтран амьдарсны эцэст Хадиже эх нас барсан билээ. Үүний 15 жил нь элч болхоос өмнө, 10 жил нь элчийн үүрэг өгөгдсөний дараах амьдрал байлаа. Элч Мухаммедэд (салаллаху алейхи уа сальлам) Хадижэ эхийг амьд ахуйд нь хэзээ ч өөр эхнэр аваагүй агаад тэр талаар бодож ч байсангүй. Хоёр хүү, дөрвөн охин нийт 6 хүүхэдтэй болжээ.

³⁴ Ибн Хишам Эс-Сопел, 43: Ибн Сагд, эт-Табакет VIII, 9:Сүхейл, эр-Равзүл-Үнф.с.II,231:Касталано, эл- Мэвэхибүл-Энбие,с, 41.

Хүүдүүдийнх нь нэрс: Касим, Зейнеф, Рукайе, Үммү Гүлсүм, Фатима, Абдуллах (Таиб эсвэл Тахир) нар юм. Элч байхуйд гэрэлсэн гэгээн Марием эхнэрээсээ Ибрахим нэрт нэг хүүрийн магнай үнрэлжээ. Бусад эхнэрүүдээсээ хүүхэдтэй болсонгүй. Охидынх нь ууган нь Зейнеф, отгон нь Фатима юм. Отгон охиндоо маш их хайртай байжээ. Энэ Фатима охин нь хижретээс (их нүүдэл) 12 жилийн өмнө хорвоод мэндэлжээ. Хөвгүүд нь бага насандаа эндсэн бөгөөд Фатима охиноос нь бусад 3 охин нь ч гэсэн Мухаммеди (салаллаху алейхи уа сальлам) амьд байхад нь түрүүлж нас нөгчжээ. Фатима эх Мухаммед элч мөнх бусийг үзүүлснээс 6 сарын дараа нас баржээ. Тэрээр гэгээн Алитай гэр бүл болж, Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) үр удам нь Фатима ба Али нарын хүүхдүүдээс тархдаг билээ³⁵.

Агуа элч Мухаммед (салаллаху алейхи уа сальлам) Хадижэ эхтэй гэрлэснийхээ дараагаар ч гэсэн наймаа арилжаа эрхлэн амьдарч байлаа.

Зейд бин Харисе

Зейд бин Харисе хүүхэд байхдаа эх Судатайгаа хамтаар хамаатнууддаа зочилхоор очжээ. Замд явахдаа өөр дээрэмчидийн дайралтанд өртөж Зейдийг тэд олзолж авчээ. Мекке хотод болсон Сук-и Указ гэдэг яармаг худалдаанд Зейдийг боол болгон заржээ. Хадижэ эхийн ач дүү нь болох Хаким бин Хизам Зейдийг 400 дирхэмээр (мөнгөн зоос) худалдан авчээ. Хаким бин Хизам Зейд боолыг Хадижээд бэлэг болгон өгчээ. Хадижэ эх түүнийг Мухаммедэд (салаллаху алейхи уа сальлам) бэлэглэжээ. Мухаммед алейхисальлам Зейдийг боолын үүргээс чөлөөлж, эрх чөлөөт иргэн болгож хажуудаа ажиллуулав. Ягаад гэвэл хэдийгээр эрх чөлөөтэй болсон ч гэсэн Зейдэд очих орон, орох газар байсангүй. Элчээс өөр бүхнээс илүүгээр түүнийг хамгаалж халамжлах хүн байсангүй болхоор Зейд ч дуртайяа тэрний хажууд үлдэв.

Зейд бин Харисе Мухаммедэд (салаллаху алейхи уа сальлам) элчийн үүрэг өгөгдхөөс өмнө үнэнч, шударга байдал, цэвэр ариун явдал, ичимхий зан, хүн бүхэнтэй ижил тэгш харьцаа бас бүх талаараа хүн төрөлхтний дээд нь болсон “Ал

35 Ибн Исхак, Эс-Соре,с, 59-61: Ибн Сагд, эт-Табакет I, 82-85 :Ибн Кесор, эл- Бидэие III, 293-295.

Амин” хочтой Мухаммедийг аав, ээжээсээ ч илүү хайрлаж тэрэнд дасаж түүн шиг болохыг хүсэн хичээж байв.

Зейдийн аав, ээж нь хүүгээ хаана яваа, түүнд юу тохиолдсныг мэдэхгүй байлаа. Харисегийн эцэг нь хүүгээ хайж, маш олон газраар явж сураг ажиг тавьсан боловч эс олов. Емен хотоос өөр хотууд руу явах хамаатан садандаа Зейд хүүгээ захиж сураг ажиг тавиаарай гэж захьдаг байлаа.

Нэг удаа ислам шашин ирхээс өмнө Бени Келб овгоос ариун Каабээд мөргөхөөр очсон мөргөлчидийн нэг нь Зейдийг хараад таньж түүнтэй ярилцахад Зейд: “Эцэг эхэд минь мэндийг минь дамжуулаарай, би сайн байгаа, хэдий гэрээс хол ч энд намайг халамжилж байгаа сайн хүн бий. Тэрнийг Мухаммед гэдэг. Тэр хүн миний ах адил надад хайртай билээ би ч түүнд хайртай” гэж хэлэв. Харисегийн эцэг энэ мэдээг дуулаад маш их баярлаж даруй дүү Кабын хамтаар мөнгө төгрөг аваад Мекке хот руу хөдөлжээ. Меккед ирээд Мухаммедийн гэрийг заалгаж аваад тэднийд очив. “Аяа, Курэйш овгийн дээд болсон Абдулмутталибийн ач хүү минь! Таа нар ариун Каабын хөрш билээ. Та нар ядуусд тусалж олзлогсодыг сулалдаг билээ. Таны боол болох миний хүүг боолын үүргээс суллахын тулд хичнээн мөнгө төлөх вэ?” гэж асуув. Мухаммед “Зейдийг дуудаж тэрэнтэй ярилцая, тэгээд тэрнийг хүсвэл явууля, хэрвээ тэр та нартай буцахыг хүсвэл ямар ч мөнгө төлөлгүйгээр түүнийг аваад буцацгаа. Хэрвээ надтай цуг энд үлдэхийг хүсвэл Аллахын нэрээр андгайлан тангаргалъя, намайг сонгосон хэнийг ч би хөсөр хаяхгүй” гэв.

Харисэ Мухаммедийн (салаллаху алейхи уа сальлам) энэ үгийг сонсоод маш их баярлаж: “Та бидэнд маш шударга хандлаа, танд гялаала” гэв.

Зейд гэрт орж ирхэд Мухаммед алейхисальлам: “Энэ хүмүүсийг чи таних уу?” гэж асуухад Зейд: “Тиймээ, нэг нь миний аав, нөгөөх нь авга ах минь байна” гэв. Мухаммед “Зейд дүү минь, чи энд байх хугцаандаа намайг сайтаар таньж мэдсэн билээ. Тэгээд ч би чамайг энд байхдаа ямар нэг зовлон үзсэн гэж бодохгүй байна. Энэ хүмүүс чамайг авхаар ирсэн байна. Чи сонголтоо хий, нэг бол намайг сонгоод эндээ үлд, эсвэл энэ хүмүүсийг сонгоод гэртээ буц” гэж хэлэв.

Эцэг, ах хоёр нь Зейдийг биднийг сонгох нь дамжиггүй гэж бодож байлаа. Гэтэл Зейд: “Би таныг орхиж хаана ч очихгүй. Та бол (Мухаммед) миний авга ах, бас миний эцэгийн оронд байгаа

билээ” гэв.

Зейдийн эцэг нь машид гайхан алмайрч: “Энэрэлгүй хүү, чамайг чөтгөр аваасай. Тэгэхлээр чи боол байхыг эцэг-эх, ах дүү нараасаа илүүд үзэж байгаа юм биз дээ?” гэж загнав. Зейд эцэгтээ: «Ааваа, би энэ хүнээс маш их үнэт зүйлс сурсан, түүнээс өөр хэнийг ч сонгохгүй» гэв.

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) Зейдийн энэ үгсийг сонсоод баярлан: “Түүнийг Кааб руу авч очоод тэнд байгсадад хандан: “Та бүхэн гэрч болцгоо! Энэ мөчөөс эхлэн Зейд миний хүү. Тэр миний гэрээслэл. Би ч тэрний гэрээслэл билээ” хэмээжээ. Зейдийн эцэг ба ах нь энэ бүхнийг дуулаад соёлгүй зан гаргаж, ууралсан явдалдаа ичиж Мухаммедээс уучлал гуйн, баяр хөөртэйгээр гэртээ буцжээ. Асхаб кирам (анхдагч мусульманууд) Зейдийг Зейд бин Мухаммед (Мухаммедын хүү Зейд) гэж нэрлэжээ. Сүүлд Аллах эзэн Куран сударт Азхаб сүрегийн (бүлэг) 5 ба 40 дэхь аетад (өгүүлбэр): “Үр хүүхдээ эцгээр нь овоглоцгоо. Ингэх нь Аллахын хувьд хамгийн зөв нь. Мухаммед (алейхиссальлам) та нараас ямар ч эрийн (Зейд шиг) эцэг биш билээ” хэмээн зарлигласан. Тийм болхоор Зейдийг эцгийнх нь нэрээр Харисын хүү Зейд гэж овогложээ³⁶.

Ариун Кааб сүмд шүүгч

Энэрэлт элч (салаллаху алейхи уа сальлам) 35 настайдаа Каабын талаарх том маргаанд шийдвэр гаргав. Тэр нэгэн жил үер бууж Каабын хаана хормой нь элэгдэж нуржээ. Тиймд Курейш овгийнхон Каабыг Ибрахим алейхисальламын барьсан суурь хүртэл нь нураагаад, ахин өнгөлж шинээр барьж эхлэв. Отог овог болгон нэг нэг хэсгийг нь барьж, хамтдаа ариун Каабыг (сүм) заваралцгаав. Энэ жилд гар бие оролцох нь маш том аз завшаан гэдгийг ойлгосон овгийнхон “Хажерүл Эсвэд” гэх ариун чулууг байрлуулах дээр зөрчилдөв. Абдуддар хөвгүүд хэмээх овгийнхон “Энэ ажилыг манай л овгийнхон л хийх учиртай, биднээс өөр хэн нэгэн хийхийг завдах юм бол бид тэдэнтэй дайтах болно” гэж ам өчиг өгцгөөв. Энэ маргаан 3-4 хонгоор сунжирч, дайн үүсэх хүртэл хурцадсан байлаа.

Энэ үед Абдулмутталибийн ах нь болох өндөр настан Хузейфэ бин Мүгире: “Хөөе, Курейшийн хөвгүүдээ! Та нар энэ

36 Бухара “Тефсир”, 2: Ибн Сагд, эт-Табакет I, 487.

маргалдааны тайлах шийдвэрийг гаргах хүн бол энэ Каабын чанх өмнө байх Бени Шейбе хаалгаар хамгийн түрүүлж орж ирсэн хүний шийдвэрлэлснээр маргаанаа тасалцгаая” гэв. Тэнд байгсад бүгд зөвшөөрч тэнд байгаа хүмүүс “яха бол” хэмээн дор бүрээ догдолцгоож, тэр хаалгыг харуулдаж эхлэв. Гэтэл тэр хаалгаар хамгаас шударга, үнэнч хэмээн алдаршсан “Ал Амин” (итгэлт хүн) Мухаммед (салаллаху алейхи уа сальлам) ороод ирэх нь тэр. “Ал Амин” ирж байна, бид тэрний шийдвэрийг хүлээн зөвшөөрнө” хэмээн дор бүрээ баярлацгаав.

Болсон явдалыг элч Мухаммедэд (салаллаху алейхи уа сальлам) тайлбарлан ярьж өгхөд тэрбээр нэг томоохон даавуу авч ирүүлхийг хүсэв. Тэр даавууг нь газар дэлгэн тавиад, дээр нь “Хажерүл Эсвэд” ариун чулууг гарган тавиад: “Овог болгоноос төлөөлж нэг нэг хүн гарч ирээд, энэ даавууны өнцгөөс барьцгаа” гэв. Тэгээд чулууг хамтаараа өргөцгөөн тавих газар хүртэл нь аваачаад, өөрөө тэр ариун чулууг тэврэн байрлуулав. Мухаммедийн (салаллаху алейхи уа сальлам) энэ мэргэн ухааныг биширсэн ард иргэд түүнд итгэх итгэл нь улам бүр нэмэгдсэнээр барахгүй гарч болзошгүй цуст мөргөлдөөнийг зогсоожээ³⁷

37 Ибн Исхак, Эс-Сопе,с, 83-105: Ибн Хишам Эс-Сопе I,192-198: Ибн Сагд, эт-Табакет I, 145-147: Ибн Кесир, эл- Бидэе III. 298-305.

БИЕСЕТ (ЭЛЧИЙН ҮҮРЭГ) БА УРИЛГА

Замбуу хорвоогийн аврал нь болсон Мухаммед (саллаллаху алейхи уа сальлам) маань 37 настай байхуйд хаа нэгтэйгээс: “Хөөе, Мухаммед” гэх дуу сонсогддог байв. Хаяа гэрэл туяа харж эхлэх болсноо зөвхөн Хадиже гэргийдээ хэлдэг байжээ. Мухаммед алейхиссальламд элчийн үүрэг ойртох тэр үед тэр үеийн хамгийн алдартай яруу найрагч Кус бин Сайде “Указ” хэмээх сургаалаа уншихдаа элч ирэх цаг ойртосныг мэдэгдэв. Кус бин Сайде энэ алдартай сургаальдаа ийн өгүүлсэн байдаг:

“Аяа, хүмүүс минь, наашаа ойртоцгоо, намайг сонсоцгоо, хүлээцгээ, сургамж авцгаа амьд бүхэн үхэх хувтай, үхэгсэд харин мөнхийг үзнэ... Болох зүйл жам ёсоороо л болно... Намайг анхааралтай сонсоцгоо! Дээд тэнгэрээс ирсэн мэдээ бий. Газарт харин сургамж болох зүйл бий!.. Аллах нэг шашин илгээнэ тэр ариун шашиныг авч ирэх нэгэн элч айсуу... Удахгүй ирнэй. Тэрнийг сонсоцгоо, тэрэнд итгэж, үгийг нь дагацгаа. Түүнийг итгэн дагагчид юутай гэгээн юм бэ? Түүний үгийг эс тоогсод ба эсэргүүцэгчид юутай өрөвдөлтэй. Тэднийг бурхан гэсгээг!..” гэж айлджээ. Энэ сургаалыг сонсогчидын дотор Мухаммед (саллаллаху алейхи уа сальлам) өөрөө байжээ.

Энэ цаг үед Арабын ард түмний харгислал дэндэж адгуусан амьтадаас ч долоон дор болсон цаг байлаа. Хүчтэй нь хүчгүйгээ дээрэлхэн, мал хөрөнгийг булаан авч, садар самуун, шалиг завхай явдал ба ичгүүр сонжуургүй байдал нь газар авчээ. Бүр ч зарим нэгнийх нь хэрцгий бүдүүлэг байдал нь хэрээс хэтэрч төрсөн нялх охиноо амьдаар нь газар булж байв. Нийгэмд эмэгтэй хүний үнэ цэнэ өчүүхэн ч байсангүй, мөнгөөр худалдагдах эд эдгуустай адил байв. Хамгийн аймшигтай нь чулуу шиг хатуу зүрхтэй болсон энэ хүмүүс өөрсдийн гараар бүтээсэн ямар ч үр ашиггүй шавар, модон бурхадыг тахин шүтдэг байв.

Адамалейхисальламаасхойшөдийгхүртэлиймихэндүүрэл бас зэрлэг балмад амьдрал болж байгаагүй билээ. Хүмүүс нэг нэгэнтэйгээ дайсагналцан тэмцэлдэх нь адгуусан амьтнаас ч долоон дор гэмээр... Хүмүүс аз жаргалтай амьдрах надвартай болохын тулд энэ харанхуй бүдүүлэг хорвоог гэрэлтүүлэх нэгэн туяа хэрэгтэй байлаа. Тэр гэрэл туяаны буянгаар үзэл бодолын хуучин ертөнц нэг нэггүй нуран унаж, гэрэлт туяаны өмнө түнэр харанхуй буснин саринах естой байлаа.

Хайрт элчид маань (салаллаху алейхи уа сальлам) гэгээн зүүдээр дамжуулан элчийн үүрэг дөхөж буйг мэдэгдэж байлаа. Тэр үүрэг ойртох тусам “Хөөе, Мухаммед” гэх дуу сонсогдох нь олширсоор байв. Мухаммед (салаллаху алейхи уа сальлам) ч ганцаар байхыг илүүд үзэх болж, Хира уулан дахь нэгэн агуйд очиж Аллахын агуу их сүр хүчний талаар бясалган суудаг байв³⁸.

Анхы уахи (Аллахаас ирсэн мэдээ)

Мухммед (салаллаху алейхи уа сальлам) 40 настай байхад Рамазан сарын 17-ны шөнө дунд Хира уулан дахь нөгөө агуйдаа өөрийн ер бусын ертөнцөөр аялан суухуйд. Түүний нэрийг дуудсан нэгэн дуу гарав. Толгойгоо өргөн эргэн тойрноо хархад ахиад “Мухммед” гэсэн дуу сонсогдов. Гэв гэнэт агуй гэрэл туяагаар дүүрч, өмнө нь Жабрайл (сахиусан тангэр) алейхисальлам ирж “Унш!” гэв. Мухаммед (салаллаху алейхи уа сальлам): “Би уншиж чаддаггүй билээ” гэж хариулхад нь түүнийг тэвэрч аваад маш хүчтэйгээр цээжиндээ шахав. Тэгснээ дахиад “Унш!” гэв. Мухаммед алейхисальлам ахиад: “Би уншиж чаддаггүй билээ” гэхэд нь Мелек (сахиусаан тангэр) түүний цээжийг ахин нэг шахав. Тэгээд “Унш!” гэв. Мухммед урдын хариултаа давтахад нь 3 дахь удаагаа тэвэрч цээжиндээ шахаж тэвэрсний дараагаар: “(Аяа, Мухаммед!) Чамайг бүтээсэн Аллахын нэрээр унш! Тэр хүмүүнийг элгэшсэн цуснаас туурвив. Унш! Аллах эгнэшгүй нийгүүсэлтэй. Тэрээр хүмүүнд мэдэхгүйг нь сургав”³⁹ гэх Алак сүрегийн (зүйл) анхны 5 аетыг (өгүүлбэр) заажээ. Мухаммед элч маань (салаллаху алейхи уа сальлам) түүнийг даган уншив. Аллахын анхны илгээмж ийн ирэв. Хорвоо ертөнцийг гэрэлтүүлсэн Исламын нар ийн мандсан бөлгөө⁴⁰.

Энэ бүх ер бусын явдалд айж бас цочирдсон Мухаммед (салаллаху алейхи уа сальлам) чичрэн дагжиж, Хира уулнаас уруудан уулын бэлд ирхэд нь Жабрайл сахиусан тэнгэр: “Аяа, Мухаммед чи Аллах эзэний элч мөн, би бол Жабрайл мелек (сахиусан тангэр) байна” гэж хэлээд тохойг нь газар цохиход тэр газраас ус ундрэн гарч эхлэв. Жабрейл алейхисальлам угаал хийж эхлэв. Энэ бүхнийг Мухаммед элч маш нухацтай

38 Ибн Хишам Эс-Сопе I,233-240.

39 эл-Алак 96/0-5.

40 Ибн Сагд, эт-Табакет I, 196.

харж зогслоо. Жабрайл мелек угаал үйлдэж дуссаны дараагаар Мухаммедийг ч гэсэн тэгэж угаал үйлд гэж хэлэв. Ийнхүү Мухаммед угаал үйлдэж дуссаны дараагаар Жабрайл мелек Имам (урьдатгал хамба) болж Мухаммед (салаллаху алейхи уа сальлам) даган 2 рекать (үе) мөргөл үйлдэв. Энэний дараагаар Жабрайл мелек “Аяа, Мухаммед! Эзэн чинь ганц. Чамд мэнд хүргэж байна” гээд, «Чи бол бугууд ба хүн төрөлхтөнд илгээсэн элч минь билээ. Тийм болхоор тэднийг одооноос эхлэн зөв зам руу хөтөл» хэмээн айлдлаа гэж дамжуулав. Тэгээд тэнгэр өөд нисэн одов. Ийнхүү Жабрайл мелекийг харж, бас тэрэнтэй ярилцав.

Мухаммед элч гэртээ хүрэх хүртлэх замд таарсан чулуу, мод болгон “Эссаламун алейкум, яа, Расулуллах (амар амгаланг эрье, аяа, Аллахын элч минь ээ)” хэмээн мэндэлж байхыг сонсов. Гэртээ ирээд, гэгээн Хадиже эхэд “намайг сайтар хуч! Намайг хучаач” гэж хэлэв. Тэгэд айдас хүйдэс нь арилтал унтаж амрав. Тэгээд сэрснийхээ дараагаар үзэж харсан бухнээ Хадижед хэлэв. “Жабрайл мелек хэдий алга болсон ч түүний сүр жавхаа, ширүүн дүр төрх одоо болтол харагдаад байна” гэв. Эрт орой энэ бүхэн болох байсныг мэдэж байсан, хүлээж ч байсан Хадиже эх “Аллах чамайг хамгаалаг. Эзэн тэнгэр чамд зөвхөн сайн сайханийг хүсдэг билээ. Аллахын нэрийг барьж андгайлъя, чи бол Аллахын илгээсэн элч билээ” гэжээ.

Энэ болсон явдалыг тодруулхаар мэргэн ухаантан Варака бин Невфел рүү очицгоов. Мухаммедийн (салаллаху алейхи уа сальлам) ярьсан бүхнийг анхааралтай сонсож дууссаны дараагаар Варака: “Баяр хүргэе, чамд Мухаммед элч минь, Аллахын нэрээр андгайлъя, чи бол Иса алейхисальамын өгүүлсэн сүүлчийн элч мөн. Чам дээр ирсэн тэр Мелек (сахиусан тангэр) бол Жабрайл (алейхиссальлам) мөн. Хэрвээ би залуухан байсан бол Мекегийн буруу номтонууд чамайг үгүйсгэх цагт чамд тусалсансан бол! Чи удахгүй шашинаа түргээж, бас Аллахын ариун шашины төлөө дайтах үүрэг авах болно” гэжээ. Тэгэд Мухаммедийн (салаллаху алейхи уа сальлам) ариун гарыг нь хүндэтгэлтэйгээр үнсэн нэг их удалгүй нас баржээ⁴¹.

41 Ибн Исхак, Эс-Соре,с, 140-142: Ибн Хишам Эс-Соре I,139-140: Ибн Сагд, эт-Табакет I, 129,194-195: Касталано, эл- Мэвэхибүл-Энбие,с, 48.

Шашин түгээх ариун үүрэг авсан нь

Ийнхүү хайрт пайгамбард маань (салаллаху алейхи уа сальлам) анхны зарлиг болсон элчийн үүрэг өгөгдсөний дараагаар гурван жил ор сураггүй болов, өөрөөр хэлвэл, Аллахаас ямар нэгэн мэдээ ирсэнгүй. Энэ хугацаанд Исафил сахиусан тэнгэр ирж зарим зүйлийг зааж сургав. Мухаммед машид айж түгшин, хааяа уйлдаг байв. Тэрнийг ингэж зовж байгаа үед Жабрайл (алейхиссальлам) мелек ирж “Аяа, Мухаммед! Чи Аллахын элч мөн” хэмээн аргаддаг байлаа. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) Аллахын илгээмж ирхээ больсон жилүүдэд нэгэн өдөр Хира уулнаас бууж явахдаа нэг сонин дуу сонсов. Толгойгоо өргөн тэр зүг рүү харваас Жабрайл алейхисальлам газар тэнгэр хоёрын хооронд нэгэн сандал дээр суугаад түүн рүү харж байлаа. Тэр айсандаа гэртээ үтэр түргэн очоод хөнжилдөө орон, өөрийгөө хучин хэвтэхэд Аллах түүн рүү мэдээ илгээв: “Хөөе, өөрийгөө хучин хэвтээ элч, бос! (Ард түмнээ Аллахын цээрлэлээр) айлга! (хэрвээ итгэн сүсэглэхгүй бол, гэсгээл хүртэх болно гэж хэл) эзнээ магтан дуул! Хувцас хунраа цэвэр байлга” хэмээн айлдсан Мүддесир сүрегийн (бүлэг) анхны аетүүдийг айлдаж эхэлсэнээс хойш уахи (мэдээ) ахиж тасраагүй билээ.

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) хүмүүсийг Ислам шашинд уриалан дуудаж Аллахын зарлигийг түгээж эхлэв. Жабрайл мелек нь заримдаа хүний төрхтэй болж ирдэг ба заримдаа асхабуудын (анхдагч мусульман) дотроос Дихе-и Келбийн дүрд орж ирдэг байлаа. Заримдаа Мухаммедын (салаллаху алейхи уа сальлам) зүрхэнд шууд ойлгогдодог байлаа. Ийнгэхэд Пайгамбар (элч) Жабрайл алейхисальламыг хардаггүй байлаа. Заримдаа зүүдэнд нь заримдаа маш их нүргэлсэн чимээтэйгээр ирж уахийг (мэдээг) дамжуулдаг байв. Ийнхүү дуу чимээтэй ирж мэдээг дамжуулах нь Мухаммедэд маш хэцүү байдаг агаад унаж явсан тэмээ нь хүртэл газар сөхөрдөг байлаа. Жабрайл(алейхисальлам) мелек хэд хэдэн удаа өрийн жинхэнэ дүр төрхөөрөө ирж мэдээг дэмжуулсан билээ.

Аллахын элч заримдаа мелекгүйгээр, ямар нэгэн хөшиг хөлхөвчгүйгээр элчид мэдээг хүргэжээ. Энэ явдал Мираж шөнө болжээ.

Анхны мэдээг авсан цагаас хойш элчийн үүрэгт ажилаа эхэлсэн Мухаммедын (салаллаху алейхи уа сальлам) Ислам

шашиныг түгээх ажил нь 23 жил үргэлжилжээ. Үүний 13 жил нь Мекке хотод, 10 жил нь Медине хотод үргэлжилжээ.

Куран судар 22 жил, 2сар, 22 хоногт бүрэн илгээгджээ.

Мухаммед (салаллаху алейхи уа сальлам) нь бичиг үсэг тайлагдаагүй нэгэн байсан ба уншиж бичих нь бүү хэл хэнээр ч хичээл заалгаж байгаагүй нэгэн билээ. Тийм байтал Таврат, Инжил сударууд бас Грек, Ромын хаант гүрний ном түүхийг ярьдаг байсан нь гайхалтай. Исламыг түгээхийн тулд Грэк, Ром, Ираны хаант улс руу бас Арабын зарим хаад ноёдруу захидал илгээж байв. Энэ талаах Куран сударт: “Чи энэ Куран Керим ирхээс өмнө ямар нэгэн ном ушиж, бичиж үзээгүй билээ хэрвээ чи ушиж, бичиж чаддаг байсан бол чамайг өөр бусдаас сурсан гэж хэлэх байсан”⁴² хэмээн айлдсан байна.

Хадис шарифт (Мухаммедын сургааль): “Би бичиг үсэг тайлагдаагүй Мухаммед билээ. Надаас хойш Пайгамбар (элч) гэж үгүй билээ”⁴³ хэмээжээ. Куран сударт бас ийн айджээ: “Тэрбээр (Мухаммед) өөрөө ярьж байгаа бус түүний үг яриа болгоныг нэгэн илгээлтээр түүнд зааж байсан билээ”⁴⁴

Анхны мусульманууд

Аугаа элчид анхны уахи (мэдээ) ирсэний дараагаар түүнд итгэн дагагч анхны мусульман бол гэгээн Хадиже эх юм. Огт эргэлзээгүйгээр Ислам шашиныг хүлээн зөвшөөрснөөр анхдагч болон нөр их буян хураажээ. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) Хадижед Жабрайлын түүнд заасан адилаар угаал хэрхэн үйлдхийг заан өгчээ. Дараа нь элч маань Имам (урьдатгал хамба) болон хоёул хамтаар хоёр рекать мөргөл үйлджээ. Хадиже эх элчийн хэлсэн заасан үг болгоныг огт эсэргүүцэлгүйгээр даган мөрддөг байснаар Аллах эзэний хувьд өндөр зэрэгт хүрчээ. Элч маань гомдох цагт тэрнийг үгүйсгэгчидийн доромлолд шоглуулж, сэтгэл санаа нь уймрах цагт элчийг аргадаж, ганцаардах үед хань түшиг нь болдог байлаа. Тэгээд: “Аяа, Аллахын элч минь, битгий гомд санаа бүү зов, эцэсийн эцэст манай шашин хүчирхэгжиж, үл итгэгсэд алга болно. Чиний овгийнхон чамд хүчин зүтгэх болно” гэдэг байв. Хадиже эхийн энэ тус Мухаммедед (салаллаху алейхи уа сальлам) маш том сэтгэлийн дэм түшиг болдог байлаа. Нэг

42 эл-Анкебут 29/48.

43 Хейсэмо, Межмагуз-Зевайд I, 125.

44 эн-Нежим 53/3-4.

өдөр Жабрайл алейхисальлам ирж “Аяа, Мухаммед, Хадижед Аллах эзэн мэнд хүргэж байна” гэв. Мухаммед элч: “Хадиже минь, дөнгөж сая Жабрайл мелек ирж Аллахын мэндийг чамд дамжууллаа”⁴⁵ гэв.

Пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) нэг удаа: “Аллах эзэн надад диваажинд эрдэнэсийн чулуугаар Хадижед зориулж ордон барьсан гэж айлдаж билээ. Тэнд өвчин зовлон, гай гамшиг гэж үгүй билээ” гэж айлджээ.

Насанд хүрсэн хүмүүсээс анхдагч мусульман эрэгтэй бол Мухаммедын (салаллаху алейхи уа сальлам) үнэнч найз Эбү Бакир юм. Эбү Бакир 20 жилийн өмнө нэгэн зүүдэнд нь “тэнгэрт байх бүтэн сар Каабын дотор унаж хэдэн хэсэг хуваагдан, тэр хэсгүүд нь Мекке хотын гэр болгоны дээр очин гэрэлтүүлж, дара нь энэ хэсэг бүрэн нь бүгдээрээ нийлж ахин сар хэвэндээ ороод тэнгэр өөдөө хөөрч байх юм гэнэ. Харин Эбү Бакир гэрт нь ирж гэрэлтүүлсэн сарны хэлтэрхийн хөөрөөгүйгээр барахгүй Эбү Бакир түүнийг гаргахгүйн тулд хаалга цонхоо хааж байна” гэж зүүдэлжээ.

Эбү Бакир нойрноосоо сэрээд өглөө болонгуут даруй жүүдийн эрдэмтэд рүү гүйн очиж зүүдээ тайлуулав. Тэр эрдэмтэн хүн “Энэ бол зүгээр л нэг зүүд байна, тайлж тайлбарлах шаардалгагүй” гэж хэлэв. Гэвч Эбү Бакир энэ зүүдээ хэзээ ч мартаж чадахгүйгээр барахгүй зүүд биелэх тэр өдөрийг хүлээж байлаа. Наймаа арилжаанд явах замдаа Бахира нэртэй жүүд мэргэн ухаантай пастр, христийн сүмийн хамба ламтай уулзаж. зүүдэлсэн зүүдээ хэлж өгчээ. Бахира “Чи хаанхын хүн бэ?” гэж асуухад нь Эбү Бакир “Би Курейш овгийн хүн байна” гэв. Бахира: “Тэр овгоос нэгэн элч гарах ёстой ба түүний түгээх шашины туяа нь Мекке хотыг гэрэлтүүлэх болно. Чи харин амьд ахуйдаа түүний түшмэл нь болно. Харин түүнийг нас барсны дараагаар залгамжлагч нь болно” гэв. Гэгээн Эбү Бакир энэ ярьсан бүхэнд маш их гайхжээ. Энэ зүүдээ ч гэсэн Мухаммедыг (салаллаху алейхи уа сальлам) элч болон тодрон гарах хүртэл хэнд ч хэлээгүй хадгалжээ.

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) өөрийгөө элч болсноо зарлахад нь Эбү Бакир тэр даруй Мухаммедын гэр лүү нь хар хурдаараа гүйн очоод: “Элчүүдийн дээд болох хүнд элчийн нотолгоо байдаг билээ. Чиний нотолгоо чинь хаана
45 Хүким,эл-Мүстедрак III.206:Ибн Хишам Эс-Сопе I, 241: Сүхейл , эр-Равзүл-Үнф.с.II, 416.

байна?” гэв. Мухаммед элч: “Миний нотолгоо бол чиний зүүд билээ. Чи энэ зүүдээ эхлээд нэг жүүдэд тайлуулхад “зүгээр л нэг зүүд” гэсэн. Дараагаар нь Бахира хэмээх нэгэн эрдэмтэнд очиход тэр хүн зөв тайлж өгөөгүй бус уу?” гэв.

Энэ бүгдийг нүдээр үзэж чихээрээ сонссон Эбү Бакир: “Би андгайлан тангаргалж байна. Аллахаас өөр бурхан үгүй, чи бол Алладын элч мөн” гэж хэлээд мусульман болов⁴⁶.

Амьдралдаа хэзээ ч амсаж байгаагүй тийм их баяр баясгалантайгаар гэртээ мусульман болоод харьжээ. Нэгэн хадис шерифт (Мухаммед элчийн сургааль үг): “Хэн нэгэнд иманыг (исламын итгэл) зааж байхад нүүрэнд нь болгоомжлох ба гээнгэлзэх сэтгэл төрж байгаа нь илт байдаг. Харин Эбү Бакир Сиддик исламыг хүлээн зөвшөөрөхдөө огтхон ч эргэлзээгүйгээр барахгүй шууд зөвшөөрсөн” хэмээжээ.

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) нэг өдөр гэгээн эх Хадижегийн хамтаар намаз (мөргөл) үйлдэж байхад нь балчир хүү Али тэднийг харжээ. Али тэр үед 12 настай хүү байлаа. Тэднийг намазаа (мөргөл) дууссаны дараагаар “Та нар юу хийсэн юм бэ?” гэж асуув. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам): “Энэ бол Аллах эзэний шашин юм. Чамайг ч бас дуудаж байна. Аллах бол цор ганц бас туслагч, хамтрагч гэж түүнд байхгүй. Агуа Аллахд итгэн биширхийг хүсэж байна” гэв. Гэгээн Али: “Би энэ талаар эхлээд аавтайгаа нэг зөвлөлдье” гэв. Мухаммед: “Хэрвээ Ислам шашинд орохгүй бол хэнд ч битгий хэлээрэй” гэв. Маргааш өглөө нь Али Мухаммедын (салаллаху алейхи уа сальлам) өмнө ирж: “Аяа, Алладын элч, надад Исламыг заагаач” гэж хэлээд мусульман болжээ. Ийнхүү гэгээн Али мусульман болсон гурав дахь хүн нь байлаа⁴⁷.

Бас анхны мусульмануудын нэг бол Зейд бин Харис юм. Энэ хүн 4 дэхь мусульман билээ. Суллагдсан боолуудаас хамгийн анхны мусульман болсноор барахгүй, өөртэй нь цуг эхнэр Үмму Емен ч мусульман болжээ⁴⁸.

Гэгээн Эбү Бакир мусульман болонгуутаа өөрийн дотны найз нар луугаа очлоо. Тэднийг ч мусульман болцгоо гэж ятгаж эхлэв. Асхабуудын (анхдагч мусульманууд) хамгийн алдартай: Осман бин Аффан, Талха бин Убейдуллах, Зүбэйр бин Аввам, Абдуррахман бин Авф, Саад бин Эби Уаккас гэх мэт овгийнхоо

46 Ибн Исхак, Эс-Соре,с, 120-121; Ибн Хишам Эс-Соре I,249-250.

47 Ибн Исхак, Эс-Соре,с, 118; Ибн Хишам Эс-Соре I,245-247.

48 Ибн Хишам Эс-Соре I,247-248.

тэргүүнүүдийн нэг болсон энэ хүмүүс дараа дараалан ислам шашинд орцгоов. Гэгээн Хадиже эхийн дараах мусульман болсон энэ 8 хүнийг “Сабикун-и ислам” ба анхдагч мусульманууд гэдэг.

Гэгээн Осман мусульман болсоноо ийн хүүрнэж байна: “Миний эмээ мэргэ төлөгч хүн байсан билээ. Би нэг өдөр түүний мэндийг мэдхээр очив. “Чи нэг бүсгүйтэй гэрлэнэ, тэр бүсгүй чамаас өмнө ямар ч эртэй ойртоогүй, чи ч гэсэн тэрнээс өмнө ямар ч эмтэй ойртоогүй байх болно. Тэр бүсгүй царайлаг бас ухаалаг хүн. Түүний эцэг нь бурханы элч юм байна” гэв. Би эмээгийнхээ энэ үгийг гайхан суув. Гэтэл эмээ үгээ цааш нь үргэлжлүүлэн: “Элч ирсэн, түүнд тэнгэрээс мэдээ ирж байгаа” гэв. Би: “Эмээ минь! Ийм зүйл хотод огт дуулагдаагүй шүү дээ, үгээ тодорхой болгооч” гэхэд минь эмээ: “Абдуллахын хүү Мухаммедэд элчийн үүрэг өгөгдсөн, үнэн шашинийг номлож эхэлсэн. Удахгүй түүний шашиний туяагаар дэлхий гэрэлтэж эхлэх ба эсэргүүцэгчидийн толгой нь цавчигдах болно” гэв.

Эмээгийн ярьсан бүхэн намайг машид гайхшруулсан. Би энэ талаар бодохгүй байж чадахгүй байлаа. Гэгээн Эбү Бакир бид хоёр үй зайгүй сайн найзууд байсан билээ. Тэгээд 2 хоногийн дараа найзтайгаа зөвлөлдхөөр шийдэв. Эбү Бакирийн гэрт нь очиход намайг хүндэтгэлтэйгээр хүлээж авлаа. Би эмээгийнхээ ярьсан бүхнийг нэг нэгэнгүй түүнд хэлхэд тэр надад: “Аяа, найз минь, чи бол ухаантай хүн билээ. Огт үзэж хараагүй бас сонсоогүй нэг зүйлд, бас тус дэм хүргэж чаддаггүй хоосон зай эзэлсэн хэдэн чулуу (шавар бурхад) яахан бурхан болох юм бэ?” гэхэд нь би: “Тийм ээ, чиний зөв, эмээ маань үнэн хэлжээ” гэлээ.

Гэгээн Эбү Бакир Османд исламыг ойлгуулсаны дараагаар түүнийг хүн төрөлхтөн ба бугуудын элч нь болсон Мухаммедэд (салаллаху алейхи уа сальлам) дагуулан бараалхав. Элч (салаллаху алейхи уа сальлам) Османд хандаж: “Аяа, Осман! Аллах эзэн чамайг диважинд зочилхыг урьж байна. Чи энэ урилгыг хүлээн ав. Би бүхий л хүмүүн төрөлхтөнийг зөв зам руу нь хөтлөгч болон илгээгдсэн билээ” гэв. Гэгээн Осман элчийн гэгээн царай, сайхан яриа нь ер бусын байсан болхоор өөрийн эрхгүй нүднээсээ баярын нулимас дуслуулан байж “Эшхэдү эн лээ илааха иллаллахү, вэ эшхэдү анна Мухаммедэн абдүхү вэ расүүлүхү (Би Аллахаас өөр бурхан үгүйг гэрчилнэ, би бас Мухаммед түүний элч нь бас боол нь мөн болохыг гэрчилнэ.)” гэж хэлээд мусульман болсон юм.

Аллахын элч маань (салаллаху алейхи уа сальлам) эхний 3 жил хүмүүсийг нууцаар ислам шашинд уриалж байв. Хүмүүс ч аяаар аяаархан мусульман болж байлаа. Энэ 3 жилийн дотор дөнгөж 30 хүн л ислам шашинд оржээ. Тэд намазаа (мөргөл) гэртээ үйлддэг ба Куран керимийн (судар) аетийг (өгүүлбэр) нууцаар уншиж цээжилдэг байв.

Хамаатан саднаа исламд уриалах нь

Аллахын элч маань (салаллаху алейхи уа сальлам) Мүддессир сүрег (Кураны нэг бүлэг) хүлээж авсныхаа дараагаар хүмүүсийг шашинд уриалан дуудаж эхэлжээ. Энэ ажилаа ч нууцаар хийж байлаа. Хэсэг хугацааны дараагаар: “Хамаатан саднаа Аллах эзэний гэсгээлээр айлган тэднийг шашиндаа дууд”⁴⁹ гэсэн зарлиг буув. Ингээд Мухаммед (салаллаху алейхи уа сальлам) бүх хамаатан саднаа шашиндаа дуудахын тулд гэгээн Алиг явуулан Эбу Талибын гэрт цуглуулав. Тэдний өмнө нэг хүнд хүрэлцхүйц нэг таваг хоол бас нэг аяга сүү тавив. Эхлээд “Бисмиллах (Аллахын нэрээр эхэлнэм)” гэж хэлээд хоолноос амсаад, дараа нь хамаатнууддаа “Зооголцгоо” гэв. Цугласан хүмүүс 40 хүн байсан ч тавьсан хоол нь бүгдэнд нь хүрэлцэснээр барахгүй бүгд хантлаа цадацгаав энэ гайхмаар зүйлийг харсан тэд юу гэж хэлхээ ч мэдэхгүй алмайрцгаав. Хоол идэж дууссаны дараагаар Мухаммед (салаллаху алейхи уа сальлам) ах дүү нартаа хандан үгээ эхлэх гэж байтал авга ах Эбу Лехеб гэнэт атаархан: “Бид урьд өмнө ийм сонин илбэ үзэж багаагүй билээ. Энэ дүү маань таа бүхний нүдийг хуурч илэблэсэн байна. Дүү минь, би чиний хийсэн шиг ийм муухай зүйл хийж байсан хүнийг үзээгүй билээ” гэж хараан, бас гутаасан үгсээр түүнийг доромжлов.

Мухаммед (салаллаху алейхи уа сальлам) Эбу Лехебд: “Курейш овгийнхон, бас бүх Арабуудын үл хийж чадах хорлолыг чи надад хийлээ” гэв. Ингээд хэн ч мусульман болохгүй тарцгаав. Энэ явдлаас хойш хэсэг хугацааны дараа төрлүүдээ ахин дуудаж цуглуулав. Урдийн адил тэднийг хоолоор дайлсны дараагаар пайгамбар маань босож: “Бүхий л магтаал сайшаал зөвхөн Аллах эзэнд зохилтой, зөвхөн түүнээс тус дэм гуйнам би. Түүнд итгэн түүнийг түшгэлнэм. Үнэнээсээ мэдэж, бас та бүхэнд мэдэгдье,

Аллахаас өөр бурхан үгүй билээ, тэрбээр цор ганц бөгөөд түүний хань ижил үгүй билээ” гэж хэлээд үгээ цааш үргэлжлүүлэн “Та бүхэнд хэзээ ч худлаа ярихгүй, чин үнэнийг хэлэе... Та бүхнийг цор ганц Аллах эзэнд итгэн бишрэхийг би уриалж байна. Би бол түүний (Аллахын) та бүхэнд хийгээд бүх хүн төрөлхтөнд илгээсэн элч мөн. Аллахын нэрээр андгайлъя, та бүхэн унах адил үхэцгээх болно. Бас нойрноосоо сэрэх адил амилах болно. Бас бүхий л хийсэн үйлийнхээ төлөө шүүгдэж, сайхан үйлийнхээ төлөөс болгон өлзий хишиг, муу үйлийнхээ төлөөс болгон гэсгээл хүртэх болно. Энэ нь диваажинд мөнх үлдэх ба тамд үлдэхийн нэр юм. Хүмүүсээс хойд ертөнцийн гэсгээлийн талаар анх айлгаж байгаа хүмүүс минь та нар билээ”

Эбү Талиб энэ үгийг соссоныхоо дараа “Аяа, хүндэт авга дүү минь, чамд туслах бол миний хамгийн нэр хүндтэй үүрэг мөн. Хэлсэн бүх зүйлийг чинь хүлээн зөвшөөрч байна. Одоо энд цуглагсад өвөө чинь болсон Абдулмутталибын хүүхдүүд, би ч мөн адил тэдний нэг, чиний даалгасан ажилд хамгийн түрүүнд би гүйдэг билээ. Чамайг ямар ч үнээр хамаагүй хамгаалхад хэзээд бэлэн гэдгээ өчиг. Чи чамд л зарлигласаны дагуу шашинаа түгээ. Гэвч миний хувьд бол хуучин шашинаасаа салж чадахгүй нь” гэв.

Эбү Лехебээс бусад бүх ах нар нь зөөлхөн ярьцгаав. Харин Эбү Лехеб: “Хөөе, Абдулмутталибын хүүхдүүдээ, бусад хүмүүс энэний (Мухаммед) гараас хөтлөлцөн төвөг учруулхаас өмнө та нар түүнийг тогтоо, хэрвээ өнөөдөр түүний хэлсэн бүхнийг та бүхэн хүлээн зөвшөөрөх юм бол маш их уй гашуу бэрхшээлтэй учирах болно. Түүнийг хамгаалхыг завдсан хэн ч миний гарт үхэх болно” гэж заналхийлэв. Эбү Лехебийг эсэргүүцэх Мухаммедын авга эгч нь босож “Хөөе, дүү минь! Дүүгийн минь хүү болох Мухаммедын авч ирсэн шашинд эс туслах нь чамд зохино гэж үү? Аллахын нэрээр андгайлъя, өнөөг хүртэл амьдарч байсан бүх эрдэмтэн мэргэд Абдулмутталибын үр саднаас нэгэн хүн элч болно гэж хэлдэг байсан билээ. Тэр элч нь одоо энд зогсож байна” гэв.

Эбү Лехеб нөгөө л муу муухай үгээрээ дайрч доромжлон байхуйд Эбү Талиб Эбү Лехебд уурлан: “Хөөе, аймхай минь! Бид амьд байх хугацаандаа түүнд туслаж, түүнийг хамгаалах болно” гээд Мухаммед элчид (салаллаху алейхи уа сальлам) хандан: “Авга дүү минь! Чамайг шашинаа номлох тэр цагийг бид мэдэж

авая, тэр үед зэвсгээ авах чамайг хамгаалхын тулд хамт зогсоё” гэв. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) ахин босож: “Хөөе, Абдулмутталибын хөвгүүдээ, андгайлан хэлье, Арабуудын дундаас миний та бүхэнд айлдсан шиг энэ хорвоо хийгээд хойд насанд тань хамгийн хэрэгтэй зүйлээс (ислам шашин) илүү дээд, бас илүү буяныг авч ирсэн хүн үгүй билээ. Би та бүхнийг хэлэх нь хялбар, дэнсэлх нь хүнд болсон хоёр өгүүлбэрийг хэлээсэй гэж хүсэж байна. Энэ үг бол: “Аллахаас өөр бурхан үгүй бас би бол түүний боол нь бөгөөд элч нь мөн” гэж гэрчилцгээх явдал юм. Аллах эзэн та бүхнийг энэнд (ислам) дуудахыг надад зарлиг болгосон юм. Тийм болохоор хэн чинь энэ урилгийг хүлээж авмаар байна?” гэв. Хэн ч дуугарсангүй, бүгдээрээ чив чимээгүй толгой гудайлган бодлогширон сууна Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) энэ үгээ 3 удаа давтан хэлэв. Ингэж хэлэх болгонд гэгээн Али хөл дээрээ босон байснаа гурав дахь удаад нь: “Аяа, Аллахын элч минээ! Хэдийгээр энд байгсадаас насаар хамгийн бага нь ч гэлээ чамд би туслах болно” гэв. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) машид баярлан Алигийн гараас нь барив. Харин бусад нь юу ч дуугарсангүй таран одоцгоов.

Аллахын хайрт элч Мухаммед (салаллаху алейхи уа сальлам) хамаатан саданыхаа энэ хөндий цэвдэг байдалд нь маш гомдсон ав ч шантралгүйгээр тэднийг тамын гэсгээлээс хэлтрүүлэн, аз жаргалд аваачих ислам шашиндаа дуудхаа зогсоосонгүй.

Элч болсон дөрөв дэхь жилд Аллахаас ийн зарлиг ирэв: “(Аяа элч минь) чамд зарлигласан зүйлийг (зарлиг ба цээрлэл) тайлбарла, шудрага үнэн ба худал хуурмаг хоёрыг ялган салга, мүшрикүүдээс нүүр буруул! (тэдний үгийг бүү тоо)” (Хижр сүре, 94). Аллахын элч Мекке хотынхныг нууцаар биш ил тодоор шашиндаа уриалан дуудаж эхлэв. Нэг өдөр Сафа толгодод гарч: “Аяа, Курейш ард түмэн ээ! Наашаа ойртож намайг сонсоцгоо” гэв. Хүмүүс цугласны дараа: “Хөөе, хүмүүсээ! Та нар намайг худал хэлж байхыг ер сонссон уу” гэв. Тэд бүгдээрээ “Үгүй, сонсоогүй” гэгцгээв. Дараа нь үгээ үргэлжлүүлж: “Аллах тэала надад элчийн үүрэг өгч намайг та нарын дотор элч болголоо” дараа нь “Аяа, хайрт элч минь! Тэдэнд ингэж хэл: “Хөөе, хүмүүсээ! Би бол таа бүхэнд бүгдэнд чинь ирсэн Аллах эзэний элч байна. Тэр бол тэнгэр газрын эзэн юм, түүнээс өөр юунд ч залбирах ёсгүй. Бүхий л амьтадыг алж бас амьдруулдаг нь Аллах юм...” гэсэн

Аграф сүрегийн 158-аетыг уншив. Тэнд байгсад дунд зогссон Эбү Лехеб уурлан: “Дүүгийн маань хүү, (Мухаммед) солиорсон байна. Бидний бурхадад үл итгэсэн бидний, шашинаас гарсан хүний үгийг битгий сонсоцгоо” гэж хараалын үг хэрэглэн орилов. Тэнд цугласан хүмүүс тарааж хэн ч шашинд орсонгүй. Мухаммед (салаллаху алейхи уа сальлам) шударга бас сайхан сэтгэлтэй нэгэн болохыг мэдсээр байж нүүр буруулцгаав, бас дайсан болцгоов.

Нэг өдөр Аллах эзэн “Чамд зарлигласан зүйлийг (зарлиг ба цээрлэл) ойлгуул” гэв. Мухаммед (салаллаху алейхи уа сальлам) ахин Сафа ууланд гарч, чанга бас баргил хоолойгоор: “Хөөе, хүмүүсээ, наашаа ирцгээ, цуглацгаа, та бүхэнд хэлэх чухал зүйл байна” ⁵⁰гэв. Энэ дууг сонссон хүмүүс гүйлдэн ирцгээв. Ирж чадахгүй хүмүүс юу гэхийг нь сонсоод ир гэж хүмүүсээ явуулав. Мухаммед: “Аяа, Курейшийн ардаа” хэмээн яриагаа эхлэв. Бүх хүмүүс тэрнийг анхааралтайгаар сонсож байв. “Би, миний байдал бол ирж буй дайснийг хараад гэр бүлдээ очиж, аюулыг хэлэхийн тулд гүйж яваа нэгэн шиг, дайсан ирхээс урьтан гэр бүлээ авархаар «Яа, Сабахах!(анхаар дайсан ирж явна)» хэмээн орилан буй нэгний адил юм. Аяа, Курейшийн ард минь! Би та нарт “Энэ уулны цаана дайсны цэрэгүүд байна, тэд удахгүй наашаа дайтхаар зэхэж байна” гэж хэлвэл та нар надад итгэх үү?” гэв. Тэд цөмөөрөө “Тийм ээ, итгэнэ, чи өдийг хүртэл худлаа хэлэж үзээгүй билээ” гэгцгээв.

Мухаммед (салаллаху алейхи уа сальлам) бүхий л Курейш овгийнхоны нэрийг дуудаж: “Хөөе, Хашимын хөвгүүд ээ! Хөөе, Абдуменаф хөвгүүд ээ! Хөөе, Абдулмутталибын хөвгүүд ээ! гэх мэтээр нэг нэгээр нь нэрлэж, «Би бол ирээдүйд нүгэлтэнүүдэд ноогдох гэсгээлийн аюулыг айлдагч билээ. Аллах эзэн надад хамгийн ойр дотоний хамаатануудаа хойд ертөнцийн гэсгээлээр айлгахыг зарлигласан билээ. Таа бүхнийг «Лаа илаха иллаллаху, вахдаху лаа шарийкалах (Аллах ганц, түүнээс өөр бурхан үгүй) гэж итгэн сүсэглэхэд (иманд) дуудаж байна. Би бол түүний боол бас элч мөн. Хэрвээ энэ бүхэнд итгэх юм бол диваажинд орох болно. Та нар «Ла илаха иллаллах» гээгүй цагт би та нарт энэ хорвоод ч хойд насанд ч тус эс хүргэж чадна” гэв. Тэдэн дунд байсан Эбү Лехеб “Ийм юмний төлөө биднийг дуудаа юу?” гэж хэлэн газраас чулуу авч Мухаммед рүү (салаллаху алейхи уа

сальлам) шидэв. Бусад нь юу ч хийгээгүй ч гэсэн исламд оролгүй тарцгаав⁵¹.

Нарыг баруун гарт минь атгуулсан ч...

Хайрт элч маань (салаллаху алейхи уа сальлам) хаана бөөн цугласан хүмүүс үзэх үү, үгүй юу тэнд очиж ислам шашиныг ярьдаг байлаа. Жинхэнэ хойд насны жаргал бол нафист (ин, хүний муу муухай хүсэл, ташаалд) хөтлөгдөхгүй байж нүгэл хийхгүй шударга бусаас, ер нь бүхий л муу зүйлээс хол байж Аллахд итгэн амьдрах явдал мөн гэдгийг ойлгуулхыг хичээж байлаа. Харгислал дээрэнгүй үзэлд автагсад бас нүглийн эзэд болсон хүмүүс Мухаммедыг (салаллаху алейхи уа сальлам) шууд эсэргүүцдэг байв. Энэ бүхий л бузар булай ажилууд нь зогсож алга болох юм шиг санагдангуут Мухаммед алейхисальламын хэлсэн ярьсан болгоныг үгүйсгэж, түүнд итгэсэн хүмүүсийн дайсан нь болож хувирч байв.

Эхлээд мүшрикүүд (буруу номтон) Мухаммедыг (салаллаху алейхи уа сальлам) доромжилж, шоглодог байсан бол, яваа явандаа түүнийг зогсоохын тулд юу ч хийхээс буцахгүй байлаа. Элчийг шашинаас нь гаргаж, исламын гэрэл гэгээг нь унтраахыг хүсэж байлаа. Ийм зорилготой хүмүүсийн толгойлогчид нь Эбү Жахил, Утбэ, Шейбэ, Эбү Лехеб, Утбэ бин Эбу Муайт, Ас бин Вайл, Эсвэд бин Муттулиб, Эсвэд бин Абди Йагвес, Эсвэд бин Мугире нар... юм.

Нэг өдөр Утбэ, Шейбэ, Эбү Жахил гурав Эбү Талибт: “Та бол бидний дундаас хамгийн ахмад нь. Тийм болохоор бид таныг үргэлж хүндэлдэг билээ. Таны дүүгийн чинь хүү (Мухаммед) шинэ шашин гарган номлож байна. Бидний бурхадыг хараад “буруу номтон” гэж байна. Тиймээс та тэрнийг энэ үйлдлээ зогсоо гэж хэл, хэрэв тэр ингэхээ болихгүй юм бол бид түүнийг хэрхэн зогсоохоо сайн мэдэж байна” гэгцгээв Эбү Талиб тэдний эвийг олон тайвшируулаад буцаажээ. Энэ явдалыг ч Мухаммедэд хэлсэнгүй. Мүшрикүүд (буруу номтон) хэсэг хоногийн дараа ахин цуглаад Эбү Талиб дээр иржээ: “Түрүүн чамд хэлсэн зүйлийг санаж байна уу? Бидний хүссэнийг чи хэлээгүй бололтой. Бид

51 Ибн Исхак, Эс-Соре, с. 188-191; Ибн Сагд, эт-Табакет I, 133; Ибн Кесир, эл- Бидэйн III, 384.

нар энэ хүнийг зогсоохын тулд сүүлчийн цусаа ч өгөхөд бэлэн байна. Мекке хотод бид эсвэл Мухаммед л үлдэх болно. Өөр замгүй” хэмээн цамнаж эхлэв. Эбү Талиб тэднийг тайвшруулхыг хийчээсэн боловч чадсангүй.

Эбү Талиб Мухаммед элчийг (салаллаху алейхи уа сальлам) гомдоохыг хүсээгүйн сацуу түүнд итгэгсэдэд ч ямарваа нэгэн зовлон тохиолдхыг хүссэнгүй. Тэгээд Мухаммед алейхисальламыг дуудан: “Мухаммед дүү минь! Мекке хотын бүх отог овогууд чиний дайсан болон нэгдэж байна. Тэгээд чамайг зогсоо гэж надад гомдоллож байна. Төрлүүд хоорондоо дайсагналцах нь сайн зүйл биш. Тэд чамаар өөрсдийгөө кафир (буруу номтон) гэж хэлүүлхийг хүсэхгүй байна” гэв. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) “Хайрт ах минь, чи нэг зүйлийг сан ойлго! Миний баруун гарт нарыг, зүүн гарт минь сарыг атгуулсан ч (тэд юу ч амалсан) би хэзээ ч энэ шашинаасаа буцахгүй, хүмүүст шашинаа номлохоосоо шантрахгүй, нэг бол би энэ шашинаа дэлхий даяар түгээх болно, эсвэл би энэ замд (шашин түгээх замд) амиа өгөх болно гээд уйлав.

Мухаммед элчийг (салаллаху алейхи уа сальлам) гомдсоныг үзсэн Эбү Талиб хэлсэн болгондоо харамсан тэрнийг тэврэн: “Аяа, дүү минь, ча ажилаа үргэлжлүүл, хүссэнээ хий, намайг амьд байхад хэн ч чамд муу зүйл хийж чадахгүй. Би чамайг хамгаалах болно”⁵² гэв.

Мүшрикүүдийн (буруу номтон) толгойлогчид болох 10 хүн Эбү Талиб Мухаммедыг хамгаалж байгааг ойлгон Умаре бин Вэлидийг аваад Эбү Талибд очиж түүнд: “Хөөе, Эбү Талиб, энэ залууг чи танина. Энэ бол Умаре Мекке хотод энүүн шиг царайлаг, ухаалаг, сайхан сэтгэлтэй хүн үгүй билээ. Энэнийг чамд өгөө, чи энэ залууг өөртөө авч ажиллуул, харин оронд нь бидэнд Мухаммедыг өг бид тэрний толгойг нь авна... Чамд хүний оронд хүн өгч байна” гэв. Эбү Талиб энэ үгийг сонсоод маш их уурлан: “Эхлээд та нар надад өөрсдийн төрсөн хөвгүүдээ өгцгөө, би тэднийг ална, тэгснийхээ дараа дүүгээ (Мухаммедыг) өгнө” гэв. Мүшрикүүд байдал хурцадсаныг ойлгон: “Бидний хүүхдүүд Мухаммедтэй адилгүй шүү дээ, түүний хийж чадахыг хийж чадахгүй шүү дээ” гэв. Эбү Талиб: «Андгайлан хэлье, миний дүү Мухаммед таа нарын хөвгүүдээс илүү буянтай билээ. Тэгэхлээр та нар хөвгүүдээ надаар асруулаад миний хайрт дүүг

минь надаас аваад толгойг нь цавчих санаатай юу?! Ингэн тэмээ ч хүртэл өөрийн ботогыг бусадаасаа илүү санаж, хамгаалдаггүй бус уу..? Та бүхэн энэндээ тулсан бол үүнээс хойш мэдэж авцгаа, Мухаммедын дайсан бол миний ч дайсан”⁵³ гэв. Мүшрикүүд уурсан гэр гэр лүүгээ зүгэлцгээв. Эбү Талиб Хашим хөвгүүд ба Абдултутталиб хөвгүүд гэсэн хоёр овгийг цуглуулж тэдэнд болсон явдлыг хэлэв. Хайрт элч Мухаммедэд (салаллаху алейхи уа сальлам) тус дэм болохыг ятгав. Мухаммедыг алахыг завдсан хүмүүсийг алах болно гэж бүгдээрээ ам өчиг өгцгөөв. Зөвхөн Эбү Лехеб эсрэг зогсов. Эбү Талиб “Хөөе, ах дүүс минь, маргааш та нар бүгдээрээ зэр зэвсэгээ авцгаагаад намайг дагацгаагаарай” гэв. Маргааш өдөр нь Эбү Талиб Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) гэрт очин бүгдээрээ хамтаар ариун Кааб сүм рүү явцгаав. Каабын хажууд очоод Мүшрикүүдийн өмнө нь зогсон тэдэнд хандан “Хөөе, курейшийн ард түмэн, миний дүүгийн хүүг (Мухаммед) алхыг завдаж байгааг чинь дууллаа, энэ ард минь зогсож байгаа залуус сэлмээ атгасан байна, дайтхад зөвхөн миний тушаалыг хүлээн зогсож буйг та нар мэдэх үү. Хэрвээ Мухаммедыг алах юм бол та нарын хэнийг нь ч амьд үлдээхгүй гэдгээ андгайлъя” гэв. Тэгээд Мухаммед элчийг магтсан шүлгүүд уншиж эхлэв. Тэнд байсан Мүшрикүүд тэр даруйдаа тархан одоцгоов.

Шударга бусаар дарлан зовоосон нь

Курейш овгийн толгойлогч мүшрикүүд Мухаммедыг (салаллаху алейхи уа сальлам) ганцаараа явж байхыг нь харвал түүн рүү дайрч, хараан доромжилдгоор барахгүй зоддог байлаа. Асхаб кирамыг (анхдагч мусульманууд) ч гэсэн зовоохоос буцацгаадаггүй байв. Мухаммед алейхисальламын талаар ийн ярьдаг байлаа: “Мухаммедыг тэвчсэн шиг бид өөр ямар ч зүйлд ийм хүлцэнгүй хандаж байгаагүй билээ. Тэд биднийг буруу номтон гэж дуудан, биний бурхадыг доромжилж, биний шашинийг худлаа хэмээн гүтгэж байна. Бас Арабуудыг хооронд нь халлан бутаргаж байгаа биш гэж үү?” гэж хоорондоо ярилцаж суухуйд гэгээн элч Каабыг эргэн мөргөхөөр ирж явааг харав. Тэд Мухаммедыг (салаллаху алейхи уа сальлам) харан зүхэж муухай үгээр доромжилж эхлэв. Пайгамбар маань маш их гомдсон хэдий

ч юу ч хэлсэнгүй, мөргөлөө үргэлжлүүлсээр байлаа. Гурав дахь удаагаа тэдний хажууд ойртохдоо зогсон: “Хөөе, курейшийнхан, намайг сонсоцгоо! Хамаг ертөнцийн эзэн Аллахын нэрээр андгайлъя, тэрбээр надад та нарыг устан сүйрэхийг мэдэгдсэн билээ” хэмээв. Мүшрикүүд энэ үгийг сонсоод юу ч гэж чадалгүй чив чимээгүй амаа ангайлган алмайрцгаалаа. Зөвхөн Эбү Жехил Мухаммедэд (салаллаху алейхи уа сальлам) ойртон: “Хөөе, Мухаммед, чи гадны хүн биш, бидний энэ ёс суртгуунгүй байдалыг битгий тоо. Зүгээр л мөргөлөө үргэлжлүүл.” гэв. Мухаммед (салаллаху алейхи уа сальлам) тэндээс гэрлүүгээ буцав.

Маргааш нь яг тэр газарт мүшрикүүд цуглан, мөн адил Мухаммедыг (салаллаху алейхи уа сальлам) муулцгаан сууж байхад Мухаммед элч Кабын өмнө ирж мөргөл үйлдхээр ирэв. Мүшрикүүд түүнийг харнгуутаа түүн рүү дайрч довтлов. Тэдэн дундаа хамгийн харгис гэгддэг Укбе бин Муайт аймшиггүйгээр элчийг заамдан амьсгал авч чадахгүй болтол нь боймлов. Яг тэр үед Эбү Бакир “Миний бурхан Аллах гэж хэлсэн хүнийг алах нь уу та нар? Та нарт их эзэний зарлиг буусан... гэж хэлээд элчийг хамгаалахын тулд тэдний дунд оров. Мүшрикүүд Мухаммедыг (салаллаху алейхи уа сальлам) тавиаад Эбү Бакирыг зодож эхлэв. Түүнийг газар унган дэвсэлж мод чулуугаар зодов. Рабиа гэх Мүшрик Эбү Бакирыг дэвслэн толгой түрүүгүй өшиглөн цус нөжтэй нь хутгаж хүн танихын аргагүй болтол нь зодов. Тэймийн өвгүүд гэх овогийнхон тэднийг салгаагүй бол үхтэл нь зодохоос сийхгүй байлаа. Босох ч тэнхэлгүй болтлоо зодуулсан Эбү Бакирыг дамнуурган дээр тавин гэрт нь хүргэцгээв.

Энэ дормжлол дээрэлхэлд өртсөн гэгээн Эбү Бакир хэдэн хоног ухаан орсонгүй. Биеийхэн байдал ч маш хүнд байв. Эбү Бакир ухаан орож нүдээ нээнгүүтээ сул дорой дуугаар “Аллахын элч хаана байна? Бие нь гайгүй юу? Тэрнийг ч гэсэн зодсон шүү дээ” гэв. Ээж нь Үммү л Хайр “ямар нэг зүйл идэж уух уу, хүү минь” гэж асуухад нь нүдээ нээгээд: “Мухаммед хаана байна?” юу хийж байгаа бэ?” гэв. Ээж нь Чиний найзын чинь талаар одоогор ямар ч мэдээ алга байна” гэв. Эбү Бакир “Хаттабын охин Үммү Жамиль руу оч, тэрнээс Мухаммедыг асуу” гэв.

Үммү Жамиль гэгээн Омарын охин дүү нь агаад мусульман болсон байлаа. Эх Үммү л Хайр Үммү Жамилийнд очиж “Миний хүү Эбү Бакир чамаас Мухаммедыг асуулгаж байна” гэв. Үммү Жамиль: “ Би Мухаммедыг ч Эбү Бакирыг ч юу болсон талаар

огт юм дуулаагүй байна, хэрвээ чи зөвшөөрвөл хоёулаа хамт Мухаммедрүү очижасууя” гэв. Үммүл Хайр “Тэгье” гэж зөвшөөрөөд тэр хоёр гэгээн Эбү Бакирын хажууд ирэв. Үммү Жамиль Эбү Бакирыг зодуулсан бас өвчтэй байхыг нь хараад сэтгэл өрөвдөн уйлж эхлэв. “чамайг ийм болгсон хүмүүс араатнаас ч долоо дор хүмүүс. Аллахаас ганцхан зүйл хүсье, энэ хийсэн зүйлийнхээ гэсгээлийг хүртэцгээг” гэв. Эбү Бакир Үммү Жамилээс “Аллахын элч Мухаммед (салаллаху алейхи уа сальлам) хаана байна, бие нь гайгүй юу” гэж асуув. Үммү Жамиль “Энд ээж чинь байна, миний ярхыг сонсож магад” гэж болгоомжлоход нь Эбү Бакир “битгий ай, энэ хүн бидэнд муу юм хийхгүй” гэхэд Үммү Жамиль “Мухаммед амьд байгаа бие нь сайн, өөрийнхөө гэртээ байгаа” гэв. Гэгээн Эбү Бакир “Би элчийг очиж үзхээс нааш хоол цай идэхгүй гэв. Тэнд байгаа хүмүүс унтаж хөл хөдөлгөөн намжхад гэгээн Эбү Бакир ээж бас Үммү Жамилийн мөрийг түшэн арай ядан Мухаммед алейхиссалламын гэрт очигцоов. Мухаммед (салаллаху алейхи уа сальлам) мусульман дүүгээ тэврэн угтав. Эбү Бакирийн ийм байдлыг харсан Мухаммед алейхисальлам маш их өрөвдөн хайлав. Эбү Бакир: “Аяа, Аллахын элч минь, чиний төлөө эцэг-эхээ золиослоё. Тэр хүмүүс намайг газар унган нүд нүүрийг маань хүн танихын аргагүй болтол зодсоноос өөр гоморхох зүйл алга даа. Энэ хүн бол намайг энэ хорвоод төрүүлсэн миний ээж Селма билээ. Тэрний төлөө залбираач гэж гуйъя, учир нь таны хүсэлтийг Аллах биелүүлдэг болхоор миний ээжийг хойд ертөнцийн гэсгээлээс ангижруулах байхаа” гэв. Эбү Бакирийн ээж Селмааг мусульман болоосой хэмээн Аллахд залбиран мөргөв. Аллахын элчийн (салаллаху алейхи уа сальлам) энэ хүсэлт нь биелэгдэж, Үммү л Хайр мусульман болснаар анхдагч мусульмануудын тоонд багтсан нь хэмжээлшгүй их буян байлаа.

Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) гэр Эбү Лехеб ба Укбе бин Муайт гэж хоёр буруу номтоны гэрүүдийн дунд нь байдаг байлаа. Эд нар элчийг боломж л гарвал дээрэлхэн доромжилдог байв. Заримдаа шөнө оройгоор малынхаа аргал баасыг Мухаммед элчийн хаалганы өмнө хаядаг байлаа. Эбү Лехеб хөрш Адыйгийн хашаан дотроос Мухаммедрүү чулуу нүүлгэдэг байв. Түүний эхнэр Үммү Жемил ч гэсэн өргөстэй модны мөчирийг Мухаммедын (салаллаху алейхи уа сальлам) явах замд нь газар булдаг байлаа. Эбү Лехеб нэг өдөр малын баасыг

Мухаммедийн (салаллаху алейхи уа сальлам) хаалганынх нь өмнө асгаж байхыг гэгээн Хамза хараад гүйн очиж Эбг Лехебийг барьж аваад адч ирсэн аргал баасыг нь түүний толгой дээр нь асгав. Эбу Лехеб түүний эхнэр хоёрын энэ бузар үйлийн талаар “Эбу Лехебийн гар нь тахираг, тахирчихсан ч байгаа” гэж эхлэх Теббет сүрэ (бүлэг) илгээгдүүээ.

Эбг Лехебийн эхнэр Үммү Жемил өөрсдийнх нь талаар сүре илгээгдсэнийг дуулаад уурлан Мухаммедийг хайж эхлэв. Мухаммедийг (салаллаху алейхи уа сальлам) Каабын хажууд байгааг сонсоод гартаа нэг том чулуу барин тийшээ очив. Тэнд Эбү Бакир Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) хоёр сургааль номлол айлдан сууцгааж байв. Ирж буй Үммү Жемилийн гарт чулуу байгааг хараад: “Аяа, Алахын элч, Үммү Жемил ирж явна, тэр маш муухай хүн билээ. Танд ямар нэг муухай зүйл хийх вий гэхээс айж байна. Нэг газар очиж нуугдаач” гэв. Мухаммед элч: “Тэр намайг харахгүй” гэв. Үммү Жемил Эбү Бакирийн хажууд ирснээ: “Хөөе, Эбү Бакир найз, Мухаммед чинь хаана байна? хурдан хэлж аль. Тэр миний нөхөр бас миний тухай муухай зүйл ярьж яваа гэнэ. Тэр шүлэг зохиодог юм бол бид ч зохиож чадна. Би тэрнийг муулсан шүлэг зохионо. Бид түүнийг тамлан зовоох болно. Түүний элч гэдгийг хүлээн зөвшөөрөхгүй, бас шашиныхыг нь ч үзэн ядна. Хэрвээ тэрнийг харвал энэ чулуугаар толгойг нь хаглах байлаа...” гэж бузар үгээр зандрав. Эбү Бакир: “Миний найз шүлэгч биш, тэгээд ч чамайг муулж бичээгүй, Аллах ингэж зарлигласан юм” гэхэд нь Үммү Жемил тэнээс үтэр түргэн холдон одов. Гэгээн Эбү Бакир: “Аяа, Расулуллах, тэр таныг харсангүй” гэж гайхахад Мухаммед (салаллаху алейхи уа сальлам) “Тэр намайг харсангүй, Аллах эзэн тэрний нүдийг намайг харахгүй болголоо” гэж айлдав.

Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) охид нь болох гэгээн Үммү Гүлсүм нь Эбү Лехэбийн хүү Утэйбетэй, харин Рүкайе нь Эбү Лехэбийн отгон хүү Утбэ нартай гэрлэх болоод сүй тавьчихсан байжээ. Эбү Лехэбийн талаарх “Теббет” сүре илгээгдсэнийг дуулаад Эбү Лехэб хөвгүүдээ дуудан “Мухаммедийн охидийг авах юм бол түүний худ ураг нь болох болно. Харин тэр бол бидний дайсан. Тиймээс таа хоёр тэдний охидоос салцгаа. Та нарт Курейш овгийнх охидоос хүссэн хүүхнийг чинь авч өгнө” гэв. Тэр хоёр хүү нь ч “за” гэж зөвшөөрөв. Утэйбэ Мухаммедийн (салаллаху алейхи уа сальлам) өмнө очоод “Хөөе, Мухаммед, би

чамайг ч чиний шашинийг ч үзэн ядаж байна, би чиний охинийг эхнэрээ болгохоос татгалзаж байна. Энэ мөчөөс эхлэн би чамайг, чи намайг ч танихгүй” гэв. Хайрт пайгамбарын маань зааман авч энгэр заамыг нь урхад нь Мухаммед алейхисальлам: “Аяа, Аллах минь, энэ Утэйбээг араатны хоол болго” гэж хэлэв. Заяа муут Утэйбэ эцэг дээрээ ирж болсон явдалыг ярив. Эбү Лехэб: “Мухаммедын энэ хараалаас айж байна” гэжээ⁵⁴.

Хэсэг хоногийн дараа Эбү Лехэб хүү Утэйбээгээ Шам хот руу наймаанд явуулав. Тэдний жин Зехра гэдэг газар хоноглохоор зогсход нэг арслан тэдний дэргэд ирснээ тэрнийг тойрон эргэлдэж эхлэв. Утэйбэ арсланг үзэсэн даруйдаа “Мухаммедын хараал ирж байна уу даа. Энэ арслан намайг идхээр иржээ” гэж айж эхлэв. Гэвч арслан юу ч хийсэнгүй яваад өгөв. Утэйбэ өндөрлөг инэг газар ороо засан хэвтэв. Шөнө дунд арслан ахин эргэж ирснээ хүмүүсийг нэг нэгэнгүй үнэрлэн явсаар Утэйбэгийн хажууд ирээд, тэрний гэдсийг нь хүүлэв. Тэгэд тэрний хоолойг нь зуун гүрээ судасыг нь тасдав. Утэйбэ амьсгал хураахынхаа өмнө “Би та нарт Мухаммедыг бүх хүнээс шударга гэж хэлсэн билүү?” гэж хэлээд үхэв⁵⁵.

Хайтр пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) хүмүүсийг зөв зам руу дуудаж тэднийг аз жргал руу хөтлөн байв. Харин мүшрикүүд “Бидний өвөг дээдсийн шашин бол энэ гээд” шавар бурхаддаа залбирсаар л байлаа. Харин Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) тэднийг хүний ёсоор амьдрахад, нэр төртэй, үнэ хүндтэй, муу муухайгаасаа салж, дээдийн бас ариун зиндаанд хүргэхэд уриалж байлаа. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) “Хөөе, хүмүүс ээ, лаа илааха иллалллахү (Аллахас өөр бурхан үгүй) гэж хэлээд гэсгээлээс аврагдацгаа” гэж уриалах болгонд Эбү Лехеб гүйж ирээд: “Хүмүүс ээ, энэ бол миний ахын хүү билээ. Тэрний үгэнд битгий итгэцгээ. Тэрнээс хол байцгаа!” гэж хэлдэг байлаа.

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) нэгэн өдөр ариун Каабд намаз (мөргөл) үйлдэж байхуйд буруу номтонуудын толгойлогчид болох Эбү Жахил, Шейбе бин Ребиа, Утбе бин Ребиа, Укбе бин Эби Муайт нар Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) хажууд ирж сууцгаав. Тэр хавьд урд өдөр нь нядлсан нэг тэмээний гүзээтэй баас бас цус нөж нь байв. Жигшүүрт Эбу Жахил хажуудаа байгаа хүмүүст хандан: “Та нарын дундаас хэн

54 Ибн Асакир, Тариху Димашк LXVII, 173: Хейсэмо, Межмагуз-Зевайд VII, 53.

55 Ибн Асакир, Тариху Димашк XXXVIII, 301.

чинь энэ гүзээтэй баасыг аваад Мухаммедийг яг газар мөргөх үед түүний хоёр мөрөн дээр асгах бэ?” гэв. Тэдэн дундаас хамгийн харгис бас хатуу сэтгэлтэй нь болох Укбе бин Эбу Муайт “Би энэнийг хийж чадна” гээд шууд босов. Гүзээтэй тэмээний баасыг өргөн Мухаммедийг яг газар мөргөх үед нь мөрөн дээр нь асгаж орхив. Энэ бүхнийг харж зогссон мүшрикүүд (буруу номтонууд) түүнийг шоолон инээлдэж эхлэв. Элч (салаллаху алейхи уа сальлам) мөргөлөө сунжруулан, толгойгоо өргөхгүй байлаа. Энэ үед мусульмануудын нэг болох Абуллах бин Мэсуд энэ бүхнийг хараад ийн өгүүлжээ: “Мухаммедийг тийм байдалтай хараад толгойд минь цус харвах шиг болов. Гэвч намайг мүшрикүүдээс хамгаалах ах дүү алга байлаа. Би өнчин бас туранхай билээ. Тэр үед би өвчтэй байсан болхоор биеэ арай ядан дааж явдаг байлаа. Мухаммед элчийг (салаллаху алейхи уа сальлам) энэ бузар хүмүүсээс хамгаалаж чадах хүчгүй байгаадаа өөртөө гоморхон түүнийг өрөвдөн хараж зогсно. Тэр үед Мухаммедийн охин нь Фатимад энэ мэдээ хүрчээ. Жаахан охин Фатима гүйж ирж, эцгийнхээ мөрөнд асгадсан тэмээний баасыг авч хаяж эхлэв. Энэнийг хийсэн хүмүүст гоморхон уйлж байлаа. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) юу ч болоогүй юм шиг намаазаа дуусгасаныхаа дараа “Аяа, Аллах минь, курейшийн энэ муу хүмүүсийг чамд захъя (гэсгээлийг нь чи өг). Аяа, Аллах минь, Эбу Жахил бин Хашм хоёрыг чамд захъя! Аяа, Аллах минь, Утбе бин Ребиаг чамд захъя! Аяа, Аллах минь, Шейбе бин Ребиаг чамд захъя!, Аяа, Аллах минь, Укбе бин Эби Муайтыг чамд захъя! Үмеййэ бин Халэфийг чамд захъя! Аяа, Аллах минь, Велид бин Утбээг чамд захъя! Аяа, Аллах минь, Умре бин Велидийг чамд шилжүүлье!” хэмээв. Энэ залбиралыг сонссон мүшрикүүд инээхээ больж айж эхлэв. Ягаад гэвэл Ариун Каабын хажууд зальбирал биелдэг гэдэгт итгэж байлаа. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) Эбу Жахилд хандан: “Аллахын нэрээр тангаргалъя, чи бол энэ бүхнээ орхино. Эсвэл Аллах чамайг зовлонд унагаах болно” гэв. “Аллахын нэрээр ангайдлъя, энэ нэрийг дурьдсан хүмүүс Бедирын дайнд бүгдээрээ алагдаж, өмхийрсөн нэгэн нүхэнд булагдсаныг өөрийн нүдээрээ харсан билээ” гэв.

Нэг өдөр Эбу Жахил Каабын ойролцоо курейшын мүшрикүүдэд хандан: “Хөөе, мүшрикүүдээ Мухаммед бидний шашинийг буруушаан, бидний бурхадийг бас түүнд мөргөсөн эцэг өвгдийг минь ч хараан зүхэхээ зогсоохгүй байна. Та бүхэнд

амлъя, маргааш би нэг томоохон чулуугаар Мухаммедийг мөргөлөө хийж байхад нь толгойг нь бяц цохиж алах болно. Харин тэр үед түүний өшөөг авхаар Абулмутталибийн хөвгүүд над руу дайрах үед та нар намайг хэрвээ хүсвэл хамгаалцгаа, эс хүсвэл битгий хамгаалаарай. Түүнийг алснаас хойш тэрний төрөлүүд намайг яасан ч яаг дээ...” гэв. Тэнд байсан мүшрикүүд “Хэрвээ чи тэрнийг алах л юм бол бид чамайг хамгаалах болно гэдгээ андгайлъя” гэгцгээв.

Маргааш өглөө нь Эбү Жахил нэг том чулуу аваад Каабын хажууд суун Мухаммедийг (салаллаху алейхи уа сальлам) хүлээж эхлэв. Хайрт элч маань (салаллаху алейхи уа сальлам) урьдын адил Каабын хажууд ирэн мөргөлөө үйлдэж эхэлхэд Эбү Жахил чулуу аваад Мухаммедийн зүг алхаж эхлэв. Мүшрикүүд энэ явдалыг сэтгэл догдолгон харан суулаа. Эбү Жахил Мухаммедэд (салаллаху алейхи уа сальлам) ойртон очих үед гар нь чичрээд, салгалан чулуугаа газар алдав, царай нь цовхийн цайж, айсанаа хойш ухааран холдов. Мүшрикүүд гайхан Эбү Жахил руу: “Юу болов?” гэгцгээв. Эбү Жахил: “Тэрнийг алхаар завдан, чулууг гартаа барьтал урьд маань нэг улангассан тэмээ гарч ирэв. Амьралдаа тийм урт хөлтэй бас тийм догшин тэмээ урьд хойшид үзэж дуулаагүй билээ. Хэрэв ахиад дөхсөн бол тэр тэмээ намайг алах байсан” гэв.

Велид бин Мугире, Эбү Жахил, Амар бин Хишам, Эсвэд бин Мутталиб, Үмеййэ бин Халэф, Эсвэд бин Абдугвес, Ас бин Ваил, Харси бин Кайс гэх мэт мүшрикүүдийг толгойлох хүмүүс элчийг (салаллаху алейхи уа сальлам) харангуут: “Энэ өөрийгөө элч гэж бас Жабрайл (сахиусан тэнгэр) түүнд ирдэг гээд байга юм аа” хэмээн шоолон доромжилдог байв. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) энэ бүхэнд маш их гомддог байлаа. Нэг өдөр Жабрайл (алейхисальлам) зарим ает дуулгахаар иржээ: “Андгайлан айлдъя, (Аяа, элч минь) чамаас өмнө илгээгдсэн элчүүдийг ч зовоон доромжилсон. Тэд элчүүдээ зовоон доромжилсон болхоор тэрнийх нь хариу болгон зовлон бас тамлалын аюулаар нөмрөгдсөн.”⁵⁶

“Үнэнээ бид чамайг доромжилсоны хариуг барина. Тэд Аллагаас өөр бурхадыг шүтдэг билээ, тэд удахгүй (тэдэнд нүүрлэх аюулыг) мэдэх болно. Үнэндээ тэдний үгэнд (өөр бурхадад итгэх нь, куран судрыг эсэргүүцэх нь бас чамайг

эсэгүүцэн доромжилж ярилцах нь) амьсгал чинь давчдан сэтгэл чинь тавгүйтэнэ” хэмээжээ⁵⁷.

Хорвоогийн энэрэл болсон элч (салаллаху алейхи уа сальлам) нэгэн өдөр ариун Каабыг таваф (тойрон залбирах) хийж байтал Жабрайл (алейхисальлам) ирж: “Би тэдний (кафируудын доромжлол) гэсгээлийг хүртээх зарлиг авлаа” гэв. Энэ үеэр бидний хажуугаар Валид бин Мугирэ өнгөрч явав. Жабрайл (алейхисальлам) : “Энэ хүн ямар хүн бэ?” гэж асуув. Мухаммед (салаллаху алейхи уа сальлам): “Энэ бол Аллах эзэний хамгийн муу боол нь” гэхэд нь Жабрайл (алейхисальлам) Валидийн хөл рүү нь заан “Энэний төлөө ирлээ” гэв. Хэсэг хугацааны дараа Ас бин Вайл өнгөрч явааг харав. Түүнийг ч Мухаммедээс асуун яг ижилхэн хариултыг сонсоод, түүний гэдэс рүү нь зааж “Түүний ч гэсгээлийг мэдэгдлээ” гэв. Эсвэд бин Мутталибийг өнгөрхөд түүний нүдийг нь заав, Абдугвэсийг хараад түүний толгойг нь заав. Харис бин Кайс өнгөрхөд түүний гэдэс рүү нь заалаа. Тэгээд “Аяа, Мухаммед! Аллах эзэн эд нарын аюулаас чамайг хамгааллаа. Тун удахгүй эд нар гэсгээлээ амсах болно” гэв.

Энэ хүмүүсээс Ас бин Вайлын хөлд нь өргөс орж, ямар ч эм тан хэрэглэсэн ч илааршаагүйгээр барахгүй хөл нь тэмээний толгой мэт том болон хавджээ. “Мухаммедын Аллах миний аминд хүрлээ дээ” гэж орилсоор амь тавьжээ. Эсвэд бин Мутталибийн хоёр нүд нь сохорчээ. Жабрайл (алейхисальлам) түүнийг толгойгоор нь модонд саваж алжээ. Абдугвэсийг Бади сэмүн гэдэг газар байхад нь нүүр ба цээж нь хав хар болжээ. Түүнийг гэртээ ирхэд нь танилгүй хөөн явуулжээ. Тэр уурласандаа толгойгоо гэрийнхээ хаалганд нүдсээр байгаад үхжээ. Харис бин Кайс давсласан загасны мах идэн маш их халууран хэчнээн л ус уусан ч цангаа нь тайлагдалгүй байсаар хагарч үхжээ. Валид бин Мугирэгийн шилбэнд нь төмрийн үзүүр орож, цус нь тогтолгүй алдсаар байж үхжээ. Ийнхүү тэд бүгдээрээ хийсэн муу зүйлийнхээ гэсгээлийг хүртэцгээжээ. Мүшрикүүдийг үүрдийн тамын зовлон хүлээж байгаа тухай ает ч иржээ.

Хорвоогийн энэрэлт Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) Эбү-л Астай тааралдан уулзаад түүнээс салхад Хакам Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) араас нь нүүр амаа муруйлган доромжилов. Мухаммед элч ч (салаллаху алейхи уа сальлам) үүнийг нь мэдрээд Аллагаас түүнийг энэ

хэвэндээ үлдэхийг хүсхэд нь Хакемийн бие нэг чичирсэнээ яг тэр хэвэндээ амьдралийнхаа сүүлчийн өдөр хүртэл чичигнэсэн хэвэндээ үлджээ.

Сахбы кирануудыг (анхдагч мусульманууд) дарлан зовоосон нь

Мүшрикүүд зөвхөн Пайгамбарыг (салаллаху алейхи уа сальлам) бус түүний анхдагч мусульмануудыг ч дарлан зовоодог байлаа. Тэр дундаа өнчин өрөөсөн ба ядуу мөхөс мусульмануудыг зовоодог байв. Ийм ядуусын нэг нь Билал Хабаши байлаа. Үмэйе бин Халеф гэгчийн боол байсан Билал Хабаши Эбү бакир-и Сиддикийн уриалснаар мусульман болжээ. Үмэйе 12 боолтой байснаас тэдний дундаас Билал Хабашид маш их итгэж найддаг байсан болхоор түүнийг өөрийн шавар бурхадын сүмийнхээ халаачаар ажиллуулдаг байлаа. Гэгээн Билал Хабаши мусульман болсныхоо дараагаар тэнд байх бүх бурхадыг Аллахд мөргөж буйгар газар тавьжээ. Энэнийг дуулсан эзэн нь маш их уурлан Билал Хабашийг дуудуулан ирүүлж “Чи мусульман болоод Мухамедийн бурханд мөргөж байгаа юм байна. Энэ үнэн үү?” гэж асуув. Билал Хабаши “Тийм ээ, би аугаа их Аллахд мөргөн залбирч байгаа” гэв. Үмэйе энэ хариултыг сонсоод хагарах шахам уурлан түүнийг тамлан зовоож эхлэв. Зуний халуун өдөр үд дунд ид халаж байхад Билалийг нүцэглээд нард халаж улайсах шахам болсон халуун чулууг түүний цээжин дээр тавьж тарчлаадаг балаа. Гал халуун чулуун дээр хэвтүүлээд дээр нь бас халуун чулуугаар даруулчихаад хөөрхий Билалийг “Ислам шашинаасаа гар, тэгээд Лат, Узза бурхадад сүсэглэ” гэв. Гэгээн Билал “Аллах ганц! Аллах ганц!” гэхээс өөр юу ч хэлсэнгүй.

Ийм их тэвчээр гарган итгэлээ хамгаалж байгааг нь харсан Үмэйе бин Халеф галзуурах шахам уурлан өргөст модны мөчирийг цээжин дээр нь зүлгэн түүнийг улаан нялга болгож хаяв. Гэвч гэгээн Билалд шантрах сэтгэл огт байсангүй “Аяа, Аллах минь, намайг мусульман болгосон чамд баярлалаа, намайг мусульман болгосон чамд баярлалаа” гэхээс өөр юу ч дууграхгүй байлаа.

Гэгээн Билал (радиаллаху анх) энэ явдлаа ийн өгүүлжээ: “Харгис Үмэйе намайг халуун наранд гадаа хүлээд, орой

болхоор намайг тайлдаг байлаа. Нэг халуун өдөр мөн л адилаар намайг халуун наранд гадаа хүлээд тамлаж эхэллээ. Тэр намайг исламаас гаргахын тулд “Миний бурхадыг шүт Аллахыг үгүйсгэ” гэж хэлэх болгонд нь би “Аллах ганц, Аллах ганц” гэхээ огт зогсоодоггүй байлаа. Тэр энэ өдөр урьд урдынхаасаа наранд улайссан том чулууг миний цээжин дээр тавьхад нь би ухаан алджээ. Намайг ухаан орход нөгөө чулууг авсан байлаа бас нарыг үүл халхалан сүүдэр тусаж байв. Аллах эзэндээ баярласнаа хэлж өөрөө өөртөө “Хөөе Билал! Ертөнцийн эзэн Аллагаас ирсэн бүх зүйл гоё, бас таатай юм” гэлээ”.

Үмэйе бин Халеф, бас нэгэн өдөр Билал Хабашийг халуун элсэн дээр дээш харуулан нүцгэн хэвтүүлээд дээр нь наранд улайсан чулуугаар дарж байхуйд мүшрикүүд ирээд: “Чамайг маш их зовоож байна, хэрвээ шашинаасаа гарахгүй бол чамайг ална гэцгээж байлаа.” Ийн хэцүү тамлалд байлаа ч Билал Хабаши “Аллах ганц! Аллах ганц!” гэж хэлж байлаа. Яг энэ үед хайрт элч Мухаммед маань (салаллаху алейхи уа сальлам) тэдний хажуугаар өнгөрч явлаа. Тэр Билал Хабашийн (радиаллаху анх) энэ байлыг үзээд маш их өрөвдөн “Агуу Аллахын нэрийг хэлснээр чи энэнээс аврагдах болно” гэв.

Пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) гэртээ ирээд дэргэдээ гэгээн Эбү Бакирыг дуудуулан түүнд Билал Хабашийн амсаж буй тамлалыг хэлээд “Маш их өрөвдлөө” гэв. Энэ үгийг дуулаад Эбү Бакир даруухан тийшээ очиж, мүшрикүүдэд хандан “Билалийг ингэж зовоосноор та нарт ямар ашгтай юм бэ? Ингэж байнаас түүнийг надад зар” гэв. Тэд: “Дэлхийгээр дүүрэх тийм их алт өгсөн ч түүнийг зарахуй, гэхдээ чиний зарц Амираар түүнийг сольж болох юм” гэцгээв. Эбү Бакирын боол Амир бол түүний наймааг хийдэг бөгөөд маш их ашиг олдог хүн юм. Түүнд бараанаас нь гадна 10 мянган алт байв. Тэрээр гэгээн Эбү Бакирын туслахаар ажиллан түүний бүхий л ажилыг хийдэг байлаа. Гэвч тэрээр кафир (буруу номтон) байсан ба түүнийгээ ч хүлээн зөвшөөрдөг байлаа. Эбү Бакир: “Амирийг эд хөрөнгтэй нь хамтаар та нарт өглөө. Билалийг одоо надад өг” гэв. Үмэйе бин Халеф ба бусад мүшрикүүд баярлан дуртайяа хүлээн зөвшөөрөд “Эбү Бакирийг сайхан монжлоо” гэцгээв.

Гэгээн Эбү Бакир Билалыг цээжин дээрхи хүнд чулууг авч хаяаад, түүнийг түшин босголоо. Эбү Бакир (радиаллаху анх) гэгээн Билалын гараас нь барин шууд Аллахын элчийн гэр

лүү нь явав. Түүний өмнө очоод “Аяа, Аллахын элч минь, би өнөөдөр Аллахын таалалын төлөө Билаалын эрх чөлөөг гарт нь авч өглөө” гэв. Хайрт пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) энэ мэддээнд маш их баярлав. Гэгээн Эбү Бакирийн төлөө залбирчээ. Энэ үед Жабрайл мелек ирж Эбү Бакирийг (радиаллаху анх) тамын гэсгээлээс алслагдсныг мэдэгдсэн Лейл сүрээгийн 17-18 аетийг авч иржээ. Энэ аетийн утга нь: “(Гэгээн Эбү Бакир шиг) их сүсэгтэн болоод, эд хөрөнгөө Аллахын ариун замд нигүүсэхийн (бас аллахын амлалтанд хүрхийн тулд) тулд зарцуулагсад түүнээс (тамын гэсгээлээс) алслагдна” хэмээжээ.

Гэгээн Хаббаб бин Эрэтийг ч шашинаас нь гаргахын тулд тамлан зовоожээ. Гэгээн Хабаб (радиаллаху анх) өнчин хүн байв. Тэр Үммү Энмар гэх нэгэн мүшрик эмэгтэйн боол нь байжээ. Түүнийг хамгаалах нэг ч төрөл садан байхгүй болхоор мүшрикүүд нийлэн, түүнийг нүцэглээд, өргөстэй модоор биеийг нь самнадаг байлаа. Заримдаа төмөр хувцас өмсгөөд халуун наранд шарж бас наранд эсвэл галд халаасан чулууг биен дээр нь тавьж тамладаг байлаа. Түүнийг “шашинаасаа гараад Лат, Узза нэртэй бурханд залбир гэж” гэж хэлдэг байв.

Мүшрикүүд нэг өдөр цуглаад, нэг талбайд гал түлээд, гэгээн Хаббабыг авч ирэв. Тэгээд түүнийг гал дээр хэвтүүлэв. Нэг бол энэ шашинаасаа гар, нэг бол галд шат гэсэн санал тавив. Галд дунд дээшээ харан хэвтэж буй Хабаб (радиаллаху анх) “Аллах минь, чи намайг харж бас ямар байдалтай байгааг минь мэдэж байгаа, миний зүрхний итгэлийг маань бататгаж, надад их тэвчээр хайрла” хэмээн забирч байлаа. Мүшрикүүд гэгээн Хаббабын (радиаллаху анх) цээжин дээр хөлөрөө дарж байлаа. Гэвч тэд нар өөрийн итгэл үнэмшилт боолуудыг Аллахын хамгаалж байгааг хэрхэн мэдэх билээ.

Хэсэгөдөрүүдийндараагаар Хаббабаас болсон үйлявдалыг асуухад тэрээр түлэгдсэн соривтой нуруугаа гарган үзүүлээд “Тэд нэг гал түлээд, намайг тишээ чирч очоод галд хийсэн. Тэр галыг миний мах л унтраасан даа...” хэмээн хүүрнэжээ.

Гадаа гэгээн Хаббаб ийн тарчилан зовж байхад эзэн нь Үммү Энмар галд төмөр улайсган халааж бас түүний толгой дээр дэвслэн байж хүлдэг байлаа.

Нэг өдөр гэгээн Хаббаб элчийн (салаллаху алейхи уа сальлам) өмнө ирээд “Аяа, Аллахын элч минь ээ! Мүшрикүүд намайг харсан даруйдаа гал түлэн намайг түлж эзэн Үммү

Энмар ч гэсэн тэдэнд туслан намайг улайссан төмрөөр толгойг минь хайрч байна. Та миний төлөө Аллахд залибраач” гэж гуйв. Тэгээд нуруу бас толгойныхоо шархыг харуулав. Пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) энэнийг үзээд түүнийг маш их өрөвдөн түүний шашинаасаа гарахгүйн тулд амссан энэ тамлалаас авсан энэ шархыг хараад: “Аяа, Аллах минь, Эзэн минь! Хаббабд тусла” хэмээн залбирав. Аллах Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) энэ залбиралыг биелүүлж, Үммү Энмарын толгойд хүнд өвчин тусгажээ. Тэр энэ өвчиндөө шаналан шөнжин зовж хоноод, маргааш нь миний толгойн өвчин жоохон ч гэсэн алга болог гээд улайссан төмрөөр толгойгоо хайруулхыг хүсжээ. Тэгээд Хаббабыг дуудан ирүүлж төмөр утасыг галд улайсгаад өөрийнхөө толгойг нь боо гэж зарлиг буулгажээ. Хаббаб ч ёсоор болгон түүний толгойг улайссан төмрөөр боодог байлаа...

Исламын анхны өдрүүдэд мусульманууд Хаббаб бин Эрэтийг энэ хэцүү байдлаас нь хамгаалж чадахгүй байлаа. Учир нь тэд бага, харин кафирууд маш их байлаа. Хаббабын энэ тамлал өдөр ирэх тусам улам хэцүү болж, зодож нүддэг болжээ. Хоног өдрүүд өнгөрөх тусам мусульман бологсодын тоо олширч тэд Хаббабыг аварсан билээ.

Ийм их хэцүү зовлонг үзэж туулсан ч Хаббаб итгэл үнэмшлээсээ бас өөрийн шашинаа хамгаалан үлджээ. Гэвч ийм их тамлал харгислалд түүний бие махбодь тэсэхээ байж Мухаммед элчид (салаллаху алейхи уа сальлам) ирэн болж өнгөрсөн бүх зүйлийг нэг нэгэнгүй хэлдэг байлаа. “Аяа, Аллахын элч минь ээ! Намайг энэ зовлон тамлалаас авраач гэж залбираач” хэмээн гуйдаг байлаа. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) ч гэсэн: “Та нараас өмнөх ариун сүсэгтэнүүдийг ч гэсэн ийн тамладаг байсан, төмөр самаар тэдний арьс, махыг нь шулж, зулгаасан хэдий ч тэднийг итгэл үнэмшилээс нь буцааж чадаагүй юм. Хөрөөгөөр тэдний толгой дундуур нь хага хуваасан ч тэднийг шашинаас нь гаргаж чадаагүй юм. Аллах эзэн заавал энэ ажилыг (ислам шашиныг) гүйцэлдүүлэд, бүхий л шашинуудын дээд нь болгох болно. Тэр үед цор ганцаараа Санагаас (хот) Хадрамут (хот) хүртэл замд гарсан. Нэгэн Аллахаас өөр хэнээс ч айхгүй, ардаа үлдсэн хонь малдаа чононоос өөр дайсан үгүй хэмээн итгэх тийм амар амгалан ирэх болно. Та нар яараад байна” гэж хэлээд түүний нурууг нь илээд бурхандаа залбирчээ. Аллахын элчийн

бие сэтгэлийг тайтгаруулсан энэ үгүүдийг сонсоод Хаббабын зовлон нь нимгэрч өвчин нь илааршив.

Гэгээн Хаббаб (радиаллаху анх) мүшрикүүдийн нэг Ас бин Вайлаас авах нилээн их хэмжээний өртэй байлаа. Түүнийгээ асуухаар Ас бин Вайл руу очив. Ас бин Вайл “Чамайг Мухаммедээс салсан цагт чиний өрийг төлнө” гэв. Хаббаб (радиаллаху анх) “Аллахын нэрээр андгайлъя би амьд ахуйдаа байсан шигээ үхсэний дараа ч, булшнаасаа амилахдаа ч хэзээ ч элчээ орхихгүй ба түүнийг үгүйсгэхгүй. Байгаа бүхнээсээ салсан ч түүнийг үгүйсгэхгүй” гэв. Энэ үгсийг сонссон Ас бин Вайл: “Бид үхсэнийхээ дараа амилах юм уу?! Хэрвээ тийм бол тэр үед надад эд хөрөнгө, үр хүүхэд ч байх болно, тэгэхдээ л чиний өрийг төлчихье” гэв.

Ас бин Вайлын энэ үгсийн төлөө Аллах эзэн Куран сударт Мериям сүрегийн (бүлэг) 77-79 аетэд йин айлджээ: “(Аяа, хайрт элч минь!) Одоо энэ аетүүдийг минь үгүйсгэсэн “надад (хойд ертөнцөд) эд хөрөнгө ба үр хүүхэд байх болно” гэгчидийг (Ас бин Вайл) харав уу? Тэр үгүйг харсан гэж үү, Аллахын өмнө бүхнийг харах нүдтэй болоо юу? үгүй тийм биш, Бид тэдний хэлснийг нь заавал бичих болно, (хойд ертөнцөд түүнийг гэгсгээх болно) бас түүний тамлалын ихэсгэсээр л байх болно.”

Ухаанаа алдтал тамласан нь...

Мүшрикүүд ийм тамлалдаа эрэгтэй, эмэгтэй хэнийг нь ч ялгадаггүй байлаа. Анхны мусульмануудын нэг Зиннире эзэгтэй (радиаллаху анха) өнчин нэгэн бөгөөд боол байлаа. Түүнийг мусульман болсонийг мэдсэн мүшрикүүд түүнийг тамлахдаа баяртай байлаа. Зиннирег (радиаллаху анха) Лат, Уззаа гэх шавар бурхадад залбир гэж хүчлэв. Түүнийг боймолж толгой нь эргэн ухаанаа алдаж унах хүртэл түүнийг зоддог байлаа. Ийнгэж зовж байсан ч шашинаасаа буцалгүйгээр барахгүй тэдний бурхадыг барьдаггүй байлаа. Тэр дундаа Эбү Жахил маш их тамлахыг хүсдэг байлаа. Нэг удаа Эбү Жахил: “Харж байна уу? Лат, Уззаа чиний нүдийг сохор болголоо” гэхэд нь Зиннире итгэл үнэмшлийнхээ баталгаа болгон: “Хөөе, Эбү Жахил, Аллахын нэрээр андгайлъя, хүсэл чинь чинийхээр болохгүй. Чиний Лат, Уззаа гэх тэр бурхад чинь ямар ч хэрэггүй нэг шавар. Миний эзэнд (Аллах) намайг нүд оруулахад түүний хүч хүрэлцээтэй” гэв.

Зиннирегийн (радиаллаху анха) энэ их зориг, энэ бат итгэл үнэмшилийг харсан Эбү Жажил алмайрч хоцорчээ. Аллах эзэн Зиннирегийн залбиралыг нь биелүүлж түүнийг хараа оруулсан бөгөөд урьд уьдынхаасаа ч илүү сайн хардаг болгожээ. Энэ бүхэн Эбү Жажил ба түүний хажууд байсан мүшрикүүдийн нүдний өмнө болсон хэдий ч тэд итгэхийг хүссэнгүйгээр барахгүй: “Энэ бол түүний элч гэх нөгөө хүнийх нь хийж буй нэг илбэ, Мухаммедын замаар замнагсадын энэ бодолгогүй байдлыг хараад та нар гайхахгүй байна уу? Хэрвээ түүний зам зөв байсансан бол хамгийн түрүүнд бид итгэх байсан, гэтэл энэ заяа муут боолууд биднээс ухаантай болоод зөв зам олчихоо юу?” гэгцгээдэг байлаа.

Энэ үгсийн төллөө Аллах, Ахкаб сүрэгийн, 11-аэтийг илгээжээ. Утга нь: “Тэр кафирууд итгэгсэдэд хандан: “Хэрэв тэнд (ислам шашинд) сайхан зүйл байсан бол, үүнийг тэд (ядуус ба ерөвдмөөр хүмүүс) биднээс урьтаж мэдээд, түүн рүү гүйхгүй байх байсан бус уу?” гэгцгээсэн. Үнэндээ тэд, тэднээр (Куран судар ба итгэгсэд шиг) зөв замд ороогүй болхоор (Куран сударыг үгүйсгэхийн тулд): “Энэ Куран бол (Мухаммедын гаргасан) хуучиний нэг худал ном” гэх болно” хэмээжээ.

Дар-ул Эркам (Эркамын гэр)

Хайрт пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) мүшрикүүдийн асхабуудад хийсэн энэ тамлалд маш их гомддог байв. Тийм болхоор исламыг түгээхийн тулд бас сурахын тулд аюулгүй газар хэрэгтэй байлаа. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) энэ ариун ажилын төлөө Эркам гэх нэг мусульманы гэрийг авчээ. Энэ гэр Сафа толгодын өмнө зүгт, жижигхэн нэгэн гудамжинд өндөрлөг газар байрладаг байв. Эндээс ариун Кааб ойрхон, тов тодоор харагдна. Гэрийн хаалга нь орж, гарагсадыг хянахад хялбар байлаа. Гэрийн эзэн Эркам ч гэсэн Мекке хотод нэр хүндтэй, олоны танил нэгэн байлаа. Гэгээн элч (салаллаху алейхи уа сальлам) энэ гэрт асхабууддаа исламыг зааж номлодог агаад шинээр мусульман бологсод энэ гэрт ирж ислаамаар ариусаж, аугаа элчийн сэтгэлийг амраан, зүрхийг догдлуулсан гайхамшигтай сургаалыг сонсон хишэгтэн болдог байлаа. Тэд хайрт пайгамбарыг маань (салаллаху алейхи уа сальлам) амьсгаа даран, нүд цавчилгүй суун, чив чимээгүй сонсдог байв. Түүний ариун үгнүүдийн нэгийг нь ч марталгүйгээр цээжилдэг

байв. Гэгээн элч (салаллаху алейхи уа сальлам) өглөөнөөс орой болтол Эркамьн гэрт сууж мусульмануудад зааж сургах ажилаа хийдэг байлаа. Энэ гэр мусульмануудын анхны хорогдох газар ба “Дар-ул Ислам”(Исламийн гэр) болжээ.

Аммар бин Яасер (радиаллаху анхума) ийн айлджээ: “Дар-ул Эркамд” ороод Аллахын элчийн өмнө бараалхаад мусульман болохыг хүсээд очтол гэрийн хаалганы өмнө Сүхэйбтэй тааралдлаа. Би: “Чи энд юу хийж яваа юм бэ?” гэж түүнээс асуухад, тэр яг тэр асуултыг надаас эргүүлээд асуулаа. Би: “Гэгээн Мухаммедын өмнө очоод түүний үгийг нь сонсоод мусульман болхоор ирлээ” гэж хариулхад тэр би ч мөн чам шиг энэний төлөө ирсэн юм” гэв. Бид хамтдаа гэрт ороод түүний ариун сургаалыг нь сонсоод мусульман болхыг санал болгоход дуртайяа Исламыг хүлээн зөвшөөрсөн билээ”⁵⁸

Аммар мусульман болсноо хэнээс ч нуулгүй зарлаж байлаа. Түүнийг шашинаас нь гарахын тулд хамгийн ихээр тамлан зовоожээ. Гэвч тэрээр хэзээ ч энэ замаасаа ухарсангүй. Мүшрикүүд түүнийг ганцаар явж байгааг харсан даруйдаа барьж аваад, Мекке хотоос зайдуу нэг эрэг газар аваачаад түүний нүцгэн биеэн дээр төмөр хувцас өмсгөөд халуун наранд шарж, заримдаа түүний биеийг улайссан төмрөөр хайрч түлдэг байлаа. Ингэх болгондоо “Аллахыг үгүйсгэ... Түүнийг үгүйсгэ... Лат ба Узза бурхадад зальбираад аврагда...” гэж хэлдэг байв. Аммар энэ тэвчхэд хэцүү тамлалд тэвчээр заан “Миний эзэн бол Аллах, пайгамбар маань Мухаммед (алейхиссаллялам)” гэж хэлдэг байлаа. Мүшрикүүд энэ үгийг сонсох болгондоо маш их уурлан түүний цээжин дээр халуун чулуу тавьж, худагт хачан усанд живүүлхийг хүсдэг байлаа. Аммар бин Яасир Мухаммед (алейхиссаллялам) элчид ирж “Аяа, Расулуллах, Мүшрикүүд биднийг зовоож тарчилаах нь хэрээс хэтэрч байна гэхэд Мухаммед элч маань Амирыг маш их өрөвдөн: “Жаахан тэвчээрэй, Якзагийн эцэг минь!” гээд, “Аяа, эзэн минь, Аммарын гэр бүлээс хэнийг нь ч тамын зовлонг битгий амсуул” хэмээн залбирчээ.

58 ИБН Сагд, эт-Табакет III, 227: Хүким,эл-Мүстедрак III,449: ИБН Асакир,Тариху Димашк XXIV,219.

Анхны шахид (Итгэл үнэмшлийнхээ төлөө амиа өгөгсөд)

Гэгээн Аммарын (радиаллаху анх) эцэг Яасир, эх нь Сүмэйе бас дүү Абдуллах нар нь мусульман болцгоосон байлаа. Мүшрикүүд гэгээн Аммарт хийдэг байсан тэр тамлал яргачлалыг түүний эх, эцэг, дүүд нарт нь ч илүүтэйгээр хийдэг байлаа. Ийн яаргалж байхдаа нөгөө л өөрсдийн гараар бүтээсэн шавар бурхаддаа залбирахыг тушаадаг байлаа. ингэхэд нь тэд: “Арьсыг минь өвчин, махыг минь зүсэм зүсэмээр огтлон шулсан ч та нарын хүссэн тэр зүйлийг огт хийхгүй гээд “Лаа илааха иллаллах, Мухаммедүн расүүлүллах (Аллахаас өөр бурхан үгүй, Мухаммед түүний элч нь)” гэж хэлцгээж байв. Нэгэн өдөр Батха гэдэг газар Аммарын гэр бүлийг эрүүдэн зовоож байхад нь Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) тэдний хажуугаар өнгөрч явлаа. Өөрийн Асхабуудаа ийн тамлагдан байхыг хараад маш ихээр өрөвдөн хайлжээ. Гэгээн Яасэр: “Аяа, Аллахын элч минь! Бидний амьдрал үргэлж ийм тамлал дунд өнгөрөх юм гэж үү?” хэмээн асуухад Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам): “Тэвчээрэй, Яасэрийн гэр бүл минь! Баярлаарай, Аммарын гэр бүл минь! Та нарын очин баярлах газар бол огт эргэлзээгүйгээр диваажин билээ” хэмээжээ.

Бас нэгэн өдөр Аммарын (радиаллаху анх) гэр бүлийг мүшрикүүд галаар зовоож байхад Пайгамбар маань тэнд очиж: “Хөөе, гал аа! Ибрахим пайгамбарыг шатаагаагүйхэн шигээ Аммарыг гэр бүлийг ч шатаалгүй сэрүүн бол!” хэмээн зарлиглав. Сүүлд Аммар (радиаллаху анх) ар нуруугаа үзүүлхэд Пайгабарын маань залбиралын өмнөх түүлэнхийний сорив нь харагдаж байлаа.

Бас нэгэн өдөр Яасэрийн гэр бүлийг таМалсаар байж гэгээн Яасэр (радиаллаху анх) ба түүний отгон хүү гэгээн Абдуулах нарын амийг нь хөнөөн шахид болгожээ. Эбү Жахил гэгээн Сүмэйегийн (радиаллаху анха) хоёр хөлнөөс нь олсоор уяаад хоёр тэмээгээр хоёр тийшээ тэлүүлсээр байж дундуур нь тас татуулан аминд нь хүрчээ. Яарагчин Эбү Жахил энэ ажилдаа бахдан, энэ эмгэнэлт мэдээг Мухаммед (салаллаху алейхи уа сальлам) ба түүний асхабуудад хүргүүлэв. Энэ эмгэнэлт мэдээг сонсоод тэд маш их гашуудан уйлцаав. Энэ явдал мусульмануудыг нэг нэгнээ гэсэн хайр энэрэл ба тэдний хоорондын холбоосыг маш ихээр бататгажээ⁵⁹.

59 Ибн Сагд, эт-Табакет VIII,264: Сүхейл , эр-Павзүл-Үнф.с.II,86.

Асхаби кирам (анхдагч мусульманууд) мөргөл үйлдэх үедээ хэний ч байхгүй, харашгүй тийм газар очоод нууцаар мөргөлөө үйлддэг байлаа. Нэг өдөр Саад бин Эбу Ваккас, Саид бин Зейд, Абдуллах бин Месуд, Аммар бин Яасэр, Хаббаб бин Эрэт нар (радиаллаху анхум) Мекке хотын Эбү Дуб гэдэг нэг томоохон жалган дотор намаз (мөргөл) үйлдэж байлаа. Яг тэр үед тэд нарыг мөрдөж байсан Ахнэс бин Шерик ба хэсэг мүшрикүүд тэдний хараад доромжилж эхлэв. Мусульманууд энэ доромжилолыг тэвчиж чадалгүй гэнэт мөргөлөө дуусангуутаа тэдэн рүү дайрлаа. Гэгээн Саад (радиаллаху анх) тэмээний ясаар кафируудын нэгнийх нь толгойг хага цохьсоноор кафирууд айн зугтаан одов. Ийнхүү анх удаа мусульманууд кафируудын цусыг гоожуулсан билээ.

Эбү Зерри Гифаригийн мусульман болсон нь

Хүмүүс ганц нэгэрээ, аяар аяархан мусульман болцгоон зөв замд орцгоож байлаа. Исламын гэгээ Меккегээс гадуур ч гэсэн тархан гэрэлтүүлж эхэлжээ.

Исламын хүч түрэн тархаж байгаад атаархасан мүшрикүүд энэнийг зогсоох арга зам хайж эхэлсэн байлаа. Энэ мэдээг Бани Гифар овогийн Эбү Зерри Гифари сонсоод өөрийн дүү Үнейсийг Мекке хот руу энэ талаар судлаад ирхийг гуйн явуулжээ. Үнейс Меккед ирээд элчийн сургаалыг сонсоод маш их гайхан гэрлүүгээ бууцжээ. Ах нь Эбү Зер “Ямар мэдээтэй ирээв?” гэж асуухад нь “Гэгээн бас дандаа сайн сайхан руу зүтгэн тэмүүлж, муу муухай бүхнээс холдон дайжихыг номлосон маш агуу нэгэн хүнийг харлаа би” гэв. Эбү Зер: “За тийм байдаг байж, харин хүмүүс түүний талаар юу гэлдэцгээж байх юм?” гэж асуухад нь тэр үеийн алдартай яруу найрагч байсан дүү Үнейс: “Түүнийг хүмүүс яруу найрагч бас мэрэгч төлөгч, илбэчин гэгцгээж байна. Гэхдээ түүний яриа нь мэрэгч төлөгчийн, илбэчиний яриатай адил биш. Тэр бүү хэл ямар ч яруу найрагч шиг мөр холболгүй ярьж байна. Тэдэнтэй ч адилгүй юм байна лээ. Түүний яриаг нь хэнийхтэй ч зүйрлэшгүй сайхан бас уран юм билээ. Аллахын нэрээн андгайлъя, тэр хүн чин үнэнийг л мэддэг, жинэнэ үнэнийг л ярьдаг. Түүнд үл итгэгсэд худалч бас буруу замд төөрөлдөгсөд” хэмээн хариулжээ.

Энэ бүхнийг сонссон Эбү Зерри Гифари Мекке хот руу

очиж Мухаммед элчийг (салаллаху алейхи уа сальлам) харан мусульман болхоор шийдээд гартаа нэг саваа мод бас хэсэг идэж уух хоол унд аваад Мекке хотын зүг замд гарчээ. Меккед ямар зорилгоор ирсэнээ хэнд ч хэлсэнгүй, учир нь тэндхийн мүшрикүүд мусульмануудыг хэрхэн зовоож байгаа сургийг дуулсан байлаа. Эбү Зерр Меккед хэнийг ч таньдаггүй байлаа. Бас тэрбээр сул дорой нэгэн билээ. Тиймээс ч хэнээс ч юу ч асуусангүй Каабын хажууд суугаад Аллахын элчийг (салаллаху алейхи уа сальлам) хүлээж түүнийг хаана байралдагийг нь тандаж эхэлжээ.

Үдэш орой нэгэн гудамжны буланд хоноглохоор хэвтэжээ. Гэтэл түүнийг гэгээн Али (радиаллаху анх) хараад очих газаргүй нэгэн болохыг нь ухаараад түүнийг гэртээ аваачжээ. Ямар ажилаар Меккед ирсэн талаар Эбү Зерр юу ч ярсангүй. Өглөө босоод ахиад л Каабын хажууд очиж, түүнийг орой болтол хүлээсэн боловч Мухаммед (салаллаху алейхи уа сальлам) ирсэнгүй, нөгөө л гудамжины мухарт хоноглохоор очоод хэвтэж байтал гэгээн Али бас л тэр хавиар өнгөрч явлаа. “Энэ хөөрхий амьтан хоноглох гэрээ одоо болтол олоогүй юм байх даа” хэмээн түүнийг ахиад л гэртээ аваачиж хонуулжээ. Маргааш өглөө нь урдын адилаар Каабын хажууд очоод өдөржин хүлээсэн авч хайсан хүнтэйгээ учирсангүй тул мөн л нөгөө гудамжиндаа очиж хэвтээд гэгээн Алитай таарчээ. Али ч (радиаллаху анх) урьдын адилаар түүнийг гэртээ аваачив. Энэ удаа түүнээс ямар зорилгоор, хэнтэй уулзхаар Меккед ирсэн талаар асуухад нь Эбү Зерр: “Хэрэв чи надад үнэнийг л хэлнэ гэж амлах юм бол хэлнэ” гэв. Гэгээн Али: “Хэл, би чиний нууцыг хэнд ч задлахгүй” гэв. Эбү Зерр: “Би энэ газраас нэг элч гарсаныг дууллаа. Түүнтэй уулзаж, учирхаар энд ирлээ” гэв. Гэгээн Али (радиаллаху анх): “Чи зөв газраа олжээ, бас маш ухаантайгаар шийджээ. Одоо би Мухаммед рүү очно. Намайг дагаад яв, миний орох гэрт чи ч бас ороорой, хэрвээ замд чамд ямар нэг муу зүйл хийх хүн таарвал би зогсоод гуталаа янзалж эхлэх болно, харин чи намайг өнгөөд явчихаарай” гэв.

Гэгээн Эбү Зерр (радиаллаху анх) Алиг дагаж яваад элчийн ариун царайг харах хувь тохиожээ. Эбү Зерр: “Эссаламү алейкүм” гэж түүнд мэндлэв. Энэ мэнд бол Ислам шашины анхны мэнд байсан ба Эбү Зерр энэ мэндийг хэлсэн хамгийн анхны хүн болжээ. Гэгээн элч (салаллаху алейхи уа сальлам) ч гэсэн мэндийн хариуг нь өгөөд “Аллах эзэн таньд хайр ивээл өгөг”

хэмээн хариулжээ. Тэгээд “Чи хэн бэ?” хэмээн түүнээс асуув. Эбү Зерр: “Би Гифар овогийн хүн байна” гэхэд нь: “Хэзээнээс энэ хотод ирэв?” гэж асуухад нь. “Гурван хоног болож байна” гэв. Мухаммед элч: “Энэ гурван хоногт чамайг хэн хооллож байсан бэ? Энд хамаатан садан чинь байгаа юу?” хэмээн асуулаа. “Надад энд хамаатан садан гэж үгүй билээ. Би зем зем уснаас уухаас өөр юу ч идэж уугаагүй. Энэ усыг уухаар огт өлсөж бас цангаагүй билээ” гэв. Пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) “Земзем бол ариун ус юм, өлсөхсөдийг ч цатгадаг билээ” хэмээжээ. Ингээд Эбү Зерр Мухаммед алейхисальламд “Надад Исламыг заагаач” гэв. Пайгамбар маань ч (салаллаху алейхи уа сальлам) түүнд келимэ-и шахаадатыг (гэрчлэл үг) хэлж өгөхөд тэрээр даган хэлэв. Ийнхүү тэрээр мусульман болон ахндагч гэх тэр тодотголтой мусульмануудын тоонд багтжээ⁶⁰.

Эбү Зерр Гифари мусульман болсныхоо дараагаар элчид (салаллаху алейхи уа сальлам) хандан: “Аяа, Расулуллах, чамайг жинхэнэ элч болгон илгээсэн Аллахын нэрээн андгайлъя, би энэ үнэнийг мүшрүүдэд зарлан тунхагламаар байна” гэв. Тэгээд ариун Каабын хажууд очоод: “Хөөе, мүшрикүүдээ! “Эшхэдү эн лаа илааха иллаллаху, вэ эшхэдү энна Мухаммеден абдүхүү вэ расүүлүх - Би Аллахаас өөр залбирч мөргөх бурхан үгүйг гэрчилнэ, бас Мухаммед бол түүний боол нь бөгөөд элч нь болохыг гэрчилнэм” хэмээн чанга дуугаар хэлэв. Үүнийг сонссон мүшрикүүд түүнийг барьж аваад газар унагаан дэвслэн зодож, цус нөжтэй нь хольж орхив. Үүнийг харсан гэгээн Аббас (радиаллаху анх) “Больцгоо, энэ хүн бол та нарын наймааны жингийн замд байх нэг овгийн хүн байна. Энэ хүнийг ингэж зодчихоод дараа тэр замаараа тайван явж чадна гэж бодож байна уу та нар?” гэв. Энэ үгийг сонссон мүшрикүүд Эбү Зеррийг зодхоо зогсооцгоов.

Гэгээн элч (салаллаху алейхи уа сальлам) Эбү Зеррд (радиаллаху анх) нутагтаа буцаж очоод ислам шашинийг түгээхийг зарлиглав. Тэр ч нутагтаа ирсэнийхээ даргаар энэ хорвоогийн эзэн нь агуаа Аллах болох нь, бас Мухаммед элч түүний үнэнч элч нь бөгөөд түүний авч ирсэн шашин нь жинхэнэ үнэнийг өгүүлэгч, чин үнэн шашин болох талаар бас өөрийн овгийнхоныхоо энэ итгэл үнэмшил нь худал хуурмаг нэгэн төөрөгдөл хэмээн номлож эхэлжээ. Түүний энэ үгийг сонсож байсан хүмүүс эсэргүүцэн шуугилдаж эхэлхэд овгийн ахлагч

болох Хаффаф: “Хүмүүс ээ, дуугүй болцгоо. Түүний юу ярихыг нь сонсъя” гэхэд нь Эбү Зерр (радиаллаху анх) ийнхүү ярьж эхлэв:

“Би мусульман болхоосоо өмнө нэг удаа өөрийнхөө бурхан Нүхэмийн өмнө тавагтай сүү тавиаад зальбирч байлаа, гэтэл нэг нохой гүйж ирээд нөгөө сүүг нь уугаад дараагаар Нүхэм бурханы толгой руу нь сарьчихаад яваад өгөхийг нь хараад миний шүтэж дээдэлж байсан бурхан маань нэг муу нохойноос ч хүртэл өөрөө өөрийгөө хамгаалж чадах хүчгүйг ойлгосон билээ. Нохой ч хүртэл доромжилдог ийм бурхадад мөргөн зальбирах нь та нарт таалагдаж байна гэж үү? Энэ бол жинхэнэ солиорол биш гэж үү?” гэж асуухад бүгд санал нэгдэн толгой дохицгоов. Тэдэн дундаас нэг нь “Чиний тэр элч чинь тэгээд юуг номлож байна? Түүний хэлсэн бүхэн нь үнэн гэдгийг нь чи яаж мэдэв?” гэж асуув. Эбү Зерр (радиаллаху анх) чанга дуугаар: “Тэр Аллах эзэн ганц бас түүнээс өөр ямар ч бурхан тэнгэр үгүй бөгөөд тэрбээр бүхнийг бүтээн туурвисан ба энэ хорвоогийн цор ганц эзэн нь болохыг номлож байна... Хүмүүсийг ч үүнд итгэхийг уриалан дуудаж байна... Сайн сайханд үйлст, тусч сайхан сэтгэлд бас энэрэнгүй үзэлд дуудаж байна. Эмэгтэй хүүхдүүдээ амьдаар газар булах гэх мэт та нарын хийж буй энэ муу муухай харгислал, дарлалаа зогсоож ийм муухайгаас зугтаан цээрлэхийг номлож байна”. Ийнхүү тэрээр ислам шашиныг тайлбарлаж эхлэв. Өөрийн овгийн муу муухай буруу бүхнийг нэг нэгээр нь тоочиж энэ бүхэнийг зогсоовол юу өөрчилөгдөж болох талаар ойлгууллаа. Түүнийг сонсож байсан хүмүүс дотороос овгийн ахлагч Хаффаф бас түүнй төрсөн дүү Үнэйс гэх мэт хэсэг хүмүүс мусульман болж, ислам шашиныг хүлээн зөвшөөрчээ⁶¹.

Анх удаа ариун Каабд Куран судар уншигдсан нь

Асхаб кирам нэг өдөр буйдхан нэг газар цуглаад ярилцаж суулаа: “Аллахын нэрээр андгайлъя! Мухаммед элчээс (салаллаху алейхи уа сальлам) өөр энэ курейшийн мүшрикүүдэд Куран сударыг ил тодоор унших нэг ч хүн бидний дундаас гарсангүй. Энэ сударыг тэдэнд ил тодоор уншиж өгөх хүн байна уу?” гэцгээв. Тэнд гэгээн Абдуллах ибн Мэсүд (радиаллаху

61 Бухара “Менакиб”, 10: Фезайлүс-Сахабе, 62: Ибн Исхук, Эс-Соре, с, 122-123.

анх) байлаа. Тэр “Би уншиж өгье” гэв. Зарим асхабууд “Хөөе, Абдуллах, Мүшрикүүд чамд ямар нэгэн гэмтэл учруулах вий гэж айж байна. Тиймээс энэ ажилыг өөрийгөө мүшрикүүдээс хамгаалж чадах хүчтэй нэгэн хийг ” гэцгээхэд Абдуллах: “Та нар намайг явуул, Аллах эзэн намайг хамгаалах болно” гэж тэднээс гуйв.

Маргааш нь үдээс өмнө Макам-и Ибрахимийн (Каабын өмнө байх индэр) хажууд очлоо. Тэнд мүшрикүүд бүгд цуглацгаасан байлаа. Абдуллах ибн Мэсүд тэнд зогсоод Бисмиллахаар (уншилгын эхний ает) эхлээд Рахман сүрег (бүлэг) уншиж эхлэв. Мүшрикүүд нэг нэгэндээ “Үммү Абдын хүү юу уншаад байна, энэ бол Мухаммедын нөгөө шашины номлол байх нь” хэмээн түүний зүг очин түүнийг бүлэглэн зодоод цус нөжтэй нь хольж орхив. Ингэж зодуулж байхдаа ч тэр уншихаа зогсоохгүй байлаа. Нүд нүүр нь хөх няц болоод, цус нөжөө гоожуулсаар асхабуудынхаа хажууд иржээ. Асхабууд энэнд маш их харамсажээ.

Гэхдээ Абдуллах ибн Мэсүд огт харамсаагүйгээр барахгүй харин ч Аллахын Кураныг тэдэнд дуулгасандаа маш их баяртай байлаа. “Би Аллахын дайснуудыг өнөөдөрийнх шиг ийм арчаагүй байгааг урьд өмнө хараагүй билээ. Хэрвээ та нар хүсвэл маргааш тэдэнд ахиад нэг уншиж өгөө” гэв. Асхабууд “Үгүй, өнөөдөр хийсэн чинь чамд хангалттай” гэцгээв⁶².

Түфэйл бин Амирийн мусульман болсон нь

Пайгамбар (элч) (саллаллаху алейхи уа сальлам) Мекке хотод исламыг ил тодоор түгээн зарлаж эхлэх үед өдөр, шөнө гэлгүй энэ ажилаа хийж байлаа. Меккегийн мүшрикүүд ч элчийг зогсоохын тулд чармайж байлаа. Түүнд итгэн мусульман бологсодыг муу муухайд гүтгэн доромжилж дээрлхэн, тэднийг тамланзовоохыг илүүд үзэж байлаа. Мухаммед элчтэй (саллаллаху алейхи уа сальлам) ярьж байгаа хүнийг харсан даруйдаа тэрэн лүү гүйн очоод Мухаммедын хэлсэн бүгд худал, түүнд битгий итгэ хэмэн ятгалга явуулж байв. Гаднаас Мекке хотод ирэгсэдийг Элчтэй (саллаллаху алейхи уа сальлам) уулзуулхгүйн тулд хэрэгтэй бүхнийг хийхэд бэлэн байлаа.

Мусульмануудын шашинаа шүтэхийг хичээн амьдрах ийн хэцүү цагт Туфэйл бин Амир эд-Девсий Меккед иржээ. Түүнийг

62

Ибн Исхак, Эс-Сопе,с, I, 166: Ибн Хишам Эс-Сопе I, 314-315.

харсан даруйдаа мүшрикүүд замыг нь тосон очоод: “Аяа, Түфэйл, сайн явж ирэв үү? Манай нутагт ирсэн болхоор чамд сануулах нэг зүйл байна. Энд Абдулмутталибын өнчин хүүгийн буруу номлол дэлгэрээд байна. Хүүг эцэгээс нь, ахыг дүүгээс нь, эхнэрийг нөхрөөс нь салган холдуулж байна. Биднийг хооронд нь зөрчилдүүлж түүний үгийг сонссон хүү эцэгээ хүндлэн сонсохоо больж, хүмүүс нэг нэгэндээ захирагдхаа больж мусульман болцгоож байна. Бидний энэ зовлон чиний ч овгийнхонд ирэх вий гэж айх юм, тиймээс чамд захиx зүйл бол тэр элч гээд байгаа хүнтэй хэзээ ч битгий нүүр тулж ярь! Түүний хэлснийг битгий сонс! Болгоомжтой бай. Энд их удсаны хэрэггүй, хурдхан буц” гэв. Энэний дараа юу болсныг Түфэйл бин Амир ийн өгүүлж байна.

“Тэд надад энэ үгээ маш их хэлж ахин дахин тайлбарлахыг хичээж байлаа. Би ч тэдэнд итгэн Мухаммедтэй (салаллаху алейхи уа сальлам) ярихгүй бас түүнийг сонсохгүй гэж шийдсэн билээ. Тийм ч болхоор ариун Кааб руу очихдоо түүнтэй таарчих вий хэмээн болгомжилон чихэндээ хөвөн чихэж бөглөөд очлоо. Очсоныхоо маргааш өглөө нь Кааб руу мөргөхөөр очив. Тэнд Аллахын элч намаз (мөргөл) үйлдэж байгааг хараад зогслоо. Түүний уншиж буйг чихэнд халыг сонсогдлоо. Чагнаад баймаар энэ гоё үгс, энэ гайхмаар утгыг би урьд өмнө сонсоогүй билээ. Тэгээд өөрөө өөртөө “Би сайн, мууг ялгаж чадах ухаантай хүн биш гэж үү?! Тэгээд ч би яруу найрагч. Түүнтэй ярилцаад үзье, хэрэв үнэн зөвийг хэлж байвал түүнийг сонсьё, хэрвээ түүний яриа буруу байвал хаяаад л яваад өгье” гэж хэллээ. Ингээд нэг газар нуугдаад Аллахын элчийг (салаллаху алейхи уа сальлам) намазаа дуусгаад гэр лүүгээ харихыг хүлээв. Тэгээд түүний араас нь дагаж эхэллээ. Түүнийг гэртээ ороход би ч бас дагаад орчихов: “Аяа, Мухаммед, намайг энэ хотод ирхэд танай овгийнхон надтай уулзаад надад чиний талаар ийн ярлаа. Чамаас хол байж, үл сонсохыг минь хүслээ. Би ч айсандаа чихээ хүртэл хөвөнгөөр бөглөж байлаа. Гэтэл би өнөөдөр санаандгүй чамайг мөргөлөө үйлдэж байгааг чинь харлаа. Чиний уншиж буй тэр зүйлийг сонсоод үнхээр сэтгэл алдарлаа. Ийм сайхан зүйл уншиж байгаа болхоор чи яав ч муу хүн байж таарахгүй гэж бодон чамайг дагаад ирлээ. Одоо чамайг сонсмоор байна. Чи юу л хэлнэ, би хүлээн зөвшөөрхөд бэлэн байна” гэлээ. Мухаммед элч надад ислакийг тайлбарлаад, Куран судраас хэсэг уншиж өгөв. Аллахын нэрээр

андгайлъя, би амьдралдаа энэнээс сайхан үг бас энэнээс сайхан хүнтэй учирч үзээгүй билээ. Би тэр дороо л калимэ-и шахадатыг хэлэн мусульман болсон юм.

Би элчид: “Аяа, пайгамбар минь, би бол нутаг орондоо хүндлэгдсэн нэгэн билээ. Миний үгийг хүн бүр сонсож надад итгэдэг юм. Би энэ ариун шашинаа тэдэнд ч бас хүргэж тэднийг ч бас уриалан дуудмаар байна. Намайг тэдэнд очиход Аллах эзэн нэг ер бусын зүйл харуулаг та энэний төлөө залбираач. Тэгвэл энэ гайхамшигийг харсан манай хүмүүс надад итгэх итгэл нь улам батжин, миний шашинаа номлох ажилд тус дэм болох болно” гэлээ. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) алгаа дэлгэн “Аяа, Аллах минь, түүнд туслан түүнийг хүчирхэгжүүлээч!” хэмээн залбирав.

Ингээд би мусульман болон нутаг буцлаа. Тас харанхуй шөнө манай овгийнхон нутагладаг голын эргийг даган явхуйд цав цагаан нэгэн туяа миний магнайд гэрэлтэн замыг минь өдөр мэт гэрэлтүүлж байлаа. Би “Аяа, Аллах минь, энэ туяаг миний магнайнаас өөр газар байрлуулаач эс бөгөөс манай овгийн мунхаг хүмүүс шашинаасаа гарсанаас болж надад цээрлэл болгон энэ туяаг өгчээ гэж мэднэ” хэмээн залбирхад тэр туяа даруйдаа миний ташуурийн үзүүрт гэрэлтэж эхлэв. Намайг тосгондоо ирхэд тэнд байгсад миний ташуурын үзүүрт нар мэт хурцаар гэрэлтэх туяаг харан гайхацгааж байлаа. Намайг гэртээ ирхэд аав минь надад ирж намайг тэврэн үнсэв. Би аавдаа: “Аав минь, хэрвээ та урьдын адилаар энэ шавар бурхаддаа итэгсээр байх юм бол би таны хүү, харин та миний эцэг байхаа болино” гэхэд аав минь гайхан “Ягаад чи ингэж хэлэв, хүү минь!” гэв. Би: “Би Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) шашинд итгэж мусульман боллоо” гэж аавдаа исламыг ойлгуулж эхлэв. Намайг хэсэг сонссоныхоо дараагаар аав маань “Тэгвэл хүү минь, би ч гэсэн чиний шашинд оръё. Чиний шашин чинь ч миний шашин болог” гээд калимэ-и шахаадатыг (гэрчлэл үг) хэлэн мусульман боллоо. Тэгээд аавдаа угаал хэрхэн үйлдэхийг зааж өглөө. Дараа нь эхнэр минь ирхэд түүнд бас исламыг ойлгууллаа, тэр ч гэсэн мусульман болсон билээ.

Маргааш өглөө нь Дэвс овгийнхонийг цуглуулаад тэдэнд ислам шашиныг номлож гарлаа. Гэвч тэд ойлгохыг хүссэнгүйгээр барахгүй нүгэл хийхээ үргэлжлүүлсээр байлаа. Тэр бүү хэл намайг шоовдорлон надаар тоглоом тохуу хийж эхэллээ. Тэдний

ихэнх нь мөрийтэй тоглоом ба архинд донтсон байсан болхоор намайг сонсохыг ч хүссэснгүй.

Хэсэг хугацааны дараа Меккед ирж өөрийн овгийнхонийгоо элчид ховлоод “Аяа, Аллахын элч минь, Дэвс овгийнхон Аллах эзний эсрэг зогсож ислам шашишнаас зугтааж байна, та тэднийг зөв зам олоосой гэж залибраач” хэмээн гуйв. Бүхнээс энэрэнгүй элч (салаллаху алейхи уа сальлам) алгаа дэлгэн Каабын зүг харан “Аяа, Аллах минь! Дэвс овгийнхонийг зөв замыг үзэн исламд оруулж хайрла” хэмээн залбирав. Тэгээд над руу хандан “Нутаг руугаа буц, тэднийг цэвэр ариун сэтгэлээр, сайхан хэлээр ислам шашинд уриалан дууд! Тэвчээртэй бас зөөлхөн ханд” гэлээ. Би тэр даруйдаа нутагтаа ирэн тэднийг исламыг номлож эхлэв⁶³.

Яармаг худалдаанд ирэгсэдийг исламд уриалах нь

Мекке хотод жил бүр газар газраас мөргөлчид ирж ариун Каабд мөргөдөг байлаа. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) ч гэсэн ирсэн мөргөлчдийг угтан аваад дайлж цайлан, тэдэнд ислам шашиныг номлоно. Аллах бол цор ганц бас өөрийгөө түүний илгээсэн элч болохоо тунхаглан зарладаг байлаа. Нэг өдөр Вэлид бин Мугире мүшрикүүдийг цуглуулаад “Хөөе, Курейш овгийнхоон, Каабд ирж мөргөх улирал ойртож байна. Мухамедийн нэр хорвоо ертөнцөд түгэж байна. Ирсэн мөргөлчид түүнтэй уулзаад түүний номлолд итгэн шашинд нь орох вий гэхээс айж байна. Тиймээс эртнээс нэг арга бодох хэрэгтэй байх, бүгдээрээ нийлээд түүнийг худал зүйлд нэг амаар гүйтгэцгээе, хэрвээ тэгвэл тэр худалч болж гарах болно” гэв. Мүшрикүүд ч дуртайяа «Вэлид минь чи ч ёстой ухаантай хүн шүү, чи л юу л гэж хэлвэл бид чинийхээр болох болно» гэгцгээв. Вэлид “Та нар саналаа хэлцгээе, би сонсьё гэхэд нь тэд “Түүнийг мэрэг төлөгч гэгцгээе” гэв. Вэлид үүнийг эсэргүүцэн, “үгүй тэр бол мэрэг төлөгч биш, бид амьдралдаа маш их мэрэг төлөгчдийг харсан билээ. Тэр бас үнэн худлийг шударгаар нь хэнээс ч юунаас ч айхгүй хэлдэг хүн бус уу? Мухаммедийн айлдаж байгаа тэр зүйл мэрэг төлөгчийнхтэй төстэй бус, тэгээд ч түүний байж байгаа байдал үзэл суртал нь мэргэн хүнээс тэс ондоо. Түүнийг худлаа

63

Ибн Хишам Эс-Сопе I,382-385: Сүхейл , эр-Павзүл-Үнф.с.II,168.

хэлж байгааг хэзээ ч сонсоогүй билээ, хэрвээ ингэж хэлэх юм бол хэн ч бидэнд итгэхгүй” гэв. Мүшрикүүд энэ удаа “Түүнийг галзуу солиотой гэгцгээ” гэв. Велид бас л эсэргүүцэн “Үгүй, тэр ямар ч галзуу солиотой хүнтэй төсгүй, ухаан нь саруул хүн, бид нар галзуу хүн ямар байдгыг маш сайн мэднэ. Тэр хэзээ ч тийм байдаггүй, хэрвээ тэгэж хэлвэл хэн ч бидэнд итгэхгүй харин ч биднийг худалч гэх болно” гэв. Мүшрикүүд “Тэгвэл яруу найрагч гэгцгээ...” гэв. Вэлид бас “Үгүй тэр бол яруу найрагч биш, бид нар янз янзын шүлгүүдийг бүгдийг нь мэднэ, харин түүний айлдаж буй энэ зүйл ямар ч шүлэгтэй төсөөгүй” гэлээ. Энэ удаа “Түүнийг илбэчин гэгцгээ” гэв. Вэлид “Тэр бас илбэчин биш, бид нар илбэчингүүдийг юу хийдгийг ч мэднэ. Харин мухаммед бол хэзээ ч хүний нүд хуурдаггүй хүн билээ, түүний ярианд ч гэсэн ямар хор уршиг байхгүй. Түүний яриа нь дэлхийгээр нэг түгэх болно. Тэрний уран илтгэх чадварыг давж ярих хүн энэ хотод байхгүй билээ. Бид тэрний талаар юу ярьсан ч гэлээ бидний худал ярьсаныг хүмүүс мэдэх болно гэв. Мүшрикүүд юу хэлхээ ч мэдэхгүй хий дэмий алмайран зогсоцгоов. “Бидний дотор хамгийн настай нь бас хамгийн ухаалаг нь та билээ. Та юу л гэнэ, бид таны хэлсэнийг хийхээ амлъя” гэгцгээв.

Вэлид бин Мугире хэсэг бодсоныхоо дараагаар “Энэ бүхнээс арай дээр нь бид түүнийг илбэчин, хараалчин гэж хэлцгээе гэв. Энэ нь арай л дөхөм, ягаад гэвэл тэр яриагараа хүмүүсийг отог овгоос нь, төрөл төрөгсдөөс нь салгаж чадаж байгаа билээ” гэв. Түүний хажууд байхад ч гэсэн энэ үгийг нэгэн дуугаар хүлээн зөвшөөрөв. Ингээд тэд тэндээсээ тараад, таарсан хүн болгондоо “Мухаммед бол илбэчин...” хэмээн цуу дэгдээв. Ариун Каабд мөргөхөөр мөргөлчид ирж эхэлхэд түүний өмнөөс угтан очоод Мухаммедтэй (салаллаху алейхи уа сальлам) ярихгүй байхыг, түүний илбэчин болохыг сануулж байлаа Гэвч мүшрикүүдийн энэ ажил төдийлөн үр дүнтэй болсонгүй, ягаад гэвэл ислам шашины талаарх яриа араб нутгаар тархан өөрсдийн шүтдэг шавар бурхаддаа эргэлзэж эхэлсэн байна.

Аллах Велид бин Мугирег маш ихээр тамлан зовоох талаар ает буулгажээ. Энэ нь Мүддэссир сүрегийн (бүлэг) 11-ает юм. Утгачилбал: “Аяа, элч минь, тэр ганцаар өнчирөх хүний (баялагаас ангид төрсөн Велид бин Мугире мэт буруу номтоны) учирыг (гэсгээлийг) надад үлдээ. (Түүнийг цээрлүүлхэд би л хангалттай. Би тэр буруу номтоныг бүтээсэн юм.) Би түүнд их эд баялаг өгсөн.

(Нэг ч малгүй ядуу гуйлагчинд би маш их хөрөнгө хишиг өгсөн билээ) баялаг хөрөнгийг бүгдийг нь би өгсөн. Түүний амьдралыг уртасгаж, бас нэр хүндтэй болгосон. (Мекке хотод нэр төртөй ажил авч, Мекке ба Тайф хот хоёрын хоорондох цэцэрлэгүүдийн эзэн нь боллоо. Түүнийг Рейханет-үл Араб хэмээн нэрийдлээ. Түүнийг бүх хүмүүс хүндлэн дээдэлж үгийг нь дагадаг байсан. Энэ бүх буян хишигт баярлан талархах ёстой бус уу? Энэ буяныг түүнд бий болгосон Аллах эзэнээ хүлээн зөвшөөрч түүнд итгэх хэрэгтэй бус уу?) Бидний өгсөнийг (эд хөрөнгө ба үр хүүхдүүд) ахиад олшруулахыг хүснэ. (Энэ өөрт өгөгдсөн буян хишигээ мэдрэн Аллахдаа залбирахыг үл хүснэ. Энэ юутай аймар сохрол вэ? Энэ юутай их цамаан байдал вээ?) Үгүй! (Тэр буруу номтоны, тэр шунхай сэтгэлтийн хүсэл биелэгдэхгүй. Түүний эд баялаг үр хүүхдэд нь олшрохгүй) Ягаад гэвэл, тэр аетүүдээс (Куран Керимээс) зөрж эсэргүүцэн, үл тоомсорлов. (Аллахын элч үнэн болохоо, жинхэнэ элч болохоо чин зүрхнээсээ ойлгуулсан ч зөрж тэрслэж, түүнд үл итгэлээ. Ямар том эндүүрэл вэ?) Тэрнийг Сауд тамлал дунд хаях болно... Энэ аетэд байгаа “сауд” үгийн утгыг хадис шерифт ийн тайлбарлажээ. Сауд бол тамын нэгэн уул юм. Тэр ууланд кафир 70 жилд гарч чадна. Тэгээд тэрнээсээ унана. Энэ ийнхүү үргэлжилсээр байх болно” дараа нь энэ кафир (Аллахын элчид илгээгдэн энэ Куран судрыг хэрхэн муулахаа) бодлоо (өөрөө өөртөө) нэгэн хэмжүүр бэлджээ (юу гэж муулах үгээ бэлджээ). Тэрнийг хараал идээсэй, (ариун Куран судрыг) яаж хэмжүүр бэлдэж чадаж байна. Ахин дахин түүнийг хараал идээсэй билээ. Хэрхэн хэмжүүр бэлдэж чадав аа. Дараа нь (өөрийн хүмүүсдээ эсвэл Куран судрын талаар юу гэхийг нь) харлаа. Дараа нь (уурлан Куран судрыг бас яаж үгүйсгэх үгээ олж чадаагүйдээ) хөмсгөө зангидан нүүрээ үрчийлгэв. “Энэ (Мухаммедын үгнүүд) зөвхөн илбэчингүүдээс сурсан нэгэн илбэ юм. Энэ үг бол яах аргагүй хүний л үг” гэв. Үнэндээ энэ хүн бол Куран судар гайхамшигтай нэгэн ном болохыг, хүн ба бугийн ч үгтэй төсөөгүй болохыг хамгийн анх өөрийн хажууд хүлээн зөвшөөрсөн билээ. Дараа нь энэ хүн найз нөхөдөө баярлуулахын тулд ярьсанаасаа булзсан. Куран Керимд огт нийцээгүй худал хуурмаг гүтгэлэг хийж эхэлжээ. Ийнхүү өөрөө өөрийгөө бурханы гэсгээлд бэлэн болгосон юм. Аллах эзэн ийн айлджээ: Би түүнийг Секерийн тамд хаях болно. Секерийн тамын юу болохыг чамд хэн мэдэгдсэн бэ? Энэ там бол хүний биенээс өчүүхэнийг ч

үлдээхгүй (бүгдийг нь алга болгон) тэгээд буцаагаад хэвэнд нь оруулаад (яг адил тамлалыг) үргэлжлүүлсээр байдаг” хэмээжээ.

Мүшрикүүдийн Куран судрыг сонссон нь

Мүшрикүүд хүмүүсийг шашинд ороход нь саад болохыг үргэлж завддаг байлаа. Меккегийн ард түмэн Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) авч ирсэн Куран судрыг уншихад үргэлж саад болдог байлаа. Харин кафирүүд шөнө оройгоор нууцаар эсвэл Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) гэрийн хажууханд хашааны мухард нуугдаад сэмхэн түүний Куран судрыг сонсдог байлаа. Харин өглөө болон харуй бүрий арилж эхэлхэд нэг нэгнээ харсан мүшрикүүд өөрсдөөсөө ичэцгээн ахиад ийм зүйл хийхгүй хэмээн ярилцдаг байв. Гэвч маргааш орой нь бас л нэг нэгэндээ хэлэлгүйгээр Мухаммедын (салаллаху алейхи уа сальлам) гэрийн хажууханд нуугдан Куран судрыг сонсоцгооно. Ахиад л өглөө болоход нэг нэгнийгээ хараад гайхан алмайрцгаана. Ахиад л ийм зүйл хийхгүй хэмээн тангараг өргөн салсан ч энэнээсээ салж чадахгүй байлаа. Нэг орой мүшрикүүд Каабын хажууханд цуглаад: “Мухаммедыг дуудан ярилцгаая. Эс тэгвэл сүүлдээ биднийг зовоох болно” хэмээн Аллахын элчийг дуудуулав. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) ч ирж мүшрикүүдийн хажууханд суув. Мүшрикүүд: “Хөөе, Мухаммед, бид чамтай тохиролцах гэж чамайг дуудлаа. Бид өнөөдрийг хүртэл араб хүмүүсийг хооронд нь бутарган, яс хаяж асуудал үүсгэсэн чам шиг хүн хараагүй билээ. Чи бидний өвөг дээдсийн шашиныг буруушааж, бидний бурхадыг муулсан, бас биднийг доромжилсан, бидний эв найрамдлыг эвдэж, нэг нэгэнтэйгээ дайсагнахад хүргэсэн. Хэрэв чи алт мөнгө эрэлхийлж энэ бүхнийг хийгээд байгаа бол бид чамд хүссэн тэр эд хөрөгийг чинь цуглуулаад өгье. Хэрэв чи хэргэм зэрэг хүсээд байгаа юм бол бид чамайг бидний даргаар томилон үгийг чинь дагъя. Хэрвээ буг чөтгөр шүгэлсэн бол бид бүх л боломжуудыг хайж чамайг анагаах арга хэмжээ авъя...” гэгцгээв.

Хорвоо ертөнцийн энэрэл болсон элч маань тэднийг сонссоныхоо дараагаар: “Хөөе, күрейшийн ард түмэн та бүхний энэ хэлсэн зүйл огт ор үндэсгүй зүйл. Миний хүсэл зорилго бол та нараас эд хөрөнгө олохын тулд биш, та нарын захирагч болохын тулд биш, та нарын хүндэтгэлийг хүртэхийн тулд биш. Гагцхүү

Аллах эзэн намайг та нарын элч болгон илгээсэн бөгөөд надаар дамжуулан нэгэн ариун судар илгээж байна. Та нарын (итгэн дагагсад) нэгэн диваажингийн баярт мэдээ буй ба (үл итгэгсэд тамд орох) нэгэн аймшиг бий болохыг надад зарлигласан юм. Би эзэнийхээ энэхүү зарлигийг та бүхэнд түгээн дамжуулсан билээ. Хэрвээ та миний шашинд итгэвэл энэ нь та бүхнийг энэ хорвоо хийгээд хойд ертөнцөд нэгэн жаргалын түлхүүр болно. Эс итгэн зугтаан дайжих юм бол Аллах эзэн та нарын гэсгээлийг өгөх хүртэл би их эзэний зарлигийг ёсчлон биелүүлэхын тулд болохоос болохгүй хүртэл тэмцсээр болно.....” гэв.

Эбү Жахил, Үмейе бин Халеф ба бусад мүшрикүүд хамтаар: “Хөөе, Мухаммед, манай нутагт амьдрал ямар хүнд хэцүүг чи мэднэ. Чи үнэхээр элч юм бол тэр бурхан тэнгэрээсээ гуйгаач, бидний амьдралыг хүндрүүлж байгаа энэ их хад чулууг энэ уул толгодыг эндээс зайлуулж, манай улсыг хөгжүүлэн хүчирхэгжүүлж, бас Шам ба Ирак хотуудад байх тэр их гол мөрнийг манай нутгаар урсгаж, бидний их өвөг дээдэс болох Кусей бин Килаб гэх мэт хүмүүсийг буцаагаад амилуулж өгөөч, учир нь Кусей бин Килаб шударга үнэнч агуа хүн билээ. Тэр хүн чиний хэлсэн бүхэн үнэн худал болох талаар бидэнд хэлэг, хэрвээ тэр хүн чамайг хүлээн зөвшөөрөх юм бол бас бидний энэ хүсэлтүүдийг биелүүлэх юм бол бид ч гэсэн чамайг элч болохыг хүлээн зөвшөөрөх болно. Бас чиний бурханы хүч чадалыг үзэх болно шүү дээ. Хэрэв энэ бүхнийг хийж чадахгүй юм бол өөрийнхөө төлөө бурхандаа залбир. Чиний дайсан болсон биднийг чамайг хамгаалах нэг сахиусан тэнгэр бурханаасаа гуй, бас чиний бурхан чамд ордон цэцэрлэг, эрдэсүүд өгөг, ингэснээр чи ядуу тарчиг амьдралаасаа салах болно шүү дээ...” гэв. Энэ үгийг дуулаад Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам): “Би та нарыг баян болгон, амьдралыг чинь өөд нь татахын тулд илгээгдээгүй билээ. Аллах эзэн надад юу л зарлиглана, би түүнийг та бүхэнд түгээх үүрэгтэй. Би (эд хөрөнгө мал баялагын төлөө) бурхандаа залбирдаг нэгэн бишээ... Аллах эзэн намайг (миний айлдсанд итгэгсэдийг диваажинд оруулах) нэгэн баярт мэдээ дуулгагч ба (миний айлдсанд үл итгэгсэдийг тамд хаях) нэгэн айлдагч болгон томилсон билээ. Хэрвээ та бүхэн миний бурханд итгэх юм бол энэ итгэл чинь энэ хорвоод бас хойд насанд чинь та бүхний энэрэл болно. Харин үл итгэн хүлээн зөвшөөрөхгүй юм бол Аллах эзэн та нарын гэсгээлийг өгөх хүртэл, их эзэний зарлигийг ёсчлон

биелүүлж эцэсээ хүртэл тэмцэх болно” хэмээв.

Мүшрикүүд энэ удаа “Чиний бурхан чиний хүссэн бүхнийг хийдэг юм бол яг одоо энэ тэнгэрийг хоёр хуваагаад бидний дээр унагаачих... Чи энийг л хийхгүй юм бол бид чамд хэзээ ч итгэхгүй” гэгцээв. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) “Энийг би хийж чадахгүй, зөвхөн Аллах л хийж чадна. Хэрвээ тэр хүсвэл энэ түүний хувьд яадах юмгүй зүйл” гэв. Ингээд мүшрикүүд бүр давран “Хөөе, Мухаммед, чиний бурхан өнөөдөр чамайг бидэнтэй уулзаж юу ярилцацгаахыг минь мэдээгүй гэж үү? Тийм л агуу юм бол чамаас бид юу асуухыг чамайг юу гэж хариулахыг зааж өгөхгүй яасан юм бэ? Чиний хэлсэн зүйлүүдийг хүлээн зөвшөөрөөгүй, бидэнд юу хийхээ яагаад хэлээгүй юм бэ?... Чамайг элч болохыг батлах сахиусан тэнгэрүүд авч ирж бидний нүдэнд үзүүлэх хүртэл чамд итгэхгүй... Ингээд чамаас асуух өөр асуулт алга даа. Энэ цаг мөчөөс хойш чамайг тайван орхихгүйгээ амлъя. Нэг бол чи биднийг үгүй хийнэ, нэг бол бид чамайг үгүй хийх болно...” гэгцээв. Тэднийг өөртөө ойртуулж татах гэхэд нь харин ч элчээс дайжин аласлагдаж байсан тул Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) тэд нараас холдон одов⁶⁴.

Меккегийн мүшрикүүд энэрэлт элчийг үгүйсгэсэн болохоор Аллах Теала Жабрайл (алейхисальлам) сахиусан тэнгэрээр дамжуулан тэдний талаар ает (өгүүлбэр) буулгажээ. Энэ нь Ангем сүрегийн (бүлэг) 4-аетаас 11-ает хүртэл, утга нь: Тэдэнд ертөнцийн эзэний аетүүдээс үгүйцгээгүй ямар ч ает байхгүй боллоо. Үнэндээ тэд үнэн (Куран керим) тэдэнд ирэхэд буруушаан мууллаа. Гэвч удахгүй тэднийг юугаар цээрлүүлэхээ мэдэгдэнэ. Юугаар доог тохуу хийсэн нь (түүний гэсгээл) мэдэгдэх болно. (Мекке ард түмэн) тэднээс өмнө хичнээн ард түмэн устан үгүй болсоныг хараагүй гэж үү? Мэдээгүй гэж үү? Тэдэнд тайлагдахгүй байх бүхий л боломжийг өгсөн юм. Тэдний ган гачигийг тайлж, хур бороогоо хайрлаагүй гэж үү? (бэлчээрт нь, цэцэрлэгт нь, тариалангийн талбайд нь) булаг шанд гол урсгасан юм. Дараа нь тэднийг (энэ өгсөн буян хишгийг үл тоон эс баярласаных нь төлөө) өөрсдийнх нь нүглээс болон устгасан билээ. Тэдний оронд өөр нэгэн хүн төрөлхтөн бүтээлээ.

Хэрвээ чамд цаасан дээр бичээстэй нэгэн судар илгээсэн бол тэд өөрсдийн гараас тэр судрыг барьсан бол бас л өөрийн мухар сүсэгээрээ “Энэ бол ил тод нэгэн илбэ байна” гэх байсан

бас “Мухаммед бидэнд үзэгдэх нэг сахиусан тэнгэр явуулж бид ч түүнийг хүлээн зөвшөөрч болохгүй байсан гэж үү? гэх байсан. Хэрвээ бид тэдэнд нэг сахиусан тэнгэр явуулсан бол (тэд мөн адил итгэл бишрэлийг олоогүй бол) мэдээж л тэднийг үгүй хийх байсан (тэднийг бүгдийн устган үгүй хийх байлаа). Тэгээд тэдэнд нүд ирмэх завдал ч өгөгдөхгүй байсан. Хэрвээ түүнийг (элчийг) нэгэн сахиусан тэнгэр болгосон бол мэдээж тэрнийг нэг эрэгтэйн дүрээр ирүүлнэ. Тэд мөн л адил эргэлзэнээсээ гарч чадахгүй байсан. Амлан хэлье, чамаас өмнө ирсэн элчүүдийг ч мөн адилаар тоглоом тохуу хийж, тамлан зовоосон. Ингэж буруу алхам хийснийхээ төлөө тэд гэсгээл тамлалыг бас зовлон тарчлал тэднийг тойрон бүсэлсэн билээ. Хэл: “газар дэлхийг хэрэн тэнүүчилцгээ, тэгээд эргэн харцгаа, өөрийн элчдээ үл итгэгсэд хэрхэн гэсгээгдэхийг ойлгоцгоо”

Фуркан сүрегийн 7 ба 10-р аетэд ийн өгүүлжээ: Кафирууд: “Энэ юун элч вэ? Бидний л адил идэж уугаад, гудамжаар яваад л байна. Хэрвээ жинхэнэ элч байсан бол сахиусан тэнгэр мэт байх ёстой биш үү, өөрийн гэсэн туслахуудтай бас ирээдүйг зөгнөөд тамын аюулаас биднийг айлгаад л өөрийн гэсэн эрдэнэсийн сантай жимсний талбайтай байх ёстой бус уу?” гэцгээнэ. Тэр дарангуйлагчид өөр хоорондоо ийнхүү ярилцана: “Хэрвээ та нар энэ элчид итгэх юм бол хараал туссан хүнд итгэсэн болно” (Аяа, хайрт элч минь)Тэднийг хар, чамайг юу гэж гүтгэн үнэн замаас хазайсаныг. Тэд одоо буруу замаар ороод хэзээ ч үнэний замыг олж чадахгүйгээр төөрчээ. Аллах эзэн агуу хүчтэй билээ. Тэр хүсвэл чамд зориулж алтан ай саваар урсах гол мөрний хөвөөнд үзэсгэлэнтэй сайхан цэцэрлэгтэй эрдэнийн чулуугаар ордон барьж чадах байсан” хэмээжээ.

21 дэхь аетэд: “Бидэнтэй учирхыг эс хүсэгчид ингэж хэлцгээлээ: “бидэнд баталгаа болгон сахиусан тэнгэрүүдийг харуулсан бол (Мухаммедэд ийнхүү бид итгэсэн бол) эсвэл Аллах бурханыг харсансан бол”. Амлан тангаргалъя, тэд хараал хүртэж, бас маш их сүсэгээр өөрийгөө итгүүлэгчид...” хэмээжээ.

Ийнхүү өөрсдийнх нь тухай илгээгдсэн Аллахын энэ аетуудыг уншсан мүшрикүүд бүр их тэрслэн эсэргүүцэж дайсагнаж эхэлжээ. Тэр дундаа Убей бин Халеф түүний дүү Үмейе нар Мухаммед элчийг (салаллаху алейхи уа сальлам) маш ихээр гомдоон доромжилдог байлаа. Золгүй Үбей тэмээний өгөрсөн яс барин Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) өмнө

ирээд: “Хөөе, Мухаммед, энэ яс өгрөн хувхайрсаны дараагаар чиний Аллах энийг дахин амилуулах юм байна, тийм үү? Тэгэхлээр чи, чиний бурхан энүүнийг ахин амилуулж чадна гэж бодож байна уу?” хэмээгээд нөгөө өгөрсөн ясаа нунтаг болтол нь няцлаад нунтагийг нь Мумхаммедийн (салаллаху алейхи уа сальлам) нүүр лүү нь цацжээ. Тэгээд “Хөөе, Мухаммед, энэнийг ингэтэл өгөрсөний дараагаар хэн дахин урьдын хэвэнд нь оруулж чадах юм бэ?” гэв. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) түүнд хандан: “Тийм ээ, Аллах эзэн чамайг ч гэсэн алах болно. Бас түүний дараа чамайг амилуулаад тамын тогоонд хаях болно.” Энэ явдалаас болж Аллах эзэн энэ аетийг илгээжээ: Утга нь: “Тэр (буруу номтон) хүмүүсийг, түүнийг нэг дусалаас туурвисаныг хараагүй гэж үү, тийм байтал идэвхтэй нэгэн эсэргүүцэгч боллоо. Юунаас бүтсэнээ умартан: “өгөрсөн хувхайрсан энэ ясыг хэн амилуулах вэ?” гэж эргэлзэж байна. (Аяа элч минь) Түүнд ингэж хэл: “Тэднийг огт үгүй байхад анх тууригсан (Аллах эзэн) амилуулах болно. Тэр бол бүхнийг хэрхэн туурвихаа мэддэг билээ. Тэр (Аллах эзэн) та нарт нов ногоон модноос дүрэлзсэн гал гаргасан хүчтэн, одоо ч гэсэн та нар тэрнийг хэрэглэдэг бус уу. Тэнгэр газарыг бүтээсэн хүчтэнд иймхэн юм бүтээх хэцүү гэжүү? Мэдээж энэнд хүч хүрнэ. Тэр (Аллах эзэн) бүхнийг бүтээсэн бас бүхнийг мэддэг...” хэмээжээ⁶⁵.

Халид бин Сайдын итгэл үнэмшил

Ислам шашин түгэж эхэлсэн анхны жилүүдэд Халид бин Сайд нэг зүүд зүүдэлжээ. Тамын хажууд зогсож байтал эцэг нь түүнийг там руу түлхжээ. Яг унаж байх үед Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) түүний бүснээс шүүрэн барьж тамаас татаж гаргаж байх юм. Өглөө босоод өөрөө өөртөө “энэ зүүд үнэн болохыг андгайлъя” гэж хэлэв. Гэрээсээ гараад гэгээн Эбү Бакиртэй нүүр тулав. Тэгээд түүнд шөнө зүүдэлсэн зүүдээ ярьж өгөхөд Эбү Бакир (радиаллаху анх) түүний зүүдийг чимээгүй чих тавин сонссоноо: “Чиний зүүд үнэн зүүд байна. Энэ хүн бол Аллах эзэний жинхэнэ элч мөн, одоохон түүн рүү оч. Тэрний шашинийг хүлээн зөвшөөр, чи тэрний хажууд байж түүний дагалдагч болсоноор зүүдэнд чинь үзэгдсэн адилаар чамайг тамаас аврах болно. Харин чиний аав мөнх тамдаа үлдэх

болно” гэв.

Гэгээн Халид (радиаллаху анх) энэ зүүдэндээ итгэн тэр даруй Эжяд гэх газар Мухаммедыг (салаллаху алейхи уа сальлам) хайж олов. Тэгээд: “Аяа, Мухаммед, чи юунд хүмүүсийг уриалан дуудаж байна” гэж асуулаа. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) түүнд “Би хүмүүсийг хань, ижил бас адилтгах зүйлгүй цорын ганц Аллахд, Мухаммед (салаллаху алейхи уа сальлам) бол түүний элч болоход нь итгэхэд, бас сонсдоггүй хардаггүй бөгөөд ямар нэг хор хөнөөл, ашиг тусгүй, хэсэг чулуун шавар бурхдад мөргөх тэр мухар сүсэгээс гарахыг уриалан дуудаж байна.” хэмээв. Энэ үгийг сонссон Халид бин Сайд “Би Аллахаас өөр залбирах бурхан үгүйг гэрчилж байна, бас чи бол Аллах эзэний элч болохыг гэрчилнэ” гэж хэлээд мусульман болжээ. Түүний ислам шашинд орсон нь Мухаммед элчийг маш ихээр баярлуулжээ. Дараагаар нь түүний эхнэр Үмеййе ч мусульман болсон байна.

Гэгээн Халид бин Сайд (радиаллаху анх) өөрсдийн дүү нараа ч гэсэн энэ зөв зам руу ороосой гэж хүсэж тэмцэж байлаа. Тэднээс Омар бин Сайд ч мусульман болжээ. Исламын дайсан тэдний эцэг Эбу Ухейха Халид ба түүний дүү Омар хоёр мусульман болоод буйдхан газар нууцаар намаз (мөргөл) хийж буйг мэдээд өөрийн мусульман болоогүй хөвгүүдээ явуулан тэр хоёрыг өөр дээрээ авч ирүүлэв. Тэгээд тэднийг энэ шинэ шашинаасаа гарахыг хүчлэв. Тэр хоёрын хэзээ ч буцахгүйг мэдээд зодож эхэлсэн нь тэр. Халид бин Сайдад (радиаллаху анх) хандан “Чи Мухаммедэд итгэв юу? Тэрнийг бидний бурхадыг муулж, бидний өвөг дээдсийн шашиныг хараан зүхэж байгааг мэдсээр байгаа атал түүнд итгэлээ гэж үү?” гэв. Халид бин Сайд: “Аллахын нэрээр тангаргалъя, Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) үнэнийг хэлдэг. Би түүнд итгэж байна, үхсэн ч энэ шашинаасаа гарахгүй” гэхэд нь маш их уурласан аав нь ташуурынхаа бариулыг хугартал цохиод: “Хөөе, заяа муут хүү минь, хүссэн зүгтээ яв. Чамд хоол өгөхгүйгээ андгайлъя” гэв. Гэгээн Халид (радиаллаху анх): “Чи миний хоолыг хорьсон ч Аллахын надад өгөх буян хишиг хүрэлцээтэй” гэв. Эцэг нь бусад хөвгүүддээ хандан: “Хэрвээ та нар тэрэнтэй ярилцах юм бол тэрэн шиг та нарыг зовоох болно” гэв. Гэгээн Халидыг гэрийнхээ нэг амбарт хориж 3 хоног халуун наранд шарав. Түүнд дусал ус, хоол өгсөнгүй.

Гэгээн Халид бин Сайд (радиаллаху анх) заль хэрэглэн эцгийнхээ гараас мултарч чаджээ. Түүний эцэг Эбу Ухейха хэдэн хоногийн дараа үхэх өвчин тусжээ. Өвчин үхлээ хүлээн хэвтэхдээ ч хүртэл “Хэрэв энэ өвчинөөсөө ангижран хөл дээрээ босох юм бол Мекке хотод байх бүх хүн өөрийнхөө л бурхадад залбирах болно. Хэн ч өөр шашинд итгэж болохгүй...” гэж хэлсээр байгаад нас баржээ.

Мусаб бин Үмейр (радиаллаху анх) мусульман болсон нь

Мусаб курейшийн хамгийн баян нэр хүндтэй айлын хүү юм. Элчийн (салаллаху алейхи уа сальлам) ариун үгсийг сонсоод зүрх сэтгэлд нь исламыг гэх итгэл үнэмшил дүрэлзэн асаж эхлэв. Элчтэй (салаллаху алейхи уа сальлам) уулзахыг маш их хүсэж тэсэлгүй Дар-ул Эркамд очин исламд оржээ. Үүнийг сонссон түүний кафир эцэг эх нь шашинаас нь гаргахын тулд хоол унд өгөлгүй хорионд хорьжээ. Гэвч энэ бүхэн түүнийг итгэл үнэмшилээс нь гаргасангүй.

Гэгээн Мусаб (радиаллаху анх) мусульман болхынхоо өмнө баян эцэгийн хөрөнгөнд умбаж тансаг амьдралаар өсчээ. Хүн бүр түүнийг атаархан хардаг байв. Түүнийг мусульман болонгуут эцэг эх нь тамлан зовоож эхэлжээ. Мусаб нэг өдөр Аллахын элчид (салаллаху алейхи уа сальлам) иржээ. Түүнийг ирэхэд гэгээн Али (радиаллаху анх) байсан бөгөөд ийн айлджээ: “Бид элчтэй хамт сууж байлаа. Гэнэт гаднаас Мусаб бин Үмейр орж ирэв. Урагдаж хуучирсан дээл өмссөн, ядарсан байдалтай байлаа. Элч түүнийг хараад өрөвдөн нулимс унагав. Мусаб энэ их зовлон зэтгэрийг үзсэн хэрнээ огт шашинаасаа гараагүй юм. Элч (салаллаху алейхи уа сальлам) “Зүрхийг нь гэгээн туяагаар гийгүүлсэн энэ хүнийг харцгаа. Эцэг эх нь түүнийг хамгийн сайхан хоол, хамгийн тансаг хувцасаар тэтгэж өсгөсөн юм. Аллах эзэнд ба түүний элчийг хайрлах хайр тэрнийг ийм байдалтай болгожээ” гэжээ.

ХАБЕШСТАН (ЭТЁП) РУУ НҮҮСЭН НЬ

Аллахын элч маань (салаллаху алейхи уа сальлам) элчийнхээ 5 дахь жилдээ мүшрикүүдийн дарлал доор мусульманчуудын тоог олшруулан зөв замд хөтлөхийн тулд мэрийж байлаа. Харин мүшрикүүд өдөр өнгөрөх тусам дарлан зовоохоо улам ихэсгэж санасан бүх муухай зүйлээ хийж байлаа. Өөрийнхөө асхабуудаа (анхдагч мусульманчууд) хоёр хөлийг нь тэмээнд боогоод хоёр тийшээ тэлэн алуулахыг хүсэхгүй байлаа. Өдөр ирэх тусам кафируудын энэ тамлал улам их нэмэгдэж янз янзын шинэ тамлан зовоох ёсон дэлгэрч байв. Энэ бүхнийг өөрийн нүдээр үзэж сууж чадахгүй болсон Мухаммед (салаллаху алейхи уа сальлам) асхабуудаа цуглуулаад: "Аяа, асхабууд минь, одоо та нар энэ хотоос дайжин газар дэлхийгээр нэг гарцгаа. Аллах эзэн тун удахгүй та нарыг ахин цуглуулах болно" гэв. Тэд: "Аяа, Аллахын элч минь, бид хашаа явах юм бэ? гэж асуухад Хабеш нутгийн зүг заагаад "Тийшээ, Хабеш орон руу нүүцгээ"⁶⁶, тэнд хэзээ ч тамлан зовоодоггүй энэрэлтэй нэгэн хаан бий. Тэр нутаг ч гэсэн шударга нэгэн газар. Аллах эзэн та нарын энэ хэцүү хүнд байдлаас гарах нэг гарц зааж өгөх хүртэл тэнд амьдарцгаа" хэмээв. Энэхүү энэрэлийн элч болсон гэгээн Мухаммед (салаллаху алейхи уа сальлам) өөрийн асхабуудаа зовлонг амьдралаас нь аварч энэ хүнд хэцүү тамлан зовлонг өөрөө үрэхийг хүсчээ. Эхээс мэндлэхдээ "Үммет минь, Үммет минь (Дагалдагсад минь, Дагалдагсад минь)" хэмээн хэлсэн хайрт пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) одоо дагалсадыгаа аврахын тулд өөрийгөө золиосолж байна. Түүний хэлсэнчлэн асхаб кирануудын зарим нь нутгаа орхин нүүжээ.

Анхны нүүгсэд гэгээн Осман ба түүний эхнэр гэгээн Рухайе бинти Расулуллах, Эбү Хузейфе ба түүний эхнэр Сэхлэ бинти Сүкэйл, Зүбейр бин Аввам, Муаб бин Умейр, Абдуррахман бин Ауф, Эбү Селеме бин Абдулэсэд ба түүний эхнэр Үмму Селеме, Хатиб бин Амр, Амир бин Ребиа ба түүний эхнэр Үмму Гүлсүм бинти Сүхэйл, Сүхэйл бин Бейда, Абдуллах бин Месуд (радиаллаху анхүм) нар билээ⁶⁷.

Мухаммед (салаллаху алейхи уа сальлам) Османд хандан: "Ямар ч эргэлзээгүй Осман бол Лут элчийн дараагаар эхнэртэйгээ

66 Ибн Исхак, Эс-Соре,с, 194: Ибн Хишам Эс-Соре I,321: Ибн Сагд, эт-Табакет I, 203-204: Ибн Кесир, эл- Бидэйе III, 94.

67 Ибн Исхак, Эс-Соре,с, 205-210: Ибн Сагд, эт-Табакети I, 204.

хамт нүүн одсон нэгэн мөн.” хэмээжээ. Нүүгсэдийн зарим нь тэмээ хөсгөөр зарим нь явган нэг шөнийн дотор нууцаар Мекке хотоос гарчээ. Наймаачдийн үнэ хөлсийг нь төлөөд тэдний усан онгоцоор улаан тэнгисийг гатлан Хабешстанд иржээ. Тэднийг нүүсэнийг мэдсэн мүшрикүүд араас нь нэхэн хөөсөн боловч гүйцэлгүй буцацгаажээ.

Очсон газар болох Хабаш нутгийн хаан Нежаси тэднийг уриалгаханаар хүлээн авч нутаглуулжээ. Асхабууд “бид энэ нутагт ирээд муу юмыг огт үзээгүй бөгөөд бидний шашин шүтлэгт тэд дургүйцсэнгүй. Бид өөрсдийн бурхан Аллах эзэндээ мөргөн залбирч сайхан амьдралаар амьдарсан билээ” хэмээжээ⁶⁸.

Гэгээн Хамзаа мусульман болсон нь

Ислам шашины нэр алдар өдөр ирэх тусам цуурайтаж байлаа. Энэ мүшрикүүдийг айлган тэд ислам шашиныг үгүй хийхийн тулд бүхий арга чаргаа хэрэглэж байлаа. “Далаил-үн нүббүве” ба “Меариж-үн нүббүвведе” гэх номонд ийн бичигджээ: Мүшрикүүдэд Валид гэх нэгэн шавар бурхан байлаа. Тэд Сафа толгодод цуглацгаан энэ бурхандаа залбирцгааж байлаа. Нэг өдөр Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) тэднийг бурхандаа залбирах гэж цуглаж байх үед ислам шашинаа номлон уриалан дуудахаар очив. Энэ үед буруу номд нэгэн буга тэр бурханы дотор ороод Мухаммед элчийг (салаллаху алейхи уа сальлам) муу муухайгаар хараан доромжилов. Харин тэр орой үгүйгээс нэгэн дуу Мухаммедэд хандан “Аяа, элч минь, өнөөдөр Софа толгодод таныг кафир буг муу муухай үгээр доромжилсон байна. Та маргааш ахиад Сафа ууланд гарч номлолоо айлтгана уу? Би харин тэр үед тэдний бурхан дотор нь ороод таныг магтан дуулъя гэв. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) Абдуллах нэртэй энэ бугын үгийг сонсоод хүлээн зөвшөөрөв.

Хайрт пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) маргааш өдөр нь Сафа ууланд гаран мүшрикүүдийг исламд уриалав. Мусульман буга мүшрикүүдын гарт буй бурханых нь дотор ороод элчийг (салаллаху алейхи уа сальлам) бас исламыг магтан дуулсан шүлэгүүд хэлж эхлэв. Энэ шүлэгийг сонссон мүшрикүүд гартаа байгаа бурханаа газар унагаан дэвсээд,

68 Ибн Исхак, Эс-Соре,с, 194: Ибн Хишам Эс-Соре I,321-332: Ибн Сагд, эт-Табакет I, 204.

Мухаммед элч рүү (салаллаху алейхи уа сальлам) дайрцаав. Түүний гэгээн нүүрнээс нь цус гартал нь дэвсэцгээв. Ингэж зодуулсан байлаа ч: “Хөөе, Курейшийнхан, та нар өөрийн элчээ зодож байна шүү дээ” хэлж байв. Нэгэн ажилчин бүсгүй энэ үйл явдлыг эхнээс дуустал нь харж байв. Энэ үед гэгээн Хамзаа ууланд ан хийж явсан юм. Нэг зээрийг харвах гэж байтал тэр зээр хүний хэлээр “Хөөе, Хамзаа, намайг харвахын оронд дүүгийн чинь хүүг алахыг завдаж буй тэр хүмүүсыг харвах юм биш үү” гэх нь тэр. Зээрийн энэ үгэнд гайхсан Хамзаа баатар түүнийг харвалгүйгээр гэр лүүгээ буцав. Ангаас буцахдаа эхлээд Каабын хажууд очоод дараа нь гэртээ харьдаг зуршилтай билээ. Хамзаа ариун Каабыг тойрон мөргөж байхад түүний ажилчин хүүхэн хажууд нь ирээд Эбү Жахил Мухаммедыг (салаллаху алейхи уа сальлам) хэрхэн зодож занчсан талаар түүнд хэлэв. Хамзаа авга дүүгээ дээрүүлхүүлэн зодуулсандаа маш их уурлан зэр зэвсгээ аваад мүшрикүүдийн байгаа газар луу явлаа. Тэдний хажууд ирээд ууртайгаар “Миний дүүгийн хүү Мухаммедыг дээрэлхэн муу муухай үгээр хараан зүхсэн хүн чи юу? Би ч түүний шашинд орсон, тэрнийг зодсон шиг одоо намайг зодооч алив?” хэмээн нумаараа Эбү Жахилийн толгойг хага цохив. Тэнд байгсад Хамзаа руу дайрахыг завдсан боловч Эбү Жахил тэднийг зогсоон “Зогсгоо, Хамзаагийн зөв, би түүний авга дүүг зодсон билээ” гэв. Хамзаа тэр газраас явсаны дараагаар Эбү Жахил мүшрикүүддээ: Түүнийг битгий уурлуулцгаа, бидэнд уурлаад мусульман болчихож мэднэ. Хэрвээ тэгвэл Мухаммед хүчирхэгжих болно” гэв. Тэрээр гэгээн Хамзааг (радиаллаху анх) мусалман болчих вий хэмээн айсандаа толгойгоо хага цохиулсан чогт эсэргүүцээгүй юм. Ягаад гэвэл Хамзааг нэр хүндтэй хийгээд эр зоригтой шударга нэгэн болохыг мэддэг байлаа.

Гэгээн Хамзаа Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) гэрт ирээд “Аяа, Мухаммед! Эбү Жахилаас чиний өшөөг авсан түүний толгойг нь хага цохилоо. Баярла, битгий гоморх” гэв. Хайрт пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) “Иймхэн юманд баярлах хүн бишээ” гэв. Гэгээн Хамзаа “Чамайг гоморхлоос гарган баярлуулахын тулд юу хүссэнийг чинь хийхэд бэлэн байна” гэхэд нь Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам): “Намайг зөвхөн та мусульман болж өөрийгөө тамын тогооноос аврах чинь л баярлуулах болно” хэмээв. Гэгээн Хамзаа (радиаллаху анх) тэр үед мусульман болсон бөгөөд түүний

талаар ает буусан билээ. Ариун Куранд Ангам сүрэ (бүлэг) 122-аетэд: Ахин амилахдаа гэгээн туяагаар бүрхүүлдэг хүмүүн гэгээн Хамзаа гэх ба яг тэр аетэд түнэр харанхуйд төөрөх хүн хэмээн Эбү Жахилийг дурьджээ.

Гэгээн Хамзаа (радиаллаху анх) мүшрикүүдийн хажууд очоод мусульман болсоноо, бас Аллахын хайрт элч Мухаммедийг (салаллаху алейхи уа сальлам) амь биеэ үл хайхран хамгаалахаа нэгэн шүлгээр шүлэглэн дуулав. Энэ шүлэг нь йим утгатай байжээ. “Зүрх сэтгэлээ би Ислам шашинд ба чин үнэнийг өгүүлэх тэр шашинд өгсөн болохоор Аллах эзэндээ талархая... Энэ шашинийг боолуудынхаа хийсэн бүхнийг мэддэг, хүн бүхнийг бүтээсэн бүх зүйлд хүчин төгс, хорвоо ертөнцийн эгнэшгүй эзэн болох Аллах эзэн илгээсэн билээ. Куран судрийг уншихад зүрх сэтнэл ба ухаантнуудын нүдээс нулимс асгарна. Тэрхүү Куран судар бол агуу их ид шидийн хэллэгээр бичигдэн Мухаммед элчид илгээдсэн юм. Харин гэгээн Мухаммед Мустафа (салаллаху алейхи уа сальлам) бол үгсийг сонсож түүнийг хүлээн зөвшөөрөх ёстой нэгэн билээ. Хөөе, мүшрикүүд ээ, та нар галзууран, түүнд хатуу бас муу муухай үг битгий хэлцгээ, хэрвээ та нар түүн рүү дайрахыг хүсвэл мусульман болсон бид нарыг эхлээд алсаны дараа л түүн рүү хүрэх болно” гэжээ.

Гэгээн Хамзаа мусульман болсон нь хайрт элчийг маань (салаллаху алейхи уа сальлам) маш их баярлуулав.

Гэгээн Хамзаа (радиаллаху анх) мусульман болсоны дараагаар их юм өөрчлөгджээ. Мекке хотынхон Хамзааг шударга үнэнч агаад аймшиггүй зоригтой бас хүчит баатар болохыг нь мэддэг байлаа. Тийм болохоор Курейш мүшрикүүд мусульманчуудыг ямар ч учир шалтгаангүйгээр барьж аваад урьдын адил тамлан зовоож чадахаа больсон байв. Ягаад гэвэл тэднийг хамгаалах баатар Хамзаагийн сэлэмнээс эмээж байлаа⁶⁹.

Гэгээн Омар мусульман болсон нь

Өдөр ирэх тусам ислам шашин өргөн дэлгэрч байлаа. Куран судрын ариун гэгээ түнэр харанхуйг гэрэлтүүлж нүгэлт хүмүүс Аллах эзэний зол буянаар итгэл үнэмшилээ олж зөв замыг замнаж байлаа. Асхаб хэмээх энэ ариун алдарыг олсон энэ

69

Ибн Исхак, Эс-Сопе,с, 151-153; Ибн Хишам Эс-Сопе I,291-292.

буянт хүмүүс гар гараа барилцан энэ шашинаа дэлгэрүүлэх гэсэн нэгэн хүсэл эрмэлзтэйгээр нэгдэцгээж байв. Тэд нар Алладын эзэний хажууд үргэлж байж, түүний ариун сургаалаар тэтгэгдэж байлаа. Түүний өчүүхэн жоохон хүслийг өөрсөддөө айлтгагдсан зарлиг мэт бат чанд даган мөрдөж гүйцүүлдүүлэхийн тулд амиа ч өгөхөд бэлэн байлаа. Харин мүшрикүүд мусульманчуудыг яаж, хэрхэн зогсоохоо мэдэхгүй байлаа учир нь тэдний гол баатар болох гэгээн Хамзаа хэдийнээ мусульман болон Мухаммедын (салаллаху алейхи уа сальлам) асхабуудын эгнээнд жагссан нь тэднийг бүүр ч галзуурахад хүргэсэн явдал байлаа. Тийм болохоор Хаттабын хүү Омар (тэрээр мусульман болж амжаагүй байлаа) нэгэн өдөр Алладын элчийн амийг бүрэлгэхийн тулд сэлмээ барин гэрээсээ гарчээ. Ариун Каадын өмнө мөргөл үйлдэж буй Мухаммед элчийг (салаллаху алейхи уа сальлам) хараад түүнийг мөргөлөө үйлдэж дуусахыг нь хүлээж зогсов. Гэгээн Мухаммед элч маань (салаллаху алейхи уа сальлам) Эл-Хакка сүрег (бүлэг) уншиж байлаа. Утга нь: “Тэр бол удахгүй илрэх үнэнхүү киямет (шүүгдэх өдөр)!.. Тэр үнэнхүү киямет юу вэ? Тэр ирэх үнэнхүү кияметийг (шүүгдэх өдрийг) хэн чамд зааж өгөв? Сэмүд ба Ад (овог аймаг) зүрх чичрэн аймшигт хойд ертөнцийн эхлэл өдрийг буруушаалаа, худал хэмээн гүтгэлээ, Семүд овог өөрсдийн энэ бузар үйлдлээсээ болж (Жабрайл (алейхисальлам) элчийн орилох дуунаар) газраас мөхөн үгүйрсэн билээ. Харин Ад овог ч мөн адил өмнө нь юу ч үл тогтоож чадан агуу хүчтэй бөгөөд чанга нүргэлсэн дуутай шуурганаар дайруулж мөхөөгдсөн бөлгөө. Аллах эзэн энэ хар салхиаар 7 шөнө 8 өдөр тэднийг зовоосон билээ. (Тэгэхэд чи тэдний хажууд байсансан бол) тэднийг үндэсээс тасрагдсан, ялзарч муудсан жимс шиг газар унахыг нь харах байсан! Одоо тэднээс амьд үлдсэн хүн бий гэж үү?

Фарон ч, бас түүнээс өмнөх отог аймгууд ч (Лут отог аймаг) бүгдээрээ тэр замыг (бурханыг үгүйсгэх) сонгосон... Ийнхүү эзэнийхээ пайгамбаруудыг (Лут (алейхисальлам) бас бусад) үгүйсгэсэн, тийм болохоор урьд өмнө ирсэн гэсгээлүүдээс хамгийн хэцүү аюултай гэсгээлийг хүртэгсэд билээ... Үнэндээ бид (Нухын тофан (бүх ертөнцөд үер болж, ус бүрхэх) хорвоо ертөнцийг усаар бүрхэж тэр цагт, та бүхэнд нэгэн сургамж ба тэр үйл явдалыг сонсогчид ч түүнийг үл мартаг цээжлэг хэмээн та бүхнийг (оршихуйд чинь үр нөлөөгөө үзүүлсэн өвөг дээдсийг тань)

нэгэн хөлөг онгоцоор зөөлөө. Сүр (бүрээ) нэгэнтээ үлээгдэхийн цагт газар дэлхий ба уул дээш шидэгдэн чичирхийлэх болно. Яг тэр өдөр киямет (ертөнцийн төгсгөл өдөр) эхлэх болно. Тэнгэр дундуураа хагаран зааглагдах болно. Тэр өдөр Раббынхаа суудалыг (тэнгэрийг тойрон буйд) найман мелек (сахиусан тэнгэр) үүрэн зөөх болно. Тэр өдөр шүүгдэхийн тулд (Аллах эзэний өмнө) зогсоцгоох болно. (хорвоод амьдрахдаа нуун дарагдуулсан) та нарын ямар ч нууц (Аллах Теалад) ил тод юм.

Тэр үед үйл үйлдлийн дэвтэр нь баруун талаас нь өгөгдөгсөд (баярлан) ингэж хэлцгээнээ: “Харцгаа, миний дэвтэрийг уншицгаа! Үнэндээ би энэ шүүлтийн өдөр ирэхийг мэдэж байсан билээ”. Харав уу, тэр хүн баяр жаргалтай нэгэн амьдралыг туулж байна, бас дээдийн нэгэн диваажинд оржээ... (Тэд ийн өгүүлнэ) “Өнгөрсөн өдрүүдэд (хорвоод амьдрахдаа) үйлдсэн цэвэр ариун үйлсийнхээ төлөөс болгон зооглоцгоо, ундаалцгаа, сайхан хооллоорой! Жаргацгаа”

Үйл үйлдлийн дэвтэр нь зүүн талаас өгөгдөгсөд нь ийн харамсах болно. “Юутай гаслантай вэ? Миний энэ дэвтэр өгөгдөөгүй байсан бол! Юу хийж үйлдсэнээ надаас хэн ч асуугаагүйсэн бол, мэддэггүйсэн бол! Аяа, юутай гаслантай вэ. Тэр (үхэл ирэхүйд) бүх зүйл төгсөж (ахиж амилахгүй байсансан бол) Эд хөрөнгө маань ямар ч ашиггүй боллоо, бүхий л үнэт зүйлс маань надаас замхран алга боллоо..!” гэнэ. (Аллах эзэн тамын сахиусан тэнгэрүүдэд хандан) “Энэ хүнийг барьцгаа (хоёр гарыг нь хүзүүн дээр нь уя) уяцгаа! ...дараа нь наадхаа дүрэлзсэн гал руу шид! Дараа нь түүнийг далан тэнгэрийн урттай нэгэн гинжээл дөнгөл, тэгээд дахиад там руу шидэцгээ!.. Учир нь тэр агуу Аллах эзэндээ итгээгүй билээ. Өлсгөлөн хүмүүсийг хооллож ундаалж, буян болоогүй билээ, тиймээс өнөөдөр түүний төлөө санаа зовох нэг ч хүн байхгүй. Түүнд илгээсэнээс өөр (тамд унагсадын цус нөжтөй холилдсон идээ бээрнээс өөр) ундаа түүнд үгүй билээ. Энэ ундааг (мэдсээр байж) алдаа гаргагсадаас (кафирууд) өөр хэн ч идэхгүй бөлгөө...”

Гэгээн Омар (радиаллаху анх) Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) энэ уншсан Кураны ариун айлтгалуудыг гайхан сонсож зогсов. Амьдралдаа хэзээ ч ийм гайхам сайхан зүйлийг сонсоогүй билээ.

Гэгээн Омар: “Мухаммед элч мөргөлийнхөө сүрег (бүлэг) уншиж дууссаны дараагаар миний зүрхэнд ислам шашины

талаар сайхан бодол төрж эхэлсэн билээ” гэв.

Гэгээн Хамза (радиаллаху анх) мусульман болсоноос гурав хоногийн дараа Эбү Жахил мүшрикүүдийг цуглуулаад: “Хөөе, Курейш овгийнхон! Мухаммед бидний бурхадыг муулж, бидний өвөг дээдсийг тамд унахыг биднийг ч бас тамд орно гэж хэлж байна... Түүнийг алахаас өөр арга алга!.. Түүнийг алсан хүнийг 100 тэмээгээр шагнана гэв.” Энэ үед гэгээн Омарын зүрхэнд ассан исламын талаарх сайхан бодол алга болж тэрээр суудлаасаа босон “Энэ ажилыг Хаттабын хүү Омараас өөр гүйцүүлдүүлэх хүн үгүй билээ” гэв. Тэнд байгсад: “Тийм ээ чиний зөв, алив Хаттабын эрэлхэг хүү минь, чамайг харъя” хэмээн алга ташицгаав.

Омар сэлмээ барин замд гарлаа. Замдаа Нуайм бин Абдуллахтай таарлаа. “Хөөе, Омар минь, чи сэлмээ хуйнаасаа гарган бариад хаашаа явж байна вэ?” гэж асуув. Тэр “ард олныг эвдрэлцэхэд хүргэсэн Мухаммедыг алахаар явж байна гэв”. Нуайм “Омар минь, чи их хэцүү ажил хийх гэж байна. Түүний дагалдагсад Мухаммедыг тойрон хүрээлж хамгаалж байна. Чи Мухаммедыг алсан ч түүний ах нар болон Абдулмутталибийн хөвгүүдээс амиа авч мултарч чадна гэж үү” гэв.

Омар энэ үгийг сонсоод маш их уурлан “Чи ч бас мусульман болоо юу? Тэгвэл эхлээд чамайг зүйл дуусгаадхъя! хэмээн сэлмээ далайв. Нуайм “Омар минь, намайг орхи! Цаана чинь чиний төрсөн дүү Фатима бас нөхөр Сайд бин Зейд ч гэсэн мусульман болсон шүү дээ” гэв. Гэгээн Омар (радиаллаху анх) энэ үгэнд нь итгэсэнгүй. “Хэрвээ итгэхгүй байгаа бол очоод өөрөө тэднээс асуу” гэв.

Омар (радиаллаху анх) дүүгийнхээ гэр лүү алхав. Яг энэ үед Таха сүрэ (бүлэг) шинээр илгээгдсэн байлаа. Сайд ба Фатима (радиаллаху анхум) хоёр энэ сүрег дуустал бичүүлэхийн тулд Хаббаб бин Эрэт гэх нэгэн мусульман тэдний гэрт ирсэн байлаа. Гэгээн Омар (радиаллаху анх) гэрийн гаднаас тэдний дууг сонсов. Тэгээд гэрийн хаалгийг хүчтэй балбахад, цонхоор түүний сэлмээ барьсан ууртай зогсохыг нь хараад бичгүүдийг, гэгээн Хаббабыг ч нуув. Тэгээд хаалгаа онгойлгов. Омар гэрт оронгуутаа та нар юу уншиж байсан юм бэ? гэв. “Бид юу ч уншаагүй” гэцгээв. Энэ үгэнд Омар улам их уурлан “Миний сонссон үнэн байна, та нар ч бас түүний илбэнд хууртагджээ” хэмээн загнаж гарав. Тэгээд Гэгээн Сайдыг (радиаллаху анх) зандаж аваад газар унагав. Дүү

нь нөхрөө аврахаар хооронд нь ороход Омар түүнийг алгадаж орхив. Фатима газар унан хамраас нь цус гарахыг нь хараад дүүгээ өрөвдөн зогсов. Фатимагийн (радиаллаху анха) нүүр ам нь цусанд будагдан хэсэг ухаан балартан сэрэв. Ухаан орсоны дараа итгэл үнэмшлийн хүчээр айдас нь үгүй болж “Хөөе, Омар! Чи яагаад Аллах эзэнээс ичихгүй Куран судар ба ариун үйлийн төлөө илгээгдсэн элчид итгэхгүй байгаа юм бэ? Би бас миний нөхөр бид хоёр мусульман болсон. Чи биднийг алсан ч бид энэ шашинаасаа гарахгүй” гээд келимэ шахедэтийг (гэрчлэл үг) хэлэв.

Гэгээн Омар (радиаллаху анх) дүүгийнхээ энэ их бат итгэлийг хараад жаахан тайвширан газар суув. Тэгээд намуухан дуугаар “Алив, намайг ирэхэд уншиж байсан тэр зүйлээ гаргаад ир” гэв. Фатима “чи угаалга үйлдэж цэвэрших хүртэл чамд тэрнийг өгөхгүй” гэв. Гэгээн Омар гусул (их угаалга) үйлдэв. Тэгээд Фатима Куран сударын хуудасуудыг авч ирэн Омарт өгөв. Энэ хуудасанд Таха сүрэ бичигдсэн байлаа. Омар түүнийг маш нухацтай уншиж гарлаа. “Тэнгэр огторгуй ба газар дэлхий хоёрын хооронд ба (долоон давхар) газар доорхи бүхий л зүйлс зөвхөн түүнийх”⁷⁰ гэх энэ аетийг уншаад гүн бодолд автав. “Аяа, Фатима дүү минь! Тэгэхлээр энэ дуусашгүй дундрашгүй зүйлс цөм та нарын бурхан Аллахыг юм уу?” гэж асуув. Фатима: “Тийм ээ мадаггүй үнэн, та итгэхгүй байна уу?” гэв. “Хүү минь, бид мянга таван зуугаад жилийн тэртээгээс мөргөж ирсэн алт, мөнгө, үнэт чулуугаар хийсэн бас чимэглэн гоёсон бурхад минь байгаа, гэхдээ тэдэнд огт эд хөрөнгө байхгүй шүү дээ” хэмээн гайхширан эрэгцүүлж эхлэв.

“Аллах эзэнээс өөр мөргөн залбирах, үнэн шударга бурхан гэж үгүй билээ. Бүхий л сайн сайхан нэр алдарууд түүнийх бөлгөө”⁷¹ гэх аетийг уншаад бодлогширон суусанаа “Ямар үнэн үг вэ” гэв. Энэ үед нуугдаж суусан Хаббаб энэ үгийг сонсоод байгаа газраасаа үсрэн гарч такбир хэлсэнийхээ дараагаар: “Баяр хүргье, Омар минь! Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) Аллах эзэнээс “Аяа, Эзэн минь! Энэ шашинаа Эбү Жахилаар эсвэл Омараар хүчирхэгжүүл” хэмээн залбирсан билээ. Харав уу энэ залбирал биелэлээ олсон байна, чи азтай хүн юм” хэмээв.

Энэ уншсан ает ба энэ залбирал нь Гэгээн Омарын

70 Таха 20/6.

71 Таха 20/8.

(радиаллаху анх) зүрх сэтгэл дэхь дайсагналыг ор мөргүй арчин хаяжээ. Тэрээр: “Аллахын элч одоо хаана байна?” гэж асуув. Тэр өдөр Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) гэгээн Эркамьн гэрт асхабуудаа цуглуулан сургаал номлолоо айлдаж байлаа. Асхабууд цуглан түүний ариун царайг нь харж, хэзээ ч давтагдашгүй гэгээн үгс бас Аллахын ает сургаал номлолыг сонсож сууцгааж байлаа.

Гэгээн Омарын ирж байгаа нь Эркамьн цонхоор харагдав. Сэлмээ гарт барин ирж байгааг харсан асхабууд босоцгоон Мухаммед элчийг (салаллаху алейхи уа сальлам) тойрон хүрээлж “Омараас айх юу байхав, хэрэв сайнаа өвөрлөж ирсэн бол хүлээж авъя. Эс бөгөөс сэлмээ далайж амжаагүй байхад нь толгойг нь таслая” гэгцгээв. Аллахын элч (салаллаху алейхи уа сальлам) “Зам тавьцгаа, тэр дотогшоо орог!” хэмээв.

Жабрайл сахиусан тэнгэр (алейхисальлам) аль хэдийнээ Омарыг мусульман болохоор ирэх цаг ойртсоныг Мухаммедэд (салаллаху алейхи уа сальлам) мэдэгдсэн байлаа. Аллахын элч (салаллаху алейхи уа сальлам) мишээн Омарыг угтав. “Түүнийг тавь, холдоцгоо” гэв. Омар Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) өмнө өвдөг сөгдөн суув. Аллахын элч (алейхисальлам) Омарын (радиаллаху анх) гарыг атган: “Итгэл рүү ир, Омар минь!” хэмээв. Тэр ч цэвэр ариун сэтгэлээр калима и шахадат хэлэн мусульман болов. Асхабууд баярлан Аллаху акбар (Аллах агуу) хэмээн такбир хэлж баярлацгаав.

Гэгээн Омар (радиаллаху анх): “Аяа, Расулуллах, Аллахын нэрээр андгайлан тангараглъя, айж эмээх тун! Бүх мүшрикүүдэд энэ шашинаа номлон айлдая. Одоо ил тодоор хэлэх цаг хэдийнээ болжээ” гэв. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) Омарын энэ үгийг хүлээн зөвшөөрөв. Мусульманчууд хоёр эгнээ болон жагсаад ариун Каабын зүг хөдөлцгөөв. Нэг эгнээгийн тэргүүнд гэгээн Хамзаа, нөгөө эгнээгийн тэргүүнд нь Омар явж байлаа. Мусульманчууд чангаас чанга алхсаар тоос татуулан ариун Каабын хажууд ирцгээв. Курейш мүшрикүүд Омар, Хамзаа хоёр луу (радиаллаху анхум) харж гайхан зогсоцгооно.

Гэгээн Омар (радиаллаху анх) ирэхэд Эбү Жахил урагш сугаран гарч: “Хөөе, Омар! Энэ юу болж байна” гэхэд Омар “Эшхадү алла илааха иллаллах, Эшхэдү энна Мухаммадэн абдүхүү вэ расүүлүх (Би Аллахаас өөр бурхан үгүйг гэрчилнэ, бас Мухаммед бол түүний элч бас боол нь болохыг гэрчилнэ)

гэв. Эбү Жажил гайхан алмайрав. Гэгээн Омар (радиаллаху анх) мүшрикүүдэд хандан: “Хөөе, Курейшхан!.. Намайг мэдэх нь мэднэ. Харин эс мэдэгсэд нь мэдэж авцгаа! Би бол Хаттабын хүү Омар!.. Эхнэрээ бэлэвсэрч, үр хүүхдүүдээ өнчин үлдээхийг хүсэгчид босоцгоо, хэн нэгэн суугаа газраасаа өндийх юм бол би сэлмээрээ толгойг нь тас цавчин гэж мэд!” гэхэд нь мүшрикүүд тэндээс үтэртүргэн тарж зайлж одоцгоов. Аллахын элч (салаллаху алейхи уа сальлам) ба асхабууд эгнэн зогсож өндөр дуугаар такбир хэлцгээв. Тэдний “Аллаху акбар... Аллаху акбар...” гэх дуу нь Мекке хот хүртэл нүргэлэн байлаа. Ийнхүү анхны удаа ариун Каабын өмнө ил тодоор намаз (мөргөл) үйлдсэн билээ⁷².

Гэгээн Омар (радиаллаху анх) мусульман болоход Энфал сүрегийн (бүлэг) 64-аг илгээгджээ. Утга нь: “Аяа, элч минь! Чамд туслахад Аллах эзэн ба мусульманчуудаас чамайг дагагсад хүрэлцээтэй” хэмээжээ. Гэгээн Омарыг (радиаллаху анх) мусульман болсоныг мэдсэний дараагаар өдөр ирэх тусам мусульманчуудын тоо олширч байлаа...

Хабешстан (Этёп) руу хоёр дахь удаагаа нүүсэн нь

Хабешстан дахь мусульманчууд “Мекке хотод мусульманчууд ба мүшрикүүд хэлэлцээрт хүрч найрамджээ” гэсэн худал мэдээ дуулжээ. Нэгэнтээ Мекке хотод амар амгалан амьдрал эхэлсэн болохоор буцацгаая, Мухаммед элчдээ очин тэрний ажилд тусалцгаая хэмээн шийдээд Хабешстан хотын албан захирагчаас зөвшөөрөл авч Меккед эргэн ирцгээв. Меккед ирээд мүшрикүүд мусульманчуудтай гэрээ хийгээгүйгээр барахгүй дайсигнал одоо болтол үргэлжилж байгааг сонсоод маш их харамсав⁷³. Хабешстанд хэрхэн амьдарч байсанаа, тэндхийн ус агаар нь ямар сайхан болохыг, бас 4 мөргөлийн газар буйг бас тэнд өдөр бүр тэмээ хонь төхөөрч ядууст махыг нь тараадагыг нь, бас тэндхийн хаан нь тэднийг найрсагаар хүлээн авч нутагшуулсан хийгээд зовлон зүдгүүргүй амьдрах нөхцөл бололцоог хангасан тухай ярьж өгөв⁷⁴.

72 Ибн Исхак, Эс-Соре, с, 160-165, 221-229: Ибн Хишам Эс-Соре I, 342-350 : Сүхейл , эр-Равзүл-Үнф.с.II, 19.

73 Ибн Сагд, эт-Табакет III, 205.

74 Ибн Исхак, Эс-Соре, с, 194: Ибн Хишам Эс-Соре I, 364: Ибн Сагд, эт-Табакет I, 208.

Асхабууд Мекке хотод ирэнгүүт нөгөө л дарлал дээрэлхэлээ эхлэн тэднийг зовоож эхлэв. Нэг өдөр гэгээн Омар “Аяа, Алладын элч минь! Хабешстан сайхан газар гэж дууллаа. Аллах эзэн өөр нэгэн нүүх амар амгалан газар зарлигдах хүртэл мусульманчуудын хувьд Хабешстанаас илүү амар амгалан газар олдохгүй байх. Ядаж л хэсэг хугацаанд мусульманчууд мушрикүүдийн дарлалаас ангижрах болно. Тэндхийн хаан Нежашигийн бидэнд хийсэн тус дэм их билээ” гэв. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) энэ үгийг сонсоод “Ахиад Хабешстан руу нүүцгээ, тэнд Алладын нэрийг барьж хамгаалагдцгаа” хэмээв.

Ийнхүү зуун нэгэн хүнтэй аянчид хоёр дахь удаагаа Хабешстаны зүг замд гарцгаав. Энэ нүүдэлчдийг толгойлж Жафер бин Эби Талиб сонгогдсон байлаа. Тэнд аян замдаа саадгүй явж Хабешстаны нутагт хүрчээ⁷⁵.

Хабешстаны хаан нь Нежаши гэдэг хүн байлаа. Тэрээр нүүж ирсэн мусульманчуудад хандан “Хөөе, хүмүүс ээ! Та нар манай газар нутагт яах гэж ирсэн юм бэ? Та нар наймаачид биш байна. Биднээс гуйх зүйл ч алга. Та нарын элч гэх тэр хүн хэн бэ? Ягаад танай Меккегийн хүмүүс шиг мэндлэхгүй өөрөөр мэндэлж байна вэ? гэж асуув. Жафер (радиаллаху анх):

«Аяа, хаантан минь! Бид харанхуй бүдүүлэг нэгэн хүмүүс байсан билээ. Мод чулуугаар урласан бурхадыг шүтдэг, үхсэн амьтадын сэгийг идэж бүхий л муу муухай бүхнийг үйлддэг байсан. Төрөл төрөгсөдийн ураг барилдлагыг салгаж, хөршүүдээ дээрэлхэж, чадалтай нь чадалгүйгээ захирч, дарлан зовоодог зэрлэг балмад хүмүүс байлаа. Аллах эзэн бидэн дундаас шударга ёс, ариун журам, цэвэрч байдал ба үнэнч сэтгэлийг зааж сургах нэгэн элч илгээх хүртэл бид ийм л бүдүүлэг нэгэн байлаа. Тэр элч бидэнд Аллах эзэн цор ганц болохыг, түүнд хэрхэн мөргөн залбирахыг, шударга яриатай бас захисан захиасыг дагахыг, төрөл садандаа нигүүлсэнгүй хандахыг, хөрштэйгээ эв найрамдалтай байхыг, нүгэл үйлдэхээс бас цус урсгахаас хол байхыг зааж номлосон билээ. Бүхий л бузар булхайгаас худал хуурмагаас, өнчин ядуусын малыг идэхээс, ариун журамт эмэгтэйчүүдийг гүтгэн доромжилхоос биднийг биднийг хорьж цээрэлсэн. Бид ч тэрний хэлсэн зарлигласан бүхэнд итгэн дагаж Аллах эзэндээ мөргөн залбирах болсон билээ. Түүний бидэнд цээрэлсэн зүйлийг цээртэй болгож, бидэнд зарлигласан зүйлийг зарлиг

(хууль) хэмээн дагаж ирсэн билээ. Тийм болохоор үл итгэгсэд биднийг дайсан мэтээр харж амар тайван амьдруулахгүй болсон билээ. Тэд биднийг шашинаасаа гарч дахин шавар бурхадад залбируулахын төлөө биднийг гадуурхан дарамтлах болсон. Биднийг байж суух аргагүй болтол дээрэлхсэн болохоор бид эх нутгаа орхин амар амгалан амьдрал хайж ирлээ. Таныг шударга хаан болохыг танай нутаг энх тайван болохыг сонссон болохоор таны хажууд байвал шударга бусаар тамлан зовоогдохоос ангид амьдрах байх гэж горьдож байна” гэв⁷⁶. Цааш үргэлжлүүлэн:

«Бидний мэндлэх ёсон бол бид таньтай Аллахын элчтэй мэндлэхтэй нэгэн адил мэндэлсэн билээ. Бид хоорондоо ч ингэж мэндэлцгээдэг. «Хойд насанд диваажинд орогсодын мэндээ мэдэлцэх ёсон ийм байх болно» гэж пайгамбар маань зааж номлосон билээ. Тийм болохоор таны мэндийг ийн асуусан бөлгөө. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) хүнд мөргөн залбирахыг цээрлэдэг болохоор бид зөвхөн Аллахын өмнө өвдөг сөгдөн мөргөдөг юм” гэв.

Нежаши хаан “Чи Аллахын илгээсэн тэр судар номноос мэдэх үү?” гэж асуув. Жафер “Тийм ээ, мэднэ” гэхэд Нежаши хаан “Надад уншиж өгөөч” гэв. Жафер Мариям сүрег (бүлэг) уншиж өгөв. Энийг сонсож суусан Нежаши хаан өөрийн эрхгүй нулимс асгаруулан уйлж байлаа. Түүний нулимс сахалыг нь норгоход хажууд нь байсан барлагууд ч мөн адил уяран уйлж байлаа. Нежаши ба хамба ламууд “Жафер, энэ гайхмаар бас сайхан судраасаа ахиад уншаач” гэж гуйв. Гэгээн Жафер (радиаллаху анх) Кехб сүрег эхнээс нь уншиж эхлэв.

Куран судрын энэ ариун сургаал номлолыг сонсож дуусаад Нежаши: “Андгайлан хэлье, би урьд өмнө ийм сайхан үг сонсож байгаагүй билээ. Муса ба Иса (алейхисальлам) элч нар ч мөн адил ийм шударга шашиныг авч ирсэн бөлгөө” ⁷⁷хэмээжээ.

Уй гашуудалт жилүүд Бэхлэлт

Мүшрикүүд ислам шашиныг зогсоохын тулд зогсолтгүй мусульманчууд руу дайрч давшиж байсан хэдий ч өдөр ирэх тусам мусульман бологсод нэмэгдэж байлаа. Тэдэнд ямар ч

76 Ибн Исхак, Эс-Соре,с, 195: Ибн Хишам Эс-Соре I,332.
77 эл-Кэхиф,18/0-7.

зовлон бэрхшээл учруулч байсан ч тэд ислам шашинаасаа буцахгүйгээр барахгүй харин ч нэг нэгнээ гэсэн сэтгэл, үнэмшил нь улам нэмэгдэж тэдний хоорондын уялдаа холбоо улам батжиж байлаа. Тэдний ч хэн ч гэсэн Аллахын элчийн (салаллаху алейхи уа сальлам) энэ ариун шашины төлөө амиа золиослоход ч бэлэн байлаа. Энийг сонссон Мекке хотоос зайдуу оршин суудаг хүмүүс исламыг гэх сонирхол нэмэгдэж исламын дуу хоолой холын холд цуурайтах болжээ. Кафирууд цуглан хуралдаж ийм нэгэн аймшигт шийд гаргажээ. “Хаана ч байсан, хаана ч үзсэн Мухаммед элчийг алах” шийд гаргав. Кафирууд цөм энэ шийдвэрийг хүлээн зөвшөөрч ам тангарагаа өргөцгөөв.

Мүшрикүүдийн энэ шийдвэрийг сонссон Эбү Талиб маш их сэтгэлээр унажээ. Өөрийн хайрт дүү Мухаммедэд (салаллаху алейхи уа сальлам) муу зүйл тохиолдох вий хэмээн эмээж байлаа. Өөрийн овогт хорвоо ертөнцийн ноён болсон Мухаммед элчийг (салаллаху алейхи уа сальлам) хамгаалахын төлөө бүхнээ зориулцгаа хэмээн зарлиг буулгав. Хашимын хөвгүүд овгийхон ч гэсэн энэ зарлигийг биелүүлэхийн тулд цугларцгаав. Тиймээс Мухаммедыг (салаллаху алейхи уа сальлам) ба түүнд итгэгсэдийг цөмийг нь Каабаас 3 км зайд орших Шиб Эбү Талибд, өөрөөр хэлбэл, Эбү Талибийн хороололд ирхийг дуудав. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) ч асхабуудаа цуглуулан Шиб хороололд амьдарч эхэлжээ. Хашемийн хөвгүүдээс зөвхөн Эбү Лехеб Мухаммедыг (салаллаху алейхи уа сальлам) хамгаалах шийдвэрээс эсэргүүцэв⁷⁸.

Мүшрикүүд Мухаммед (салаллаху алейхи уа сальлам) ба түүний асхабуудыг Шиб хороололд нутаглахыг сонсоод цуглан хуралдаж өөр нэг шийд гаргав. “Мухаммед элчийг алуулахын төлөө мүшрикүүдэд өгөх хүртэл Хашимын хөвгүүд овгийнхоос бэр гуйхгүй... Тэдэнд ч охидоо өгөхгүй ямар ч наймаа хийхгүй... Тэдэнтэй юу ч ярихгүй... Тэдний гэрт бас тэдний хороололд орохгүй... Тэдний найрамдах гэсэн хүсэлтийг нь хүлээн зөвшөөрөхгүй байх, тэднийг өрөвдөхгүй байх... гэх мэт” шийдвэрийг Мансур бин Икримэ гэх мүшрик нэг цаасанд бичиж тамгалав. Тэгээд тэр шийдвэрийг Каабын хананд өлгөв.

Энэ шийдвэрийг дуулсан Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) ихэд сэтгэлээр унан Аллах эзэндээ залбирав. Харин маргааш өглөө нь Мансурын хоёр гар нь тахирч яс нь өгөрчээ.

Мүшрикүүд гайхширан: “Харцгаа, Хашимийн хөвгүүдэд хийсэн үйлийнхээ төлөө Мансурын гар нь тахирлаа” гэцгээв. Тэд энэ зүйлийг хараад буруу зүйл хийж байгаагаа ухаарахын оронд бүр ч галзууран Шиб хороолол руу явах замд харуулууд зогсоон хоол хүнс бас хувцас хунар оруулахыг нь хориглов. Ийнхүү гаднаас ирсэн наймаачидыг Шиба хороололд наймаа хийхийг нь хориглон, хүсвэл тэдний барааг өндөр үнээр худалдаж авна гэж шийдвэрлэжээ. Энэ нь жил бүр хүн ихээр цуглардаг мөргөлийн сар байлаа.

Арабуудын хувьд энэ сард цус урсган дайн хийх нь хориотой байсан болохоор мусульманчууд Мекке хотод очин нэг жилийнхээ хоол хүнс хувцас хунараа авахаар очлоо. Тэднийг захад очоод наймаа хийхээс урьтаж Эбү Жахил, Эбү Лехеб гэх мэт мүшрикүүд наймаачидад очин “Та нар Мухаммедийн асхабуудад барааныхаа үнийг худалдаж авахааргүй болтол өсгө, хэрвээ бараа чинь та нарт үлдэх юм бол бид бүгдийг нь худалдаж авна” гэж ятгаж байлаа. Наймаачидад ч гэсэн барааныхаа үнийг маш ихээр өсгөснөөр мусульманчууд юу ч худалдаж авч чадалгүй гэртээ буцацгаадаг байлаа...

Энэ үед хайрт элч бас Хадиша эх ба Эбү Бакир нар өөрт байсан бүх мал хөрөнгөө хэрэглжээ. Энэ хороолол өлсгөлөнд нэрвэгдсэн ч мусульманчуудын итгэл бишрэл огтхон ч мохсонгүй.

Мүшрикүүд Хашимийн хөвгүүд овгийнхонийг бас Эбү Талибийг Мухаммедийг (салаллаху алейхи уа сальлам) тэдэнд өгөх байх гэсэн горьдлогоор харж байлаа. Гэвч Эбү Талиб ба түүний хороололынхон харин ч эсрэгээр нь Мухаммедийг (салаллаху алейхи уа сальлам) хамгаалахын төлөө бүх зүйлээ өгөхөд бэлэн байлаа. Эбү Талиб болзошгүй аюулаас Мухаммед алейхисальламыг хамгаалахын тулд түүний хажууд харуул тавьж эсвэл өөрийн гэртээ түүнийг хонуулдаг байлаа. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) ч Аллахын зарлиг, ислам шашинаа номлон түгээх үүргээ зогсоолгүй хийж байлаа. Түүний дайсан болсон мүшрикүүдэд ч энэ зовлонг амсуулахын тулд алгаа дэлгэн “Аяа, Аллах минь! Энэ кафируудад ч гэсэн Юсуф (алейхиссальлам) элчийн үед өгсөн долоон ган гачиг, адил долоон жилийн ган гачиг өгч надад туслаач гэж залбирав.

Энэ өдрөөс хойш тэнгэрээс нэг ч дусал бороо орсонгүй, газар гандаж хагаран өлсөж үхсэн малын сэгийг ноход идэн цадаж

байлаа. Өлсгөлөнгөөс болж үхэгсэдийн тоо олширч байлаа. Мүшрикүүдийн нэг Эбү Сүфян Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) өмнө ирж: “Аяа, Мухаммед! чи өөрийгөө Аллахын элч бөгөөд энэ хорвоогийн хайр энэрэлийн төлөө илгээгдсэн гэж байсан. Тэгээд ч төрөл садандаа хүндэтгэлтэйгээр хандан шударга ёсыг тогтооно гэсэн. Харин одоо чиний ард түмэн ган гачиг өлсгөлөнгөөс болж сүйрэх аюул тулгараад байна. Энэ зовлон шанлалыг алга болгохын тулд Аллах бурхандаа залбир Аллах чамайг сонсоно. Хэрвээ чи ингэж залбираад биднийг зовлонгоос аврах юм бол бид цөмөөрөө чиний шашинд орох болно...” хэмээн амлалт өгөв.

Ийнхүү өөрсдийн хийсэн гэм буруугаас болоод гэсгээгдэж буйгаа ухаарч Мухаммед элчид ирэн гуйж эхлэв. Элч (салаллаху алейхи уа сальлам) тэдний алдааг уучилж “итгэх болно” гэсэн үгийг нь бодон ариун гараа тэнгэрт өргөн Аллахдаа залбирчээ. Аллах эзэн ч хайрт элчийнхээ (салаллаху алейхи уа сальлам) залбирлыг биелүүлж Мекке хотод хур бороогоо харамгүй хайрлав. Газар дэлхий ногоорч ган гачиг тайлагдсан ч мүшрикүүд хэлсэн үгэндээ үл хүрэн нөгөөх л муу санаа хорон хүслээ үйлдсээр байв.

Аллах эзэн энэ явдалд тохиолдуулан илгээсэн аятад ийн өгүүлжээ: “Харин ч эсрэгээрээ тэд нар, (Куран судар ба дахин амилах явдалд) эргэлзэн (чамаар) тохуурхана. Тийм болохоор (хайрт элч минь) тэнгэрээс ил тодоор нэгэн түймэрийн утаа буух үеийг хүлээ. Тэр утаа бүх хүн төрөлхтөнийг бүрхэн авч “Энэ ямар аймшигт гэсгээл вэ? Аяа, эзэн минь, биднийг энэ гэсгээлээс хэлтрүүлээч, бид чамд итгэе” гэгцгээх болно. Тэдэнд ухааран ойлгох хугацаа байхгүй. Тэдэнд үнэнийг ухааруулсан нэгэн элч илгээгдсэн атал, ахиад л түүнээс нүүр бурууллаа. Түүнд: “Галзуу, солиотой” гэгцгээв. Бид энэ гэсгээлийг (утаа ба ган гачиг) жаахан (эсвэл хэсэг хугацаанд) тогтоох болно. Гэвч та нар ахиад л өөрсдийн мухар сүсэг, буруу зам руугаа орцгоох болно. Маш их хүчтэйгээр бас зэрлэгээр (тэднийг) дайрах үед (Бедир өдөр) бид эргэлзэх зүйлгүй тэднээс өшөөгөө авах болно”⁷⁹.

Мүшрикүүд “Шашинд чинь орно” гэсэн амлалтаасаа няцаж урьдийн тамлалаа эхэлцгээв. Аллах эзэн Мухаммед элчид (салаллаху алейхи уа сальлам) “Каабын хананд өлгөгдсөн бүх цаас, зарлалуудыг нэгэн шувуу идэж “Аллах” гэсэн нэрийг

идэлгүй орхихийг мэдэгдэв. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) Эбү Талибд хандан: “Аяа, авга ах минь! Миний эзэн Аллах мүшрикүүдийн бичсэн бүх зүйлийг идэх нэгэн шувууг илгээжээ, тэр шувуу Аллах гэсэн нэрнээс өөр бусад бүх юм бичсэн цаасыг идсэн байна” хэмээв. Эбү Талиб “Энийг чамд Аллах бурхан чинь айлдаа юу?” гэж асуухад Мухаммед элч “Тиймээ” хэмээв. Тэгэхэд нь Эбү Талиб “Би чамайг үргэлж үнэнийг хэлдэгт итгэж байна” гэв. Эбү Талиб тэр даруй хувцаслан ариун Каабын зүг явав. Тэнд мүшрикүүдийн толгойлогчид сууцгааж байлаа. Эбү Талибийг ирж явааг хараад “Тэр Мухаммедыг бидэнд өгөхөөр ирж байгаа байх” гэж горьдож байлаа. Эбү Талиб тэдний хажууд ирээд “Хөөө, Курейш овгийнхон! “Ал-Амин” болох, хэзээ ч худлаа үг ярьж байгаагүй миний дүү Мухаммед та бүхний бичсэн бичиг бүрийг Аллахын нэрнээс бусад бүх цаасыг нэгэн шувуу идсэн гэж сонслоо. Алив бидний эсрэг бичсэн цаасаа аваад ирцгээ, үзье!.. Хэрвээ энэ үг үнэн бол бид цөмөөрөө үхэх хүртлээ Мухаммедыг хамгаалахаа амлаж байна. Та нар ч гэсэн түүнийг шаналган зовоохоо больцгоо...” гэв.

Мүшрикүүд сандарцгаан Каабын хананд өлгөсөн бичгийг буулган үзэцгээв. Эбү Талиб “уншицгаа” гэхэд. Тэдний нэгэн уншихаар завдахад “бисмике, Аллахүмма” гэх хоёр үгнээс бусад бүх үгнүүд арилсан байлаа. Мүшрикүүд юу хэлэхээ үл мэдэн гайхан зогсоцгооно. Зарим нь 3 жил үргэлжилсэн энэ зовлон шаналалын төгсгөл ирэх цаг болсоныг ойлгон, хий дэмий тэмцэж байгаагаа ухаарсан ч ягаад ч юм энэ мухар сүсэгээ үл хаяж чадна. Тэд хэдий маш их хичээсэн ч ислам шашин өдөр ирэх тусам дэвжин цэцэглэж итгэгсэдийн тоо олширсоор байлаа. Аллахын элч (салаллаху алейхи уа сальлам) энэ харанхуй бүдүүлгээс хүмүүсийг авран, тэдэнд аз жаргал шударга үнэний түрхүүрийг атгуулж байв. Энэ аз жаргалын түлхүүрийг атгагсад исламдаа итгэн Аллахдаа баярлан буруу номтонуудын тамлал зовлонгийн эсрэг сөрөн зогсох хүчийг олж авч байлаа...

Сар хоёр хуваагдсан нь

Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) агуу гайхамшигт явдалын нэг нь сарыг хоёр хуваасан явдал юм. Эбү Жажил ба Валид бин Мүгире тэргүүтэй хэсэг мүшрикүүд Мухаммед элчид (салаллаху алейхи уа сальлам) ирж “Чи

үнэхээр элч юм бол энэ сарыг талыг нь Куайкиан уулын цаана, талыг нь Эбү Кубейс уулын цаанаас үзэгдүүл гэв. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) “Хэрвээ би энийг хийвэл ислам шашинд итгэх үү?” гэж асуув. Тэд “Тийм ээ, итгэнэ” гэцгээв. Элч (салаллаху алейхи уа сальлам) сарыг хоёр хуваагдахын төлөө Аллах эзэнд залбирав. Энэ үед Жабрайл (алейхисальлам) сахиусан тэнгэр Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) өмнө ирж: “Аяа, Мухаммед! Энэ орой Мекке хотынхонд гайхамшигтай зүйлийг харуулахын төлөө дууд” гэв. Мухаммед элч сарын 14-нд, өөрөөр хэлбэл, бүтэн сар гарах тэр шөнө сарыг хоёр хуваагдахыг харж итгэл бишрэлийн замд хүрэлцэн ирэхийг дуудав. Тэр шөнө хайрт пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) долоовор хуруугаараа сарыг дундуур нь зурж буй мэт болоход тэр даруй сар хоёр хуваагдан нэг хэсэг нь Эбү Кубейс нөгөө хэсэг нь Куайкиан уулын цаагуур орлоо. Ахин тэнгэрт гаргаж нийлүүлэн бүтэн болгов.

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) асхабуудаа: “Хөөе, Эбү Селеме бин Абдулэсэд, Эркам бин Эби-л Эркам! Гэрч болцгоо” хэмээв. Мүшрикүүд өөрсдийн нүдээр энэ гайхамшигт үйл явдалыг харцгаав. Харамсалтай нь урьдын адил итгээгүй, бөгөөд бусад нь ч итгэхих вий хэмээн “Энэ бол Мухаммедын хийсэн удаах илбэ байлаа, яаж тэр бүх хүмүүсийн нүдийг хуурч чадваа. Энийг өөр газраас ирсэн хүмүүсээс ч асууцгаая. Тэд энэ гайхамшигийг харсан болов уу үгүй болов уу? Хэрвээ тэд ч мөн адил харсан бол жинхэнэ элч мөн. Хэрэвээ хараагүй бол нэг илбэ юм гэцгээв. Холоос ирэгсэдээс асууж байлаа тэд “Тийм ээ, бид сар хоёр хуваагдахыг харсан гэсэн хариулт өгч байлаа. Гэвч тэд итгэсэнгүй, үл итгэгсэдийн тэргүүнд Эбү Жажил байгаа тэрээр хүмүүсийг төөрөгдүүлэхийн тулд “Эбү Талибийн өнчин (Мухаммед) хүүгийн илбэ тэнгэрт хүрлээ...” гэж орлиж байлаа. Тэрний ийнхүү эсэргүүцлийн төлөө Аллах эзэн ает илгээжээ: «Тэр хугацаа (шүүгдэх өдөр) ойртон бас сар хоёр хуваагдлаа. Тэд (Курейш овгийнхон, Мухаммед элч үнэн болохыг нь гэрчилсэн) нэг гайхамшиг үзсэн бол (түүнийг тунгаан ойлгохоос итгэж үнэмшихээс) нүүр буруулцгааж, бас: “Энэ бол үргэлжилсэн (дуусашгүй) нэгэн илбэ юм” гэцгээнэ. Өөрсдийн хүсэл сонирхолд (дур ташаалдаа) татагдан, дагацгаав. Үнэндээ (диваажингийнхан диваажиндаа, тамынхан тамдаа л орцгоох болно) Тангараглан айлдъя! Тэдэнд (Меккегийн мүшрикүүдэд Куран сударт, өнгөрсөн

хүмүүст ба хойд ертөнцийн амьдралын тухай үгүйсгэх ба эсэргүүцэхээс) зогсоох, маш хэрэгтэй мэдээнүүдийг илгээсэн агаад энэ нь үгээр илгээгдсэн нэгэн гайхамшиг билээ. (Тэр сударыг хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд) эсэргүүцсэн (тамын гэсгээлээр айлгах) элчүүд тэдэнд хэзээ ч тус дэм болохгүй. Тийм болохоор (хайрт элч минь, тэдэнд элч болохоо шударга замд уриалан дуудсаныхаа дараагаар) чи ч бас тэднээс нүүр буруул. Тэр уриалагсадын (Исрафил ба Жабрайл кафируудыг маш хүчтэйгээр) үгүйсгэсэн зүйлдээ (шүүх өдөр) дуудах өдөр. (Аюулаас) нүд нь орой дээрээ гаран (айсандаа хаашаа зугтахаа мэдэхгүй болсон тэр үед) үхсэн царцаа мэтээр булшнаасаа өндийх болно. Кафирууд (толгойгоо бөхийлгөн) тэр уриалан буй хүн рүү гүйн очоод: “Энэ өдөр бидний хувьд ямар аймшигт өдөр вэ?” гэгцгээх болно⁸⁰.

Эзэн маань та нарыг ч зөв замд оруулаг!..

Мүшрикүүдийн мусульманчуудад хийсэн 3 жилийн бүслэлт эцэс болсоны дараагаар Нежран хотоос хэсэг хүмүүс Мухаммед элчид (салаллаху алейхи уа сальлам) бараалхан иржээ. Энэ хүмүүс хорь гаруй бөгөөд Хабешстан руу нүүсэн мусульманчуудаас ислам шашиныг дуулжээ. Тиймээс Куран сударыг сурч, Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) ариун царайг нь харж мэлмийгээ баясгахын тулд Меккед ирсэн нь энэ байлаа. Тэд элчтэй (салаллаху алейхи уа сальлам) ариун Каабын хажууд уулзаад, урьдаас асуух гэж төлөвлөсөн асуултаа тавьцгаан бодсоноо ч илүү сайхан хариултууд авсандаа сэтгэл хангалуун байлаа. Тэдний яриаг хажууханд нь хэсэг мүшрикүүд сонсож зогсоно. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) энэ хүмүүст Аллахын илгээсэн Кураны аетаас хэсэг бүлэг уншиж сонордуулахад Нежраны хүмүүс энэ гайхамшигт сударыг уншиж дууссаны дараа сэтгэл нь догдолж сэтгэлээ барьж үл тэвчин үйлж байлаа. Үүний дараагаар элчийн исламд уриалахыг сонсоод маш их баярлан келима и шахаадет хэлж мусульман болцгоов. Мусульман бологсод хэсэг Меккед амарч тухалсаны дараагаар нутаг буцах зөвшөөрөл авахад Эбү Жахил тэдний хажууд ойртон ирээд: “Би амьдралдаа та нар шиг тэнэг хүмүүсийг огт харсангүй... Тэдний хажууд хэсэгхэн суугаад босохдоо шашинаасаа

гараад түүнд итгэлээ. Юутай их тэнэглэл вэ?” хэмээн тэднийг доромжлов. Дөнгөж асхаб болцгоосон энэ хүмүүс түүнд хандан: “Аллах таныг ч бас зөв замд оруулаг. Бидэнд хэлсэн энэ бүдүүлэг түрэмгий авирыг бид таньд гаргахгүй. Үнэндээ бид хүнийг муулж хараахаас ангид билээ. Тиймээс ч бид буруу номтнуудын хэсэг үгэнд хууртагдан энэ шашинаасаа хэзээ ч гарахгүйг та мэдэж ав” хэмээн хариулжээ⁸¹.

Аллах эзэн энэ явдалыг тохиолдуулан ает илгээжээ: “Энэнээс (Куран судраас) өмнө, өөрсдөд нь судар илгээгдсэн хүмүүс бий, тэд энэнд (Куран сударт) итгэдэг. Тэд нардт (Куран судрыг) уншиж сонордуулахад “Бид энэнд итгэж байна. Гарцаагүй энэ бол их эзэнээс (илгээсэн) үнэн судар мөн. Үнэндээ бид урьд өмнө исламыг хүлээн зөвшөөрсөн шүү дээ” гэгцээнэ. Энэ хүмүүст няцашгүй тэвчээртэй байсны төлөө хоёр дахин илүү буян, бэлэг өгөх болно. Эд нар муу муухайг сайн сайханаар хариулдаг. Зөвхөн өөртөө оноогдсон буян хишигийг (ариун үйлд) хэрэглэдэг. Эд нар муу муухай үг сонсохоос нүүр буруулдаг ба “Бидний үйл бидэнд, та нарын үйл та нарт л зохино. Та нарыг ивээг, бид мунхагуудыг хайгаагүй (тэдэнтэй ч нөхөрлөхгүй) гэгцээнэ.”⁸²

Гашуудалт жилүүд

Пайгамбарын маань (салаллаху алейхи уа сальлам) Касым гэх хүү нь 17 сартайдаа энджээ. Энэ гунигт явдалаас хэсэг хугацаа өнгөрсөны дараагаар хоёр дахь хүү Абдуллах ч гэсэн нас баржээ. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) гэгээн мэлмийгээсээ нулимс унаган уул руу харан: “Аяа, уул минь, намайг нөмөрсөн энэ зовлон шанлал чамд тохиолдсон бол чи өргөж чадахгүй нурж унах байсан” хэмээжээ. Гэгээн Хадиже эх “Аяа, Аллахын элч минь, хөвгүүд маань одоо хаана байгаа юм?” гэж асуухад Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) “Тэд диваажинд байгаа” гэжээ. Хорвоогийн энэрэл хайр болсон Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) энэ гашуудал явдалд мүшрикүүд баярлан алгаа ташицгааж байлаа. Эбү Жажил мэтийн кафирууд энэ явдалыг хараад “Ийнгээд Мухаммедын үр удам тасарлаа, түүнд голомт залгах хүү үлдсэнгүй. Тэрнийг үхэнгүүт нэр алдар нь ч гэсэн мартагдах болно” хэмээн тавалсан

81 Ибн Исхак, Эс-Соре,с, 194-200: Ибн Хишам Эс-Соре I,391-392.
82 эл-Касас28/52-55.

цуурхал тараажээ. Энэ явдалыг тохиолдуулан Аллах эзэн Кавсэр сүрег (бүлэг) илгээжээ. Утга нь: “(Хайрт элч минь,) үнэндээ бид чамд кавсер булагийг өглөө. (Кавсер булаг, тоо тоомшгүй олон буян хишиг заяалаа) Тийм болохоор эзэнийхээ төлөө намаз мөргөлөө үйлд, тахилаа өргө. Үнэндээ чамайг (үр удам тасарсан хэмээн) доромжилогсод, буянгүй бас тэдний үр удам нь тасарсан. (Чамайг үр удамгүй гэгсэдийн өөрсдийнх нь үр удам нь журамгүй бас ичгүүргүй билээ. Харин хайрт элч чамайг өндөрт өргөн, хойд ертөнцөд чиний нэр алдар бүхнээс дээд ариун байх болно. Тэнд чамд юутай ч зүйрлэшгүй маш их буян хишигийг хүртээх болно.) хэмээжээ.

Аллахын элчийн (салаллаху алейхи уа сальлам) хөвгүүдийн үхлээс хойш хэсэг хоногийн дараа авга ах Эбү Талибд үхлийн өвчин туссан байлаа. Өдөр ирэх тусам өвчин нь улам хүндэрч байв. Энэ мэдээг дуулсан Курейшийн мүшрикүүд: “Эбү Талиб эдгэшгүйгээр өвджээ. Түүний амьдралын хугацаа дуусах дөхсөн бололтой. Тэр амьддаа Мухаммед элчид хир халдаахгүйгээр хамгаалдаг байсан бол одоо тэрнийг үхчихвэл Мухаммедыг хэн хамгаалах юм. Үнэндээ Хамзаа Омар хоёр шиг эр зоригт баатарууд мусульман болсон. Исламын дуу хоолой өдрөөс өдөрт цуурайтаж тэрэнд итгэгсэд олширсоор байна. Бүгдээрээ Эбү Талибийн бие лагшинг асууж мэдэцгээе, тэр бол манай шашиний хүн шүү дээ.” хэмээн Эбү Талиб руу очигтоов.

Укбе, Шейбе, Эбү Жажил, Умейе бин Халеф тэргүүтэй хэсэг мүшрикүүд Эбү Талибийн хажууд ирээд ийн хэлэв. “Чамайг бид хүндэлж дээдэлдэг билээ. Бидний дундаас хамгийн настай буурал нь чи болохоор бид хэзээ ч чамайг эсэргүүцэж байгаагүй билээ. Одоо чамайг ингээд нас барахаар Мухаммед дүү чинь их ганцаардаж хүчин мөхөсдөх болно. Тийм болхоор бид нарыг эврүүл, нэг нэгнийхээ шашинаар тоглохгүй байъя” гэцгээв.

Эбү Талиб Мухаммед элчийг дуудуулан ирүүлээд: “Курейш овгийн бүхий л толгойлогчид чамайг өөрсдийнхөн шашинаар тохуурхахгүй байхыг хүсэж байна. Хэрвээ тэгвэл тэд чамд саад болохгүй гэж ам өчгөө өгье гэнэ” гэв. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) “Аяа, авга ах минь! Тэднийг ганцхан үгээр уриалахыг хүсэж байна. Тэр үгийг л хэлчихвэл бүхий л Арабууд толгой бөхийлгүй энх тунх найрамдалтай амьдрах юм.” гэв. Курейшийн толгойлогчидод “Тийм ээ! Та нар надад ганцхан үг хэлж өгөх юм бол тэр үгээр бүхий л арабууд нэр алдараа

мандуулж тэр бүү хэл Арабаас бусад улс үндэстэн ч та нарын өмнө бууж өгөх болно” гэв. Эбү Жахил : “Болно, бид тэр үгийг маш чангаар дуудах болно. Тэр үг чинь тэгээд юу юм бэ?” гэв. Аллахын элч (салаллаху алейхи уа сальлам) “Лаа илааха илаллах (Аллахаас өөр бурхан үгүй) гэж хэлцгээх юм бол, бас Аллахаас өөр бурхад гээд байгаа чулуу шаваруудыг хөсөр хаях юм бол” гэж хэлхэд мүшрикүүд: “Чи биднээс өөр зүйл гуй” гэцгээв. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) “Та нар нарыг миний гарт атгуулсан ч би та нараас энэнээс өөр зүйл гуйхгүй” гэж хэлэв.

Мүшрикүүд “Хөөе, Мухаммед хүү! Чи биднээс маш хэцүү зүйл шаардаж байна. Бид чамайг баярлуулахыг хүссэн, гэтэл чи биднийг гомдоогоод байна” гэцгээж тэндээс тарж явцаалаа. Эбү Талиб элчид (салаллаху алейхи уа сальлам) хандан “Чи курейшийнхнаас маш зөв зүйл шаардлаа” гэв. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) Эбү Талибд хандан “Аяа, авга ах минь! Ганцхан удаа «Лаа илаха илаллах» гэж хэлээч. Хэрвээ тэгвэл хойд ертөнцөд би таньд туслах болно” гэв. Эбү Талиб “Хүмүүс үхлээс айгаад мусульман боллоо гэж намайг муу хэлхээс эмээж байна, үгүй бол чамайг баярлуулмаар л байна” гээд исламын шашинд орж амжилгүй нас баржээ.

Гэгээн Хадиже эхийн үхэл

Аллахын элчийн (салаллаху алейхи уа сальлам) түшиг болсон 24 жил ханилан амьдарсан гэгээн Хадиже эх (радиаллаху анха) их нүүдлээс 3 жилийн өмнө Рамазан сарын эхэнд 65 настайдаа нас баржээ. Гэгээн пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) түүнийг өөрийн гараар оршуулжээ. Энэ хагацал элчийн хувьд маш их уй гуниг харуусалыг авч иржээ. Нэг жилийн дотор авга ах Эбү Талиб, хайрт хань Хадиже хоёроосоо хагацсан нь Мухаммед элчийг (салаллаху алейхи уа сальлам) дааж давашгүй гашуудалд унагжээ. Тийм болохоор энэ жилийг Сенет-үл Хүзн буюу уй гашуудалд жил хэмээн нэрэлжээ.

Гэгээн Хадиже эхийн нас барсан нь Мухаммед элчийг (салаллаху алейхи уа сальлам) маш ихээр гашуудахад хүргэжээ. Учир нь хамгийн анхны мусульман бол тэр байлаа. Тэгээд ч хамгийн ихээр элчийг (салаллаху алейхи уа сальлам) түшиж халамжилдаг хүн тэр юм. Бүх хүн түүний дайсан болохуйд

тэрээр хамаг бүхнээрээ элчийг хамгаалж ямагт түүний төлөө шаналан зовдог байлаа. Бүх мал хөрөнгө эд хогшил юу л байна тэр бүхнээрээ исламыг түгээхэд зориулжээ. Мухаммед элчийг (салаллаху алейхи уа сальлам) мэдээж гомдоож байгаагүй билээ.

Нэг өдөр Хадиже эх Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) гадуур гарсаны хойгуур түүнийг хайхаар гарчээ. Жабрайл (алейхисальлам) сахиусан тэнгэр түүний дүрд хувиран Хадиже эхэд харагдахад Хадиже эх (радиаллаху анха) тэрнээс Мухаммед элчийг (салаллаху алейхи уа сальлам) асуухыг хүссэн боловч дайсан байж магад гэж бодоод гэрлүүгээ буцжээ. Гэртээ ирээд элчийн ирсэн байхыг хараад тохиолдсон явдалаа ярьжээ. Тэгэхэд нь Мухаммед элч ийн өгүүлжээ. “Чиний харсан бас намайг асуухыг хүссэн хүн бол хэн болохыг чи мэдэх үү? Тэр бол Жабрайл (алейхисальлам) сахиусан тэнгэр юм. Тэрээр чамд мэнд дамжуулаарай гэж хэлсэн. Тэгээд диваажинд чамд зориулж маргад эрдэнэ, шүр сувдаар чимэглэсэн нэгэн ордон чамд зориулж барьсан, мэдээж чи тэнд энд байгаа шигээ хэцүү хүнд биш бас гачигдах зүйл байхгүй”

Гар нь хөдөлгөөнгүй болсон нь

Хайрт пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) ислам шашиныг түгээхийн тулд бүхий л хүч хөдөлмөрөө дайжилж байлаа. Мэдээж Эбү Жахил ба Вэлид бин Мугире гэх мэтийн мүшрикүүд энэнд маш их уурлан атаархдаг байлаа. “Энэ байдалаараа бол Мухаммед бүх хүнийг өөрийн шашиндаа татах байх” хэмээх айдаг байлаа. Тиймээс ч энэ хүнийг зогсоох ганц зам бол Муххаммед элчийг (салаллаху алейхи уа сальлам) алах явдал байв. Эбү Жахил, Вэлид бин Мугире бас Махзумын хөвгүүд гэх хэсэг залуус ариун Каабын (сүм) өмнө иржээ. Энэ үед хайрт элч маань (салаллаху алейхи уа сальлам) намаз (мөргөл) үйлдэж байлаа. Эбү Жахил нэг том чулуу бариад урагш ухас хийв. Мухаммед элчийг (салаллаху алейхи уа сальлам) цохихоор чулуутай гараа далайх үед хоёр гар нь өргөгдөн хөдөргөөнгүй хөшиж орхив. Өөрийн гараа удирдаж чадахаа байсан Эбү Жахил гайхширч хойш ухарч эхлэв. Тэгээд мүшрик найзуудынхаа хажууд ирэхэд гар нь хэвийн байдалд орж чулуу ч газар унах нь тэр. Махзумын хөвгүүдээс нэг хүн тэр чулууг шүүрэн аваад “Харж

байгаараай, би түүнийг алах болно” гээд ухасхийхэд гэв гэнэт нүд сохорч харахаа больжээ. Үүнийг харсан Махзумын хөвгүүд Мухаммед элч рүү (салаллаху алейхи уа сальлам) давшилан ойртоход тэд бүгдээрээ юм харахаа больж хий дэмий агаарт гараа савчина. Харин Мухаммед элчийг (салаллаху алейхи уа сальлам) сонсож байлаа. Тэд ийнхүү Мухаммед алейхисальламд юу ч хийж чадалгүйгээр буцацгаав. Аллах эзэн явдалыг тохиолдуулан ает (лүндэн) илгээжээ:

«Тэдний өмнүүр нэгэн хөшиг татлаа. Тэдний нүдийг нь бүрхлээ. Одоо харж чадахгүй»⁸³

Тайф тосгоныг исламд уриалсан нь

Мүшрикүүд хайрт пайгамбарын маань (салаллаху алейхи уа сальлам) олон гайхамшигийг үзсэн хэдий ч хуучин байдалаа хаян исламд итгэж чадахгүй байлаа. Тэгээд ч зогсохгүй өөрсдийнхөө төрөл саданаасаа мусульман бологсодыг дарлан дээрэлхэж зовоодог байв. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) Мекке хотын эргэн тойронд орших отог овгууд руу очиж чин үнэн шашинд уриалан дуудаж эхлэв. Нэг удаа хажуудаа Зейд бин Харисег дагуулан Тайф хэмээх тосгонд очив. Тайфын толгойлогч болох Амрын хүү Абд-и Ялил, Хабиб ба Мэсүд нартай уулзацгаав. Тэдэнд исламыг номлож Аллахд итгэн бишрэхийг хүсэв. Тэд итгээгүйгээр барахгүй хэл амаараа доромжилон шоолов. “Аллах тэнгэр элч болгохын тулд чамаас өөр хүн олдсонгүй юу? Чам мэтийн элч явуулхаар тийм ядарсан амьтан гэж үү? Манай нутагаас зайл, чиний хамаатан садан чамд итгээгүй болохоор чи манайхыг зориогүй гэж үү? бид чамд туслан чамд ойртохоос айж байна” гэгцгээв.

Аллахын элч (салаллаху алейхи уа сальлам) тэдний энэ доромжлолд маш их гоморхон тэндээс буцав. Секиф тосгонд очоод 10 хоног ислам шашиныг номолжээ. Харамсалтай нь хэн ч итгэл олоогүйгээр барахгүй харин ч Мухаммед элчийг (салаллаху алейхи уа сальлам) шоглон хараан зүхжээ. Хүүхэд багачуудаа гарах замд нь эгнэн зогсоогоод чулуу нүүлгэн зодож дээрэлхжээ. Зейд (радиаллаху анх) тэдний шидсэн чулууг биеэр халхалж элчийг (салаллаху алейхи уа сальлам) хамгаалж байлаа. Зейд Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) эргэн тойрон

гүйж түүн рүү шидсэн чулууг биеээр хаахыг оролдож байв.

Гэгээн Зейд элчийг (салаллаху алейхи уа сальлам) хамгаалж байх үед чулуунууд түүнийг нүүр нүдгүй цохин ам хамрыг нь цус нөжтэй хольжээ. “Больцгоо... Зогсоцгоо... Тэр бол хорвоогийн элч... Намайг яасан ч болно, харин түүнд битгий хүрцгээ” хэмээн орь дуу тавин орилж байв. Энэ үед Зейдийг өнгөрөн нэг чулуу Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) хөлөөс нь цус гаргажээ.

Аллахын элч (салаллаху алейхи уа сальлам) гомдон бас ядарч туйлдан явсаар Утбе, Шейбе гэх цэцэрлэгт очжээ. Тэнд очоод хөлнийхөө шархнаас гарсан цусыг арчин дарет (угаалга) үйлдэж нэгэн саглагар модний сүүдэрт намазаа (мөргөл) үйлдээд сүүлд нь хоёр гараа дэлгэн Аллахдаа залбирчээ.

Энэ бүхнийг цэцэрлэгийн эзэн харж зогсжээ. Тэд пайгамбард маань (салаллаху алейхи уа сальлам) тохиолдсон бүхнийг нэг нэгэнгүй харсан болохоор өрөвдөн Аддас нэртэй боолоороо үзэм явуулж элчийг дайджээ. Аллахын элч (салаллаху алейхи уа сальлам) үзэмнээс амсахдаа бисмиллах (Аллахын нэрээр эхэлнэм) гэж хэлээд идэж эхлэв. Энэ боол христийн шашинтан байлаа. Бисмиллах үгийг сонсоод гайхширан “Би маш олон жил энд амьдарч байна. Энэ үгийг огт дуулаагүй юм. Энэ юу гэсэн үг вэ?” гэж асуув.

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) “Чи хаанахын хүн бэ?” гэж асуув. Аддас “Ниневейн хүн байна” гэв. Мухаммед алейхисальлам “Юнус (aleyхисальлам) пайгамбарын нутгийн хүн юм уу?” гэхэд, Аддас “Чи Юнус элчийг хаанаас мэддэг юм бэ? Тэрнийг энд хэн ч мэддэггүй шүү дээ?” гэв. Аллахын элч (салаллаху алейхи уа сальлам) “Тэр бол миний ах юм. Учир нь тэр хүн над шиг пайгамбар билээ” гэв. Аддас “Ийм сайхан царайтай, ийм шударга яриатай хүн худалч байж таарахгүй. Би чамайг Аллахын элч гэдэгт итгэж байна гээд мусульман болов. ”Аяа, Расулуллах, олон жил би энэ буруу номтонгуудын боол болж байна. Эд нар хүн бүрийг мэхэлж, хүн бүртэй дайсагнадаг эдэнд авах сайхан юм гэж үгүй. Эд хөрөнгө нэр алдарын төлөө юу ч өгөхөөс буцахгүй хүмүүс би эд нараас залхаж байна, болдогсон бол тантай хамт явж таны энэ ариун үйлсэд хувь нэмрээ оруулан ислам шашиныг түгээхийн төлөө зүтгэж, таныг хамгаалж таны төлөө үхмээр байна гэв⁸⁴.

Аллахын элч (салаллаху алейхи уа сальлам) инээмсэглэн: “Одоогоор чи эзэнийхээ хажууд үлд, тун удахгүй миний нэр алдар бүх газараар дуурсагдах болно. Тэр үед миний хажууд ирээрэй” гэв. Тэндээ хэсэг амс хийгээд Мекке рүү буцацгаав. Замдаа Нахисе гэх нэг газар жаал амраад намаз (мөргөл) үйлдэж байх үед Нусайбин гэх жинүүд (буг) өнгөрч яваад элчийн уншсан кураны аетуудыг дуулаад зогсон сонсоцгоожоо. Тэгээд Мухаммед элчид (салаллаху алейхи уа сальлам) ирж ярилцан мусульман болцгоов. Аллахын элч (салаллаху алейхи уа сальлам) тэдэнд : “Та нар өөрсдийн ардуудаа очоод намайг, ислам шашиныг түгээж буйг дамжуулаарай. Тэднийг ч мөн адил исламд уриалан дуудацгаа” хэмээжээ. Энэ бугууд ард түмэндээ очоод Мухаммед элчтэй (салаллаху алейхи уа сальлам) таарсан явдалаа ярин тэднийг итгэл үнэмшилд уриалан дуудахад тэд цөм нэгэн дуугаар мусульман болцгоожээ⁸⁵.

Энэ тухай Куран сударт Жин сүред (бүлэг) бас “Бухари” ба “Мүслим” нэртэй хадис шариф (Мухаммед алейхисальламын айлтгал) номонд дурьдагджээ.

“Лаа илааха иллаллах” гэж хэлээд аврагдацгаа...

Аллахын элч маань (салаллаху алейхи уа сальлам) Мекке хотод эргэн ирээд урьдийн ажилаа үргэлжлүүлж хүмүүсийг итгэл үнэмшилд уриалан дуудаж эхлэв. Энэ нь мүшрикүүдийг улам ихээр уурлуулан түүнийг зогсоохын тулд байж болох бүх муу муухайг хийж эхлэв. Жабрайл (aleyхисальлам) сахиусан тэнгэр ирж мөргөлийн үе болох цагаар гадна дотноос ирсэн мөргөлчин Арабуудад шашинаа номлохыг зариглав.

Раба бин Аббад ийн айлджээ: “Би залуухан хөвгүүн байлаа нэг өдөр ааваа даган Мина дахь мөргөлчид рүү очсон юм. Аллахын элч (салаллаху алейхи уа сальлам) тэнд хоноглосон араб мөргөлчидөд очоод “Хөөе, мөргөлчид өө, мөргөн залбирч буй энэ шавар бурхадаа хөсөр хаян Аллах эзэнд огт эргэлзээгүйгээр итгэн залбирахыг бас намайг элч гэдэгт итгэн дагахыг, бас үнэнхүү бурханаас илгээсэн энэ үйлсийг бүтээхийн тулд намайг хамгаалж найдан дагахыг цор ганц бурхан Аллах зарлиглаж байна” хэмээжээ. Яг энэ үеэр ногоон нүдтэй сүлжсэн үстэй нэгэн хүн өндөрлөг чулуун дээр “Хөөе, мөргөлчид өө, бидний бурхад

бол Лат ба Узза билээ. Бид энэ бурхандаа үе дамжин мөргөн залбирч байгаа билээ. Та бүхнийг төөрөгдүүлэх гэж байгаа энэ хүн (Мухаммед) бол худалч юм. Бүү итгэцгээ, бүү сонсоцгоо!..” гэж орилж байлаа. Би ааваасаа “Энэ хүн хэн бэ?” гэж асуухад: “Мухаммедын авга ах Эбү Лехеб” гэв.

Тарик бин Абдуллах ийн айлджээ. “Нэг өдөр Аллахын элч Зулмежаз гэх яармаг худалдаанд өндөр дуугаар “Хөөе, хүмүүсээ! Лаа илааха иллаллах (Аллахаас өөр бурхан үгүй) гэж хэлээд тамаас аврагдцгаа” хэмээн орилж байлаа. Яг энэ үед нэг хүн гарч ирээд түүн рүү чулуу шидэн байж: “Хөөе, ард түмээн! Түүнээс болгоомжилцгоо, энэ хүн бол худалч...” гэж хөөж байлаа. Түүний шидсэн чулуу элчийг хөлийг онож цус гаргажээ. Би нэг хүнээс “энэ хүн хэн бэ?” гэж асуухад Абдулмутталибийн хөвгүүдын нэг” гэв. “Тэгвэл энэ чулуу шидээд байгаа хүн хэн бэ?” гэж асуухад “Энэ бол түүний авга ах Эбү Лехеб” гэж хариулсан билээ.

МИГРАЖ

Хорвоогийн хайр энэрэл болсон элч (салаллаху алейхи уа сальлам) хаана хэсэг бүлэг хүмүүс үзэгдэн тэнд очиж ислам, итгэл үнэмшлийг зааж байлаа. Гэвч заримд нь хөөгдөн доромжлуулж худалч хэмээн гүтгүүлж байв. Хорвоогийн элч маань (салаллаху алейхи уа сальлам) ядарч өлсөж цангасан ч хэзээч зогсохгүй байлаа. Мүшрикүүд тэрнийг хаана ч явсан даган мөрдөж түүнийг доромжилж байв. Мухаммед очих аюулгүй газар Меккед үгүй болжээ. Тэр орой Эбү Талибийн охин Үмми Ханигийн гэрт очихоос өөр арга байсангүй.

Үмми Хани хараахан мусульман болоогүй байсан юм. Хаалгыг нь тогшиход “Хэн бэ?” гэх дуунаар “Авга ахын чинь хүү Мухаммед байна, хэрэв та зөвшөөрвөл зочиноор ирлээ” гэв.

Үмми Хани “Чи бол үнэн ч шударга эрэнгүй нэгэн билээ, тавтай морил” гэв. Та ирэхээ эртнээс мэдэгдсэн бол би хоол унд бэлдэх байлаа, уучилаарай” гэж угтав.

Аллахын элч (салаллаху алейхи уа сальлам): “Идэх хоол унд хүсэхгүй байна, надад зөвхөн намазаа (мөргөл) үйлдэх залбирах газар байхад л хангалттай” гэв.

Үмми Хани элчийг (салаллаху алейхи уа сальлам) гэртээ оруулж түүнд угаалга үйлдэх түмпэн бас данхтай ус өглөө. Ирсэн зочиноо дайлан түүнийг хамгаалах нь арабуудын ёс жаяг билээ. Тиймээс Үмми Хани “Энэ хүний дайсан нь Меккед маш олон, алахыг хүсэгчидэд ч цөөнгүй, тийм болохоор өглөө болтол унтахгүйгээр харж хоньё” гэж боджээ. Тэгээд эцгийнхээ сэлмийг барин харуулд гарчээ.

Тэр өдөр мүшрикүүд Аллахын элчийг (салаллаху алейхи уа сальлам) маш ихээр доромжилон гомдоосон байлаа. Элч (салаллаху алейхи уа сальлам) дарет (угаалга) үйлдээд Аллах эзэндээ мөргөн, төөрөлдөгч хүмүүсийг итгэл үнэмшилээ олж зөв замд оруулаач хэмээн залбирч эхлэв. Маш их ядарсан бас өлссөн байсан болохоор мөргөж байхдаа унтчихжээ. Энэ үед Аллах эзэн Жабрайл (алейхисальлам) сахиусан тэнгэрт “Хайрт элчээ их гомдоолоо, тэрний ариун бие, эмзэг зүрхийг нь маш их ядраалаа. Гэвч тэр надад залбирсаар л байна. Надаас өөр юу ч бодохгүй байна. Алив, миний хайрт элчийг авч ир! Диваажин, тамыг үзүүл. Түүнд, бас түүнийг дагагсадыг зориулсан бэлэгийг үзэг. Түүнд үл итгэгсэд ба түүнийг гомдоогсодод бэлдсэн

гэсгээлийг үзэг. Түүнийг би тайтгаруулах болно. Тэрний эмзэг зүрхтэй шархыг нь анагаах болно” гэв.

Жабрайл (алейхисальлам) Мухаммедын хажууд ирхэд тэрээр унтаж байлаа. Түүнийг шууд сэрээж зүрхэлсэнгүй. Тэгээд түүний хөлийг үнсэхэд хүйтэн уруул Мухаммед элчийг сэрээв. Жабрайлыг таниад “Хөөе, Жабрайл! Энэ цагт юу гэж явна? Би ямар нэгэн алдаа гаргаа юу? Надад аймшигт мэдээ авч ирээ юу?” хэмээн Аллах эзэнээсээ айж эхлэв.

Жабрайл (алейхисальлам): «Аяа, бүхий л бүтээгдэгсэдийн дээд нь болсон, Туурвигчийн хайрт элч, элчүүдийн дээд, сайн сайханы эхлэл болсон гэгээн пайгамбар минь! Эзэн чинь чамд мэнд хүргэж байна, бас таныг өөртөө урьж дуудаж байна. Босогтун, явъя” гэв. Хайрт пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) угаалга үйлдэв. Жабрайл (алейхисальлам) элчийн толгой дээр туяа гэрэл цацарсан нэгэн малгай өмсгөж, ногоон маргад эрдэнийн бүс бүслүүлэв. Түүний гарт дөрвөн талд нь сувдан чимэглэлтэй нэгэн таяг бариулав. Хөлд нь ногоон маргад эрдэнийн гутал өмсгөв. Тэгээд гараас нь хөтлөөд Каабын зүг явав. Тэнд очоод Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) цээжийг задлан зүрхийг нь гаргаад замзам усаар угаав. Дараагаар нь гайхамшигт итгэл үнэмшилээр дүүрэн нэгэн лонхыг авч ирээд түүний цээжийг дүүргэв.

Дараа нь Жабрайл (алейхисальлам) диваажингаас авч ирсэн Бурак нэртэй цасан цагаан амьтан руу заан “Аяа, Расулуллах! Энэнийг уна. Бүхий л сахиусан тэнгэрүүд замыг чинь тосон хүлээж байна” гэв. Энэ мөчид Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) хэсэг хугацаанд бодолгоширон зогсов. Аллах эзэн Жабрайл алейхисалламаас “Хөөе, Жабрайл! Тэрнээс асуу! Хайрт элч минь яагаад гунихран бодолгоширон вэ?” гэв. Жабрайл (алейхисальлам) асуухад Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам): Би одоог хүртэл маш их хүндэтгэл хайр энэрэл амслаа. Гэнэт хойд ертөнцөд намайг дагагсад маань ямар байх бол, 50 мянган жил Арасатын талбайгаар ийм их нүгэлтэйгээр өнгөрөх билээ. 30 мянган жилийн зам болох сиратийн гүүрийг хэрхэн туулах билээ” гэв.

Энэ үед Аллах эзэн түүнд: “Аяа, хайрт элч минь, сэтгэлээ тайвшруул, чамайг дагалдагсадын хувьд 50 мянган жилийн замыг туулахдаа нүд цавчих зуур л өнгөрөх болно” хэмээв. Ингээд Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) Бурак

гэх тэр моринд мордоод маш хурдтайгаар давхиж гарлаа. Тэр нэг алхахад хэдэн мянган бээрийг туулах увидастай морь юм. Жабрайл (алейхисальлам) зарим газар зогсож Мухаммед элчийг (салаллаху алейхи уа сальлам) намаз (мөргөл) үйлдэхийг хүсэж байв. Ийм байдалтай гурван удаа унаанаасаа бууж мөргөл үйлдэв. Энэ гурван газарыг ямар газар болохыг Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) Жабрайлаас (алейхисальлам) асуухад тэрээр: «Анхны зогссон газар бол Медина хот, тэнд нүүж ирж амьдралынхаа төгсгөл хүртэл амьдарна» гэж мэдэгдэв. «Хоёр дахь газар бол гэгээн Муса элчийн Аллах эзэнтэй ярилцсан Тура и Сина уул юм. Харин сүүлчийн зогссон газар бол Иса (алейхисальлам) элчийн төрсөн Бейтү-ү Лахм юм гэж хариулав. Тэд цааш явсаар Куддус хот дахь ариун месжид Аксаад иржээ.

Месжид Акса хэмээх энэ ариун сүмд ирээд Жабрайл (алейхисальлам) нэг ханыг нь хуруугаараа цоолоод Буракийг тэндээс уялаа. Өнгөрсөн үеийн элчүүдийн сүнс хүн төрхөнд ороод намаз (мөргөл) үйлдэхийн тулд тэнд цугалсан байлаа. Тэнд Адам, Нух , Ибрахим пайгамбарууда (алейхумусальлам) имам (урьдатгал хамба) болооч хэмээн гуйхад тэд уучлал гуйгаад хүлээн зөвшөөрсөнгүй. Жабрайл (алейхисальлам) “Чамайг энд байхад хэн нэгэн имам болохгүй” гээд Мухаммед элчийг (салаллаху алейхи уа сальлам) урагшаа хөтлөн гарав.

Расулуллах (салаллаху алейхи уа сальлам) тэнд байх элчүүдэд имам болон 2 үе намаз (мөргөл) үйлдэв. Энэнээс хойш болсон үйл явдалыг ийн өгүүлжээ: “Жабрайл (алейхисальлам) надад нэг хундага диваажингийн ундаа бас хундаг цагаан сүү өргөв. Би сүүтэй хундагийг нь сонгон авахад “Фитратийг сонголоо” (хоёр ертөнцийн хайр ивээлийг сонголоо) гэв. Дараа нь хоёр хундаг өргөв. Нэгэнд ус нөгөөд нь зөгийн бал байлаа. Би энэ хоёрийн хоёулангаас нь уулаа. Жабрайл (алейхисальлам) “Бал бол чамайг дагагсад хойд ертөнц хүртэл тасралтгүй үргэлжилэхийн бэлэг тэмдэг, харин ус бол тэдний нүгэлийг угаахын бэлэг тэмдэг мөн” гэв. Үүний дараа Жабрайл (алейхисальлам) бид хоёр хамтаар тэнгэр өөд нислээ. Жабрайл хаалгыг тогшиход дотроос “Чи хэн бэ” гэх нь дуулдав. “Би Жабрайл байна” гэв. “Тэгвэл хажууд чинь байгаа хүн бэ?” гэж асуув. “Энэ хүн бол Мухаммед” гэж хариулав. “Түүнд зөвшөөрөл (тэнгэр өөд дээшлэх урилаа) өгөгдсөн үү?” гэв. “Тийм ээ, өгөгдсөн” гэв. “Сайн явж ирэв үү, зочин минь энэ ямар сайхан хүн бэ?” хэмээхэд хаалга

онгойв. Тэнд Адам (алейхисальлам) байхийг нь харлаа. Тэр надад “Амрыг тань эрье” гээд миний төлөө залбирав.

Энэ газарт би тоо тоомшгүй олон сахиусан тэнгэрүүд буйг харлаа. Тэд цөмөөрөө босоо байдалтайгаар залбирч байх юм. Хэлэх үг нь «Суббуухун куддүүсүн раббүна вэ раббүл малаа икати вэр-рух» гэгцгээж байх юм. Би Жабрайлаас (алейхисальлам) энэ сахиусан тэнгэрүүдийн мөргөл залбирал ийм юм уу? гэхэд тэрээр “Тийм ээ, эд нар анх туурвигдсан цагаасаа л эхлэн энэ байдалтайгаар мөргөл хийж байгаа, энэ нь хойд ертөнцийн эхлэл хүртэл үргэлжлэх болно. Чи Аллах эзэндээ энэ залбирлийг хойч дагалдагсаддаа өгөөч гэж залбир гэв. Би ч ёсчлон залбирсан болохоор бидний мөргөлд байдаг Кыям (босоо байдал) энэ билээ.

Тэнд хэсэг бүлэг хүмүүстэй таарлаа. Мелекүүд тэдний толгойг нь чулуугаар няц цохисон ч ахин урьдийн байдалдаа эргэн орох юм. Тэд ахиад л зодож толгойг нь няц цохиход хуучин байраа ахин олж байлаа ийнхүү зогсолтгүй үргэлжлэхийг нь хараад “Эд нар хэн юм бэ?” гэж асуухад жума (баасан гаригийн их мөргөл) олон нийтээр унших намазыг үл тоомсорлогчид ба рүкү (тонгойх) ба сажде (газар мөргөх) гүйцэт хийгээгүй хүмүүс” гэж хариуллаа.

Нэг хэсэг бүлэг хүмүүсийг харлаа. Тэд өлсгөлөн бас хувцасгүй шалдан нүцгэн байлаа. Зебани хэмээх тамын ажилчид сахиусан тэнгэрүүд тэднийг галд хаяхын тулд газар чирч яваа харагдав. “Энэ хүмүүс юу хүмүүс вэ?” гэж асуухад минь “Эд нар ядуусыг өрөвдөж хайрлаагүй, бас өргөл барьц бариагүй хүмүүс” гэв. Бас нэг хэсэг хүмүүсийг харлаа өмнө нь маш гоё амттай хоол унд тавьсан байв. Харин хажууд нь үхсэн малын өмхийрсэн сэгийг тавьжээ. Тэд өмнө нь байгаа хоолноос идэхгүйгээр малын сэгийг идэж байх юм. “Энэ хүмүүс хэн вэ? “ гэж асуухад “Эд нар шударгаар хоолоо олж идэхээс холдож шударга бусаар хоол ологсод гэв.

Өөрөө өөрийнхөө гарыг зулгаан идэж байх хүмүүстэй таарлаа. “Эд нар хэн юм бэ?” гэж асуухад “Эд нар хүнийг гүтгэсэн хүмүүс” гэв.

Хав хар царайтай, хөх нүдтэй дээд уруул нь сунан унжсан харин доод нь уруул нь сунахдаа хөлнийх нь ул хүртэл сунсан байлаа. Амнаас нь цус нөж ба идээ бээр гоожиж байх хэсэг хүмүүсийг харлаа. Тэдэнд улаан дөлөөр улайссан төмөр аяганд

идээ бээрээр ундаалж байх юм. “Энэ хүмүүс хэн бэ?” гэж асуухад “Эд нар архи дарс уугсад гэж хариулав.

Бас нэгэн хүмүүстэй таарлаа. Тэдний гэдэс нь хөөж, өнгө нь хөхрөн хөл гар нь хүлэгдсэн хэсэг хүмүүс байлаа. Жабрайл (алейхисальлам) эд нар бол мөнгө хүүлэгчид гэв⁸⁶.

Бас нэг хэсэг эмэгтэйчүүдтэй таарлаа. Тэдний царай нь хар, нүд нь ногоон өнгөтэй байлаа. Тэдэнд галын улаан дөлтөй хувцас өмсгөн тамын гэсгээлийн сахиусан тэнгэрүүд улаан галын дөлтөй төмөр ташуураар хайр найргүй ташуурдаж байлаа. Тэдний орилох нь яг л гахай ба нохой адил дуугарна. Жабрайл (алейхисальлам) “Эд нар завхай явдалт, бас нөхрөө гомдоосон эмэгтэйчүүд” гэв.

Бас нэг хэсэг бүлэг хүмүүс тамын тогоонд байлаа. Тэд галд шатаж байх юм. Тэд шатангууд ахиад л урьдийн хэвэндээ орно. “Эд нар бол эцэг эхээ гомдоогсод гэлээ.

Ингээд дараа нь 2 дахь давхар тэнгэрт гарлаа. Жабрайл (алейхиссальлам) хаалгыг тогшиход дотроос “Чи хэн бэ” гэх нь дуулдав. “Би Жабрайл байна” гэв. “Тэгвэл хажууд чинь байгаа хүн бэ?” гэж асуув. “Энэ хүн бол Мухаммед” гэж хариулав. “Түүнд зөвшөөрөл (тэнгэр өөд дээшлэх урилга) өгөгдсөн үү?” гэв. “Тийм ээ, өгөгдсөн” гэв. Хаалга онгойлгон, «Та сайн явж ирэв үү? Тавтай морил. Энэ хүн ямар сайхан хүн бэ?» гэх нь дуулдав. Тэнд Закерия (алейхиссальлам) байлаа. Тэр миний төлөө залбирч байлаа.

Тэнд сахиусан тэнгэрүүд эгнэн зогсоцгоожээ. Тэд цөм рүкү (тонгойн зогсох) байдалтайгаар мөргөл залбирал үйлдэж байгаа нь харагдав. Тэд огт нуруугаа цэхлэж, толгойгоо өндийлгөхгүй өөрийн гэсэн нэгэн төрлийн залбирал уншиж байх юм. Жабрайл (алейхиссальлам) “Энэ сахиусан тэнгэрүүдийн мөргөл нь ийм юм. Аллах эзэндээ дагалдагчидийнхаа мөргөл ийм болог хэмээн залбир” гэв. Би ч залбирч бидний мөргөлд рүкү (тонгойх) нь энэ билээ.

Дараа нь 3 дахь давхар тэнгэрт гарлаа урьдийн адилаар асуулт ба хариулт болсоны дараагаар хаалга онгойж тэнд Юсуф алейхиссальламтай тааралдав. Тэр надтай мэндлэн миний төлөө Аллахд залбирав.

Тэнд бас маш олон тооны сахиусан тэнгэрүүдийг харлаа. Тэд цөм газар мөргөн залбирч байлаа. Жабрайл (алейхиссальлам)

86 Сүхейл , эр-Равзүл-Үнф.с.II,208.

“Эд нарын мөргөл ийм юм. Чи өөрийн дагалсаддаа ийм мөргөл энэ залбиралаас хайрлаач хэмээн Аллахаас гуй” хэмээв. Би Аллахаас хүсч, намаз (мөргөл) дэх сажде (газар мөргөх) нь энэ билээ.

4 дэх давхар тэнгэрт гарлаа. Мөнгөн хүрээтэй гэрэл цацарсан туяанаас бүтсэн. Нэгэн том хаалга харагдав. Тэр хаалганы гэрэлт цоожин дээр “Лаа илаха иллаллахү, Мухаммедүн расуллахи” гэж бичигдсэн байв. Өнөөх асуулт хариулт болсоны дараагаар хаалга онгойлгон надтай мэндэлсэн хүн бол Идрис пайгамбар (aleyхисальлам) байв. Тэр миний төлөө Аллахд залбирлаа. Аллах эзэн Идрисийн (aleyхисальлам) талаар “Бид тэрнийг өндөрлөг нэгэн газар өргөсөн билээ.” хэмээжээ⁸⁷.

Дараа нь 5 дах давхар тэнгэрт гарлаа. Тэнд Харун (aleyхисальлам) пайгамбартай уулзаж мэндлэв.

Энэ тэнгэрт сахиусан тэнгэрүүд босоо байдалтай цөм хөлнийхөө өлмий рүү харан зогсож мөргөн залбирч байх юм. Жабрайл (aleyхисальлам) “Энэ сахиусан тэнгэрүүдийн залбирал нь ийм билээ. Энэ залбиралийг дагалдагсаддаа өгөөч гэж Аллах эзэнд залбир” гэв. Аллах миний хүсэлтийг хүлээн авч намазд (мөргөл) энэ залбирлийг өгсөн юм.

Дараа нь 6-р давхар тэнгэрт гарлаа. Тэнд Муса (aleyхисальлам) элчтэй уулзаж мэнд мэдэлцэв. Дараа нь 7-р давхар тэнгэр өөд гарлаа. Нөгөө л асуулт хариулт болсоны дараагаар Ибрахим (aleyхисальлам) элч тэнд байхыг харав. Тэрээр Вейт-ү Мамур гэх ариун газрыг түшин сууж байлаа. Вейт-ү Мамур бол сахиусан тэнгэрүүдийн залбирдаг газар юм. Тэнд өдөртөө 70 мянган сахиусан тэнгэрүүд ирж мөргөл үйлддэг бөгөөд тэнд дахиж хэзээ ч ирэх ээлж олддоггүй байна. Би Ибрахим алейхисальламын мэндийг асуулаа. Тэр миний мэндийг аваад “Сайн явж байна уу? Дээдийн элч, дээдийн хүү минь” гэв. Ибрахим (aleyхисальлам) “Аяа, Мухаммед, диваажин бол маш өргөн уудам газар нутаг билээ. Өөрийн дагалдагсаддаа тэнд маш их хэмжээний мод тарь гэж хэл” гэв. Би диваажинд хэрхэн мод тарих билээ? гэж асуухад “Лаа хавле вэ лаа куввата илла биллах” гэх энэ залбиралийг уншаад тарь” гэв.

Жабрайл (aleyхисальлам) намайг Сидретүл Мүнтахa гэх газар хүртэл дагуулж ирээд “Би энэ газраас цааш явж үл чадна. Хэрвээ нэг алхвал далавч минь шатах болно. Та эндээс цааш

өөрөө яв” гэхэд тэрээр айсандаа чичирч эхлэв⁸⁸.

Хорвоогийн энэрэлийн элчийг Жабрайл (алейхисальлам) энэ хүртэл авч иржээ. Жабрайл (алейхисальлам) анх туурвигдсан шигээ Мухаммед элчид (салаллаху алейхи уа сальлам) өөрийн 600 далавчаа дэлгэн үзүүлжээ. Далавч дэлгэгдэх бүрд шүр сувд маргад эрдэнэс ба туяа цацарч байлаа. Нарнаас хурц гэрэлтсэн Рефреф гэх ногоон өнгөтэй диваажингийн бяцхан хивс нисэн ирэв. Тэр хивс зогсолтгүйгээр Аллах эзэнийг магтан дуулж залбирч байх юм.

Мухаммед элчид (салаллаху алейхи уа сальлам) мэндэлсэнийхээ дараагаар түүний өмнө зогсов. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) Рефреф дээр суугаад маш хурдтайгаар дээш өргөгдөж эхлэв. Хижаап гэх 70 мянган хөшгийг гэтлэн өнгөрч байлаа. Бүх Хижаабууд хоорондоо маш хол зайтай байв. Рефреф Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) хамтаар тэр хөшгүүдийг туулсанахаа дараа Курси, Арш ба Рух гэх ертөнцөөр дайрч өнгөрөв.

Хайрт пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) хөшиг болгоныг өнгөрөх үед “Бүү ай, аяа, Мухаммед! Ойрт! Ойрт!” гэх нэгэн дууг сонсож байлаа. Тэр маш ойртсон агаад Кабе-кавсейн гэх газар хүрсэн байлаа. Хэн ч үл мэдэм, үл ойлгом, үл ойлгуулам тийм ойрхон тэр Аллахын хүссэн тэр газар хүртэл ойртон очсон бөгөөд ямарч хугацаагүй ямарч орон зайгүй, ямарч биегүй бас ямарч зүг чиггүйгээр өөрийн мэлмийгээрээ Аллах Теалааг харжээ. Тэнд хэзээ ч хэнд ч өгөгдөж байгаагүй буян хишиг зол баяр тохиожээ.

Аллах эзэн Мухаммед элчээс (салаллаху алейхи уа сальлам) “Аяа, хайрт элч минь, чи юу хүсэж байна вэ? Надаас асуу, гуй” гэхэд нь Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) “Аяа, эзэн минь, би дагалсадынхаа аз жаргалыг хүснэм” гэв.

Аллах эзэний найлдав: «Аяа, Мухаммед! Мэлмийгээнээгээд хөлнийхөө доор хар” гэв. Намайг доош харахад миний хөлний доор хэсэг шороо харагдав. Аллах “Чи энэ шороог дэлхийгээс хайрт эзэнийхээ өмнө чирч ирлээ гэж үү? Энэ бол чиний гуталанд наалдсан шороо. Миний хувьд чиний дагалдагсадыг уучлах нь энэ шороог уучлахаас ч хялбар” хэмээсэн юм.

Гэгээн элч (салаллаху алейхи уа сальлам) нэгэн сургаал үгэндээ: “Би гэгээн эзэнээс маш олон асуултыг асууж

88 Ахмед бин Ханбел, эл-Мүснэд III, 164, IV, 128; Бейхако ес-Сүнэн I, 265;

Кади Уюуз, Шифа-и Шериф, с, 179.

хариултыг нь ч авч байлаа. Зарим асуултыг асуусандаа ичиж билээ. (энэ асуултуудын нэг нь) “Аяа, Аллах минь! Чи Жабрайл (алейхиссальлам) сахиусан тэнгэрт 600 далавч хайрлажээ. Энэн шиг надад юуг ивээсэн бэ?” гэж асуухад Аллах Теала: “Чиний биений ганц ширхэг үс миний хувьд Жабрайлийн 600 далавчнаас хүндтэй билээ. Би чиний нэг ширхэг үснээс болж хэдэн мянган нүгэлт боолуудыг өршөөж энэрэх юм. Аяа, Мухаммед, Жабрайл (алейхиссальлам) нэг далавчаа дэлгэхэд наран мандах зүгээс жаргах зүгийг цөмийг нь бүрхэж чадах юм. Хэрвээ чи хүсвэл наран мандахаас наран жаргах газарт буй бүхий л нүгэлт хүмүүсийг өршөөж чадах бус уу?” гэв. Би: “Аяа, Аллах эзэн минь, Нухт (алейхиссальлам) усан онгоц өгсөн. Энэ шиг надад юу өгөөв?” гэж асуухад: Аллах: “Би чамд Буракийг өглөө, нүд ирмэхийн зуур маш хол замыг туулж миний хажууд ирээгүй гэж үү? Чамд диваажин бас тамыг үзүүллээ. Чиний дагалдагсадад Месжид (сүм) өглөө. Тэд шүүлтийн өдөр ирэхийн цагт хөлөг онгоцонд суух адилаар Месжидэд (сүм) ороход Сират гүүрийг нүд ирмэхийн зуур туулж диваажинд залрах бус уу?” гэв.” хэмээв.

Хорвоогийн энэрэл болсон элч (салаллаху алейхи уа сальлам) Исафил (алейхиссальлам) сахиусан тэнгэртэй хамтаар Жабрайлийн (алейхиссальлам) хажууд ирэв. Жабрайл (алейхиссальлам) Аллах эзэний зарлигласанаар Мухаммедийг (салаллаху алейхи уа сальлам) диваажинд авч одов. Тэнд сахиусан тэнгэрүүд гартаа диваажингийн ундаа ба гэрэл туяа цацруулан тавгаар дүүрэн амттан барин хүлээж байв. “Аяа, Аллахын элч минь! Эд нар Адамаас (алейхиссальлам) (анхний хүн) 80 мянган жилийн өмнө туурвигдсан ба энэ газар энэ хоол ундыг чамд бас чиний дагалдагсадад өгөхийн тулд яаран хүлээж байгаа билээ. Хойд ертөнцөд чи ба чиний дагалдагсад диваажингийн босгоор алхах тэр мөчид эд нар гүйн ирээд та бүхнийг дайлах болно. Диваажингийн сахиусан тэнгэр болох Ридван тэднийг тосон авч баярт мэдээг сонордуулав. “Аллах эзэн хоёрыг нь чиний дагалдагсадад, үлдсэн нэгийг нь бусад элчүүдийн дагалдагсадад бэлэглэхээр диваажинг 3 хэсэг болгосон билээ” гэв. Ийнхүү намайг диваажингаар аялуулав.

Мухаммед элч ийн айлдахдаа: “Надад 8 диваажинг үзүүллээ. Бүгд нэг нэгнээсээ өөр өөр баялаг жаргалаар дүүрэн ажээ. Би тамын ангилалыг ч үзэхийг хүссэн болохоор Жабрайл (алейхиссальлам) намайг хөтлөн тамын хамгийн том сахиусан

тэнгэр болох Маликд намайг авч явав. “Хөөе, Малик! Гэгээн Мухаммедэд (салаллаху алейхи уа сальлам) түүний дайсануудын тамлагдах тамыг харуул” гэв. Малик намайг дагуулан Тамын давхарга бүрийг сонирхуулав. Тамд 7 давхар байдаг ба хамгийн доод тал болох 7-давхарт нь бусад тамуудын тамлалаас илүү ширүүн илүү хүнд аж. “Энэ давхарт ямар хүмүүс тамлагдах вэ?” гэхэд Малик: “Энд Фарон ба Карун бас чиний дагалдагсадаас Мунафик (хоёр нүүртэй) хүмүүс тамлагдах болно. Тамын 6-давхарыг Лади гэх ба тэнд мүшрикүүд (огт шашингүйчүүд) тамлагдах болно. Тамын 5- давхарыг Хутаме гэх бөгөөд гал, үхэрт мөргөн залбирагсад ба Буддын шашинтангууд тамлагдах юм. 4-давхарыг Жаким гэх ба тэнд нар ба од эрхэст мөргөгсөд, зурхайчид тамлагдах юм. 3-давхарыг Сакер гэх ба тэнд христийн шашинтангууд тамлагдах юм. Тамын 2-давхарыг Сайр гэх бөгөөд тэнд жүүдүүд тамлагдах юм. Тамын 1-давхарыг Жахеннем гэх ба энэ тамын тамлал нь бусад тамуудынхаас арай хөнгөн билээ. Энд 70 мянган галан гол урсдаг юм. Энэ гол маш том бөгөөд хэрэв тэрэн лүү дэлхий ертөнцийг хийх юм бол тэгээд тэрнийг сахиусан тэнгэрүүдэд ол гэж тушаавал тэр 1000 жил хайгаад ч олж үл чадах тийм том гол юм. Зебаничүүд (тамын ажилчин сахиусан тэнгэрүүд) тэд маш том биетэй бөгөөд хэрвээ тэд дэлхийг амандаа хийх юм бол үл мэдэгдэм нүсэр том ажээ. Тэр галаар урсах гол цалгилан давалгаалах нь юутай аймшигтай вэ? Тэр давалгааны нүргэлэх дуу хорвоо ертөнцөд сонсогдох юм бол, бүхий л амьд амьтад тэр дорхноо үхэцгээх байсан. “Энэ тамд ямар хүмүүс орох юм бэ?” гэж асуухад Малик (алейхиссальлам) хариулсангүй. Би асуултаа давтан хэлэхэд мөн л адилаар дуугүй зогсоно.

Жабрайл (алейхиссальлам) Маликд “Чамаас хариулт хүлээж байна” гэхэд тэр «Намайг уучилаарай» гэв. Би: “Юу ч байсан хамаагүй хариул, Аллах чамайг өршөөх болно” гэлээ. Малик “Аяа, Расуллах! Энэ там бол чамайг дагалдагч мусульманчуудаас нүгэлт хүмүүс нь орох газар. Тэдэнд сургаалаа айлд, тэд энэ тамд унахгүйн тулд мэрийцгээг, өөрдийгөө энд тамлуулахаас хамгаалцгааг, тамлах тэр мөч ирэхийн цагт би огт өршөөл энэрэл үзүүлэхгүй, хөгшин ч бай залуу ч бай тамлагдах болно” гэв.

Энэ үгийг дуулаад энэрэнгүй элч (салаллаху алейхи уа сальлам) уйлж эхлэв. Гэгээн тэргүүнээсээ Сариг буюу

алчуураа тайлан Аллах эзэндээ залбирч эхэллээ. Өөрийн дагалдагсадынхаа дутагдлыг хэлэн Аллах эзэнээс өршөөл гуйн уйлхад Жабрайл (алейхиссальлам) ба хажууд нь байсан бүх сахиусан тэнгэрүүд даган уйлав. Аллах эзэн ийн айлдав. “Хөөе, хайрт элч минь! Чиний энэ үнэ цэн ба нэр хүнд надад маш их эрхэм билээ. Залбиралыг чинь хүлээн авлаа. Баярлан тайвшир, чиний залбиралыг биелүүллээ, чамд хүссэн өөрийн нүгэлт дагалсаддаа энэрэл өршөөл үзүүлэх эрхийг өглөө. Аяа, хайрт элч минь! Хэн ч байсан ялгаагүй миний зарлигийг биелүүлж амьдрах юм бол хойд ертөнцөд миний энэрэл ивээлийг хүртэж диваажинд залрах болно. Тэнд намайг харах хувь тохиох юм. Чамд бас чиний дагалдагсадад нэг өдөрт 50 удаа мөргөл үйлдэхийг зарлиг болгож байна.” гэв.

Пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) үгээ үргэлжлүүлж: «Дараа нь Аршт хүрлээ. Самеуатаас өнгөрсч Мусагын (алейхиссальлам) зогсоолд очлоо. Надад «Аллах чамд болон дагалдагсадад чинь юуг даалгалаа?» гэж асуув. Би «Өдөр шөнөгүй 50 удаа намаз мөргөл үйлдэхийг зарлиглав» гэв. «Аллах Теалад очоод жаахан хөнгөлүүлэхийг гуй, ягаад гэвэл дагалдагсад чинь үүнийг гүйцэтгэж чадахгүй» гэв... Эцэст Аллах эзэн: «Энэ намаз мөргөлийг 5 удаад булгалаа. Намаз болгонд 10 буян бичигдэнэ. Тийм учраас 50 удаагийн мөргөлтэй тээнцэнэ..» гэв. Муса элчид байдлыг хэллээ. «Очоод дахиж хөнгөрүүлэхийг гуй» гэж хэллээ. Би түүнд «Аллахаас их юум гуйсан болхоор ичиж байна» гэж хэллээ⁸⁹.

Ийнхүү Аллах эзэн хайрт элчийнхээ зовлонг нимгэлж баярлуулах гэж нэгэн шөнө, өөр ямар ч хүнд тохиогоогүй хувь төөргөөр хэн ч үл ойлгом үл ханаж чадах аз жаргалын орноор аялуулсан нь Мухаммедийг (салаллаху алейхи уа сальлам) гэх түүний хайр энэрэл байлаа.

Ингээд хорвоо ертөнцийн энэрэл болсон элч (салаллаху алейхи уа сальлам) маш богино хугацаанд Куддус хотод тэндээсээ Мекке хот руу очиж тэндээсээ Үммү Ханигийн гэрт иржээ. Түүнийг ирэхэд хэвтэж байсан ор нь бүлээхэн байсан төдийгүй угаалга үйлдсэн усны долгио нь арилаагүй байлаа. Гадаа харуулдан байсан Үммү Хани жаал зүүрмэглэсэн бөгөөд энэ явдалыг огтхон ч мэдсэнгүй. Тэрээр Куддус хотоос Меккед ирэх замдаа тэмээн жингийн цуваатай тааралджээ. Жингийн нэг

89 Ахмед бин Ханбел, эл-Мүснэд III,164,IV,208;Бейхако ес-Сүнэн I,265:
Кади Уюуз,Шифа-и Шериф,с,179.

тэмээ үргэн унажээ. Өглөө босонгууд Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) ариун Каабд очоод Мигражын талаар (нүд ирмэх зуурд Меккегээс Кудуст, Кудусаас долоон давхар тэнгэр огторгуйгаас өнгөрөн, бидэнд үл мэдэгдэх өндөрлөгт очиж ирсэн явдал) хүмүүст хэлэв. Кафирууд (буруу номтон): “Мухаммед солиорч” гэгцгээн доромжилон инээлдэж эхлэв. Мусульман болохыг бодож явсан хүмүүс ч энэ үгийг сонсоод эргэлзэж эхлэв. Мүшрикүүдээс зарим нь энэ явдалд баярлан Эбү Бакийн гэр лүүгээ гүйцгээв. Учир нь тэрнийг ухаантай, олоныг мэдэх наймаачин нэгэн болохыг маш сайн мэддэг байлаа: “Хөөе, Эбү Бакир! Маш олон удаа Кудус хот руу очиж байсан. Мекке хотоос Кудус хот руу очоод ирэхэд хэдэн хоног явах хэрэгтэй вэ?” гэж асуув. Гэгээн Эбү Бакир (радиаллаху анх): “Би сайн мэдэж байна, хамгийн багаар бодоход нэг сар явна” гэв.

Энэ үгийг сонсож баярласан кафирууд “Ухаантай хүмүүс ийм л байх ёстой” гэгцгээн Эбү Бакийг ч мөн адил өөрсдийн адил бодох байх гэж бодоод “Чиний найз болох Мухаммед өнөө шөнө Кудус хот руу яваад ирлээ гэж байх юм. Тэр лав солиорсоноос зайлшгүй” гээд гэгээн Эбү Бакийг (радиаллаху анх) бас л инээх байхаа хэмээн найдаж хүлээв.

Гэгээн Эбү Бакир Аллахын элчийн (салаллаху алейхи уа сальлам) нэрийг сонсонгуудаа “Хэрвээ тэр хэлсэн бол үнэн, түүнийг нүд ирмэх зуур очоод ирсэнд би итгэж байна” гэж хэлээд Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) зүг гүйн одов. Кафирууд гайхан “Юу болох нь энэ вэ? Мухаммед ямар их ид шидтэй хүн бэ? Эбү Бакийг илбэдэчихжээ” гэгцгээн гэртээ харьцаав.

Гэгээн Эбү Бакир (радиаллаху анх) гүйсээр Аллахын элчийн хажууд ирээд “Аяа Аллахын элч минь! Диваажин рүү сайн явж ирэв үү? Бидэнд чам шиг агуу элчид туслах ажилыг олгосон, чиний ариун царайг харж, гэгээн сургаалыг чинь сонсон, чамтай хамт нэгэн хотод амьдрах хэмжээлшгүй их хувь заяаг хайралсан Аллах эзэндээ баярлалаа. Аяа, Аллахын элч минь! Чиний бүх үг чинь үнэн билээ. Би итгэж байна” гэв. Гэгээн Эбү Бакийн энэ үг кафируудыг гайхшируулав. Тэдэнд хэлэх үг үл олдсон болохоор тэндээсээ таран одоцгоов. Энэ үгэнд эргэлзэн тээнгэлзэж эхэлсэн хэсэг хүмүүсийн эргэлзээг арилган зориг ухаан хайрлав.

Аллахын элч (салаллаху алейхи уа сальлам) тэр өдөр Эбү

Бакирт “Сиддик” гэх нэрийг хайрлажээ. Энэ нь үнэн ч шударга гэсэн утгатай юм. Эбү Бакир энэ нэрийг авсанаас түүний зиндаа дээшилж хэмжээлшгүй их буян хураажээ⁹⁰.

Хижретээс (их нүүдэл) 1 жилийн өмнө Режеб сарын 27 ны баасан гаригийн орой болсон энэ явдалыг Миграж гэдэг юм. Аллахын элч Мигражд бие сүнсээрээ бас нойрон дундаасаа биш сэрүүн байхдаа аялаад иржээ. Энэ явдал түүнд маш олон үнэн зүйлсийг харуулсан бөгөөд өдөрт 5 удаа намаз (мөргөл) үйлдэхийг зарлиглажээ. Бас Бакара сүрегийн (бүлэг) сүүлийн 2 аетийг түүнд өгчээ. Миграж Куран сударт Исра ба Нежим сүренүүдэд бас зарим хадис шерифт (Мухаммедын сургаал) өгүүлэгджээ⁹¹.

Миграж шөнө өнгөрсөний дараа маргааш өглөө нь Жабрайл (алейхисальлам) сахиусан тэнгэр Мухаммедд (салаллаху алейхи уа сальлам) ирж 5 удаагийн мөргөлийн цаг хугацааг түүний өмнө имам (урд нь зогсох хамба) болон зааж өгчээ. Элч нэг сургаалдаа ийн айлджээ:

“Жабрайл (алейхисальлам) Каабын хаалганы өмнө надад хоёр хоног имам болон мөргөл үйлдсэн. Бид хоёр үүр цайхаас өмнө өглөөний мөргөлийг, нар оройгоос өнгөрөх үед үдийн мөргөлийг, бүх зүйлийн сүүдэр өөрийнхөө биеийн урттай адил болохуйд оройн мөргөлийг, нар жаргах үед (нарны туяа арилан харанхуй болох хүртэл) үдшийн мөргөлийг, гэгээ тасархад шөнийн мөргөлийг үйлдсэн юм. Маргааш өдөр нь өглөөний мөргөлийг эргэн тойрон харагдаж эхлэх үед, үдийн мөргөлийг бүх зүйлийн сүүдэр өөрөөс нь 2 дахин урт болоход, оройн мөргөлийг үүний дараа даруйхан, үдшийн мөргөлийг нар жаргаснаас хэсэг хугацааны дараа, шөнийн мөргөлийг шөнийн гуравны нэг болоход үйдсэн юм. Дараа нь “Аяа, Мухаммед! Чиний бас чамаас өмнөх элчүүдийн мөргөлийн цаг энэ билээ. Дагалдагсаддаа энэ 5 удаагийн намазыг (мөргөл) бидний үйлдсэн энэ хугацааны хооронд үйлд гэж хэл” гэсэн юм⁹².

Мөргөлийн цагийг ийнхүү мэдэгдсэний дараа Хабешстан руу мэдээ явуулан, 5 удаа мөргөл үйлдэхийг бас эхлэх өдөр хүртэл үйлдээгүй мөргөлүүдээ нөхөн үйлдэхийг тэдэнд мэдэгджээ.

90 ⁹⁰Ибн Сагд, эт-Табакет I, 144.

91 ⁹¹Ибн Сагд, эт-Табакет I, 215.

92 ⁹²Бухара “Менкибүл-Энсар”42.;Тирмизи “Тефсиру-Куран”,20: : Ибн Хишам Эс-Соре I ,403: Бейхако ес-Сүнен I,255: Сүхейл , эр-Равзүл-Үнф.с.II, 208.

ХИЖРЭТ

Хайрт пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) жил бүр Меккед ирсэн аянчидийг ислам шашиндаа уриалж тамын галаас аврахыг хичээдэг байлаа. Ирсэн аянчидийн буудаллах газар нь хүлээгээд тэдэнд “Аллах эзэний илгээсэн элчийн үүргийг гүйцэлдүүлэх хүртэл намайг хамгаалж надад туслах хэн байна вэ? (Ийнхүү) диваажинд залраг” гэдэг байв. Харамсалтай нь хамгаалах бас туслах хүн олдсонгүй.

Элч болсоны 11 дэх жилд Мекке хотод нэгэн том үзэсгэлэн худалдаа болов. Медине хотоос ирсэн хэсэг хүмүүс Мухаммед элчтэй (салаллаху алейхи уа сальлам) тааралдав. Тэдэнд «Та нар хэн бэ?» гэж асуухад Медине хотоос ирсэн Хазреж овгийн хүмүүс болохоо хэлэв. Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) өвөө Абдулмутталибийн ээж Селма эзэгтэй Хазреж овгийн Нежраны хөвгүүд отогийн хүн байв. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) энэ Хазреж овгийн хүмүүстэй хэсэг суугаад Куран судараас Ибрахим сүрегийн 35-52-аетуудыг уншин өгөн ислам шашинийг тэдэнд номлон айлдав. Эд нар Медине хотод амьдрах жүүд хүмүүсээс ойрын хугацаанд нэгэн элч ирнэ гэснийг дуулсан байв. Тэд нар өөр хоорондоо “Жүүдүүдийн мэдэгдсэн элч бол энэ хүн мөн байна” хэмээн ярилцгааж ислам шашинд орцгоов.

Тэд “Аяа, Аллахын элч минь, Мединед манай овог Жүүдүүдтэй байлдаж байгаа, бидний хоорондын харьцаа маш муу, бид гэртээ буцаж очоод чамайг бас чиний номлосон шашиныг тэдэнд заах болно. Аллахын авралаар тэд цөм мусульман болох юм бол бидний он жил үргэлжилсэн дайсагнал үгүй болж, найрамдах байхаа гэж найднам. Хэрвээ тэгэвээс та бидний хувьд хамгийн эрхэм хүн болох болно” гэгцгээв.

Энэ 6 хүн үнэн сэтгэлээсээ Аллах ба элчид итгэсэн билээ. Ингээд нутаг буцахаар Мухаммед элчээс (салаллаху алейхи уа сальлам) зөвшөөрөл аваад харьжээ. Энэ хүмүүсийн нэр алдар нь Укбе бин Амр, Эсад бин Зураре, Авф бин Харис, Рафи бин Малик, Кутбе бин Амр, Жабир бин Абдуллах (Аллах тэднийг хайр ивээлдээ аваг) нар юм⁹³.

93 Хаким,эл-Мүстедрак 4,648-649: Ибн Хишам Эс-Соре I,403-404: Ибн Сагд, эт-Табакет I, 216-215.

Анхны Акабе гэрээ хэлэлцээр ба Мединед мандсан нар

Мусульман болсон 6 хүн эх нутагтаа очсон даруйдаа ислам шашиныг Мухаммед элчийн талаар (салаллаху алейхи уа сальлам) тайлбарлаж, тэднийг уриалан дуудаж эхлэв. Эд нар Медине хот дахь бүх айлаар орж ислам шашиныг, Мухаммед элчийг тайлбарлан ярьж явлаа.

Акабед болсон энэ уулзалтаас хойш нэг жилийн дараа Эсед Бин Зураре тэргүүтэй мусульман болсон 12 хүн Хажын (Меккед очиж Каабааг тойрон мөргөх) улиралд Мекке хотод ирцгээжээ. Тэр жил мүшрикүүд мусульманчуудыг урьд урьдийнхаас ч илүү улам ихээр хавчин дээрэлхэж байлаа. Мухаммед элчийг (салаллаху алейхи уа сальлам) үргэлж тандан тагнаж түүнтэй ярилцсан хүн бүрийг зодон зовоодог байв. Энэнийг мэдсэн Мединегийн мусульманчууд Мухаммед элчтэй Акабе зайдуу ууланд шөнө дөлөөр уулзахаар болцгоов. Энэ уулзалтанд тэд “Аллах эзэнийг өөр бурханаар солихгүйгээ, завхай зайдан явдал үйлдэхгүйгээ, хулгай хийхгүйгээ, худлаа хүн гүтгэхээс зугтаан зайлахаа, цээрлүүлсэн бас буян зайлан гэж айн хүүхдүүдээ алахгүй байхаар ам тангараг өргөцгөөлөө”⁹⁴. Хоёр нь Эвс овгийн, 10 нь Хазреж овгийн гэх мэт 12 хүнийн толгойлогч нь Эсад бин Зураре (радиаллаху анх) юм.

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) энэ 12 хүнийг өөрийн отог овгоо шашинд уриалах төлөөлөгчид болгожээ. Тэд овог хамаатан садандаа Мухаммед элчийг ойлгуулж, ислам шашиныг номлох үүрэг хүлээв. Эд нар бол Малик бин Нежжарын хөвгүүд овгоос: Эсад бин Зураре, Авф бин Харис, Муаз бин Харис, Зүрейк бин Амирийн хөвгүүд овгоос Рафи бин Малик, Зекван бин Абдикайс, Гани бин Авф хөвгүүд овгоос Убаде бин Самит, Гусайна хөвгүүд овгоос Иезид бин Салебе, Ажлан бин Зейд хөвгүүдээс Аббас бин Убаде, Харам бин Кааб хөвгүүд овгоос Укбе бин Амир, Севад бин Ганм хөвгүүд овгийнхоос Кутбе бин Амир ба Абдулешхел бин Гүшем хөвгүүд овгийнхоос Эбү Хейсем, Малик бин Тейихан, Амр бин Авф овгийнхоос Үвейм бин Сайде нар байв. Эд нарын толгойлогчоор нь Эсад бин Зурераг (радиаллаху анх) томилжээ.

Энэ хүмүүс Медине хотдоо буцаж очоод хамаатан садан

отог овгийнхоныгоо өдөр шөнөгүй ислам шашинд уриалж эхэлсэн бөгөөд ислам шашин Медине хотод маш хурдацтайгаар түгэж байв. Тэр бүү хэл урьд өмнө дайсан болон дайсагналцдаг байсан Эвс ба Хазреж гэх хоёр овог хоорондоо нэгдэн найрамдаж исламын шашинаа илүү сайн сурахын тулд Мухаммед элчээс (салаллаху алейхи уа сальлам) нэг багш явуулахыг хүсжээ. Пайгамбар маань тэдэнд Куран судар ба ислам шашинийг заах нэг хүн илгээсэн нь Мусаб бин Умейр (радиаллаху анх) байв.

Гэгээн Мусаб Эсадийн (радиаллаху анхум) гэрт байрлан өдөр бүр түүнийг даган айл айлаар даган ислам шашиныг түгээж байлаа.

Өдөр ирэх тусам Медине хотод исламын дуу хоолой чангаас чанга цуурайтаж Мусаб бин Умейрын унших Куран сударт айлдсан номлолыг чих тавин чагнах хүн олширч Мухаммед элчийг (салаллаху алейхи уа сальлам) өөрийн нүдээр харах хүсэл тэмүүлэлийн оч мусульман бологсодын зүрх сэтгэлд бадамлан асаж эхэлсэн байв. Эвс ба Хазреж овгийгхон цөм ислам шашиныг хүлээн зөвшөөрч мусульман болцгоосон байв. Сайд бин Муаз ба Үсейд бин Худайр нар өөрийн овгийн шүтдэг байсан шавар бурхадаа хага цохин хогонд хаяжээ. Энэ мэдээг дуулсан Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) маш их баярлажээ. Мекке хотынхон зөв замыг олсондоо маш баяртай байлаа⁹⁵. Энэ жилийг (621 он) Сенетүс сүрүр (баярт жил) хэмээн нэрлэжээ.

Хоёр дахь Акабе (гэрээ)

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) элчийн ажил үйлсээ эхлээд 13 жил болсон байлаа. Меккегийн мүшрикүүдийн хяналт хавчилд мусульманчуудыг байж суух газаргүй болтол шахаж байв. Харин Медине хот дахь мусульманчууд ирэх тусам шашинаа гүнзгий ойлгож энэ шашин ариун үйлсийнхээ төлөө юу ч хийхэд бэлэн болсон байв. Тэд Мухаммед элчийг Медине хотод урин авч ирүүлхийг хүсэж байв. Хажын улирал эхэлсэн байлаа. Медине хотын 73 эрэгтэй 2 эмэгтэй мусульман Мекке хотод мөргөхөөр иржээ. Хаж мөргөлөө үйлдсэний дараагаар цөм ахиад л Акабе ууланд гэгээн элчтэй уулзацгаав. Тэд элчийг Медине хотод нүүж ирэхийг санал болгоцгооно.

95

Ибн Хишам Эс-Сопе I,435: Сүхейл , эр-Равзүл-Үнф.с.II,258.

Мусульман болж амжаагүй байгаа Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) авга ах Аббас ч тэнд байлаа. Аббас гэрээ хийхээр ирсэн хүмүүст хандан:

“Хөөеб Медине хотынхон! Энэ хүн бол миний дүүгийн хүү билээ. Би бүх хүнээс илүүтэйгээр үүнийг хайралдаг билээ. Хэрвээ та нар түүнд итгэн Аллахаас авч ирсэн бүхнийг хүлээн зөвшөөрч бас түүнийг өөрсөдтэйгээ цуг нутаг руугаа авч явахыг хүсэж байвал надад амлалт өгөх хэрэгтэй. Бид Мухаммедыг (салаллаху алейхи уа сальлам) түүний дайсанууд ба ямар нэгэн аюулаас амь биеэ үл хайхран хамгаалж байгаа билээ. Тэрээр бидний дунд айх аюулгүй амар жимэр амьдарч байгаа. Гэтэл одоо тэр бүхнийг орхиод та нарыг даган танай нутагт очоод амьдрахыг шийдсэн байна. Та нар тэрнийг харж хамгаалан гэж амлалт өгч чадах уу?” гэв.

Эсад бин Зураре Мухаммед элчид (салаллаху алейхи уа сальлам) хандан: “Аяа, Расулуллах, хэрвээ та нар зөвшөөрвөл хэлэх үг байна, болох уу?” хэмээн зөвшөөрөл аваад үгээ үргэлжлүүлэн: “Таны авч ирсэн энэ шударга шашиныг бид цөм хүлээн зөвшөөрсөн билээ. Аллах эзэний хайр ивээлд багтан нэг бурхан, нэг элч, нэгэн сударын өмнө нэгдэн эв найрамдалтайгаар амьдарч эхэлсэн цаг саяханаас билээ. Энэ ариун шашинд юу л айлдагдан бид түүнийг чин зүрхээрээ хүлээн зөвшөөрч дагадаг. Бид өөрсдийн үр хүүхэдээ хэрхэн хамгаалдаг бас таныг сүүлчийн цусны дусал унах хүртэл хамгаалахаа амлаж байна” хэмээв.

Мухаммед элч: “Та нараас хүсэх зүйл бол Аллах эзэндээ мөргөн залбирахыг бас түүнээс өөр ямар ч юмыг бурхан мэт үзэж Аллахтай тэнцүүлээрэй. (Аллах бол хань, ижил бас адилтгах зүйлгүй цорын ганц бурхан юм).” гэв.

Бера бин Мамур “Чамайг үнэн ба шашин ба ариун Куран судартайгаар илгээсэн Аллах эзэндээ амлан тангаргалай, бид чамайг өөрийн амь насаараа хамгаалах болно. Аяа, пайгамбар минь бидэнтэй хэлэлцээр хий” гэв. Тэнд байх Медине хотын мусульманчууд цөм “Аяа, Аллах эзэн минь, гэрч бол! Бид Мухаммед элчийг хамгаалахын тулд эд хогшил минь алга болсон ч хамаатан саднууд маань үхэж үрэгдсэн ч энэ амлалтаасаа няцахгүй, үхэж болох ч буцах эрхгүйгээр амлая” гэгцгээв.

Тэгээд Мухаммед элчид (салаллаху алейхи уа сальлам) хандан: “Аяа, Расулуллах! хэрвээ бид энэ амлалтаа биелүүлвэл бидэнд юу ноогдох вэ?” гэж асуув. Хайрт Мухаммед элч маань

(салаллаху алейхи уа сальлам): “Аллах эзэний хайр ивээл бас диваажингийн хаалга та нарын төлөө нээгдэх болно” хэмээв. Дараагаар нь Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) тэнд байгсадаас “Аллах эзэнийг өөр ямар ч бурханаар солихгүй байх, гүтгэлэг бас завхай явдал хийхгүй байх, хүүхдүүдийг алахгүй, худлаа ярихгүй, үргэлж сайн сайхан зүйл хийж байх талаар тэднээс амлалт авчээ...

Ийнхүү Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) Мединегийн мусульманчуудтай хийсэн хоёр дахь гэрээ амжилттай болж тэр өглөө мусульманчууд нутаг буцацгаав⁹⁶.

Хижрет (их нүүдэл)

Сүүлчийн Акабе ба гэрээнээс хойш мусульманчуудад энх тунх амар амгалан шашинаа шүтэн амьдарч болох нэгэн газар олдсон байлаа. Энэ уулзалтийг дуулсан Меккегийн мүшрикүүд маш их айж сандарч эхэлжээ. Харин мусульманчуудын хувьд Мекке хотод амьдрах нь өргөст торонд орсон мэт хэцүү болсон байв. Нэгэн өдөр Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) маань баярлан асхабуудын хажууд ирэн: “Та нарын нүүн нутагших газарыг надад Аллах мэдэгдлээ. Тэр газар бол Ясриб (Медине) хот юм. Тийшээ нүүцгээ” бас “Тэнд мусульман ахан дүүстэйгээ нэгдэцгээ, Аллах эзэн тэд нарыг та нарын ахан дүүс болгосон билээ. Ясрибийг (Медине) та нарын хувьд амар амгалан бас баяр жаргалт нэгэн хот болголоо” хэмээв. Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) энэ үгийг сонсоод мусульманчууд хэсэг бүлгээрээ Медине хот руу нүүж эхлэв⁹⁷.

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) нүүгсэдэд маш болгоомжтой бас хянуур байхыг захиж байлаа. Мусульманчууд мүшрикүүдийн анхаарлыг татахгүйн тулд жижиг нэгэн нүүдэл болон шөнө дөлөөр замд гарцгааж байлаа.

Гэгээн Омар (радиаллаху анх) сэлэм жадаа барин ариун Каабыг 7 удаа тойрон мөргөснийхөө дараагаар чанга дуугаар мүшрикүүдэд хандан: “Харцгаа, би шашинаа хамгаалахын тулд Аллахын зарлигласанаар нүүж байна. Эхнэрээ бэлэвсэрч, хүүхдүүдээ өнчрүүлж, ээжээ уйлуулж үлдээхийг хүсэгсэд энэ хотгорт миний өмнөөс эсэргүүцэг...” гэв.

96 Ибн Хишам Эс-Сопе I,438: Ибн Сагд, эт-Табакет I, 221-223: Сүхейл, эр-Равзүл-Үнф.с.II,261.

97 Ибн Сагд, эт-Табакет I, 226.

Ийнхүү гэгээн Омарын (радиаллаху анх) хамтаар хориод мусульман Медине рүү нүүцгээв. Асхабууд ар араасаа нүүцгээн Мединед хүрч байлаа.

Нэг өдөр гэгээн Эбү Бакир нүүх зөвшөөрөл гуйв. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам): “Тэвч, Аллах эзэн надад зөвшөөрөл өгөх цагт хамтдаа нүүцгээе гэв” Гэгээн Эбү Бакир (радиаллаху анх): “Аллахд баярлалаа. Тантай хамт замд гарах шиг баяр баясгалан үгүй билээ” гэв.

Гэгээн Эбү Бакир 800 дархемээр (мөнгөн зоос) нэг тэмээ худалдаж аваад нүүхэд зэхэж эхлэв. Мекке хотод Мухаммед элч, Эбү Бакир гэгээн Али, хөгчүүл, ядуус, мүшрикүүд бас тэдний шоронд хорьсон хэсэг мусульманчууд үлджээ.

Харин Медине хотод Ансарууд (Мединегийн мусульманчууд) Мекке хотоос нүүж ирэгсэд буюу Мухажирүүдийг маш хүндтэй хүлээн авсанаар тэнд эв найрамдалтай нэгэн амьдрал өрнөж эхэлсэн байлаа.

Аллахын элчийг (салаллаху алейхи уа сальлам) Медине хот руу нүүн, мусульманчуудыг нэгтгэх байх гэсэн айдас мүшрикүүдийг айлгаж байлаа. Тиймээс ч тэд Дар-үн Недве гэх газар цуглацгаан цаашид юу хийхээ зөвлөлдөхөөр босов. Тэнд чөтгөр Шейх-и Нежидийн дүрээр, өөрөөр хэлбэл, нэгэн хөгшин хүний дүрд хувиран тэдний дунд ирсэн байлаа. Тэдний санаа бодлыг сонсоцгоолоо, аль аль нь ч түүний санаанд хүрсэнгүй. Чөтгөр тэсэлгүй ярианд оролцон: “Та нарын бодол аль нь ч утгагүй зүйл байна. Ягаад гэвэл түүний сайхан царай, ухаант яриа юуг ч татах увидастай. Өөр санаа байна уу? гэж асуув.

Мүшрикүүдийн толгойлогч Эбү Жахил: “Овог болгоноос нэг нэг хүчтэй залууг сонгоё, тэд нар сэлмээ гартаа барин нэгэн зэрэг Мухаммед рүү дайран алаг. Гэхдээ хэн алсан нь мэдэгдэхээргүй зэрэг цавчицгааг. Ийнхүү тэрний овог биднээс Мухаммедын өшөөг авч чадахааргүй болно” Гэв. Чөтгөр ч энэ санааг дэмжин тэдэнд арга заль зааж өгөв⁹⁸.

Мүшрикүүд ийнхүү бэлдэцгээж байхад Аллах эзэн Мухаммедэд (салаллаху алейхи уа сальлам) нүүх зарлиг буулгажээ. Жабрайл (алейхиссальлам) ирж мүшрикүүд энэ шөнө юу хийх гэж байгааг Мухаммедэд (салаллаху алейхи уа сальлам) мэдэгдэв. Тэгээд гэгээн Алиг өөрийнхөө оронд хэвтүүлэхийг түүнд даатган, үлдээсэн зүйлүүдийг эздэд нь тарааж өгөхийг

захиад: “Энэ орой миний оронд хэвтээд унт, энэ дээлийг минь дээрээ нөмөр! Бүү ай, чамд ямар ч муу зүйл тохиолдохгүй” гэв.

Гэгээн Али (радиаллаху анх) Мухаммед элчийн хэлсэнчилэн оронд нь хэвтэв. Өөрийнхөө амийг түүнд өгөхөд бэлэн гэдэгээ харуулав.

Тэр шөнө мүшрикүүд Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) гэрийн гадна цуглав. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) гэрээсээ гаран Ясин сүрегийн анхны 10 аятийг уншаад, атга шороо аван тэдэн рүү цацахад хэн ч юу ч харж чадсангүй харин Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) тэдний хажуугаар гарч Эбү Бакирийн гэрт очжээ.

Хэсэг хугацааны дараа мүшрикүүдийн хажууд нэг хүн иржээ. “Та нар энд юу хүлээж байгаа юм бэ?” гэж асуув. Тэд “Мухаммедыг гэрээсээ гарахыг отож байна” гэхэд “Сая та нарын хажуугаар Мухаммед гарсан шүү дээ” гэв. Тэд ч сандралдан хаалгыг нь онгойлгон гэрт гүйн орцгооход Мухаммед алейхиссальламын оронд Али (радиаллаху анх) байхыг хараад Мухаммедыг хаана байгааг асуухад: “Мэдэхгүй! Та нар намайг тэрнийг харуулдуулахаар үлдээсэн гэж үү?” гэв. Али хүүхэд байсан болохоор мүшрикүүд тэрэнд юу ч хэлэлгүй гэрээс гарцгаав. Кафирууд элчийг хайж эхлэв⁹⁹.

Тэд юун түрүүнд Эбү Бакирийн гэрт очив. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) Эбү Бакир хоёр зугтаан гарсаныг мэдээд тэд улам уурлаж зүг бүрт түүнийг хайж гүйлдэв. Тэдний хамгийн харгис болох Эбү Жахил нь маш чангаар Мухаммед ба Эбү Бакирийг олж өгсөн буюу нуугдаж байгаа газрыг нь зааж өгсөн хүнийг 100 тэмээгээр шагнахаа амлаж орилов. Энэ дууг сонссон хүмүүс эд хөрөнгө мөнгөний төлөө нум садгаа агсан, мориндоо мордон тэр хоёрыг хайхаар гарцгаав.

Гэгээн Эбү Бакир (радиаллаху анх) Абдуллах бин Үрейкт гэх газарчин ба хөтөчөөр алдартай нэгэн хүнд цалин мөнгийг нь өгөөд 3 хоногийн дараа 2 тэмээтэй ирж Севр ууланд байх агуйгаас тэднийг авч явахыг тохиролцов. Сафер сарын 27-ны пүрэв гаригт Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) ба Эбү Бакир Сиддик хоёр хэсэг хэсэг хоол хүнс замын ундаагаа аваад шөнө дунд замд гарчээ¹⁰⁰.

Хайрт пайгамбарын маань (салаллаху алейхи уа сальлам) өмссөн гутал нимгэн байсан болохоор чулуутай уулын замд

99 Сүхейл , эр-Равзүл-Үнф.с.II,309.

100 Ибн Сагд, эт-Табакет I, 230: . Ибн Асакир,Тариху Димашк XXX,78.

урагдаж шалбарчээ. Элчийн ариун хөл нь шархалж цус гоожин гишгэх боломжгүй болсон байв. Тэд явсаар байж Севр уулан дахь агуйд хүрчээ.

Аллахын элч (салаллаху алейхи уа сальлам) ба Эбү Бакир ёрадиаллаху анх) хоёрыг хайсан мүшрикүүд мөрийг нь мөшгөсөөр байж агуйд иржээ. Агуйн аманд нэгэн аалз шүлсээрээ тор татан түүний яг өмнө нэг тагтаа үүрээ засан өндгөө даржээ. Куриз бин Алкаме: “Мөр энд дагуулж ирлээ, тэд энэ агуйд байгаа” гэв. Харин кафирууд “Хэрвээ тэд энэ агуйд орсон бол энэ аалзны торийг сүйтгэх хэрэгтэй байсан бус уу?” гэгцгээв. Тэдний зарим нь : “Энэ хүртэл ирсэн юм чинь агуйд нэг нь орж хараг” гэгцгээв. Үмейе бин Халеф гэх кафир: “Та нар ухаангүй юм уу? Агуйн аманд аалзний тор нэхэгдсэн байгааг харахгүй байгааг байна уу? Энэ тор Мухаммед төрөхөөс ч өмнө татагдсан байх, энд хүн байх боломжгүй” хэмээн тэдний санааг үгүйсгэжээ. Мүшрикүүд агуйн гадаа ийнхүү нэг нэгэнтэйгээ маргалдан зогсох үед гэгээн Эбү Бакир (радиаллаху анх) сандрангуй дуугаар “Аяа, Аллахын элч минь! Би өөрийнхөө төлөө сана зовохгүй байна. Тэд таньд ямар нэг муу зүйл хийх вий гэж айна. Би алагдах юм бол ганцхан хүн, хэн ч мэдрэхгүй өнгөрнө, харин таньд муу зүйл тохиолдвол бүхий л дагалдагсад бас шашин нурж унах болно” гэв. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) “Аяа, Эбү Бакир минь! бүү санаа зов! Үнэндээ Аллах эзэн бидэндтэй хамт” хэмээжээ. Энэ явдалын дараа Аллах эзэн Куран сударт ийн айлджээ: “Хэрэв та нар элчид эс тусалвал, (санацгаа тэр үед) кафирууд түүнийг (Меккегээс) хоёрын хоёр дахь болгон (Гэгээн Эбү Бакиртай хамт) хөөн гаргах үед (Севр уулын оройд) Агуйд байх үед, Аллах эзэн түүнд (элчид) тусалсан билээ. Тэр үед найздаа (Эбү Бакир Сиддикт) “Бүү ай, Аллах эзэний тусламж дэмжлэг бидэнтэй хамт” гэж хэлсэн. Аллах эзэн түүнийг тайвшруулж, түүнийг (хайрт элчээ) үл үзэгдэм нэгэн цэргүүдээр хүчирхэгжүүлсэн, кафируудын үгийг үнэ цэнгүй болгосон юм. Аллах эзэний (тавхид) үг нь маш агуу билээ. Аллах эзэн бүхнээс хүчтэй. Бүхний шийдийг гарган захирагч билээ.” (Тавбе сүре, 40)

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) ба Эбү Бакир (радиаллаху анх) хоёр энэ агуйд 3 хоног нуугджээ. Эбү Бакирийн хүү Абдуллах Мекке хотод болж буй үйл явдалыг өдөр болгон тэдэнд ирж дуулган хоол ундаар хангаж байв.

Дөрөв дөх өдөр нь Аллахын элч Кусва нэрт цагаан

тэмээндээ суугаад Эбү Бакирийг ардаа сундлаад нөгөө тэмээгээ замыг заагч Абдуллах Үрейктд өгөн Мединегийн зүг замд гарчээ. Тэдний аян зам тайван өнгөрчээ. Мүшрикүүд Мухаммедыг байж болох бүх газраар хайж нэгжсэн боловч олж чадсангүй горьдлого тасарцаав.

Сурака бин Малик

Мүшрикүүд Мухаммед элчийг (салаллаху алейхи уа сальлам) олохын тулд байгаа бүхнээ зориулж байлаа. Учир нь мусульманчууд олшрох юм бол өөрийн гэсэн нэгэн улс байгуулан хүчирхэгжээд мүшрикүүд бут цохих байх гэсэн айдас тэднийг нөмөрчээ. Тиймээс ч Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) ба Эбү Бакир хоёрын толгойг авч ирсэн хүнд 100 тэмээ бас их алт мөнгөөр шагнах болно гэсэн зар тараажээ. Тэр үед Сурака бин Малик гэх нэгэн алдартай мөр хөөгч байв.

Мүшрикүүд Суракагийн байх тосгонд ирж тэнд хоноглохоор буудалцаав. Сурака өөрийн боолоосоо 2 тэмээтэй, 3 хүн тосгоноос зайдуу Медине хотын зүг өнгөрсөнийг дуулаад хэнд ч хэлсэнгүй, учир нь 100 тэмээ алт мөнгийг өөрөө авахыг хүсэж байв.

Сурака бин Малик өөрийн боолдоо зэр зэвсэг, бас морио аваад толгодын цаана хүлээж бай гэж захиад өөрөө хувцааа өмсөн сэмхэн гэрээсээ гарчээ. Тэр хоёр мөр мөшгиж явсаар Мухаммедын (салаллаху алейхи уа сальлам) мөрийг олоод тэдний араас нэхэж эхлэв. Ойртох тусам Мухаммед элч Эбү Бакир хоёр тодрон харагдана. Тэр бүү хэл Элчийн (салаллаху алейхи уа сальлам) уншсан Куран сударын дуу Суракаад сонсогдож эхлэв. Эбү Бакир гэнэт эргэж харахад ард нь хоёр хүн маш ойрхон ирсэн байхыг хараад сандран тэвдэхэд Мухаммед элч: “Бүү ай, Аллах эзэн бидэнтэй хамт” гэв. Сурака Мухаммед элчид (салаллаху алейхи уа сальлам) маш ойрхон очсон байв. Тэгээд: “Хөөе, Мухаммед чамайг надаас хэн хамгаалах юм?” гэхэд Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) “Намайг аймшиггүй зоригт агуу хүчит Аллах эзэн хамгаалах болно” гэв. Сурака ч давшихад бэлдэн сэлмээ хуйнаасаа суглан дайрахад гэв гэнэт унасан морьных нь урд хоёр хөл нь өвдөгөө хүртэл газар шигдэн оров. Сурака хичнээн л тэмцэн мултаравыг оролдсон боловч чадсангүй. Суракад хийж чадах зүйл байхгүй

байсан болохоор арга тасран элчээс гуйж эхлэв. Тэрээр “Аяа, Мухаммед, чамайг хамгаалж байгааг ойлголоо. Аллахдаа намайг авар гэж залбираач, энэ мөчөөс эхлэн би чамд хэзээ ч муу зүйл хийхгүй, бас чиний талаар дайсануудад чинь огт дурдахгүй” гэв. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам): “Аяа, Аллах эзэн минь! Хэрвээ тэр үнэн хэлж байгаа бол түүнийг суллаач” хэмээн залбирав. Аллах эзэн залбиралыг нь хүлээн авчээ.

Суракагийн морь залбиралийн дараагаар газраас суллагдан гарав. Энэ бүхнийг өөрийн нүдээр харж, Мухаммед элчийг хамгаалж Аллах буйг мэдэрсэн Сурака бин Малик: “Аяа, Мухаммед! Намайг Сурака бин Малик гэдэг билээ! Би энэ цаг мөчөөс эхлэн таны таалалд үл нийцэх зүйлийг хэзээ ч хийхгүйгээ амлъя. Мүшрикүүд таны хойноос нэхэж асуу. Би тэднийг хуурч замыг нь төөрөгдуулье” гэв. Сурака бин Малик Мухаммед элчид (салаллаху алейхи уа сальлам) хоол унд бас замын унаа болох тэмээ өгөхийг хүсэхэд Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) хүлээн зөвшөөрсөнгүй ба түүнд: “Хөөе, Сурака! Чи ислам шашинд орохгүй бол би чиний тэмээ ба хоол хүнсийг чинь авахгүй. Чи биднийг харсанаа хэнд ч битгий хэл” гэв. Сурака ам мөчигөө өгөөд гэр лүүгээ буцжээ.

Баярт мэдээ! Баярт мэдээ! Хорвоогийн энэрэлийн элч ирж асуй!..

Аллахын элч (салаллаху алейхи уа сальлам), гэгээн Эбү Бакир ба газарчин Үрейкитийн хамтаар их нүүдэлийн анхны жил Рабби-үл эввэл сарын 8-ны өдөр даваа гаригт (622-оны 9-сарын 20-ны өдөр) үүр хаяарах цагаар Медине хотын захад орших Куба гэх тосгонд хүрч ирэв. Энэ өдөр мусульманчуудын цаг тоолол болох Хижра тоололын анхны өдөр билээ. Күлсүм Бин Хидм (радиаллаху анх) гэх нэгэн мусульманы гэрт байрлав. Энд хамгийн анхны Месжид (сүм) баригдсан бөгөөд хамгийн анхны Жума (Баасан гаригийн мөргөл) намаз үйлдэгджээ. Куба Месжидийн (сүм) талаар Куран сударт: “...Суурь нь тахилч, ариун сэтгэлээр баригдсан месжид” хэмээн айлдагджээ. (Тавбе сүре, 108)

Энэ үед Мекке хотод үлдсэн гэгээн Али ариун Каабын өмнө Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) суудал суудалд суугаад: “Мухаммедэд хадгалуулахаар үлдээсэн зүйлээ

авцгаан уу? хэмээн хашгирч байв.

Хэсэг хугацааны дараа Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) Медине рүү эд хогшилоо авч ирэхийг Алид даатгав. Аллахын арслан гэгдэх Али Курейш мүшрикүүдийн цуглан байгаа тэр газар очоод: “Аллахын тааллаар маргааш бид нар Медине хот руу замд гарна. Та нарт хэлэх захих зүйл байна уу? Хэрвээ байгаа бол намайг энд байгаа үед хэлцгээ” гэв. Мүшрикүүд айсандаа дэмий л толгой гудайлган газар ширтэцгээнэ. Өглөө босонгууд Али Мухаммед элчийн эд хогшилийг нь ачаад тэрний гэр бүлийг нь дагуулан Медине рүү нүүхээр замд гарцгаав. Тэдний хөл хавдан цус гарсан байдалтай арай ядан Куба тосгонд иржээ. Тэднийг ирсэнийг дуулсан Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) тэдэнд очив. Гэгээн Алигийн ядарч туйлдсан байхыг нь хараад түүнийг өрөвдөн тэвэрч нулимс дуслуулан ариун гараараа хагарч цэврүүдэн, цус гарсан Алигийн хөлийн төлөө залбиран мөргөжээ. Гэгээн Алигийн (радиаллаху анх) энэ тэвчээр хатуужилийн тухай Куран сударт “Хүмүүсээс зарим нэг нь Аллахын төлөө амь биеэ үл хайралсан билээ” (Бакара сүре, 207)

Медине хотод нүүж ирсэн мусульманчууд ба тэнд байсан бүх хүмүүс Мухаммед элчийг (салаллаху алейхи уа сальлам) замд гарсан тэр цагаас эхлэн Мекке хотын замыг тосон нүд цавчилгүй тэсвэр алдалгүй сандран хүлээж эхэлжээ. Тэдний энэ хүлээлт элсэн цөлд усгүй хатсан хүн мэт түүнийг харан цангаагаа гаргахаар зогсоно. Гэнэт нэг дуу: “Ирж явна! Ирж явна!” орилох нь тэр. Энэ үгийг сонссон мусульманчууд баярлан сандаралдаж цав цагаан элсэн цөл рүү гараа саравчилж харж байв. Тиймээ! Тиймээ! Улайссан халуун наранд цөлийн дундаас Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) ба түүнийг дагагсад ойртон асуй. “Баярт мэдээ!.. Баярт мэдээ!.. Аллахын элч ирж явна!.. Элч (салаллаху алейхи уа сальлам) ирж явна!.. Медине хотийнхон баярлацгаав. Инээцгээ, Аллахын хайрт элч ирж явна!” хэмээн хөл дээрээ үсчин хашгиралдаж эхлэв. Энэ мэдээ Медине хотын өнцөг булан бүрт цуурайтахад зөвхөн энэ баярыг л сэтгэл догдлон хүлээсэн 80 настай бууралаас, 8 настай балчир хүртэл цөм гоё ганган хувцасаа элчийг угтахаар гарцгаав. Тэдний баярлан инээлдэх, Аллаху акбар (Аллах агуу) хэмээн такбир хэлэх нь нүүргэлэн Медине хот маш их хөл хөдөлгөөнтөй болжээ. Баярын нулимс асгарч жаргалаас нүүр царай гэрэлтсэн энэ бүхэн Медине

хотын түүхэнд хамгийн баярт өдөр байлаа.

Мусульманууд “Сайн явж ирж ирэв үү, пайгамбар минь?” “Тавтай морил” хэмээн урьж байв. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам): “Тэмээний бурандагыг тавигтун. Тэр бол миний зан заагч, тэмээ хэний гэрийн өмнө очиж зогсон би тэнд зочлох болно” гэв. Хүн бүр амьсгаа даран хүлээж байлаа. Тэмээ хаана очиж зогсох бол! Тэмээ гудамжаар урагшилсаар л... Кисва тэмээ явсаар одоогийн Мухаммед элчийн сүмийн хаалгын өмнө нь сөхөрчээ. Мухаммед элч тэмээнээс буусангүй. Тэмээ ахин босоод явж эхлэв. Гэвч эргэж ирээд нөгөө л газараа сөхөрчээ. Ахиж боссонгүй. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) тэмээнээсээ буун “Аллахын тааллаар миний байрлах газар энэ юм” бас “Энэ хэний газар вэ?” гэв. “Аяа, Расулуллах, энэ бол Амирийн хүү Сүхэйл ба Сехилийн газар” гэв. Энэ хүүхдүүд өнчин болохоор Мухаммед элч: “Хамаатан садангаас нь алинийх нь гэр хамгийн энэ газарт хамгийн ойр вэ?” гэж асуув. Халид бин Зейд Эбү Эюүб-эл Энсари баярласандаа “Аяа, Аллахын элч минь! Миний гэр хамгийн ойр билээ. Энэ бол миний гэр, энэ хаалга нь” гэв. Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) ирсэн нь Медине дэхь мусульманчууд ба нүүж ирсэн асхабуудын хувьд маш том баяр байлаа.

МЕДИНЕ МҮНЕВБЕРЕ ҮЕ

Хайрт пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) элчийн 13 дахь жил раббийл еввел сарын 12-ны өдөр (622-онд) Мединед ирсэнээр 10 жил амьдрах Мединегийн үе эхэлжээ.

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) Халид бин Зейд Эбү Эйүб-эл Энсаригийн гэрт зочлохдоо тэдний доод давхар буюу 1-давхарт нь амьдрахаар сонгожээ. Ийнхүү гэгээн элчийг (салаллаху алейхи уа сальлам) зочилон хүндлэх ариун ажил энэ гэгээнтэнд ноогджээ.

Гэгээн Халид (радиаллаху анх) ийн өгүүлрүүн: “Аллахын элч манайд зочлохдоо доод давхарт байрлахыг сонгосон, харин би эхнэртэйгээ дээд давхарт нь амьдардаг байв. Энэ байдал бидэнд тун хэцүү байлаа. Учир нь Аллахын элчийн дээр байрлах нь бидний хувьд хэрээс хэтэрсэн хэрэг байв. Нэг удаа бидний ваар хагарч ус асгарахад усний дусал Мухаммед элчийг норгож амар амгалан байдлыг нь алдагдуулах вий гэж сандран эхнэр бид хоёрт байсан ганц хөнжилөөрөө усыг шингээж авч байсан түүхтэй. Энэ хэцүү байдлаа Мухаммед элчид ойлгуулан өөрсдөө доод давхарт байрлан, Мухаммед элчийг дээд давхартаа гаргажээ. Эбү Эйүб хэлэхдээ “Бид үдэш болгон элчийн хоол ундыг нь бэлдэн оруулж өгдөг байлаа, хоол идээд үлдсэнийг бидэнд буцаахад түүний гар хүрсэн талаас нь эхлэн эхнэр Үмму Эйүбтэйгээ хамтаар идэхийг маш их хэмээн боддог байв.

Нэг өдөр зөвхөн Эбү Бакир ба элчид л хүрэлцэх хэмжээний хоол бэлдээд аваачихад элч (салаллаху алейхи уа сальлам) “Аяа, Эбү Эйүб, Ансаруудаас (Мединегийн иргэд) 30 хүнийг хоолонд урь” гэв. Би энэ хоол маш бага бөгөөд 30 хүнд хүрэхгүйг бодон зогсоход ахин “Аяа, Эбү Эйүб, Ансаруудаас 30 хүнийг хоолонд урь” гэв. Би эргэлзэн бодсон боловч зарлигийн даган 30 хүнийг гэртээ урьв. Тэд энэ хоолноос идэцгээн ханаж цадан бүгдэд нь хүрэхээр барахгүй их хоол үлдсэн байлаа. Ийнхүү би анх удаа Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) гайхамшигийг харсан юм” хэмээжээ.

Ансар ба мухажир ахан дүүсийн барилдлага

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) Мединед илүү их уялдаа холбоог батагахийн тулд нүүж ирсэн

мухажирүүдийг (Меккегийн мусульман) гэртээ байлгаж байгаа ансаруудтай (Мединегийн мусульман) ахан дүүсийн барилдлага бий болгожээ. Энэ холбоо тэдний хооронд нэг эхийн хүүхдүүд мэт бат бөх юм. Угаасаа Мединегийн мусульманчууд Аллах эзэний таалалд нийцэхийн төлөө ислам шашиныхаа холбоо хэлхээг бэхжүүлэхийн тулд нүүж ирсэн мусульман ахан дүүсдээ эд хөрөнгө, хоол унд, байж болох бүхий л туслалцаа үзүүлэхийг эрмэлзэж байв.

Мединегийн мусульманчууд өөрийн мал газар, хашаа хороо, өөртөө байгаа бүх зүйлээ орхин нүүж ирсэн мусульман ахан дүүстэйгээ хуваалцаж байв.

Ансар (Мединегийн иргэд) ба мухажир (Меккегийн иргэд) нар гар гараасаа барилцан сэтгэл зүрхээ нэгтгэн ислам шашиныхаа төлөө бүхий л хүч бололцоогоор ханган сүүлийн амьсгал хүртэл чармайн зүтгэхээ нэг нэгэндээ тангаралцгаав. Ийнхүү энэ их нүүдэл нэг гэр улс орон болох замдаа анхны алхамаа хийжээ. Медине хот ислам шашины өлгий нутаг ба төв нь болж байлаа.

Энэ хотод Асхабуудаас гадна христийн шашинтангууд, жүүд шашинтангууд, бас шавар бурхадад мөргөгсөд ч байлаа. Жүдүүд: Бени Кайнука, Бени Курейза, Бени Нар гэх мэт 3 овогт хуваагддаг байлаа. Эд нар тэр хайрт пайгамбард маань жинхэнэ дайсан байлаа.

Харин Меккегийн мүшрикүүд Медине дахь мусульманууд өөр хоорондоо ах дүүс болцгоож, эв найрамдалтай хүчирхэгжиж байгааг дуулаад хэзээ нэгэн цагт мусульманчууд хүчтэй болон олон цэргүүдтэйгээр дайран ирж Мекке хотод үлдээсэн эд хөрөнгө ба газар нутгаа авах вий гэсэн бодол тэднийг айлгаж байв. Тиймээс ч мүшрикүүд Медине хот руу тэднийг айлган сүрдүүлсэн захиа илгээсэн нь ийм утгатай билээ: “Ямар ч алдаа мадаггүй арабуудын хооронд дайсагналын галыг асааж ноцоон, бидний та бүхэн шиг гомдоосон хүн үгүй билээ. Ягаад гэвэл биднээс гаралтай нэгэн хүнийг бидэнд буцаан өгөхийн оронд, түүнд туслан найр тавих нь та бүхний маш том алдаа юм. Та нараас гуйх нь бидний хоорондоос гарцгаа, тэгээд тэрнийг (Мухаммед) бидэнд буцаан өгцгөө. Хэрвээ энэ хүсэлтийг биелүүлвэл бид маш их талархах болно. Хэрвээ эс биелүүлвэл бид түүнийг дайны аргаар булаан авах болно” гэж бичсэн байлаа.

Энэ захианы хариу болгон Мединегийн мусульманчууд

тэднийг доромжилсон нэгэн захиа явуулжээ. “Хэрвээ та нар бидний мусульман ахан дүүсийг шоронгоос суллан тавьж явуулахгүй юм бол бид танай хотыг дайрч та нарыг алаад эхнэр хүүхдүүдийг чинь өөрийн боолоо болгоцгооно” хэмээн сүрдүүлэв.

Месжид-и Неби (Элчийн сүм)

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) Мединед ирээд тэнд асхабуудыг цуглуулж намаз (мөргөл үйлдэх) бас сургаал айлдах месжид (сүм) бариулахыг хүсэж байв. Энэ үер Жабрайл (алейхисальлам) Мухаммедэд (салаллаху алейхи уа сальлам) ирж “Аяа Расулуллах! Аллах эзэн чулуугаар эсвэл тоосгоор нэгэн гэр месжид (сүм) барихыг зарлигласан байна” гэв. Ингээд Мухаммед элч анх Мединед ирэхэд Кусва тэмээний сөхөрсөн газрын эздээс нь худалдан авахыг хүсэв. Эзэд нь “Аяа, Расулуллах! Бид энийг яахан зарж зүрхлэх билээ. Ийм буянтай ажилд шууд өгье” гэв. Гэсэн ч Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) мөнгө төгрөгийг нь өгч худалдан авчээ.

Ийнхүү Месжид (сүм) барих ажил өрнөж эхлэв. Зарим нэг нь газрыг тэгшлэн цэвэрлэж байхад зарим нэг нь тоосго хэвлэн цохиж, зарим нь чулуу мод татан авч ирж байлаа. Бүх бэлтгэл хангагдсаны дараагаар шав тавихийн тулд бүх мусульманчууд цугларцгаав. Шав тавихад хамгийн анхний чулууг Мухаммед Мустафа (салаллаху алейхи уа сальлам) элч өөрийн гараар тавив. Дараагаар нь “Эбү Бакир чи чулуугаа миний чулууний хажууд тавь, дараа нь Омар чи чулуугаа Эбү Бакирийн чулууний хажууд тавь, дараа нь Осман чи чулуугаа Омариин чулууний хажууд, дараагаар нь Али чи чулуугаа Османы чулууний хажууд тавь!” хэмээв. Тэд чулуугаа тавьсны дараагаар тэнд байх асхабууд “та нар ч мөн адил чулуунуудаа тавьцгаа” хэмээв.

Месжид барихын тулд юун түрүүнд хайрт пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) хийгээд бүхий л асхабууд өдөр шөнөгүй зогсоо зайгүй хөдөлмөрцгээжээ. Чулуугаар суурыг нь 15 м өндөр өргөөд дараа нь тоосгоор ханыг нь босгожээ.

Месжид-и Небийг босгоход хамгийн их ажил хийж байсан хүн бол Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) байв. Дааж давшгүй том том чулуунуудыг ариун нуруундаа үүрэн гар нь цэврүү болтол ажиллаж байв.

Элчийн энэ их хөдөлмөрийг харсан мусулманчууд бүр

ч их хичээн урайран хөдөлмөрлөж байв. Хүн болгон нэг чулууг зөөж байхад Аммар бин Яасир (радиаллаху анх) гэдэг нэгийг нь Мухаммед элчийн төлөө, нэгийг нь өөрийн өмнөөс гэж 2 чулууг зэрэг зөөж харагдав. Үүнийг харсан Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) ариун гараараа Аммарын нурууг илэн “Аяа, Сүмейегийн хүү! Чамд хоёр, бусдад нь ганцхан буян байгаа” хэмээжээ.

Месжидийн хаана босож, дээвэр нь хийгдсэний дараагаар тэрний хажууд Мухаммед элчид зориулагдсан 2 өрөөтөй гэр бас барив. Ийнхүү Месжид баригдсаний дараагаар Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) Халид бин Зейдийн гэрээс эд хогшилоо аван нүүн ирж байрлажээ.

Хурма мод уйлсан нь

Гэгээн пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) Жума (баасан гаригийн их мөргөл) өдөр Месжидэд байх Ханане гэх нэгэн Хурма модны гуалинг түшиж зогсоод айлтгалаа хэлдэг байв. Харин сүүлдээ гурван шаттай нэгэн индэр хийлгэсэн билээ. Нэгэн Жума өдөр мусульманууд мөргөл үйлдэн, сургаал сонсохоор Месжидэд цугларцгаасан байлаа. Гэв гэнэт нөгөө Курма модон гуалин хэлтэй тэмээ уйлж байгаа мэт чанга дуугаар уйлж эхлэв. Бүх асхабууд гайхан энэ дууг сонсов. Хайрт пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) нөгөө модон гуалинг гараараа илбэхэд уйлахаа больж чимээ тасрав. Тэнд байх мусульманууд ердийн нэгэн модны Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) төлөөх хайрыг нь бодоцгоон нүдэн дэхь нулимсаа барьж үл дийлэн уйлцгаав.

Мухаммед алейхиссальлам “Хэрвээ түүнийг илбээгүй бол энэ мод надад гэсэн гоморхолоосоо болон хойд ертөнц хүртэл ийнхүү уйлах байсан” хэмээжээ. Сүүлдээ Пайгамбар алейхисальламын зарлигласанаар тэр гуалинг газар булжээ.

Гэгээн Айшетэй гэрлэсэн нь

Хорвоогийн энэрэл болсон Мухаммед (салаллаху алейхи уа сальлам) ба Эбү Бакир Сиддик (радиаллаху анх) хоёр Медине рүү нүүхэд Эбү Бакирын гэр бүл Мекке хотод үлдсэн билээ. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) гэгээн

Хадиже эхийг нас барсанаас нэг жилийн дараа Эбү Бакирийн охин болох Айшетэй сүй тавьсан юм. Тэр хоёр сүй тавьсан ч хуримаа хийж амжаагүй байлаа. Гэгээн Айше (радиаллаху анха) эх ийн өгүүлсэн юм: “Аллахын элч Медине рүү нүүхдээ биднийг, бас өөрийн охидийг ч Меккед үлдээсэн юм. Тэгэхээс ч өөр алга байсангүй. Зейд ба Харис ба Эбү Рафи хоёрт хоёр тэмээ ба хэрэгтэй зүйлсээ худалдан авах 500 дирхам өгөн биднийг авхуулхаар Мекке рүү илгээсэн юм. Аав минь ч Абдуллах бин Үрейкитэд 3 тэмээ өгөн ээж, бас миний дүү нарыг авхуулхаар тэдэнтэй цуг илгээсэн юм. Ийнхүү тэд Меккед ирэн ээж, дүү, бас Мухаммед элчийн охидуудын хамтаар бид нар Медине рүү нүүн ирсэн билээ. Мединед ирэхэд би аавынхаа гэрт үлдэж элчийн охидууд өөрсдийнхөө гэр лүүгээ явцгаав. Би хэсэг хугацаанд аавынхаа гэрт байлаа. Нэг өдөр гэгээн Эбү Бакир Мухаммед элчид очоод: “Аяа, Расулуллах, гэргийтэйгээ хуримаа хийхгүй байгаагийн учир юу билээ?” гэж асуухад Аллахын элч: “Мехир (инжийг) өгөх хөрөнгө надад алга” хэмээв. Эбү Бакир Мухаммед элчид (салаллаху алейхи уа сальлам) мөнгө өгөв.

Энэ мөнгөөр гэгээн Айше эхтэй хуримаа хийжээ. Тэр үед Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) 55 настай байлаа. Айше эх маш ухаалаг бөгөөд нэг сонссон зүйлээ хэзээ ч мартдаггүй байлаа. Асхабууд (радиаллаху анхум) зарим зүйлийг түүнээс асууж сурч авдаг байв.

Анхны азан (Намазын дуудлага)

Месжид-и Неби баригдсаны дараагаар мөргөлийн цаг эхэлсэнийг мэдэгдэх, бас хүмүүсийг цуглуулах нэгэн дохио алга байлаа. Зөвхөн “Эссалатү Жамий” буюу (Месжидэд намаз руу) гэж орилдог байв.

Нэг өдөр Муаммед элч (салаллаху алейхи уа сальлам) асхабуудтайгаа намазд ард түмнийг дуудах нэгэн дохио хэрэгтэй байна хэмээн зөвлөлджээ. Янз янзийн санаа оноо хэлж байлаа. Христийнхэн шиг хонх дуугаргая, жүүдүүд шиг бүрээ үлээе, зарим нь мөргөлийн үед гал асаан өндөрт өргөө гэх мэт санал гаргасан боловч Аллахын элч алиныг нь ч хүлээн зөвшөөрсөнгүй.

Абдуллах бин Зейд бин Салебе ба гэгээн Омар (радиаллаху анхум) хоёр нэг шөнө зүүдэндээ Азан дуудаж байхыг үзжээ. Гэгээн Абдуллах Мухаммед (алейхиссальлам) элчид очин зүүдээ

ийн өгүүлжээ:

“Толгойдоо ногоон алчуур боосон, гартаа ногоон өнгийн гоёмсог алчуур барьсан нэгэн хүнтэй таарлаа. “Гартаа байгаа наад зүйлээ надад зараач” гэж гуйхад минь “Чи энэнээр юу хийх гэж байна?” гэв. Би: “Наад алчуураар чинь намазд (мөргөл) хүмүүсийг дуудъя” гэлээ. “Би чамд тэрнээс сайханыг нь зааж өгөө” гээд Каабын харан зогсоод чанга дуугаар уянгуулан “Аллаху акбар, Аллаху акбар...” хэмээн уншиж эхлэв. Тэгээд дууссаны дараагаар намаз эхлэхийн өмнө босож зогсоод азаныг дахин хэлээд сүүл хавьд нь “Кад каамет-ис-салатү” гэх үгийг нэмж хэлэв”

Энэ үгийг сонсож маш их баярласан Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) “Энэ зүүд үнэн зүүд байна. Энэ үгнүүдийг Билалд зааж өг, тэр уншиг!” гэв. Энэнд Азан гэж нэр өгчээ.

Гэгээн Билал Месжидийн хажууд байх өндөрлөг хашаан дээр гараад анхны Азаныг зааж өгсөнчилөн уншжээ.

Гэгээн Омар Азаныг сонссон даруйдаа гүйсээр Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) хажууд ирээд шөнө зүүдэндээ яг ийм үгийг зүүдэлж сонссоноо ярьжээ.

Билал Хабаши (радиаллаху анх) нэгэн өглөө хайрт пайгамбарын маань (салаллаху алейхи уа сальлам) гэрийн үүдэнд ирээд “Эс-салаатү хайрун минанавум” гэж хоёр удаа хэлжээ. Энэ үгийн утга нь «намаз нойрноос эрхэм» гэсэн үг юм. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) энэ үгийг таалан: “Билал минь! Энэ ямар гоё үг вэ? Өглөөний азандаа энэ үгийг нэмж хэлээрэй” гэжээ. Ийнхүү өглөөний намазд энэ үгийг нэмж хэлдэг болжээ.

Мухаммед элчийг (салаллаху алейхи уа сальлам) нас барах хүртэл Билал-и Хабаши мұазанлик (азан дуудах ажил) хийжээ. Түүний дуу маш гоё баргил агаад азаныг нь сонссон хүн болгон уяран сонсдог байв.

Асхабуудыг сургаж эхэлсэн нь

Хорвоогийн хайр энэрэл болсон элч (салаллаху алейхи уа сальлам) асхабуудыг сурган хүмүүжлэх ажилд шамдан орсон байлаа. Хэзээ ч уйдамгүй амтат сургаалуудыг айлдан Аллах эзэний буян хишигийг өөрийн асхабууддаа харамгүй хайрладаг

байлаа. Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) энэ хайр сургаал номлолыг сонсох бүрдээ урьд урьдийнхаас ч илүүтэйгээр исламд дурлан мэдлэг боловсрол олж авдаг байв. Бүхий л Асхабууд Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) энэ амтат үгс, гэгээн царайг харахын тулд өдөр бүр тэрнээс нэг ч алхам холдолгүй цуглацгаана. Ийнхүү асхабууд (радиаллаху анхум) элчүүдийн дараах хүн төрөлхтөний хамгийн дээд нь болцгоосон юм.

Аллах эзэн асхабуудын тухай Куран сударт: “Та нар он цагийн бүхий л дагалдагсадын хамгийн дээд нь болцгоолоо, хүмүүст буян болохын тулд туурвигдан, тэднийг сайн үйл хийхийг уриалан дуудаад, муу үйлээс хоргилцгооно...” (Али-Имраан сүре, 110)

Гэгээн пайгамбар маань ч асхабуудын талаар ийн айлджээ. “Миний асхабыг битгий муулцгаа, тэдэнд зохихгүй муу үг битгий хэлцгээ! Намайг туурвигч эзэн Аллахын нэрээр андгайлан хэлье, та нараас хэн нэгэн Ухуд уулын чинээ алтаар өргөл барьц өгсөн ч миний асхабын нэг ширхэг тариан буудайны дайтай буян үл хурааж чадна” бас “Миний асхаб тэнгэрт буй одод мэт тэдний алинийг нь ч дагасан зөв замыг олох болно.” хэмээжээ.

Асхаб-и суффе

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) Месжид-и Небигийн хойд хэсэгт нь Курма модны мөчирөөр нэгэн сүүдрэвч бариулжээ. Тэнд Меккегээс нүүж ирсэн мал хөрөнгөгүй ядуусыг хоноглож болно гэжээ. Ийм ядуус 400 гаруй байсан бөгөөд тэд Аллахын элчийг (салаллаху алейхи уа сальлам) бараадан түүний хажуунаас үл холдоно. Өдөр бүр Куран уншиж хадисийг (Мухаммедын сургаал үг) цээжлэн мэдлэг боловсрол олохын тулд шамдацгаан өдөр нь мацаг барьж шөнө нь намаз үйлдэн залбирч хоноглоно.

Энэ сургуульд сурч боловсрогчидыг шинээр мусульман болсон отог овог руу багшлуулхаар явуулдаг байлаа. Маш их буян хураан мэдлэг боловсролтой болсон энэ хүмүүсийг Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) маш их хайрлан хүндэлдэг байлаа, үргэлж тэдэнтэй ярилцаж тэдэнтэй хамт хооллодог байлаа. Энэ хүмүүсийг “Асхаби суффе” ба “Сурагч Асхаб” хэмээн нэрэлжээ.

Аллахын элч (салаллаху алейхи уа сальлам) бүхнээс түрүүнд Асхаб-и суффе нарыг хоол ундаар хангаад дараагаар нь гэр бүлдээ хоол унд олдог байлаа. Эбү Хурейре ийн өгүүлж байна: “Аллах эзэндээ андгайлъя, би ядуу нэгэн билээ. Өлсгөлөн болохоор заримдаа гэдсээрээ түрүүлгээ харж хэвтэн, заримдаа өлсгөлөнгөө мэдрэхгүйн тулд гэдсэндээ чулуу боодог байлаа. Нэг өдөр Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) Месжид рүү явах замд сууж байтал хорвоогийн энэрэл болсон элч миний хажууд ирлээ. Намайг хараад инээмсэглэн: “Аяа, Эбү Хурейре!” гэв. Би “Амиа таний төлөө өргөө! Таныг сонсож байна” гэлээ. Элч (салаллаху алейхи уа сальлам) “Намайг дагаад яв” гэв. Би ч түүний араас дагалаа. Гэрт нь нэг аяга сүү байна лээ. “Алив, Асхаб-и суффег дууд” гэлээ. Би тэднийг дуудахаар явах замдаа өөртөө «Бүх Асхаб-и суффед ганцхан аяга сүү хэрхэн хүрэлцэх юм?» Надад ганц балга сүү ноогдох болов уу?» гэж бодсоор явлаа. Тэднийг дуудан авч ирэв. Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) зөвшөөрөлийг аван гэрт орж байраа эзлэн сууцгаалаа. Дараагаар нь Мухаммед элч: “Алив, Эбү Хурейре тавагтай сүүг хүмүүст өг, ууцгаар” гэлээ. Би тавагтай сүүг хүн бүрт ээлж ээлжээр өгч уулгаж эхлэв. Хүн бүр сүүг цадталаа уугаад буцааж надад өгөхөд огт дундраагүй байв. Тэр сүүг бүгд ууцгаан цадсаны дараагаар Аллахын элч (салаллаху алейхи уа сальлам): “Аяа, Эбү Хурейре! Сүү уугаагүй чи бид хоёр л үлдэх шив. Алив эхлээд чи уу!” гэв. Би суугаад ууж эхэллээ. “Ахиад уу!” гэлээ. Би уулаа, пайгамбар маань хэд хэдэн удаа “Уу!” гэв. Би ингэж хэлэх болгонд балган уусаар цадсан юм. Ингээд би сүүг Мухаммед элчид (салаллаху алейхи уа сальлам) өгөхөд тэр Аллах эзэндээ баярлаж талархсанаа хэлсэнийхээ дараагаар Бисмиллах (Аллахын нэрээр эхэлнэм) гэж хэлээд уусан юм.

Жиблийн түүх

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) шашинд зарлигласан ба цээрлэсэн бүхий л зүйлийг мусульманчууддаа зааж сургаж байв. Итгэл үнэмшил, исламын болзолууд, намаз (мөргөл), мацаг, Хаж (даяанчлал, Каабд очиж тойрон мөргөх), өргөл барьц ба энэ бүхэнтэй холбоотой бүх зүйлийг заан сургаж байсанаар барахгүй, хэрхэн яаж хүнтэй ярих, мэндлэх, идэж уух, хувцаслах, наймаалцах, хөршийн харилцаа, хамаатан саданы

харилцаа, найзлах, гэрлэх, гэрээслэл тараах, цээрлүүлэх, нүгэл буян, эрүүл мэндээ хамгаалах, дайсануудтайгаа тулалдах, дайны ёс, тэр бүү хэл үсээ хэрхэн засаж, хумсаа хэрхэн авахыг хүртэл исламийн жаяг ёсоор зааж сургаж байлаа. Өөрийн хэрэгтэй гэсэн зүйлийг хоёр гурван удаа давтан сургах нь тэрний багшлах авъяас билэгийн агуу том илрэл байв.

Гэгээн Омар (радиаллаху анх) ийн айлднам: “Нэгэн өдөр бид цөм Месжид цугларсан байтал гаднаас нэг хүн орж ирлээ. Тэр хүний хувцас нүүр царай нь цав цагаан тас хар хөмсөгтөй, энэ хүнийг урьд хойчид хараагүй танихгүй хүн байлаа. Тэр хүн бидэн дундуур явсаар Аллахын элчийн өмнө сөгдөн суув. (Энэ ирсэн хүн Жабрайл (алейхисальлам) сахиусан тэнгэр байв. Түүний ирсэн явдал нь хүмүүст маш чухал нэгэн зүйлийг заахын тулд байв. Энэ нь Исламын шашинаа сурч мэдэхийн тулд огт ичихгүй байхыг бас өөрийн багшийнхаа өмнө хэрхэн яаж суухыг энэ биеэрээ зааж үзүүлхээр иржээ.)

Тэр хүн Аллахын эзэний өвдөг нь дээр хоёр гараа тавиад: “Аяа, Расулуллах! Надад ислам шашиныг бас мусульманы тухай хэлж ойлгуулаач!” гэв.

Аллахын элч (салаллаху алейхи уа сальлам) ийн ярьж эхлэв: “Ислам шашины болзолуудын анхных нь бол “Келима-и шахаадатыг” хэлэх явдал юм. (Кэлима-и шахаадатыг хэлэх гэдэг нь “Эшхэдү эн лаа илааха иллаллахү, вэ эшхадү эннэ Мухаммеден абдүхү вэ расүүлүхү” гэж хэлэх юм. Өөрөөр хэлбэл насанд хүрсэн, эрүүл ухаантай, ярьж чаддаг хүн бүр “Аллахаас өөр мөргөн залбирч болох амьд амьгүй бурхан үгүйг бас Мухаммед бол түүний боол ба элч болохыг гэрчилнэм” гэсэн энэ үгийг хэлж чин зүрхнээсээ итгэн сүсэглэх явдал юм.)

“Цагнь болохоор намазаа үйлдэх явдал. Малхөрөнгөнөөсөө зекет өгөх (40-өөс нэг хэсгийг), Рамазан сар болоход нэг сар мацаг барих, эд хөрөнгө нь хүрэлцээтэй хүмүүс амьдралдаа нэг удаа Хаж (даяанчлал, Каабд очиж тойрон мөргөх) явах явдал” гэв. Тэр хүн Мухаммед элчээс (салаллаху алейхи уа сальлам) хариултыг сонсоод “Чи үнэн хэллээ, аяа, Расулуллах!” Тэнд байгсад энэ хүн асуулт асуучихаад зөвтгөж байна” хэмээн гайхан эхлэв.

Энэ хүн: “Аяа, Расулуллах, итгэл үнэмшил гэж юу болохыг надад заагаач!” гэв.

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам): “Хамгаас түрүүнд Аллах эзэнд, дараа нь мелекүүдэд (сахиусан тэнгэрүүд),

Аллахын элчүүдэд, мөнхийн хойд насанд итгэх, хувь төөрөгт, сайн сайхан ба муу муухай зүйлс Аллахын тааллаар болдогт бат итгэх явдал” гэв. Тэр хүн зөв хэллээ хэмээн хүлээн зөвшөөрөв. Дараа нь “Аяа, Расулуллах Ихсан гэж юу болохыг надад заагаач!” гэв. Мухаммед элч “Аллах эзэнд түүнийг харж байгаа мэт мөргөл үйлдэх юм. Ягаад гэвэл чи тэрнийг үл харсан ч тэр чамайг харж байгаа нь гарцаагүй юм...” хэмээв. Тэр хүн ахиад “Аяа, Аллахын элч минь! Надад кияметийн (дахин амилах өдөр) талаар ярь!” гэв. “Энэ асуудлын талаар асуугдагч хүн асуугчаас илүү мэдэхгүй билээ” гэв. Тэр хүн “Тэгвэл түүний таних тэмдэгүүдийг хэл” гэв. Зарцуудын өөрийн эзэдийг төрөх, хөл нүүцгэн хувцасгүй ядуу малчдын (байжиж) өндөр барилга барьж уралдахыг үзэх гэлээ. Тэр хүн гарч одов.

Аллахын элч над руу харан “Хөөе, Омар, энэ ирсэн хүн хэн болохыг чи мэдэх үү?” гэж асуулаа. Би “Аллах эзэн бас түүний элч хамгийн сайн мэдэх билээ” гэлээ. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам): “Энэ хүн бол Жибрил (Жабрайл алейхисальлам) юм. Та нарт шашиныг заахаар иржээ” гэв.

Селман-и Фарисийн мусульман болсон нь

Өдөр ирэх тусам ариун туяа дэлхийгээр түгэн Аллахын элчийн (салаллаху алейхи уа сальлам) нэрийг дуулсан хүмүүсийн зүрх нь уярч байв. Түүний ирэхийг тэсэн яадан хүлээх ухаантангууд түүнийг хайн хаа холоос Медине хотод зорин ирж исламд итгэн мусульман болцгоосон хүмүүсийн нэг бол Селман-и Фариси юм. Тэрээр хэрхэн мусульман болсоноо ийн хүүрнэжээ:

“Би Фарис (Иран) улсын иргэн Исфехан хотын Жей хэмээх тосгоноос гарсан, аав маань тоосгон дахь хамгийн баян хүн байлаа. Түүний мал хөрөнгө газар нутаг нь маш их юм. Би айлын ганц хүү болохоор намайг тэд нүдний цөцгий мэт хайрлан яг охин хүүхэд шиг өсгөсөн билээ. Манайх межуси (галд шүтдэг) шашинтай байсан болохоор гэрт маань үргэлж нэг галыг унтрааалгүй асаан түүнд мөргөн залбирдаг байв. Намайг хэзээ ч гэрээс гаргалгүй межуси шашины зан үйлийг заан сургадаг байлаа. Нэг өдөр аав маань намайг гэрээсээ гаргаад: “Хүү минь, надад байгаа бүх эд баялаг намайг үхэхлээр чиний болох болно. Тиймээс чи мал хөрөнгө газар нутагтайгаа танилцах цаг боллоо” гэв. Би “за” гэж зөвшөөрөөд цэцэрлэг ба эзэмшил газраараа

зугаалж эхлэв.

Нэг өдөр цэцэрлэгт зугаалж яваад нэг хүүтэй таарлаа. Тэр хүү христийн шашинтай агаад мөргөл хийж байлаа. Би урьд өмнө ийм зүйл огт хараагүй болохоор ихэд сонирхон удаан гэгчийн харж зогсов. Тэд нар огт үзээгүй сонсоогүй хэрнээ ертөнцийн эзэнд залбирч байлаа. Ягаад гэвэл манай межуси шашин бол гал түлж түүндээ мөргөхөөс өөр онцлого зүйл үгүй билээ. Би дотроо “Эд нарын шашин бол үнэн, харин бидний шашин бол худлаа” гэж хэлэв. Би тэдэнд очоод “Энэ шашины төв хаана байдаг вэ?” гэж асуухад “Шам хотод байдаг” гэв. “Хэрвээ би Шам руу очих юм бол намайг хүлээн зөвшөөрөх болов уу?” гэж асуухад “Тийм ээ, хүлээж авна” гэж хариуллаа. “Та нараас ойрын хугацаанд Шам хот руу явах хүн байгаа юу?” гэхэд хэдэн хоногийн дараа нэгэн тэмээн жин Шамын зүг хөдлөх талаар хэлж өгөв.

Энэ шашин миний сонирхлыг маш их татсан байсан ба би аав ээждээ хэлэлгүй нууцаар Шам хот руу явахыг бодож эхлэв. Хэсэг хугацааны дараа христийн хамба ламаас Шам руу явах жингийн бэлэн болсоныг дуулаад шөнө дөлөөр гэрээсээ зугтаан гарч жингийн цуваа байх христийн сүмд орголоо. Тэдэнд энд байж чадахгүйгээ тайлбарлан жинд нь нэгдэн Шам хотын зүг хөдөлсөн юм. Маш урт хугацааны аялалын дараа Шам хотод хүрч очлоо. Тэндхийн хамгийн том хамба ламыг зааж өгөөч гэж гуйн хайж явсаар тэр хамбаа ч оллоо. Би түүнтэй танилцан хэрэг зориггоо хэлж надад христийн шашиныг зааж өгөх юм бол түүний ажилчин нь болохоо амлав. Тэр ч зөвшөөрч би христийн сүмд ажил хийн хажуугаар христийн шашиныг сурч эхлэв.

Гэвч энэ хүн миний бодсон шиг сайн хүн биш байлаа. Хүмүүсийн өргөл хандивийг аваад ядууст тарааж өгөх ёстой байтал энэ хүн өөртөө цуглуулдаг байлаа. Ингэж цуглуулсан алтууд нь гурван авдар болжээ. Энэнийг зөвхөн надаас өөр хэн ч мэддэггүй байлаа. Нэг өдөр түүнийг нас барахад шашин нэгт нөхөдүүд нь цуглан гашуудацгаав. Би: “Та нар юунд гашуудан вэ? Энэ хүн та нарын бодсон шиг сайн хүн биш байсан юм. Учир нь энэ хүн ядууст өгөх ёстой байсан мөнгийг өөртөө зарцуулдаг байсан. Хэрвээ та нар итгэхгүй байгаа бол үүнийг харцгаа” гээд нуусан алтуудыг хүмүүст харуулхад тэд хий дэмий гашуудсанаа мэдээд хамбын цогцыг нэгэн нүхэнд хийж булж орхив.

Түүний дараагаар бас нэгэн хамба ламд шавиар орсон нь тэр хүн маш их эрдэм мэдлэгтэй үнэнч шударга нэгэн байлаа.

Би тэрний хажууд байх хугацаандаа их зүйлийг сурч мэдэж авсан билээ. Он жилүүд өнгөрч багш лам маань ч хөгширч үхэх цаг ойртсон юм. Би : “Багш минь, та маш ариун хүн билээ. Би таны энэ зан чанарыг маш их хичээлээ, одоо таныг нас барахаар би хэндээ очих билээ. Надад нэг хүн зааж өгнө үү?” гэж гуйлаа. Тэр : “Хүү минь, одоо үед христийн шашинд зөв зам заагч үнэн ч шударга хүн үлдсэнгүй. Чи хэнд ч очсон тэд чамайг буруу зам руу хөтөлнө. Гэхдээ сүүлчийн элч ирэх цаг ойртлоо. Тэр араб нутагаас гарах болно. Үнэн ч шударга, түүний дэлгэрүүлэх шашин нь дэлхий даяар түгэх учиртай. Тэрний хоёр мөрний хооронд элчийн тамга болох мэнгэ бий” гэж элчийн шинж тэмдэгүүдийг нэг нэгэнгүй тоочиж гарлаа. “Хэрвээ чамд боломж гарвал араб нутагт очоод түүнийг ол” гэв. Би түүнийг нас барсаны дараагаар тэрний хэлсэнчилэн Араб орон руу явахаар шийдлээ.

Өөрт байгаа хамаг мөнгөө Араб руу явах хэсэг аянчидад өгөөд тэднийг дагалаа. Энэ хүмүүс намайг зам зуур Вауи-үл Курра гэх газар ирэхдээ боол болгон нэг жүүд хүнд зарсан юм. Би хэсэг хугацаанд боол болон ажиллаж байлаа. Гэхдээ миний зүрхэнд сүүлчийн элчийг олох гордилго тасраагүй билээ. Хэсэг хугацааны дараагаар эзэн маань намайг өөрийн дүүдээ зарсан юм. Харин тэр намайг аваад Медине хотод нүүж ирсэн. Би Медине хотод эзэнийхээ жимсний цэцэрлэгт ажилдаг байлаа.

Нэг өдөр би Курма модны оройд гаран ажил хийж байх үед эзэн маань тэр модны доор сүүдэрлэн хэн нэгэнтэй ярилцаж сууна. Тэр хүнд: “Эвс ба Хазреж овгийнхныг хараал идээсэй. Мекке хотоос Куба тосгонд нэг элч нүүж ирж яваа гэнэ. Энэ хоёр овгийнхон түүний шашинд итгэсэн юм байх...” гэхийг нь сонсоод би өөрийн эрхгүй модноос үсрэн буугаад “Та юу гэнээ? Ахиад хэл дээ” гэхэд тэр: “Чамд ямар хүртээлтэй юм бэ? гээд намайг нэг алгадав. Тэр орой нэг том цар тавганд курма жимс хийгээд Куба тосгонд очлоо. Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) өмнө ирээд: “Чи цэвэр ариун хүн билээ хажууд чинь ядуус буй. Энэ жимсийг өргөл болгон аваач” гэлээ.

Аллахын элч (салаллаху алейхи уа сальлам) хажуудаа байсан асхабууддаа “ Нааш ирцгээ, курма идэцгээ” гэлээ. Тэд курма идэж эхэлхэд элч өөрөө нэг ч амссангүй. Би өөрөө өөртөө “Энэ бол элчийн шинж” гэлээ. Хэсэг хоногийн дараа Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) Меккед ирсэнийг дуулаад би энэ удаа бас курма жимсээр дайлахаар очихдоо “Энэ бол миний

бэлэг” гэхэд Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) өөрөө ч идээд хажууд байгсаддаа ч өгөв. Би: “Энэ бол элчийн 2 дахь шинж” гэж өөртөө шивнэлээ. Миний аваачсан курма жимс 25хан ширхэг байсан атал үлдсэн үр нь 1000 хол давсан байхыг нь хараад “ Нэг шинж ахиад үзлээ” гэлээ. Би нэг өдөр Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) хажууд очлоо. Түүний элчийн тамгыг үзэхийг хүсэн ойртон очиход тэр миний санааг ойлгосон бололтой цамцаа өргөн элчийн бэлгэ тэмдэг болсон тамгыг надад харуулав. Тэрнийг харсан даруйдаа үнсэн цурхирхан уйлж эхэлхэд Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) миний толгойг илэн надад Кэлиме-и шахадатыг хэлж өгсөн юм. Ийнхүү би мусульман боллоо.

Би өөрт тохиолдсон бүх явдалуудаа элчид нэг нэгэнгүй ярьж өгөхөд элч маш их гайхан энэ бүхнээ Арабуудад ч гэсэн ярьж өгөхийг хүссэн юм.

Селман-и Фариси мусульман болсоныхоо дараа ч боолоос чөлөөлөгдөөгүй байлаа. Мухаммед элч(салаллаху алейхи уа сальлам): “Өөрийгөө боолоос чөлөөл, Селман минь” гэв. Би эзэндээ очоод боолоос чөлөөлж өгөхийг гуйхад тэрээр: “Хэрвээ чи 300 курма мод тариад үр жимсээ өгөх хүртэл ургуулах юм бол дээр нь нэг боодол алт өгөх юм бол чөлөөлье” гэлээ. Би энэнийг Мухаммед элчид (салаллаху алейхи уа сальлам) хэлэхэд асхабуудаа цуглуулаад: “Шашин нэгт дүүдээ тусалцгаа” гэв. Мусульманууд ганц хоёроор авч ирсээр 300 курма мод тэр дороо цуглав. Пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам): “Энэ моднуудыг тарих нүүхнүүдийг ухаж бэлдээд надад мэдэгд” гэв. Би нүүхнүүдийг ухаж бэлэн болгосны дараа элч өөрийн гараар 300 мод тарихад надад тусласан юм. Энэ бүх мод тэр жилдээ жимсээ өгсөн нь хачирхалтай.

Аллахын элч (салаллаху алейхи уа сальлам) нэг өдөр намайг дуудан хэсэг алт өгөөд: “Ма, энэ алтуудыг аваад өрөө төл” гэсэнээр би эрх чөлөөгөө олж авсан юм” гэжээ.

Сахиусан тэнгэрүүд түүнийг сонсохоор ирдэг байлаа

Пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) Куран сударыг хэнээс ч илүүтэйгээр сайхан уншдаг байлаа. Түүнийг сонссон кафирууд ч хүртэл гайхан шагширдаг байв.

Куран судараа бас сайхан уншдаг хүн бол гэгээн Эбү Бакир (радиаллаху анх) байлаа. Намаз үйлдэхдээ Кураныг уншиж эхлэхэд өөрийгөө барьж үл дийлэн нүднээсээ нулимс унаган уйлдаг байв. Түүний энэ байдлыг харсан хүмүүс шагшин гайхдаг байлаа.

Таврат ба Инжил сударыг сайн мэдэх Абдуллах бин Селам (радиаллаху анх) мусульман болохоосоо өмнө жүүд эрдэмтэн байжээ. Тэрээр мусульман болсоныхаа дараагаар ийн өгүүлжээ: “Би Таврат (Тора) сударыг эцгээсээ сурсан билээ. Нэг өдөр аав минь надад удахгүй ирэх сүүлчийн элчийн дүр төрх шинж тэмдэгийг нэг нэгэнгүй надад зааж сургаж. Тэгээд хэрвээ тэр элч Харун пайгамбарын үр удмаас төрөх юм бол би түүнийг дагах болно эс бөгөөс дагахгүй!” гээд Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) Мединед нүүж ирэхээс өмнө нас барсан юм.

Аллахын элч (салаллаху алейхи уа сальлам) Мекке хотод өөрийгөө зарлаж эхлэхэд би түүний нэрийг бас ирэх цагийг нь урьдаас мэдэж байлаа. Тиймээс ч тэрнийг хүлээж эхэлсэн юм. Гэхдээ би энэ санаагаа бүх жүүдүүдээс нууж байлаа.

Намайг ийнхүү дотроо элчийг хүсэн хүлээж байхад нэгэн өдр Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) Мединед нүүж ирсэн байлаа. Би түүнийг харахын тулд цугласан олон мусульмануудын дундуур оров. Түүний ариун нүүр царайг харсан даруйдаа “Тэрний царай худалчын царай биш” гэж өөрөө өөртөө андгайлсан юм. Мухаммед элч хүмүүст ислам шашинийг номлож байлаа. Анх элчээс сонссон үг маань энэ билээ:

“Мэндийг хоорондоо түгээцгээ, өлсгөлөн хүмүүсийг цадгацгаа, сила-и рахим хийцгээ (ойр дотны хамаатан садангууддаа очицгоо), хүмүүс унтаж байх үед мөргөл үйдэцгээ. Ийнхүү диваажингийн хаалгаар орцгоо”

Хорвоогийн энэрэл болсон элч (салаллаху алейхи уа сальлам) намайг тэр олон хүмүүсийн дундаас таньж “Чи Медине хотын эрдэмтэн ибн-и Селам уу?” гэлээ. Би “Тийм ээ” гэж хариулахад элч: “Над руу ойрт” гэв. Тэгээд надаас ингэж асуулаа: “Аяа, Абдуллах! Аллахын нэрийн өмнөөс үнэнээ хэл! Таврат (Тора) сударт миний шинж тэмдэгийн талаар уншиж мэдсэн үү?” гэж асуув. Би түүнээс “Аллах эзэний бэлэг тэмдэг юу вэ? Надад хэлээч?” гэж асуухад минь элч хэсэг дуугүй суув. Яг энэ үед Жабрайл (алейхисальлам) сахиусан тэнгэр түүнд Ихлас сүрег авч ирсэн юм. Элч надад энэ сүрег уншихад би: “Тийм ээ,

Расулуллах, чи үнэн хэллээ!” гээд келиме–и шахаадатыг хэлэн мусульман болсон юм.

Намайг ислам шашинд орсоныг мэдээд жүүдүүд дээрэлхэж эхэлсэн юм. Зарим жүүд эрдэмтэд: “Арабаас элч төрөх учиргүй, тэр бол худалч нэгэн” хэмээн намайг ислам шашинаас гаргахыг оролдож байлаа. Харин би тэгэх тусам исламыг гүн гүнзгий ойлгон хамаатан садан найз нөхөдөө энэ зөв шашинд уриалан дуудаж байв. Намайг дагаад Салебе бин Сайе, Үсейд бин Сайе, Эсэд бин Үбейд (радиаллаху анхум) тэргүүдтэй хэсэг жүүд хүмүүс мусульман болсон юм.

Медине дахь анхны жилд болсон зарим үйл явдалууд

Мусульманчууд Мединед нүүж ирсэн анхны жилд Ансаруудаас Эсад бин Зурере, Бера бин Мамур, Күлсүм бин Хидм, мухажирүүдаас Осман бин Мазун нар нас барцгаав. Кафируудтай байлдах зөвшөөрөл олгогдов. Мөн Медине хотын агаар ба ус таараагүйгээс гэгээн Эбү Бакир ба Билал Хабаши нар (радиаллаху анхум) хүнд өвчин тусчээ. Тиймээс Аллахын элч (салаллаху алейхи уа сальлам): “Аяа, Аллах эзэн минь! Меккег хайралдаг шиг Мединег ч бидэнд хайрлуул, бас энэ хотод буян хишгээ харамгүй хайрлаач” хэмээн залбирдаг байв.

Анхны бичигдсэн гэрээ

Мекке дэхь мүшрикүүд ч Мухаммед элчид (салаллаху алейхи уа сальлам) хийж байсан дарлалаа Мединед ч гэсэн хийхийг эрмэлзэж байлаа. Медине рүү айлган сүрдүүлсэн захиа явуулж байсан шигээ Медине хот дахь Жүүдүүдэд ч гэсэн сүрдүүлгийн захиаг илгээж байлаа. Гэвч тэдний энэ балчимгүй явдал харин ч мусульмануудын хувьд сайнаар эргэн жүүдүүд Мухаммед элчид (салаллаху алейхи уа сальлам) ойр дотно болох шалтгаан болж байлаа.

Жүүдүүд Мухаммед элчид (салаллаху алейхи уа сальлам) ирээд “Та нартай найрамдахаар ирлээ, тиймээс нэг амлалт гэрээ хийцгээе” гэв. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) болон тэд тавин таван нөхцөлтэйгээр гэрээ хийцгээв.

1- Энэхүү гэрээ Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) зүгээс бас Меккегийн ба Мединегийн мусульмануудтай бас тэдэнтэй нэгдэгсэдтэй бас сүүлд нийлэгсэдтэй хамтаар

хийсэн нэгэн гэрээ юм.

2- Яах аргагүй энэ хүмүүс бусад хүмүүсээс өөр нэгэн бүлэг юм.

3- Бүх овгууд олзлогдсон хүмүүсээ суллах мөнгийг (мусульмануудын хооронд шийдсэнчлэн) төлцгөөх болно.

4- Мусульмануудын хооронд үл ойлголцох байдал үүсгэсэн хүмүүс өөрийн хүүхэд байлаа ч тэдэнтэй дайсан болох.

5- Жүүдүүдээс мусульман хүмүүстэй нэгдэгсэд ямар нэгэн зовлон шанлалд унахгүйтэй адилаар, тэдэнд туслалцаа үзүүлэх болно.

6- Жүүдүүд мусульмануудтай хамтран амьдарцгаах болно. Гэхдээ өөрийн шашинаа шүтэцгээнэ.

7- Жүүдүүдийн хэн нь ч Мухаммед алейхисальламын зөвшөөрөлгүйгээр цэргээ хаашаа ч гаргаж болохгүй.

8- Хэн ч гэрээ хийсэн хүмүүст муу зүйл хийхгүй байх.

9- Медине хотод энэ гэрээ хийгсэд цөм нэг нэгэн рүүгээ дайрч довтлохгүй байх

10- Меккегийн мүшрикүүдэд тус дэм бологсодод өршөөл үзүүлэхгүй байх

11- Медине хот руу дайрагсад руу мусульманууд болон Жүүдүүд нэгдэцгээх болно.

Жүүдүүдтэй хийсэн энэ гэрээнд заасанаар амьдарвал мусульман ба жүүдүүд хоорондоо эвдрэлцэхээс сэргийлэх байлаа.

Аяа, хайрт элч минь, битгий гунихар!..

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) нүүж ирэхээс өмнө Медине хотын даргаар Хазреж овгийн Абдуллах бин Үбей сонгогдох ёстой байжээ. Акабе хэлэлцээрийн дараагаар Хазреж ба Евс овгийнхны ихэнх нь мусульман болсон болохоор Абдуллах бин Үбей хотын даргаар сонгогдсонгүй. Тиймээс Абдуллах бин Үбей Мухаммед элчид (салаллаху алейхи уа сальлам) бас мусульмануудад нууцаар өширхөж эхэлжээ. Өөртэйгээ адил хэсэг хүмүүстэй нэгдэн мунафик (хоёр нүүртэй, бялдууч) болцгоожээ. Эд нар мусульмануудын хажууд байхдаа бид мусульман болсон гэгцгээх атал холдсоныхоо дараагаар тэднийг доромжлон инээлддэг байлаа. Тэд нууцаар яс хаяж эвдрэлийн очийг асааж байлаа. Тийм учраас Мухаммед элчийн

(салаллаху алейхи уа сальлам) айлдсан ариун сургаалийг өөрчилөн эсрэгээр нь хүмүүст хэлж эхэлжээ.

Харин жүүдүүд хэдийгээр дайсан байлаа ч Мухаммед элчид ирж гэрээ хэлэлцээрт гарын үсэг зурсан бөгөөд эрдэмтэн мэргэд нь маш хүнд хэцүү асуултыг Мухаммед элчид (салаллаху алейхи уа сальлам) тавихад Мухаммед элч ямар ч алдаа мадаггүй хариулахыг хараад жинхэнэ элч болохыг ойлцгоожээ. Тиймээс Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам): “Жүүд эрдэмтэдээс 10 хүн мусульман болсон бол бүх жүүдүүд мусульман болох байсан” хэмээн айлджээ. Хийсэн гэрээ хэлэлцээрийг сонссон зарим хөрш жүүдүүдтэйгээ найз нөхдийн холбоо тогтоосон байна. Энэ талаар Куран сударт ийн зарлиглажээ: “Хөөе, итгэн сүсэглэгчидээ! Шашин нэгт ахан дүүсээсээ өөр (кафир ба хоёр нүүртэнгүүдтэй) хэн нэгэнтэй битгий найзалцгаа! Тэд та нарт муу зүйл хийхээс, эвдрэлийн гал асаахаас өөр ямар ч сайн зүйл хийхгүй ба та нарыг зовж шаналахыг хүснэ. Тэдний өч хонзон ба дайсагнал нь амаар нь гадагш урсана. Өөрсдийн нуусан энэ дайсагнал нь бүр аймшигтай юм. Тэдний дайсагналын талаар ает илгээлээ. Хэрвээ ойлгох ба бодоцгоох юм бол...” (Али имран, 118)

Мунафикуудын ба кафируудын энэ байдал хурцдаж байлаа. Асхабууд харин энэ дайсагналын төлөө цусаа урсган байлдахыг хүсэж Аллах эзэндээ залбирах болжээ.

Харин Аллахын элч (салаллаху алейхи уа сальлам) ямар ч асуудал гарсан ширүүн тэмцэл өрнүүлэхгүйгээр тэвчиж байв. Учир нь түүнд дайтах зарлиг Аллагаас ирээгүй билээ. Гэвч одоо нэгэнтэй цаг нь болжээ. Жабрайл (алейхисальлам) сахиусан тэнгэр Аллагаас уахи (мэдээ) авч иржээ: “Та бүхнний эсрэг дайтахаар ирэгсэдтэй Аллахын замд дайтацгаа, гэхдээ ээрлэгшин довтолж, тамлан зовоохоос сэргийлцгээ. (та нартай дайтаагүй хүмүүст битгий хүрцгээ, дайтахдаа эмэгтэйчүүд, хүүхдүүд, хөгшчүүлийг бүү зовооцгоо) Үнэндээ Аллах эзэн хирээс хэтэрсэн хүмүүсийг үзэн яддаг билээ. Тэд нарыг (Меккегээс) хөөн гаргасны адилаар, та нар ч тэднийг хөөцгөө. Тэдний итгэл үнэмшил хүн алахаас ч муухай зүйл. Тэд нар Каабын хажууд та бүхэнтэй дайтах хүртэл та нар битгий дайрцгаа. Гэхдээ та нарыг алах юм бол та нар ч тэднийг алцгаа. Кафируудын (буруу номтнуудын) гэсгээл нь ийм юм. Хэрвээ тэд Аллахыг үгүйсгэхээс бас дайтахаа ч зогсооцгоовол (та нар ч зогсцгоо). Үнэндээ Аллах

эзэн бүхнээс энэрэнгүй билээ. (Бакара сүре, 190-192)

Анхны цэргийн нэгдэл

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) Медине хотын амгалан тайван байдлыг алдагдуулахгүйн тулд, дайсануудынхаа байр байдлыг хянан анхааралдаа байлгахын тулд хэсэг бүлэг хүмүүсийг тагнуулд томилжээ. Анхны энэ тагнуулуудын тоо таваас дөрвөн зуу хүртэл хүн байлаа. Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) оролцон толгойлсон дайныг Газа гэж нэрлэдэг.

Мүшрикүүдийн наймаа арилжаа ба эдийн засгийн хувьд шахаж боох нь тэдний зорилго байлаа. Тиймээс Сийр улсаас Меккег зорих торгоны замыг хаажээ. Медине хотын хажуугаар мүшрикүүдийн наймааны жингийн цуваа өнгөрч явааг сонссон Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) тэднийг зогсоох 30 хүнтэй нэгэн цэрэг бэлдээд толгойлогчоор нь гэгээн Хамзааг томилов. “Аллахын ариун замд, Аллахын нэрийг барин дайтацгаа! Аллахыг үл мэдэгсэдийг айлгацгаа...” хэмээжээ. Хамзаад цав цагаан туг өгчээ.

Гэгээн Хамзагаар толгойлуулсан цэргүүд 300 хамгаалагч бүхий мүшрикүүдийн жингийн цуваа руу хөдөлцгөөв. Энэ жин Шам хотоос Мекке рүү очих замд Сифр-ул-Вахр гэх газар ирэхэд мусульман цэргүүдтэй таарчээ. Энэ үед Мэжди бин ал-Жүхени тэдний хооронд оржээ. Мэжди бин ал-Жүхени бол хоёр талын холбоотон байлаа. Мусульманууд маш багаб харин мүшрикүүд их байхыг нь хараад яасан ч мусульманууд кафируудыг дийлэхгүйг ухааран хоёр талын хооронд ярилцсаар байгаад тэднийг дайтуулахгүй хоёр тийш болгожээ. Хамза тэргүүтэй цэргүүд Мединед буцаж ирэн учир явдалыг тайлбарлахад Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) маш их баярлан: “Межди зөв үйлдэл хийжээ” гэжээ.

Энэ цагаас хойш тагнуул туршуулууд олширчээ. Убейде бин Харис тэргүүтэй 60 хүнийг томилжээ. Мүшрикүүд эднээс айн амиа арайхан авч зугтаадаг байлаа.

Месжид-и Киблетейн (Хоёр зүгт месжид)

Хайрт пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) Мединед ирээд 17 сар өнгөрсөн байлаа. Энэ бүх хугацаанд тэрээр намаз (мөргөл) үйлдэхдээ Кудус хот ариун Бейт Макдис руу харан зогсдог байв. Энэ талаар мэдсэн жүүдүүд: “Энэ ямар сонин юм бэ? Шашин нь биднээс өөр хэрнээ мөргөх зүг нь биднийхтэй ижилхэн” хэмээн шивэр авир гэлцэх болжээ. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) энэ үгийг сонсон зүрхэн дотроо харуусна. Нэг өдөр Жабрайл (aleyхисальлам) сахиусан тэнгэр ирхэд Мухаммед элч: “Аяаб Жабрайл! Аллах эзэний, миний нүүрээ Жүүдүүийн Киблэ (зүглэх газар) рүү биш, ариун Каабын зүг харуулахыг хүсэж байна” гэжээ. Жабрайл (aleyхиссальлам): “Би бол зөвхөн нэг боол, энэ хүсэлтээ Аллахаас гуй” гэжээ. Энэний дараагаар Бакара сүрегийн 144-ает илгээгдсэн бөгөөд ийн айлджээ: “(Аяа, элч минь, уахи (мэдээ) авахын төлөө) тэнгэр өөд харан зог хүлээхийг чинь бид мэдэж байна. Тийм болохоор бид чамайг баярлуулах нэгэн зүгийг зааж өгнө. Одоо нүүрээ Месжид-и Харамын зүг (Каабын зүг) эргүүл, (хөөе, мусульмануудаа!) Та нар ч мөн адилаар хаана ч байсан ялгаагүй намаз (мөргөл) үйлдэхдээ тэр зүг (Каабын зүг) харцгаа. Ямар ч алдаа мадаггүй өөрт нь Куран судар өгөгдөгсөд энэ зүг рүү харцгааг. Эзэнийх нь хувьд үнэн болохыг тэд мадаггүй мэднэ. Харин Аллах эзэн бол тэдний хийсэн бүх зүйлийг сайн мэднэ” хэмээжээ.

Энэ аетүүд ирэх үед Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) асхабуудтайгаа үдийн мөргөл үйлдэж байлаа. Мөргөлийн дунд иржээ. Энэ мэдээг сонсонгуутаа тэр даруй Каабын зүг нүүрээ харуулан эргэцгээжээ. Асхабууд ч Мухаммед элчийг (салаллаху алейхи уа сальлам) даган эргэцгээв. Энэ месжидийг Месжид-и Киблетейн ба хоёр киблэтэй (зүг) месжид гэж нэрлэжээ.

БЕДИР ГАЗИ (ДАЙН)

Кафирүүдийн замыг тоссосоор асхабууд хожиж харин мүшрикүүд айх болжээ. Тэд жингийн цуваа явуулахдаа маш олон хамгаалагч цэрэг аль эсвэл бүр отог овгоороо явахаас өөр арга замгүй болсон байлаа. Нэг удаа мүшрикүүд айл болгоноос тэмээ хүн аван 100 тэмээтэй том жинг Шам хот руу илгээжээ. Тэднийг толгойлж Эбү Сүфиян гэх мүшрик явав. Тэр үед Эбү Сүфиян мусульман болоогүй байсан. Жинг хамгаалахаар 40 хамгаалагч байв. Жингийн мал зарагдсаны дараагаар бүх мөнгөөрөө дайнд хэрэглэх зэр зэвсэг худалдан авах ёстой байлаа.

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) энэ жингийн талаарх мэдээг авсан даруйдаа ямар учиртайг нь тагнуулахаар Мухажир (меккегийн мусульман) хэсэг бүлэг хүмүүсийг томилон явуулжээ. Тэд мүшрикүүдийг ямар учираас Шам орох гэж байгаа санааг мэдэн Мухаммед элчид (салаллаху алейхи уа сальлам) илтгэв. Хэрвээ мүшрикүүд зэр зэвсэгтэй байвал маш хүчирхэг болохыг ухаарсан Мухаммед алейхисальлам тэдний замыг тагнуулахаар Талха бин Абдуллах ба Сайд бин Зейд нарыг томилон явуулжээ.

Энэ боломжийг алдаж болохгүй байлаа. Тиймээс Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) замд бэлдэн Мединед намаз уншуулах хүнээр Абдуллах ибни Мектумыг томилон үлдээж мухажир ба ансаруудаас 305 асхабыг аван Рамазан сарын 12-ны өдөр Бедир гэх газар луу хөдөлжээ. Тэдний тоо Мединед ажил дааж аван үлдэгсэдийг нийлүүлбэл 313 хүн болж байлаа. Бедир бол Мекке, Медине ба Сийр хотын зам нийлдэг газар юм. Энэ дайнд оролцохын тулд шинээр сурсан хөвгүүд тэр бүү хэл эмэгтэйчүүд хүртэл Мухаммед элчээс (салаллаху алейхи уа сальлам) гуйж байлаа.

Саад бин Эби Ваккес ийн өгүүлнэ: “Мухаммед элчтэй хамт мөр зэрэгцэн байлдах анхны дайнд бэлдэж байх үед дайнд явахыг хүссэн олон хүүхдүүд ирж зөвшөөрөл гуйж байлаа. Энэ үед миний дүү Умейр нэг газар харагдахгүйг хичээн нуугдаж байгааг би анзаарав. Тэрээр 16 настай байлаа. Би: “Чи яагаад нуугдаад байна” гэж асуухад “Мухаммед элч намайг нас нь бага гээд дайнд авч явахгүй байх гэж айж байна. Үнэндээ би дайнд оролцон Аллах эзэний ариун замд амиа өгөхийг хүснэм” гэлээ. Би энэ үгийг сонсоод Умейрийг Мухаммед элчид хэлэхэд “Гэр

лүүгээ буц” гэлээ. Харин Умейр цурхиран уйлж эхлэв. Энэнийг харсан энэрэлт пайгамбар маань тэсэлгүй зөвшөөрсөн юм. Үнэндээ миний маш жаахан байсан болохоор түүнийг сэлмээ бүсэлхэд нь би тусалдаг байлаа.

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) ба түүний энэ цэрэг арми халуун нарыг үл ажигран Бедир лүү дөхөн очих үед мүшрикүүдийн Шамаас ирж буй жингийн цуваа ч ойртсон байлаа. Эбү Суфиян тэргүүтэй энэ жингийн цуваа Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) илгээсэн цэргийн отрядын мөрийг хараад өмнө цэрэг отож байх вий хэмээн айж эхэлжээ. Тэд явдалаа түргэгсэн улаан тэнгисийн хөвөөгөөр яван Меккед очихоор шийдэв. Дамдам бин Амр Гифариг тэнд байгаа мүшрикүүдэд мэдээ хүргүүлхээр Мекке хотын зүг явуулав.

Дамдам Меккед ойртохдоо өмссөн хувцасаа урж сийгээд, тэмээнийхээ тохомыг буруу эргүүлж тавиад тоос шороогоор нүүрээ будаад: «Амь авраарай! Амь авраарай!.. Туслаарай! Хурдлаарай! Бидний жингийн цуваа руу Мухаммед ба түүний хүмүүс дайрлаа. Хэрвээ та нар шалавлахгүй юм бол байгаа бүхнээ алдаж мэднэ” хэмээн орь дуу тавин Меккегийн гудамжаар гүйв.

Үүнийг сонссон Меккегийн мүшрикүүд цуглан дайнд бэлдэцгээв. 700 тэмээтэй, 100 морьтой, 150 явган хүн цуглацгаав. Эбү Лехебд “Алив, чи ч бас явна биз дээ” гэхэд тэрээр айсандаа өвчтөй байна гэж шалтаг тоочин өөрийнхөө оронд Ас бин Хишам гэх боолоо явуулжээ. Эбү Жахил маш их айж байсан атал өөрийг нь муу хэлэхээс эмээн явахаас өөр аргагүй байдалд хүрчээ.

Мүшрикүүдийн цэрэг маш их дуулга илд бамбайтай бөгөөд хажуудаа дуу дуулах бүсгүйчүүдийг авчээ, бас архи дарсаа ч авахаа мартсангүй. Тэд ийм их цэргээрээ 300 битгий хэл 1000 цэрэг байсан ч хурдан ялна гэж найдаж байлаа.

Энэ үед Эбү Сүфиян Бедирийн замаа өөрчилөн өөр нэгэн тойруу замаар Мекке хот руу ойртож байлаа. Аймшиг ард үлдсэнийг ойлгоод нэгэн хүнийг Меккегийн мүшрикүүд рүү илгээн “Хөөе, Курейшийнхэн! Бид жингийнхээ мал хөрөнгө бас бүх зүйлээ авран аюулаас зугтааж чадлаа. Тийм болохоор та нар буцацгаа, мусульманчуудтай байлдахаар Медине рүү битгий явцгаа” гэсэн мэдээг хүргүүлжээ.

Энэ мэдээг дуулаад мүшрикүүдийн толгойлогч Эбү Жахил “Бид Бедирт очоод 3 хоног, 3 шөнө тэмээ төхөөрөн архиа уун

хүүхнүүдтэйгээ наргиж хоноод буцацгаая. Бид юунаас ч айдаггүй баатар зоригтой болохыг харсан хүмүүс энэ өдрөөс хойш бидэн рүү дайрах гэсэн тэр бодлоо хаях болно. Хөөе, Курейшийн цэргүүд ээ, урагшаа!.." гэв.

Эбү Жахилийн энэ үгийг дуулсан Эбү Сүфиян маш их холч ухаантай байлдааны тактиктэй хүн байсан болохоор: "Курейшийн цэргүүд галзуурчээ... Энэ бол тэдний толгойлогч Эбү Жахилийн хэрэг юм. Тэр энэ байдалаар нэр алдар олохыг хичээж байна. Үнэндээ ийм ухаангүй байдал үргэлж хохирол авч ирдэг билээ. Хэрвээ тэд мусульмануудтай байлдвал дийлэгдэх вий гэж айж байна" гээд жингээ маш хурдан Меккед хүргээд өөрөө буцан давхисаар мүшрикүүдийн цэрэгт нийлэв.

Исламын цэргүүд Сафа гэх газар ирэхэд Меккегээс олон тооны цэрэг дайтахаар хөдөлсөн гэх мэдээг дуулав. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) асхабаа цуглуулаад энэ мэдээг хэлэн юу хийхээ зөвлөлдөв. Эбү Бакир Сиддик, Омар Фарук нар (радиаллаху анх) мүшрикүүдтэй байлдацгаая гэж санал гаргав. Мухажируудаас Микдад бин Эсвед босон: "Аяа, Расулуллах! Аллах эзэний зарлиг юу гэнэм түүнийг дага. Бид нар бүхий л үед чамтай хамт чамаас холдохгүй дагаж, Аллахын элчийг энэ шашиныхаа төлөө амь биеэ үл хайрлах болно" гэв. Микдадын энэ яриа Мухаммед элчийг (салаллаху алейхи уа сальлам) маш их баярлуулав.

Энэ үед Мединегийн мусульмануудын шийдвэр маш чухал байв. Учир нь цэргүүдийн ихэнх нь Мединегийн ардууд бөгөөд тэд Акабе гэрээнд Мухаммед элчийн зөвхөн Медине хотыг хамгаалахаа тангаргалсан билээ. Харин одоо тэд хотоос зайдуу гарсан бөгөөд юу гэж шийдэх нь хэцүү байлаа. Ансараас Саад бин Муаз босон: "Аяа, Расулуллах, би Мединегийн мусульмануудыг төлөөлж үг хэлмээр байна" гэв. "Аяа, пайгамбар минь! Бид чамд итгэсэн билээ. Аллахаас юу ч авч ирсэн ч бид түүнд ямар ч эргэлзээгүй итгэн залбирдаг билээ. Тийм болохоор чамайг дагана, сонсоно гэж ам өчигөө ч өгсөн юм. Бид тэр амлалтаасаа хэзээ ч няцахгүй. Та юу л гэж зарлиг буулганам бид таныг эсэргүүцэхгүй. Амиа бас эд хөрөнгөө энэ ариун замд өргөх болно. Аллах эзэндээ амлая, хэрвээ чи энэ тэнгис рүү үсэрвэл бид ч бас араас чинь үсрэх болно. Та биднээс юу л хүснэм бид хийхэд бэлэн байна. Амь биеээрээ чамайг хамгаалан дайсантай нүүр тулах болно. Аллахын хайр ивээл чамайг түшиг..." гэв. Энэ

үгийг сонссон асхабууд маш их баярлан зоригжицгооно. Цөм энэ үгийг хүлээн зөвшөөрч байгаагаа хэлцгээв. Хайрт пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) маш их баярлан нулимс унаган байж Саадын төлөө, асхабынхаа төлөө Аллах эзэндээ залбирав.

Ингээд айх аюулгүй болон зоригжиж мусульманууд дайсанууд хэдэн түм дахин их байсан ч хамаагүй дайнд амиа өгөхөд бэлэн болсон байлаа. Энэ зоригоороо ч Аллахын энэрэл, хайр ивээлийг хүртэх учиртай байв. Тэднийг Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) захирч байсан цагт айдас хүйдэс үгүй болон, хийж чадахгүй зүйл тэдэнд үгүй билээ. Хорвоогийн энэрэлт элч өөртөө гэсэн итгэл өвөрлөсөн зоригт дайчидаа хараад баярлан: "Алив, цэргүүд ээ хөдөлцгөөе! Аллах эзэний туслалцаанд баярлацгаа! Аллахын нэрээр андгайлан хэлье, би одоо Курейшийн мүшрикүүдийн цавчигдан унах тэр газрыг харж байна. Тэдний цогцосыг харж байна" хэмээн баярт мэдээг дуулгажээ. Энэ үгийг сонссон мусульманууд маш их зоригжин элчийн араас дагацгаав.

Сахиусан тэнгэрүүдийн туслахаар ирсэн нь

Бедирт хүрч очиход Жумагийн (баасан гариг) орой байлаа. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам): "Энэ жижиг толгодын хажууд байгаа худганд очвол нилээдгүй юм мэдэж авах гэж бодном" гэв.

Гэгээн Али (радиаллаху анх) хэсэг нөхдийн хамтаар Мухаммедын (салаллаху алейхи уа сальлам) хэлсэн тэр худганд хүрч очив. Тэнд Курейшийн тэмээчингүүд тэмээгээ услах ус авч байлаа. Тэд мусульмануудийг хараад зугтацгаав. Гэвч хоёрыг нь мусульманчууд барьж амжив. Энэ хоёр хүн бол Эшлем ба Ариз бин Эбү Ясир байлаа. Тэр хоёрыг Мухаммед элчид (салаллаху алейхи уа сальлам) авч ирэв. Мухаммед элч тэднээс "Мүшрикүүд хаана байна?" гэж асуухад "Энэ элсэн толгодын цаана бууцгаасан" гэв. "Тэд хэдүүлээ вэ?" гэж асуухад "Мэдэхгүй" гэгцгээв. Мухаммед элч "Нэг өдөрт хэдэн тэмээ идэж байна" гэхэд "Нэг өдөр 9-өөс 10 тэмээ идэцгээдэг" гэв. Мухаммед элч "1000-аас бага 900-аас их юм байна" гэв. "Тэнд Курейшийн томчуудаас хэн байна" гэж асуухад " Утбе, Шейбе, Харис Бин Амр , Эбү-л Бухтери, Хаким Бин Хузам , Эбү Жажил, Умейе бин

Халеф.” гэхэд “Ирж яваад замын голоос Мекке рүү буцсан хүн байгаа юу?” гэж асуухад тэд: “Тийм ээ, Бейн Зүхрэ овгийн Ахнес бин Эбу Шерик буцсан” гэв.

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) гэгээн Омарыг сүүлийн удаа сануулга өгүүлхээр Курейшийнхан луу гэрээ хийлгэхээр явууллаа. Омар Бин Хаттаб (радиаллаху анх) тэдэнд очоод: “Хөөе, мунхаг хүмүүс ээ! Аллахын элч (салаллаху алейхи уа сальлам) ингэж айлдаж байна: “Хүн бүр энэ ажилаа зогсооцгоо, гэр лүүгээ харьцгаа, ягаад гэвэл та нараас өөр хэн нэгэнтэй байлдах нь та нартай байлдахаас илүү буянтай үйл...” гэлээ гэв. Энэ үгийг сонсоод мүшрикүүдээс Хаким бин Хузам: “Хөөе, Курейш анд нар аа, Мухаммед бидэнд маш энэрэнгүй хандлаа. Түүний үгийг гүйцэлдүүлэн гэр гэртээ буцацгаая. Хэрвээ бид энэ удаа түүнийхээр болохгүй бол ахиж бидэнд ингэж энэрэнгүй хандахгүй байх гэж бодож байна” гэв. Эбү Жажил энэ үгийг сонсон маш их уурлан “Энэнийг хэзээ ч хүлээн зөвшөөрөхгүй. Бас мусульмануудаас өшөөгөө авч дуусталаа бид ухрахгүй” гэж хариулан гэгээн Омарыг буцаав.

Тэр орой мусульманууд худагний хажууд мүшрикүүдээс түрүүлэн ирж буудалцгаав. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) асхабуудтайгаа удирдах газар ба нуувчаа хаана байрлуулахаа зөвлөлдөн дайны тактик боловсруулав.

Гэгээн Хаббаб “Эцэг эхээ таны төлөө өргөө, Мухаммед элч минь! Бид нар дайнд мэргэшсэн улс билээ. Энэ Курейшуудийн буудалсан газрын хажууханд цэвэр тунгалаг устай нэг худаг байгаа. Бид тэр худагийг эзэгнэн авцгаая. Тэнд буудалцгаая. Тэгээд тэнд нэг жижиг цөөрөм үүсгье. Хажуу хавийн бүх худагийг бөглөн хаяхад тулалдааны үеэр цангагсад гүйж ирээд цөөрмөөсөө усаа уугаад дайтна, харин мүшрикүүд усгүй үлдэх болно. Энэ нь тэдний хүчийг сулруулах үндсэн хүчин болно” гэв. Тэр үед Жабрайл (алейхссальлам) энэ санаа зөв болохыг мэдэгдсэн ает буулгав. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам): “Аяа Хаббаб! Хамгийн зөв санаа бол чинийх байна” гээд босов. Мусульманууд цөм нөгөө худагны хажууд ирээд цөөрөм үүсгэв. Хажуу хавийн бүх худагийг бөглөж орхив.

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) цэргүүдээ 3 хэсэг болгон хувааж, мухажируудын тугыг Муаб бин Умейрд, Аус овгийн тугыг Саад бин Муазд, Хазраж овгийн тугыг Хаббаб бин Мүнзирийн гарт атгуулаад бүх цэргүүдээ гурван тугныхаа

доор 3 эгнээ болгон жагсаан зогсов.

Исламын цэргүүдийн баруун жигүүрийг баатар Зүбейр бин Аввам, зүүн жигүүрийг зоригт баатар Микдад бин Эсвэд хоёр (радиаллаху анхум) удирдан тулалдахаар болжээ.

Энэрэлт элч (салаллаху алейхи уа сальлам) цэргүүдтэйгээ тулааныг хэрхэн эхлэх талаар зөвлөлдөхөөр: “Яаж тулалдах вэ?” гэж асуухад Асим бин Сабит (радиаллаху анх) гартаа нум сумаа барин ийн хэлэв: “Аяа, Аллахын элч минь, дайсанууд бидэнд 100 метр ойртоход зогсолтгүй харвацгаая, тэд бидний шидсэн чулуу хүрэхүйц хэмжээнд ойртоход бид чулуу нүүлгэж эхлье, харин жаданд хүрэх төдий ойртоход жадаа хугартал сүлбье, дараа нь сэлмээ сугалан цавчилдацгаая” гэв. Энэ санаа Мухаммед элчид (салаллаху алейхи уа сальлам) таалагдсан тул цэргүүдээ дээрх хэлсэнчлэн зохион байгуулав. “Хүн бүр эгнээгээсээ битгий гарцгаа, зогсож буй газраасаа хөдлөлгүй тогтвортой байцгаа. Намайг тушаал өгөх хүртэл хэн ч эхлэж болохгүй, сумаа дайсан бидэнд ойртоогүй байхад харван үрж болохгүй, дайсанууд бамбайгаа нээсэн цагт л харваж эхэлцгээ, дайсан сайтар ойртсоны дараагаар чулуу нүүлгэж эхэлцгээ, ойртож ирэхэд нь жадаа хэргэлцгээ, дайсаны цээж ойртоход сэлмээ сугалан цавчилдцгаа...” гэв.

Ийнгээд тал бүртээ харуул тавьж мусульманууд амрахаар хэвтэцгээв. Учир нь тэднийг маргааш хүнд өдөр хүлээж байлаа. Харин хайрт пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) хурма модны сүүдэрт суун алгаа дэлгэн: “Аяа, Аллах минь! Та энэ нэг атга хүмүүсийг алуулах юм бол, үүнээс хойш таньд мөргөн залбирах хэн ч үлдэхгүй” хэмээн өглөө болтол залбирч хоножээ.

Тэр шөнө маш хүчтэй аадар бороо орсон болохоор үер бууж мүшрикүүдийг шавараар булж орхив. Харин мусульман цэргүүд өндөрлөг газар буудалсан болохоор тэд бороонд норх төдий л өнгөрөв.

Үүр хаяархад Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) асхабуудаа намаз (мөргөл) үйлдүүлэхээр сэрээв. Тэд өглөөний намаз (мөргөл) үйлдсэний дараагаар Мухаммед алейхиссальлам мусульмануудад Аллахын шашины төлөө байлдах ба үхлийн тухай сургаал айлдав.

Рамазан сарын 17-ны Жума (баасан) гаригийн наран манджээ. Хэсэг хугацааны дараагаар түүхэн дэхь хамгийн

хүнд, хамгийн чухал дайна эхэлнэ. Нэг талд хорвоогийн энэрэл болон илгээгдсэн Мухаммед (салаллаху алейхи уа сальлам) ба исламын төлөө өөрийн амь насаа өргөхдөө өчүүхэн ч үл эргэлзэх мусульманууд, нөгөө талд исламыг зогсоон, Аллах эзэний хайрт элч болсон хүнийг үгүй хийхийг хүссэн зэрлэг балмад буруу номтонгууд...

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) цэргүүдээ ахин нэг хянан хараад тэдэнд анхааруулах зүйлээ давтан хэлж, тэднийг зоригжуулав. Гэв гэнэт курейшийн цэргүүд толгодыг даван урсах ус адил давшин орж ирэв. Тэдний ихэнх нь хуяг дуулгатай агаад зэвсэг нь ч хүртэл мусульмануудынхаас илүү хүчтэй байлаа. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) гэгээн Эбү Бакирийн хамтаар майхандаа ороод алгаа дэлгэн: “Аяа, Аллах эзэн минь, курейш мүшрикүүд бүхий л хүчээрээ ирж явна. Чамайг үгүйсгэн намайг алахаар ирж явна. Аяа, Аллах минь! Надад амласан амлалт ба тусламжаа одоо хайрла, Аллах минь! Хэрвээ энэ нэг атга мусульмануудыг кафируудын гарт амь алдахыг заяасан бол энэ өдрөөс таньд мөргөн залбирах нэг ч хүн үлдэхгүй!” хэмээн залбирчээ. Аллах эзэн энэ тухай Куран сударт ийн өгүүлжээ. «(Бедир дэхь) энэ хүмүүс (мүшрикүүд) удахгүй эвдрэлцэн уй гашууд умбах ба хойшоо эргэж ч харалгүй зугтаана. Үнэндээ тэдний жинхэнэ гэсгээл, цээрлэл бол хойд ертөнцөд байна. Тэр үед гэсгээл цээрлэл илүү хүнд, илүү аймшигтай билээ” хэмээжээ. (Гамер сүре, 45, 46)

Тэр үеийн ёс жаягаар бол хоёр тал тулалдахаасаа өмнө баатаруудаа нэг нэгээр гарган тулалдуулдаг байв. Ингэж тэдний тулааныг хараад хоёр талын хүмүүс дайны уур амьсгалд орж өөрсдийгөө дайнд бэлддэг байв. Мүшрикүүдээс Арм бин Хадрами тэсэлгүй мусульманууд руу нэг сум тавьжээ. Энэ сум мухажируудаас Михжааг онон алсан тул түүний сүнс диваажингийн орон руу өөдлөв. Аллахын элч (салаллаху алейхи уа сальлам) анхны шахидын (Аллах эзэний төлөө амиа өргөсөн хүн) тухайд “Михжа бол шахидуудын ноён билээ” хэмээжээ. Энэ явдал асхабуудыг байж зогсоох газаргүй болтол уурлуулжээ.

Гэнэт мүшрик цэргүүдээс 3 хүн урагш сугаран гарах нь харагдав. Энэ хүмүүс бол: Утбе, түүний дүү Шейбе ба түүний хүү Велид нар юм. Тэд мусульмануудад хандан: “Та нар дотроос бидэнтэй тулалдах зоригтон байна уу?” гэж орилов. Асхабуудаас хамгийн түрүүнд гэгээн Эбү Хузейфе төрсөн эцэгтэйгээ

цавчилдахын төлөө эгнээнээс урагш гарахад Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) түүнд “Чи зогс” гэв. Мединегийн мусульман болох Муаз ба Мүаввез бас Абдуллах бин Раваха (радиаллаху анхум) гэх 3 хүн тулалдахаар сэлмээ сугалан гарцгаав.

Мүшрикүүд: “Та нар хэн бэ?” хэмээн тэдний өөрсдийгөө танилцуулахыг хүсэв. “Бид Мединегийн мусульманууд байна” гэхэд “Бид нар та нартай дайсагнаагүй, бидэнтэй Меккегийн Абдулмутталибын хөвгүүд тулалдаг” гэв. Тэд ислам цэргүүд рүү харан “Хөөе, Мухаммед, бидэнтэй манай нутгийнхнаас хүч тэнцэх хүнийг гарга” гэж орилов.

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) талбарт гарсан 3 цэргийг дуудаад цэргүүддээ хандан: “Хөөе, Хашимын хөвгүүд ээ босоцгоо! Аллахын шашиныг өөрийн мухар сүсэгээрээ дийлэхийг хүсэгчид энд иржээ. Шударга замд баатарлагаар байлдацгаа. Аллах эзэн энэний төлөө элчээ илгээжээ. Бос, Убейде! Бос, Хамза! Бос, Али” хэмээв.

Аллахын зоригт баатарууд болох Хамза, Али, Убейде нар (радиаллаху анхум) сэлмээ барин талбарт гарцгаав. Мүшрикийн 3 хүн: “Та нар хэн бэ? хэрвээ бидэнтэй эн тэнцэхүйц хүн бол бид тулалдая” гэцгээв. Тэд “Би Хамза, би Али, Би Убейде байна” гэхэд мүшрикүүд “Та нар бол бидэн шиг эр зоригтнууд байна. Гэвч биднийг дийлэхгүй, бид та нартай тулалдана” гэцгээв. Мусульманууд тэр гуравыг эхлээд ислам шашинд уриалан дуудсан үг хэлэв. Харин тэд хүлээн зөвшөөрөхгүй сэлмээ хуйнаасаа сугалан дайрав. Гэгээн Хамза ба Али Утбе ба Велид хоёрыг энэ тулаанд дийлж алав. Харин Убейде Шейбег шархдуулжээ. Шейбе ч Убейдег шархдуулав. Гэгээн Хамза ба Али Убейдед туслан Шейбег алж орхив. Тэр хоёр Убейдег тэврэн гэгээн элчийн өмнө ирлээ.

Убейдегийн (радиаллаху анх) гуянаас цус булигнан гоожино. Убейде: “Амиа чиний төлөө өргөв, аяа, элч минь! Хэрвээ би үхвэл шахид болох уу?” гэж асуув. Мухаммед элч “Тийм ээ, чи шахид” хэмээн түүний диваажинд орохыг нь мэдэгдэв. (Гэгээн Убейде дайнаас буцах замдаа нас барсан юм).

Энэ тулаанд 3 баатараа алдсан мүшрикүүд гайхан айж эхлэв. Тэднийг тайвшируулах гэсэн гэсэн Эбү Жахил: «Утбе, Шейбе, Велид нар яарч байгаад л үхчихлээ. Бид нар олон бас хүчтэй. Бид энэ дайнд мусульмануудыг бүгдийн алахаас нааш

буцахгүй” гэв.

Энэ үед мүшрикүүдийн дундаас хамгийн зоригтой бас хамгийн мэргэн нь болох Эбү Бакирийн хүү Абдуррахман талбарт гаран тулалдах хүн дуудав. Мухажирүүдын дундаас нэгэн хүн сэлмээ сугалан гарсан нь анхны мусульман, хүн төрөлхтөний дундаас элчийн дараах хамгийн дээд нь болох Эбү Бакир байлаа. Тэрээр хүүтэйгээ тулалдахаар гарчээ. Энэ үед Мухаммед элч: “Аяа, Эбү Бакир минь, чи бол миний харах нүд, сонсох чих минь болохоо мартаа юу? Зогс!” гэв. Харин Эбү Бакир өөрийн хүүд: “Аяа, хэдэр хэрцргий хүү, надад гэсэн хүндэтгэл чинь хаач ваа!” гэхээс өөр юу ч хэлсэнгүй.

Дараа нь Алладын элч тонгойн газраас нэг атга шороо аваад дайсанууд руугаа цацан: “Царай нь хар болог! Аллах минь, эдний зүрхэнд айдас өг, хөлийг нь чичрүүл!” гэв. Тэгсэнээ асхабууд руугаа эргэж харан “Босоцгоо, дайраад!..” гэж тушаав. Энэ үгийг сонсонгуудаа асхабууд урьд нь зэхэж төлөвлөсөний дагуу хөдөлцгөөж эхлэв. “Аллаху Акбар! Аллаху Акбар!” хэмээн сумаа харваж эхлэв. Алладын арслан гэгээн Хамза хоёр гартаа сэлэм барин цавчилдаж эхлэв. Гэгээн Али, Омар, Зубейр бин Аввам, Саад бин Эбу Ваккас, Эбү Дужане, Абдуллах бин Жахш нар (радиаллаху анхум) дайсаны цэргийн нэг талаас ороод нөгөө талаар нь нэвт цавчилдан гарч байв. “Аллаху акбар! Аллаху акбар!” гэх уриа тэнгэр ертөнцийг нүргэлүүлнэ. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) “Яа Хаюу, Яа Каюум” хэмээн залбиран довтолно. Гэгээн Али (радиаллаху анх) хэлэхдээ: “Бедир дайнд бидний дундаас хамгийн зоригтой нь, хамгийн баатар нь Алладын элч байсан юм. Дайсануудад хамгийн ойр, бас бүхнээс түрүүлж давшсан нь ч тэр билээ. Бид хэцүүдэх үед тэрний ард хорогддог байв” гэжээ.

Мүшрикүүдийн толгойлогч Эбү Жахилийг дундаа оруулцаав. Тэдний дундаас нэг хүн Эбү Жахил шиг хувцаслан түүнтэй ижил болж мусульмануудыг хуурахыг оролдож байв. Энэ хүн бол Абдуллах бин Мүнзир юм. Гэгээн Али Абдуллах руу довтлон Эбү Жахилийн өмнө толгойг нь тас цавчжээ. Энэ хувцасыг Эбү Кайс өмсжээ. Харин түүнийг Хамза алав.

Гэгээн Али нэгэн мүшриктэй тулалдаж байлаа. Нөгөө мүшрик түүнийг цавчихаар сэлмээ далайх үед Али урьтаж түүний мөрнөөс нь цээж хүртэл нь доош цавчихад төмөр хуяг цаас мэт зүсэгдэн мүшрик газар үхэтхийн унав. Элч (салаллаху алейхи уа

сальлам) мусульмануудаа ийн зоригтой тулалдаж байгааг хараад “Тэд бол Аллах эзэний газар дээрхи арслангууд юм” хэмээжээ.

Дайны хүч улам ширүүсч нэг мусульман руу хамгийн багадаа гурван мұшрик нэгэн зэрэг дайрч байлаа. Нэг хүн гурван хүнтэй нэгэн зэрэг цавчилдаж байхдаа огт эцэж цуцалгүй “Аллаху Акбар! Аллаху Акбар!” хэмээн уриагаа хэлэн давшилна.

Хэсэг хугацаанд мұшрикүүдийн хүч нэмэгдэн довтолход асхабуудын хүч мөхөсдөн удааширч эхлэв. Энэ үед Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) алгаа дэлгэн: “Аяа, Аллах минь! Надад амласан тусламжаа хайрла!” хэмээн залбирахад Аллахын уахи (мэдээ) илгээгдэв: “Энэ үед алгаа дэлгэн эзнээсээ тусламж ба ялалт гуйсан юм. Тэр эзэн та нарт: “Үнэндээ би ар араасаа цуварсан 1000 мелекүүдийн (сахиусан тэнгэр) армиар тусална” гээд залбиралыг чинь хүлээн зөвшөөрсөн билээ. (Энфал сүре, 9) Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) үсрэн босоод: “Баярт мэдээ, аяа, Эбү Бакир минь! Аллах эзэний тусламж ирж байна. Хар! Энэ бол Жабрайл (алейхисальлам). Элсэн толгодын оройд мориныхоо жолоогоо атган, зэвсгээ барин миний тушаалийг хүлээн зогсоно” гэв.

Ийнхүү Жабрайл, Микайл, ба Исафил (алейхумуссальлам) гэх сахиусан тэнгэрүүдээр толгойлуулсан мянга мянган сахиусан тэнгэрүүд Мухаммед элчийн баруун, зүүн, хойно нь байралцаав.

Жабрайл (алейхисальлам) толгойдоо шар өнгийн алчуур боожээ. Бусад сахиусан тэнгэрүүд цагаан өнгийн алчуур боосон бөгөөд цав цагаан морь хөлөглөсөн байлаа.

Сахиусан тэнгэрүүд дайнд оролцож эхлэнгүүт бүх зүйл өөрчлөгдөв. Мусульманууд дайсан руу гар далайж амжаагүй байхад тэдний толгойг биенээсээ тасран газар унаж байлаа. Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) урд хойно, бас ард талд нь огт танихгүй зүс үзээгүй хүмүүс байлдаж байлаа.

Эбү Жахилын үхэл

Мұшрикүүдийн туг барьсан хүн Эбү Азиз бин Умейр олзлогджээ. Харин Эбү Жахил курейшүүдийг зоригжуулахын тулд шүлэг уншиж чангаар орилож байлаа. Тэрээр залуу дайчин мэт давшилан “Энэ өдөрийн төлөө ээж минь намайг төрүүлсэн юм...” хэмээн орилно.

Асхабуудын нэг болох Муаз бин Амр урт сүүлтэй морь унасан Эбү Жахил руу дайран түүний хөлийг цавчив. Эбү Жахилийн хөл тасран газар унахад эцэгтээ туслахаар түүний хүү Икриме гэгээн Муаз бин Амр руу дайрав.

Яг энэ үед Муаз ба Муаввез хоёр хамтдаа өмнөө зогсох дайсаныг хөсөр унагаагаад Эбү Жахилд дөхөж очив. Тэд Эбү Жахилийг газар унаган маш олон удаа цавчив.

Энэ үед Муаз бин Амр (радиаллаху анх) Эбү Жахилийн хүү Икриметэй тулалдаж байлаа. Түүний гарыг цавчисан болохоор зүүн гар нь зөвхөн арьсандаа тогтоно санжигнана. Муаз бин Амрт гараа эмчилж боож байх зав байсангүй. Цавчигдсан гараа арьсандаа л тогтож байхад зогсолтгүй байлдаж байв. “Аллаху Акбар. Энэ юутай их хүч вэ! Энэ юутай их итгэл вэ! Энэ юутай их зориг вэ! Гэгээн Муазын хөдөлгөөнд дайрагдсан гар нь саад болж эхэлхэд тэрээр гараа гишгэж байгаад зулгаан тасдаж хаяв.

Билал Хабешийг (радиаллаху анх) халуун элсэн дээр тэнийлгэн хэвтүүлээд наранд улайссан чулуугаар цээжийг нь даран яргалж байсан Умейе бин Халеф мүшрикүүдийн хамгийн зэрлэг нь байлаа. Түүнийг харсан Билал Хабаши дайсаны цэргүүдийг сөрөн явсаар түүний өмнө очив. “Хөөе, заяа муут Умейе бин Халеф! Чи аврагдах юм бол би үхэх болно!” гээд дайрав. Тэрээр Умейегийн толгойг нүд ирмэхийн зуур цавчин тасдав.

Мүшрикүүдийн толгойлогч ба тэдний баатарууд нь цөм үхэцгээжээ. Тэд юу хийхээ мэдэхгүй ийш тийшээ хий дэмий л гүйлдэнэ. Асхабууд тэднийг хөөн хэсэг мүшрикүүдийг барин олзолжээ. Мухаммед элчийн авга ах Аббас олзлогсодын дунд байлаа.

Ялалт

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) асхабуудаасаа “Невфел бин Хувейлидыг харсан хүн байна уу?” гэж асуухад гэгээн Али “Расулуллах! Би түүнийг алсан” гэв. Энэ үгийг дуулаад Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) маш их баярлан “Аллаху акбар” хэмээгээд “Аллах эзэн тэрний талаарх миний залбирлыг биелүүлжээ” хэмээв.

Умейе бин Халефийн үхсэнийг дуулаад их баярлан: “Аллахдаа баярлъя! Миний эзэн намайг хүлээн зөвшөөрөн,

шашинаа дээдлэв” гэв.

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) шархадсан хүмүүсийн шархыг боож тэдэнд ус авч ирэн уулган үйлчилж байлаа. Мусульмануудаас шахид (шашиний төлөө амиа өгөгсөд) бологсодыг цуглуулаад мухажуудаас 6 хүн, ансаруудаас 8 хүн нас барсан байлаа. Нийт 14 хүнээ энэ дайнд алджээ. Харин мүшрикүүдээс 70 хүн үхэж нэлээд хэсэг хүн олзлогджээ.

Пайгамбар (салаллаху алейхи уа сальлам) ялалтын баярт мэдээг хүргүүлэхээр Абдуллах бин Реваха, Зейд бин Харисе нарыг (радиаллаху анхум) Медине хот руу илгээжээ.

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) шахид бологсодын жаназа намазыг (нас барьсан хүнд хийгдэх шашины үйлдэл) нь үйлдээд тэнд оршуулжээ.

Алагдсан мүшрикүүдээс 24-ыг нь ширгэсэн нэг нь худаг руу, үлдсэнийг нь нэгэн нүхэнд булж орхижээ.

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) асхабуудтайгаа худагны хажууд ирээд: “Хөөе, худаганд унагсад аа!” гэж орилоод үгээ үргэлжлүүлэн үхсэн мүшрикүүдийн нэрийг нь дуудан: “Хөөе, Утбе бин Рабия, Үмеййе бин Халеф, Эбү Жахил бин Хишам! Та нар элчийнхээ эсрэг боссон ямар муухай нүгэлтнүүд билээ. Та нар намайг үгүйсгэж байхад бусад хүмүүс намайг хүлээн зөвшөөрлөө. Та нар намайг төрсөн хотоос минь, төрсөн нутгаас минь хөөн гаргаж байх үед бусад нь надаа хаалгаа онгойлгон хүлээн авлаа. Та нар надтай дайтаж байхад бусад нь надад тус хүрэглээ. Миний эзэний амласан цээрлэлийг хүртэв үү? Би эзэнийхээ амалсан ялалтыг амслаа” гэв.

Гэгээн Омар (радиаллаху анх): “Аяа, Аллахын элч! Та үхсэн хүнтэй ярьж байна” гэхэд пайгамбар маань: “Намайг үнэнхүү элч болгон илгээсэн Аллахын өмнөөс ярьж байна. Тэд нар та нараас илүүтэйгээр намайг сонсож байна. Гагцхүү хариулж чадахгүй болохоос биш” хэмээв.

Мүшрикүүд дайны талбараас мусульмануудаас айн, ум хумгүй зугтахдаа авч ирсэн бүх зүйлсээ орхин оджээ. Энэ бүхэн мусульмануудын олз омог болжээ. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) энэ бүх дайны олзыг мусульмануудад ижил тэгш тараан өгөв. Энэ үед баярт мэдээг Мединед дуулгахаар явсан хоёр асхаб даваа гаригийн өглөө Мединед хүрчээ. Абдуллах бин Реваха нэг талаас, нөгөө талаас Зейд бин Харис айл айлын өмнө очиж чанга дуугаар ялалтын баярт мэдээг хүргэж байлаа.

Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) шүлэгчидийн нэг болох Абдуллах бин Реваха энэ баярыг гайхалтайгаар шүлэглэх нь хүн бүрийн сэтгэлийг баясган нулимсыг нь асгаруулж байлаа. Тэр өдөр Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) охин Рукайе (радиаллаху анха) нас баржээ. Нөхөр нь болох гэгээн Осман (радиаллаху анх) түүний жаназа (оршуулгын намаз) намазыг үйлдэн оршуулжээ.

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) ялалтандаа баярлан Аллах эзэндээ мөргөл үйлдсэнийхээ дараагаар цэргээ аван Медине рүү буцжээ.

Пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) Мединед авч ирсэн 70 олзны хүмүүсийг асхабууддаа тараан өгөөд сайн харж хандахыг захижээ. Тэр үед олзны хүмүүсийн талаар ямар нэг Аллахын зарлиг ирээгүй байлаа. Мухаммед алейхисальлам асхабуудтайгаа зөвлөлдсөний үндсэн дээр тэднээс мөнгө аван суллахаар тохиролцжээ. Харин хөрөнгө мөнгөгүй хэрнээ бичиг үсэг мэддэг олзлогсад 10 хүнд бичиг үсэг зааж сургасаныхаа дараагаар Мединегээс явж болно гэж тушаал гаргажээ. Олзлогсад дунд Мухаммед элчийн авга ах Аббас ч байлаа. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) Аббаст хандан: “Хөөе, Аббас! Чи дүүгийнхээ хүү Укейл бин Эби Талиб, Невфел бин Харисийг суллах мөнгийг төл! Чи бол баян хүн” гэв. Аббас: “Аяа, Расуллах! Би мусульман хүн билээ. Курейш мүшрикүүд намайг хүчээр дайнд дагуулсан юм” гэв. Мухаммед элч: “Чиний мусульман болсон болоогүйг Аллах л мэднэ. Хэрвээ чи үнэн хэлж байгаа бол Аллах эзэн гарцаагүй чамайг зовлонгоос салгана. Гэхдээ чи хэзээ ч мусульман шиг харагдаж байгаагүй. Тийм болохоор тэднийг суллах мөнгийг төлөх хэрэгтэй” гэв. “Аяа, Мухаммед! Надад байсан бүх 800 дархем мөнгийг та нар дайны олз болгон авсан шүү дээ” гэв. Мухаммед элч: “Аббас! Чи тэр алтнуудаа ягаад нуугаад байгаа юм бэ?” гэв. Аббас: “Ямар алт вэ?” гэв. Мухаммед элч: “Чи Меккегээс гарахаасаа өмнө эхнэр Үммү Фадлдаа өгсөн алтуудаа мартаа юу! Чи тэр алтыг өгөхөд та хоёроос өөр хэн ч байгаагүй. Чи эхнэртээ: “Энэ удаа надад юу тохиолдохыг би мэдэхгүй, үхчихэж магадгүй. Хэрвээ би эргэж ирэхгүй бол энэ алтыг хүү Фадлд, энэ алтыг Абдуллахд, энэ алтыг Үбейдуллахд, энэ алтыг Кусемд, энэ алтыг өөртөө үлдээ” гэж алт өгсөнөө санахгүй байна уу?” гэхэд гэгээн Аббас гайхан: “Тэр үед бид хоёрын хажууд хэн ч байгаагүй билээ, чи яаж мэдэв?” гэхэд

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам): “Аллах надад мэдэгдлээ” гэв. Аббас: “Чамайг Аллахын элч гэж би чин зүрхнээсээ итгэлээ” хэмээн мусульман болжээ. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) түүнийг Мекке хот дахь бие төлөөлөгчөөр томилон тэнд байгаа мусульмануудыг хамгаалж, Исламын дайсануудын талаарх мэдээг илгээж байхаар томилов.

Олзлогсодыг мөнгөөр суллаж болох талаар мэдээг Мекке хотод хүргүүлэв. Тэдний дундаас Мухаммед элчийг Меккед байхад маш их дээрэлхэн дарамталж байсан Надир бин Харис ба Мухаммед элчийг намаз (мөргөл) үйлдэж байхад тэмээний гүзээтэй баас мөрөн дээр нь асгасан Укбе бин Эбу Муаит хоёрын толгойг цавчив.

Бедир дайны ялалт мусульмануудын хувьд маш их баяр байсан төдийгүй тэдний бие биенээ гэсэн итгэл сэтгэлийг улам лавшруулжээ. Харин мүшрикүүдийн хувьд сэтгэл санаа эд материалын хүнд цохилт байв. Хабешстаны хаан Нежаси Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) ялалтыг сонсоод нутагтаа байх мусульмануудыг цуглуулан “Аллах эзэндээ хязгааргүй баярла. Мухаммед элч Бедир дайнд ялалт байгуулжээ” хэмээн баярт мэдээг дуулгажээ.

Гэгээн Али ба Гэгээн Фатима хоёрын хурим

Их нүүдэлийн хоёр дахь жил байлаа. Хорвоогийн энэрэлт элчийн (салаллаху алейхи уа сальлам) хайрт охин гэгээн Фатима 15 нас хүрчээ. Нэгэн өдөр Фатима охин нэг ажил хийхийн тулд Мухаммед элчийн хажууд иржээ. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) түүнийг хадамд гарах цаг ирсэнийг ойлгожээ. Тэр өдөрөөс хойш Мухаммед алейхиссальламын охинийг бэр гуйгсад олон иржээ. Харин Мухаммед элч хэнд нь ч өгсөнгүй “Түүний хадамд гарах нь Аллах эзэний зарлигаар болно” гэдэг байв.

Нэг өдөр Эбү Бакир, Омар бас Саад бин Муаз нар (радиаллаху анхум) месжидэд сууцгаан ийн ярилцана. “Гэгээн Фатимаг Алигаас бусад бүх хүн гуйлаа, хэнд ч өгсөнгүй” гэгцээнэ. Эбү Бакир: “Түүнийг Алитай гэрлүүлэх байх гэж бодож байна. Бүгдээрээ Алид очиж энэ талаар ярилцъя. Хэрвээ хурим хийх хөрөнгөгүй бол туслая” гэв. Саад: “Аяа, Эбү Бакир минь, чи үргэлж сайн зүйл хийдэг билээ. Босоцгоё, чамтай хамт очъё”

хэмээн тэр гурав Алигийн гэрт очигдоо. Али (радиаллаху анх) тэмээгээ голын эрэг дээр услаж байлаа. Эбү Бакир, Омар, Саад (радиаллаху анхум) гуравыг хараад угтан босоод мэнд усаа мэдэлцсэний дараагаар Эбү Бакир: “Али, найз минь! Чи үргэлж сайн үйлсийн эзэн билээ. Мухаммед элчийн хувьд чиний орон зай дээд нь юм. Гэгээн Фатимаг чамаас бусад бүх хүн бэрээ болгохоор гуйлаа хэнд нь ч зөвшөөрсөнгүй. Энэ хүн чинийх болох байхаа гэж бид бодоцгооно. Чи яагаад гуйж болохгүй гэж” гэхэд гэгээн Алигийн нүдэнд нулимс цийлэгнэн: “Аяа, Эбү Бакир! Намайг бүр ч илүүтэйгээр зовоолоо. Түүнийг хэн хүнээс ч илүү хайралдаг хүн би билээ. Гэвч миний энэ ядуу амьдрал боломж өгдөггүй” гэв. Гэгээн Эбү Бакир “Ингэж ярьж болохгүй дүү минь, Аллах ба түүний элчийн хувьд хөрөнгө мөнгө чухал биш, оч, Фатимааг эцгээс гуй!” гэв.

Гэгээн Али (радиаллаху анх) ийн өгүүлжээ: “Би ичиж зовсон байдалтайгаар Мухаммед элчийн өмнө бараалхлаа. Мухаммед элчийн хажууд суусан боловч сандарсандаа ярих тэнхэл надад байсангүй. Мухаммед элч надаас урьтаж: “Ямар ажилаар явна, Али минь? Асуух зүйл байна уу?” гэв. Би дуугүй л доош харан хуруугаараа оролдож суулаа. “Чи Фатимааг гуйхаар ирээ юу?” гэхэд нь би “Тийм ээ” гэлээ. (Мухаммед элч гэгээн Фатимад Али түүнийг гуйхаар ирсэнийг хэлэхэд Фатима дуугарсангүй) Мухаммед элч “Фатимад мөхир (инж) болгож өгөх юм байна уу чамд?” хэмээв. Би: “Надад түүнд өгөх нэг их зүйл алга даа, пайгамбар минь!” гэлээ. “Чамд өгсөн хуягт хувцас байгаа юу?” гэж асуулаа. Би: “Надад байгаа” гэхэд “Түүнийг зар, тэр мөнгө мөхир (инж) болоход хүрэлцээтэй” гэлээ.

Гэгээн Али (радиаллаху анх) гэрлэх хүртэлээ Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) гэрт амьдардаг байлаа. Мухаммед элчийн хэлсэнчлэн Месжид-и Небевигийн хажууханд гэгээн Айше эхийн гэрийн харалдаа орших Харисе бин Нуманы гэрийг түрээслэжээ. Али (радиаллаху анх) хуяг дуулгаа гэгээн Османд 480 дирхемаар заржээ. Харин Осман түүнийг эргүүлээд Алид бэлэглэжээ.

Гэгээн Али хуяг дуулгаа бас дирхемээ аван Мухаммед элчид ирэхэд Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) маш их баярлан Османы төлөө залбирчээ: “Осман бол диваажин дахь миний найз мөн” гэжээ. Дараа нь гэгээн Билалыг дуудан ирүүлээд хэсэг мөнгө өгөн: “Энэ мөнгийг аваад захад оч! Тэндээс

хэсэг цэцгийн ус бас зөгийн бал худалдан ав. Месжидэд цэвэрхэн нэгэн тавганд цэцгийн ус ба зөгийн балыг найруулан ундаа хий. Никах (гэрлэлтийн баталгаа) хийсэний дараагаар ууцгаая. Ансар ба мухажируудаас хэн л байна, бүгдийг нь месжидэд дууд. Фатима Али хоёрын хурим болохыг хүмүүст зарла” гэж тушаав.

Билал (радиаллаху анх) Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) хэлсэнчлэн гэгээн Али ба Фатима хоёрын гэрлэх ёслол болох гэж буйг хүмүүст зарлав. Асхабууд месжидийн дотор гадуургүй дүүрэн хүн ирсэн байлаа. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) босон: “Бүхий л талархал ба магтаал хорвоогийн эзэнд хамааралтай билээ. Тэр хайралсан буян хишигээрээ магтагдан дуусашгүй хүч чадалдаа мөргөгдсөн, гэсгээл ба шүүлтээрээ айлгагдсан, өөрийн эзэгнэл ба хүчээрээ хорвоо ертөнцийг захирагч нь билээ. Бүхий л зүйлийг бүтээсэн, шударга байдал ариуг санааг түгээгч, тэр хүмүүсийг (Ислам) шашин ба элч Мухаммедээрээ (алейхиссальлам) гийгүүлсэн бурхан билээ...

Аллах Теала надад охин Фатимагаа Али бин Эби Талибтай гэрлүүл гэж зарлигласан, одоо та нар гэрч болцгоо, (Аллахын зарлиг ёсоор) 400 мискал мөнгөн зоосоор инж болгон Фатиماغ Али бин Эбу Талибтай гэрлүүллээ. Эзэн минь, тэднийг буян хишигээр арвижуулж нэг нэгэндээ аз жаргал бэлэглэгч болго. Аллахаас өөрийн төлөө, та нарын төлөө уучлал хүсье” хэмээв.

Гэрлэх ёслол болсоны дараагаар Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) асхабуудад хурма жимс тараан “Алив, энэ хурмаагаас авцгаа, идэцгээ” гэв. Билал (радиаллаху анх) зөгийн бал ундааг хүмүүст тараан дайлав. Асхабууд: “Барекаллаху фи кума ве алейкум ве жамега шемлакума” хэмээн залбирав.

Гэгээн Фатима гэрлэх ёслолын дараагаар уйлж байхыг хараад Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) түүний хажууд очин: “Хайрт охин минь! Юунд уйлна вэ? Би чамайг мусульмануудын хамгийн эрдэмтэй бас зан ааш, үнэнч байдалаараа бүхнээс илүү ба анхны мусульман нэгэн хүнтэй гэрлүүллээ” хэмээв. Гэгээн Фатима: “Аав минь! Гэрлэсэн хүүхнүүдийн хувь заяа нь инж болох алт, мөнгөөр цэгнэгддэг билээ. Миний инж алт мөнгөөр цэгнэгдсэн бол элч болох та бусадаас юугаар ялгагдах билээ. Хойд ертөнцөд та хичнээн хүнд хайр энэрэлээрээ туслана, би тэд нарын эхнэрүүдэд тусалмаар байна. Энэ бол миний хүсэл зорилго билээ” хэмээв.

Аллах эзэн Фатимагийн энэ хүсэл биелэгдэх болно гэдэгийг Мухаммед элчид (салаллаху алейхи уа сальлам) мэдэгдэхэд, Мухаммед элч: “Фатима минь! Чи элчийн охин болохоо энэ үгээрээ мэдэгдүүлээ” хэмээн баярлажээ.

Гэгээн Али (радиаллаху анх) ийн өгүүлжээ: “Бидний хурим болсоноос 4 хоногийн дараа гэгээн элч (салаллаху алейхи уа сальлам) манайд зочлов. Зүрхийг уярааж элэг дэвтээсэн сайхан сургаалаа бидэнд айлдлаа. Дараагаар нь надад: “Аяа, Али ус авч ир!” гэв. Би босоод нэг аягатай ус авч ирэхэд “Энэ усны талыг нь уу, талыг нь үлдээ” гэлээ. Би хэлсэн ёсоор хийхэд үлдсэн усыг нь миний толгой руу бас цээж рүү цацлаа. Ахиад “Ус авч ир” гэв. Би ахиад ус авч ирлээ. Надад хийсэн шигээ Фатимад ч гэсэн мөн адилаар үйлдэв. Дараа нь намайг гадагш гаргалаа.”

Түүнийг гарсаны дараагаар охиноосоо гэгээн Алигийн талаар асуулаа. Фатима: “Эцэг минь! Бүхий л сайхан зан чанар түүнд бий. Гэхдээ зарим Курейш эмэгтэйчүүд надад “Чиний нөхөр ядуу хүн” гэлцэх юм” гэхэд Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) ийн айлджээ: “Аяа, охин минь! Чиний эцэг бас нөхөр чинь ядуу хүмүүс биш. Хамаг дэлхийн алт эрдэнэс, баялагыг надад санал болгосон билээ. Би хүлээн зөвшөөрөөгүй, зөвхөн Алладын хувьд хамгийн үнэтэй зүйлийг сонгох юм. Аяа, охин минь! Хэрвээ миний мэдэж буйг чи мэддэгсэн бол! Хорвоо ертөнц чамд ямар их атаархдаг гэж! Алладын хувьд чиний нөхөр хамгийн анхдагч асхабуудаас билээ. Ислам шашинд том орон зай түүнийх, мэдлэг оюунаараа маш агуу билээ. Охин минь! Аллах эзэн хоёр хүнийг ариун Каабын эзэдээс сонгосон билээ. Нэг нь би нэг нь чиний нөхөр Али, түүнийг хайрла, түүний үгийг үргэлж дага” гэв.

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) Алиг дуудан оруулаад түүнд охиноо ийн захьжээ. “Аяа, Али минь! Фатимаг жаргуул, тэр бол миний нэг хэсэг, түүнийг баярлуул, хэрвээ түүнийг гомдоовол намайг гомдоосонтой ижил” хэмээв. Тэр хоёрыг Аллахдаа даатган залбираад гарахыг завдан босоход Фатима “Аяа, Алладын элч минь! Гэр доторхыг би хийнэ, гадуурхыг Али хийнэ, та надад нэг туслагч эмэгтэй өгөөч, би их баярлах болно” гэхэд Алладын элч “Аяа, Фатима, чамд ажилчинаас сайн зүйл өгөх үү? Эсвэл ажилчин өгөх үү?” гэхэд

Фатима эх: “Ажилчинаас сайн зүйл өгөөч” гэв. Алладын элч: “Үдэш бүр унтахаасаа өмнө 33 удаа «Сүбханаллах», 33 удаа

«Алхамдүлиллах», 33 удаа «Аллаху Акбар» гээд төгсгөлд нь «Ла илаха иллаллаху вахдаху лаа шарика лах, лахул мүлкү вэ лахул хамдү ве хува алаа күлли шайн кадийр» гэж хэл. Энэ бүхэн 100 үг юм. Хэрвээ ингэж хийвэл хойд ертөнцөд 1000 хасене (буян) олж, дэнсэлхэд буян чинь их болно” гэжээ.

Гэгээн Али ба Фатима нарын сүй тавих ёслол хижретээс (их нүүдэлээс) 5 сарын дараагаар, харин хурим нь Бедир дайны дараа болжээ.

Кааб бин Эшрефын үхэл

Бедирийн дайнд мусульманчуудын ялалт тэнд байх жүүдүүд ба мүшрикүүдийг айлгажээ. Зарим жүүдүүд: “Шинж тэмдэг нь бидний судар Тэвратад (Тора) бичигдсэн элч бол энэ хүн мөн. Үүнээс хойш түүний эсрэг зогсох боломжгүй. Учир нь тэр үргэлж ялах болно” хэмээн мусульман болцгоож байв. Харин зарим нь “Мухаммед байлдаж сураагүй Курейшийнхантай байлдаад арга замаар дийлжээ. Хэрвээ бидэнтэй дайтсан бол түүнд хэрхэн дайтахыг, хэрхэн ялахыг харуулах байлаа” хэмээн бардамнана.

Кааб бин Эшреф гэх нэгэн жүүд Бедирт исламын цэрэг ялсаныг сонсоод, мусульмануудад өшөөрхөн Медине рүү явжээ. Тэнд байж мүшрикүүдийг цуглуулаад Мединег дайлаар морьдох шүлэг хэлж тэднийг энэ дайнд уриалан дуудаж байв. Тэднийг дайнд явахыг ятгаж дараагаар нь Мухаммед элчийг (салаллаху алейхи уа сальлам) алах төлөвлөгөө зохиожээ. Аллах эзэн энэ тухай Мухаммед элчид хэдийнээ мэдэгджээ. Тиймээс Куран сударт: “Тэд нар Аллахын хараал зүхэлийг хүртэгсэд мөн...” (Ниса сүре, 52)

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) асхабуудаа цуглуулан: “Кааб бин Эшрефийг хэн алах вэ? Тэр Аллах эзэн ба түүний элчийг доромжилжээ” хэмээв. Мухаммед бин Меслеме: “Аяа, Аллахын элч минь! Би тэрнийг алахыг хүсэж байна уу?” гэхэд Аллахын элч: “Тиймээ, хүсэж байна” хэмээв. Мухаммед бин Меслеме хэдэн хоног энэ ажилыг гүйцэлдүүлэхээр бодолгоширон төлөвлөгөө боловсруулжээ. Энэ төлөвлөгөөгөө найзууд болох Эбү Найле, Аббас бин Бишр, Харис бин Эвс, Эбү Абс бин Жебир нарт хэлэхэд тэд хүлээн зөвшөөрч “Хамтдаа энэ ажилыг гүйцэлдүүлцгээе” гэв.

Тэдний боловсруулсан төлөвлөгөө нь бол Кааб бин Эшрефийн цэргүүдийн дотор орж түүнийг алах явдал юм. Мухаммед бин Меслеме (радиаллаху анх) найзуудынхаа хамтаар Кааб руу очигцооно: “Энэ Мухаммед биднээс өргөл барьц гэж маш их зүйл хүсэж байна. Тиймээс чамаас зээл авахаар ирлээ” гэгцгээв. Кааб баярлан тэднийг өөрийн талд байна гэж бодон: “Тэр та нарыг шулж байна” гэв. Мухаммед Меслеме: “Анх бид түүнд итгэж даагна гэж андгай өгчихсөн. За яахав, юу болохыг нь хүлээж л байя. Чи бидэнд зээл өгөөч” гэв. Кааб: “Болно, гэхдээ та надад барьцаа өгөх ёстой” гэв. Мухаммед Меслеме “Юуг барьцаанд өгөх билээ” гэж асуухад Кааб “Эхнэрүүдээ барьцаанд тавьцгаа” гэв. Мухаммед Меслеме: үгүйсгэн “Бид эхнэр хүүхэдээ барьцаанд тавихгүй, харин өөрсдийн зэр зэвсэг, хуяг дуулгаа барьцаалы” гэв. Кааб үүнийг зөвшөөрөн тэднийг хэзээ ирж мөнгөө авч болохыг нь хэлэв.

Мухаммед бин Меслеме Эбү Найлегийн хамтаар нэг орой Кааб бин Эшреф рүү очжээ. Кааб бин Эшреф тэдэнтэй уулзахаар гарлаа. Эхнэр нь: “Энэ орой болсон хойно хаашаа гарч байна вэ? Чиний найз болох Мухаммед бин Меслеме нараас болгоомжил, тэд сайн санаа өвөртлөөгүй мэдээж” гэв. Кааб бин Эшреф: “Бүх зүйл чиний бодсон шиг биш ээ, Мухаммед бин Меслеме ба түүний дүү Найле нар сайн хүмүүс. Би тэд нарыг өөртөө татаад Мухаммед элчийг алахад ашиглах болно” гэв. Мухаммед бин Меслеме ба Эбү Абс бин Жабир, Харис бин Эвс, Аббад бин Бишр (радиаллаху анхум) Кааб бин Эшрефийн цайз бэхлэлтэнд нэвтэрчээ. Мухаммед бин Меслеме найзууддаа: “Каабыг ирэхэд би түүний гоё үнэрийг нь үнэрлэе гээд толгойг нь барьж үнэрлэнэ, намайг сайн ойртоод толгойг нь сайн барьж авсаны дараагаар та нар цавчицгаа” гэж хэлэв. Кааб бин Эшреф гоё хувцасаа өмсөн, үнэртэн түрхжээ. Мухаммед Меслеме: “Ямар гоё үнэр вэ? Одоог хүртэл ийм үнэр огт үнэртсэнгүй” хэмээн Каабад дөхөж очив. Кааб: “Арабын хамгийн гоё энгэсэгүүд миний хажууд байдаг юм” хэмээн онгиров. Мухаммед Меслеме: “Таны толгойг үнэрлэж болох уу?” гэв. Кааб зөвшөөрөн толгойгоо өгөхөд Меслеме толгойг нь барингуудаа найзууддаа дохио өгөхөд хоёр сэлмээр хүзүүнд буулгав. Кааб маш хүчтэй орилсон боловч үхсэнгүй. Мухаммед Меслеме (радиаллаху анх) чинжаал хутга гарган түүнийг зүйл дуусгав. Мусульманууд үтэр түргэн зугтаан Мединед хүрчээ. Энэ баярт мэдээг Мухаммед элчид мэдэгдэхэд тэрээр Аллахдаа

баярлан Мухажируудын төлөө залбирчээ.

Кааб бин Эшрефийн үхэл жүүдүүдийг айлгажээ. Учир нь Кааб шиг зоригт дайчинийг алж чадсан юм чинь тэднийг хороох нь гарын үзүүр хөдөлгөх ажил төдий хэмээн бодоцгооно. Жүүдүүд өглөө нь цугларцгаан Мухаммед элчид (салаллаху алейхи уа сальлам) бараалхав. Каабын үхлийн талаар түүнд гомдолход Мухаммед элч: “Кааб бин Эшреф бидний амгалан тайван байдалыг алдагдуулж, биднийг доромжилон шүлэг бичдэг байсан. Мэдэж авцгаа, хэрвээ та нараас хэн нэг нь ийм болчимгүй зүйл хийх юм бол түүний хариу нь сэлэм байх болно” хэмээв. Энэ аюулт мэдээг дуулаад жүүдүүд Мухаммед элчтэй (салаллаху алейхи уа сальлам) дахин шинэ гэрээ байгуулцгаав.

Бени Кайнукагийн жүүдүүд

Нэг өдөр Бени Кайнука хороололын жүүдүүд мусульман эмэгтэйг доромжилон тогложээ. Энэ явдалыг харсан асхабуудын нэг сэлмээ сугалан тэр жүүдийг алж орхижээ. Харин жүүдүүд бүлэглэн тэр асхабыг шехид (шашиний төлөө амиа өргөх) болгожээ. Энэ эмгэнэлт мэдээг Мухаммед элчид (салаллаху алейхи уа сальлам) дуулгав. Пайгамбар маань жүүдүүдийг Кайнука захад цуглуулаад: “Хөөе, жүүд хүмүүс ээ! Та нар Аллах эзэний Курейш овгийнхонд хийсэн гэсгээл мэт гэсгээлээс айж мусульман бологтун! Намайг Аллах эзэний илгээсэн элч болохыг сайн мэдэх бус уу?” хэмээв.

Ийнхүү тэдэнд энэрэл үзүүлсэн ч гэрээгээ цуцалсан жүүдүүд: “Хөөе, Мухаммед, дайтаж чадахгүй хэсэг хүмүүст жүүдүүд бууж өглөө гэж битгий бод! Чи бидэнтэй байлдаж эхлэх тэр мөчид л өчнөөн олон баатаруудыг харах болно...” хэмээн онгирч доромжилж эхлэв. Ийнхүү мусульмануудтай хийсэн гэрээгээ өөрсдөө эвдсэн тул Жабрайл (алейхиссальлам) Аллахын уахиг (мэдээ) буулгав. “(Аяа, элч минь!) Хэрвээ (чамтай) гэрээ хэлэлцээр хийсэн хүмүүс эсэргүүцэн (хэлэлцээрээсээ өөр зүйл хийвэл) зогсвол (дайтахаасаа өмнө) үнэн шударгаар гэрээ хэлэлцээрээ эвдсэнийг тэдэнд мэдэгд. Үнэндээ Аллах тагала бялдуучуудыг үзэн яддаг билээ. (Энфал сүре, 58)

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) хэсэг цэргүүдээ аваад Кайнука хороолол дахь жүүдүүд рүү очив. Цагаан тугаа гэгээн Хамзад бариулжээ. Мусульман цэргүүд хороололыг

бүслэлтэндээ авахад “Бид дайчин хүмүүс” хэмээн онгирч байсан жүүдүүд байлдах нь бүү хэл ганц ч сум харвах сөхөөгүй болтолоо айж сандарчээ. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) тэдний орох гарах газрыг хараандаа аван тэднийг бүслэлтэнд 15 хоног барьжээ. Жүүдүүд мусульмануудад бууж өгөхөөс өөр аргагүй болсон байлаа. Гэрээг эвдсэн хүмүүсийг алах ёстой байтал хамгаас энэрэлт элч (салаллаху алейхи уа сальлам) тэднийг өршөөн цагаатгажээ. Ийнхүү Кайнука дахь жүүдүүдийг Шам хот руу нүүх зөвшөөрөл өгчээ. Ийнхүү тэд Мединегээс хөөгдөв.

Энэ үед зекет (өргөл барьц, эд хөрөнгөнийхөө тодорхой хэсгийг ядуу мусульмануудад өгөх) өгөх ёстой хэмээн зарлиг бууж, буяны өргөл өгөх, ба айт (тахилийн ба мацагийн баярын мөргөл) мөргөл үйлдэх, тахил өргөхийг зарлиглажээ. Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) охин Үммү Гүлсэмийг гэгээн Османтай гэрлүүлжээ. Өөрөө Зейнеф бинти Жахш ба гэгээн Омарын охин Хафаза нартай гэрлэх ёслол үйлджээ. Гэгээн Алигийн хүү Мухаммед элчийн зээ Хасан хорвоод мэндэлжээ.

УХУД ДАЙН

Меккегийн мүшрикүүд Бедир дайнд ялагдсандаа сургамж аваагүй шигээ энэ ялагдлаа мартаж хүлээн зөвшөөрч чадахгүй байлаа. Курейш овгийнхон хамгийн сайн толгой хүмүүсийг энэ дайнд алдсан юм. Бас Шам хот руу явах наймааны зам нь мусульмануудын гарт орсон нь тэднийг маш их уурлуулж байлаа.

Саффан бин Үмеййе, Икриме бин Эбу Жахил, Абдуллах бин Раба гэх мэт эцэгээ, дүүгээ, хүүгээ алдсан мүшрикүүд өш хонзон санаж “Мусульманууд бидний толгойлогчидыг алж, биднийг уй гашууд автуулаа. Тийм болохоор тэднээс өшөөгөө авах цаг иржээ. Бид цэрэг зэр зэвсэгээ бэлдэж, Медине хотыг дайлаар морьдоцгооё, өшөөгөө авцгаая” хэмээн Эбү Сүфянийг толгойлогчоороо томилжээ.

Эбү Сүфян Шам хот руу жин тээн ирсэн нь маш их олз омог байлаа. Энэ олзныхоо талаар нь зэр зэвсэг талаар цэрэг цуглуулан, дуучин эмс охид, бүрээ бөмбөр, архи дарс ба шүлэгчидийг цуглуулан, мусульмануудыг Меккегээс хөөн гаргах, хайрт элчийг нь алах, исламын шашиныг ор үндэсгүйгээр устгах

зорилгоор ойр хавийн отог овгуудаас цэрэг цуглуулав.

Ийнхүү Мекке хотод 3000 цэрэгтэй маш том арми бий болсон байлаа. Эд нарын 700 нь хуяг дуулгатай, 200 нь морьтой, 3000 тэмээтэй байлаа. Эмс хүүхэн ба эхнэрүүдтэйгээ нийлсэн энэ армийг Эбү Сүфян удирдаж байв. Түүний эхнэр Хинд эмэгтэйчүүдийг уриалан дуудаж байлаа. Тэрээр Бедир дайнд эцгээ бас хоёр дүүгээ алдсан билээ. Энэ хагацал нь түүнд маш их хүнд цохилт байв.

Мүшрикүүдээс Жүбейр бин Мүтим жад шийдэхдээ гарамгай мэргэн Вахши гэх нэг боолтой байлаа. Хинд аав Утбегээ, харин Жүбейр авга ах Туаймагаа Бедирт алуулсаныг сонсоод Хамза баатард маш их өширхөж байв. Жүбейр боол Вахшид: “Хэрвээ чи Хамзаг алах юм бол чамайг боолоос чөлөөлж эрх чөлөөтөй болгоно” хэмээн амлажээ.

Дайны бэлтгэлээ хийж дууссан мүшрикүүд тугаа гарган нэгийг нь Талха бин Эби Талхад, нэгийг нь Эхабиш овгийнхоны нэгэнд, нөгөөг нь Үвейфийн хүү Сүфянд атгуулжээ.

Гэгээн Аббас мүшрикүүд 700 хуягдуулгатай, 200 морьтой, 3000 тэмээтэй 3000 гаруй цэрэгтэй армийг дайнд бэлдэж байгааг Мекке хотод мэдээ хүргэн, дайнд бэлд гэсэн захиа Мухаммед элчид (салаллаху алейхи уа сальлам) илгээжээ.

Энэ мэдээг дуулсан Аллахын элч (салаллаху алейхи уа сальлам) тагнуул болон хэсэг хүмүүсийг Меккегийн зүг илгээв. Асхабууд Меккегийн замд мүшрик цэргүүд ирж буйг харангуут буцан ирцгээв. Тэдний харсан зүйл Аббасын бичсэн захиатай яв цав таарч байлаа.

Мусульманууд шалавлан дайнд бэлдэж эхлэв. Бүх мусульманууд зэр зэвсгээ агсан гэрийхэнтэйгээ салах ёс гүйцэтгээд Мухаммед алейхиссальламын хажууд цугларцгаав.

Тэр өдөр Жума (баасан) гариг байлаа. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) асхабуудтайгаа Жума мөргөлөө үйлдээд, сургаал номлолдоо Аллахын шашины төлөө байлдахын үнэ цэнэ ба буяны талаар ярьж байлаа. Энэ сэтгэлээр амиа өргөгсөд шахид болон диваажинд залрах хувьтай гэв. Дайсаны өмнө цээж дэлгэн хамаг хүчээрээ эсэргүүцэгсэдэд Аллах эзэн туслах болно” гэв.

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) дайсануудаа хаана тосож байлдах талаар тэдэнтэй зөвлөлдөн санал асуугаад, тэр шөнө зүүдэлсэн зүүдээ ярьжээ. “Зүүдэндээ би маш бат

бөх хуяг өмссөн байлаа. Зүлфикар нэртэй сэлмээрээ нэг нүх онгойлгон, хүзүүг хэрчсэн нэгэн үхэрийг дараа нь нэг хонь авч ирсэнийг харлаа” гэв. Асхабууд: “Аяа, Расулуллах, учир битүүлэг энэ зүүдээ яаж тайлав” гэж асуув. “Бат бөх хуяг дуулага бол Мединед үлдэхийн шинж тэмдэг юм. Тэнд үлдэцгээ... Сэлэмний минь үзүүр нүх гарах нь нэгэн аюулд тулгарахын тэмдэг. Хүзүү нь хэрчигдсэн үхэр нь Асхабуудаас зарим нь амиа алдахын шинж тэмдэг. Түүний дараагаар дараагаар нэг хонь авч ирэх нь цэргүүдийн эв найрамдал бөгөөд Аллах дайсануудыг минь алах болно” гэв.

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) өөрт нь Аллагаас мэдээ ирээгүй тохиолдолд ямар нэгэн хүнд асуудалыг Асхабуудтайгаа зөвлөлдөн шийдсэний үр дүнд нэг алхам хийдэг байлаа. Асхабууд: “Дайсаныг Медине хотод өмнөөс тосож байлдая гэсэн” гэсэн санал тавив. Мухаммед элч болон бусад асхабууд энэ саналыг хүлээн зөвшөөрөв.

Оройн мөргөлөө үйлдсэний дараа Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) гэр лүүгээ зэр зэвсгээ авахаар явлаа. Энэ үед асхабууд Мухаммед элчийг хүлээн суулаа. Медине хотод дайсанаа тосон байлдахыг хүсэгсэд “Аллахын элч Мединегээс гарч байлдахыг хүсээгүй, энэ бол та нарын хэлсэнээр болж байна. Үнэндээ элч Аллахын зарлигаар хөдөлдөг билээ. Түүний хэлсэнийг л хийцгээ” гэв. Бусад нь өөрсдийн гаргасан шийдвэртээ харамсан “Аллахын эсрэг зогссон байх вий” хэмээн эмээцгээв. Тэд Мухаммед элчийг (салаллаху алейхи уа сальлам) гэрээсээ ирэх үед “Аяа, Расуллах! Дайны хувьд та яамаар байна таны тааллаар болцгооё, бид хаана ч байсан тантай хамт байх болно гэж амлая” гэгцгээв. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам): “Нэгэн элч өмссөн хуяг дуулагаа дайсаны цэргүүдийг бут цохиж ялах хүртэл тайлдаггүй билээ. Та бүхэнд захиx зүйл бол, миний тушаалыг дагаад Аллахын нэрийг бодон тэвчээртэйгээр хүлээцгээ. Аллах эзэн та бүхэнд туслах болно...” гэв.

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) ба түүний цэргүүд Медине хотод мөргөл үйлдүүлэх хүнээр Абдуллах бин Үмми Мектумыг орхиод дайнд мордоцгоолоо.

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) 3 тугаа намируулав. Нэгийг нь Хаббаб бин Мүнзирт, нэгийг нь Үсейд бин Худайрт, нэгийг нь Мусаб бин Умейрт атгуулжээ. Мусульманууд 2

морьтой, 100 хуяг дуулагатай, 1000 гаруй хүн хүн байлаа.

Замдаа жүүдүүдийн 600 хүнтэй цэрэг мусульмануудтай нэгдэцгээв. Энэ хүмүүс мунафикуудын (хоёр нүүртэн) толгойлогч Абдуллах бин Үбей бин Селүлийн хамтаар ислам цэргүүдтэй нэгдэхийг хүсэв. Мухаммед элч: “Эд нар мусульман болсон юм уу?” гэж асуухад “Үгүй, Расулуллах” гэв. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам): “Тэдэнд хэлцгээ, гэрлүүгээ буцацгааг, бид нар мүшрикүүдийн эсрэг кафируудын тусламж авахгүй” хэмээв.

Мусульман цэргүүд Ухуд ууланд байх Шейхайн гэх газар буудалцгаан тэнд хоноглохоор болов. Мусульман цэргүүд дунд дайнд оролсон буян хураахыг хүссэн насанд хүрээгүй олон хүүхэд байв. Мухаммед элч цэргүүдийг нэг нэгэнгүй байцаан 17 насанд хүрээгүй хүүхдүүдийг олжээ. Тэдэн дундаас Рафи бин Хадиж хөлнийхөө өлмий дээрээ зогсон өндөр болж харагдахыг хичээж байлаа. Гэгээн Зүбейр “Аяа, Расулуллах, Рафи маш сайн харвадаг юм” гэхэд түүнийг цэргийн тоонд оруулав. Үүнийг харсан Семүре бин Жүндү “Би Рафигээс хүчтэй билээ, барилдахдаа дандаа би давдаг юм. Би түүнтэй хамт дайтаар байна” гэв. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) мишээгээд тэр хоёрыг барилдуулав. Гэгээн Семүре Рафиг дийлсэн болохоор түүнийг гэсэн цэргийг тоонд оруулжээ.

Үдшийн мөргөлөө үйлдсэний дараагаар хайрт пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) Мухаммед бин Меслемег 50 хүний хамтаар харуул, манаанд гаргав. Тэр шөнө Мухаммед элчийг хамгаалан зогсох ариун үйл гэгээн Зекванд ноогджээ.

Тэр шөнө Шейхайн гэх газар мусульман цэргүүд хоноглон буйг мэдсэн мүшрикүүд Икримегээр толгойлуулсан хэсэг цэргүүд Харре гэх газар дөхөж очин дайтахыг хүссэн боловч мусульмануудын хүчтэй эсэргүүцэлд ялагдан буцацгаав.

Өглөө нь мусульман цэргүүд босоцгоон Ухуд ууланд ирцгээв. Энэ газар хоёр талын цэргүүд нэг нэгнийгээ харж байлаа. Цэргүүд Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) ард нь зогсон мөргөлөө үйлдэн залбирсаны дараагаар дайнд бэлэн болсон байлаа.

Энэ үед мунафик (хоёр нүүрт) Абдуллах бин Үбей: “Бид энд үхэх гэж ирээгүй, энэнийг эртхэнээс бодох ёстой байсан юм” гээд өөрийн адил хоёр нүүрт 300 хүнээ аваад мусульманы цэргүүдээс салан Медине рүү явцгаав.

Итгэл үнэмшилт сэтгэлээр нэгдэн, өөрийн толгойгоо энэ

ариун замын төлөө өргөхөд бэлэн чин үнэнч мусульмануудын тоо 700 билээ. Тэд цөм сүүлчийн дусал цусаа үл хайрлан Мухаммед элчийг хамгаалан тулалдахаа амалцаав.

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) цэргүүдийг эгнээн зогсоов. Цэргүүд ар талаа Ухуд уул руу харуулан урд талаараа Медине рүү харсан байдалтай зогсоцгоов. Баруун жигүүрт Укаша бин Михсан, зүүн жигүүрт Абү Селеме бин Абдуэсэд нар байрлажээ. Сагд бин Эбү Ваккас ба Эбү Убейде бин Жаррах хоёр урд талд зогсож хуягт дайчидийг толгойлуулан Зубейр бин Аввамыг томилжээ. Хамгийн урд байрлах хуягтай дайчидийн толгойлогч нь Хамза баатар байлаа. Харин Михад бин Амр арын цэргүүдийг толгойлохоор болов. (радиаллахум анхум)

Ислам цэргийн зүүн зүгт Айнейн гэх жижигхэн нэг толгод бий. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) энэ тодгодод Абдуллах бин Жүбейрээр толгойлуулсан 50 харваачийг байрлуулав. Тэд толгойн оройд байрласаны дараагаар Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) тэдэнд ийн захив. “Та нар биднийг араас хамгаалах болно. Энэ газардаа хүлээцгээ, эндээс битгий холдон явцгаа, дайсануудад ялагдсан ч хамаагүй энэ толгойноос битгий бууцгаа. Дайсанууд биднийг алсан ч бидэнд тусалхаар битгий бууцгаа. Дайсаны хүч та нар луу эргэх үед харваж эхэлцгээ” гэж хатуу захив.

Ийнхүү мусульманууд дайнд бэлэн болон, төлөвлөгөөгөө хэрэгжүүлэхээр зэхэж зогсож байх үед шинэхэн гэрэлсэн гэгээн Ханзала Мединегээс давхин ирж цэргийн дунд оров.

Ухуд ууланд 3 хоногийн өмнөөс ирж байрласан мүшрикүүдийг Эбү Сүфян толгойлон мусульмануудыг сөрж зогсон байрлалаа эзэлцгээв.

Мүшрикүүдээр зэрэвсэг, цэргийнхээ тоогоор мусульмануудаас 4 дахин их байлаа. Тэд өшөө авахаар улайрсан бух мэт байж ядна. Бүрээ үлээн, бөмбөр дэлдэн, эмс охид нь дуу дуулцгааж цэргүүдээ дайнд хурцална. Өөрсдийн шавар бурхадаа залбирцгаана.

Мусульманууд Аллах эзэндээ бүхнийг даатган: “Аллаху Акбар, Аллаху Акбар!” гэх уриа нүргэлнэ. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам): “Аяа, асхаб минь! та нар дайсанаасаа бага, тийм болохоор маш их хүч шаардана. Хэрэв тэд тайван, өөртөө итгэлтэй тайван байлдах юм бол, Аллах

тэднийг ялалтанд хүргэнэ, ягаад гэвэл Аллах өөрийн үнэнч боолуудтай хамт... Аллах эзэнээс та нарт амалсан тэр жаргалыг гуйцгаа..." хэмээв.

Сэтгэл зүрх нь итгэлийн галаар дүрэлзэн, нүдэнд нь эр зоригийн гал гялалзсан мусульманууд шахид (Аллахын шашины төлөө амиа өгөх) болохын төлөө яаран тогтож ядна.

Хоёр тал нэг нэгэндээ ойртон ирэх үед хүн бүхний зүрх цохилох нь өөрт нь сонсогдуйц болон сандарцгаана. Нэг тал нь исламын шашинаа авч үлдэхийн төлөө өөрийн кафир хамаатан садантангуудтай байлдахад бэлэн болсон мусульманууд, нөгөө талд өөрсдийн дээрэнгүй зан ба мухар сүсэгтэнгүүд болох ариун ислам шашины галыг унтраахыг хүсэгч кафирууд...

Харвасан сум хүрэхүйц болох үед дайсануудын дундаас нэг хүн урагш сугаран гарч мусульмануудаас нэг хүнийг халз тулаанд дуудав. Түүнтэй халз тулалдахаар исламын цэргүүдээс өндөр биетэй, шар сахалтай нэгэн баатар сугаран гарах нь харагдав. Энэ хүн бол Мухаммед элчийн нагац дүү Зүбейр бин Аввам (радиаллаху анх) байлаа. Исламын цэргүүдийн "Аллаху Акбар" гэх уриа нь нүргэлнэ. Зүбейр дайсаны цэрэгт ойртоод очингуудаа тэмээнээсээ үсрэн түүнд дайрав. Тэмээн дээр тэр хоёр тулалдана... Энэ үед Мухаммед элчийн "Түүнийг газар унгаа" гэх дууг сонсонгууд Зүбейр түүнийг газар түлхээд араас нь өөрөө үсрэхдээ сэлмээ хүзүүнд нь зоож орхив. мүшрикийн дуулгатай толгой газар өнхөрхөд Мухаммед элч Зүбейрийн төлөө залбирив.

Дараа нь мүшрикүүдийн тугыг баригч Талха бин Эбү Талха тулааны талбар луу гарав. "Та нар дотороос надтай тулалдах зоригтон байна уу?" гэж бархирав. Түүнтэй халз тулалдахаар Аллахын арслан Али (радиаллаху анх) гарлаа. Али төдхөн зуурын ганцхан цавчилтаар толгойноосоо хөл хүртэл хуягласан мүшрикийг оройноос нь эрүү хүртэл цавчиж орхив. Энэ явдалыг харсан элч: "Аллаху Акбар! Аллаху Акбар!" хэмээн дуу алдав.

Мүшрикүүдийн туга газар унахыг харсан Талхагийн хүү Осман бин Эби Талха талбар луу гүйн ороод тугийг өргөн тулалдах хүн дуудав. Түүнтэй тулалдахаар гэгээн Хамза гарав. "Яа, Аллах!" гээд Османы туг барьсан гарыг нь цавчихад гар нь тугатайгаа тасран ойчив. Осман хэдийгээр бултан зайлахыг хичээсэн боловч Хамзагийн цавчилтанд оногдон үхэв.

Мүшрикүүдээс бас л Эбү Саад бин Эби Талха явган тулааны

талбар луу гарлаа. Тугаа өргөн Исламын цэрэгүүд рүү бархиран: “Би Кусамын эцэг билээ, миний өмнө хэн гарч надтай тулалдаж зүрхлэх вэ?” гэв. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) түүнтэй тулалдуулахаар дахин гэгээн Алиг (радиаллаху анх) гаргав. Гэгээн Али тэр мүшрикийг алан тугыг нь газар унагав.

Энэ мэтээр маш олон мүшрикүүд талбарт гарган тугаа өргөн мусульмануудтай халз тулах хүн дуудсан боловч тулаан бүрт баатар цэрэг болох мусульмануудын ялалтаар төгсөв. Ислам цэрэгүүдийн уриа тэнгэрт хадан, харин мүшрикүүдийн зүрх айдаст автан чичирч эхлэв. Мүшрикүүд “Та нар арчаагүй амьтад” хэмээн өөрсдийн цэрэгүүдээ муулцгаана....

Хоёр талын дайчид байлдахад бэлэн болон байж зогсож чадахгүй болсон тэх үед: Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) гартаа барьсан сэлмээ: “Айхад ичгүүр, давшихад гэгээрэл ба тусламж бий. Хүн айж хувь заяанаасаа зугтаадаггүй” хэмээн бичигдсэн гэж хуйнаасаа сугалан дээш өргөөд: “Энэ сэлэмийг надаас авах хэн байна?” гэж хэлэх нь сонсогдов. Асхабууд цөм түүнийг авахыг хүсэн гараа сунгахад Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) дахин: “Энэ сэлэмээр хамгаас илүү байлдах хэн байна?” гэхэд Асхабууд зогсон чимээгүй болцгоов. Тэр сэлэмийг маш их авахыг хүссэн Зүбейр бин Аввам “Би авъя, Аяа Аллахын элч минь!” гэв. Элч гэгээн Зүбейрт өгсөнгүй.

Эбу Дужане: “Аяа, Расулуллах! Энэ сэлэмний Хак (үнэ цэнэ) юу вэ? гэхэд Мухаммед элч: “Энэ сэлэмний хак (үнэ цэнэ) бол махир болж нугартал дайсантай байлдах явдал юм. Түүний хак бол кафирүүдээс зугтаахгүй байх, түүнийг барин үхэх хүртэл эсвэл ялан дийлэх хүртэл байлдах нь түүний хак (үнэ цэнэ) билээ” гэв. Эбу Дужане: “Аяа, Расулуллах! Наад сэлэмний чинь үнэ цэнийг би өгье, надад өг” гэв. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) сэлэмээ түүнд өгөв. Эбу Дунаже (радиаллаху анх) сэлэмээ барьсан даруйдаа дайны талбар луу зоригтойгоор алхав. Тэр нэг нимгэхэн цамцтай, толгойдоо улаан өнгийн алчуураас өөр зүйлгүй аж.

Хүлээж ядсан мүшрик Халид бин Велидын толгойлсон цэрэг довтолж эхлэв. Мусульманууд Мухаммед алейхиссальамын тушаалыг хүлээж зогсоцгооно. Гэв гэнэт “Аллаху Акбар” гэх дуу тэнгэрт хадахад хамгийн өмнө байх гэгээн Хамза сэлэмээ сугалан цэрэгүүдтэйгээ урагш гүйн байлдаж эхлэв. Халид бин Велидийн

цэрэг тэр доороо айн хойшоо ухарцгаалаа. Халид бин Велид энэ удаа уулыг тойрон ар талаас нь довтолохоор Айнейн толгойн зүг очсон боловч Абдуллах бин Жүбейрээр толгойлуулсан харваачидийн суманд бут цохигдов.

Дайн ид бужигнан өрнөж байлаа хоёр талын дайчид хамаг хүч, ур ухаанаараа байлдаж эхлэв. Гэгээн Хамза “Аллаху Акбар! Аллаху Акбар! Би Аллахын арслан байна” хэмээн урдаа таарах кафир бүрийг ганц цавчилтаар газар унагаан давшина. Энэ үед Савфан бин Умейр “Хамза хаана байна, надад харуул даа?” хэмээн цэрэгүүдээс асууна. Хоёр гартаа сэлэм барин зэрэг эргүүлэн тулалдах эр зоригт баатар Хамзаг олж хараад “Би энэ өдөр энэ хүртэл өөрийн отог омогоо алахын тулд байлдах ийм аймшигт хүн харсангүй” гэв.

Дайн маш халуунаар өрнөж байхад Зүбейр бин Аввам Мухаммед элч сэлэмээ өгөөгүйд гоморхон дайтна. Өөрөөр өөртөө “Би Аллахын элчийн сэлэмийг нь гуйсан боловч өгсөнгүй. Эбү Дужанед өглөө. Үнэндээ би нагац эцэг Сафиегийн хүү нь билээ, бас курейш овгийнхоноос сэлэмийг хамгаас түрүүлж хамгаас би гуйсан билээ. Эбү Дужанег хэрхэн тулалдаж байгааг харъя” гээд дайн дотор Эбү Дужанег олж хараад араас нь мөшгин дайтаж эхлэв. Эбү Дужане “Аллаху Акбар!” хэмээн уухайлан өмнөө тааралдсан кафир болгоныг цавчин унагаж байлаа. Тэрээр огт хойш ухралгүй урагшаа явна, түүний хүчирхэг гар сэлэмийн өмнө хэн ч босоогоороо үлдэж үл чадна. Эбү Дужане ийнхүү байлдан явсаар кафируудын нөгөө захад нь гарч уулын хормойд байх эмэгтэйчүүдэд тулж очоод Эбү Сүфяны эхнэр Хиндиг сэлэмээр цавчихаар далайсан боловч зогслоо. Энэнийг харсан Зүбейр бин Аввам өөрөө өөртөө “Сэлэмээ хэнд өгөхийг Аллах ба түүний элч сайн мэддэг билээ” гэв. “Аллахын нэрээр тангараглая, тэр дайнд Эбү Дужанегээс илүүтэйгээр байлдсан зоригтоныг хараагүй билээ” хэмээжээ.

Микдад бин Эсвэд, Зүбейр бин Аввам, гэгээн Али, гэгээн Омар нар (радиаллаху анхум) хэн ч үл нэвтрэм бат бөх цайз мэт билээ. Дайнд дайсануудтайгаа маш ойроос баруун солгойгүй цавчилдах Мухаммед элчийг (салаллаху алейхи уа сальлам) харсан асхабууд улам зоригжин уухайлж, түүнийг хамгаалахын тулд хажууд нь цугларан байлдана, бамбайгаараа хаан дайсанд түүнрүү дайрах боломж үл олгоно. Энэ үед Абдуллах бин Амр (радиаллаху анх) амь үрэгдэв. Энэ хүн Ухуд дайны анхны шахид

юм. Түүний унахыг харсан мусульманууд орилолдон галзуурсан мэт байлдаж байлаа.

Дайн өрнөж байх үед гэгээн Абдуллах бин Жахш ба мэргэн харваачин Саад бин Эби Ваккастай тааралджээ. Сад бин Ваккас ийн өгүүлрүүн: “Ухуд дайны ид үргэлжилж байсан үе. Гэв гэнэт миний хажуугаар Абдуллах бин Жахш шурган орж ирээд тэр миний гарнаас чангаан, намайг хүмүүсээс зайдуу нэгэн жалга руу чирч оруулав. Надад “Одоо энд чи залбир би “Амин” (болтугай) гэж хэлээ, дараа нь би залбиръя чи “Амин” гэж хэл” гэв. Би “за” хэмээн зөвшөөрөөд залбирч эхлэв. “Аллах минь, над руу хамгийн хүчтэй дайсанг явуул бас намайг тэднээс хүчтэй болго. Би бүгдийг нь алъя. Тэгээд гэртээ “баатар” болоод буцай” гэлээ. Тэр: “Амин” гэв. Дараа нь түүний ээлж болоход:

“Аллах минь, надад хамгийн хэцүү дайсануудыг илгээ, би бүгдэнтэй нь тулалдан ялъя. Дараа нь намайг хэн нэгэн алаг. Тэгээд миний хамар, ам, чихийг минь огтлог, хойд ертөнцөд таны өмнө шахидийн гэрч болсон цустайгаа очъё” гэв. Би “Абдуллах минь! Хамар, амаа ягаад ингэж хэлэв” гэхэд тэрээр “Би маш их ам, чихээрээ их нүгэл хийсэн билээ. Буян үйлдэхэд тэднийгээ хэрэглээгүй” гэв. Би тийм залбиралд “Амин” гэж хэлэхийг огт хүсээгүй ч түүнд амалсан болохоор “Амин” гэлээ.

Ингээд бид хоёр сэлэмээ барин мөр зэрэгцэн байлдаж эхлэв. Тэрээр хамаг хүчээрээ довтлон урагшилан түүний энэ их зориг баатарлаг биеээс нь айсан мүшрикүүд ойртоход л тарж зугтаана. Үхсэн дайсаныг ахин дахин цавчин шахид болох их хүсэлээр довтолно. Гэв гэнэт түүний сэлэм хугаран гар хоосон үлдэхэд Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) түүнд хурма модны мөчир өгөн, байлд” гэв. Тэрээр огт эргэлзэхгүйгээр модыг гартаа барин далайх тэр мөчид гайхам ид шидээр мөчир хурц нэгэн сэлэм болон хувирав. Абдуллах тэр сэлэмээр ахин байлдаж эхлэв. Тэрээр маш олон дайсаныг алж дайны төгсгөл үеэр Эбү-л Хакем гэх мүшрикийн харвасан суманд оногдон хүссэн шахидаа олсон юм”. Дайны дараа түүний цогцосыг олоход хамар, ам, чих нь огтлогдсон, бүх бие нь цусанд будагдсан байлаа...”

Дайн эхэлсэнээс хойш хорвоогийн элч Мухаммед (салаллаху алейхи уа сальлам) түүний зоригт асхабууд буцалтгүй байлдсаар мүшрик цэрэгүүдийг айлган хөөв. Мод чулуугаар хийсэн “Лат, Узза, Хубел” нэртэй бурхаддаа залбиран зугтааж эхлэв. Тэднийг дайнд зоригжуулах эмс хүүхнүүд тэдний араас

гүйцэхээр гүйлдэнэ.

Курейш мүшрикүүд дайны талбараас толгой дараалан зугтааж эхэлхэд ислам цэрэгүүд Аллах эзэний амласан амлалт биелэгдэхэд баярлан дор бүрнээ үсрэнэ тэврэлдцгээнэ. Цэрэг зэр зэвсэгээрээ мусульман цэрэгүүдээс хэд дахин илүү дайсануудыг бут цохин үдэн хөөж гүйцсэнээ алж байх энэ үзэгдэл исламыг хүчирхэгжүүлэх Аллахын аврал байлаа. Энэ үед Ханзала бин Амр мориндоо мордон зугтахыг завдсан Эбү Сүфияны морины хөлийг цавчин унагаан түүнийг барьж авав. Эбү Сүфяин айн: “Хөөе, Курейшүүд ээ! Амь авраарай! Би Эбү Сүфиян байна” гэж хоолой мэдэн чадах чинээгээрээ орилсон боловч хэн ч түүнд туслахыг оролдсонгүй, бүгд амь амиа бодон зугтааж байлаа. Тэр бол мүшрикүүдийн толгойлогч байлаа.

Гэвч тэр үед гэгээн Ханзалагийн (радиаллаху анх) нуруунд нь Шеддад бин Эсведийн жад зоогдоход Ханзала “Аллаху Акбар!” гээд сэлэмээ далайсан боловч цавчиж чадалгүй газар унан шахид болов. Мухаммед элч : (салаллаху алейхи уа сальлам) “Би Ханзалааг газар тэнгэр хоёрын хооронд сахиусан тэнгэрүүдийн дунд мөнгөн түмпэнд борооны усанд угааж байгааг харж байна” гэжээ. Эбү Үсейд ийн айлджээ: “Би Мухаммед элчийн энэ үгийг сонсоод гэгээн Ханзалагийн хажууд очиход түүний үс нь норсон ус дуслаж байлаа. Би энэ талаар элчид очиж хэлэхэд Тэр: “Тэр бол Гасил-үл мелаике (сахиусан тэнгэрүүдэд угаагдсан хүн) гэсэн юм.

Мүшрикүүдийн зугтаахыг харсан Айнейн толгой нь орой дахь харваачидийн зарим нь мусульманууд яллаа гэж бодон толгойноос бууцгаав. Тэдний дарга нь Абдуллах бин Жүбейрээс гадна 12 хүн байрандаа үлджээ.

Гэгээн Алигийн баатарлаг явдал

Энэ үед дайныг нарийн нягт хянан харж байсан курейшийн харваачидийн салааны дарга Халид бин Велид тэдний замд (Айнейн толгодын) мухажуудыг байхыг хараад морин цэрэгээ хөдөлгөн Икриме бин Эби Жахилийн хамтаар хойгуур тойрон Айнейн орц руу иржээ. Абдуллах бин Жүбейрээр толгойлуулсан 12 харваачид мөр зэрэгцэн зогсоод мүшрикүүдийн морин цэрэгийг зогсоохыг эрмэлзэн харваж байлаа. Харваачид сумаа дуустал харван сүүлдээ сум нь дууссаны дараагаар тэдэнтэй жад

сэлэмээрээ “Аллаху Акбар! Аллаху Акбар!” хэмээн баатарлагаар байлдаж эхлэв. Харин мүшрикүүд тэднээс 20 дахин их байлаа. Зоригт асхабууд Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) хэлсэнчлэн тэр газараасаа огт хөдлөн зугтаасангүй, сүүлчийн дусал цусаа дуустал тэнд байлдаж нэг нэгнийхээ араас нас баран бүгд шахид болжээ.

Халид бин Велид ба Икриме нар орцонд хамгаалах харваачидийг яалаад мусульмануудыг араас нь дайрж оров. Асхабууд гэв гэнэт ар талаас нь гарч ирсэн кафируудыг харан сандран хэвийн байдалаа олж авч чадсангүй, учир нь тэд баярлан зэр зэвсэгээ газар хаячихсан байжээ. Ийнхүү бүх зүйл гэв гэнэт өөрчлөгдөн, урд талаас зугтаасан дайсанууд эргэн ирж дайралтанд ороход хоёр талын хавчилтанд өртөнө сандарцгааж эхлэв. Асхабуудын нөгөө мөр зэрэгцэн тулалдах нь алга болж таран бутарч эхлэв.

Гэгээн Али (радиаллаху анх) ийн айлджээ: “Би Икриме бин Эбү Жахилаар толгойлуулсан хэсэг цэрэгийн дунд үсэрч орлоо. Тэд цөм намайг тойрон нэгэн зэрэг дайрсан ч би тэднээс шалавлан хөдөлж ихэнхийг алж орхилоо. Тэр газараас сугаран гараад бас нэг хэсэг мүшрикүүд рүү дайрлаа. Тэдний ихэнхийг нь мөн адилаар цавчин аллаа. Би Мухаммед элчийг олж харж чадаагүй болохоор “Тангараглая! Тэр бол дайны талбарыг орхин явах хүн биш! Аллах эзэн бидний хийсэн тоомжиргүй алдаанаас болоод Мухаммед элчийг биднээс авсан байх! Одоо надад дайтсаар байгаад үхэхээс өөр зам үлдсэнгүй дээ” гэж бодоод сэлэмнийхээ хуйг хугалан хаяаад мүшрикүүд рүү дайрлаа. Хэсэг бөөн мүшрикүүдийг тараан бутаргахад Мухаммед элчийг тэдний дунд байлдаж байгаа нь харагдав. Түүнийг Аллахын сахиусан тэнгэрүүд хамгаалж байлаа.”

Дайсаны цэрэгүүд элчийн хажууд маш ойрхон ойртон очсон байлаа. Хайрт пайгамбар маань тэдэнтэй тулалдахын хажуугаар тархсан асхабуудыг цуглуулахыг зорьж “Хөөе, тэр нааш ир! Хөөе, тэр (нэрийг хэлэн) наашаа ир! Надад эргэн ирэгсэдэд диваажин бий!” гэж байлаа.

Эбү Бакир, Абдуллах бин Авф, Талха бин Убейдуллах, Али бин Эби Талиб, Зүбейр бин Аввам, Эбү Дужане, Эбү Убейде бин Жеррах, Саид бин Муаз, Саид бин Эби Ваккас, Хаббаб бин Мүнзир, Үсейд бин Худайр, Сехл бин Ханиф, Асым бин Сабит, Харис бин Симме нар (радиаллаху анхум) маш хурдан

цугларцгааж, хайрт элчийг (салаллаху алейхи уа сальлам) тойрон авч түүнийг хамгаалан байлдав. Маш олон мусульманууд дайсаны гарт үрэгдэж байлаа.

Мусульманууд аяар аяархан цугларцгаан байдалыг ойлгон байлдаж байлаа. Мухаммед элчийг (салаллаху алейхи уа сальлам) тойрон нэгэн тойрог болон тулалдах хэсэг баатар тал бүрээс ирсэн мүшрикүүдийг цавчин унагааж нэгэн давшгүй хэрэм босгосон байлаа.

Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) өөдөөс хэсэг мүшрикүүд ирж явааг хараад гэгээн Алид: “Тэд нар луу дайр” гэж тушаав. Али тэдэн рүү арслан бар мэт дайрахад цөм нэгэн зэрэг тулалдсан ч яаж ч дийлсэнгүй. Али Амр бин Абдуллахыг алахад тэд зугтаан одов. Алигийн сэлэм хугарсан болохоор Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) Зүлфикар нэртэй сэлэмээ түүнд өгөв. Өөр нэгэн хэсэг хүмүүс рүү заан: “Аяа, Али! Эд нарыг надаас зайлуул!” гэж тушаав. Али энэ үгийг сонссон даруйдаа тэдэн рүү үсрэн очоод Шейбе бин Маликийг алж, бусдыг нь үлдэн хөөв. Энэ үед Жабрайл (алейхиссальлам) ирж Мухаммед элчид: “Аяа, Расулуллах! Энэ бол зөвхөн Алигээс гарсан хэмжээлшгүй эр зоригоор бүтээнэ” гэв. Энэ үед хаа нэгтээгээс нэгэн дуу “Али шиг баатар, Зүлфикар шиг сэлэм олдохгүй” гэжээ.

Мухаммед алейхиссальламд хүрч чадахгүйгээ ойлгосон мүшрикүүд сум харваж эхлэв. Тэдний харвасан сум бай гаа огт онохгүй эсвэл зөрж дээгүүр нь өнгөрч байлаа. Эбү Талха Мухаммед элчийн өмнө гаран зогсоод өөрийн цээжээрээ халхавч болон харвасан сумнаас хамгаалж зогсоно. Гэв гэнэт мүшрикүүдийг гайхшируулан айлгасан нэгэн сонин орь дуу (хашгирах) тэнгэрт хадав. Мухаммед элч маань: “Цэрэгүүдийн дундаас Эбү Талхагийн дуу 100 хүнээс ч илүү” хэмээжээ.

Ухуд талбарт маш хүчтэй байлдаан өрнөнө. Морьтой, явган, итгэлт ба үл итгэгсэдүүдийн хоорондох ширүүн мөргөлдөөн... Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) хажууд зогсохгүйгээр байлдах гучаад хан дайчин байлаа. Сахабанууд хүрд адил эргэлдэн ирсэн сумыг бамбай, өөрийн биеээрээ халхлан хэнийг үл ойртуулна. Тэдний ганц хүсэл нь Мухаммед алейхиссальламын тушаалыг биелүүлэн, амь насаараа түүнийг хамгаалах. Баатаруудын эцэг нь болсон гэгээн Хамза (радиаллаху анх) Мухаммед элчээс зайдуухан хэсэг бүлэг

мүшрикүүдийн дотор хоёр гартаа сэлэм зэрэг эргүүлэн баруун зүүнгүй цавчилдана.

Түүний “Аллаху Акбар” гэж орилох нь дайсаны зүрх, хамаг биеийг нь чичрүүлэн айлгана. Ганцаараа тулалдан 31 мүшрикийг цааш харуулжээ. Кафир Сиба бин Үммү Энмер “Надтай тулалдах залуу байна уу?” гэж гэгээн Хамза руу орилов. Хамза: “Хүрээд ир, эмч авгайн хүү минь! Чи Аллахын элчийн баатарын эсрэг үг хэлнэ гэн ээ?!” гэв. Түүнийг хөдлөж амжаагүй байхад хөлнөөс бариад газар савж орхив. Дээр нь гараад толгойг нь тас цавчих үед урд нь байх жалганд Вахши гартаа жад барин түүнийг отож суугааг харав. Хамза түүн рүү явахад хөл нь халитарч тэнцвэр алдах тэр агшинд Вахши жадаа шидэн гэгээн Хамзаагийн цээжинд зоож орхив... Жад нэг талаар нь ороод нөгөө талаар нэвт гарчээ. Баатар дайчин “Аллах минь!” гэж хэлээд газар сөхрөв. Хүсэн хүлээсэн тэр зүйлдээ ч хүрч Аллахын шашин ба элчийн төлөө амиа өргөн диваажин руу нисэн одов.

Курейш мүшрикүүдийн гол бай нь хорвоогийн энэрэл болсон Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) байлаа. Огт зогсолтгүй түүн рүү дайрсан боловч түүний хажууд сэнс мэт эргэлдэн тулалдах асхабуудыг нэвтэрч үл чадна. Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) өмнө ирж буй хэсэг мүшрикүүд рүү заан, өөрийн асхабууддаа “Аллахын төлөө амиа бидэнд хэн өгөх вэ?” гэхэд 5 асхаб урагш үсрэн гарч Мухаммед элчийн өмнө “Аллаху Акбар!” гэж уухайлаад тэдэнтэй тулалдаж эхлэв. Тэдний 4 нь амиа алджээ. Харин тав дахь нь 14 газараа шархдан газар унав. Хорвоогийн энэрэл болсон элч (салаллаху алейхи уа сальлам) “Түүнийг миний хажууд ойртуул” гэв. Элч өөрийн өвдгөн дээрээ түүний толгойг тавин сууна. Бүх бие нь шархдан цус нөжиндөө холилдсон баатар удалгүй нас барав. Энэ хүн бол Умаре бин Иезид (радиаллаху анх) байлаа.

Талха бин Убейдуллахын эр зориг

Мүшрикүүд ойртон ирэх тэр үед Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам): “Эд нарыг хэн угтах вэ?” гэв. Талха бин Убейдуллах: “Би угтъя” гээд ухас хийхэд Мухаммед элч “Чамаас өөр хэн байна?” гэж асуув. Мединегийн сахаба нарын нэг: “Расулуллах! Би байна” гэхэд хайрт элч маань: “Алив, урагш, дүү минь!” гэж тушаав. Тэр мусульман тэдэнтэй зоригтойгоор

тулалдан баатарлагаар амь үрэгдэв.

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) ахиад: “Энэ хүмүүстэй хэн дайтах вэ?” гэж асуухад бүхнээс түрүүлж Талха бин Убейдуллах ухас хийв. Мухаммед элч: “Чамаас өөр хэн байна?” гэж асуув. Ансаруудаас нэг мусульман “Би тэдэнтэй тулалдъя, аяа, Расулуллах!” гэхэд Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам): “Алив, тэднийг сөр” гэв. Тэрч мұшрикүүдтэй байлдан амиа алдав. Энэ мэтээр Мухаммед элчийн хажууд байсан мусульманууд байлдсаар амиа алдаж байв. Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) хажууд гэгээн Талхагаас өөр хүн үлдээгүй байв. Гэгээн Талха элчид ямар нэгэн аюул учрах вий гэж айн элчийг тойрон хурдтайгаар гүйн тал бүрээс ирсэн мұшрикүүдтэй тулалдана. Түүнийг сэлэмээ ийм хурдан эргүүлэн, сум жад, сэлэмийг бамбай, өөрийн биеээрээ хаан тулалдах нь гайхамаар их ур ухаан, хүч зориг байлаа. Сэнс мэт эргэлдэн тулалдах Талха зүссэн шарахаа огт үл тоон тулалдана. Түүний ганц хүсэл зорилго нь элчийн ариун амийг хамгаалах юм. Бүх биендээ шархадан цус нөжиндөө холилдсон ч үхэл ирэх хүртэл байлдах нь түүний зорилго билээ. Энэ үед гэгээн Эбү Бакир ба Сад бин Эби Ваккас (радиаллаху анхум) хоёр Мухаммед алейхиссальламын хажууд гүйн ирж тулалдаж эхлэв.

Энэ үед гэгээн Талха цус их алдсанаас болж ухаан алдан газар унав. Түүний хамаг бие сум, жад, сэлэмний шархаар дүүрчээ. 66 том ба тоолж барамгүй жижиг шархтай байлаа. Мухаммед (салаллаху алейхи уа сальлам) гэгээн Эбү Бакирт Талхад туслахыг тушаахад Талхаг сэрээхийн тулд нүүр лүү ус цацав. Талха бин Убейдуллах ухаан оронгуутаа: “Аяа, Эбү Бакир! Аллахын элч мэнд үү?” гэж түүнд хичнээн их хайртайгаа харууллаа. Мухаммед элчийг хайрлах, түүний төлөө амьдрахын нэг том жишээ бол энэ билээ. Эбү Бакир: “Аллахын элч сайн байгаа, тэр намайг явууллаа” гэхэд Талха баярлан санаа алдаад “Аллах эзэндээ хязгааргүй их баярлалаа” Тэр (Мухаммед элч) амьд мэнд байсан цагт бүх муу зүйл арилна” гэв. Энэ үед хэд хэдэн асхабууд түүний хажууд цугларчээ.

Хорвоогийн энэрэл болсон элч (салаллаху алейхи уа сальлам) гэгээ Талхагийн хажууд ирэхэд шархдасан баатар Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) амьд байгааг хараад баярласандаа уйлав. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) түүний биеийг, толгойг илбэсэний дараагаар алгаа

дэлгэн: “Аллах минь, түүнийг илаашруул, түүнд хүч өг” хэмээн залбирав. Энэ гайхамшигийн хүчээр гэгээн Талха хөл дээрээ босоод ахин байлдахаар мүшрикүүд рүү явж байгаа нь харагдав. Хайрт пайгамбар маань түүний талаар: “Ухуд дайнд энэ дэлхий дээр баруун талд минь Жабрайл (алейхиссальлам) сахиусан тэнгэр, зүүн талд минь Талха бин Убейдуллахаас илүү ойр зүйл хараагүй билээ”, “Дэлхий дээр амьдарч буй диваажингийн хүнийг харахыг хүсвэл Талха бин Убейдуллах руу харцгаа” хэмээжээ.

Мүшрикүүдийн хамгийн мэргэн хүн болох Малик бин Зубейрийн харвасан сум онилсон газартаа тусдаг байлаа. Тэрээр Мухаммед элчийг хайн түүнийг харвахыг хүсэж байлаа. Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) ойр байх нэг газар нуугдан нум сумаа бэлдэн боломж хүлээн отоож эхлэв. Нумаа нугартал нь татаж Мухаммед элчийн толгой онилон сумаа тавихад энэ хоромхон хугацаанд маш хурдан мэдэрсэн гэгээн Талха гараа дэлгэн элч рүү чиглэсэн сумыг гараараа хаахад сум алгыг нь нэвтлэн гарыг нь хоёр хэсэг хуваав. Түүний алганы бүх шөрмөс тасрав. Үүнийг Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) харж: “Хэрвээ чи (намайг хамгаалахын тулд суманд гараа тосох үед) бисмиллах гэж хэлсэн бол хүмүүс чамайг харж байх үед сахиусан тэнгэрүүд чамайг өргөх байсан”.

Меккегийн мүшрикүүдээс Абдуллах бин Камиа, Үбей бин Халеф, Утбе бин Эби Ваккас, Абдуллах бин Шихаб, Зүхри гэх дөрвөн мүшрик Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) амийг бүрэлгэхээр амлацгаав. Тэд маш хүчтэй довтлож урагш явна. Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) өмнө туга баригч Мусаб бин Умейр зогсоно. Гэгээн Мусабын (радиаллаху анх) өмссөн хуяг дуулага Мухаммед элчийнхтэй адилхан харагдана. Тэрээр баруун гартаа туг барьсан хэдий ч мүшрикүүдтэй ан ман тулалдана. Энэ үед мүшрик Ибн-и Камиа морьтойгоор гарч ирэв. Тэр маш чангаар “Надад Мухаммедийг үзүүлээд аль! Амьд үлддэг бол би үхнэ” хэмээн орилон элчийн зүг давшилан дайрна. Түүний өмнөөс Несибе Хатуныг явуулсан Мусаб тугаа барин элчийн өмнө байлдана. Ибн-и Камиа Несибе Хатуныг ганц цавчилтаар амийг нь бүрэлгээд Мусабд дөхөж ирэв. Тэр Мусабын баруун гарыг тас цавчихад өөрийн аминаасаа илүүтэйгээр хамгаалах исламын далбааг газар унагалгүй зүүн гартаа шилжүүлэн барилаа. Энэ үед: “Мухаммед (салаллаху алейхи уа сальлам) элч мөн, түүнээс өмнө ч элчүүд

илгээгдсэн юм” (Али имран сүре, 144) гэх аетийг уншжээ. Ибн-и Камие Мусабын зүүн гарыг нь цавчихад Мусаб далбаатайгаа газар уналгүй мухар хоёр гараараа цээжиндээ наан тэврээд хоёр тийш хөдөлгөн намируулж байлаа. Кайма энэ удаа жадаа түүний цээжинд зооход зоригт баатар Мусаб амиа алдан шахед боллоо.

Мусаб газар унахад исламын далбаа газар унасангүй түүнийг Мусабын дүр төрхтөй нэгэн сахиусан тэнгэр шүүрэн авчээ. Хайрт пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) “Урагшил! Аяа, Мусаб, урагшил” гэхэд далбааг барьсан Мелек (сахиусан тэнгэр) эргэн хараад “Би Мусаб биш “ гэв. Мухаммед элч түүнийг аваад далбааг гэгээн Алид (радиаллаху анх) атгуулав.

Ибн-и Камие гэгээн Мусабыг элч гэж бодоод үтэр түргэн мүшрикүүд рүү очоод “Мухаммедыг аллаа” гэж орлиж эхлэв. Зорилгоо биелүүлсэн гэж андуурсан мүшрикүүд баярлан орилож хашгирч дор бүрнээ дэвхцэн улам их галзуурч эхэлхэд жинхэнэ элч үхээгүйг үл мэдэх асхабуудыг гар хөл хөшиж хүйтэн салхи үлээх мэт жиндэн сэлэмээ газар унаган дор бүрнээ сөгдөгөөв. Энэ бол тэдний хувьд жинхэнэ аймшиг байлаа. Энэс бин Надр мусульмануудыг хараад “Та нар ягаад суугаад байгаа юм бэ?” гэж асуухад тэд “Аллахын элч шахид болжээ!” гэсэн чичрэнгүй хоолойгоор үгээ зөөн ядаж хэлэхэд гэгээн Энэс: “Аллахын элч нас барсан нь үнэн юм бол, түүний эзэн Аллах мөнх биш гэж үү?” Мухаммед элчээс хойш бид амьд мэнд яваад яах юм! Алив, босоцгоо! Аллахын элчийн амиа өгсөн тэр ариун замын төлөө бид ч бас амиа өгцгөөе” хэмээн өөрийн сэлэмнийхээ хуйг хугалан хаяад “Аллаху Акбар!” хэмээн дайсанууд руу үсрэн оров. Дайсануудаас нэлээд хүнийг алан өөрөө ч шахид болсон юм. Түүний нүүрэнд л гэхэд далаад шарх байсан болохоор түүнийг охин дүүгээс нь өөр хэн ч таньсангүй.

Хэсэг хугацаанд асхабууд тархан өөр өөрийнхөөрөө байлдаж байлаа. Ихэнх нь шахед (шашины төлөө амь үрэгдсэн) болсон байв. Энэ боломжийг ашигласан мүшрикүүд Мухаммед элч рүү (салаллаху алейхи уа сальлам) дайран чулуу нүүлгэн, жад шидэж байлаа. Пайгамбар минь хоёр давхар хуяг өмссөн болохоор элчийн нүүрийг нь онож доод уруулыг шархдуулжээ. Доод шүднээс нэг шүд хугарчээ. Энэ үед Ибн-и Камие гэх мүшрик сэлэмээ элчийн толгой дунд буулгахад дуулага нь хагарч

хоёр хагаран хүрээ нь эрүүрүү нь шигджээ. Хоёр дахь удаагаа Мухаммед элчийг (салаллаху алейхи уа сальлам) цавчихад элчийн баруун мөрийг шархдуулав. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) хажуу тийшээ унахдаа мүшрикүүдийн ухсан нүхрүү унав. Мухаммед элч Камиед хандан: “Аллах эзэн чамайг гэсгээн цээрлүүлэг” хэмээн хараав. Ибн-и Камие баярлан ахиад л “Мухаммедыг аллаа! Мухаммедыг аллаа!” хэмээн орилож хашгирав. Мүшрикүүд баярлан Мухаммед элчийн унасан нүхнээс холдоцгоон байлдахаа зогсоожээ.

Мухаммед (салаллаху алейхи уа сальлам) нүхэнд унажээ. Түүний ариун нүүрнээс нь цус гарч уруул, сахал нь цусанд будагдсан байлаа. түүний ганц дусал цус газар унахаас урьтаж Жабрайл сахиусан тэнгэр (алейхиссальлам) нисэн ирж шүүрэн аваад ийн хэлэв: “Аяа, Аллахын хайрт элч минь, хэрвээ энэ цуснаас ганц дусал газар унасан бол хойд ертөнц хүртэл дэлхийг шатаах гал түймэр дуусахгүй байх байлаа” гэв. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам): “Хэрэв миний ганц дусал цус газар унасан юм бол тэнгэрээс гэсгээл буух байлаа. Аяа, Аллах эзэн минь, энэ хүмүүсийг уучил. Тэд юу хийж байгаагаа мэдэхгүй байгаа билээ” хэмээн өөрийг нь алахыг завдаж байсан, гэгээн мөрийг нь шархдуулагч, ариун шүдийг нь хугалагч, нүүрийг цусаар будагч нүгэлт хүмүүсийн төлөө залбирсан юм.

Энэ үед Кааб бин Малик: “Хөөе, хүмүүс ээ! Мухаммед элч амьд байна. Тэр тэнд байна” гэж орилоход мусулманууд дахин амилсан мэт баярлан гүйлдэнэ ирцгээв. Гэгээн Али ба Талха бин Убейдуллах хоёр нүх рүү орон элчийг нүхнээс өргөж гаргав. Гэгээн Эбү Убейде бин Жеррах хайрт пайгамбарын маань эрүүнд шигдсэн дуулганы хэлтэрхийг шүдээрээ зуун гаргав. Энэ төмөрийг гаргахад урд хоёр шүд нь ч бултаран гарав. Асхабуудаас Малик бин Синан Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) нүүрнээс урсах цусыг амаараа соржээ. Энэ үед Мухаммед элч: “Миний цус цусанд холигдсон хүн хүнд тамын гал үл хүрнэм” хэмээв. Мүшрикүүд ахиад элч рүү дайрахыг завдсан ч авч энэ удаа мусульманууд тэднийг огт халдаасангүй, ойртохыг хүссэн хүн бүр газар үхтхийн унаж байлаа. Энэ удаа ямар ч боломжгүй болохыг ойлогсон мүшрикүүд таран зарим нь уулд мацаж эхлэв. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) өөрийн мэргэн харваач Саад бин Эби Ваккаст “Тэд нарыг эргүүл” гэв. Саад: “Надад нэгхэн сум байна пайгамбар минь, би яаж тэднийг эргүүлэх

юм бэ?” гэхэд Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) урьдын тушаалаа давтаж хэлэхэд Саад сумны сарвуугаас гараа явуулан байгаа ганц сумаараа харвахад онилсон газараа унан нэг мүшрикийг унагаав. Ахиад гараа явуулахад нэг сум нь гарт нь баригдав. Ийнхүү тэрээр сумныхаа сав руугаа гараа явуулах бүрдээ сум гарсаар байлаа. Энэ бол Мухаммед элчийн бас нэгэн гайхамшиг юм.

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) нэгэн өндөрлөг толгод өөд гарах хэрэгтэй болов. Гэвч 2 давхар хуяг өмссөн, бас дээр нь 70 удаа сэлэмээр цавчуулсан болохоор ядарсан пайгамбар маань хичнээн зүтгэсэн ч хүч нь хүрэхгүй байлаа. Энэ үед Талха бин Убейдуллах элчийг нуруундаа үүрээд толгодод гарахад элч маань: “Талха Аллахын элчид туслах тэр мөчид диваажин түүнийх болсон юм” гэжээ.

Уулын хормойд асхабууд мүшрикүүдийг цавчин Хатиб бин Белта элчийн өмнө ирээд: “Аяа, Расулуллах, таныг хэн ингэв?” гэж асуулаа. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) “Утбе бин Эби Ваккас над руу чулуу шидэн нүүрийг минь цохилоо, хоёр шүдийг минь хугаллаа” гэхэд гэгээн Хатиб: “Пайгамбар минь, аль зүгт явсаныг нь мэдэх үү?” гэж асуув. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) Утбегийн байгаа зүгийн заан өгөхөд гэгээн Хатиб (радиаллаху анх) тэр зүг рүү гүйн одов. Хайсаар байгаад Утбег олоод түүнийг мориноос нь татаж буулган толгойг нь тас цавчин Мухаммед элчийн өмнө авч ирэв. Расулуллах (салаллаху алейхи уа сальлам) баярлан Хатибын төлөө залбирав. “Аллах чамайг ивээг! Аллахаа чамайг ивээг” хэмээн залбирчээ.

Мүшрикүүд ахин цуглан учир начираа олон хүчирхэгжин байлдаж эхэлсэн мусульмануудыг зогсоож чадахгүй далаад хүнээ алуулаад ухран зугтаацгаав. Элчийг шахид болсон (нас барсан) гэсэн мэдээ Меккед хүрчээ. Гэгээн Фатима, гэгээн Айше, Үммү Сүлейм, Үммү Эймен, Хамнэ Бинти Жажш, Куайбе(радиаллаху анхунне) гэх мэт эзэгтэй нар сандран Ухуд уул руу гүйлдэн ирцгээв. Гэгээн Фатима (радиаллаху анха) эцэгийнхээ шархдасан царайг хараад уйлахад Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) аргадан зогсоов. Гэгээн Али бамбайгаараа ус авч ирэхэд Фатима тэр усаар элчийн нүүрэн дэхь цусыг угаав, гэвч цус тогтохгүй гарсаар байлаа. Фатима жаахан хөвөн шатаан шархан дээр дарахад цус тогтов.

Дараагаар нь дайны талбар луу очицгоов. Юун түрүүнд

шархагсадыг олоод шархыг нь боож цэвэрлэв. Мүшрикүүд зарим шахидүүдийн цогцсыг зэрэмдэглэн хэрчиж хүн танихгүй аргагүй болгосон байлаа. Абдуллах бин Жажш (радиаллаху анх) тэдний дунд байлаа. Тэрний зэрэмдэг болсон цогцсыг нь харсан хайрт пайгамбар маань бас бүх асхабууд маш их гашуудан харамсав. Хамгийн сайн асхабууд шахид болцгоожээ. Тэдний цогцсыг жагсаан даавуугаар бүтээж гунигт харуусалын нулимсаа барьж үл дийлэн уйлцгаана. Хорвоо ертөнцийн энэрэл болсон пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) нулимс унагаан: “Би энэ хүмүүсийг Аллахын ариун шашины замд өөрийн амиа өргөсөнд хойд ертөнцөд гэрч болно. Тэд нарыг цустай нь оршуулцгаа. Аллахдаа амлъя! Хойд ертөнцөд махшарын талбарт энэ цустайгаа хамт ирэх болно. Өнгө нь цусан өнгөтэй. Үнэр нь анхилуун үнэртэй ирцгээх болно” хэмээв.

Хайрт пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам): “Хамза харагдахгүй байна, тэр хаана байна?” гэж асууж сураглав. Гэгээн Али Хамзагийн цогцсыг хайж олжээ. Мухаммед (салаллаху алейхи уа сальлам) түүний хажууд ирээд хүн итгэхийн аргагүй аймшигт дүр төрхийг харлаа. Учир гэгээн Хамзагийн чих хамар уруул нь огтлон, гэдэсийг хүлээн доторыг нь гаргаж зэрэмдэглэжээ. Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) ариун нүднээс нулимс бөмбөрөн гашуудалын хар үүл түүнийг бүрхжээ. Хөл дээрэ тогтож үл чадан газар суугаад Хамзаад хандан: “Аяа, Хамза урьд өмнө нь нэг ч хүн чам шиг гай зовлонтой учираагүй билээ. Учрах ч үгүй биз. Аяа, Аллахын элчийн ах аа! Аяа, Аллахын арслан, бар, баатар Хамза! Аяа, буянт үйлсийн эзэн Хамза! Аллах эзэн чамайг ивээлдээ аваг...” гэж хэлэв.

Энэ үед нэгэн эмэгтэй гүйн ирж яваа нь харагдав. Энэ хүн бол хайрт пайгамбарын маань авга эгч Сафия эх байлаа. Тэр ч мөн адил Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) нас барсан гэх худал мэдээг дуулаад сандран Мединегээс гүйн ирж яваа нь энэ юм. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) Зүбейр бин Аввамд “Ээжийгээ тогтоо, буцаа! Тэр энд дүүгээ (Хамзааг) харах нь хүнд тусна” гэв. Гэгээн Зүбейр ээжийнхээ өмнөөс гүйн очоод зогсоов. Гэгээн эх сандарсан байдалаар “Хүү минь! Мухаммед элч амьд мэнд үү?” гэв. Гэгээн Али тэдний “Аллахын элч мэнд байна” гэхэд нь баярлан “Надад харуулаач” гэв. Али элч рүү заан харуулахад тэрээр Аллахдаа баярлан талархав. Дараа

нь Хамза дүүгээ харах гээд урагшилахад хүү Зүбейр: “Ээж минь! Аллахын элч таныг буцахыг зарлиглаж байна” гэхэд гэгээн Сафия: “Хэрвээ түүнд тохиолдсон зүйлийг надад үзүүлэхгүйгээр буцаах гэж байгаа бол би тэртээ тэрэнгүй дүүгийнхээ цогцсыг яараглан сийжсэнийг нь мэдэж байна. Тэр ийм байдалтайгаар Аллахын замд тэмцсэн юм байна. Бид энэ замд л байгаа бол хамаагүй, түүнээс илүү яараглалд бэлэн биш гэж үү? Буян хишигийг нь Аллах өгөхөөс цааш...” гэв. Энийг Зүбейр бин Аввам Мухаммед элчид (салаллаху алейхи уа сальлам) ирж хэлэхэд Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам): “Тийм бол хараг” гэв. Гэгээн Сафия Хамза шахидийн хажууд ирж цогцсыг нь хараад хажууд нь суугаад чимээгүйхэн уйлав.

Гэгээн Сафия ирэхэд хоёр дээл авч ирсэн байлаа. Тэрийгээ гаргаад: “Энэнийг Хамза дүүдээ авч ирсэн юм. Түүнд өмсгө” гэв. СЕЙД ҮШ-ШҮХЕДА, өөрөөр хэлбэл, шахид бологсодын хаан болсон гэгээн Хамзааг энэ дээлтэйгээр оршуулжээ.

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) ба мусульманууд далбааг баригч Мусаб бин Умейрийн цогцос руу очив. Гэгээн Мусабын хоёр гар тайрагдсан, маш олон газартаа шархдан цусны дунд хэвтэнэ. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) маш их гашуудан энэ гэгээн шахидэд хандан Азхеб сүрегийн (бүлэг) 23-аэтийг уншжээ. Утга нь: “Мусульмануудын тийм нэгэн баатар байдаг юм. Тэд Аллах эзэнд өгсөн амлалтандаа үнэнч, тэдний зарим нь шахид (үхэх хүртэл) болох хүртэлээ дайран гэсэн үгэндээ хүрч (шахед болдог). Зарим нь шахед болох гэж хүлээдэг. Тэд нар амласан амлалтаасаа хэзээ ч буцдаггүй” хэмээжээ.

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) асхабууддаа нафсийг (хүний хүсэл тачаал) бодон: (“Аяа Асхабууд минь! Одоо бид) бага дайнаас их дайн руу байлдахаар явж байна” хэмээжээ. Дараа нь бүх хүмүүсийг гэртээ очиж амрахыг, шарх соривоо боож эмчлэхийг хүсээд өөрөө ч гэсэн амрахаар гэр лүүгээ явав.

Хамра-үл Эсэд рүү явсан нь

Маргааш өдөр нь Аллахын элч (салаллаху алейхи уа сальлам) Медине рүү мусульманууд буцсаны дараа мүшрикүүд эргэн ирж Мединег эзэлж магадгүй гэсэн болгоомжлолоор, бас өчигдөрийн дайнд мусульманууд хүчин мөхөсдөөгүйг мэдүүлэх

гэж Билал Хабашийг явуулан.: “Аллахын элч та нарыг дайсануудыг араас нь нэгэн хөөхийг тушааж байна. Өчигдөр Ухуудад бидэнтэй хамт байлдаагүй хүмүүс биш, зөвхөн байлдагсад ирэх ёстой” гэсэн мэдээг тараав. Шархдасан байлаа ч үтэр түргэн цуглацгаав. Тэр бүү хэл хамгийн хүнд шархадсан Абдуллах бин Рафи Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) энэ мэдээг сонсоод хамаг хүчээ шавхан байж “Мухаммед элчтэй хамт байлдах энэ завшааныг алдах гэж үү?” хэмээн босон хувцасаа өмсөн иржээ.

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) асхабуудаа дагуулан мүшрикүүдийг нэхэн хөөв. Ревха гэх газар мүшрикүүд цуглараад буцаад Мединег хотыг дайлаар мордохоор шийд гаргасан байлаа.

Мүшрикүүд мусульман цэрэгүүд ирж байгаа мэдээг дуулсан даруйдаа айн, үтэр түргэн Мекке рүү зугтаацгаав. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) тэд нарыг Хамра-үл Эсэд гэх газар хүртэл нэхэн хөөжээ. Мүшрикүүдээс хоёр хүн баригдан олзлогджээ. Мусульман цэрэгүүд энэ газар 3 хоног байрлаад дараагаар нь Медине рүү буцжээ.

Аллах эзэн Хамра-үл Эсэд рүү явсан гэгээн асхабын талаар Куран сударт ийн магтан дуулжээ: “Шархдасаныхаа дараагаар, ахиад Аллах Теалагийн ба Түүний элчийн урилгийг хүлээн зөвшөөрөн ирэгсэд ба тэр дундаас сайн сайханыг хийн, муу муухайгаас зугтаагсадад маш том нэгэн буян бий” (Али Имран сүре, 172)

Ухудын дайнд Мухаммед элчийг (салаллаху алейхи уа сальлам) ална гэж амласан Ибн-и Камиа Меккед гэртээ ирсэнийхээ дараагаар нэг шөнө хонио эргэхээр гарчээ. Хонь ч ууланд байхыг харчихаад буцах гэтэл нэгэн том хуц Ибн-и Камиаг мөргөсөөр байгаад алжээ. Абдуллах Шихаб-и Зүхриг Мекке хот руу буцах замд хорт могойд хатгуулан үхжээ.

Режигийн явдал

Ухуд дайны мэргэн харваач Асим бин Сабит энэ дайнд мүшрикүүдээс Мусафи бин Талха ба түүний дүү Харис нарыг алжээ. Энэ мүшрикүүдийн эх болох Сүнаф бинти Санд өширхөн хөвгүүдийнхээ алуурчин Асим бин Сабитын толгойг авч ирсэн хүнд 100 тэмээ өгөхөө амлан зар тараав. Бас Асимийн гавалын ясаар ундаа уухаа амалжээ. Бас Лихяны хөвгүүд овгийн Халид

бин Сүфян үхсэн болохоор өширхөн Лихян овгийнхон Меккегийн хажууд байх Адел ба Каре гэх хоёр овгийнхонтой тохиролцжээ.

Энэ хоёр овогт: “Та нар бид мусульман болцгоолоо, зекетээ (өргөл барьцаа) ч өгнө. Энэнийг авах бас бидэнд ислам шашиныг заах нэг багш явуулцгаа” гэж Мухаммедээс хүсэцгээ. Бид ирсэн хүмүүсийг алж өшөөгөө авцгаах болно” гэв.

Их нүүдэлээс 4 жилийн дараа энэ хоёр овог 6-7 хүнтэй хэсэг төлөөлөгчид Мухаммед элчид ирцгээж: “Бид мусульман болцгоосон, бидэнд Куран Каримийг заах багш нар өгөөч” гэцгээв. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) Меккегийн мүшрикүүдийг тагнаж байх хэсэг тагнуулчидийг явуулахаар зэхэж байлаа. Адел ба Каре овгийнхон багш нар гуйхаар нь тэнд исламыг заахын хажуугаар Меккег тагнах зорилгоор 10 хүнтэй тагнуулыг ирэгсэдтэй хамт явууллаа. Энэ хүмүүс бол: Мерсед бин Эби Мерсед, Халид бин Эби Букейр, Асим бин Сабит, Хубейб бин Адый, Зейд бин Десинне, Абдуллах бин Тарик, Муаттиб (Мугир) бин Убейд ба нэр нь мэдэгдээгүй 3 асхаб бас байлаа.

Энэ хэсэг тагнуулууд өдөр нь нуугдан шөнө нь явсаар өглөөгүүр Режи гэх нэг голын эрэг дээр иржээ. Тэнд хэсэг амраад дараа нь тэндээсээ зайдуу нэг ууланд гарч нуугдацгаав. Хүзейл овгийн хонь хариулж яваа нэгэн авгай Режи голын эрэг дээр ирээд тэнд байх идсэн хоолны үлдэгдэлийг хараад Мединегийн хурма байхыг анзаарав. “Тэр Мединегээс хүмүүс ирсэн байна” гээд орилон овгууддаа мэдээ өгөв. Нуугдаж буй мусульмануудыг дагуулж явсан хоёр нүүртэнгүүдээс нэг нь сэмхэн холдон Лихягийн хөвгүүд овгийнханд очоод мэдээг дуулгажээ.

Лихягийн хөвгүүд овгийнхон энэ мэдээг дуулангуутаа 100 харваачтай нийт 200 цэрэгийг энэ хэдхэн хүн рүү илгээв. Энэ цэрэгүүд гэгээн Асим бин Сабит ба түүний нөхөдийг буслэлтэндээ авчээ.

Гэв гэнэт 10 асхабыг алахаар ирсэн хүмүүс мүшрик цэрэгүүдтэй нийлэх тэр үед мусульманууд хууртагдсанаа ойлгож тэдэнтэй байлдахаар шийдэцгээв. Мүшрикүүд: “Хэрвээ та нар бууж өгөх юм бол бид та нарыг алахгүйгээ амлаж байна, бид та нарыг барьцаалан Мухаммедэд буцааж өгөх болно” гэв.

Мусулманууд “Мүшрикүүдийн ямар ч амлалтанд итгэж болохгүй” хэмээн тэдний бүх болзолыг хүлээн зөвшөөрсөнгүй. Асим бин Сабид: “Би хэзээ ч мүшрикүүдийн тусламжинд итгэж найдахгүй, тийм болохоор уулнаас буун бууж өгөхгүйгээ амлаж

байна” гэв. Тэгээд алгаа дэлгэн: “Аллах минь, бидний энэ байдлыг элчид мэдэгдээч” хэмээн залбирав. Асимын энэ залбирал биелэгдэн Мухаммед элчид (салаллаху алейхи уа сальлам) тэдний талаар мэдээ хүрсэн байлаа.

Гэгээн Асим: “Бид үхэлээс айхгүй байна. Ягаад гэвэл бид үхэх юм бол шахид болоод диваажинд орох болно” гээд мүшрикүүд рүү харваж эхлэв. Асимд 7 сум байлаа. Энэ сумаараа 7 мүшрикийг харваж алав. Сум нь дуусангууд жадаа барин хэдэн хүнийг сүлбэж орхив. Тэднийг дөхөн ирэхэд сэлэмээ сугалаад хуйыг хугалан хаяв. (Энэ нь үхэх хүртэлээ тэмцэлдэхийн шинж тэмдэг билээ) Дараа нь: “Аяа, Аллах минь, би өнөөдөрийг хүртэл чиний шашиныг мэдэж сурлаа. Чамаас энэ өдөрийг дуустал амыг минь хамгаалахыг хүсэж байна” хэмээн залбираад “Аллаху Акбар!” хэмээн уриалаад 200 цэрэг рүү дайран орлоо. Тэдний маш хүчтэй эсэргүүцэл мүшрикүүдийн зүрхэнд айдас өгчээ. Ойртсон болгон цавчигдан газар унаж байв. Кафирууд ойртож чадалгүй холоос харвасаар 10 асхабын долоог нь шахид (алж) болгон гурвыг нь олзложээ.

Мүшрикүүд Сүлафе бинти Саадад зарахаар Асим бин Сабитын толгойг авахыг хүссэн боловч Аллах эзэн Асимын залбиралыг биелүүлж зөгийн сүрэгийг тэдэн рүү илгээв. Үүл мэт зөгийн сүрэг Асимийн дээр эргэлдэн хэн ч ойртож чадсангүй тул “Больцгоо орой болохоор зөгийнүүд алга болно тэр үед ирж авцгаая” гэв.

Харин орой нь маш хүчтэй аадар бороо орон үер буусан болохоор Аллах Асимын цогцсыг урсган авч оджээ. Мүшрикүүд түүнийг хичнээн хайсан боловч олж чадсангүй.

Мүшрикүүдийн олзлосон 3 асхаб бол Хубейв бин Адый, Зейд бин Десинне, Абдуллах бин Тарик нар (радиаллаху анхум) юм. Абдуллах бин Тарик (радиаллаху анх) уяагаа тасдан зугтаахыг оролдож байв. Мүшрикүүд ч түүнд чулуу нүүлгэн шахид болгожээ. Харин үлдсэн хоёр мусульман магадгүй Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) даатгасан тагнуулын ажилаа үргэлжлүүлэх боломж гарч магадгүй хэмээн тэвчээртэйгээр хүлээжээ.

Мүшрикүүд олздлогсон хоёр мусульманыг Меккед аваачихад Хужейр бин Эби Ихаб-и Темими Бедир дайнд алдсан дүүгийнхээ өшөөг авахаар Хубейбийг, Сафван бин Умейр Бедир дайнд амь үрэгдсэн эцэгийнхээ өшөөг авахаар Зейд бин

Десиннег (радиаллаху анх) худалдан авцгаав. Тэд тэр хоёрыг алахыг завдсан боловч энэ сард арабуудын хувьд цус урсгах нь цээртэй сар байсан болохоор олзлогсодыг гянданд хорьжээ.

Хубейб бин Адый ба Зейд бин Десинне хоёрыг (радиаллаху анх) алахаар товолсон өдөр иржээ. Өглөө нь тэднийг гинжнээс суллан Мекке хотын захад Темим гэдэг газар аваачив. Меккегийн мүшрикүүд цаазаар авах ёсыг харахаар цөм цуглацгаажээ.

Мүшрикүүд цаазлагдах газар мусульмануудын хөлийг тушин өлгөх модонд ойртуулахад Хубейб (радиаллаху анх): “Намайг сулал, би хоёр рекаат (үе) мөргөл үйлдмээр байна” гэв. Түүнийг суллан: “Энд мөргөлөө хий” гэв. Хубейб хоёр рекаат (үе) мөргөл үйлдэв. Тэнд байх эмс хүүхэнүүд, хөгшин залуугүй түүнийг амьсгал даран харцгаана. Намаз (мөргөл) үйлдэж дуусаад: “Хэрвээ үхэлээс айж мөргөлөө сунжруулж байна гэж бодоцгоохгүй байсан бол мөргөлөө маш удаанаар үйлдэх байлаа” гэв. Ийнхүү цаазлагдахынхаа өмнө хоёр үетэй мөргөл үйлдэх ёсыг анх тавигч хүн нь Хубейб бин Адый (радиаллаху анх) юм.

Хубейбын (радиаллаху анх) хүзүүнд олсыг уяаад, толгойг нь Медине хотын зүг харуулан: “Хэрэв чи шашинаасаа гарах юм бол амийг чинь хэлтрүүлъя” гэв. Тэр ийм хариулт өгчээ: “Аллахын нэрээр тангараглая, дэлхий ертөнцийг надад өгсөн ч би ислам шашинаасаа гарахгүй!” гэв. Тэд ахин “Одоо чиний оронд Мухаммед өлгөгдөхөд баярлах байсан уу? Хэрвээ чи “Тийм ээ” гэж хариулбал бид чамайг суллан явуулъя” гэв. Тэрээр: “Би Мухаммед элчийн биенд ганц өргөс орохыг ч хүсэхгүй” гэв. Мүшрикүүд инээлдэн түүнийг доромжилоод “Хөөе, Хубейб! Ислам шашинаасаа гар! Бид чамайг суллая, үнэндээ бид чамайг алахыг хүсэхгүй байна” гэв. Хубейб: “Аллахын замд байсан цагт үхэл бол аймшиг биш ээ” хэмээн зоригтойгоор очив.

Хубейбын (радиаллаху анх) хажууд цугласан мүшрикүүд “Энэ бол бидний аавыг алсан алуурчин” хэмээн жадаар хатгаж эхэлхэд Хубейб ариун Каабын зүг харлаа. Мүшрикүүд түүний толгойг Меккегийн зүг эргүүлхэд Хубейб: “Аллах минь, хэрэв би чиний хувьд үнэнч боол бол миний толгойг Каабын зүг харуулаач” гэж залбирав. Мүшрикүүд хичнээн оролдсон ч Хубейб (радиаллаху анх) Каабын зүг харсаар байлаа. Хубейб: “Аллах минь, Курейш мүшрикүүдийг гэсгээн цээрлүүл! Тэднийг тархаан бутарга! Шаналган зовоо! Тэгээд нэг нэгээр нь амийн

ав! Миний өшөөг тэднээс ав!” хэмээн орилон хараал хэлэв. Энэ үгийг сонссон мүшрикүүдийн зарим нь чихээ даран зугтаацаав. Зарим нь улам уурлан түүнийг дуугүй болгох гээд цээжинд жадаа нэвт зооход Хубейб: “Эшхэдү эн лаа илааха иллаллаху вэ эшхэдү энна Мухаммеден абдүхү вэ расүүлүх (Аллахаас өөр залбирч мөргөж болох бурхан үгүйг би гэрчилнэ, бас Мухаммед бол Аллахын элч бас боол нь мөн болохыг гэрчилнэ) гэж хэлээд амьсгал хураажээ.

Зейд бин Десиннег ч (радиаллаху анх) шашинаасаа гарахыг тулгасан боловч тэдний энэ үйлдэл харин ч эсрэгээр түүний итгэлийг улам лавшируулжээ. Мүшрикүүд түүнийг модонд боогоод харван шахид болгожээ.

Бир-и Мауне түүх

Мөн тэр жил Сафер сард Арабын Нежд аймагийн дарга Эбү Бера Амир бин Малик Медине хотод Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) мэнд амарыг мэдэхээр иржээ. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) түүнд исламыг номлон мусульман болохыг санал болгов. Эбү Барре мусульман болсонгүй. Гэхдээ ислам шашин шударга сайхан шашин болохыг мэдэгджээ. Бас Нежд аймагт ислам шашиныг номлон түгээх хэдэн хүн илгээхийг гуйв. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам): “Бидний явуулсан хүмүүст муу зүйл хийхгүй байх гэж итгэж чадахгүй байна” гэв. Эбү Амир “Тэднийг би өөрөө хамгаална, хэн ч муу зүйл хийж чадахгүй” гэж ам өчгөө өгөв.

Энэ үгийг хүлээн зөвшөөрсөн асхаб-и Суффегээс 70 хүнийг Мүнзир бин Амрыг толгойлогчоор томилон илгээв.

Эбү Берра тэднээс өмнө өөрийн нутагтаа ирээд ард иргэддээ ислам шашин заахаар Медине хотоос 70 мусульман ирж буйг, тэднийг өөрийн хамгаалалтандаа байлгахаар амласаныг, бас тэднийг энд байх хугацаанд хэн ч тэдэнд муу зүйл хийж болохгүйг ард иргэдээс дахин амлалт авав. Тэнд байгсадаас зөвхөн Амир бин Туфейлээс бусад нь ам өчгөө өгцгөөв. Эбү Беррагийн зээ дүү Амир бин Туфейл 3 овгийн цэрэгийг аваад Бир-и Мауне гэх газар асхабуудыг отож эхлэв. Дөрвөн талаасаа дайралтанд өртсөн асхабууд сэлэмээ сугалан нэг хүнээс бусад нь цөм үхэх хүртэлээ баатарлагаар тулалдав.

Энэ Асхабуудын сүүлчийн үг нь: “Аяа, их эзэн минь! Яг

одоо Аллахын элчид бидний мэдээг хүргэхээс өөр гуйх зүйл байхгүй билээ. Түүнд бидний мэндийг дамжуул” гэцгээв. Тэр үед Жабрайл (алейхиссальлам) гашуудалтайгаар ирэн Мухаммед элчид (салаллаху алейхи уа сальлам) асхабуудынхан талаар мэдээг хүргэн иржээ. “Тэд нар Аллах эзэнтэй золголоо. Аллах эзэн тэдний хийсэн үйлд баярласан юм.” хэмээв. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) уйлан асхабууддаа хандан: “Бидний ахан дүүс мүшрикүүдтэй баатарлагаар тулалдлаа, мүшрикүүд тэднийг цавчин, жадаар сүлбэн хөнөөжээ” хэмээв.

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) Режи ба Бир-и Маунед болсон явпалд маш их гомдон харамсаж, нэг сар мөргөл болгоныхоо хойноос энэ муухай нүгэл үйлдсэн отог овгийн төлөө хараан залбирал үйлдэв. Аллах эзэн элчийнхээ залбиралыг биелүүлэн тэр овгуудад ган гачиг байгалийн гамшиг өгч, дараагаар аймшигт тахал өвчин өгсөнөөр 700 хүн үхжээ.

Бени Надирын Жүүдүүд

Ухудын дайны дараагаар Надирын хөвгүүд гэх овгийн жүүдүүд Мухаммед элчид (салаллаху алейхи уа сальлам) хор хөнөөл хийхийг завджээ. Энэнээс урьтаж Жабрайл (алейхиссальлам) Мухаммед элчид (салаллаху алейхи уа сальлам) мэдэгдсэн болохоор энэ төлөвлөгөө нь бүтэлгүй болжээ. Мухаммед элч маань хийсэн гэрээ тангарагаасаа няцсан Жүүдүүд рүү Мухаммед бин Меслемээг явуулав. “Надир хөвгүүд овгийн жүүдүүд рүү оч! Мухаммед элч хэлж байна: Та нар Мединегээс үтэр түргэн гарч явцгаа. Энэ хотод надтай хамт амьдарч болохгүй. Та нар надад нэг хор хөнөөл хийхээр төлөвлөсөн. Гэвч бүтсэнгүй, та нарт 10 хоногийн хугацаа өгч байна. Энэ хугацаа дууссаны дараагаар Меккед та нараас хэн л харагдана, толгойг цавчих болно гэж хэл” гэв.

Мухаммед бин Меслеме (радиаллаху анх) энэ үгийг жүүдүүд рүү очиж хэлэхэд тэд айсандаа замд гарах бэлтгэлээ хийж эхлэв. Гэвч мунафикуудын (хоёр нүүртэй) толгойлогч Абдуллах бин Убей жүүдүүдэд “Нутагаасаа битгий гарцгаа, эд хөрөнгө гэр орноо хаян битгий зугтаацгаа, би 2000 цэрэг аваад та нарт туслахаар ирж явна” гэсэн мэдээг явуулав. Энэ мэдээг мэдсэн Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) өөрийн асхабуудаа аваад Медине хотоос 4 км зайдуу орших Надир

хөвгүүд гэх тосгон руу хөдлөв. Исламын далбааг гэгээн Алид (радиаллаху анх) бариулан тосгоныг бүслэлтэндээ авчээ. Өмнө нь мусульмануудыг үл тоон онгирч байсан жүүдүүд гэртээ бүгэн толгойгоо ч үл цухуйлгана. Мунафикуудын (хоёр нүүртэн) тусламж ирж амжсангүй. Жүүдүүд бууж өгсөний дохио болгон далбаагаа бөхийлгөн өөрсдийн зэр зэвсэг эд хөрөнгөө орхин зарим хэсэг Шам хот руу, зарим хэсэг нь Хайбер хот руу цөллөгджээ. Ийнхүү Медине хот дахь жүүдүүдээс зөвхөн Курейзегийн хөвгүүд гэх овог үлджээ.

Фатима бинти Эсэдийн үхэл

Архи уух нь харам (цээрлэгдсэн) болсон ает их нүүдэлийн 4 дэхь жилд илгээгджээ. Ухуд дайнд шархдан нас барсан гэгээн Үммү Сэлекегийн (радиаллаху анх) нөхөр ардаа хэдэн хүүхэдээ өнчрүүлэн оджээ. Үммү Сэлеке эх хөгшин нуруун дээрээ амьдралын хүнд ачааг үүрч бэлэвсэрч хоцорсонд Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) маш их өрөвдөн түүнтэй гэрлэх ёслол үйлджээ.

Бас энэ жил Затуррика дайн хийн хажуу хавийн отог овогийг мусульман болгов.

Гэгээн Османы (радиаллаху анх) Мухаммед элчийн охин гэгээн Рукайегээс төрсөн хүү Абдуллах энджээ. Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) зээ хүүгийнхээ жаназа (оршуулгын) намазыг уншиж өөрийн гараар оршуулжээ.

Гэгээн Алигийн эх Фатима бинти Эсэд мусульман болон нас баржээ. Энэ явдалд Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) маш их гашуудан: “Өнөөдөр миний ээж нас барлаа” хэмээжээ. Учир нь пайгамбар маань өвөө Абдулмутталиб нас барсаны дараагаар түүний хажууд өсөн торнижээ. Элч болсоноо мэдэгдэхэд шууд мусульман болсон юм. Тийм болохоор төрүүлээгүй ч гэсэн элч ээж шигээ хайрлан дээдлэдэг байлаа. Түүнийг гэх хайр энэрэлээр нь пайгамбар маань цамцаа тайлан түүнийг өөрийн цамцаар ороон оршуулахыг хүсэв. Жаназе намаз бэлэн болсоны дараагаар намазд 70 мянган сахиусан тэнгэр ирж нэгдсэнийг мэдэгджээ.

Түүний цогцсыг өөрийн гараар булшний нүхэнд өөрийн гараар тавив. Тэрээр уйлахад ариун нүднээс нь унасан нулимс булшний нүх рүү дуслана. Гэгээн Омар (радиаллаху анх): “Амиа

таны төлөө өргөө Расулуллах! Хэнд ч хийгээгүй энэрэл, ивээлийг та түүнд хийлээ!” гэхэд энэрэл хайрын дээд нь болсон элч (салаллаху алейхи уа сальлам): “Эбү Талибаас хойш энэ хүнээс өөр надад хийсэн буян ихдэсэн хүн байхгүй билээ. Тэр бол миний ээж билээ. Өөрийнхөн хүүхдүүд өлсгөлөн байхад түрүүлж намайг цатгадаг байсан юм. Өөрийнхөн хүүхдүүд тоос шороонд хутгалдаж байхад түрүүлж миний үсийг самнан цэцэгийн тосоор тослодог байсан юм. Тэр бол миний ээж байсан юм!

Түүнд диваажингийн хувцас өмсгөхийн тулд өөрийнхөө цамцыг өглөө. Булшных нь амьдрал хөнгөн байлгахын тулд булшинд хамт хэвтлээ. Жабрайл надад ирээд “Энэ хүн бол диваажингийн хүн гэж мэдэгдлээ” хэмээжээ.

Хэсэг хугацааны дараагаар элчийн эхнэр гэгээн Зейнеф бинти Хузейме 30 настайдаа нас нөгчжээ. Энэ жил гэгээн Али ба Фатима хоёрын хоёр дахь хүү Хусейн мэндэлжээ.

Бас энэ жил Меккегийн мүшрикүүдээс Эбү Сүфиянаар толгойлуусан 2000 цэрэг исламыг зогсоохоор Бедир лүү хөдөлжээ. Мухаммед элч 1500 баатар цэрэгүүдээ аван тэднээс урьтаж очжээ. Мусульман цэрэгүүдийн өөрсдөөс өмнө Бедирт хүрсэнийг сонссон мүшрикүүд айн Мерразахран гэдэг газараас ухарцгаажээ. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) мүшрикүүдийг 8 өдөр Бедирт хүлээгээд ирээгүй болохоор Медине рүү буцжээ.

Бени Мусталик дайн

Хижрегийн 5 дахь жилд Мусталикын хөвгүүд гэх овгийн толгойлогч Харис бин Эби Дирар Мухаммед элчтэй (салаллаху алейхи уа сальлам) байлдахаар олон цэрэгээ цуглуулан Медине рүү хөдлөжээ. Энэ мэдээг сонссон пайгамбар маань маш хурдан 700 цэрэгээ бэлдэн дайсаныг тосон замд гарав. Юун түрүүнд дайсануудаа исламд уриалав. Тэд хүлээн зөвшөөрөөгүй тул эхэлж сум тавьсанаар дайн эхэлжээ. Мухаммед элчийн “Бүгдээрээ нэгэн зэрэг гэнэт дайрцгаа” гэсэн тушаалыг биелүүлж асхабууд дайсаны цэрэгүүдээс 10 хүнийг алав. Овгийн дарга амиа аван зугтаасан боловч түүний охин Берре ба 600 хүн мусульмануудад олзлогджээ. Дайны олзоо мусульманууд хуваан авав. Берра Мухаммед элчид (салаллаху алейхи уа сальлам) бараалхан: “Намайг авсан эзэндээ 9 алтан зоос өгөөд эрх чөлөөгөө авахаар

боллоо, надад туслаач” гэж элчээс гуйв. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) энэрэнгүйгээр түүний гуйлтыг биелүүлэн алтнуудын өгчээ. Тэрээр элчийн уриалсанаар мусульман болов. Түүнийг мусульман болоход маш их баярлан пайгамбар маань өөртэйгээ Никах (гэрлэх ёслол) үйлдэн ивээжээ. Дараагаар нь мусульманууд бид элчийн гэргийгийн хамаатан саданыг боол болгон ажилуулахаас ичиж байна” хэмээн олзлогсодыг цөмийг нь суллажээ. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) өөрийн эхнэрийнхээ Берре нэрийг нь Жувейре болгон өөрчилжээ. Гэгээн Жувейрегийн (радиаллаху анха) талаар гэгээн Айше эх: “Би Жувейре эх шиг буян хишигтэй, хайр ивээлтэй эмэгтэйг хараагүй билээ” хэмээжээ.

ХЕНДЕК ДАЙН

Хижретийн (их нүүдэл) 5 дахь жил Мединегээс гарсан өдөөн хатгалаг болон эвдрэлцэлийн эхлэлийг Надир хөвгүүд гэх овгийн жүүдүүд тавьжээ. Хоорондоо хуваагдацгаан зарим нь Шам руу зарим нь Хайбер хот руу явцгаажээ. Гэхдээ тэдний гол зорилго бол исламын гэрэлийг унтрааж, элчид өвөрлөсөн өс хонзонгоо авах байлаа. Жүүдүүийн толгойлогч Хуйей өөрийн овгийн толгой хүмүүс болох 20 хүнийг аваад Мекке рүү Эбү Сүфиянтай уулзахаар явжээ. Мухаммед элчийг (салаллаху алейхи уа сальлам) дайлаар морьдох талаар зөвлөлдөв. “Энэ ажилийг бүрэн дуусгах хүртэл та нарын хажуугаас холдохгүй” хэмээн ам тангарагаа өргөцгөөв.

Мүшрикүүд дайнд бэлдэж эхэлцгээжээ. Хөрш мүшрик аймаг руу мэдээ хүргэн дайнд уриалцгаав. Мөнгө, хурма жимсээр зэр зэвсэг худалдан авцгаав. Мүшрикүүд Меккегээс 4000 цэрэгтэй том арми босгожээ. Эбү Сүфиян Дар-үн Недве гэх газар далбаагаа намирган Осман бин Эби Талхад атгуулжээ. Тэнд 300 морин цэрэг ба тоо тоомшгүй зэвсэг байлаа.

4000 цэрэг Мерраззахран гэх газар ирэхэд Сүлейман хөвгүүд, Фезаре хөвгүүд, Мүрре хөвгүүд, Эсэд хөвгүүд гэх мэт овгуудаас бүрдсэн 6000 цэрэг ирж нийлэн дайсаны цэрэгийн 10000 давжээ.

Эрт үеээс Мухаммед элчид (салаллаху алейхи уа сальлам) итгэн мусульман болсон Хузаа овог Медине рүү энэ байдалын талаар мэдээ илгээжээ. 10 хоногийн замыг 4 хоногт туулсан

тагнуул Мухаммед элчид (салаллаху алейхи уа сальлам) ирж мүшрикүүдийн талаар мэдээг дуулгав.

Хайрт пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) асхабуудтайгаа зөвлөлдөн хурал хийж дайныг хаана, хэрхэн хийх талаар төлөвлөгөөг боловсруулав. Селман-и Фариси: “Аяа, Расулуллах, миний өөрийн төрж өссөн нутагт нэгэн дайны төлөвлөгөө бий. Дайсаны гэнэтийн дайралтаас болгоомжилж хотынхоо гадуур маш том гуу жалга ухдаг юм” гэв. Энэ санаа Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) ба асхабуудад таалагдаж хэрэгжүүлэхээр тохиролцгоов.

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) гуу жалга ухан газарыг асхабуудтайгаа шийдэцгээв. Мединегийн өмнө зүгт Хурма модны цэцэрлэг шигүү ой мод байгаа болохоор дайсанууд энэ зүгээс довтлох нь хэцүү бас тэдэнд хор хөнөөлтөй юм. Дорно зүгт болохоор мусульмануудын гэрээ хэлэлцээр хийсэн Бени Курейза нэртэй жүүдүүдийн хороолол байлаа. Тийм болохоор мүшрикүүд зөвхөн хойд зүг ба умард зүгээс л дайрах магадлалтай, энэ хоёр зүгт нүх ухахаар болов. Ухах газараа хүн бүрт хувааж өгөв. Нэг хүний ухах газар бол 3-4 м гүн, 3.5 м урттай өргөн нь хариасан морь хүрч чадахааргүй байхаар тийм нүх ухах ёстой юм. Хугацаа маш бага дайсанууд аль хэдийн замд гарсан, ирж байгаа. Тийм болохоор энэ гуу жалгийг маш хурдан ухаж бэлэн болгох ёстой юм.

Хайрт пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) хамгаас түрүүлж хүрээ барин “Бисмиллахир рахманиррахим” гэж хэлээд ухаж эхлэв. Асхабууд түүний дараагаар ханцуй шамлан ажилдаа шалавхан орлоо. Хөгшин залуу, хүүхэд, эмэгтэйчүүд гэлтгүй Медине хотынхон цөм ажиллаж байлаа. Нүхнээс гарсан чулуу Мекке талд асгагдаж байлаа. Дайсанууд руу шидэх гэж зэхэн сагсгүй хүмүүс хормойгоороо чулуу зөөнө. Хамгаас түрүүнд хайрт пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) ядартлаа ажилдаг байлаа. Үүнийг харсан асхабууд улам хүчирхэгжин: “Аяа, Аллахын элч! Бид ажиллаж байхад та битгий ажил хүчээ гамна, та амар” гэсэн ч “Би ч гэсэн энэ буянт ажилыг хийн буян хураамаар байна” гэв.

Тэр жил зун ган гачигтай болсоны хажуугаар маш хүйтэн байлаа. Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) хамтаар бүхий л асхабууд өлсгөлөнд нэрвэгдсэн хэцүү үе байлаа. Өөрсдийгөө хүчтэй гэж бодохын тулд гэдсэндээ чулуу

уядаг байв.

Хорвоогийн энэрэлт элч (салаллаху алейхи уа сальлам) өөрөө өлссөндөө бус энэ хүйтэнд ажиллаж өлсгөлөн ажиллаж байгаа мусульмануудад маш их санаа зовон өрөвдөж байлаа. “Аллах минь! Хойд ертөнцийн диваажингийн амьдралаас өөр зүйл таниас хүсэхгүй, аяа, Эзэн минь! Ансар ба мухажируудад энэрэлээ илгээ” хэмээн зогсолтгүй залбирна.

Гуу жалга ухах ажил өглөө эрт эхлээд орой болтол үргэлжилнэ. Нэг өдөр Али бин Хакем (радиаллаху анх) хөлөө гэмтээжээ. Түүнийг моринд мордуулаад элчийн өмнө авч ирэхэд Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам): “Бисмиллахир рахманиррахим” гэж хэлээд хөлийг нь илбэхэд тэр дороо цус нь тогтон илааршжээ.

Жалга ухаж байх явцад чулуунаас хатуу газар таарчээ. Хичнээн оролдовч ухаж чадахгүй хатуу аж. Мусульманууд элчид мэдээ хүргүүлэв. Хайрт пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) жалганд ороод нэг аяга ус өгөхийг хүсэв. Дараа нь усыг амандаа балгаад хатуу газар луу цацсанахаа дараагаар жоотугаа аван цохиход нөгөө чулуу мэт хатуу газар бутран элс мэт зөөлхөн болсон нь элчийн нэг гайхамшиг байлаа. Мухаммед элчийг (салаллаху алейхи уа сальлам) өлсөөд гэдэсэндээ чулуу уяж байгааг харсан Жабир бин Абдуллах (радиаллаху анх) маш их өрөвдөн элчээс: “Та надад түр чөлөө өгөөч, би гэртээ очоод ирмээр байна” гэв. Чөлөө авсанахаа дараах явдалыг Жабир ийн хүүрнэжээ:

“Элчээс чөлөө аваад гэртээ ирлээ. Эхнэртээ: “Аллахын элч маш их өлсөж байна. Өлссөнөө мэдрэхгүйн тулд гэдсэндээ чулуу боож байгааг нь харлаа. Гэрт идэж уух зүйл бий юу?” гэж асуув. Тэр: “Энэ жаахан мах хэдэн атга арвай буудайнаас өөр зүйл алгадаа” гэв. Би тэр арвай буудайг тээрэмдээд гурил болгон тосоор зуураад пийшин дээр хэсэг махтай хоол хийж жаал цай чанаад Мухаммед элч рүү гүйн очив. “Аяа, Расулуллах! Манайд жаахан хоол бий, та хэдэн хүн дагуулаад гэрт зочил” гэлээ.

Элч (салаллаху алейхи уа сальлам) “Танай хоол хэр их вэ?” гэж асуулаа. Хэллээ. Мухаммед элч: “Маш их, бас гоё хоол. Эхнэртээ очиж хэл, намайг ирэх хүртэл тогооноосоо хоолоо битгий гарга” гэв. Дараа нь мусульманууд руу харан “Хөөе, асхабууд аа! Босоцгоо, Жабир биднийг хоолонд урьж байна” гэв. Энэ үгийг сонссон асхабууд цуглан элчийн араас даган ирцгээлээ.

Би гэртээ гүйн ороод эхнэртээ бүгдийн хэллээ. “Хоол маань бага, хүн их, одоо яах вэ?” гэхэд надад “Элч чамаас хичнээн хоол байгааг асуусангүй юу?” гэв. Би “Асуулаа, би ч хариулсан” гэв. “Асхабыг элч урьсан уу? Чи урьсан уу?” гэлээ. Би “Элч урьсан” гэхэд “Тэгвэл Аллахын элч илүү сайн мэднэ, айх зүйлгүй” гэв.

Хэсэг хугацааны дараа Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) асхабууд хаалганы өмнө ирлээ. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам): “Нэг нэгээрээ шахцалцахгүйгээр орж хоол идэцгээ” гэлээ. Асхабууд 10, 10аар орж хооллов. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) хоолыг арвижуулах гэж залбирч, дараа нь тогооны тагийг хагас онгойлгоод хүн бүрт нэг аяга шахам хоол өгч байлаа. Бүх асхабууд цадталаа идэцгээв. Хооллогсод 1000аас илүү хүн байсан атал тогооны хоол огт дундарсангүй агаад үлдсэнийг нь бид цадталаа идээд дараагаар нь хөршүүддээ тараасан юм” гэжээ.

Селман-и Фариси хамгийн сайн жалга ухагч байлаа. Ганцаараа 10 хүний хийх ажилыг гүйцэтгэжээ. Энэ их хөдөлмөр хөлсийг нь харсан пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) баярлан түүний төлөө залбирчээ. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) Селманд хандан: “Аяа, Селман! Шам мусульман хот болох болно. Гераклийн хаан нь нутагийнхаа хамгийн бөглүү газар луу зугтаах болно. Та нар Шамын өнцөг булан бүрийг хянан захирах захирагч болно. Та нарыг хэн ч эсэргүүцэж зүрхлэхгүй Емен ч мусульмануудийх болно. Энэ Диар-и Мешрих газар нутагууд ч мусульманчууд биднийх болох болно. Бас Кисра (жүүдийн хаант төр) мөхөх болно. Аллах эзэн энэ бүхнийг намайг нас барсаны дараа хийх болно” хэмээжээ.

Селман-и Фариси: “Аллахын элчийн энэ хэлсэн бүх зүйл биеллээ олсоныг би нүдээрээ харсан юм” гэжээ.

Жалга ухах ажил эхлээд 6 хоног болжээ. Хүн бүр өөрийн ноогдсон ажилаа дуусгажээ. Зөвхөн хэсэгхэн газар гүн ухагдаагүй байлаа учир нь мүшрикийн цэрэг нэгэнтээ иржээ. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам): “Мүшрикүүд энэнээс өөр газараар гарч чадахгүй” гэж хэмээжээ.

Мүшрикийн цэрэг маш ойрхон ирлээ. Жүүдүүдийн Надир хөвгүүд овгийн толгойлогч Хуей цэрэгүүдийн даргад очоод “Мединед байх Курейза овгийн жүүдүүд мусульмануудтай гэрээ хэлэлцээр хийсэн талаар, хэрвээ тэдний толгойлогч Кааб бин Эсэдийг ятгаж чадвал өөрийн талдаа оруулж чадахаа” хэлэв.

Цэргийн дарга: “Чи шууд Кааб бин Эсэдэд оч! Мусульмануудтай хийсэн гэрээгээ цуцлаад бидэнтэй нэгдэхийг тушаа” гэв. Энэ гэрээний нэг нөхцөл нь “Мединед гаднаас дайсан дайрвал мусульмануудтай нэгдэн дайсантай тэмцэх” гэсэн байв.

Хуей шөнө дөлөөр Бени Курейза хороололд очин Каб бин Эсэдийн гэрт иржээ. Каабтай уулзан “Курейшийн бүх цэрэг Кинане ба Гатафаны хөвгүүд мэтийн овгуудын нэгтгэн 10000 цэрэгтэйгээр ирлээ. Бид хүчтэй. Мухаммед ба түүний дагалсадыг илдэн хөөе...” гэв. Кааб: “Мухаммед ба түүний асхабыг дийлэхгүй, Курейшүүд буцаад зугтаах юм бол энд зөвхөн бид л үлдэнэ. Мусульманууд биднийг хүйс тэмтрэх байх гэж айж байна” гэв. Гэвч Хуей: “Би энэ бүхнийг өөрийн толгойгоороо хариуцана” хэмээн ятгасаар Каабыг урвуулан авч чаджээ. Кааб өөрийн бусад жүүдүүдээ ятган гэрээ хийсэн цаасаа урж хаяв. Ийнхүү ам тангарагаасаа няцжээ.

Хуей мүшрик цэрэгүүдэд ирэн байдлыг илтгэв. Бени Курейза овог мусульмануудын ар талаас цохилт хийнэ гэж хэлэв.

Долоо дахь өдөр мүшрикүүдийн 10000 цэрэг бүхий арми Медине хотын хойд ба умард зүгт ирж буудалцгаан майханаа босгожээ. Энэ нь жалганы цаана юм. Мүшрикүүдийн зорилго бол Медине хотыг шатаан сүйтгээд Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) ба түүний асхабуудыг хөөн гаргах ийнхүү ислам шашины галыг унтраах юм.

Мүшрикүүд огт туулж гаршгүй энэ том гуу жалгийг хараад гайхан алмайрцгаав. Тэд сэтгэлээр унцгаав. Учир нь энэ жалга сайн морь хүчтэй хариахад ч цаана нь хүрч үл чадам тийм өргөн, унсан хүн гарч чадахгүй гүн юм.

Мүшрик цэргүүд ирсэнийг сонссон пайгамбар маань асхабуудаа цуглуулан жалганы нөгөө талд Сел уулын хормойд нуувчаа байрлуулав. Медине хотод намаз уншуулахаар Үммү Мектумийг үлдээжээ. Эмэгтэйчүүд ба хүүхдүүдийг хэрэм цайзны цаана нуужээ. 30 морьтой харваачид 3000 цэрэгтэй ислам арми дайнд бэлэн болжээ. Далбааг Зейд бин Харисе ба Сагд бин Убаде нар барьжээ.

Асхабууд дайсны хийх үйлдэлийг хүлээж эхэлцгээв. Гэгээн Омар (радиаллаху анх) элчид ирээд: “Расулуллах! Курейзагийн жүүдүүд бидэнтэй хийсэн гэрээгээ цуцлан бидний эсрэг дайнд бэлдэж байна гэж сонслоо” гэв. Санаанд оромгүй энэ муу мэдээг

сонсоод элч маань “Хасбуналлаху вэ нимел векийл - Аллах эзэн бидэнд хүрэлцээтэй, тэр ч ямар сайн туслагч вэ?” хэмээн хариулав. Одоо ислам цэргүүд тойрон дайсан дунд үлджээ. Умард ба хойд зүгт мүшрикийн цэргүүд, өмнөд ба дорно зүгт жүүдүүдийн цэрэг... Пайгамбар маань Сагд бин Муаз, Саад бин Убаде, Хаввет бин Жубейр, Амр бин Авф, Абдуллах бин Ревеха нарыг (радиаллаху анхум) Курейза овгийнх руу явуулж тэднийг ятган ахин гэрээгээ шинэчлээд ир гэв.

Үүрэг авсан 5 сахаба Курейза хороололд очоод тэдэнд сургаал айлдав. Гэвч ямар ч үр ашиг өгсөнгүй. Тэд доромжлон тохуурхаж: “Та нар бидний ахан дүүс Надирын хөвгүүд овгийнхонийг нутагаас нь хөөн гаргасанаар биднийг өөрсдийнхөө мөнхийн өшөөтөн болгосон билээ. Мухаммед гэж хэн юм бэ? Бидний хооронд гэрээ хэлэлцээр ам тангараг байхгүй. Одоо бид танай элчийг ялан дийлж алахаар ам тангарагаа өгцгөөсөн улс, бид та нарын жинхэнэ дайсан мөн” гэгцгэв.

Сад бин Муаз (радиаллаху анх) нөхөдүүдийнхээ хамтаар элчид ирж болсон үйл явдалыг хэлэв. Мухаммед элч(салаллаху алейхи уа сальлам): “Энэ мэдээгээ нууцалцгаа. Зөвхөн мэдэж байгаа хүмүүст л хэлцгээ. Дайн бол хуурахаас үүдэлтэй” гэв.

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) асхабууддаа: “Хөөе, мусульман ард түмээн! Аллах эзэний тус дэм ба хайр ивээл ирлээ, баярлацгаа!” хэмээн дайнд ялахын дохио бэлэглэв. Асхабууд энэнээс өмнө Бедир, Ухуд гэх мэт олон дайнд оролцсон болохоор бүгд туршлагжсан бөгөөд тэдний өмнө юунаас ч илүү баатар ухаалаг Аллахын элч (салаллаху алейхи уа сальлам) байгаа нь тэднийг зоригжуулна. Тэдний өмнө дайсанууд шоргоолж мэт олон ажээ. Гэвч асхабууд дайсныхаа тоо, зэр зэвсэг огт хамаагүй мэт тэд юунаас ч айхгүй байлаа.

Курейшийн цэргийн дарга ба тэдэнтэй хамт ирсэн бусад овгийн даргууд нийлэн хуралдаж довтлохын тулд жалгийг хэрхэн гэтлэх газар хайж байлаа. Гуу жалгийн бүх газараар нь явж үзээд дутуу малтсан хэсэгхэн газараар довтлохоор төлөвлөв. Мүшрикүүд цөм ухсан энэ нүхийг бас мусульманууд руу харан гайхацгаана.

Мүшрикийн толгойлогч цэргүүдээ жалганы гүехэн хэсэгт оруулаад “Эндээс хэн үсрээд цаана нь гарч чадах вэ?” гэхэд цэргүүд дотороос 5 хүн гарч ирэв. Энэ морьтой 5 цэрэг үсрэхдээ хүч авахаар хойш нь ухраад давхиж ирээд үсрэн жалганы цаана

гарцгаав. Энэ жалгийг гэтлэгсэдийн дотор Амр бин Абд гэх маш хүчтэй дайчин хүн бий. Тэрээр хамаг биеэ хуяг дуулгаар бүрхжээ. Аймшигт дүр төрхтэй энэ хүнийг харсан хэн бүхэн айдас төрнө. Тэрээр мусульмануудад: “Надтай халз тулалдах эр зоригтон байна уу? Байгаа бол урагш гар” гэж орилов.

Энэ үед гэгээн Али (радиаллаху анх) элчийн өмнө гараад: “Аяа, Аллахын элч минь, тэрэнтэй би тулалдая” гэлээ. Түүнд хуяг дуулга байхгүй байжээ. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) өөрийн хуяг дуулгаа тайлан Алид өмсгөв. Өөрийн сэлэмээ бариулаад, өөрийн толгой дахь саргиаа (ороолт) гаргаад өөрийн гараар Алид ороож өгөв. “Аллах минь! Бедир дайнд авга дүү Убейде, Ухуд дайнд авга ах Хамзааг шахид боллоо. Надад авга ахын минь алт л үлдлээ. Та түүнийг хамгаал. Түүнд тусламжаа үзүүл, намайг ганцааранг минь битгий үлдээ” хэмээн залбирав. Асхабууд бүгд “Амин” гэгцгээв.

Явган тулааны талбар луу алхах Аллахын арслан Али (радиаллаху анх) нүднээсээ бусад бүх газар нь үл харагдалтал нь тоногдлогдсон нүсэр биет Амир бин Абдын өмнө очиж зогсов. Амир бин Абд тэрнээс хэн болохыг нь асуув. “Би Али бин Эбү Талиб байна” хэмээн өөрийгөө танилцуулав. Амр: “Хөөе, дүүгийн минь хүү, чиний эцэг миний найз билээ. Тийм болохоор чиний цусыг үзэхийг хүсэхгүй байна. Надтай тулалдах ах нараас чинь нэг зоригтон гарсангүй юу?” хэмээн түүнийг өрөвдөв. Али: “Хөөе, Амр! Би чиний цусыг асгамаар байна, гэхдээ бид хоёулаа адил тэнцүү байх ёстой биш үү? Чи морин дээр, харин би явган байна. Чи бид хоёр шиг залууд энэ нь зохистой гэж үү?” гэв.

Энэ үгийг сонссон Амр мориноосоо буун өөрийн моринийхоо хөлийг сэлэмээрээ тас цавчин хаяад Алигийн өмнө очив Али: “Хөөе, Амр, чи Курейшийн овгийнхноос хэн нэгний өмнө очвол түүний хоёр хүсэлийг биелүүлнэ гэж амласан гэж сонслоо! Энэ үнэн үү?” гэв. Тэр “Тийм ээ, үнэн” гэхэд Али: “Тийм бол миний хүсэл - чи Аллахт итгэн мусульман бол” гэв. Энэ үгийг сонссон Амр уурлан: “Үгүй, энэ надад хэрэггүй!” гэв. Али: “хоёр дахь нь Мекке рүү буц. Учир нь Аллахын элч дайсанаа ялах юм бол, чи түүнд тусалсантай тэнцэнэ” гэв. Амр: “Үгүй, би өшөөгөө автлаа гоё үнэртэн түрхэхгүй гэж амласан билээ. Өөр хүсэл чинь байвал түүнийгээ хэл” гэхэд гэгээн Али: “Хөөе, Аллахын дайсан, одоо надад чамтай халз тулалдахаас өөр хүсэл алга” гэв.

Амр энэ үгийг сонсоод инээж: “Гайхаж байна. Арабд миний

өмнө зоригтойгоор эсэргүүцэх хүн гарна гэж бодож байсангүй! Хөөе, дүү минь! Чамайг алахыг хүсэхгүй байна. Ягаад гэвэл чиний эцэг миний сайн найз минь байсан юм. Би Курейшийн хүлэгт баатаруудаас Эбү Бакир, Омар шиг хүнийг хүссэн юм” гэв. Гэгээн Али: “Тийм байлаа ч би чамайг алахаар энэ талбарт гарсан юм” гэхэд Амр уурлан сэлэмээрээ цавчилаа. Энэ гэнэтийн дайралтанд бэлэн байсан Али шалавхан бултан бамбайгаараа хаалаа. Бамбай нь зат цохигджээ. Амрын цохиолтонд тэсэх бамбай байдаггүй байжээ. Дайрах ээлж Алид ирэхэд: “Аяа, Аллах” гээд Зүлфикар сэлмээрээ Амрын хүзүүг цавчив. Энэ цавчилт маш хурдан бас цагаа олсон болохоор Амрын дуулгатай толгой тасран газар өнхрөн унахад “Аллаху Акбар!” гэх мусульмануудын уухай тэнгэрт хадав. Харин дайсанууд харамсан орилцгоов. Энэ бол элчийн (салаллаху алейхи уа сальлам) залбиралын биелэл юм. Хамгийн их итгэж байсан Амрыг алахыг үзээд үлдсэн 4 хүн Али руу дайрав. Энэнийг харсан мусульманууд талбар луу гүйцгээлээ. Тэд Зүбейр бин Аввам (радиаллаху анх) Невфел бин Абдуллахыг шархдуулаад зугтаахдаа нүхэнд унажээ.

Ийнхүү дайн хэрхэн үргэлжлэх нь мэдэгдлээ. Мүшрикүүдийн хувьд ухсан нүх хамаг зүйлийн саад болж байв. Мүшрикүүд сум харван мусульманчуудыг дийлэхгүйгээ ойлгожээ. Тэд сум чулуу шидэж хий дэмий цагаа гарздана. Жалгийг гэтлэх арга зам хайн ингэсээр байтал орой болжээ.

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) шөнө болонгууд жалгын энэ тэнд харуул хамгаалалт гарган өөрөө гүехэн бас нарийнхан хэсэгт нь манаанд гарав. Медине рүү 500 цэрэгийг явуулан “Аллаху Акбар” гэж уухайлан орилохыг тушаав. Ийнхүү жүүдүүдийг сүрдүүлж мүшрикүүдийг айлгах гэсэн санаа байлаа. Курейза овгийн жүүдүүд Хувейбээс 2000 цэрэг гуйн шөнө Медине хот руу дайрахыг хүсэв. Тэнд байгаа хүүхэд эмэгтэйчүүдийг эзлэн авахаар завдсан боловч өглөө болтол “Аллаху Акбар” гэж уухайлсан цэргийн дуунаас айн юу ч хийж чадсангүй.

Өглөө болоход мүшрикүүд жалганд дөхөж ирээд сум харван дайтахаас өөр арга замгүй байлаа. Нөгөө талаас жүүдүүд бас дайрахад бэлэн болжээ. Мусульманууд ядарсан бас өлсгөлөн болохоор хүч тамир нь муудсан байхыг харсан Мухаммед пайгамбар (салаллаху алейхи уа сальлам): “Хорвоо дэлхийг эзэгнэгч Аллахын нэрээр амлая! Та нарын энэ зовлон

зүдгүүрийг Аллах заавал арилгаж, та нарыг жаргах цаг ирэх болно” гэж ялан дийлэхийн дохио, баярт мэдээг дуулгав. Энэ үгийг сонссон зоригт мусульманууд улам их зоригжин жалгаар хэнийг ч гаргалгүй тэмцэж эхлэв.

Мүшрикүүд зогсолтгүй дайрч сум харван, жад шидсэн байлаа. Тэдний хамгийн их хүчээ өгч дайрч байгаа газар нь жалганы дутуу ухагдсан нарийн газар байв. Мүшрикүүд өдөрөөр мусульмануудыг ялж дийлэхгүйгээ ойлгожээ. Тэдний удаах төлөвлөгөө бол шөнөөр дайрах юм. Мусульмануудыг зөвхөн ингэж л дарж авна гэж бодоцгооно. Шөнө мүшрикүүд цэргээ хэдэн хэсэг хуваагаад ээлж ээлжээр давшуулан тулалдуулж эхлэв. Ийнхүү дайн хэдэн хоногоор үргэлжлэв. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) ба бүх мусульманууд өлсгөлөн бас ядарсан ч хамаг хүчээ дайчлан хамгаалцгааж, нэг ч хүнийг жалганаас нааш оруулсангүй. Энэ дайн урьд өмнөх дайнуудаас илүү ширүүн, илүү хэцүү, илүү олон хоногоор үргэлжилж байлаа.

Хэдхэн хоногоор байлдсан мүшрикүүдийн цэрэг идэх хоолоор хомсдож эхлэв. Морь тэмээ нь өвсгүйдэж, усгүйдэн эцэж туйлджээ. Тиймээс мүшрикийн толгойлогч Дирар бин Хаттабаар толгойлуулсан хэсэг хүмүүсийг Курейза тосгон руу хоол унд авч ирүүлхээр явуулжээ. Жүүдүүд 20 тэмээ, арвай буудай, хурма жимс, мах бас малд өгөх өвс өгөн буцаав. Дирар баярлан буцах замд хэсэг асхабтай тааралдав. Зоригт мусульманууд тэдэн рүү дайран тэмээ хоол ундыг нь булааж аваад Мухаммед элчид (салаллаху алейхи уа сальлам) авч ирэв. Энэ явдал элчийг маш их баярлуулжээ.

Мүшрикүүд өлсгөлөн амссанаасаа болоод маш их ядарсан байлаа. Үтэр түргэн мусульмануудыг ялаад гэртээ харихыг мөрөөдөл болгоцгооно. Тиймээс ч хамаг хүчээ шавхан дайрч эхлэв. Ийнхүү байлдаж байхдаа зүрхэндээ мусульмануудыг гэх энэрэлийг мэдэрсэн нэгэн хүн шөнө дунд Мухаммед элчид (салаллаху алейхи уа сальлам) ирлээ. Энэ хүн бол Нуайм бин Месуд юм. Тэр элчид: “Аяа, Мухаммед, би Аллах эзэн нэг болохыг бас чамайг жинхэнэ элч болохыг хүлээн зөвшөөрөхөөр ирлээ. Мусульман болгосон Аллахдаа баярлалаа. Одоог хүртэл таны эсрэг байлдаж байсан бол, одооноос эхлээд таны талд орлоо. Надад юу л тушаасан ч би биелүүлэх болно” гэв. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам): “Энэ кафируудын дунд ороод

сэмхэн тэд нарыг нэг нэгэнтэй нь маргалдуулж, үл ойлголцох байдал үүсгэж чадах уу?” гэв. Тэр: “Аяа, Расулуллах, Аллахын туслалцаатайгаар тэднийг хооронд нь эвдрэлцүүлж чадна. Гэхдээ хүссэн үгээ хэлж ярьж болох уу?” гэв. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) “Болно” гэв.

Нуайм бин Месуд (радиаллаху анх) Курейза жүүдүүдэд очоод: “Би та нарт хичнээн хайртайг та бүхэн мэдэх билээ. Гэхдээ энэ миний одоо ярих зүйл бидний хооронд л үлдэг. Та нар хэнд ч хэлэхгүй гэж ам өгцгөө” гэв. Жүүдүүд: “Хэн ч мэдэхгүй, хэнд ч хэлэхгүй” гэж амлацгаав. Нуайм: “Энэ хүний (Мухаммед элчийн) хийж буй зүйл бол жинхэнэ хараал билээ. Хичнээн өдөр байлдаад ч ямар нэг шийдэлд хүрсэнгүй. Энэ дайн сунжирсаар байх болно. Курейшийнхан мал хөрөнгө эхнэр хүүхэд нь хол байгаа та нар шиг биш. Хэрвээ ямар нэгэн аргаар ялалт байгуулах юм бол Курейшийнхан бүхий л дайны олзоо өөрсдөө аваад яваад өгнө. Хэрвээ ялагдах юм бол зугтаагаад яваад өгнө. Харин та нар мусульмануудтай дангаараа үлдэх болно. Та нар дангаараа мусульмануудыг дийлэхгүй нь мэдээж. Одоогоор мусульсануудын ялах магадлал их байгаа. Хэрвээ ийм юм болвол та нарыг амьд үлдээхгүй нь мэдээжийн хэрэг. Тийм болохоор маш хурдан ямар нэгэн арга хэмжээ авах хэрэгтэй.” гэв.

Энэ үгийг сонсоод хүлээн зөвшөөрсөн жүүдүүд гэгээн Нуаймд баярлан: “Чи бол бидний жинхэнэ найз билээ, бид одоо яах ёстой вэ?” гэж түүнээс асуув. Энэ үгийг хүлээж байсан Нуайм “Та нар курейш ба гатафаны цэргүүдээс барьцаа аваагүй цагт дайнд оролцохгүй байх хэрэгтэй” гэв. Тэдний барьцаа та нарын хажууд байхад мүшрикүүд дайсанаас зугтааж чадахгүй” гэв. Түүний энэ санааг зөвд тооцон баярласан жүүдүүд Нуаймд бэлэг сэлд өгөн буцаав.

Нуайм жүүдүүдээс яваад курейшуудад очоод цэрэгийн даргад бараалхан: “Та нар намайг Мухаммедыг хэрхэн үзэн яддагийг бас та нарт хэрхэн үнэнчээр зүтгэдэгийг та бүхэн мэдэх билээ. Одоо би та нарт маш чухал мэдээ хэлэх гэж байгаа болохоор хэн ч энэ яриаг минь мэдэхгүй байх ёстой. Тийм болохоор та нар надад амлалт өгөх ёстой” гэв. Тэд амлалтаа өгөөд “Одоо ярь, чамайг сонсож байна” гэлээ. Нуайм: “Курейзагийн жүүдүүд та нарт туслаж байгаадаа харамсаж байна. Тэд Мухаммед рүү мэдээ явуулжээ. “Курейшийнханы толгойлогчдыг дийлэхийн тулд тэднээс барьцаа аваад чамд өгнө. Дараа нь чамтай нэгдэн

мүшрикүүдийн бут цохиё. Гэхдээ нэг болзол байна бидний ахан дүүс болох Надирийн хөвгүүд гэх овгийг уучилан нутагт буцаан авч ирүүл” гэгцгээжээ. Мухаммед элч жүүдүүд та нараас барьцаа асуух юм бол битгий зөвшөөрцгөө.” гэв. Курейшууд ийм үнэтэй зөвлөгөө өгсөн Нуаймд хязгааргүй баярлан шагнал урамшуулал өгөв.

Нэг өдөрийн дараа курейшийн дарга Курейза жүүдүүдэд: “Бидэнд одоо энд байх маш хэцүү байна. Хүйтэрч бас малууд маань өлсөж үхэж эхэллээ. Энэ орой сайн бэлдээд маргааш цөмөөрөө хамтдаа маш хүчтэй цохиолт хийе” гэсэн мэдээг ирүүлжээ. Жүүдүүд: “Бид бямба гаригт дайн хийдэггүй билээ, маргааш бямба гариг, тэгээд ч та нартай хамт байлдахын тулд өөрийн толгой хүмүүсээс хэсэг хүнийг бидэнд барьцаа болгон өгцгөө. Хэрвээ та нар дайныг орхин Мекке рүү буцах юм бол биднийг Мухаммед элчид орхин одсонтой ижил. Хэрвээ та нар барьцаа хүмүүсийг өгөх юм бол биднийг хаяж явахгүй гэдэгт итгэж байна...” гэсэн хариу явуулав. Энэ мэдээг авсан цэргийн дарга “Нуайм бин Месүдийн хэлсэн үг үнэн болж таарлаа” гэв. Жүүдүүдэд: “Бид та нарт нэг ч хүнээ барьцаанд өгөхгүй. Хэрвээ маргааш бидэнтэй байлдах юм бол сайн байна. Хэрвээ үгүй бол бид нутаг буцацгаана. Та нар Мухаммед ба түүний асхабуудтай байлдах хэрэг гарах нь...” гэсэн мэдээг илгээв.

Курейза жүүдүүд “Нуайм үнэн хэлсэн байна” гэж бодоод: “Тэгвэл бид та нартай хамтран тулалдахаас татгалзаж байна” гэсэн хариуг илгээжээ.

Элчид Жабрайл (алейхиссальлам) ирж Аллахын илгээсэн хар шуурганаар мүшрикүүдийг үлдэн хөөх болно гэсэн мэдээг өгчээ. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) газар сөгдөн алгаа дэлгэн: “Аяа, Аллах минь! Надад бас асхабуудад маань энэрэнгүй хандсаны чинь төлөө чамдаа баярлалаа” хэмээн залбирчээ. Дараа нь зоригт асхабуудтаа (радиаллаху анхум) энэ мэдээг дуулгав. Тэр шөнө баасан гаригийн шөнө байлаа. Тэнгэр тас харанхуй болон юу ч харагдахгүй болов. Гэв гэнэт маш хүчтэй исгэрэн нүргэлэх дуу гаран өмнөө таарсан юуг ч газрын хөрснөөс арчих хүчит хар салхиа дэгдээв. Энэ шөнийн талаар Хузейфет-ибн Эман ийн өгүүлжээ.

“Тэр шөнө шиг харанхуйг урьд өмнө би хараагүй билээ. Энэ хав харанхуйд гэв гэнэт цахилгаан цахилан, тэнгэрт хүчтэй дуу гаран салхи дэгдэж эхлэв. Мүшрикүүд айн сандарч өөр

хоорондоо үл ойлголцож байх үед элч бидэнд мэдээг хүргэсэн юм.

Мухаммед элч намаз мөргөлөө үйлдэн дуусаад нилээн удаан залбирал үйдсэнийхээ дараагаар бидэн рүү хандан! “Та нар дотороос мүшрикүүдийн хажууд очоод болж буй үйл явдалыг хараад надад ирж хэлэх хүн байна уу? Энэ мэдээг авч ирэх хүн диваажинд миний найз болохыг Аллахаас гуйлаа” гэв. Тэнд байгсад маш их хүйтэнд бас өлсгөлөнгөөсөө болоод хүссэн атал босох тэнхэлгүй болжээ. Пайгамбар (салаллаху алейхи уа сальлам) цэргүүд дундуур явсаар өвдөг сөхрөн нэгэн эрэгний нөмөрд дээлээ нөмрөн хэвтэж байсан миний хажууд ирээд: “Чи хэн бэ?” гэж асуув. “Би Хузейфе байна, Расуллуллах” гэлээ. “Бос! Энэ дайсанууд юу хийж байна хараад ир! Буцаж ирэх хүртэлээ тэдэн рүү сум, чулуу битгий нүүлгэ, чамд миний хажууд эргэн ирэх хүртэл ямар ч муу зүйл тохиолдохгүй” гэв.

Би сэлэм, нум сумаа аваад мориндоо мордон бэлэн болоход элч миний төлөө: “Аллах минь! Түүнийг урд хойноос, баруун зүүнээс, дээр доороос нь хамгаал” хэмээн залбирав.

Би мүшрикүүд рүү алхаж эхэллээ. Надад ямар ч аймшиг байхгүй байлаа. Би мүшрикүүдийн хажууд очлоо. Цэрэгийн дарга ба толгойлогчид нь гал түлэн дулаацаж суулаа. Эбү Сүфяан “эндээс буцацгаая” гэх нь сонсогдов. Гэнэт толгойд минь түүнийг харваж алах санаа буулаа. “Нум сумаа нугартал нь татан онилож байхад гэнэт элчийн: “Эргэж ирэх хүртэлээ нум сум харваж болохгүй” гэсэн захиас санаанд орлоо. Би харвахаа больж, нум сумаа буцааж хураалаа. Би мүшрик цэргүүдийн хажууд очоод галын дэргэд суулаа. Нэг нэгнээ олж үл харахаар хүчтэй салхи нүд нээх боломж өгөхгүй шуурна. Энэ бол Аллахын илгээсэн үл үзэгдэх цэрэгүүд (Мелек) байлаа. Салхи гал, гэрэлүүдийг унтраан майхан нуувчуудыг агаарт өргөн шидэх нь аймшигтай. Цэрэгүүд тэр хүйтэнд хорогдох газар хайцгаан дэмий л нааш цааш гүйлдэнэ. Салхи улам ширүүсч өөрийн эрхгүй үлдээн хөөнө. Сөрөх хүч хэнд ч үгүй байлаа.

Эбү Сүфяан цэрэгүүддээ: “Хөөе, цэрэгүүд ээ! Та нар байрлаж болох аюулгүй газар луу явцгаа. Ган гачигаас болоод мал, хүн тогтож чадахаа байлаа. Тэгээд ч энэ салхинд хэн ч тэсэхгүй нь үтэр түргэн нүүцгээ. Би ч бас явлаа” гээд тэмээндээ морьдов. Мүшрик цэргүүд Мекке рүү буцахдаа баяртай байлаа. Ягаад гэвэл тэд маш их ядарчээ. Үүнээс илүү тэвчиж чадахгүйгээ

ойлгожээ. Тэнгэрээс элсээр бороо цутгаж байв.

Мүшрик цэргүүд зугтаан явсаныг хараад даруйхан элчийнхээ зүг баярлан гүйлээ. Замын дунд ирэхэд миний өмнө хориод цагаан хувцас өмссөн Мелекүүд (сахиусан тэнгэр) угтаж зогсоно. Тэд надад: “Аллахын элчид очиж хэл, Аллах түүний дайсаныг үлдэн хөөлөө.” гэв. Би гүйсээр Мухаммед элчид ирэхэд тэрээр нэгэн хивсэн дээр намаз (мөргөл) үйлдэж байлаа. Элч мөргөлөө дуусгаад надаас ямар мэдээтэй ирсэнийг минь асуулаа. Би мүшрикүүдийн амссан зовлон бас хэрхэн амиа аван зугтаан одсоныг хэлэхэд маш их баярлан хэдэн хоног нойргүй байсан болохоор пайгамбар маань намайг хажуудаа хэвтүүлэн өөрийн нөмөрч байсан хоёр нөмрөгний нэгээр нь намайг нөмрөв. Тэр орой мусульман цэрэгүүд амар амгалан тайван нойрсжээ. Өглөө болоход элч намайг сэрээв. Мүшрикүүдийн цэрэгүүдээс хэн ч үлдээгүй байлаа. Тэд нарыг үлдэн хөөсөн хар салхи Мекке хотод дөхөх хүртэл нэхжээ.

Дайсаны цэрэг энэ мартагдашгүй ялалтандаа гоморхон маш ихээр шаналж байхад хорвоогийн энэрэлт элч (салаллаху алейхи уа сальлам) асхабаа цуглуулан баярын нулимс унагаан намаз (мөргөл) үйлдэж байлаа. Зоригт мусульман цэрэгүүд “Аллаху Акбар! Аллаху Акбар!...” гэсэн уриагаа хэлэн Медине хот руу орон очиход эмэгтэйчүүд, хүүхдүүд баярлан угтах нь Медине хот тэр аяараа баяр хөөрөөр бялхаж байв” гэж хэлэв.

Хендек дайнд 6 хүн шахед (Аллахын замд амиа өгөх) болжээ. Энэ дайны талаар Аллах эзэн Куранд ийн айлдсан байна: “Аллах теала (Хендек дайны) тэр кафируудыг, ямар ч сайн зүйлд, ялалтанд хүргэлгүйгээр, харуусал гунигаар буцаалаа. Ийнхүү Аллах Теала (мелекүүд ба хар салхиар) дайнд оролцон (ялахын тулд) мүминүүдэд хүрэлцлээ. Аллах Теала бүх зүйлд хүчин төгс, тэр бүх зүйлийг дийлэх хүчтэн” (Азхаб сүре, 25) “Хөөе, итгэн сүсэглэгчид ээ! Аллах та нарт өгсөн буян хишигийг санацгаа! Тэр та нартаа (Хендек дайнд) дайсанууд довтлох үеээр, Бид тэдэн рүү нэг хар салхи ба та нарын үл үзэх (мелекүүд) арми илгээсэн юм...” (Азхаб сүре:9)

Энэ дайны дараагаар пайгамбар маань: “Одоо та нарын ээлж ирлээ, үүнээс хойш курейшүүд ирэхгүй” хэмээжээ.

Бени Курейза жүүдүүд

Гэгээн пайгамбар маань Мединед ирээд Айше эхийн гэрт очжээ. Зэр зэвсэг хуяг дуулгаа тайлан тоосонд дарагдсан болохоор усанд оржээ. Энэ үед хуяг дуулга өмсөн зэвсэглэсэн гэгээн Дихиегийн дүрээр Жабрайл (алейхиссальлам) ирж элчийг дуудав. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) хажууд нь очиход: “Хөөе, Аллахын элч Аллах чамайг нэн даруй Курейзагийн хөвгүүд овгийнхонийг хяр цохихыг зарлиглаж байна” гэсэн уахиг (мэдээг) хэлэв. Хорвоогийн энэрэлт элч (салаллаху алейхи уа сальлам) гэгээн Билалыг дуудаад асхабуудад сонсгох энэ тушаалыг хэлэв. “Аяа, асхаб минь! Морь, тэмээндээ морьдоцгоо! Итгэн дагагсад оройн мөргөлийг Курейза тосгонд үйлдэг!”

Аллахын элч (салаллаху алейхи уа сальлам) нэн даруй хуяг дуулгаа өмсөн сэлэмээ барин мориндоо мордоод асхабуудынхаа хажууд очоод гэгээн Алид исламын далбааг бариулав. Абдуллах ибн-и Мектумыг Мединед орлогчоор үлдээв.

Зоригт асхабууд Мухаммед элчийг (салаллаху алейхи уа сальлам) даган “Аллаху Акбар! Аллаху Акбар!” гэсэн уриагаа хэлэн Медине хотоос гарлаа. Замдаа Ганмын хөвгүүд овгийнхоны цэрэгүүд зэр зэвсэгээ асган элчийг хүлээж зогсож байлаа. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам): “Та нартай хэн нэгэн дайралдаагүй биз!” гэхэд тэд: “Расулуллах! Бидэнтэй цав цагаан луус унасан Дихие Келби тааралдлаа. Тэрээр гартаа хээгүй өнгөлөг нэгэн торго барьсан харагдлаа” гэв. Мухаммед элч: “Тэр бол Жабрайл (алейхиссальлам) юм. Бени Курейза жүүдүүд рүү илгээгдсэн. Тэдний хэрэмийг ороож зүрхийг нь айлган чичрүүлэх гэж.” гэв. Курейза тосгонд хүрэх хүртэл ислам цэрэгүүдийн тоо 3000 хүрсэн байлаа.

Гэгээн Али (радиаллаху анх) исламын далбааг Курейза жүүдүүдийн хэрэмийн өмнө байрлуулав. Энэ бүхнийг харж байсан жүүдүүд Мухаммед элчийн цэргийг нүд цавчилгүй, амьсгаа даран харж зогсоно. 3000 цэрэгтэй ирсэн хэдий ч энэрэнгүй хандан тэднийг ислам шашинд орохыг санал болгов. Харин тэд хүлээн зөвшөөрсөнгүй. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам): “Тийм бол Аллах ба түүний элчийн өмнө сөгдөцгөөн бууж өгцгөө” гэлээ. Тэд эсэргүүцэв. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) гарамгай мэргэн Саад бин Эби Ваккад: “Хөөе Саад! Тэднийг харва” гэв. Саад (радиаллаху анх) ба харваачид “Аллаху

Акбар!” гээд харваж эхлэв. Тэд ч мөн адил харван эсэргүүцэл үзүүлэв.

Мусульмануудыг хэцүүдэх үед араас нь довтолсон өөдгүй жүүдүүд хэрэмнийхээ хаалгыг онгойлгон талбарт гарах зориг үгүй байлаа.

Жүүдүүд эсэргүүцэл үзүүлэн байлдаж эхлэв. Тэднийг зоригжуулсан зүйл нь мунафик (хоёр нүүртэнүүд) “Бид та нарт туслана, битгий бууж өгцгөө” гэсэн байлаа. Жүүдүүд тэдний тусламж ирэхийг хүлээн эсэргүүцсэн аж. Тулалдаан үргэлжлэн хэдэн цаг болоход жүүдүүд тусламжын цэрэгүүд ирэхгүйг ойлгон айж эхлэв. Тэд мусульмануудтай гэрээ хэлэлцээр хийхийг хүссэн мэдээ явуулав.

Гэрээ хийхээр Неббаш бин Кайс гэх жүүд Мухаммед элчид (салаллаху алейхи уа сальлам) ирлээ. “Аяа, Мухаммед, Надирийн хөвгүүд овгийнхонд үзүүлсэн өршөөлөө бидэнд бас үзүүл, биднийг өршөө, бидний эд хөрөнгө зэр зэвсэгийг бүгдийг нь та ав. Зөвхөн бидний цусыг битгий урсга. Үр хүүхэд эхнэрүүдээ аваад энэ нутагаас явахад минь битгий саад бол. Зэвсэгээс гадна нэг айл 1 тэмээ ачаа авч явахыг зөвшөөрөөч” гэж гуйв. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) “Үгүй би энэнийг зөвшөөрөхгүй” гэхэд “За тэгвэл ачаа авахаа больлоо. Бидний амийг хэлтрүүл” гэв. Мухаммед элч: “Үгүй ямар ч эргэлзэх зүйлгүйгээр бидэнд дагаар орж, бидний зарлигийг даган, бууж өгөхөөс ямар ч зам та нарт байхгүй. Эс бөгөөс бүгд үхэх болно” гэв. Жүүд хэрэм рүүгээ буцан яваад болсон явдалаа хэлэв.

Тэдний толгойлогч Кааб бин Эсэд өөрийн жүүдүүддээ ийн санал тавив. “Хөөе, нөхөд минь! Биднийг маш том гай зовлон нөмөрлөө. Би та нарт 3 зүйл санал болгомоор байна. Нэгдүгээрт: “Энэ хүнд дагаар орж элчийн үүргийг нь хүлээн зөвшөөрөө. Үнэндээ тэр бол бидний Тора сударт бичигдсэн сүүлчийн элч мөн болохыг та бид цөм мэдэх билээ. Хэрэв түүнд итгэн мусульман болох юм бол амь насаа, эхнэр хүүхэдээ, эд хөрөнгөө хамгаалан үлдэх болно. Бүгдээрээ түүнтэй нэгдэцгээе!” гэхэд жүүдүүд цөм эсэргүүцэв. “Үгүй, бид энэ саналыг хэзээ ч хүлээн зөвшөөрөхгүй” гэгцгээв.

Энэ удаа Кааб бин хоёр дахь саналаа тавив. “Цөмөөрөө эхнэр, үр хүүхдүүдээ алж хаяаад үхэн үхтлээ мусульмануудтай тулалдцгаая” гэв. Энэ саналыг бас л эсэргүүцэв.

Кааб 3 дахь саналыг хэлэв. “Өнөө орой бямба гариг

мусулманчууд биднийг энэ өдөр дайн хийдэггүйг мэддэг болохоор өөрсдөндөө итгэсэн байж болох юм. Цөмөөрөө сэлэмээ барьцгаан хэрэмийн хаалгаар гарцгаая” гэв. Жүүдүүд бид бямба гаригт байлдахыг цээрлэдэг ёсоо дагах болно” гэцгээв. Энэ саналыг хүлээн зөвшөөрсөнгүй. Зөвхөн Эсид бин Салибе гэх ах дүү нар бас тэдний авга ах Эсэд анхны саналыг хүлээн зөвшөөрөн мусульман болцгоов. Хэрэмнээс гаран асхабууд дунд нэгдэв.

Жүүдүүд бууж өгсөн цагаан тугаа өргөн Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) хэлсэнээр амьдрах болов. Мухаммед элчээс хэн нэгэнийг бидний дарга болго гэв. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам): “Асхабаас хүссэн хүнээ сонго. Тэр хүн та нарын дарга болно” гэв. Жүүдүүд “Бид Саад бин Муазыг сонгож байна. Түүний гаргасан шийдийг дагах болно” гэцгээв. Мухаммед элч зөвшөөрөөд Сагд бин Муазыг авч ирүүлэхийг хүсэв.

Саад бин Муаз дайнд хүнд шархадсан болохоор Мухаммед элч түүнийг Месжид-и Небид эмчлүүлэхээр үлдээжээ. Мусульманууд Саадыг дамнуурган дээр тавиад Курейзад авч ирэв. Замдаа гэгээн Саад өөрөө өөртөө: “Аллахын ариун замд явахад хүмүүсийн бодол санааг үл тоон, зөвхөн Аллахын зарлигаар шдаргаар захирах болно” гэж байлаа. Мухаммед элчийн урд авч ирэхэд элч (салаллаху алейхи уа сальлам): “Хөөе, Саад эд нар чиний шударга шийдээр бууж өгцгөөх боллоо, тэдний талаар юу гэж шийдмээр байна” гэв. Саад бин Муаз: “Амиа танд өргөө, Аллахын элч минь! Үнэндээ шийд гаргах нь Аллах ба түүний элчид зохистой” гэв. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам): “Эдний шийдийг гаргахыг Аллах чамд тушаасан юм” гэв. Саад хэсэг бодолгоширон зогссоны дараагаар маш агуу нэгэн шийдийг хэлэв.

Миний шийд бол: “Ухаан гүйцсэн нас биенд хүрсэн, бүх эрэгтэйчүүдийн толгойг нь цавч! Харин эмэгтэйчүүд ба хүүхдүүдийг олзлон авч, бүх эд хөрөнгө мал адгуусыг нь мусульмануудад тэгш хуваан өгөг”

Энэ шийдийг сонссон жүүдүүд гайхан алмайрч хоцров. Ягаад гэвэл тэдний өөрсдийнх нь сударт ийм буруу үйлдэл хийгсэдийг нь гэсгээх гэсгээл яг ийм юм.

Саад бин Муазын гаргасан шийд Аллахын таалалд нийцсэн болохоор элч түүнийг сайшаан: “Чи Аллах эзэний долоон давхар

тэнгэр дээрх, Левх-үл Махфуз дахь шийдтэй ижил шийдийг хэллээ” хэмээв.

Жүүдүүд өөрийн судартаа бичигдсэн энэ шийдийг сонсоод эсэргүүцсэнгүй. Бүх эрчүүдийн гарыг хүлэн авч ирэв. Тэдний хүүхдүүд, эмэгтэйчүүдийг цөм асхабуудад хувааж өгөв.

Ийнхүү мусульманууд хэцүү үед тэднийг араас нь дайрч гэрээ хэлэлцээ ам тангарагаа эвдэн, элчийг бага настайгаас нь энэ үе хүртэл алахыг завдсан бүхий л үед хорон муу санаа өвөрлөж явсан исламын заналт дайсаныг Медине хотоос цэвэрлэжээ. Асхабууд баяр жаргалтайгаар Медине хот руу буцав. Олзны хүмүүс дотороос нэгэн эмэгтэй мусульман болон жаргалын ундааг амсжээ.

Саад бин Муаз шахид болсон нь

Саад бин Муазыг буцаагаад эмнэж байсан майханд нь хүргэв. Түүний шарх нь хүндэрч, тамир нь барагдан, улам хүндэрчээ. Пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) хажууд ирээд түүнийг тэврээд: “Аллах минь! Саад чиний баярын төлөө, чиний ариун замд байлдсан билээ. Элчийгээ ч үргэлж хүлээн зөвшөөрсөн түүнд хөнгөлөлт үзүүл...” хэмээн залбирав. Саад бин Муаз элчийн энэ ариун үгийг сонсоод нүдээ нээн: “Аяа, Аллахын элч минь! чамд итгэн хүндэтгэл үзүүлье! Чамайг Аллахын элч болохыг баталнам” хэмээн хэлэв. Ингээд Саадыг өөрийнх нь гэрт аваачив. Тэр энэ зовлонг давж гарах нь хэцүү байлаа. Жабрайл (алейхиссальлам) элчид ирэн: “Аяа, Аллахын элч! Энэ орой чиний дагалдагсадаас нэг хүн нас бараад дараагаар нь түүнийг сахиусан тэнгэрүүд баярт мэдээгээр угтах хүн хэн бэ?” гэж асуув. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) хэсэг асхабтай Саад бин Муазын гэр лүү явлаа. Замдаа маш хурдан явж байсан болохоор асхабууд “Ядарлаа, Расулуллах!” гэцгээв. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам): “Сахиусан тэнгэрүүд Ханзалагийн жаназед (оршуулгын намаз) биднээс өмнө очсон шиг Саадын жаназед биднээс өмнө иржээ. Бид яаравчлах хэрэгтэй” гэв. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) Саад бин Муазын хажууд ирэхэд тэрээр нас барсан байлаа. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) Саад бин Муазын (радиаллаху анх) хоч нэрийг нь хэлээд: “Хөөе, Абу Амр! Чи толгойлогчдын хамгийн сайн нь билээ. Аллах эзэн

чамд аз жаргал, буян хишиг бас бүхий л сайн сайханыг ивээг. Чи Аллахдаа амласан үгэндээ хүрлээ. Аллах ч гэсэн чамд амласанаа өгөх болно” хэмээв.

Эслэм бин Харис (радиаллаху анх) ийн айлджээ. “Саад бин Муазын үхэл хамаг мусульмануудыг тэр дундаа Мухаммед элчийг маш их уй гашууд автуулав. Пайгамбар маань өөрөө түүний Жаназе (нас барсан хүнд хийгдэх шашины үйлдэл) мөргөлийг үйлдүүлж, өөрөө түүнийг өргөн явсан юм. Саадын цогцсыг зөөж байхад бид: “Аяа, Расулуллах, ямар хөнгөхөн юм бэ?” гэхэд. Элч: “Сахиусан тэнгэрүүд бууж түүнийг өргөж явна” гэв.

Цогцосыг булш руу зөөж явахад мунафикууд (хоёр нүүртэн) муулах гэж “Ямар хөнгөхөн цогцос вэ?” гэгцгээв. Хайрт пайгмбпр маань (салаллаху алейхи уа сальлам): “Саадын жаназег уншихаар 70000 сахиусан тэнгэр тэнгэрээс буулаа. Өнөөдөрийг хүртэл ийм их сахиусан тэнгэр ирээгүй билээ” хэмээжээ.

Нэг удаа Мухаммед элчид (салаллаху алейхи уа сальлам) маш их үнэтэй нэгэн хувцас бэлэглэжээ. Асхабууд энэ ямар гоё хувцас вэ? гэгцгээхэд Элч (салаллаху алейхи уа сальлам): “Саад Бин Муазын диваажин дахь алчуур нь энэнээс илүү сайхан” хэмээжээ.

Хижрегийн (их нүүдэл) 5 дахь жилд болсон зарим үйл явдалууд: Мухаммед пайгамбар (салаллаху алейхи уа сальлам) Дүмет-үл Женделд амьдарч буй бас Шам руу ирж очих аянчидийн замд аюул учруулах бас Мединегийн ойр хавьд байх отог овгуудийг дайлаар морьдохоор 1000 цэргийг аван замд гарчээ. Энэ сурагийг дуулсан кафир отог овгууд цөм зугтаан зайлжээ. Тэндээс хэсэг хоногийн дараа нутаг буцацгаав.

Аллахын элч (салаллаху алейхи уа сальлам) Зилкаде сард Зейнеф бинти Жахштай гэр бүлээ батлуулжээ. Энэ жил Хижабын талаар ает-кериме (зарлиг) бууж, мусульман эмэгтэйчүүдэд алчуур боон, урт хувцас өмсөх зарлиг иржээ. Мунафикүүд гэгээн Айше эхийг гүтгэжээ. Зарим мусульманууд ч энэ гүтгэлгэнд хутгалдав. Аллахаас уахи бууж Айше эхийг (радиаллаху анха) цагаатгажээ. Мединед ойр байх Мүзейне гэх овог төлөөлөгчөө илгээн мусульман болцгоожээ. Мөн энэ жил газар хөдлөн сар хиртсэн байна. Мөн Хаж (Ариун Каабд очиж мөргөх ёсон) явах нь энэ жил фарз болов.

ХУДЕЙБИЕ ЭНХ ТАЙВАНЫ ГЭРЭЭ

Хендекийн дайнд ялсанаас хойш мусульмануудын хүч чадалыг ойр хавийн отог аймагууд хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй болжээ. Одоо мусульмануудтай найз болох нь тэр бүү хэл мусульман болох нь хамгийн зөв шийд гэж бодогцооно. Зарим нэг нь Мухаммед элчийн өмнө ирж мусульман болцгооно.

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) исламын шашинаа түгээхийн тулд асхабуудаасаа хэсэг хүмүүсийг бие төлөөлөгчөө болгон ойр хавийн аймагуудруу илгээжээ. Зарим аймагууд руу өөрийн биеээр очиж байв.

Хижрегийн (их нүүдэл) зургаа дахь жилд аймшигт ган гачиг болжээ. Өвс ургамал, тариа ногоо үл урган хүн мал өлсгөлөнд нэрвэгджээ.

Рамазан сард мусульманууд элчид ирэн: “Аяа, Расулуллах, Аллахт залбираач, бидэнд хур бороо илгээг” гэж гуйцгаав. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) асхабуудтайгаа ууланд гараад азан, камет уншихгүй хоёр үетэй намаз (мөргөл) үйлджээ. Дараагаар нь өөрийн алгаа дэлгэн: “Аяа, Аллах минь! Бидэнд хур бороогоо хайрла!...” хэмээн залбирч эхлэв. Асхабууд “Амин” гэцгээнэ.

Тэр үед тэнгэр цэлмэг нэг ч үүлгүй байсан юм. Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) энэ залбиралийн дараагаар хэсэг салхи гарсанаа үүлшиж эхлэв. Дараа нь бороо шивэрч эхлэв. Бороо ширүүссээр маш хүчтэй цутгахад элчийн хамаг хувцас норсон байлаа, ган гачигч тайлагджээ.

Хижрегийн 6 дахь жилд Зилкаде сард нэг шөнө пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) зүүдэндээ асхабуудтайгаа Мекке дэх ариун Кааб руу хаж (мөргөл) үйлдэхээр очин асхабуудын зарим нэг нь үсээ засуулж зарим нь үсээ хусуулж байна гэж зүүдэлжээ. Пайгамбар (салаллаху алейхи уа сальлам) энэ зүүдээ асхабууддаа хэлэхэд тэд маш их баярлацгаав. Төрж өссөн, хэцүү хүнд ч, жаргалтай зовлонтой цаг хугацааг өнгөрөөсөн төрөлх нутаг Меккегээ маш их санажээ.

Асхабууд элчийн: “Та нар ариун Кааб руу заавал очих болно” гэх баярт мэдээг дуугангуудаа яаран бэлдэцгээж эхлэв.

Хайрт элч (салаллаху алейхи уа сальлам) ба асхабууд бэлтгэлээ базаасаныхаа дараагаар Абдуллах бин Үмми Мектумыг Мединед орлогчоор үлдээгээд Зилкаде сарын нэгэнд

даваа гаригт Кусва нэрт тэмээндээ мордон 1400 асхабуудтайгаа цуг Мединегээс гарцгаав. Тэд зэр зэвсэг 470 тэмээнд ачжээ. Энэ жинд 200 морьтой бас 4 эмэгтэй дагажээ. Энэ эмэгтэйчүүдийн нэг бол хайрт элчийн минь гэргий Үммү Селеме (радиаллаху анха) байлаа.

Зүл-Хулейфе гэх Меккед ойрхон газар ирээд Ихрамаа (мөргөлийн хувцас) өмсцгөөн, үдийн мөргөлөө үйлдэцгээв. Дараа нь тахил үйлдэх тэмээнүүдийнхээ чихийг цоолон, хүзүүнд уяа уяцгаав. Аббад бин Бишрээр толгойлуулсан 20 хүнийг хамгаалагч ба тагнуулаар томилон явуулав. Бүшир бин Суфияныг Мекке хот руу мэдээ хүргүүлэхээр илгээв.

Ихрамаа (мөргөлийн хувцас) өмсөн цав цагаан тагтаа мэт болцгоосон Аллахын сүр хүчийг биширцгээн залбирч эхэлцгээв. “Леббейк! Аллахүмме леббейк! Лебейке лаа шарика лака леббейк! Иннал хамда ве нигмата лака вэ-л мүлк лаа шерийке лак” гэх энэ талбиегээр (мөргөлчдийн унших тарни) тэнгэр газарыг нүргэлүүлэн тасралтгүй уншина. Зүл Хулейфе гэрэл гэгээтэйгээр хучигдан байна. Бүх хүмүүс баярлан сандарч хурдхан л Меккед очихын тулд хөдөлцгөөв.

Тэдний зам тайван байлаа. Замд тааралдах отог овгуудад золгон, пайгамбар маань тэднийг ислам шашинд уриалан дуудна. Зарим овогууд элчид бэлэг сэлт илгээж байлаа. Ийнхүү явсаар Усфаны ард Гадир-үл Эштат гэх газар иржээ. Энд Мекке рүү мэдээ хүргүүлэхээр явсан Бүшр бин Суфиян Меккед очоод эргэн ирж хүлээж байв. “Аяа Аллахын элч минь! Меккегийн мүшрикүүд таныг наашаа гарсаныг эрт дуулжээ. Тэгээд ойр хавийн отог овогуудаас тусламж гуйн тэднийг дайлжээ. Тэр отгуудад ч мүшрикүүдтэй нэгдэн нийлж цэрэг босгожээ. Тэд Мекке хот руу таныг оруулахгүй хэмээн ам өчиг өгцгөөсөн байна” гэв.

Энэ мэдээг дуулаад Аллахын элч (салаллаху алейхи уа сальлам) маш их гайхан: “Курейшууд устаж үгүй боллоо. Тэртээ тэрэнгүй дайн тэднийг устгасан юм. Курейш мүшрикүүд өөрсдийгөө хүчтэй гэж бодож байгаа юм болов уу? Аллахын нэрээр андгайлъя! Надаар түгээлгэх энэ шашин бүхнээс нандин болохоор толгой минь салж унах хүртэл тэдэнтэй дайтахаас буцахгүй” хэмээв.

Мухаммед пайгамбар (салаллаху алейхи уа сальлам) энэ талаар асхабуудаасаа асуухад “Амь биеэ чамд өргөө, аяа, Расулуллах! Бид дайтах биш мөргөл хийх сайхан сэтгэлээр замд

гарсан билээ. Хэрэв Кааб руу биднийг оруулахгүй замд минь хөндөлзөх юм бол тэдэнтэй тулалдаж заавал зорьсондоо хүрэх болно.” гэгцгээв.

Асхабын энэ шийд элчийг (салаллаху алейхи уа сальлам) маш их баярлуулжээ. “Тийм бол, алив, Аллахын нэрийг бариад урагшаа” гэв. Асхабууд: “Леббейк! Аллахумме леббейк!..” гэгцгээн урагшилцгаав.

Үдийн намазын (мөргөл) азан (мөргөлийн дуудлага) Билал-и Хабаши дуудан мөргөл эхэлхэд бэлэн болжээ. Яг энэ үед курейшийн түрүүлж илгээсэн 200 морьтой тагнуулууд мусульмануудын хажууд иржээ. Мусульманууд тэднийг харсан хэдий ч намазаа үйлдэхээ хойшлуулсангүй. Цөм нэгэн зэрэг мөргөн, босож өөрийн тэргүүнээ шороонд хүргэн сөгдөх нь тэднийг хэр үнэнч хэр ариун ариун замналаар явж буйг харуулах том сургамж байлаа. Мүшрикүүдийн цэрэгүүд энэ мөргөж буй мусульмануудыг хараад зүрхэнд нь исламыг гэх оч гялалзан хайрлаж эхэлжээ.

Тэдний дарга нь: “Бид мусульмануудыг мөргөл хийж байхад ягаад дайрсангүй вэ? За яахав, ахиад мөргөл хийх цаг ирэх биз” гэж шүд зуун заналхийлэв.

Тэдний энэ заналхийллийг Аллах Жабрайл (алейхиссальлам) сахиусан тэнгэрээр Мухаммед элчид (салаллаху алейхи уа сальлам) ийн мэдэгджээ.

Куран судард ийн зарлигласан байдаг: “(Аяа, элч минь!) Чи ч гэсэн дотор нь ороод, (дайсаныхаа өмнө) тэдэнд (асхабдаа) намаз үйлдүүлэх үед (тэднийг хоёр хэсэгт хуваа) нэг хэсэг нь чамтай хамт (намазд, нөгөө хэсэг нь дайсаны эсрэг зогсог) зогсог. Зэвсэгээ хажуудаа бариг. Чамтай намазд зогсон 1 рекать (үе) үйлдэгсэд (намазаа эвдэх зүйлээс зайлсхийж) дайсаны өмнө очиг. Дараагаар нь намаз үйлдэж амжаагүй хэсэг нь ирж 2-дахь рекатийг (үе) чамтай хамт үйлдэг. Бас өөрийг хуяг бамбай ба зэвсэгээ бариг. (тешеххүдийг чамтай хамт уншиг. Чи мэндлэхэд тэд мэндлэхгүйгээр дайсаны өмнө очиж зогсог. Урьд нь 1 рекать уншигсад буцаж ирээд өөрсдөө сүүлчийн рекатыг уншин дуусган мэндлэг. Хоёр дахь рекатийг имамын хамтаар уншигсад буцаж ирээд 1 рекать ахиад уншаад намазаа дуусган мэндлэг) Кафирууд та нарыг зэр зэвсэггүй үед гэнэт дайрахыг хүсэж байна. Хэрэв та нарт борооноос нэг зовлон тохиолдвол эсвэл өвчтөн байвал зэвсэгээ хажуудаа байлгахад саад үгүй. Гэхдээ бүхий л зүйлд

бэлэн байцгаа. Үнэндээ Аллах эзэн кафируудад, нэгэнт гунигт бас аймшигт цээрлэл бэлдсэн юм” Ниса сүре, 102)

Орой намазын цаг болоход Билал бас Азан уншив. Курейшууд бас мусульманууд руу дайрахад зэхэцгээв. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) аетэд хэрхэн өгүүлсэнчлэн намазаа хэсэгчилэн үйлдэв.

Мусульмануудыг ингэж болгоомжлон мөргөл үйлдэхийг хараад мүшрикүүд ч алмайрч хоцров. Аллах тэдэнд айдас өгсөн болохоор юу ч хийж чадсангүй хий дэмий л харж зогсоцгооно. Мекке рүү буцацгаав. Асхабууд цөм Худейбие гэх газар луу хөдлөв.

Ариун газар Меккегийн ойр хавьд ирэхэд элчийн Кусва тэмээ өөрөө сөхөрчихөв. Түүнийг босгохыг маш их оролдсон боловч боссонгүй. Гэгээн пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) “Кусва хэзээ ч ингэж сөхөрдөггүй байсан. Гэхдээ нэгэн цагт (Эбрехегийн) зааныг Мекке рүү орохыг хориглон зогсоосон Аллах Кусваг бас хоргилон зогсоожээ. Хорвоо ертөнцийн эзэн Аллахт амлан айлдая! Курейшууд Аллах эзэний цээрлэсэн бүх зүйлийг (байлдах, цус урсгах, зугтаах гэх мэт) альныг нь ч надаас хүсэн, би тэдний хүсэлтийг нь биелүүэх болно” гэв.

Мусульманууд Худейбие гэх энэ газар хоноглов. Энэ бол Меккегийн хил юм.

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) майханаа Меккегийн хилийн гадна татав. Асхабуудтайгаа хүлээж эхлэв. Намаз цаг болоход намазаа Меккегийн хил дотор орж үйлдээд буцан гарч байлаа. Энэ газар усгүй газар юм. Мусульмануудын ус дууссан зөвхөн Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) тулманд жаахан ус үлджээ.

Мусульманууд “Аяа, Аллахын элч! Ус дууслаа. Бид сөнөх нээ”, гэхэд хорвоогийн энэрэл болсон элч (салаллаху алейхи уа сальлам): “Би та нарын хажууд байгаа цагт хэн ч сөнөхгүй” гэв. Тэгээд гараа тулмандаа усандаа түрж гаргаад дээш өргөн “Авцгаа! Ууцгаа” гэхэд түүний хуруу нь завсараас крант шиг зүйлээс ус оргилон гоожиж эхлэв. Асхабууд бүгд ханаж цадталаа ууцгаан бүх тулман сав суулгаа усаар дүүргэн авав. Морь тэмээнүүдээ ч услав.

Тэр өдөр тэнд байсан Жабир бин Абдуллах: “Бид 1500 хүн байсан хэрвээ тэнд 100 мянган хүн байсан бол тэр ус бүгдэд нь хүрэх байсан юм” гэжээ.

Ридвани Биат (тангараг)

Мусульманууд Хубейбиед байх үед дээр үеэс мусульман найз байсан Хуза овгийн толгойлогч Будейл Мухаммед элчид (салаллаху алейхи уа сальлам) ирж мүшрикүүд цэрэгээ цуглуулан Худейбиегийн иргэн мусульмануудыг үлдэн хөөх хүртэлээ байлдахаар зэхэж байгааг мэдэгдэв. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам): “Бид хэнтэй ч тулалдахаар энд ирээгүй билээ. Зөвхөн Умре (Каабд очиж мөргөн залбирах бага хаж) хийхийн тулд, Каабыг тойрон залбирахаар ирсэн юм. Гэсэн хэдий ч биднийг хэн Аллахын тэр (Кааб) хөндийлэн холдуулахыг хүсвэл тэдэнтэй дайтах болно. Үнэндээ энэнээс өмнөх дайнууд Курейшийг хүчин мөхөс болгосон юм. Хэрвээ курейшууд хүсэх юм бол тэдэнд хэсэг хугацааны боломж олгоё. Энд хугацаанд надаас айх зүйлгүй тэд бас өөр отог овгуудын хооронд битгий орог. Намайг тэдэнтэй чөлөөтөй ярилцах боломж олгог. Хэрвээ би тэр отог овгуудыг ялан, тэд мусульман болцгоох юм бол Курейш мүшрикүүд хэрвээ хүсвэл тэдэн шиг мусульман болгож болно. Хэрэв би тэд нарын бодсон шиг буюу отог омгуудыг эс дийлвэл, тэр үед өөрсдөө ч гэсэн амар амгалан болон хүчирхэгжих болно. Хэрвээ мүшрикүүд энэ саналыг зөвшөөрөхгүй надтай байлдахыг хүсвэл Аллах эзэний нэрээр амлан тангараглая. Толгойгоо цавчуулах хүртэл тэдэнтэй байлдах болно. Аллах надад амласан амлалтаа заавал биелүүлэх болно!” гэв.

Хуза овгийн Будейл Аллахын элчийн энэ үгийг курейшийнханд дуулгажээ. Курейшүүд элчтэй уулзуулахаар Урве бин Месудийг илгээжээ. Урве бин Месуд хэнийг ч Меккед оруулахгүй гэсэн мүшрикүүдийн хатуу шийдвэрийг хэлэхэд Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам): “Хөөе, Урве Аллахын төлөө хэл! Энэ их тэмээгээр тахил өргөхөд, энэ Каабе-и Муеззамаг тойрон мөргөхөд саад болно гэж үү?” гээд Хуза овгийн ахлагчид хэлсэнээ бас хэлжээ.

Урве пайгамбарын (салаллаху алейхи уа сальлам) үгийг сонсож байхдаа мусульмануудын байр байдал, соёлч зан, элчдээ гэсэн хүндлэл, ааш араншинг нэгэн нэгэнгүй ажиглаж суулаа. Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) үгийг сонсож дуусаад курейш руу буцлаа. Курейшийнханд ирээд: “Хөөе, курейшийнхан би Кайзер, Нежаши, Кисра гэх мэт маш олон хаад ноёдын өмнө бараалхаж байсан билээ. Гэхдээ

энэ өдөрийг хүртэл мусульмануудын Мухаммедэд үзүүлж буй хүндлэл шиг хүндлэл өөр ямар ч хаанд үзүүлж байхыг хараагүй билээ. Асхабуудын хэн нь ч тэнд зөвшөөрөлгүйгээр ярьдаггүй юм байна. Тэрний толгойноос ганц ширхэг үс унахад хүртэл барьж аваад өвөртөө хадгална. Түүний хажууд ярихдаа дуугаа намсган шивнэлдэж ярина. Түүнд үзүүлэх хүндэтгэлээсээ болж нүүр лүү нь эгцэлж харахгүй юм. Тэр фсхабдаа нэг зангахад эсвэл нэг тушаал хэлэхэд амиараа ч болов дэнжин тавьж биелүүлэхэд бэлэн байх юм.

Хөөеб Курейшийнхан! Та нар яаж ч зүтгээд дайтаж байсан ч тэд нар өөрийн элчийнхээ ганц ширхэг үсийг та нарт өгөхгүй! Тийм болохоор сайн бодоцгоо, Мухаммед бидэнд маш сайн болзол тавьж байна. Энэнийг ашиглацгаая!” гэв.

Курейшууд энэ үгийг зөвшөөрөлгүй Урвег зодож занчив. Тэгээд удаах мусульман руу илгээсэн элч нь Ахабиш овгийн толгойлогч Хулейс байжээ. Хулейсийн ирж явааг харсан элч маань: “Энэ ирж буй тахилд хүндлэл үзүүлцгээ. Бидний авч ирж буй тахилд хүндлэл үзүүлсэн хүн Аллахын зарлигийг биелүүлж мөн мөргөл залбирал хийх дуртай овгоос болж тооцогдоно. (Асхаб минь!) Тахил өргөх тэмээнүүдийг түүний өмнүүр тууцгаа” гэв.

Хулейс тамгалагдсан, хүзүүндээ тахилын шинж тэмдэг болсон олс боосон олон тэмээнүүдийг анхааралтай харж зогсохдоо: “Мусульманууд Каабд мөргөн залбирахаас өөр ямар ч зорилгогүй иржээ. Тэдний энэ ариун үйлсийг зогсоох, эсэргүүцэх нь том нүгэл юм. Мүшрикүүд маш том эндүүрч байна даа” гэж өөртөө шивнэнэ. Энэ үгийг сонссон элч (салаллаху алейхи уа сальлам) “Тийм ээ, яг үнэн, Кинане хөвгүүд овгийн дүү минь” гэв. Хулейс юу ч ярилгүй мүшрикүүд рүү буцаж очив. “Та нарын энэ үйлдэл буруу юм байна” гэсэн үгийг ойлгуулан хэлэв.

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) мүшрикүүдтэй хэлэлцээр хийхээр гэгээн Осман бин Аффаныг илгээлээ. Түүнд: “Бид энэ газар хэнтэй ч байлдахаар ирээгүй. Авч ирсэн тахилын тэмээнүүдээ тахиад буцацгаах болно. Тэдэнд хэл, бас тэднийг Ислам шашинд уриалан дууд” гэв. Осман (радиаллаху анх) элчийн хэлсэн энэ үгийг мүшрикүүдэд хэлэхэд, тэд мөн л эсэргүүцэв. Зөвхөн чи өөрөө Каабд мөргөөд буц гэгцээв. Осман: “Аллахын элч мөргөөгүй байхад би ч гэсэн мөргөхгүй” гэв.

Энэ үгийг сонсоод маш их уурласан мүшрикүүд түүнийг зодов. Энэ асхабуудад: “Осман шахед (амь үрэгдсэн) боллоо” гэсэн буруу мэдээ болж ирэв. Энэ мэдээг пайгамбард (салаллаху алейхи уа сальлам) хэлэхэд маших харуусан: “Хэрвээ энэ үнэн юм бол байлдаж мүшрикүүдийг ялахаас нааш эндээс буцахгүй” гэв. Дараа нь Семүре гэх модон доор суугаад: “Аллах надад тангараг өргөхийг зарлиглалаа” гэв. Дараа нь асхабуудаа тангарагт дуудав.

Асхабууд цөм Аллахын элчийн (салаллаху алейхи уа сальлам) өмнө сөгдөж суугаад гараа элчийн гараас бариад: “Аллах эзэн чамд ялалт өгөх хүртэл, чамтай мөр зэрэгцэн тулалдаж ялалтыг байгуулах, эсвэл ийм сэтгэлээрээ амиа өргөхийг амлаж байна” хэмээн амлалтаа өгөв. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) нэг гараа нөгөө гар дээрээ тавиад тэнд байгаагүй Османы өмнөөс амлалт өгөв. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) асхабуудынхаа ам тангарагт талархан: “Энэ модны доор тангараг өргөгсөдийн хэн нь ч тамд унахгүй” хэмээжээ. Энэ тангарагийг Биат-и Ридван гэдэг.

Гэгээн Османыг (радиаллаху анх) мүшрикүүд барьж шоронд хийсэн байлаа. Нэг шөнө мусульман цэрэгүүд унтаж байх хооронд Микрез гэх кафираар толгойлуулсан 50 хүнтэй мүшрик мусульманууд руу дайрсан боловч харуул хийж байсан цэрэгүүд тэдэнтэй тулалдан Микрезээс бусадыг барьж олзолжээ. Зөвхөн Миркез л зугтаан гарч амжжээ. Энэ хүмүүсийн талыг нь суллаж талыг нь олзолжээ. Маргааш нь мөн адил дайрсан боловч нилээн хэдийг нь мусульманууд барьж аван олзолоод дараагаар нь тавьж явуулжээ.

Намайг авраач, Аллахын элч минь!..

Исламын цэрэгүүд байлдаанд бэлэн болохыг ойлгосон мүшрик цэрэгүүд эмээцгээж эхлэв. Тэдэнд гэрээ хийхээс өөр арга зам байхгүйг мэдээд үтэр түргэн гэрээ хийх хэсэг хүн бүхий төлөөлөгчид илгээв.

Хайрт пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) курейшийн төлөөлөгчидийг хүлээж авав. Төлөөлөгчдийн анхны хүсэлт нь озлогсодыг суллахыг хүсэв. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам): “Меккед хоригдож буй мусульмануудыг тавьж явуулах хүртэл бид олзлогсодыг суллахгүй” гэв. Сүхейл:

“Та бидэнтэй их шударга байлаа” гээд Мекке хотод баригдсан гэгээн Осман ба түүнээс өмнө шоронд байсан арваад асхабыг суллан явуулав. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) олзлогдсон мүшрикүүдийг суллан явуулав.

Тэд удаан ярилцсаны дараа гэрээ хийхээр болов. Цаасан дээр бичихээр болоод гэгээн Али (радиаллаху анх) бичээч нь болов. Гэрээг бичих цаас, бэхээ бэлдэв. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) Алид хандан “Бич” гэлээ. “Бисмиллахир рахманиррахим!” Энэ үгийг Сүхейл эсэргүүцэв. “Би рахман (энэрэнгүй) үгийг юу болохыг мэдэхгүй ингэж битгий бич: “Бисмике Аллахумма (Аллах минь чиний нэрээр эхэлнэм)” гэж бич! Эс бөгөөс гэрээ хийхгүй!” гэв. Пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) энэ гэрээг маш их утга учиртай гэрээ гэж бодож байв. Тиймээс “Бисмике Аллахүме гэж бич, тэр ч гоё үг” гэв. Али ч бичив. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам): “Энэ Мухаммед элчийн Сүхейл бин Амртай хэлэлцсэний үндсэн дээр хийн тохиролцсон, бас гарын үсэг зурсан зүйл юм” гэж хэлэхэд Сүхейл гэгээн Алигийн гарыг барин авч Мухаммед элчид (салаллаху алейхи уа сальлам) хандан: “Бид чамайг Аллахын элч гэдэгийг хүлээн зөвшөөрсөн бол чиний эсрэг зогсохгүй байх байсан, тийм болохоор Аллахын элч гэж бичихгүй, Абдуллахын хүү Мухаммед гэж бич” гэв. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) тэр үгийг хүлээн зөвшөөрч: “Та нар намайг эсэргүүцсэн ч би үнэндээ Аллахын жинхэнэ элч мөн. Миний нэр ба эцэгийн минь нэрийг бичих нь намайг элчийн үүрэгээс чөлөөлөхгүй шүү дээ. Али, тэрнийг арилга! Мухаммад бин Абдуллах гэж бич!” гэв.

“Аллахын элч” гэсэн үгийг арилгуулахыг аль ч асхаб хүссэнгүй. Тэд гэнэт хөл дээрээ босон “Хөөе, Али, Мухаммед Аллахын элч гэж бич, хэрвээ ингэж бичихгүй бол мүшрик бид нарын хоорондын асуудалыг зөвхөн сэлэм л шийднэ” гэгцгээв. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) асхабуудынхаа энэ итгэл үнэмшилд баярлав. Гэхдээ гараа өргөн тэднийг чимээгүй байхыг дохив. Гэгээн Али: “Аяа, Расулуллах! Би таны энэ ариун нэрийг арилгаж үл зүрхэлнэм” гэв. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам): “Түүнийг надад харуул, би өөрөө арилгъя” гэв. Гэгээн Али (радиаллаху анх) харуулахад элч өөрийн гараар арилгав. Оронд нь Абдуллахын хүү Мухаммед (салаллаху алейхи уа сальлам) гэж бичив. Дараа нь гэрээний нөхцөлүүд бичигджээ.

1. Энэ гэрээ 10 жил хүчинтэй, энэ хугацаанд хоёр тал нэг нэгэнтэйгээ дайн хийхгүй байх.

2. Мусульманууд энэ жил Каабд мөргөхгүй, зөвхөн нэг жилийн дараа Хаж хийж болно.

3. Каабд мөргөхөөр ирсэн мусульманууд Меккед 3 хоног болно, бас өөртөө замын зэвсэгээсээ өөр зэр зэвсэггүй байх.

4. Мусульманууд Каабыг тойрон мөргөх үед Меккегийн мүшрикүүд тэндээс холдож боломж олгож өгөх.

5. Курейшуудаас мусульман болсон хүн эзэнийхээ зөвшөөрөлгүй Медине рүү явах юм бол тэрнийг буцаах хэрэгтэй. Мусульмануудаас хэн нэгэн хүн курейшын талд орон Меккед ирэх юм бол буцааж явуулахгүй байх.

6. Асхабуудаас хэн нэгэн хүн Хаж ба Умре (бага хаж) хийхээр Меккед ирэх үед түүний хөрөнгө ба аминд нь аюулгүй баталгаа гарган өгөх.

7. Мүшрикүүдээс хэн нэгэн хүн Шам, Египет эсвэл өөр нэг газар луу явахдаа Меккед орох юм бол түүний амь, мал хөрөнгөнд нь халдахгүй байх.

8. Бусад Арабын отог овогууд өөрсдийн хүссэн талдаа орох боломжтой. Мусульманууд эсвэл мүшрикүүдийн аль нь ч тэдний хувьд нээлттэй. Гэрээнд гарын үсэг зурах гэж байхад хөлөнд байгаа гэнжийг чирч нэг хүний исламын цэрэгт ирж байгаа нь харагдлаа. Тэр хүн арай гэж пайгамбарын өмнө ирж унаад: “Намайг авраач, аяа, пайгамбар минь!” гэж хэллээ. Мусульман болж, зөв замд яваа энэ хүн бол Сүхейлийн хүү Эбү Жендел байсан. Сүхейл Эбү Женделийг зааж “Шинээр бичсэн гэрээний ёсоор эргүүлж өгөх анхны хүн чинь энэ болно” гэв. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) “Одоохондоо гэрээнд гарын үсэг зураагүй шүү дээ” гэхэд Сүхейл: “Хэрэв хүүхдийг минь эргүүлж өгөхгүй бол энэ гэрээнд хэзээ ч гарын үсэг зурахгүй” гэв. Пайгамбар маань түүнийг миний хувьд гэрээнээс гадуур болго гэсэн ч буруу номтонууд үүнийг зөвшөөрсөнгүй. Сүхейл хүүхдийг нь авч явж байхад Эбү Жендел: “Аяа, Расулуллах, аяа мусульман ах дүү нар минь, намайг энээ мүшрикүүдэд даалдаж байгаа юм уу? Намайг өдөр бүр тамлан зовоохыг зөв гэж байгаа юм уу?” гэж орилов. Ийм өрөвдөлтэй үгнүүдэд тэсэхийн аргагүй байлаа. Пайгамбарын (салаллаху алейхи уа сальлам) нүдэнд нулимс сийлэгнэж: “Жаахан тэвчээрэй, аяа, Эбү Жендел. Энэний хариуг Аллагаас гуй. Аллах эзэн чамд гарах замыг өгнө” гэж

тайвшруулаад “Өгсөн амлалтанд хүрэхгүй нь бидэнд тохирохгүй зүйл” гэв.

Ингээд гэрээг хоёр хувь болгон хоёр цаасанд бичээд гарын үсэг зурж батлацгаав.

Энэ гэрээ мусульмануудын эсрэг гэж бодоцгоосон мүшрикүүд маш их баярлацгаав. Гэхдээ энэ бол Мухаммедын (салаллаху алейхи уа сальлам) жинхэнэ ялалт байсанийг тэд хэрхэн ойлгох билээ. Энэ бол мусульмануудыг нэг улс болохыг хүлээн зөвшөөрч байгаагийн шинж юм. 10 жилийн хугацаатай энэ гэрээ мусульмануудыг хүчирхэгжүүлж дэлхий даяар ислам шашин түгээхийг мүшрикүүдээс хэн нь ч бодоогүй биз.

Ингээд мусульманууд гэрээ ёсоор буцахаар болов. Мухаммед элч маань (салаллаху алейхи уа сальлам): “Босоцгоо, тахилаа өргөцгөө. Үсээ засуулцгаагаад Ихрамаасаа (хаж мөргөлийн хувцас) гарцгаа” хэмээв. Расулуллах (салаллаху алейхи уа сальлам) бүхнээс урьтаж тахилаа өргөв. Дараа нь элчийн (салаллаху алейхи уа сальлам) үсийг Хераш бин Үмейе засав. Асхабууд түүний ариун үсийг газар унагахгүй нь тулд шүүрэн авч буян хишиг хүлээн өвөрлөж байлаа. Асхабууд ч тахилаа өргөн зарим нь үсээ тайруулж, зарим нь хусуулжээ.

Мусульманууд Худейбид 20 хоног буудалжээ. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) мусульмануудаа аваад Медине рүү буцацгаав. Буцах замд Аллах эзэн элчид Фетих сүрег (бүлэг) илгээжээ.

Мусульманууд ялалт байгуулан Мединед ирэх үед Курейшийн хамгийн зэрлэг овогоос Эбү Басир (радиаллаху анх) мусульман болжээ. Мүшрикүүдийн хажууд амьдрах боломжгүйг ойлгосон Эбү Басир Медине рүү ирсэн боловч, гэрээнд заасан ёсоор буцах ёстой учираас тэндээс ч явж Улаан тэнгисийн хажууд Ис гэх газар нутаглан амьдарчээ.

Энэ газар нь курейш мүшрикүүдийн Шам руу явах наймааны зам байлаа. Энэ өдөрөөс хойш курейшээс мусульман болсон хүмүүс Меккед ирж нутаглах боломжгүйгээс болж Исд байх Эбү Басирын хажууд очиж нутаглах болжээ. Ингэж Ис хотод ирэгсэд өдөр ирэх тусам нэмэгдсээр 300-гаад хүн болжээ. Курейшийн наймааны жингийн цуваа Шам руу явах замдаа энэ Ис тосгоныг дайран өнгөрдөг байлаа. Эбү Басир хамт амьдрах мусульмануудтайгаа энэ газараар дайрч өнгөрөх мүшрикүүдийг барьж аваад мусульман болцгоохыг нь хүсдэг байлаа. Мусульман

болоогүй хүмүүсийг хяхан хавчиж хэцүү байдалд оруулдаг байв.

Меккечүүдийн Шам хот руу явах зам ийн хэцүү болсоныг бодон Медине хот руу хэсэг төлөөлөгчөө илгээн гэрээний заалт болох “Курейшээс мусульман бологсод Медине рүү ирэх юм бол буцаагдана” гэсэн заалтыг хүчингүй болгооч гэж Мухаммед элчээс гуйв. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) ч тэдний энэ гуйлтыг зөвшөөрсөнөөр мүшрикүүдийн Шам руу явах зам нээгдэн харин Ис хот дахь мусульманууд Медине хотод нүүн иржээ.

УРИАЛСАН ЗАХИА

Хаадуудад илгээсэн захиа

Хорвоогийн сүүлчийн элчийн (салаллаху алейхи уа сальлам) хамаг хүсэл зорилго нь энэ ариун шашиныг дэлхий даяар тараан хүн бүр зөв замыг сонгон хойд ертөнц ба энэ хорвоогийн үүрдийн аз жаргал олоосой гэсэн хүсэл эрмэлзэл юм. Тийм болохоор хажуу хавийн хаад ноёдод элчээ илгээн исламд уриалсан захиа хүргүүлэхийг хүсчээ. Дихие Келбийг (радиаллаху анх) Ром, Амр бин Умейг (радиаллаху анх) Этёп руу, Хаттаб бин Эбу Белтеаг (радиаллаху анх) Египет рүү явах элч болгон томилов. Бас Салит бин Амрыг (радиаллаху анх) Емен рүү, Шужа бин Вехбийг (радиаллаху анх) Гассан руу, Абдуллах бин Хузафег (радиаллаху анх) Иран руу илгээв.

Энэ элчүүд асхабын хамгийн мэдлэг боловсролтойгоороо шилэгдсэн хүмүүс ба царай төрх ба үг яриа нь хамгийн цэцэн нь юм. Бүх хаадад тус тусд нь Исламд уриалсан захиаг бичжээ. Захиаг “Аллахын элч Мухаммед алейхиссальлам” гэсэн тамгаараа тамгалав.

Египет хот руу элчээр очсон Амр бин Убей хаан Нежашид бараалхан элчийн захиаг хүргэв. Нежаши хаан ширээнээсээ хүндэтгэлтэйгээр хоёр гардан захиаг аван үнсээд магнайд хүргэсэнийхээ дараагаар задлан уншив.

“Бисмиллахиррахманиррахим!”

Аллах эзэний элч Мухаммедээс (aleyхиссальлам) Этёпын хаан Нежаши Эсхаме танаа!

Зөв замд орогсодод мэнд хүргэе! Аяа, хаантан минь! Таны мэнд амарыг мэдэн мэндчилье, танд олгогдсон буян хишигийн төлөө Аллах эзэндээ талархая. Тэрнээс өөр бурхан үгүй билээ.

Тэр хамаг бүхэний эзэн нь юм (бүхий л хорвоо ертөнцийн эгнэшгүй нь тэр юм). Аллах Куддус юм (бүхий л зүйлд хүчин төгс юм), Селам юм (Боол бологсодоо бүхий л аюул заналаас хамгаална), Мүмин юм (Энх тайваныг өгөгч), Мүхейм юм (Бүх зүйлийг харж хамгаалагч).

Би Иса (Есүс) элч бол Аллахын цэвэр ариун элч болохыг хүлээн зөвшөөрч байна. Түүний эх Мариям бол цэвэр ариун явдалт, бүхий л муу муухайгаас ангид нэгэн хүн билээ. Гэсэн ч тэрээр огт үгүйгээс жирэмсэн болон Иса элчийг төрүүлжээ. Аллах эзэн анхны хүн Адамыг (алейхиссальлам) хэрхэн үгүйгээс бүтээсэн шигээ Иса элчийг ч ингэж мэндлүүлжээ.

Аяа, хаан минь! Би чамайг цор ганц эзэн Аллахд итгэхийг, түүнд захирагдан дагахыг, түүний илгээсэн шашинд орохыг урьж байна. Би бол энэ бүхэнийг хүмүүст түгээхээр томилогдсон Аллахын элч юм.

Одоо би таныг юу юунаас ч илүү хэрэгтэй зүйлд уриаллаа. Миний үгийг хүлээн зөвшөөрөөч! Зөв зам руу орон, гэгээрэлийг ологсодод хайр ивээл өгөг.”

Мухаммед элчийн (радиаллаху анх)энэ захиаг хүндэтгэлтэйгээр сонссон Нежаси Эсхаме: “Эшхадү эн лаа илааха иллаллаху, вэ эшхадү энна Мухамеден абдүхү вэ расүүлүх (Аллахаас өөр бурхан үгүйг гэрчилнэм, Мухаммед бол түүний элч бас боол болохыг гэрчилнэм)” гэж хэлээд мусульман болжээ. Тэрээр: “Би энэ элч бол христүүд ба жүүдүүдийн сударт айлдагдсан сүүлчийн элч мөн болохыг гэрчилж байна. Хэрвээ элчийн хажууд очоод ариун дүр төрхийг үзэх завшаан тохиох юм бол, энэ бол миний хамгийн их аз жаргал байх болно” хэмээжээ. Тэгээд захиаг маш гоё хээнцэр нэгэн хайрцаганд хийгээд: “Энэ захиа энд байх хугацаанд Этөпт Аллахын буян хишиг тасрахгүй” гэв.

Гэгээн Дихие-и Келби ч Ром гүрэнд исламын захиаг хүргэн очив. Захиагаа Бусра хот дахь Гассаны хаан Харист өгөх үүрэгтэй юм. Тэр цааш нь дамжуулан Ромын хаан Геркулест илгээх ёстой байлаа.

Дихие (радиаллаху анх) Харистай уулзан учирч, явдалаа хэлжээ. Харис Дихиегийн хажууд Адын бин Хатемийг дагуулан, тэр үед Кудус хотод яваа Геркулес рүү тэднийг явуулав. Тэд Куддуст ирээд хаантай уулзахаар болоход хааны шилтгээний албат барлагууд: “Хааны өмнө бараалхахаар орохдоо толгойгоо

бөхийлгөж явсаар байгаад ойртон очихдоо газар сөхрөн түүнд мөргө. Тэр толгойгоо өргө гэж тушаах хүртэл хэзээ ч толгойгоо өргөж болохгүй, мөргөсөөр бай” гэж захив.

Энэ үгийг сонссон гэгээн Дихие “Бид мусульманууд Аллах эзэнээс өөр хэний ч өмнө мөргөхгүй, хүн хүндээ мөргөхийг хориглодог билээ” гэв. Ордны барлагууд: “Тийм бол энэ захиаг огтхон ч нээж уншихгүй, бас чамайг хөөж гаргах болно” гэв. Гэгээн Дихие: “Миний пайгамбар Мухаммед (алейхиссальлам) хэн нэгэн хүн өөрт нь мөргөх нь байтугай жаахан бөхийхийг хүртэл зөвшөөрдөггүй. Түүнтэй ярихаар ирсэн хүн адгийн нэг боол ч байсан түүний үгийг сонсож түүнтэй ярилцдаг. Түүний асуудалыг сонсож, туслаж баярлуулдаг билээ” гэв.

Энэ яриаг сонсож зогссон нэг хүн “Чи тэгэхээр мөргөхгүй юм бол би чамд захиагаа түүнд хүргэж өгөх зам зааж өгье. Манай хаан өдөр бүр үд дунд хавиар өөрийн цэцэрлэгдээ суун нарладаг юм. Тэнд очихдоо нэг индэр мэт чулуу бий. Тэр чулуун дээр бичигтэй цаас тавигддаг бол хаан тэр цаасыг авч уншаад бодолгоширон суудаг. Чи ч мөн адил захиагаа тэр чулуунд тавьчих. Хаан авч уншаад чамайг дуудахад чи ирээд өөрийн зорилгоо хэл” гэв.

Энэ хүний хэлсэнчлэн гэгээн Дихие (радиаллаху анх) захиаг чулуун индэр дээр тавив. Геркулес захиаг анзааран хараад очиж авав. Тэгээд Араб хэл мэдэх нэгэн орчуулагч дуудав. Орчуулагч Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) бичсэн захиаг уншиж эхлэв. Захианы хамгийн эхэнд “Бисмиллахиррахманир рахим! Аллах Теалагийн элч Мухаммедээс (алейхиссальлам) Ром гүрний дээдэс Геркулес танаа!” гэж бичсэн байлаа. Геркулес орчуулагчид захиаг ингэж эхэлхэд маш их уурлан түүний цээжийг маш хүчтэй цохив. Орчуулагч цохилтыг дийлэхгүй газар унахад захиа гарнаас нь мултран газар унав. Геркулес орчуулагчад “Ягаад ингэж уншив?” гэж асуув. Орчуулагч: “Захиа нь дээр ингэж бичсэн байна. Эхлээд өөрийнхөө нэрээр эхлээд дараа нь таны нэрийг бичихдээ “хаан” биш “дээдэс” гэсэн байна” гэв.

Геркулес “Түүний захиаг өнөөдөр уншихгүй” гэв. Геркулес “Мухаммед, чи эсвэл их ухаантай хүн, эсвэл дүүрчихсэн тэнэг. Чамайг ийм хүн байхыг төсөөлөөгүй явж, намайг захианы дотор юу бичигдсэнийг уншихгүй урж хаясан гэж бодож байна уу? Амь амьдралаараа тангарагъя! Хэрвээ тэр өөрийнхөө бичсэн шиг Аллахын элч юм бол миний нэрнээс өмнө өөрийн нэрээ бичиж

бас Ромын “хаан” гэж биш “дээдэс” гэж хэлэх нь зүй. Би үнэндээ хаан биш дээдэс мөн” гэж дотороо бодоод орчуулагчийг хөөн явуулав.

Дараагаар нь христийн шашинтнуудын хамгийн их эрдэм мэдлэгтэй хүн болох өөрийн шадар түшмэл Ускуфыг дуудан ирүүлж захиаг үргэлжлүүлэн уншуулав. “Аллахын ариун замыг ологсод ба зөв үйлийг үйлдэгсэдэд мэнд хүргэе! Энэ цагаас хойш (Аяа, Ромын дээдэс) таныг ислам шашинд уриалж байна. Исламыг хүлээн зөвшөөрөн амар амгаланг олж ав. Мусульман болвол Аллах чамд хоёр дахин илүү буян хишигээ хайрлана. Хэрвээ чи нүүр буруулваас бүхий л христийн шашинтнуудын зовлон нүгэлийн чи үүрэх болно! “Ингэж хэл: “Хөөе, сударын эзэд ээ, (христүүд ба жүүдүүд) бидний дунд гарч ирсэн ариун үгийг хэлэн нэгдэцгээе. Аллахаас өөр юу ч битгий шүтэцгээ ба Хэрэв энэ үгнээс нүүр буруулах юм бол “Бид мусульман!” гэцгээ” (Али Имран, 64). Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) энэ захиаг уншиж байхад Геркулесийн магнайгаас хүйтэн хөлс дуслаж байлаа. Захиа дууссаны дараа: “Сүлеймен (алейхиссальлам) элчээс хойш би энэ “Бисмиллахиррахманиррахим” гэж эхэлсэн захиа үзээгүй билээ” гэв. Геркулес Ускуфаас бодож байгаа зүйлийг нь асуухад: Тэр “Энэ Муса ба Иса (алейхимуссальлам) элчүүдийн бидэнд ирэхээр мэдээлсэн сүүлчийн элч мөн. Бид түүнийг хүлээж байсан юм” гэв. Геркулес “Чи энэ талаар юу гэж захимаар байна?” гэж асуухад Ускуф: “Түүнд итгэж дагах нь зөв” гэв. Геркулес: “Би чиний хэлж буйг маш сайн ойлгож байна. Би түүнд итгэн мусульман болж чадахгүй. Ягаад гэвэл намайг хаан ширээнээс авч хаян, алах болно” гэв. Ингээд Дихие ба Ад бин Хатем нарыг дуудуулав. Ад: “Хаантан минь, наймаа хийхээр Араб руу явсан жинчид маань маш сонин зүйл ярьж эхлэх боллоо” гэв. Геркулес: “Тэр сонин явдал чинь юу юм бэ?” гэж асуухад Дихие (радиаллаху анх): “Бидний дундаас нэгэн элч гарсан юм. Ард түмэний зарим нь түүнд итгэн дагаж, зарим нь эсэргүүцэн зогссон юм. Энэ хоёр тал хоорондоо дайтаж байгаа билээ” гэв.

Ингээд Геркулес Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) талаар судлаж эхэлжээ. Шамын захирагчид элчийн овгийн нэг хүнийг олж өгөхийг тушаал буулгажээ. Шам хотын захирагч тийм хүн хайж явахдаа Меккегээс Шам хотод ирсэн наймаачидаас асууж сураглажээ. Тэр наймаачид дотор мусульман болж амжаагүй Эбү Сүфиян байлаа.

Шамын амбан захиргч цэрэг явуулан Эбү Сүфиянийг авч ирүүлээд Геркулест бараалхуулав. Энэ үед Геркулес Кудддус хотод нэгэн христийн сүмд байлаа. Тэрээр Эбү Сүфияний хажууд байх 30 хүнийг сүмд хүлээн авав.

Орчуулагч дуудуулав. Тэдэнд: “Арабд гарсан шинэ элчийн хувьд хамгийн ойрын хамаатан болох хүн та нар дотор байна уу?” гэж асуулаа. Эбү Сүфиян: “Түүний ойрын хамаатан нь би байна, тэр бол миний авга ахын хүү” гэв. Геркулес Эбү Сүфияныг өөртөө ойртохыг хүсэв. Геркулес түүнээс асуув.

- Өөрийгөө элч гээд байгаа тэр хүний удам угсаа ямар вэ?

-Тэр бол Арабуудын хамгийн эрхэм дээд овгийн удам угсааны хүн юм.

-Та нар дотор түүнээс өөр өөрийгөө элч гэж зарласан хүн байсан уу?

-Үгүй.

- Түүний өвөг дээдэс дотроос хаан болж байсан хүн бий юу?

- Үгүй.

- Түүнд ихэнхдээ ихэс дээдэс итгэж байсан уу? Эсвэл ядуус уу?

-Түүнд итгэгсэд дандаа ядуус, өнчин өрөөсөн хүмүүс ба залуус. Ард олноос хөгшин бас дээдсүүдээс түүнд итгэгсэд нь маш бага.

- Түүнд итгэгсэд нь олширч байна уу? Багасаж байна уу?

- Өдөр ирэх тусам олширч байна.

-Түүний шашинд орсоныхоо дараагаар уурлаад эсвэл таалагдахгүй болохоор шашинаас нь гарсан хүн байна уу?

-Үгүй байхгүй.

-Тэр хүн огт амлалтаа эс биелүүлэн, худалаа ярьж байсан уу?

-Үгүй. Бид одоо түүнтэй хэсэг хугацаанд байлдахаа болиод гэрээ хийсэн юм. Энэ хугацаанд түүний юу хийхийг нь мэдэхгүй.

-Тэр та нарт юу гэж зартиглаж байсан бэ?

-Тэр Аллахд итгэн залбирахыг, түүнтэй өөр юуг ч зүйрлэхгүй байхыг зарлиглан номлодог. Манай өвөг дээдсийн мөргөдөг байсан зүйлд (шавар бурхадад) мөргөн сүсэглэхийг биднээс хориглодог юм. Намаз (мөргөл) үйлдэхийг, шударга байхыг, ядууст туслахыг, нүгэлээс зугтаахыг, амлалтаа биелүүлэхийг, даалган

захисан захиасийг ёсчлон биелүүлэхийг бидэнд номлодог юм.

Сүмд ийм яриа өрнөв. Геркулес Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) илгээсэн захиаг ахин нэг уншаад хүндэтгэлтэйгээр үнсээд хоёр нүдэндээ хүргээд толгой дээрээ тавихад шуугиан эхлэв. Эбү Сүфиян ба хажууд нь байсан бүх мүшрикүүд гадагш гаргахад Эбү Сүфиян мусульман болоогүй хэрнээ Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) энэ үйл заавал бүтэж, улам дэвжинэ гэж өөртөө хэлжээ.

Геркулес Дихиег дуудаад: “Надад нэг захиа ирвэл уншилгүй, би ухаантуудтай зөвлөлдөхгүйгээр ямар нэгэн хариу бичдэггүй билээ. Чи надад бодох хугацаа өг” гэв. Геркулес хэдэн хоногийн дараа Дихиег өөрийн өргөөндөө дуудуулан ганцаарчилан уулзахдаа “Чамайг илгээсэн хүн бол бидний (христийн) номонд дурьдагдсан сүүлийн элч болохыг би мэдэж байна. Гэхдээ түүнд итгэх юм бол Ромынхон намайг алах вий гэхээс айж байна. Би чамайг тэдний дундах хамгийн ухаантай гол эрдэмтэн болох Дагатир луу илгэе. Тэр бол сүсэгтэнүүдийн (христийн) тэргүүн билээ. Түүний үгийг ард олон минийхээс илүү хүндлэн дагадаг юм. Хэрвээ тэр хүн танай шашинд итгэн үнэмших юм бол би тэр үед зүрхэнд байгаа итгэлээ ард олны өмнө дэлгэх болно” гэв.

Ингээд Геркулес нэг захиа бичээд Дихиед өгөөд Дагатир луу илгээв.

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) Дагатирд ч захиа илгээсэн билээ. Дагатир захиаг задлан уншаад Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) шинж тэмдэгүүдийг сайтар асууж мэдээд, түүнийг Муса (алейхиссальлам) ба Исагын (алейхиссальлам) ирнэ гэж мэдээлсэн сүүлчийн элч болохыг огт эргэлзэхгүйгээр ойлгон итгэж үнэмшжээ. Тэрээр гэртээ очин мөргөн залбирч 7 хоног бүр хийдэг байсан сургаал номлолдоо 3 долоо хоног очсонгүй. Христүүд түүний гэрийн гадна очоод: “Дагатирт юу болов? Тэр арабтай уулзсанаасаа хойш гэрээсээ гарахгүй байна. Дагатирийг гарга” хэмээн орлилдцгоов.

Дагатир хар пастрын хувцасаа тайлан цав цагаан хувцас өмслөө. Гартаа таяг барин сүмд иржээ. Хотын ард иргэдийг цуглуулсаны дараагаар “Хөөе, христүүд минь! Мэдэцгээ, сонсоцгоо, бидэнд Ахмедээс (алейхиссальлам) захиа ирлээ. Тэрээр биднийг үнэн шашинд уриалж байна. Би тэрнийг Аллахын элч болохыг мэднэ. Бас итгэж байна” гэв. Христүүд энэ үгийг сонсоод Дагдирыг бүлэглэн зодов. Зодсоор байгаад

шахед (алж) болгожээ. Гэгээн Дихие энэ явдалыг Геркулест ирж хэлэхэд, Геркулес: “Би чамд хэлээгүй юу, Дагатир бол христийн сүсэгтнүүдийн хувьд надаас илүү нэр хүндтэй хүн байсан юм. Хэрвээ би ийм алхам хийсэн бол намайг ч бас тэд алах байсан” гэв.

Геркулес нутагийн толгойлогчид болох ихэс дээдэсийг цуглуулан ислам шашинд итгэхийг уриалсан боловч тэд маш хүчтэй эсэргүүцэл үзүүлэв.

Геркулес гэгээн Дихиег дуудан маш үнэтэй бэлэг сэлт бэлдэн Мухаммед элчид (салаллаху алейхи уа сальлам) захиа бичин Дихиег буцаав. Геркулес мусульман болохыг хүссэн ч тэр байр байдалаас амиа алдахаас айн мусульман болж чадаагүй юм. Гэгээн Дихие Мединед буцаж ирээд элчид өгөх бэлэг сэлт ба Геркулесийн захиаг өгөв. Тэгээд болсон бүх зүйлийг дэлгэрэнгүйгээр ярьж ойлгуулав. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) Геркулесийн захиаг уншаад: “Тэр хэсэг хугацаанд ахин (баялагийн дунд) амьдрах болно. Миний илгээсэн захидал түүний хажууд байгаа цагт эд баялагаасаа хагацахгүй” гэв.

Элч Геркулесийн итгэн сүсэглэсэнийг уншаад “Геркулес худал хэлж байна. Тэр шашинаасаа (христ) гараагүй” хэмээжээ. Харин Геркулес элчийн илгээсэн захидалыг алтаар бүрхсэн нэгэн хайрцаганд хийн хадгалжээ. Түүний үр удам нь ч гэсэн тэр захиаг үргэлж хадгалсаар иржээ. Элчийн (салаллаху алейхи уа сальлам) хэлсэн захиа байгаа тохиолдолд эд баялаг нь үргэлжлэн гэсэнд итгэн найддаг байв. Энэ ч гэсэн үнэн билээ.

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) Хатиб бин Эби Белтеаг Египетийн хаан руу илгээжээ. Хатиб бин Белтеа (радиаллаху анх) Египетийн хаан Мукавкисд бараалхан элчийн исламд уриалан дуудсан захиаг хүргэв. Мукавкис захиаг уншин ойлгоод Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) талаар Хатибаас асууж эхлэв.

Мукавкис Хатибаас:

- Таныг явуулсан хүн жинхэнэ элч мөн үү?
- Тийм ээ, тэр бол элч.
- Тэр үнэхээр элч юм бол өөрийг нь нутагаасаа хөөн өөр ард түмэнд хорогдох тийм хэцүү байдлыг өгсөн өөрийн ард түмэндээ ягаад хараал хийгээгүй юм? гэв.
- Тэр бол энэрэнгүй хүн билээ.

- Чи маш гоё ухаалаг хариулт өглөө. Өнөөдөр манай ордонд тухалж алжаалаа тайл. Би хариугаа маргааш өгье гэв.

Харин маргааш Мукавкис гэгээн Хатибыг өөрийн өрөөндөө дуудуулж ирүүлээд, тэр хоёр маш удаан ярилцав. Мукавкис элчийн ямар хүн болохыг, юу юу номлодогийг цөмийг нь нэг нэгэнгүй асууж лавлав. Гэвч тэр өөрийн мухар сүсэгээсээ нэг л мултарч өөрийгөө чөлөөлж чадахгүй байлаа. Ийн ярилцсаны дараагаар араб бичиг мэдэх нэгэн хүнийг дуудуулаад Мухаммед элчид (салаллаху алейхи уа сальлам) захианы хариу болгон захиа бичүүлэв.

“Абдуллахын хүү Мухаммедэд Египетийн дээдэс Мукавкисээс!

Чамд мэнд болог! Над руу илгээсэн захиаг тань уншлаа. Захианд бичсэн исламын урилгыг ойлголоо. Би нэг элчийн ирэх болсоныг мэддэг байсан юм. Гэхдээ тэр элч нь Шам хотоос илрэх байх гэж боддог байсан. Элчийг чинь хүндэлж явууллаа. Чамд бэлэг болгон хоёр үзэсгэлэнт шивэгчин бүсгүй бас бус бэлэг сэлт илгээлээ” гэж бичив.

Мукавкис мусульман болсонгүй. Гэгээн Хатибыг (радиаллаху анх) маш хүндэтгэлтэйгээр дайлж зочилсоны дараагаар элчид өгөх захидал ба бэлэг сэлт болон 2 шивэгчин хүүхэний хамтаар нутаг буцаав. Бас тэдэнд морь унаа ба замд нь аюулгүй байдалыг хамгаалах цэрэг дагуулан явуулжээ.

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) болсон бүх зүйлийг Хатибаас (радиаллаху анх) олж дуулаад: “Энэ ямар муу хүн бэ? Эд баялагаа гэсэн шуналаасаа болоод мусульман болсонгүй. Үнэндээ тэрний эд баялаг мөнх бус билээ” гэв.

ХАЙБЕР ХОТЫГ ЭЗЭЛЭХ НЬ

Медине хотод мусульман болж харагдавч үнэндээ мунафик (хоёр нүүртэн) жүүдүүд олон байлаа. Эдний дунд гарамгай илбэ хараал хийдэг мунафик Лебид бин Асем гэдэг нэгэн байв. Жүүдүүд түүнд алт, мөнгө өгөн “Мухаммедэд хараал хийж, бидний өшөөг авч өг” гэгцгээв. Тэр ч үүнийг зөвшөөрөн Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) үс ба самыг нь, бас шүдийг нь гартаа оруулахыг завдаж байв. Энэ хүсэлээ ч элчийн хажууд ажиллаж байсан жүүдүүдээр дамжуулан гартаа оруулав.

Лебид элчийн (салаллаху алейхи уа сальлам) үс, самын шүдийг нь нэгэн даавуунд 11 боодол болгон боогоод хараалаа хэлж худагны гүнд чулуунд даруулж орхив. Энэ өдөрөөс хойш элчийн бие муудаж эхлэв. Маш хүндээр өвджээ. Орноосоо босож чадахаа больсон пайгамбарыг маань (салаллаху алейхи уа сальлам) асхабууд үргэлж эргэж тойрч байв. Харин Мунафикууд баярлан дэвхцэнэ.

Мухаммед элчид (салаллаху алейхи уа сальлам) Жабрайл (алейхиссальлам) сахиусан тэнгэр ирэн түүнийг хараасаныг, хараал нь Зерван худагны гүнд байгаа талаар мэдэгджээ.

Зерван худаг Мединед Бени Зүрейк гэх овгийн цэцэрлэгт байдаг аж. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) тэр худаг руу гэгээн Али, Зүбейр, Талха бин Аммар нарыг (радиаллаху анхум) явуулав. Тэд худагны усыг татаад ёроолд буй чулуун доорх 11 зангилаа бүхий даавууг авч Мухаммед элчид (салаллаху алейхи уа сальлам) ирэв. Тэд зангилааг тайлсангүй. Жабрайл (алейхиссальлам) Фелак, Нас сүрег авч ирээд, Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) 2 сүрег уншиж, ает болгондоо нэг зангилаа тайлагдаж байв. Ийнхүү зангилаа тайлагдсаар дуусахад элчийн бие хараалаас суллагдаж буцаад хэвийн байдалдаа оржээ.

Хараалч Лебид жүүдийг барьж, Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) өмнө авч ирэв. Элч (салаллаху алейхи уа сальлам) түүнд: “Аллах эзэн чиний надад хийсэн хараалыг мэдэгдэж, газарыг нь зааж өглөө. Чи яах гэж энэнийг хийсэн юм?” гэж асуув. Тэрээр “Алт, мөнгөнд шунсанаас болоод” гэв. Асхабууд “Аяа, Расулуллах! Та зөвшөөрвөл энэ жүүдийн толгойг цавчъя” гэхэд өөрийнхөө төлөө хэнд ч ял өгөөгүй элч (салаллаху алейхи уа сальлам) “Түүний амьдралын төгсгөлд

амсах Аллахын гэсгээл илүү аймшигтай билээ” гэв.

Жүүдүүд Мединегээс хөөгдөж гарсаны дараагаар Арабын Умард зүгт нутаглажээ. Зарим хэсэг нь Хайвер хотод суурьшжээ. Энэ жүүдүүдийн Мухаммед элчид (салаллаху алейхи уа сальлам) өширхсөн өш хонзон нь хэзээ ч мартагдсангүй бөгөөд үргэлж дайнд бэлдэж байлаа. Даруйхан л Аллахын элчийг (салаллаху алейхи уа сальлам) алж, исламын шашиныг зогсоохыг хүснэ. Тэд энд тэндхийн жүүд отог овогоос тусламж гуйн нэгдэцгээн Мединег дайлаар мордон, бүх өш хонзонгоо авцгаая гэж тохиролцгоов.

Хайвер дахь жүүдүүд энэ санааг хүлээн зөвшөөрөөд хажуу хавийн бүх жүүд отог овогуудаас гуйцгааж, тэднийг нэгдэхийг уриалав. Ингээд Хайбер хотод дайны бэлтгэл эхлэжээ.

Тэд ийнхүү дайнд бэлдэж байгааг Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) мэджээ. Абдуллах бин Ревахагийн хажууд 3 сахабаг (радиаллаху анхум) дагуулан Хайбер луу тагнуулаар явуулжээ. Хайбер бол том цайз хэрэмээр хүрээлэгдсэн маш том үр өгөөжтөй, газар нутагтай баян хот юм. Абдуллах хамт яваа тагнуулуудаасаа нэгийг нь Шикдүүрэг лүү, нэгийг нь Кетибе дүүрэг лүү, нэгийг нь Натат дүүрэг лүү тагнуулаар илгээв. Өөрөө бас нэг дүүрэг лүү нь очиж 3 хоног тагнуул хийж ажиглав. 3 хоногийн дараагаар нь тагнуулууд болзсон газараа уулзан нэгдээд үтэр түргэн Медине рүү буцан жүүдүүдийн дайны бэлтгэлээс сурч мэдсэн зүйлээ Мухаммед элчид (салаллаху алейхи уа сальлам) хэлэв.

Пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) асхабдаа маш хурдан дайнд бэлдэхийг тушаав. Жүүдүүдийг Медине хот руу ирэхээс өмнө урьтаж Хайвер хотыг дайлаар морьдохоор шийдэцгээв.

Мунафикуудын (хоёр нүүрт) толгойлогч Абдуллах бин Убей: “Мухаммед маш бага хүчээр дайтахаар очиж явна. Та нарт айх зүйл байхгүй. Гэхдээ болгоомжлон малаа цайз хэрэмэндээ оруулцгааж, тэднийг хэрэм цайзнаасаа гарч угтацгаа” гэсэн мэдээг Хайбер луу илгээв.

Дайны бэлтгэл дуусчээ. Мусульман цэрэгүүд цуглан 200 морин цэрэг, 1400 явган цэрэг, цэрэгүүд ислам шашинаа түгээн шахид болж буян хураахын тулд Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) зарлигийг хүлээн цуглацгаав. Мөн цэрэгүүдийн хоолыг нь хийж, шархын боож, эмчлэх зорилготойгоор 20 эмэгтэй бас армид нэгджээ.

Энэрэлт элч (салаллаху алейхи уа сальлам) Медине хотод өөрийг нь орлож намаз (мөргөл) үйлдүүлэх хүнээр гэгээн Сибат томилон үлдээгээд цэрэгээ аван Хайберийн зүг хөдлөв.

Энэ бол Хижретиин (их нүүдэл) 7 дахь жил байлаа. Исламын далбааг гэгээн Али намируулан барина. Баруунжигүүрийн даргаар гэгээн Омар удирдан явна. Зоригт мусульман баатарууд “Аллаху Акбар! Аллаху Акбар!” гэх такбираа нүргүүлэн явна. Хоноглох газар болгонд пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам): “Аллах минь! Буцаж ухархаас, өнгөрсөнд сэтгэл зовохоос, хүчин мөхөсдөн залхуурхаас, харамч сэтгэлээс, аймшиг ба өр зээлээс, догшин хорон муу санаат хүмүүсийн хор уршигаас таньдаа хорогдном!” хэмээн залбирдаг байв. Асхабуудаа: “Бисмиллахир рахманиррахим” гэж хэлээд урагшилцгаа” хэмээв.

Асхабууд урагшилсаар явж хамгийн том хэрэм цайз болох Нататын Өмнө очоод байрлалаа эзэлцгээв. Орой болж байлаа. Мухаммед элчийн зан ёсоор өглөө болтол дайралт хийхгүй, бас юуны түрүүнд ислам шашинд уриалан дуудав.

Өглөөний мөргөлөө үйлдсэнийхээ дараагаар дайралтанд бэлдэж эхлэв. 200 цэрэг, 1400 явган цэрэг жагсан Натат цайзны хаалганы өмнө тулж очив. Энэ үед хонь малаа маллах, тариалангийг ажилаа хийхээр цайзаас гарсан жирийн ард иргэд ислам цэрэгүүд хэдийнээ ирсэн байхыг хараад цочицгоон, буцаж гүйлдэн орцгооно. Тэдний энэ байдалыг харсан Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам): “Аллаху Акбар! Аллаху Акбар! Хайбер дайн болж өнгөрлөө” хэмээн энэ үгээ 3 удаа давтан хэлэв.

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) жүүдүүдэд нэг бол мусульман болох, эсвэл бууж өгцгөөн гувчуур, албан татвар өгөх эс бөгөөс дайтан цус урсгахаа мэдэгдлээ. Энэ саналыг сонссон жүүдүүдийн толгойлогч Селлам: “Би та нарт Мухаммедээс урьтан тэднийг дайлаар мордоё гэж хэлсэн билээ. Та нар хүлээн зөвшөөрөөгүй. Одоо харж байна уу? Тэд биднийг дайрахаар иржээ. Одоо бид байлдацгаая, та нар үхэх хүртэлээ байлдацгаа” хэмээн жүүдүүдээ дайнд уриалав.

Исламын цэрэгийн мусульман болох саналыг жүүдүүд сум харван эсэргүүцэж байгаагаа илэрхийлжээ. Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) зарлиг ёсоор жүүдүүд рүү нэгэн зэрэг харваж эхэлсэнээр дайн эхэлжээ. Исламын цэрэгүүд тэднийг зөв замд оруулахыг уриалсан боловч эс хүлээн зөвшөөрөв. Учир

нь тэд сүүлчийн элч жүүд ард түмэнээс гараагүйд атаархсандаа тэр. Энэ атаархлаасаа болоод элчийг хүүхэд байхаас нь үгүй хийхийг хүсдэг байлаа. Гэхдээ түүнийг Аллах эзэн хамгаалж буйг тэд хэзээ ч ойлгохгүй биз ээ.

1600 мусульман цэргүүд 10 мянга хол давсан жүүд цэрэгтэй дайтан сум харваж байлаа. Нэг удаа Хаббаб бин Мүнзир Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) өмнө ирж: “Амиа таньд өргөө, аяа, Расулуллах! Бид байрлалаа өөрчилвөл болохгүй юу?” гэж асуув. Элч (салаллаху алейхи уа сальлам): “Аллахын тааллаар, орой нар жаргахаар өөрчилье” гэв.

Тэр өдөр шөнө болтол хоёр тал нум сумаар л байлдацгаалаа. Тавиад мусульман цэрэг шархджээ. Орой болоход өөр ашигтай байрлал олохоор Меслемед даалгав. Тэр Режи гэдэг газар мусульмануудын хувьд ашигтай газар байгааг ирж дуулгав. Исламын гол хүч тэр газар луу шилжив.

Маргааш өдөрөөс нь эхлээд Натат цайзны өмнө мусульманууд орой болтол байлдацгаалаа. Жүүдүүд цайз бэхлэлтээсээ гарч байлдсангүй. Гэнэт Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) маш хүчтэй толгойны өвчин тусаж, хоёр хоног цэрэгээ удирдан байлдаж чадсангүй.

Энэ үед зоригжсон жүүдүүд цайзын хаалгаа нээн, гадагш гарч байлдаж эхлэв. Нүүр тулж байлдаж эхэлхэд дайн жинхэнэ утгаараа болов. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам): “Аллаху Акбар! Аллаху Акбар!” гээд уриагаа хэлцгээ” гэж хэлэх тоолонд мусульмануудын уухай тэнгэрт хадаж нүргэлнэ.

Маргааш өдөр нь Хайбер хотын хамгийн агуу баатар болох Мерхаб цэрэгүүдээ дагуулан бэхлэлтээсээ гарлаа. Мерхаб бол лагс биетэй хүчит баатар юм. Энэ өдөрийг хүртэл түүнтэй тэмцэх дайчин олдохгүй байжээ. Тэр мусульман цэрэгүүд рүү хандан: “Би бол аймшиггүй зоригт Мерхаб байна” хэмээн орилов. Тэр ингэж орилож байхад асхабуудын дундаас нэгэн цэрэг урагш сугаран гарах нь харагдав. Тэрээр өмнөөс: “Би аймшигт халз тулаанаас хэзээ ч буцаж байгаагүй Амир байна” хэмээн түүний өмнө очив. Мерхаб “Хэнийг ч цавчинав, алах болно” хэмээн бичигдсэн сэлэмээ далайн Амирыг цавчихад амжиж бамбайгаараа хамгаалахад Амирын бамбай хагаран бутрах нь тэрээ...

Энэ удаа гэгээн Амирын (радиаллаху анх) ээлж байлаа. Тэрээр сэлэмээрээ “Яа, Аллах!” гээд Мерхабын хуягаар бүрхэгдсэн хөлийг нь цавчихад хуяганд хүрсэн сэлэм огт

цавчигдалгүй буцаж ойхдоо Амрын хөлийг нь шархдуулжээ. Энэ шарх нь том судасыг нь тасдаж, цус алдав. Асхабууд Амирыг аван, майхандаа авч ирэхэд маш их цус алдсан гэгээн Амир (радиаллаху анх) төдөлгүй шахид (нас барах) болжээ.

Орой болоход 4000 цэрэгтэйгээр жүүдүүдэд туслахаар ирсэн Гатафануудад Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) дайнд оролцохгүй, нутаг буцахыг санал болгов. Хэрвээ буцвал Хайберийн нэг жил идэх хурма жимсийг өгөхөө амлав. Гэвч Гатафанууд энэ саналыг хүлээн зөвшөөрсөнгүй. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) асхабуудаа Гатафанууд цэрэгүүд байх цайз руу очиж хоноглохыг тушаав. Гатафанууд шөнө мусульмануудын дайралтаас айж унтаж чадсангүй. Тэр орой хаан нэгтэйгээс нэгэн дуу: “Гатафанын нутаг дайнд ялагдсаныг, үр хүүхдүүд нь мал хөрөнгө нь олзлогдсоныг” мэдэгдэн орилоно. Энэ дуу 3 удаа гарсан бөгөөд үүнийг Гатафанууд цөм зүрх даран сонсосгоожээ. Энэ дуунаас айсан Гатафанууд өглөө болохын алдад цэрэгээ аван дайнаас ухарцгаан, нутаг буцжээ.

Гэгээн Алигийн баатарлаг явдал

Тэр өдөр Хайбер дайн хүчтэйгээр өрнөсөн ч цайзыг эзэлж амжсангүй. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам): “Маргааш исламын далбааг би нэг баатарт атгуулах болно. Тэр Аллахын эзэн ба түүнийг элчийг хайралдаг. Аллах ба түүний элч ч тэр баатарыг хайрладаг билээ. Түүний удирдлагаар ялалтыг бид авах болно” хэмээн баярт мэдээг дуулгав. Тэр орой энэ баярт мэдээг дуулсан асхабууд догдлон унтаж чадсангүй. “Далбааг хэнд өгөх бол?!” гэсэн бодолоор өглөөг хүлээв. Үүр хаяархад Билал Хабаши (радиаллаху анх) уянгат хоолойгоороо өглөөний Азан (мөргөлийн дуудалга) дуудав. Хайрт пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) өглөөний мөргөл үйлдсэний дараагаар исламын далбааг авч ирэхийг хүсэв. Ариун исламын далбааг хүндэтгэлтэйгээр авч ирэн элчийн гарт атгуулахад Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам): “Мухаммедыг элч болгон гийгүүлсэн Аллахын нэрээр тангараглъя. Би энэ далбааг айхыг үл мэдэх хүнд өгнө” хэмээгээд асхабуудыг тойруулж харсанаа “Али хаана байна?” гэж асуув. Асхабууд: “Аяа, Расулуллах! Түүний нүд нь өвдөж байна” гэцгээхэд элч (салаллаху алейхи уа сальлам) “Түүнийг дууд” гэв. Тэр өдөрүүдэд гэгээн Алигийн

нүд нь өвдөж нүдээ нээж чадахгүй болсон байлаа. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) Алигийн нүд илааршихийн төлөө Аллах эзэндээ залбирав. Өөрийн гараа шүлсдээд, Алигийн нүдийг арчив. Тэр үед Алигийн нүдний өвчин алга болж, нүдээ нээв. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам): “Аяа, Эзэн минь! Хүйтэн ба халууны зовлонг Алигаас ав” хэмээн залбирав. Дараагаар нь гэгээн Алид хуягийг нь өөрөө өмсгөж өгөөд, бүсэнд нь өөрийн сэлэмээ бүслүүлэв. Гарт нь цав цагаан исламын далбааг бариулан “Аллах эзэн чамд ялалтыг өгөх хүртэл байлд, хойшоо битгий ухар” гэв.

Гэгээн Али (радиаллаху анх) “Амиа чамд өргөө, аяа, пайгамбар минь! Энэ далбаатайгаар исламын шашин дэлгэрэн түгэх болтол байлдана” хэмээгээд далбааг барин жүүдүүдийн бэхлэлт рүү урагшилан довтолоход асхабуудад ч араас нь дагав. Натат хэрэмийн хаалга онгойн жүүдүүд байлдахаар гарч ирцгээв. Эд нар Хайберийн хамгийн шилмэл дайчид юм. Тэд нар цөм хоёр давхар хуяг өмсжээ. Эд нар баатар Мерхабын дүү зоригт дайчин Харисаар удирдуулжээ. Харис огцом довтлон дайрахад түүний хоёр давхар хуяг хавьрах дуу чимээ нь нүргэлэн сүртэй ажээ. Али дайралтийг эсэргүүцэн маш хурдан шаламгайгаар түүнийг цавчин толгойг нь тасдав. Энэ үйл явдалыг харсан мусульманууд зоригжин “Аллаху Акбар! Аллаху Акбар!” гэх уриагаар тэнгэрийг нүргэлүүлнэ.

Хайрт дүүгээ үхсэнийг сонссон Мерхаб маш их уурлах нь арслангийн архирлттай адил ажгуу. Мерхаб дайны талбар луу гүйн орж ирж зөвхөн дүүг нь алсан Алиг улангасан бух мэт нааш цааш холхино. Тэр бас хоёр давхар хуяг өмсөн хоёр сэлэм барьжээ. “Би дайнд хэний ч өмнө ялагдаж үзээгүй зоригт баатар Мерхаб байна! Надтай арслан тулалдахаас ч эмээнэ” хэмээн орилов.

Гэгээн Али (радиаллаху анх) “Надад эцэг эх минь Хайдер (арслан) нэр өгсөн билээ. Би аймшиггүй нэгэн арслан шиг билээ! Чамайг ганцхан дайралтаар газар хэвтүүлэх залуу би байна” хэмээн өмнө нь очиж зогсов. Мерхаб Алигээс Хайдер (арслан) гэх үгийг нь сонсоод жаахан эмээв. Учир нь тэр шөнө зүүдэндээ нэгэн арслан түүнийг идэж байна гэж зүүдэлжээ. Тэр зүүдэн дэхь арслан энэ болов уу? гэж бодож ч амжаагүй байхад Али маш хурдтай хөдлөж зүлкифер сэлэмээрээ түүнийг цавчив. Мерхаб амжиж бамбайгаараа хамгаалсан боловч түүний сэлэм төмөр

бамбайг нь хоёр зүсэгдэн өнгөрч дуулагыг нь ч зүсэн толгой нь оройноосоо эрүү хүртэл хоёр хуваагдав. Энэ үйл явдалыг харсан бүх хүн гайхан зогсож орилов.

Аллахын элч (салаллаху алейхи уа сальлам) баярлан: “Хайберийн ялалт ирж байна” хэмээв. Зоригт асхабууд гэгээн Алигийн энэ зоригийг хараад гайхацгаана. Дайн маш ширүүнээр үргэлжилж мусульманууд урагшилсаар цайзны хаалганы өмнө иржээ. Нэг жүүд Алигийн бамбайг цохин унгаалаа. Бамбайгаа барьж авах цаг завдал байгаагүй болохоор Али тулаанаа бамбайгүйгээр үргэлжлүүлнэ. Нөгөө жүүд боломжийг ашиглан Алигийн газар унасан бамбайг аваад цайз руу зугтаан одов. Али бамбайгүй үлдсэндээ шаралхан цайзын хаалгаар бамбай хийе гэж бодов. “Бисмиллахиррахманниррахим” гэж хэлээд цайзын том төмөр хаалгыг барин, нугаснаас нь хуу татаж авав. 10 бөх өргөөд үл хөдөлгөж дийлэх энэ том хаалгыг ганц гараараа хуу татан бамбай болгоод дайрч эхлэв. Түүний өмнө жүүдийн 6 том бөх залуу жагсан гарч ирцгээв. Тэд нарыг нүд ирмэхийн зуур газар нялж орхисон гэгээн Али цэрэгүүдийг алан цайзны дотогш нэвтрэв. Исламын далбаагаа цайзны дотор байрлуулан мандуулсанаар жүүдүүдийн хамгийн том цайз болох Натат мусульмануудых болов.

Хайрт пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) гэгээн Алигийн нүдийг үнсээд “Чиний гаргасан зоригийг хараад Аллах эзэн, түүний элч хоёр баярлалаа” гэв. Энэ үгийг сонсох Али (радиаллаху анх) баярласандаа уйлав. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) “Чи ягаад уйлав?” гэж асуухад “Амиа чамд өргье, Расулуллах! Баярласандаа уйлж байна. Аллах бас түүний элч надад талархсан болохоор” гэв. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам): “Зөвхөн бид биш ээ. Жабрайл, Микайл ба бүх мелекүүд (сахиусан тэнгэр) (aleyхимуссальлам) ч баярлаж байна” хэмээв.

Энэ үед Дэвс овгийн 400 цэрэг Мухаммед элчид (салаллаху алейхи уа сальлам) туслахаар ирэв. Ингээд бусад үлдсэн 7 цайз бэхлэлтийг дайтаж нэг нэгээр нь буулган авцгаав. Дайнд ялагдал хүлээсэн жүүдүүд Мухаммед элч рүү хэсэг төлөөлөчидөө илгээж найрамдахыг хүсэв.

Энэ саналыг хүлээн аваад ийм хэдэн болзолтойгоор гэрээ хийв.

1- Энэ дайнд мусульмануудтай дайтан амьд үлдсэн

жүүдүүийг алахгүй.

2- Хайбер хотыг орхин гарах жүүдүүд зөвхөн хүүхдүүдээ бас цуг нэг тэмээ ачаагаа аваад гарна.

3- Үндсэн эд хөрөнгө, хуяг дуулга, сэлэм, зэр зэвсэг, өөрсдийнх нь өмссөн хувцаснаас бусад бүх хувцас, даавуу, торго дурдан, алт эрдэнэс, хонь үхэр тэмээ гэх мэт малууд цөм мусульмануудад үлдэх болно.

4- Мусульмануудад үлдэх зүйлсээс ямар нэгэн зүйл нуухгүй байх. Ингэж нууж орхисон бол Аллах ба түүний элчийн энэрэлээс алдагдах болно.

Энэ болзолыг үл биелүүлэн алт эрдэнэсээ тулманд хийгээд газар булсан жүүд Кинанэ бин Реби шийтгэгдэн толгойгоо авхуулав. Хайберийн арвин шимт газар нь цөм исламынх болжээ.

Хайбер олзлогсодоос баригдсан хүмүүсийн дунд Хувей бин Ахтабын охин Сафие байлаа. Цэрэгийн даргын охиныг Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) энэрэн олзлогсодоос суллажээ. Энэ их энэрэл өршөөлийг үзсэн Сафие Исламын шударга ёсыг бодон үнэн сэтгэлээсээ Келиме-и шахадетийг (гэрчлэл үг) хэлэн мусульман болжээ. Энэ явдалд маш их баярласан пайгамбар маань түүнийг удаах гэргийгээ болгон Никах (гэрлэх ёсон) үйлджээ.

Хайбер дайнд ялагдал хүлээсэн жүүдүүд элчид (салаллаху алейхи уа сальлам) бараалхан “Аяа, Мухаммед! Бид Хайберээс явцгаах болно. Гэхдээ бид тариа ногоо тарих, газар тариаланг сайн мэддэг хүмүүс билээ. Чи бидэнд энэ үржил шимт газараа хөлслүүл, бид энд тариа тарьж амьдаръя. Харин хөлс болгон хураасан тариа ногооныхоо талыг нь чамд өгч байя” гэсэн санал тавив. Энэ саналыг Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) баярлан хүлээж авав. Учир нь мусульмануудад тариа ногоо тарьж байх зав байхгүй билээ. Тэгээд ч жүүдүүдийг хөөн гаргавал мусульмануудаас холдон одох болно. Тэд ойр байх тусам исламд орох магадлал их байсан болохоор: “Гэхдээ та нарыг хүссэн үедээ нутгаас гаргаж болох болзолтойгоор зөвшөөрөө” гэхэд жүүдүүд зөвшөөрөв.

Ялалт байгуулсан мусульман цэрэгүүд Медине рүү буцацгаав. Энэ үед урьд нь Хабешстан (Етёп) руу явуулсан асхабуудыг толгойлсон Жафер бин Эбу Талиб тэргүүтэй мусульманууд Мединед нүүн ирсэн байлаа. Мухаммед элч

(салаллаху алейхи уа сальлам) Жаферийг тэврэн аваад, “Би Хайверийг эзэлсэндээ баярлах уу, Жаферийг ирсэнд баярлах уу, сайн мэдэхгүй байна. Та нар хоёр удаа Хижрет (их нүүдэл) хийлээ. Хабеш (Етён) руу бас миний нутаг (Медине) руу нүүлээ” хэмээжээ.

Ийнхүү Хайберийн ялалт Арабд байх бүхий л жүүдүүдийг айлган сүрдүүлжээ. Үүнээс хойш тэд мүшрикүүдэд туслах бодол үгүй болсон нь лавтай. Ийнхүү хажуу хавийн улс орон ислам улсаас айж, хүлээн зөвшөөрөх эхлэл тавигдсан билээ. Энэ ялалтаас хойш том жижиг маш олон отог аймаг мусульман болохын тулд Медине хотод ирцгээн асхаб гэх тэр ариун алдарын эзэн болцгоов. Гатафан овгийнхон ч бас ирэв.

УМРЕТ-ҮЛ КАЗА АЯН

Худейбиед хийсэн гэрээ хэлэлцээрээс хойш даруй нэг жил өнгөрчээ. Курбан (тахилийн баяр) баяр болохоос нэг сарын өмнө Аллахын элч (салаллаху алейхи уа сальлам) бүх мусульмануудад Умре (Каабыг тойрон мөргөх ёсон, бага хаж) хийхээр явах аян замд бэлэн болцгоо гэв. Өнгөрсөн жилд Умре хийхээр Худейбиед очоод замын голоос гэрээ хэлэлцээр хийгээд буцсан бүх мусульманууд явах ёстой байв. Тахил өргөх 70 тэмээ авав. Эд нарыг Мекке хотод хариулахаар туун очих Нажие бин Жүндүбийн хамт 4 тууварчин бэлдэв. Бас Мухаммед бин Меслемегээр толгойлуулсан 100 тагнуулыг дайны зэвсэг болох сэлэм, жад, нум сум, хуяг дуулга гэх мэт зүйлийг тэмээнд ачаад урьтаж явуулав. Мүшрикүүдэд итгэхэд бэрх байлаа. Асхабууд: “Аяа, Расулуллах, гэрээ ёсоор бол Умред ирэгсэд зөвхөн чинжаал хутагнаасаа өөр зэвсэггүй байх биш билүү?” гэж асуухад Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам): “Энэ зэвсэгүүдийг аваад бид Меккед орохгүй. Зөвхөн ямар нэгэн санаанд оромгүй эвдрэлцэл, дайн болох үед энэ зэвсэг Мекегийн хажууд бэлэн байх ёстой” гэв.

Медине Мүнавверед орлогчоо болгон Эбү Зерр-ил Гифариг томилон үлдээв. 2000 асхаб Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) хамтаар Мекке рүү хөдлөв. Асхабууд маш их догдолцгооно. Учир нь өөрийн нутаг Мекке рүү бас Аллахын ариун сүм Кааб руу явж байгаа юм.

Мединед үлдэгсэд Мухаммед элч (салаллаху алейхи уа

сальлам) ба асхабуудыг (радиаллаху анхум) аян замд нь үдэн гаргаж өгцгөөв.

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) ба асхабууд Мединегээс 80км холдонгуудаа Зүл Хулейфа гэх газар Ихрамаа (мөргөлийн хувцас) өмсөцгөөлөө. Бүх хүмүүс цав цагаан хувцасаа өмсөцгөөн Умрегийн (хаж) төлөө сэтгэл зүрхээ чиглүүлэн Мекке хотын зүг баяр жаргалтайгаар хөдөлцгөөв. Тэд “Леббейк! Аллахумма Леббейк! Лаа шарийка лака леббейк! Иннал хамда вен-нигмете лекэ вэл-мүлк, лаа шарийка лек!” хэмээн хаж мөргөлийн уриа болсон залбиралыг нүргэлүүлэн хэлцгээнэ. Аян зам нь маш тайван жаргалтайгаар өнгөрнө.

Мухаммед бин Меслемегээр удирдуулсан 100 хүнтэй исламын тагнуулчид мүшрикүүдэд үзэгджээ. «Тэд гэрээ ёсоор болж байна. Мухаммед ба мусульманууд маргааш гэхэд энд ирнэ» гэж мүшрикүүдэд хэлэхэд мүшрикүүд элчтэй (салаллаху алейхи уа сальлам) ярилцахаар хэсэг элч төлөөлөгчидөө мусульманууд руу илгээжээ.

Энэ үед мусульман мөргөлчид яван явсаар Мекке хотыг харж чадахуйц ойртож Батин-и Емен гэх газар ирж буудалсан байлаа. Бүх зэр зэвсэгээ энд үлдээж зэвсэгийн харуулдах 200 харуул үлдээжээ.

Энэ бэлтгэл ажил дууссаны дараагаар Курейшээс илгээсэн элч төлөөлөгчид Мухаммед элчтэй (салаллаху алейхи уа сальлам) уулзахаар иржээ. Тэд: “Аяа Мухаммед! Худейбие гэрээ хэлэлцээрээс өдийг хүртэл бид гэрээг эвдэх, эсвэл амлалтаа цуцлуулах ямар нэгэн зүйл хийгээгүй юм. Чи дайнд ирж буй мэт энэ зэр зэвсэгээ авч ирсэний учир юу вэ?” гэж асуув. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам): “Би бага байхаасаа л эхлэн хэлсэн амлалтандаа хүрдэг хүн гэж танигдсан нэгэн. Кааб руу орохдоо зөвхөн чинжаал хутагтайгаа л орох болно. Гэхдээ зэр зэвсэгээ надад бас ойр байхыг хүсэж байна” гэв. Элч төлөөлөгчид тэд дайтахаар ирээгүйг мэдээд тайвширцаав. “Тийм ээ, Мухаммед! Бид чамайг үргэлж шударга, хэлсэн үгэндээ хүрдэгийг чинь гарцаагүй мэддэг билээ!” гэж хэлээд буцацгаав. Меккед ирээд болсон явдалыг курейшийнханд хэлэхэд тэд ч тайвширцаав.

Курейшаас өшөө авахыг хүсэгч хэсэг хүн Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) ба мусульмануудын энэ баяр жаргалтай хоромыг харахгүйн тулд ууланд гарцгаав.

Хайрт пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) бэлтгэлээ хангаж дуусаад тахилийн тэмээнүүдээ урагш туулгаад, өөрөө Мекке хот руу орохоор хөдөлцгөөв. Хорвоогийн энэрэл болсон элч (салаллаху алейхи уа сальлам) Кусва тэмээндээ суун асхабуудынхаа дунд урагшилсаар “Леббейк! Аллахумме леббейк!..” хэмээн уриалан залбирах мусульмануудын дуу зүрхийг догдлуулан баярын нулимс унагана. Тэд ийн явсаар Меккед орж очиход мусульмануудийн энэ итгэлт байдал, туяа цацарсан жавхлант царайг нь харсан мүшрикүүдийн зүрхэнд уярал хайр дүрэлзэн өөрийн эрхгүй исламын сайханд атаархан хайлна. Ийнхүү эцсийн эцэст Мухаммед (салаллаху алейхи уа сальлам) ялжээ.

Ингээд Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) ба түүний итгэлт асхабууд Кааб руу очив. Элчийн тэмээ Кусвагийн бурантагийг Абдуллах бин Реваха барин урагш хөтлөнө. Меккегийн хэсэг мүшрикүүд ба эмс, хүүхдүүд Дар-үн Недве гэх газар нуугдацгаан мусульмануудын хийж буй мөргөлийг ажиглана.

Хайрт пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) Аллахын гэр (Кааб) лүү ойртон орохдоо баруун мөрөө ил гаргав. Гэгээн нүднээсээ баярын нулимс бөмбөрүүлэн байж “Өнөөдөр энэ нүгэлт хүмүүст өөрсдийгөө хүчтэй бас батарлагаар харуулах энэ залууст (асхаб) Аллах минь хайр ивээл үзүүлэг” хэмээн залбирав. Асхабуудтайгаа сүр жавхлантайгаар хурдан хурдан алхсаар Ариун Каабыг 3 удаа тойрч залбирав. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) ба асхабууд Хажер-үл Эсвадыг (хар чулууг) үнсэцгээлээ. Гараа өргөцгөөнө Хажер-үл Эсвадад мэндлэнэ.

Үлдсэн 4 тавафыг (тойрон мөргөх) удаанаар бас тогтуун явдалаар явсаар дуусгав. Ингээд таваф (7 удаа тойрч залбирах) дууссаны дараагаар Макем-и Ибрахимд зогсон 2 рекать (үе) мөргөл үйлдэцгээв. Дараагаар нь Сафа ба Мерва нэртэй хоёр толгодын хооронд 7 удаа сай (гүйх) хийгээд, дараагаар нь тахилаа өргөн малаа хэрчсэнийхээ дараагаар Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) өөрийн үсээ авхуулсанаар бүх Асхабууд үсээ авхуулав. Ийхүү Мухаммед элчийн 1 жилийн өмнө зүүдэлсэн зүүд нь биелэгдэв. Умре (хаж мөргөл) дуусан, үдийн мөргөлийн цаг болсон байлаа. Аллахын элч гэгээн Билал Хабашид Азан уншихыг тушаав. Билал (радиаллаху анх) ч босон

эхэлхэд Мекке хот чичирхийлэн хөдлөхөд, асхабууд харин Азаны үгийг дотороо давтан хэлцгээнэ. Азаны дараа Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) имам (урьдатгал хамба) болон цөмөөрөө үдийн намазыг (мөргөл) үйлдэхэд энэ үзэгдлийг харж зогсох мүшрикүүдийн зүрхэн дэхь мэдрэмж нэг л өөр болжээ.

Мусульманууд Каабын ойролцоо майхан босгожээ. Мөргөлийн цаг болоход цөмөөрөө цуглан Каабын өмнө мөргөлөө үйлдэнэ. Бусад үед нь асхабууд Мекке дэхь хамаатан саданууддаа очицгооно. Исламын ариун шашинаа номлон тэндээс олсон эелдэг ааш соёлоороо гайхуулахад бүдүүлэг мүшрикүүд уяран хайлж байлаа. Тэд 3 хоног Меккед хоноглов. Ийнхүү Мекке хот чимээгүй ялагдлаа хүлээсэн мэт болжээ.

Ингээд 3 хоногийн дараагаар мусульмануудын буцах цаг нь болжээ. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) “(Умре хийхээр ирсэн) мусульмануудын хэн нь ч энэ шөнийг Меккед өнгөрөөхгүй, замд гарцгаах болно!” хэмээн хэлээд цөм Медине рүү баяр жаргалтайгаар буцацаав.

МУТЕ ДАЙН

Хорвоод энэрэл болон илгээгдсэн хайрт элч (салаллаху алейхи уа сальлам) асхабуудаа Велид бин Велидэд: “Халид хаана байна? Түүн шиг нэг хүнд исламыг танихгүй, мэдэхгүй байх нь үл зохино. Тэр бүхий л сэтгэл зүрх хүчээрээ мусульмануудын хажууд байж, мүшрикүүдтэй тэмцэлдсэнсэн бол юутай их сайн бэ? Түүнийг хайрлаж, хүндлэх байлаа” хэмээжээ. Велид бин Велид (радиаллаху анх) урьд өмнө ах Халидад дандаа захиа бичиж исламд итгэн сүсэглэхийг уриалдаг байсан болохоор элчийн (салаллаху алейхи уа сальлам) хэлсэн энэ үгийг удаа бичиж захиандаа илгээхэд Ахынх нь (Халидийн) исламыг гэх сэтгэл өдөр ирэх тусам татагдан байж сууж чадахаа больж, хурдхан л гэгээн элчтэй уулзан, исламд орохыг мөрөөдөж байлаа. Тэрээр исламын эсрэг болж байсан бүх дайнд оролцдог байжээ.

Велид бин Велид дүүгийнхэн захиа ийм байлаа: “Бисмил лахиррахманниррахим! Аллах тэнгэртээ баярлан, элчдээ мэнд, жаргал хүссэнийхээ дараагаар: Ах минь! Үнэндээ би чамайг Исламаас нүүр буруулан явах шиг гайхмаар зүйл үгүйг ойлгож байна. Чи одоогийн мухар сүсэгээ худал нэг зүйл гэдэгийг мэдэх хэмжээний ухаантай хүн шүү дээ. Ягаад толгойгоо ажиллуулахгүй

байгаа юм бэ? Исламын шашин шиг ариун шашиныг мэдэж ойлгохгүй байх нь ямар эмгэнэлтэй юм бэ? Пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) надаас чамайг асуулаа. Чамайг ислам шашинд орж хөдөлмөр ба баатар зоригоо мусульмануудын дунд, мүшрикүүдийн эсрэг хэрэглэхийг чинь хүсэж байна. Ах минь! Битгий их хожигд, хурдхан мусульман бол!" хэмээжээ.

Ийнхүү тэр өгүүлэхдээ. "Бидүүгийнхээ захиаг аваад исламд орж мусульман болохыг эрмэлзэж эхлэх боллоо. Медине рүү явахад маш их яарч байна. Мухаммед элчийн хэлсэн үг намайг баярлуулан, исламыг гэх сэтгэлийн галыг минь бадраасан юм.

Би Мухаммед элч рүү явахаар зэхэж байхдаа "Тэнд очиход минь замд хэн надад хань болж чадах юм бол" гэж бодон Осман бин Талхагийн гэрт очин, "Надтай хамт Мединед очиж мусульман болооч" гэж санал тавихад тэрээр зөвшөөрөв. Маргааш өглөө нь бид хоёр замд гарч Хадде гэх газар ирэхэд Амр бин Астай тааралдав. Тэр ч бас мусульман болохоор Медине рүү явж байлаа.

Бид гурав Мединед очицгоолоо. Хамгийн гоё хувцасаа өмсөн Мухаммед элчтэй (салаллаху алейхи уа сальлам) уулзахаар зэхэцгээж эхэллээ. Энэ үед Велид дүү маань ирж: "Хурдал, Мухаммед элчид таныг ирсэн талаар мэдээ очсон байна. Тэрээр маш их баярлаж байна. Одоо хүлээж байна" гэлээ. Би ч хурдхан шиг тэр агуу элчийн өмнө бараалхлаа. Тэр инээмсэглэн намайг угтаж аваад мэндлэв. Би: "Аллах эзэнээс өөр бурхан байхгүй, бас чамайг Аллахын илгээсэн элч болохыг гэрчилнэм" гэж хэлэхэд: "Чамайг зөв замд оруулсан Аллах Теаалад баярлалаа" гэв. Дараагаар нь нүгэлийг маань наминчлахын тулд залбираач гэж гуйлаа. Элч (салаллаху алейхи уа сальлам) миний төлөө залбирав. Дараа нь "Исламд шинээр элссэн хүний өмнөх үйлдсэн бүх нүгэлүүд нь наминчлагддаг" хэмээн айлдсан юм. Нөгөө хоёр хүн маань мусульман болсон юм.

Хижретийн 8 дахь жилд хорвоогийн энэрэлт элч (салаллаху алейхи уа сальлам) ислам шашинаа түгээхийн төлөө боломжтой гэх бүх зүйлийг хийж байлаа. Хажуу хавийн отог аймаг, улс орнууд луу элч төлөөлөгчидөө илгээн исламд дуудаж байлаа. Нэг удаа Бурса хотын амбан захирагч руу илгээсэн элч Харис бин Умейрыг Шам хотын Муте гэх тосгонд христийн цэргүүд барьж авч гянданд хорьж амийг хөнөөжээ. Энэ мэдээг дуулаад пайгамбар маань маш их гомдон асхабууддаа дайнд бэлдэхийг хүсэв. Энэ мэдээг

сонссон баатарлаг мусульман цэрэгүүд дайнд бэлэн болоход Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) үдийн мөргөлөө үйлдсэнийхээ дараагаар: “Дайнд мордох цэргүүдийн даргаар Зейд бин Харисег томиллоо! Зейд бин Харисе нас барвал оронд нь Жафер бин Эбү Талиб болог, Жафер бин Эби Талиб шахид болвол, Абдуллах бин Реваха оронд нь болог, Абдуллах бин Реваха нас барвал, мусульманууд өөрсдөө зөвлөлдөөд хэн нэгнийг даргаараа томилцгоо!” Энэ нэр дурьдагдсан асхабууд нас барах юм байна гэж бодсон асхабууд уйлж: “Аяа, Расулуллах! Тэд амьд үлдээд бидэнд зааж сургасансан бол?” гэж хэлцгээхэд элч юу ч дуугарсангүй.

Энэ үгийг сонссон Зейд, Жафер, Абдуллах нар (радиаллаху анхум) баярлаж байв. Учир нь Аллахын шашиныг түгээхийн төлөө тэмцэж бүгд шахид (амиа өргөх) болох нь тэдний хамгийн том хүсэл зорилго байлаа. Дайчид бэлэн болцгоон даргаа хүлээн зогсоцгооно. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) исламын цагаан далбааг Зейд бин Харисийн гарт атгуулан түүнд Харис бин Умейрийн алагдсан газар хүртэл очин исламыг уриалан зарлахыг захив. Хэрвээ тэд хүлээн зөвшөөрөхгүй бол байлдахыг тушаав.

3000 цэрэг бүхий исламын арми “Аллаху Акбар! Аллаху Акбар!” хэмээн уриалан Мединегээс замд гарлаа. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) дайчиддаа хандан: “Би та нарт Аллах эзэний зарлигийг биелүүлэн, түүний хориглосон цээрлэсэн бүхнээс зугтаан, хажуудаа байгаа мусульмануудтайгаа сайхан харьцахыг захираар байна. Аллахын ариун замд түүний алдарыг дуудан байлдацгаа. Хүүхдүүдийг битгий хорооцгоо, та нар тэнд христүүдийн сүмээс холдон, өөрсдийн бодол сэтгэлээрээ мөргөж буй хүмүүстэй таарцгаах болно. Тийм хүмүүсийг тайван орхицгоо. Та нар эмэгтэйчүүдийг, хөгшидийг бас тахир дутуу хүмүүсийг битгий алцгаа. Модыг битгий шатаа, битгий тайр, гэр байшинг битгий нураацгаа”

Цэргийн удирдагч Зейд бин Харисед: “Мүшрикүүдтэй, дайсантайгаа уулзах үедээ тэднийг 3 зүйлд уриалан дууд. (Хэрвээ тэд мусульман болох юм бол) тэднийг мухажируудын гэр болох Мединед нүүж ирэхийг хүс. Тэд энэ урилгийг хүлээн зөвшөөрвөл мухажируудын эдэлсэн эрхийг тэд нар ч бас эдлэх болно. Тэд мусульман болоод өөрийн төрөлх нутагтаа амьдрахыг хүсвэл нүүдэлчин Араб мусульманууд шиг болохыг, дайны олз омогоос

юу ч хүртэхгүй, бас дайны олз омогийг зөвхөн дайнд оролцсон мусульманууд хоорондоо хувааж авахыг мэдэгд.

Хэрвээ исламыг хүлээн зөвшөөрөхгүй бол тэднээс алба татвар өгөхийг хүс, энэнийг хүлээн зөвшөөрөгсөдөд битгий хүр! Албан татвар өгөхгүй гэгсэдтэй дайт” хэмээн хичээнгүйлэн захив.

Асхабууд Шам хотын нутаг дэвсгэрт орж ирэхэд Ромын 100 мянган цэрэг дайтахаар өөдөөс нь ирж явааг дуулав. Тэд Муана гэх газар 2 хоног саатав. Цэргийн захирагч Зейд бин Харисе мэдээг цэрэгүүдэдээ хэлээд дайсануудтайгаа хэрхэн яаж байлдах талаар зөвлөлдөв. Тэд: “Аллахын элчид захиа бичин дайсаны цэрэг хичнээн их болохыг мэдэгдэе, элч бидэнд нэмэлт хүч явуулаг, бас хэрхэн байлдахыг маань зааж өгөг” гэгцгээв. Энэ саналыг зөв гэж хүлээн зөвшөөрөх үед Абдуллах бин Реваха “Чин үнэн шашин ба шударга ёсныхоо төлөө үхэх хүртэл байлдана. Хэрвээ үхэл дайнд ирэхийн цагт зөв замд үхсэндээ харамсахгүй бол шахид болон, Аллахын диваажинд заларна. Үхэх хүртэлээ тулалдцгаая” хэмээн уриалсан шүлэг хэлэхэд бүх мусульманууд зоригжин Ревахагийн (радиаллаху анх) саналын зөвшөөрөн “Тийм ээ, хэзээ ч ухрахгүй, үхэх хүртэлээ тулалдцгаая” хэмээн шийдэв.

Исламын арми Муте гэх тосгонд ирцгээхэд Ромын 100 мянган цэрэгтэй нүүр тулав. Нэгэн том тал дайсаны цэрэгээр хучигджээ. Мусульман цэрэгүүд 3000 юм. Энэ дайнд нэг мусульман 30 дайсантай тулалдах хэрэгтэй болж байлаа.

Хоёр тал байлдаанд цэрэгээ жагсаан байрлалаа аван бэлдэж байх үед Аллахын элчийн захисан ёсоор юун түрүүнд исламд уриалан дуудахаар хэсэг төлөөлөгчид Ромын цэрэг лүү очив. Элч төлөөлөгчид Ромын цэрэгийн захирагчтай уулзан ислам шашинд орцгоохыг нь санал болгов. Эс бөгөөс мусульмануудад бууж өгөн, албан татвар өгөхийг тушаав. Ромынхон энэ тушаалыг хүлээн зөвшөөрөхгүйгээр барахгүй мусульмануудыг доромжлон тохуурхав. Ингээд цаг алдалгүй дайтах болсоныг ойлгосон толгойлогч Зейд бин Харисе цэрэгүүддээ дайрах тушаал өгөв. Энэ тушаалыг амьсгаа даран хүлээж байсан исламын цэрэгүүд “Аллаху Акбар!” гэгцгээн урагш ухас хийв. Тэд аянга мэт сэлэмээ сугалан, үер мэт дайсаны цэрэгүүд рүү дайрцгаав. Морьд янзгаах, Аллаху Акбар гэж уриалах, шархагсадын ёоолох, цавчилдах сэлэмийн нүргэлсэн чимээ тэнгэр хорвоог чичирхийлүүлнэ. Дайн

эхлээд удаагүй байхад талбар цусан далай болжээ.

Гартаа исламын цагаан далбааг барьсан Зейд бин Харисе дайсаны дунд “Аллах, Аллах” хэмээн баруун зүүнгүй цавчин ганцаараа 30аад дайсаныг газар нялж хаяна. Байлдах захирагчаа харсан мусульманууд улам их урамшин байлдацгаана. Гэв гэнэт Зейдийн цээжинд хэсэг жад хатгагдахад Зейд газар унахгүй тогтохыг хичээн тугаараа түшин зогсов. Ийнхүү Зейд (радиаллаху анх) шахид болох хүсэлдээ хүржээ.

Зейд бин Харисег харж байсан Жафер гүйн очоод тугыг газар унагалгүй шүүрэн аваад намируулж эхлэв. Далбаагаа намирч байгааг харсан мусульман цэрэгүүд ахин дайндаа улайран орцгоов. Гэгээн Жафер (радиаллаху анх) ч Зейд шиг баатарлагаар тэмцэлдэнэ. Дайсантайгаа байлдахын зэрэгцээ цэргүүдээ удирдан, тэдэнд сэтгэлийн хүч өгөн “Аллаху Акбар!” хэмээн орилно. Жафер байлдсаар байгаад өөрийн мэдэлгүй цэргүүдээсээ холдсон байлаа. Зөвхөн ганцаараа дайсануудынхаа дунд тулалдаж байлаа. Түүнд буцах зам үгүйг ойлгосон Жафер: “Надад ойртсон кафируудыг цөмийг нь цавчина” гэж хэлнэ. Нэг кафир Жаферийн гарыг нь тас цавчихад Жафер далбаагаа унагалгүй зүүн гараараа барин намируулав. Энэ үед бас нэгэн сэлэм зүүн гарыг нь цавчив. Энэ удаа ч далбааг унагалгүй тасарсан мухар гараараа барин намируулав. Гэвч бороо мэт асгарах дайсаны сэлэм Жаферийг сүлбэхэд түүний хүсэн хүлээсэн шахид (Аллахын төлөө амиа алдах) болох цаг нь ирэв. Түүний биед ерээс илүүтэйгээр сэлэм ба жадны шарх сүлбэжээ.

Даргаа шахид болохыг харсан дайчид гүйн очоод исламын далбааг аван Абдуллах бин Ревахад (радиаллаху анх) аваачиж өгөв. Тэр ч мөн адил хэн хүнээс ч дутахааргүй баатарлагаар тулалдана.

Ийнхүү тулалдаж байхад нэг кафирын цавчилт Абдуллахын хурууг цавчихад Абдуллахын хуруунууд нь арьсандаа зүүгдэн санчигнаж байв. Абдуллах хуруугаа хөлөндөө гишгэн: “Чи зүгээр л нэг шархдасан хуруу, Аллахын ариун замын төлөө таслагджээ” гэж хэлээд тас татан хаяв. Абдуллахын тулалдах нь улам их ширүүсч, урдаа таарсан хэн бугайг ч цавчин хаяж байлаа. Гэв гэнэт тэрний цээжинд дайсаны жад зоогдон газар унав. Ингээд Абдуллах (радиаллаху анх) Аллахын ариун шашины төлөө амиа өргөн шахид болж, диваажин руу нисэв.

Тэр үед Абдуллахын хажууд мөр зэрэгцэн тулалдаж байсан

Эбү-л Юсуф Кааб бин Умейр исламын далбааг барин намиргав.

Тэрээр асхабууд дотор нүдээ нүүлгэн өөрөөсөө арай хөгшин, удирдаж чадах хэн нэгэнийг хайж эхлэв. Тэнд Сабит бин Эркэмын тулалдаж буйг хараад далбааг түүнд аваачиж өгөв. Сабит (радиаллаху анх) “Одоо нэг хүнийг толгойлогчоор сонгоё” гэхэд асхабууд “Чамайг сонголоо” гэгцгээв. Сабит энэ саналыг хүлээн зөвшөөрсөнгүй гэгээн Халид бин Велид рүү харан “Хөөе, Эбү Сүлейман, далбааг чи ав” гэв. Дөнгөж мусульман болсон Халид далбааг авахаас айж байлаа. Учир нь өөрийгөө далбааг барихад зохистой хүн гэж бодохгүй байлаа. Сабит ахин: “Халид, дүү минь! Энэ далбааг би чамд бариулахаар, чамайг даргаар сонгохоор авсан билээ! Биднийг удирд, учир нь чи дайтахдаа сайн” гэв. Бүх мусульманууд нэгэн дуугаар “Халид дүү минь! чамайг даргаар томилож байна, биднийг удирд” гэгцгээв.

Ингээд Халид Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) ариун далбааг хүндэтгэлтэйгээр аваад үнсэв. Мориндоо мордоод бүхий л хүчээрээ дайсан руу орилож дайрав.

Дайчин мусульманууд ахин шинэ хүчээр дайсан руу дайран оров. Гэгээн Халид урьд өмнө байгаагүйгээр улайран хүчирхэгжиж дайрч байлаа. Орой болоод нар жаргахад харанхуйд дайнаа үргэлжлүүлэх хэцүү болсон байлаа. Учир нь шөнө өөрийн дайчинаа андуурах аюултай болохоор дайнаа зогсооцгоов.

Тийм болохоор хоёр талын цэрэгүүд нуувчиндаа бууцацгаалаа. Шархагдаа эмчилцгээж байлаа. Гэгээн Халид дайны ухаанд мэргэн, туршилгатай нэгэн билээ. Өглөө нь дайсанууд руугаа өөр шинэ хувилбараар, өөр байрлалаар тулалдан, дайсануудаа гайхшируулмаар санагдаж байлаа. Тиймээс цэргүүдийнхээ байрлалыг солив. Баруун талынхыг зүүн жигүүрээр, зүүн жигүүрээ баруун жигүүрийн цэрэгээр сольж урд байлдагсадыг хойноо, хойно байлдагсадыг урд гаргав.

Өглөө нь дайчид ахиад л шинэ хүчээр “Аллаху Акбар” хэмээн дайрцгаалаа. Дайсанууд өглөө шинэ цэрэгүүдтэй байлдаж байгаагаа анзааран “Эд нар өчигдөрийн байдлагсад биш байна. Мусульмануудад шинэ армийн тусламж ирсэн байна” гэж бодоцгоон, айж эхлэв. Тэр боломжийг ашиглан Халид бин Уалид ба мусульман баатарууд илүү сайн дайтаж тэр өдөр 1000 дайсаны амийг там руу илгээжээ. Аллахын элчийн залбиралын үр дүнд 3000 мусульман цэрэг 100 мянган Ромын цэрэгтэй халз тулалдан бут цохиж үлдэн хөөжээ. 15 хүнээ алдан тулалджээ.

Ийнхүү Византи гүрэнийг айлгасан мусульмануудын зоригт дайчид ялалтыг гартаа авчээ.

3 хоногийн дараа Медине хотод ялалтын баярт мэдээг дуулгахаар Яла бин Үмейе иржээ. Болж өнгөрсөн бүхнийг Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) маш сайн мэдэж байлаа. Элч түүнд: “Хүсвэл тэдэнд чи энэ мэдээг дуулга, хүсвэл би дуулгая” гээд дайны талбарт болсон бүхэнийг нүдээрээ харсан мэт нэг нэгэнгүй асхабууддаа хэлж өгөв. Яла бин Үмейе: “Чамайг чин үнэн шашинтайгаар илгээсэн Аллахдаа талархaya! Үнэндээ дайны үед болсон бүх зүйлийг нэгийг нь ч үлдээлгүй үнэнээр нь хэллээ” гэв. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам): “Аллах эзэн миний хувьд 3 орон зайг чөлөөлж, би дайны талбарыг өөрийн нүдээрээ харсан юм” хэмээв.

Хэсэг хоногийн дараагаар дайчид Мединед ойртож ирсэн мэдээг дуулгахад Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) асхабуудтайгаа тэднийг угтахаар Медине хотын гадна гарав. Холоос тоос татахад ариун догшин исламын далбаа намиран асуй. Тэднийг толгойлж гэгээн Халид бин Велид (радиаллаху анх) ирж явна. Зоригт дайчид Медине хотдоо морилжээ.

МЕККЕ ХОТЫГ ЭЗЭЛСЭН НЬ

Хижретийн (их нүүдэл) 8 дахь жил Худейбид хийсэн найрамдлын гэрээнд: “Арабын отог овог хүссэн талдаа дагаар орж болно. Мусульман эсвэл мүшрикүүдийн альнийх нь ч талд орох нь чөлөөтэй” гэж тусгагдсан билээ. Тийм болохоор Хуза овог мусульманы талд, Бени Бекр овог мүшрикүүдийн талд орцгоожээ. Энэ хоёр овог эрт дээр үеэс нэг нэгэнтэйгээ дайсагналцсаар иржээ. Гэрээ ёсоор тэр хоёр овог хэсэг дайнаа зогсоожээ. Бекр овгийн нэг хүн ислам ба Мухаммед элчийг (салаллаху алейхи уа сальлам) хараан зүхсэн шүлэг зохиол уншсанаар Хуза овгийн нэг хүнд толгойгоо хага цохиулжээ. Тэд өширхөн боломжийг ашиглан, дайтах гэсэн Бекр овгийнхон шөнө дөлөөр Хуза овгийнхонд дайрчээ. Энэ дайралтанд Курейш мүшрикүүд ч туслажээ.

Тэр орой Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) гэгээн Меймуна эхийн гэрт тухлаж байв. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) намаз (мөргөл) үйлдэхээр угаалга үйлдэж байхад Аллахын нэгэн гайхамшигаар Меккед байгаа мусульманууд түүнээс тусламж гуйж байгааг харжээ.

Тэдэнд хариулт болгон “Леббейк! Урилгыг чинь хүлээж авлаа!” хэмээв. Меймуна эх элчийн хажууд хэн ч байхгүй байгаа атал ийн хариулж байхыг сонсоод гайхан: “Аяа, пайгамбар минь! Таны хажууд хэн нэгэн байгаа юу?” гэж асуув.

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) түүнд Меккед болж буй зүйлийг бас курейшууд дайнд оролцсоныг хэлж өгөв.

Курейш мүшрикүүд Бени Бекр овогт туслан, Хуза овогыг дайран, хэсэг хүнийг алсанаар Худейбиед болсон энхийн гэрээг эвджээ. Гэхдээ энэ талаар курейш овгийн толгойлогч Эбү Сүфиян мэдээгүй байлаа. Учир нь тэр үед Шам хот руу наймаанд явсан байв. Эбү Сүфиян энэ талаар дуулаад “Бид нэн даруй Медине рүү явж Мухаммедээс уучлал гуйн энхийн гэрээг дахин шинэчлэх ёстой” гэгцгээв.

Үнэндээ Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) энэ мэдээг тэр дор нь мэдсэн билээ. Мөн Хуза овгийн Амр бин Салим 40 хүний хамтаар Мединед ирж болсон бүхнийг хэлжээ. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам): “Хуза овогт туслахгүй бол, надаас битгий өршөөл хүлээгээрэй” хэмээн нэгэн захиа бичжээ. Курейш овгийнхонд бичсэн энэ захианд “... Та нар нэг бол Бекр овгийнхноос холбоогоо таслан хол байцгаа, эсвэл Хуза овгийнхны алсан хүн бүрийнхээ үнэ цэнийг тэдний хүссэнчлэн төлцгөө, хэрвээ энэ хоёр зүйлийн нэгийг нь хийхгүй бол та нартай дайтахаа мэдэгдэе!” хэмээжээ.

Курейшууд энэ энэрэлийг эс ойлгон: “Бид нар энэ овгоос салахгүй, бас амьны төлөөс ч төлөхгүй” хэмээн мэдээ илгээв. Гэхдээ ингэж хэлсэндээ маш их харамсан уучлалд гуйж ахин энхийн гэрээ байгуулахаар Эбү Сүфиян нэн даруй Медине рүү замд гарав.

Эбү Сүфиян Мединед ирж амжаагүй байхад Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам): “Би Эбү Сүфиян гэрээг дахин шинэчилж, хугацааг нь сунгахаар ирж асуй. Гэхдээ түүний энэ санаа бүтэхгүйгээр буцах байхаа гэж бодож байна” гэв.

Мусульман болж амжаагүй яваа Эбү Сүфиян Мединед ирлээ. Тэрээр өөрийн охин болох Мухаммед элчийн гэргий Үммү Хабибагийн гэрт очив. Мухаммед элчийн орон дээр суух гэтэл гэгээн Үммү Хабиба урьтаж очоод орыг авчихлаа. Эцэг нь энэнд маш их гомдон: “Хөөе, охин минь! Энэ орыг надаас харамлаж байна уу?” гэхэд Мухаммед элчийн хайрыг бүхнээс илүүд үзэх

мусульмануудын ээж Үммү Хабиба: “Энэ ор бол Аллахын элчийн ор юм. Энэнд мүшрикүүд сууж болохгүй! Чи бол мүшрик ба нежис (хир) юм. Тийм болохоор ийм оронд суух нь огт нийцэхгүй” гэв.

Эцэг нь “Охин минь, гэрээсээ гараад их өөрчлөгджээ” гэв. Тэр: “Бурханы авралаар би мусульман болсон. Харин та одоо болтол сонсдоггүй, хардаггүй, чулуугаар хийсэн бурхадад мөргөж байна. Эцэг минь! Тань шиг курейш овгийн том толгойлогч бас хамгийн настан нь ягаад исламаас ингэж хол үлдэн вэ?!” гэв. Эцэг нь энэ үгэнд маш их уурлан “Намайг үл хүндлэн, харанхуй бүдүүлэг гэж хэллээ. Тэгэхлээр би эцэг өвгөдийнхөө шашиныг орхиод Мухаммедэд итгэх хэрэгтэй болж байна уу? Хэзээ ч үгүй!” гээд гарч одов.

Хайрт пайгамбарын маань (салаллаху алейхи уа сальлам) өмнө ирсэн Курейшийн дарга: “Би Худейбиед хийсэн энхийн гэрээг ахин нэг харж шинэчилхээр ирлээ. Алив, хэдэн бичиг бичээд энэ үл ойлголцох явдалыг таслан, гэрээ байгуулъя” гэв. Харин Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) “Бид Худейбие гэрээг эвдэх зүйл хийхгүй. Бас шинэ гэрээ ч хийхгүй” гэв. Эбү Сүфиян ахин дахин “Гэрээг өөрчилъе, шинэчилъе” гэсэн авч хайрт пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) зөвшөөрсөнгүй. Энэ хүсэлт ямар ч боломжгүйг ойлгосон Эбү Сүфиян Мекке рүү буцжээ.

Хэн Месжид-и Харамд хорогдвол...

Эбү Сүфиян Мединегээс явангуут Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) Меккег эзлэхээр шийдэв. Ягаад гэвэл курейшууд гэрээг эвдэн тангарагаасаа няцжээ. Гэхдээ энэ санаагаа маш нууцаар хэрэгжүүлэв. Мүшрикүүдэд бэлдэх боломж өгөлгүй, Меккед огт цус урсгалгүй, чим чимээгүйгээр буулган авах бодол өвөртлөв.

Энэ бодолоо Эбү Бакир ба асхабуудынхаа толгой болсон хэсэг хүмүүст мэдэгдэв. Асхабдаа замд гарахад бэлдэхийг тушаагаад, гэхдээ хаашаа явцгаахаа хэлсэнгүй. Асхабууд дайнд бэлдэж эхлэв. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) ойр хавийн мусульман отог овогт Эслэм, Эшча, Жүхейне, Хусайн, Гифар, Мүзейне, Сүлейм, Дамра гэх овогууд руу мэдээ илгээв. “Аллах эзэн ба хойд ертөнцөд итгэгсэд, Рамазан сарын эхэнд Медине хотод ирцгээ” гэсэн мэдээг тараав.

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) болгоомжлох үүднээс Мекке хот руу явах замд харуул болгон Омарыг томилов. Тэрэнд: “Мекке рүү явахыг хүссэн хэн боловч хойшоо (Медине рүү) буцаа” гэж тушаав.

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) энэ ажилаа маш нууцаар хийхийн тулд: “Аяа, Эзэн минь! Хотод нь гэв гэнэт орж очих хүртэл Курейш тагнуулуудын нүдийг нь халхал. Тэд биднийг энгийнээр харцгааг” хэмээн залбирав.

Энэ үед Мекке рүү бэлтгэл ажилын талаарх мэдээг хүргэхээр нэг захиа бичигдсэнийг Аллах элчид мэдэгдэв. Элч (салаллаху алейхи уа сальлам) гэгээн Алиг явуулж захиаг замаас нь авчээ.

Рамазан сарын хоёр дахь өдөр хүртэл ойр хавийн овогуудаас тусламж ирэв. Мусульманууд Эбү Инебе худгийн хажууд цуглажээ. Тэдний цэрэгийн тоо 12 мянга хүрчээ. Эдгээрээс 4000 нь ансар (Мединегийн мусульман) 7000 нь мухажир (Меккегийн мусульман), үлдсэн нь Меккегийн хажуу хавийн мусульман отог овгийн цэргүүд юм.

Ийнхүү хорвоогийн энэрэл болсон элч (салаллаху алейхи уа сальлам) 12000 цэрэгээ дагуулан замд гарлаа. Энэ өдөрөөс 8 жилийн өмнө хорлол, тамлалаар дээрэлхүүлэн нутагаасаа хөөгдөн гарсан. Тэр нутагаа буцаан авахаар би янз янзын шавар, мод, чулуу, бурхад сахиусаар дүүргэсэн ариун Каабыг цэвэрлэхийн тулд явж байна... Мухар сүсэгээсээ болоод юу ч хийхээс буцахгүй зэрлэг балмад мүшрикүүдэд шударга үнэнийг ойлгуулж, энэрэл хайрыг заахаар явж байна... Аллах эзэний шашиныг дэлгэрүүлж, тэнд байгсадыг мөнхийн тамын зовлонгоос аврахаар явж байна. Энэ юутай их энэрэл вэ?!

Исламын цэрэг Зүл- Хулейфед ирэхэд Мекке хотоос гэр бүлээрээ Медине рүү нүүж ирж яваа гэгээн Аббастай тааралдлаа. Хайрт пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) авга ахыгаа хараад маш их баярлан: “Аяа, Аббас! Би элчүүдийн сүүлчийн элч болсон шиг, чи бол мухажирчуудын (Меккегээс Мединед нүүсэн мусульманууд) сүүлчийх” хэмээв. Гэгээн Аббас ачааг Медине рүү илгээн, өөрөө элчийн хажууд үлдэн, Меккег эзлэхээр буцав.

Цэрэгүүд Меккед ойр Кудейд гэх газар ирэхэд Аллахын элч цэргүүдээ жагсаан, дайны бэлэн байдалд оруулаад, овог болгонд өөр өөрийн далбааг өгч, исламын далбааг гэгээн Али, Зүбейр бин

Аввам, Саад бин Эби Ваккас нар (радиаллаху анхум) барьжээ.

Орой болоход Меккед тун ойрхон дөхөж ирсэн байлаа. Меруззахран гэх газар ирээд Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) цэргээ зогсоон бүх цэрэг нэг нэг бамбар асааж барихыг тушаав. 10000-аас илүү гал асахад Мекке хот гэрэлтэж байв. Огт юу ч дуулаагүй мэдээгүй байсан мүшрикүүд гайхширч хоцров. Юу болоод байгааг асуулгахаар Эбү Сүфияныг илгээв. Тэр хэсэг хүн аваад исламын цэрэгүүд рүү ойртон ирж явна. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) асхабдаа: “Эбү Сүфияныг харж хандацгаа, тэр заавал эргэн ирэх болно (мусульман болно!)” хэмээжээ. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) ба цэргүүд Мекке хотын захад буудалцгаалаа. Хайрт пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) Эбү Сүфиянд: “Хөөе, Эбү Сүфиян! Юутай харамсалтай вэ? Аллахаас өөр бурхан үгүй гэдэгийг ухаарах цаг чинь болоогүй гэж үү?” хэмээв. Эбү Сүфиян: “Эцэг эхээ чамд өргөө! Сайхан сэтгэл, хүнлэг чанар, шударга байдалаараа чамгаас илүү хүн энэ хорвоод үгүй билээ. Бид чамайг зовоон, үгүй хийхийн тулд ямар их муу муухай зүйл хийсэн билээ. Гэтэл чи одоо ч гэсэн биднийг энэрэн, шашиндаа уриалж байна. Чи ямар агуу хүн билээ. Аллахаас өөр бурхан үгүй гэдэгт итгэлээ. Чи ч гэсэн Аллахын элч мөн” хэмээн мусульман болжээ.

Мухаммед элчид (салаллаху алейхи уа сальлам) Аббас: “Аяа, пайгамбар минь! Эбү Сүфиянд Мекке хотод нэр хүндээ олж авах нэг зүйл өгөөч?” гэв. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам): “Хэн нэгэн Эбү Сүфияны гэрт орж хорогдох юм бол түүнд бид хүрэхгүй. Тэр хүн амьд үлдэнэ” хэмээв. Эбү Сүфиян: “Аяа, Расулуллах! Арай жаахан хүрээг тэлж, томосгооч?” гэж гуйхад Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам): “Хэн нэгэн Харамд (Каабын бүс газар) орж хорогдох юм бол, тэр хүнийг амьд үлдээнэ. Хэн нэгэн хаалгаа хааж гэртээ суух юм бол түүнийг амьд үлдээнэ” гэв.

Хайрт пайгамбар маань Эбү Сүфиянд хандан: “Өнөөдөр Аллах эзэн Каабыг өндөрт өргөсөн өдөр. Өнөөдөр Аллахын гэрийн (Кааб) нөмрөг нөмөргөх өдөр. Өнөөдөр энэрэлийн өдөр... Өнөөдөр Аллах Курейш овгийг (Исламаар) мялаах нэгэн өдөр” хэмээв.

Гэгээн Эбү Сүфиян сонсох зүйлээ сонсож, мэдэх зүйлээ ойлгожээ. “Би Кайзер, Кисра хотуудыг үзсэн. Гэхдээ амьдралдаа

ийм агуу дайчид, ийм агуу армийг үзээгүй билээ. Эднийг яалж дийлэх хэзээ ч үгүй байх. Бид дийлэхгүй нь ойлгомжтой боллоо” гэж мэдээ дуулгахаар Мекке рүү буцав.

Эбү Сүфиян Меккед ирээд курейшуудад мусульмануудын сүр хүчийг тайлбарласаныхаа дараагаар “Хөөе, курейш хүмүүс ээ! Мухаммед (aleyхиссальлам) хэзээ ч түүний өмнө сөрж тогтоон үл чадан маш их хүчээр ирж асуй. Өөрийгөө битгий хуурцгаа, мусульман болоод амиа аварцгаа. Би та нарын үзээгүйг үзлээ. Тоо тоймшгүй морьт, явган цэрэг, зэр зэвсэг... Энэ бол бидний хүч хүрэх зүйл биш. Хэн Эбү Сүфияны гэрт, Харамд, эсвэл өөрийн гэртээ хаалгаа хааж суугаад хорогдох юм бол тэр хүн аюулгүй, түүний амийг хэлтрүүлэн гэж байна” гэв.

Энэ үгийг сонссон мүшрикүүдийн зарим нь Эбү Сүфияныг хараан зүхэв. Тэр бүү хэл исламын цэргийг эсэргүүцэхээр дайнд бэлдэж эхлэв. Гэхдээ ийм бодолтой хүмүүс маш бага байлаа. Зарим нь амиа бодоцгоон өөрийн гэр лүүгээ гүйцгээв. Зарим нь Месжид Харамд орж хорогдов.

Исламын цэргүүд Зитува гэх газар зогсцгоолоо. Мухаммед (aleyхиссальлам) элч өөрийн баатар дайчиддаа нүд гүйлгэн нэг харсанаа, энэ өдөрөөс 8 жилийн өмнө Меккегээс хөөгдөн зугтааж байсан мөчөө санаж, тэр үед гэрийг маань мүшрикүүд бүсэлсэнийг, Ясин сүрег уншаад харагдаагүй зугтаасаныг, Эбү Бакирийн хамтаар Севр ууланд хорогдон нуугдсаныг, Меккегийн хилээс гарахдаа аргшаагаа хараад “(Хөөе, Мекке) Амлан өгүүлье, чи бол Аллах эзэний бүтээсэн газаруудаас хамгийн гэгээн нь билээ. Эзэний минь хувьд ч, миний хувьд ч тэр, чи хамгийн их хайртай нутаг минь билээ. Чамаас хүчээр хөөгдөөгүйсэн бол хэзээ ч чамаас холдохгүй байх байлаа” хэмээн хэлжээ. Энэ гунигт явдалын үед Жабрайл (aleyхиссальлам) ирж Касас сүрегийн 85-дахь аетийг нь илгээн ирж түүнийг баярлуулсаныг, энэ жаахан хүмүүс агуу том дайн Бедир, Ухуд, Хэндэк, Мутедэд хэрхэн тулалдан, ялалт байгуулсаныг цөмийг нь эргэн нэг дурсав. Одоо 12000 асхаб хажууд нь тойрон хүрээлж, Мекке хотод орох тушаал хүлээн зогсоно. Хайрт пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) энэ бүх зүйлийг олгосон Аллах эзэндээ хамгаас илүү баярлан талархаж байлаа.

Элч цэрэгээ 4 бүлэг болгон хуваагаад тус тусд нь дарга томилов. Баруун жигүүрийн даргаар Халид бин Велид, зүүн жигүүрийн даргаар Зүбейр бин Аввам, морин цэргийн даргаар

Эбү Убейде бин Жеррах, үлдсэн цэргийн даргаар Саад бин Убаде нарыг томилжээ. Гэгээн Халид Меккегийн өмнөд зүгээс, Зүбейр Меккегийн дорно зүгээс, Саад бин Убаде Меккегийн хойд зүгээс орохоор болцгоов.

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) даргууддаа “Тэд та нар луу дайраагүй тохиолдолд түрүүлж битгий дайрцгаа, хэнийг ч битгий алцгаа” гэж захив. Гэхдээ нэр нь дурдагдсан 15 хүнийг Каабын нөмрөгний доор нуугдсан ч барьж толгойг нь таслах ёстойг хэлэв.

Шударга үнэн дийлж, худал хуурмаг сарнин одов...

Рамазан сарын 13-ны өдөр Жума (Баасан) өдөр байлаа. Халид бин Велид Мекке хотын өмнө хэсгээр цэрэгтэйгээ орж ирхэд хэсэг мүшрик тэдэн рүү довтлон эсэргүүцэж түрүүлж хөдөлцгөөв. Хоёр мусульман алагдан (шахид) болоход гэгээн Халид: “Зөвхөн дайрсан мүшрикүүдийг л алцгаа” хэмээн тушаан урагш довтлов. Гэв гэнэт мүшрикүүд зугтаан ухарч эхэлхэд энэ мөргөлдөөнд 70 мүшрик алагджээ. Үлдсэнүүд нь өөрийн гэр лүүгээ зугтаав.

Харин Меккегийн нөгөө талаас орсон цэрэгүүд лүү эсэргүүцэх нэг ч хүн гарсангүй. Цаазлахыг тушаасан 5 хүн баригдан шийтгэлээ амсацгаав. Бусад нь Меккегээс зугтаажээ. Дайчид: “Аллаху Акбар! Аллаху Акбар!” гэж уухайлах нь Мекке хотыг чичирхийлүүлнэ. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) Кусва тэмээндээ суун Мекке хот руу орж ирэв. Өөрт нь ийм их буян хишигийг хайралсан Аллах эзэндээ талархан Меккег эзэлсэн баярт мэдээг түгээн, Фетих сүрег уншин урагшилна.

Хорвоогийн энэрэлт элч (салаллаху алейхи уа сальлам) маш их баяр хөөртөйгөөр зоригт дайчидаа дагуулан ариун Каабын зүг урагшилна. Баруун талд гэгээн Эбү Бакир, зүүн талд нь Усейд бин Худейр явна. Хажер-үл Эсвэдийг очиж үнссэнийхээ дараагаар Телбие ба Текбирийг уншив. Энэнийг сонссон асхабууд “Аллаху Акбар! Аллаху Акбар!” гэх уриагаа хэлэн, энэ гайхам зүйлд баярлацгаана, цөм уйлцгаана.

Дараа нь асхабууд цөм Каабыг таваф (тойрон мөргөх) хийж эхлэв. 7 дахь таваф дууссаны дараагаар Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) тэмээнээсээ бууж Макам-и

Ибрахимд хойр хоёр рекать (үе) мөргөл үйлдэцгээв. Дараагаар нь гэгээн Аббасын худагнаас гаргасан Земзем усыг уув. Дараагаар нь Земзем усаар мөргөлийн угаалга үйлдэж эхэлхэд асхабууд түүний нүүрнээс дуслас усыг газар унагалгүй шүүрэн авцгаан, биедээ түрхэцгээж эхлэв. Энэ бүхнийг харж байсан мүшрикүүд: “Бид амьдралдаа ийм агуу удирдагчийг хараагүй, сонсоогүй билээ” гэгцгээн гайхана.

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам): “Шударга үнэн ирэхэд, худал хуурмаг зайлна, худал хуурмаг үргэлж зайлан зугтаадаг” (Исра сүре,81) аетийг уншаад гартаа барьсан таягаараа шавар бурхад руу заав. Таягны заасан бүх бурхадууд нэг нэгээрээ түрүүлгээ харан газар унцгаалаа. 360 шаавар бурхадыг газар унагаав.

Хайрт пайгамбар маань Каабын түлхүүрийг авч ирүүлэв. Дотор байсан зураг хөрөг бас унасан бүх бурхадыг цэвэрлэн гаргасныхаа дараагаар хажууд гэгээн Усеме бин Зейд, гэгээн Билал, гэгээн Осман бин Талха (радиаллаху анхум) нарын хамтаар дотогш орцгоов. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) дотор нь 2 рекать (үе) мөргөл үйлдэв. Булан бүрт нь такбир хэлэн алгаа дэлгэн зальбирав.

Хорвоогийн энэрэлт элч (салаллаху алейхи уа сальлам) ариун Каабын хаалгыг гараараа онгойлгон барьж байлаа. Бүхий л Курейш Каабын өмнө цуглацгаан, элчээс айж эмээхийн хажуугаар, авралын горьдлогын нүдээр элч рүү харцгааж байлаа. Учир нь тэд элчид бас түүний асхабуудад маш их хор хөнөөл учруулсан юм. Тэдний хүзүүнээс дөнгөлөн моринд чирүүлж, галд амьдаар нь шатааж, улайссан төмөр чулуугаар даруулж, ухаан алдаж унах хүртэл нь тамлан зовоож, 3 жил өлсгөлөн хорьсон билээ. Хөлнөөс хоёр тэмээнд уяна хоёр тийш татуулан хувааж, энэ бүхэнээс хамгийн хэцүү нь хайрт эх нутагаас нь хөөж гаргасан явдал юм. Тэгээд ч зогсоогүй хэд хэдэн удаа байлдсан юм.

Гэхдээ энэ бүхнийг уучлан гэсэн горьдолго тасраагүй байлаа. Учир нь тэдний өмнө бүхнээс илүү энэрэлт элч (салаллаху алейхи уа сальлам) бий болохоор. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) хэсэг тэднийг харж зогссоныхоо дараагаар: “Хөөе, курейш ард түмэн, би та нарыг яах гэж байна гэж бодож байна?” гэж асуулаа. Тэд: “Бид чамаас өршөөл гуйж байна. Сайн сайханыг хүсэж байна. Учир нь чи бидний сайн үйлст дүүгийн минь хүү билээ” гэгцгээв.

Мухаммедэлч(салаллахуaleyхиуасальлам)инээмсэглээд:
“Миний бас та нарын учир явдал Юсуф (aleyхиссальлам) ба түүний ах дүүс шиг болох болно. Тэрэн шиг би ч гэсэн өнөөдөр (өнөөдөрөөс хойш буруу нүгэлийг чинь хэлж, тамлах гэх мэт миний зүгээс) та нарыг зовоох ба буруутгахгүй. Аллах та нарыг уучилж өршөөг. (Юсуф сүре, 92) гэж байна. Явцгаа, та нар эрх чөлөөтэй хүмүүс” гэв.

Энэ их агуу энэрэл хөрөн мөс болсон сэтгэлийг дэвтээн, үзэн ядах сэтгэлийг хайраар өөрчилж чаджээ. Мухаммед элч (салаллаху aleyхи уа сальлам) тэднийг ислам шашинд уриалхад мусульман болохын тулд цөм цуглацгаав. Хайрт пайгамбар маань (салаллаху aleyхи уа сальлам) анх курейшийг исламд уриалан дуудахдаа гарсан Сафа толгодод ахин гарав. Мөн тэнд хөгшин, залуу, эрэгтэй, эмэгтэй бүхий Меккечүүд исламын итгэлийг хүлээн зөвшөөрөв.

Ингээд мусульман бологсодод шинээр болзол тавьлаа. Аллахаас өөр бурханд мөргөн залбирахгүй байх, Мухаммед элчид хорон муу санаа өвөрлөхгүй байх, хулгай хийхгүй байх, ариун явдалт ба журамт ёсыг сахих гэх мэт. Мусульман болсон эмэгтэйчүүдийн дунд цаазаар авагдах ёстой хүмүүсийн дунд бичигдсэн Эбү Сүфияны гэргий Хинд байлаа. Гэхдээ энэрэлт элч (салаллаху aleyхи уа сальлам) түүнийг өршөөжээ. Мусульман болсон хүмүүс цөм өөрийн гэрт байсан шавар бурхадаа эвдэн хогонд хаяцгаав. Ийнхүү шударга үнэн явдал хуурмагийг үндсээр нь устгажээ. Өршөөгдсөн хүмүүсийн дотор Эбү Жахилийн хүү Икриме, гэгээн Хамзаг хөнөөсөн Вахши (радиаллаху анх) нар байлаа.

ХҮНЕЙН ДАЙН

Мусульманууд Мекке хотыг дайтахаар гарах замд Мекке хотод ойр орших Хевазин ба Сакиф гэх хоёр овог мусульманууд биднийг бас дайрах байх гэж эмээн дайнд бэлдэж эхлэв. Гэвч мусульманууд зөвхөн Меккег эзэлхээр ирсэнийг сонсоод тайвширсан ч дайны бэлтгэлээ хангаж: “Курейшуудын дараах ээлж бид болох нь дамжиггүй. Тиймээс бид Мухаммедээс урьтаж дайн зарлан тэднийг буулгаж авъя” гэж тохиролцгоов. Хевазин овгийн толгойлогч Малик бин Авф 20000 цэрэг бүхий маш том армитайгаар дайнд мордов.

Энэ мэдээ хурдан Меккед дуулдав. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) энэ мэдээг лавлахын тулд Абдуллах бин Эби Хадредыг (радиаллаху анх) Хевазин овог руу илгээв. Гэгээн Абдуллах дүрээ өөрчлөн дайсаны отогт очоод дайны бэлтгэлийг нь хараад буцаж ирэн элчид мэдэгдэв.

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) нэн даруй асхабаа дайнд бэлдэн Мекке хотод 20 настай Аттаб бин Эсидийг захирагчаар томилон үлдээгээд шалавхан дайнд мордов. 12000 цэргийн хамтаар Хевезин ба Сакиф овгийг дайлаар морьдов. Исламын далбааг гэгээн Али барьжээ. Эхний цэрэгүүдийг гэгээн Халид бин Велид захирна. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) өөрийн дулдул нэртэй луусаа унажээ. Шеввал сарын 11-өдөр Хунейн гэх газар бочжээ. Тэр орой Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) цэргүүдээ хянан дайны бэлэн байдалд оруулав. Өглөө мөргөлөө үйлдсэний дараагаар хөдөлцгөөв.

Мүшрикийн цэргүүд тэр шөнө Хунейн талбарт ирж өөрийн цэрэгээ байршуулжээ. Гэгээн Халид бин Велид цэргүүдийн хамтаар урагшилж байхдаа өмнө нь дайсаны отолт буйг анзаарсангүй. Гэв гэнэт дайсанууд харваж эхлэв. Энэ мөндөр мэт орох сумнаас хорогдох газар байхгүй болохоор цэргүүд ухархаас өөр аргагүйд хүрчээ. Мусульманууд ухрахдаа араас нь ирж явсан цэргүүдийн жагсаал горимыг алдагдуулжээ. Энэ бүхнийг харсан мүшрикүүд баярлан, дайрах цаг боллоо гэж бодоцгоон толгодыг даван 20000 цэрэг давшсаар орж ирэв.

Хайрт пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) гав ганцаараа дайсаны өмнөөс дайрахад зөвхөн гэгээн Аббас ба Эбу Бакир тэргүүтэй 100-аад хүн л Мухаммед элчийн араас даган

дайралтанд орцгоов. Тэд биеээрээ элчийг халхалан тулалдана.

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) ислам шашинаа мөхөх вий гэж айсандаа: “Аяа, Аббас, чи тэдэнд: “Хөөе, Семүре модны доор амлалтаа өгсөн асхабууд аа” гэж орил!” хэмээв. Гэгээн Аббас (радиаллаху анх) лагс биетэй сүр жавхлант нэгэн юм. Тэрнийг орилох үед дуу нь маш хол хадаж дуулдана. Тэрээр “Хөөе, мусульманууд аа! Хөөе Семүре модны доор Мухаммед элчид ам тангарагаа өгөгсөд, битгий зугтаацгаа, наашаа ирцгээ” хэмээн орилход энэ үгийг сонссон мусульманууд эргэн буцахыг хүссэн боловч морьдоо зогсоож үл дийлнэ. Тэд арга ядан морьноосоо үсэрэн бууцгаав. Тэд буцан ирж ам ман тулалдаж эхлэв. “Аллаху Акбар! Аллаху Акбар!” хэмээн орилолдох нь зүрхийг зоригжуулж хүч нэмэх мэт. Бедир, Ухуд, Хендек дайнд баатарлагаар тулалдсан асхабууд тэр дундаа гэгээн Али, Эбү Дужене, Зүбейр бин Аввам нар (радиаллаху анхум) юунаас ч дутахгүй баатарлагаар тулалдаж мүшрикүүдийг бут ниргэж байлаа.

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) мусульманууд амь биеэ үл хайрлан тулалдахыг нь хараад: “Аллах минь, бидэнд туслаач. Үнэндээ чи биднийг дайсанаа ялахыг хүссэн” хэмээн залбирна. Ийнхүү залбираад газараас нэг атга элс аваад: “Нүүр нь харлаг” гээд мүшрикүүд рүү цацав. Энэ үед мүшрик цэрэгүүдийн цөмийнхөн нүдэнд элс орон харж чадахаа болиход мелекүүд (сахиусан тэнгэрүүд) туслахаар иржээ. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам): “Аллахын нэрээр тангараглая! Ялагдаж эхэллээ” гэв. Мүшрикүүд нүдээ ухацгаан ухаран зугтааж эхлэв. Асхабууд тэдний араас нэхэн хөөв. Тэд авч ирсэн эмс охид, эд хөрөнгөө хөсөр хаян, амиа бодон зугтаацгаалаа.

Дайны талбарт 70 үхсэн дайсан, 6000 олзны хүн, маш олон дайны эд хөрөнгө үлджээ. Зугтаагсадын ихэнх нь Тайф гэх хэрэм бэхлэлтэнд очиж хорогдоцгоожээ. Тэдний дарга Малик бин Авф ч зугтаан очжээ. Энэ дайнд мусульманууд ялалт байгуулж, 4 хүнээ шахид болгожээ.

ТАЙФ РУУ ОЧСОН НЬ

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) Тайф руу зугтаасан мүшрикүүдийн хойноос нэхэж очоод энэ дайныг төгсгөл болгож, үр дүнг үзэхийг хүсэв. Меккед ойр орших энэ хэрэм цайз сүүлчийн бас хамгийн чухал цайз байв. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) урьд нь Тайфд ирээд нэг сар номлол сургаалаа айлдан, исламд уриалсан юм. Гэвч Тайфын ард түмэн элчийг дээрэлхэн зовоож, ариун хөлийг нь цус болтол чулуудаж хөөж гаргасан билээ. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) Зейд бин Харисегийн хамтаар энэ хотод хамгийн гашуун зовлонг амссан билээ. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) Халид бин Велидийн цэргийн хамтаар урьтаж явуулаад өөрөө цэргээ дагуулан асхабуудтай Тайфын зүг араас нь хөдлөв. Тайф ардууд мусульман цэргүүдийг хараад цайзынхаа хаалгыг хааж дайтахаар шийдэцгээв. Цайзад ойрхон цэргүүд лүү сум харван эсэргүүцэж байлаа. Тайфынхан цайзнаасаа гарч дайтахаас айж байлаа.

Асхабууд цайз руу чулуу харвагчаар чулуу шийдэхийг санал болгов. Пайгамбар (салаллаху алейхи уа сальлам) энэ санааг зөвд тооцож чулуу харваач хийлгүүлж эхлэв. Тэрээр мүшрикүүд рүү чулуу харвацгаан дайнаа үргэлжлүүллээ. Асхабууд бүх хүчээ дайчлан дайлдаж, хурдхан цайзыг өөртөө авахыг оролдлоо. Гэхдээ бат бэх болохоор цайзыг эзэмдэх хэцүүдэж байлаа. Ийнхүү дайтсаар 20 хоног өнгөрөв. Тэр шөнө пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) бэлэглэгдсэн сав дүрэн тосыг нэг тахиа асгаж байсныг зүүдэлжээ. Үүнийг Тайфыг энэ жилд эзэмдэж чадахгүй хэмээн тайлж, бүслэлтийг авав. Энэ удаад ч гэсэн өрөвдсэн сэтгэл үзүүлж: «Аяа, Аллах минь, Сакифийнхэнд зөв замыг харуул, тэднийг бидэнд ирүүл» гэж залбирав.

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) асхабуудтай хамт Тайфаас холдон явж Хунейн дайнаас олзлосон зүйлсээ хуваацгаав. 1000 морин цэрэг, 20000-аас илүү бод, 40000-аас илүү бог малыг олзлохын хажуугаар тоо тоймшгүй хэмжээний мөнгө хөрөнгийг олзложээ. Энэ бүхэнээ дайчин асхабууддаа тэгш хэмжээгээр тарааж байхад Хевазин овгийн хэсэг төлөөлөгчид элчид ирж, овог цөм мусульман болцгоосоноо мэдэгдэхэд Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) энэ мэдээг дуулаад маш их баярлан энэ овгоос олзлогдсон бүх хүнийг суллан

тавьжээ. Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) ганцхан энэрэл 6000 гаруй хүнийг эрх чөлөөтөй болгожээ. Энэ мэдээг дуулсан Тайф цайзад хорогдож байсан Хевазин овгийн дарга Малик бин Авф өөрийн биеээр ирж мусульман болжээ.

Ингээд энд хийх ажил дууссан болохоор Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) цэргүүдээ аван Медине рүү буцаагаав. Аттаб бин Эсидийг (радиаллаху анх) Мекке хотын даргаар томилов. Муаз бин Жебелийг шашины бие төлөөлөгчөө болгов.

Нэг жилийн дотор Тайф хотоос 6 хүн бүхий төлөөлөгч Мединед ирж элчийн өмнө бараалхан, мусульман болцгоосоноо мэдэгдлээ. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) тэднийг мусульман болсонд маш их баярлан бэлэг сэлт өгөн, Тайф руу буцаав. Тайфын амбан захирагчаар Осман бин Эбу-л Асыг томилжээ.

ТЕБУК РУУ ОЧСОН НЬ

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) Мединегээс ирсэнийхээ дараагаар янз янзын улс гүрнүүдэд элчээ илгээн исламд уриалан дуудав. Оман, Бахрейн гэх мэт аймагийн амбан захирагчид ислам шашиныг хүлээн зөвшөөрөв. Басхүү олон тооны отог овгуудын төлөөлөгчид ирж мусульман болсоноо зарлан тунхаглав.

Одоо ислам шашин маш хурдацтайгаар тархаж байна. Өөр хавийн отог аймагууд руу ислам шашиныг заах багш, номлогчид илгээж байлаа. Хижрегийн (их нүүдэл) 9 дэхь жилд Медине хот мусульман бологсодын үерт автжээ.

Ислам хүчтэйгээр тархаж буй энэ 9 дэхь жилд Визант улсын хаан Геркулест христийн шашинт арабууд: “Энэ элч гээд байгаа хүн (Мухаммед) нас барж, мусульманууд уй гашуунд автан толгойлох хүнгүй боллоо. Бас энэ жил их ган гачигтай байгаа тул яг одоо л мусульмануудыг зогсоож эзлэн авах цаг болж байна” гэсэн захиаг илгээсэн тул Геркулес 40000 цэрэг бүхий арми Кубадад гэх баатараар удирдуулсан мусульмануудыг дайлаар мордохоор хөдөлжээ.

Энэ мэдээг авсан Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) асхабуудаа цуглуулан дайнд бэлдэж эхлэв. Тэр жил ган гачигтай байсан болохоор асхабууд ядуу хүчгүй байлаа.

Гэсэн хэдий ч асхабууд шашин ба элчийнхээ зарлигийг ёсчлон биелүүлж байлаа.

Тиймээс бүгд өөрт байгаа баялагаараа дайнд бэлдэж байлаа. Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) агуу найз Эбү Бакир (радиаллаху анх) хамаг малаа цөмийг нь дайны бэлтгэлд авч иржээ. Мухаммед элч: “Гэр бүлдээ юу үлдээв?” гэж асуухад Эбү Бакир: “Аллах эзэн ба түүний элчийг үлдээлээ” хэмээн хариулжээ. Гэгээн Омар мал хөрөнгийн тэн хагасыг нь тусламжинд авч ирэхэд Мухаммед элч түүнээс “Гэр бүлдээ юу үлдээв?” гэж асуухад Омар “Авч ирсэн шигээ үлдээлээ” гэв. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам): “Та хоёрын хоорондын ялгаа хэлсэн үгний чинь ялгаа мэт” хэмээжээ. Омар: “Аяа, Расуллаллах! Гэгээн Эбү Бакир бүхий л сайн үйлст надаас түрүүлж байдаг юм. Би одоо түүний буянт үйлсийг хэзээ ч урьтаж өнгөрч чадахгүйгээ хүлээн зөвшөөрлөө” хэмээв.

Асхабууд өөрийн бололцоогоороо туслаж байлаа. Харин Мунафикууд (хоёр нүүртэн): “Та нар нүд хуурахын тулд ингэж өгч байна” хэмээн асхабуудыг доромжилж байлаа. Мухаммед элч: “Хэн өнөөдөр хандив өргөх юм бол тэр хандив нь хойд насанд нь Аллахын өмнө түүний буяны гэрч болно” хэмээв. Энэ үгийг сонссон асхабууд бүүр их тусламж үзүүлж эхлэв.

Тебук руу хөдлөхөөр бэлдэцгээж байх үе бол мусульмануудын хамгийн зовлон гачигдалтай өдөрүүд байлаа. Ган гачигаас болоод зовж хоцорсон мусульманууд элчид ирж: “Аяа, пайгамбар минь! Бид явган нүцгэн хоцорлоо, идэж уух зүйл ч алга. Энэ дайнд таньтай хамт явж байлдамаар байна” гэцгээж байлаа.

Дайны бэлтгэл ажил дуусангууд элч (салаллаху алейхи уа сальлам) асхабуудаас Сениет-үл Веда гэх газар цуглуулав. Энэ дайнд оролцоогүй мусульман бараг үгүй байв. Цэргүүдээ цуглуулаад өөрийн орлогчоор Мединед Мухаммед бин Меслемег үлдээжээ. Замд гарахынхаа өмнө цэргүүддээ: “Өөртөө бас нэг гутал нэмж авцгаа. Хоёр гуталтай байхад зовлон амсахгүй” гэж захив.

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) Сениет-үл Ведагаас Тебук руу хөдлөхөөсөө өмнө далбаагаа намирган мандуулав. Хамгийн том далбаагаа Зүбейр бин Аввамд, хамгийн том тугаа Эбү Бакирт бариулжээ. Эвс овгийн далбааг Үсейд бин Худейрт, Хазреж овгийн далбааг Эбу Дужанед атгуулжээ.

Мухаммед элчийн толгойлсон цэргийн тоо 10000 морьт цэрэг бүхий 30000 хүн юм. Баруун жигүүрийн толгойлогчоор Талха бин Убейдуллах, зүүн жигүүрийн толгойлогчоор Абдуррахман бин Авфыг томилжээ.

Аагим халуунд цэргүүд урагшилна. Тэднийг толгойлж хорвоогийн элч явж байгаа цагт өлсгөлөн, ган гачиг тэднийг зовоохгүй, бас хичнээн мянган дайсан ч тэднийг айлгахгүй билээ.

Цэргүүд яван явсаар найм дахь удаагаа зогсоход Салих элчийн ард олоны Аллахын гэсгээлийг хүртсэн Хижр гэх газар хүрч одоцгоов. Энэ өдөр элчидээ үл итгэн дагаагүйгээс болж маш хүчтэй хашгиран исгэрэх нэгэн дуугаар ард олныг хөнөөжээ. Мухаммед элч (салаллаху алейхи уа саллям) асхабдаа: “Өнөө шөнө маш хүчтэй шуурга болох болно. Хэн ч хажуудаа хүнгүйгээр битгий хөл дээрээ бос, бас тэмээнийхээ хөлийг сайн туш. Энэ газар бол Аллахын гэсгээл ирсэн газар юм. Хэн ч энэ уснаас битгий ууцгаа, бас битгий угаалга үйлдэцгээ” хэмээв. Бүх хүн энэ зарлигийг ёсчлон биелүүлэв. Шөнө дунд маш хүчтэй салхи исгэрэн шуурахад энэ үед нэг хүн тэмээгээ харахаар ганцаараа босоход салхинд татагдан Тай уулын хормой хүртэл шидэгджээ.

Тэр өглөө бүх тулман нь хоосорч ус үлдээгүй байлаа. Бүх хүн маш их цангаж байлаа. Мухаммед элч (салаллаху алейхи уа саллям) алгаа дэлгэн бороо оруулахыг Аллагаас хүсэж залбирав. Хав халуун цэв цэлмэг байтал гэв гэнэт борооны үүл гарч, хүчтэй бороо орж эхлэв. Хүн бүр борооны уснаас туламаа дүүргэж аваад угаалга үйлдэцгээв. Мухаммед элч (салаллаху алейхи уа саллям) ба асхабууд Аллахдаа талархалаа илэрхийлэв.

Ийнхүү замаа цааш үргэлжлүүлэн мусульман цэргүүд Тебукт ирцгээхэд Визант гүрний цэрэг ба Амиле, Лахи, Жузам гэх мэт христийн шашинт арабуудын цэрэгүүдээс бүрдсэн дайсаны армийг үзсэнгүй. Мутед 3000 мусульманууд 100000 Византийн цэрэгийг бут цохисон бол одоо 30000 цэрэгтэй дайчидийг толгойлон хорвоогийн энэрэлт элч иржээ. Византын цэргүүд зоригт мусульман дайчидын сургийн сонсонгуутаа зугтаах газараа хайж эхэлсэн биз.

Мухаммед элч (салаллаху алейхи уа саллям) асхабуудтайгаа зөвлөлдөөд Тебукаас цааш явсангүй. Энэ үед зарим отог аймаг ба улс орон исламын цэргүүд ирсэнийг сонсоод

өөрийн элчээ илгээж алба татвараа өгч, энхийг хүсэж байгаагаа мэдэгдцгээв. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) тэдний саналыг хүлээн авч, нэг нэгэнгүй бугдэнтэй нь энхийн гэрээ хийж гарын үсэг зурцгаав.

Занга

Тебукт мусульман арми 20 хоног дайсануудаа хүлээцгээв. Тэд үргэлж номлол сургаалаа айлдан асхабуудынхаа сэтгэлийн анирийг үргээж байлаа. Ийм хорвоод хосгүй сургаалынхаа нэгэнд ийн айлджээ: “Хүн төрөлхтөний хамгийн дээд, хамгийн сайханы талаар та бүхэнд хэлэх үү?” гэв. Асхабууд: “Тийм ээ! Хэлээч, Расулуллах!” гэцгээв. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) үгээ үргэлжлүүлэн: “Хүмүүсийн хамгийн сайн бас буянт хүн бол мориндоо тэмээндээ мордоод үхэн үхтэлээ Аллахын илгээсэн энэ замд буян хийн ажиллаж байгаа хүн юм, харин хамгийн муу дорд хүн бол Аллах эзэний сударыг уншсан хэдий ч өөртөө юу ч тусгаж авахгүй төөрөлдөгчид билээ” хэмээв.

Шахидын (Аллахын ариун замд амиа өргөх) талаар асуусан нэгэнд: “Хорвоо ертөнцийг өөрийн эрхэндээ захирах Аллахын нэрээр тангараглая, шахидууд хойд ертөнцийн өдөр сэлмээ мөрлөн очицгоох болно. Гэрэл туяа цацарсан нэгэн олбог дээр сууцгаах болно” хэмээв.

Исламын дайчид Тебукаас Медине рүү буцахаар эргэхэд мунафикууд (хоёр нүүртэн) пайгамбарын (салаллаху алейхи уа сальлам) замд нэгэн занга тавьж алахыг санаархжээ. Тэгээд нарийнхан гарцанд занга тавьж хүлээцгээж эхлэв. Элчийн тэмээний бурантагийг Аммар бин Ясир барьж явна, хойно нь гэгээн Хузейфе бин Еман ирж явлаа. Мунафикууд хорон санаа агуулсаныг Мухаммед элчид (салаллаху алейхи уа сальлам) Жабрайл (алейхиссальлам) ирж мэдээлэв. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) занганд ойртоход мунафикууд нүүрэндээ баг зүүн дайрцгаав. Мухаммед элчийн хойно явах гэгээн Хузейфе: “Хөөе, Аллахын дайсанууд” хэмээн гартаа барьсан модоороо тэднийг шавхуурдаж эхлэв. Мунафикууд айн гүйлдсээр хурдхан олон цэргүүд дунд орж хутгалдав. Тэд 12 хүн юм. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) тэдний нэрийг гэгээн Хузейфед хэлээд хэнд ч битгий хэл гэж сануулав.

Энэ явдалыг дуулсан Усейд бин Худейр элчид ирэн: “Аяа,

Расулуллах, надад тэдний (мунафик) нэрийг хэлээч, би тэдний толгойг таны өмнө авч ирье” гэж зөндөө гуйсан боловч Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) зөвшөөрсөнгүй.

Дирар Месжид

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) ба түүний зоригт асхабуудаас Византийн арми айн ухарчээ. Мусульманууд Мединед ойртох үед Зи-Эван гэх газар цэргүүдээ зогсоон хоноглохоор буудаллав. Асхабууд унтаж байх үед хэсэг мунафик элчид ирээд Дирар месжидэд (сүм) очихыг урив.

Дирар месжид Куба тосгонд байрладаг билээ. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) Мединед ирэхдээ Кубад бариулсан анхны месжидийг мунафик (хоёр нүүртэнүүд) барьжээ.

Мунафикуудын гол зорилго бол мусульмануудын хооронд зөрчилдөөн гаргаж, яс хаян үймээн самуун дэгдээх явдал юм. Тэд Византи цэрэгүүдийг дуудан энэ месжидийг (сүм) тэдний зэвсэгийнагуулахболгохыгхүсэжбайлаа. Гэхдээпайгамбармаань (салаллаху алейхи уа сальлам) тэнд намаз (мөргөл) үйлдсэнээр тэр газарыг ариун газар болгон хувиргажээ. Мусульманууд цөм тэнд намаз (мөргөл) хийхээр цувархад мунафикуудын хувьд энэ санаагаа хэрэгжүүлэхэд маш ашигтайгаар эргэх байлаа.

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) мунафикуудын энэ урилгийг зөвшөөрөн очихыг завдаж байтал Тэубе сүрегийн 107-108 аетийг илгээн, жинхэнэ хорон санааг түүнд мэдээлжээ. Ингээд Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) Малик бин Духшум, ба Асим бин Адыйд: “Энэ хорон санаат хүмүүсийн месжидийг нурааж, шатаацгаа” гэх зарлиг буулгав. Тэд орой бүрийгээр очоод нөгөө месжидийг галдан шатаав. Мунафикууд юу ч хийсэнгүй.

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) Тебукээс ирсэнээс хоёр сарын дараа мунафикуудын толгойлогч Абдуллах бин Убей нас баржээ. Энэнээс хойш мунафикуудын холбоо таржээ.

Ийнхүү мунафикууд төдийгүй Араб дахь бүх кафирууд исламын бүр хүчийг хүлээн зөвшөөрчээ.

ХАГАЦАХ ХАЖ

Исламын таван шаардлагын нэг нь Хаж хийх (Каабд очиж мөргөх) юм. Энэ нь их нүүдэлийн 9 дэхь жилд фарз (зарлиг) болжээ. Энэ талаар Куран сударт ийн айлджээ. “Тэнд (Каабд) тов тодорхой шинж тэмдэг, Ибрахим (алеихиссальлам) пайгамбарын зогсоол бий. Хэн нэгэн хүн тийшээ очих юм бол бүх муу муухайгаас хол байх болно. Тийшээ явах зам ологсод (явах хүч, хүч чадал хүрэгсэд) тэр гэрийг хаж (эргэн тойрох) хийх нь Аллах эзэний хүмүүст өгсөн нэг зарлиг, фарз юм. Хэн нь энэ зарлигийг эсэргүүцвэл яах аргагүй, Аллах эзэний өмнө бүхий л ертөнц гачигдалтай билээ” (Али Имран сүре, 97)

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) Аллахын энэ зарлигийг асхабууддаа мэдээлэв. Тэр жил гэгээн Эбү Бакир (радиаллаху анх) хаж явах 300 хүний бүлэгт толгойлогч болов. Энэ хүмүүс гэгээн Эбү Бакирийн хамтаар Мекке рүү явав. Энэ үед Берае сүрегийн анхны ает ирэв. Энэ аетэд шашины ёсны талаар зарим зүйл байлаа. Гэгээн элч (салаллаху алейхи уа сальлам) энэ зүйлийг мэдэгдэхээр гэгээн Алиг Мекке рүү илгээв.

Али хаж явагсадын араас нэхэн очоод хамтдаа Мекке рүү очив. Гэгээн Эбү Бакир Меккед ирээд асхабуудад хаж хэрхэн үйлдэгдэх талаар сургаал айлдав. Асхабууд ч заан сургамжилсан хаж мөргөлөө үйлдэн дуусгав. Гэгээн Али (радиаллаху анх) Минада Жемре-и Акабе гэдэг газар очоод олонд хандаж нэгэн илтгэл тавив. Энэ илтгэлд: “Хөөе, хүмүүс ээ! Намайг та нарт элч болгон илгээлээ” гэж эхэлнэ. Тэгээд Берае сүрегийн анхны аетийг уншив. Дараагаар нь “Би та нарт 4 зүйл мэдээлэх ёстой” гэв.

1. Мусульмануудаас өөр хэн ч диваажинд орохгүй.

2. Энэ жилээс хойш ямар ч мүшрик (буруу номтон) ариун Кааб руу орохгүй.

3. Хэн ч ариун Каабыг нүцгэн таваф (тойрон мөргөх) хийхгүй. (Тэр үед мүшрикүүд нүцгэнээр Каабыг таваф хийдэг байлаа)

4. Хэн Аллахын элчтэй гэрээ хийсэн бол гэрээний хугацаа дуустал гэрээгээ мөрдөх гэх мэт 4 зүйлийг зарлиг болгожээ.

“Энэ өдрөөс хойш ямар ч мүшрикүүдтэй хэлэлцээр хийж, тангараг өгөдөхгүй, энэрэл өршөөл үгүй...” гэв.

Тэр өдөрөөс хойш нэг ч мүшрик Кааб руу очихоо больж бас хэн ч нүцгэнээр Каабыг таваф хийсэнгүй. Энэ зүйлийг хийсэнээс хойш мүшрикүүдийн ихэнх нь мусульман болцгоов.

Хажаа үйлдсэний дараагаар гэгээн Али ба Эбү Бакир хамт ирсэн мусуьмануудаа дагуулан Медине рүү буцацгаав.

Хижрет (их нүүдэлийн) 10 дахь жилд Алладын элч (салаллаху алейхи уа сальлам) Халид бин Велидийг 2000 цэрэгийн хамтаар Харис бин Кааб хөвгүүд гэх овог руу ислам шашиныг номлохоор илгээв. Халид бин Велид 3 хоног энэ овогийг шашинд уйгагүй уриалсанаар энэ овог эцэстээ ислам шашиныг хүлээн зөвшөөрөв. Мөн энэ жилд Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) Нижраны христүүдтэй энхийн гэрээ хийв. Энэ христүүдийн зарим нь сүүлд мусуьман болцгоожээ. Мөн энэ жил гэгээн Алигээр толгойлуулсан 300 хүний хамтаар Емен хотод байх Медлэж овгийнхоныг исламд уриалахаар илгээв. Тэд энэ саналыг нааштайгаар хүлээн авч, мусуьман болцгоожээ. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) энэ өдөр ислам шашин түгсэн бүх орноос зекет (мал хөрөнгөний өргөл барьц) цуглуулав.

Хижрет (их нүүдэлийн) 10 дахь жилд Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) Хаж (Кааб руу мөргөлд) явах гэж бэлдэж эхлэв. Асхабуудаа ч гэсэн энэ мөргөлд бэлдэцгээхийг тушаав. Мединегийн хажуу хавийнханд ч бас хэлэв. Ингээд 1000-аад мусуьман цуглав. Бэлтгэл ажил дуусахад Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) зилкаде сарын 25-ны өдөр 40000 хүнийг дагуулан үдийн намазаа (мөргөл) үйлдээд Мединегээс хөдлөв. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам): “Аяа, Аллах минь! Энэний надад худал хуурмаг ба нүд хуурахаас ангид, чамд таалагдсан нэгэн хаж болгож хайрла” хэмээн залбирав. Ихрамаа (хаж мөргөлийн хувцас) өмсөөд Жабрайлийн (алейхиссальлам) мэдээлсэнээр өндөр дуугаар Телбие хэлж эхлэв. Энэнийг асхабууд ч даган хэлэхэд газар тэнгэр Телбиегээр дүүрэв. “Леббейк! Аллахүмме леббейк! Леббейке лаа шарийка леке леббейк! Инна-л хамда вэ-и нигмете леке-уал мүлк! Лаа шерике лек!” гэх энэ Телбиег (залбирал) хэлцгээв. Пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) тахих 100 тахилийн тэмээг бас авч ирэв. 10 хоногийн урд удаан замыг туулсаны дараагаар Зилхиджэ сарын 4 дэхь өдөр Мекке хотод хүрч очив. Емен ба өөр хотуудаас хаж мөргөл хийхээр ирэгсэд ирж нийлсэнээр 124000 хол давжээ. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) Зилхиджэ сарын 8-ны өдөр Мина талд 9-ны өдөр (Арафе) Арафат талд очив. Арафат талын дунд Кусва нэрт

тэмээндээ дээрээ морьдон сүүлчийн хагацалын итгэлээ уншиж асхабуудтайгаа салах ёс гүйцэтгэв.

ХАГАЦАЛЫН ИЛТГЭЛ

...Аяа, хүмүүс минь! Миний үгийг сайтар сонсоцгоо. Магад энэ өдөрөөс хойш та бүхэнтэй хэзээ ч энд ахиж уулзахгүй байх.

Хүмүүс ээ! Энэ өдөрүүд ямар өлзийтэй бол, уг сарууд ямар бэлэг дэмбэрэлтэй бол, энэ хот Мекке ямар ариун, буянтай бол, амь нас тань, мал хөрөнгө тань, нэр алдар тань яг л тийм эрхэм бөгөөд энэ бүхэнийг янз бүрийн дарамт хүчирхийллээс хамгаалагдсан!

Асхаб минь! Хэнд гэрээс (захиас) байгаа бол эзэнд нь олгогтун. Хүүтэй хонжоогийн бүх төрөлүүд устгагдав. Гэхдээ зээлийн хүүг биш зөвхөн зээлээ л өгөгтүүн, бүү зальлагтун. Зальлан хуурах, мэхлэх хэрэгт бүү өртөгтүн, Аллахын зарлигаар бол хүүтэй зээл өгөх, авах үйлдэлийг хориглолоо. Харанхуй бүдүүлэг үеийн бүх муу муухай ёс заншилууд дарагдлаа.

Аяа, хүмүүс минь! Дайн хийхийн тулд харам сарын (дайнгүй сар) зайг өөрчиллөө. Үнэндээ буруу номлол, мухар сүсэг маш хурдацтай тархаж байна. Энэ бол кафирууд (буруу номтонууд) өөрснөө төөрөлдсөн зам юм. Нэг сар халал (дайн хийх сар) гэж нэрийдсэн сараа дараа жил нь харам (дайнгүй, энхийн сар) сар болгон зарлана. Аллахын халал (хийж болох) гэсэн зүйлийг тэд харам (хориглоно), харин харам (хориотой) гэсэн зүйлийг халал болголоо.

Ямар ч мадаггүй цаг хугацаа Аллахын бүтээсэнээр урсан өнгөрөх болно.

Аяа, хүмүүс минь! Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалж бас энэ тухай Аллахаас айхтун! Та нар эмэгтэйчүүдийг Аллахаас даатган авсан. Тэдний нэр төр ба ариун байдалыг Аллахын өмнө андгайлан өөртөө үнэнч болгогтун. Эмэгтэйчүүдийн өмнө та нарын, та нарын өмнө эмэгтэйчүүдийн эрх ашигууд бий. Та нарын эрх ашиг бол гэр бүлээ та нарын үл таалагдах хэн нэгний өмнө тавлуулахгүй хамгаалах, хэрвээ танай эхнэр таны хүсээгүй зүйлийг хийвэл тэднийг аяархан зодож айлгаж болно. Эхнэрийнхээ өмнө та нарын үүрэг бол тэднийг өмсөх, идэх зүйлээр хангах явдал.

Аяа, мусульманууд минь! Намайг сайн сонсоцгоо бас

санацгаа! Мусульман бол мусульманы ахан дүүс юм. Ийнхүү бүх мусульманууд ах дүүс боллоо. Иймд шашин нэгд ахан дүүсийн ямар нэгэн зүйлд зөвшөөрөлгүй хүрэх нь балмад үйл юм.

Аяа, асхаб минь! Өөрсдийгөө бүү хуурахтун! Та өөрөө өөртөө хүлээсэн үүрэгтэй.

Аяа, хүмүүс ээ! Аллах эзэн эрх ашигтай бүхний эрх ашигийг Куран сударт заасан билээ. Гэрээслэл үлдээх шаардалгагүй. Хүүхэд хэний оронд төрсөн л бол түүнийх. Шалиг завхай явдал үйлдэгсэдэд гэсгээл бий. Эцгээсээ өөр хүнээр овоглогсодын удам угсаа үгүй, бас эзэнээсээ өөр нэгнээс ивээл гуйгсад бол тэр заяа муут, ийм хүмүүс Аллахын гэсгээл бас бүхий л мелек ба мусульмануудын хараал идэг! Аллах эзэн ийм хүмүүсийн нүгэлийг наминчлахгүй, бас гэрээслэлийг нь ч хүлээн зөвшөөрөхгүй.

Аяа, хүмүүс минь! Та нарын эзэн бол цор ганц, эцэг тань ч ганц, та нар Адам эцэгийн үр удам. Адам эцэгийг шорооноос туурвисан юм. Аллахын хувьд хамгийн үнэ цэнтэй хүн бол тэрнээс айж сүсэглэгсэд. Арабууд араб биш хүнээс ямар ч илүүрхэх зүйлгүй илүү нь зөвхөн сүсэг бишрэлтэй хамаатай.

Аяа, хүмүүс минь! Маргааш (хойд ертөнцийн өдөр) та нараас намайг асуух болно. Та нар юу гэх вэ?"

Асхабууд: "Аллахын шашиныг түгээж, бидэнд сайн бүхэнийг захиж номлож байсан гэж гэрчлэх болно" гэгцгээв.

Энэ үгийг сонсоод Аллахын элч (салаллаху алейхи уа сальлам) маань долоовор хуруугаа дээш өргөн олон түмэнийг заан "Гэрч бол, Эзэн минь! Гэрч бол, Эзэн минь! Гэрч бол, Эзэн минь!" хэмээв.

Хайрт пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) хагацах илтгэлээ уншсанахаа дараагаар Маиде сүрегийн: "Өнөөдөр та бүхэнд шашинаа бүрэн төгс болголоо. Та бүхэнд өгөх буян хишигээ өглөө, бас та бүхэнд шашин болгож исламыг өгсөнөөр баярлалаа" гэх 3 ает илгээгдэн иржээ. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) энэ аетийг уншиж эхэлхэд Эбү Бакир уйлж эхлэв. Асхабууд түүнээс уйлсаны учирьг асуухад: "Энэ ает бол Аллахын элчийн хорвоогоос халих цаг ойртсоны дохио" гэв.

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) Меккед 10 хоног хоноглоод сүүлчийн хажаа үйлдээд сүүлчийн хагацах тавафаа (Каабыг тойрон мөргөх) үйлдээд Медине рүү буцав. Энэ хажын (мөргөл) дараагаар асхабууд ирсэн газартаа очиж элчийн

хэлсэн бүхэнийг түгээв.

Хижретийн (их нүүдэлийн) 10 дахь жилд болсон нэг зүйл бол өөрсдийгөө элч хэмээн зарласан хуурамч хүмүүс гарч эхэлжээ. Ийм хүмүүсийн нэг бол Емен хотод байх Эсвэд-и Анси юм. Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) тушаалаар Эсвэд-и Ансийг Емен хотод байх мусульманууд хөнөөжээ.

ХОРВООГООС ХАЛЬСАН НЬ

Хижретийн (их нүүдэл) 11 дэхь жил. Энэ жил Жабрайл (алейхиссальлам) сахиусан тэнгэр ирж Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) түүнд 2 удаа Куран сударыг эхнээс дуустал бүрэн уншиж өгөв. Үнэндээ урьд өмнөх жилүүдэд зөвхөн нэг удаа уншдаг байлаа. Жабрайл (алейхиссальлам) хамгийн сүүлийн авч ирсэн: “Аллахын тус дэм ба ялалт ирэн, хүмүүс Аллахын шашинд (Исламд) ар араасаа орохыг хараад, эзэндээ баярлан залбир! Түүнээс уучлал гуй! Учир нь тэр наминчлалыг үргэлж хүлээж авдаг билээ” гэсэн Наср сүрег сонссоныхоо дараагаар: “Аяа, Жабрайл! Надад үхэл ойртсоныг мэдэрч байна” гэв. Жабрайл (алейхиссальлам) энэ аетийг уншив: “Чиний хувьд хойд ертөнц энэ хорвоогоос илүү аштай. Эзэн чинь чамд баярлалаа гэх хүртэл хүссэн бүхэнийг чинь өгөх болно” (Духа сүре, 4-5)

Хайрт пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) тэр өдөр Медине дэхь бүх асхабуудаа үдийн мөргөлд Месжидед цуглахыг хүссэн мэдээ илгээв. Аллахын элч (салаллаху алейхи уа сальлам) намаз (мөргөлөө) үйлдсэнийхээ дараагаар хүмүүст нэгэн сургаал айлдав. Энэ сургаалийг сонссон хүн бүхэний зүрх догдолж уйлцгааж байв. Дараагаар нь “Аяа, хүмүүс ээ! Та нар элч болсон намайг ямар хүн гэж бодож байна?” хэмээн асуухад асхабууд: “Аяа, Расулуллах! Аллах эзэн бидний талаас чамд маш олон буян хишигээ хайрлаг. Чи бидний төлөө үргэлж санаа зовьнож, нэг эцэг хүүдээ хайртайгаас илүү хайртай билээ. Аллахын зарлигийг бидэнд хүргэж, Аллах эзэний замд исламыг түгээн дэлгэрүүллээ. Хүмүүсийг сайхан сургаалаараа уриалж дуудлаа. Аллах чамд хамгийн сайн сайхан, хамгийн дээдийн буян олгог” гэцгээв.

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам): “Аяа, мусульманууд аа! Аллахын төлөө хэн нэгэнд өр зээл, эсвэл эрх ашигийг нь зөрчсөн бол хойд ертөнцөөс урьтан одоо гомдолоо

тайлж, надаас авцгаа” гэв. Хэн ч гомдол мэдүүлсэнгүй. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) хоёр гурав дахь удаагаа энэ үгээ давтан “Гомдогсод гомдолоо тайлцгаа” гэв. Гэнэт асхабууд дотороос нэг хүн хөл дээрээ босож зогсов. Гэгээн Укаше (радиаллаху анх) Алладын элчийн өмнө очив. “Аяа, Алладын элч минь! Тебук дайнд таньтай хамт явсан билээ. Тебукээс буцах замд би таны хажууд дөрөө хавируулан явж байх үед би таньд ойртсон юм. Миний хүсэл таны гэгээн царайг ойроос харахыг хүссэн билээ. Гэтэл та гэв гэнэт ташуураараа миний нуруун дээр цохисон билээ. Юуны төлөө цохисоныг тань мэдэхгүй” гэв.

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам): “Аяа, Укаше! Аллах эзэн чамайг элчийн мэдсээр байж цохих цохилтоос хамгаалаг. Тэр үед би санаандгүй цохисон юм. Аяа, Билал, Фатима охины минь гэрээс очоод тэр ташуурыг аваад ир” гэж тушаав. Билал (радиаллаху анх) месжидээс гараад хоёр гараа толгой дээрээ барин халаглан явсаар Фатимагаас элчийн ташуурыг авч ирэв. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) ташуурыг гэгээн Укашед өглөө.

Гэгээн Омар, Эбү Бакир нар (радиаллаху анхум): “Хөөе, Укаше! Биднээс хариугаа ав, элчээс битгий аваач” хэмээн гуйцгаав. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) Эбү Бакирт хандан: “Аяа, Эбү Бакир! Боль, эндээс холд. Омар, алив, чи ч бас холд. Аллах эзэн та нарыг дээд хүн гэдэгийг мэднэ” хэмээв. Энэ үгийг сонссон Али босон: “Хөөе, Укаше! Алладын элчийг цохихыг чинь би хүлээн зөвшөөрөхгүй. Цохивол намайг цохь хүсвэл 100 удаа цохисон ч болно. Зөвхөн элчийг л битгий цохь” гэж гуйв. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам): “Хөөе, Али, чи ч гэсэн суу! Аллах эзэн чамайг ямар их өндөр заяат хүн болохыг мэдэж буй” гэв. Энэ удаа Хасан ба Хусейн босон: “Хөөе, Укаше! Чи бид хоёрыг элчийн зээ хүү нар болохыг мэднэ. Түүнээс авах өрөө биднээс ав. Биднийг цохь. Алладын элчийг л битгий цохь” гэгцгээв. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) тэдэнд “Та нар ч сууцгаа, миний хайрт хүүхдүүд минь” хэмээв. Дараа нь “Алив, Укаше! Ир, цохь” гэв.

Укаше (радиаллаху анх): “Элч та намайг цохих үед би цээж нүцгэн байсан юм” гэв. Гэхэд Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) цамцаа тайлж нуруугаа ил гаргав. Энэ үед асхабууд толгойгоо барин халаглан уйлж байлаа. “Укаше! Чи Алладын элчийн нурууг цохиж зүрхлэн гэж үү?” гэгцгээнэ. Гэгээн

Укаше (радиаллаху анх) Аллахын элчийн нуруун дээрх элчийн тамгыг (мэнгэ) хангуутаа: “Эцэг эхээ чамд өргөө, Аллахын элч минь! Өрөө авахын тулд чиний нурууг ташуурдах зориг хэнд байх билээ! Энэнийг хэн зориглон хийх юм” гээд Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) нуруун дахь элчийн тамгыг үнсэв. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам): “Үгүй, цохь, эсвэл уучил” гэв. Гэгээн Укаше (радиаллаху анх) “Амиа таньд өргөө, уучиллаа. Харин Аллах эзэн хойд ертөнцөд намайг уучлах болов уу?” гэв.

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам): “Хэн диваажин дахь миний найзыг харахыг хүсвэл энэ пир-и фание (өвгөн) рүү харцгаа” хэмээв. Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) энэ үгийг сонссон асхаб Укашегийн хоёр нүдний хооронд үнсэж эхлэв. Цөм “Чи ямар азтай хүн бэ? Аллахын элчтэй хамт байх үедээ диваажингийн дээдийг оллоо” гэгцээнэ.

Аллахын элч (салаллаху алейхи уа сальлам) маш хүндээр өвджээ. Хатгаа туссан байлаа. Өдөр ирэх тусам өвчин нь хүндэрч байлаа. Ийм нэгэн үед шөнө дунд орноосоо босож хувцасаа өмсөж явахад бэлдэв. Үүнийг харсан гэгээн Айше эх: “Аяа, Аллахын элч! Та хаашаа явж байна вэ?” гэж асуухад хорвоогийн энэрэлт элч (салаллаху алейхи уа сальлам) “Баки оршуулгын газар оршлогдсон хүмүүсийн төлөө залбирах тушаал авлаа. Тийшээ явж байна” гэв. Хажуудаа Эбү Мүвейхиб ба Эбү Рафиг дагуулан явав. Оршуулгын газар очоод маш удаан залбирч тэнд нойрсогсодийн нүгэлийг наминчлахыг Аллахаас хүсэв.

Нэг өдөр Ухудад амь үрэгсэдийн шарилд залбиран, хайр өршөөл хүсэж мөргөв. Дараагаар нь мөсжидед ирээд: “Би та нартай Кавсар булагын (Диваажингийн нэгэн булаг) өмнө бүхнээс түрүүлж уулзах, хүлээн авах хүн болох юм. Та нартай уулзахаар болзсон газар минь тэр юм. Би та нарын төлөө надаас хойш эргээд мүшрик (буруу номтон) болох вий гэж айхгүй байна. Зөвхөн эд хөрөнгөний шуналд автан нэг нэгэнтэйгээ тэмцэлдэж нэг нэгэнээ алж, та нараас өмнөх хүн төрөлхтөн хэрхэн үгүй болсон мэт гэсгээгдэн сүйрэх вий гэж айж байна” хэмээв.

Элчийн (салаллаху алейхи уа сальлам) өвчин улам хүндэрчээ. Гэгээн Айше (радиаллаху анха) эхийн гэрт хэвтэхээр болжээ. Өдөр бүр хүчтэй халуурч байлаа. Асхабууд цөм эргэж очиж элчийн энэ өвчин зовлонг хараад тэсэлгүй уйлан буцацгаана.

Эбү Сайд-и Худри (радиаллаху анх) ийн айлдав. “Нэг өдөр элчийн биеийг асууж эргэхээр очлоо. Элч орондоо хэвтэн босож чадахгүй болжээ. Түүний өвчин шаналал, халуун нь ихэсэж дээгүүр нь нөмөрсөн хөнжил нь хүртэл халуу шатаж байлаа. Би маш их гайхахын зэрэгцээ өрөвдөн мэгшхэд элч: “Хамгийн хэцүү зовлонг зөвхөн элчүүд л амсдаг гэсэн хэдий ч элчүүдийн энэ зовлонд баярлах нь, та нарын жаргалдаа баярлахаас илүү юм” гэсэн юм.

Хайрт пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) Абдуллах бин Месудед ийн айлджээ. “Мусульман хүн өвчин ирэхэд Аллах түүний нүгэлийг энэ өвчинөөр арилгана. Яг л модны навчис унах мэт түүний нүгэл цөөрөх болно” хэмээжээ.

Нэг өдөр асхабууд месжидэд цуглан Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) биеийг асуулгахаар гэгээн Алиг элч рүү явуулав. Али гэрт орж ирэхэд элч маань “Асхаб минь юу гэж байна?” гэж асуув.

Али (радиаллаху анх): “Аллахын элч биднээс явах юм бол юу болох вэ?! хэмээн маш их айн уйлцгааж байна” гэв. Асхабын гэх хайр энэрэл нь улам их пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) ийм тэсэшгүй их өвчтэй хэрнээ хүчээр босож Али ба Фадил бин Аббас хоёрыг түшин явсаар месжидед ирэв. Минбер (индэр) дээр гараад асхабдаа хандан: “Аяа, асхаб минь! Та нар намайг хорвоогоос халих байх гэж айцгааж байна. Ямар ч элч дагалдагсадынхаа хажууд мөнх үлдэхгүй. Би удахгүй эзэнтэйгээ уулзах болно. Та бүхэнд захих зүйл бол мухажируудын (Меккегээс ирсэн мусульманууд) настануудыг хүндлэн дагацгаа. Аяа, мухажир! Та нарт захих зүйл бол ансаруудад (Мединегийн мусульманууд) сайхан хандацгаа. Тэд та нарт тусласан билээ. Гэртээ урьж, өөрсдөө ядуу амьдралтай хэрнээ та нарт чадах ядахаараа тусалсан, хүндэлсэн юм. Мал хөрөнгөө та нартай хуваалцаж, хэннэгэн ансаруудад гомдох үедээ энэ тусыг нь бодоод, тэдний алдааг өршөөн уучилаг” гэв. Эбү Бакир (радиаллаху анх) Аллахын элчийн буцах цаг ойртсоныг ойлгоод “Чиний төлөө амиа өргөө, аяа, Аллахын элч минь!” гээд уйлж эхлэв. Энэрэлийн мөрөн болсон элч (салаллаху алейхи уа сальлам) “Битгий уйл, Эбү Бакир минь!” гэв. Бүх зүйлд тэвчээртэйгээр хандах ёстойг хэлэв. Өөрөө ч уйлж байлаа. “Аяа, асхаб минь! Ислам шашины төлөө үнэнч бас чин сэтгэлээсээ хамаг мал хөрөнгөө, хүчээ харамгүй өгсөн Эбү Бакирт би талархнам, хойд ертөнцөд найзаа

сонгох эрх байсансан бол би түүнийг сонгох байсан юм” гэв. Бас “Месжидэд нээгдсэн хаалгуудаас Эбү Бакирийн гаргасан халгаас бусад бүх хаалгыг хаацгаа” хэмээн тушаав.

Дараагаар нь гэгээн Айшегийн гэр лүү буцав. Асхабууд цөм уйлж гашуудаж эхэлхэд Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) ахин гэгээн Али ба Фадил бин Аббас хоёрыг түшин месжидэд ирэв. Минберийн (индэр) хамгийн доод талын шатан дээр зогсоод:

“Аяа, мухажирууд ба ансарууд аа! Цаг нь мэдэгдсэн нэгэн зүйл рүү яарахын ашиг байхгүй. Аллах өөрийнхөө ямар ч боолынхоо төлөө яардаггүй билээ. Хэн нэгэн хүн Аллахын өгсөн хувь тавиланг өөрчлөхийг, хүслээ хэрэгжүүлэхийг хүсвэл түүнийг гэсгээдэг билээ. Аллахын ариун замд (Исламд) нүд хуурч, түүнийг хуурахыг хүсэгсэдийн ажил нь үл бүтэж, өөрсдийгөө л хуурах болно. Би та бүхэнд энэрэлтэй билээ. Та бүхэн ч надтай уулзах болно. Бидний учрах газар бол Кавсар (Диваажингийн горхи) горхины өмнө юм. Диваажинд орж надтай учирхыг хүсэгсэд огт хэрэггүй газар битгий яриг. Аяа, мусульманууд аа! Кафир (буруу номтон) болох нь нүгэл үйлдэн, буян хишиг зайлахын шалтгаан болно. Хүмүүс Аллахын тушаалыг биелүүлвэл ерөнхийлөгч, амбан захирагчид бас даргууд энэ хүмүүст халамжтай ханддаг хүлцэнгүйгээр дагдаг билээ. Дээрэм, худал байдал, нүд хуурагсад ба нүгэл үйлдэгсэд шударга даргатай учирахгүй. Миний амьдрал та нарын төлөө хайр энэрэл байсан шиг миний үхэл ч мөн адил та нарын хувьд хайр энэрэл билээ. Хэрвээ би хэн нэгэнийг шударга бусаар зодож эсвэл муугаар хэлсэн бол одоо надад яг тэр зүйлийг хийцгээн хариугаа авцгаа. Учир нь хорвоогийн гэсгээл хойд ертөнцийн гэсгээлээс маш хөнгөн билээ. Хорвоод гэсгээл амсах нь амар юм” гэв. Энэ удаа гэгээн Омарыг магтан сайшаав. “Омар надтай хамт, би ч түүнтэй хамт. Надаас хойш үнэн, шударга Омартай хамт” гээд тэндээс гарч гэртээ харив.

Хорвоогийн энэрэл болсон элч (салаллаху алейхи уа сальлам) асхабуудтайгаа салах ёс гүйцэтгэхийн тулд гэгээн Билал Хабашид хандан: “Хүмүүсийг дууд! Месжидэд цуглаг. Би тэдэнд сүүлчийн захиасаа хэлмээр байна” гэв.

Билал бүх асхабыг месжидэд цуглуулав. Мухаммед элч Али ба Фадил хоёрыг түшин Месжидэд ирээд минбер (индэр) дээр суугаад, Аллахт баярласаны дараагаар: “Аяа, асхаб минь! Та нараас хагацах цаг иржээ. Хэн надад өртөй гомдолтой бол

одоо асууг, аваг, намайг хайралдаг хүн л бол одоо надаас гомдолоо тайлж авцгаа. Эс бөгөөс уучилцгаа, би Аллахын өмнө өр, зээл, гомдолгүйгээр цэвэр уулзмаар байна” гэв. Дараагаар нь минберээсээ бууж өдрийн мөргөлөө үйлдүүлэв. Намазын (мөргөл) дараа ахин минбер (индэр) дээрээ суугаад өмнө хэлсэн үгээ давтан хэлэв.

Элчийн (салаллаху алейхи уа сальлам) нас барахад 3 хоног үлдэхэд өвчин нь улам их даамжирч, мөсжидэд очиж олон түмэнтэй мөргөл үйлдэж чадсангүй. Олон түмэнтэй үйлдээгүй анхны мөргөл нь шөнийн мөргөл байлаа. Билал элчийн хаалгыг тогшин “Эс-салат, яа Расулуллах!” (Намазын цаг боллоо, Аллахын элч) гэхэд Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) орноосоо ч өндийх хүчгүй болсон байлаа. “Эбү Бакирт хэл! Асхабуудад намаз (мөргөл) үйлдүүлэг” гэв. Ингээд тэр өдөрөөс хойш элчийг амьд байх үед Эбү Бакир 17 намаз (мөргөлийг) элчийг орлож үйлдүүлжээ.

Нэг өдөр пайгамбарын маань (салаллаху алейхи уа сальлам) бие жаахан хөнгөрөхөд элч Али ба Аббасыг түшин мөсжидэд намаз (мөргөл) үйлдэхээр ирэв. Эбү Бакир элчийг ирсэнд маш их баярлан холдохыг хүссэн ч Аллахын элч (салаллаху алейхи уа сальлам) “Наанаа зогс!” гэх утгатайгаар зангав. Элч маань (салаллаху алейхи уа сальлам) Эбү Бакирийн ард нь зогсож, асхабуудтайгаа хамт сүүлчийн удаа намаз (мөргөл) үйлджээ.

Элчийг (салаллаху алейхи уа сальлам) хорвоогоос халихаас 3 хоногийн өмнө Жабрайл (алейхиссальлам) ирж: “Аяа, Расулуллах, Аллах эзэн чамд мэнд хүргэж байна. Таныг юунаас ч илүү сайн мэдэх авч таниас ямар байгааг тань асуулгаж байна” гэв. Хорвоогийн элч (салаллаху алейхи уа сальлам): “Гансарч байна” гэв.

Жабрайл (алейхиссальлам) ням гаригт ахин ирж урьтах асуултаа давтаж асуухад пайгамбар маань мөн л нөгөө хариултаа өгчээ.

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) Айше эхийн гэрт очиж хэвтэв. “Аллахын өмнө хорвоогийн мал хөрөнгөтөйгээр очмооргүй байна. Энэ жаахан алт мөнгийг ядууст тарааж өг” гэж захив. Дараагаар нь халуурч, хэсэг хугацааны дараагаар нүдээ нээн гэгээн Айшегээс алт мөнгийг тараасан үгүйг асуув. Тарааж амжаагүй байгаагаа хэлэхэд удаа дараа тарааж өг гэж хэлэв.

Айше эх алт мөнгийг ядууст тараагаад элчид мэдэгдэхэд “Одоо л сэтгэл амарлаа” гэв.

Элч (салаллаху алейхи уа сальлам) хэсэг амарсаны дараагаар гэгээн Алиг дуудуулав. Толгойгоо Алигийн өвдгөн дээр түшин хэвтэв. Нүүрнийх нь өнгө өөрчлөгджээ. Духнаас хүйтэн хөлс цутгана. Гэгээн Фатима охин нь эцгийнхээ энэ байдалыг харж зогсож чадсангүй. Хасан, Хусейн хөвгүүд рүүгээ гүйн очив. Тэдний гараас барин уйлж эхлэв. “Аяа, эцэг минь! Охиноо хэнд үлдээж байна? Хасан, Хусейн зээ нараа хэнд даатгаж байна? Аав минь! Амиа чамд өргөө! Таниас хойш би яах болж байна? Таниас өөр хэнийг харах гэж?!”

Элч (салаллаху алейхи уа сальлам) охиныхаа энэ үгийг дуулаад Фатимаг хажуудаа дуудуулав. “Аяа, Аллах эзэн минь! Үүнд тэвчээр өг” хэмээн залбирав. “Охин минь! Миний нүдний гэрэл минь! Аав нь амиа өгч байна” гэхэд Фатима цурхиран уйлж эхлэв. Али: “Фатима минь! Зогс! Элчийг битгий гомдоо” гэв. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам): “Али, орхи түүнийг, эцгийнхээ төлөө уйлаг!” гээд гэгээн нүдээ анин ухаан алдах мэт болов.

Гэрийн гадаа гашуудан хүлээж буй асхабууд элчийн өвчин маш их хүндэрсэнийг сонсоод уйлцгааж эхлэв. Сүүлчийн удаа элчийг харахыг хүсэн “хаалгаа онгойлгооч гэж гуйн, сүүлчийн удаа түүний царайг хармаар байна” гэгцгээв. Энэ үгийг сонссон элч (салаллаху алейхи уа сальлам) “Хаалгаа онгойлго” гэв. Асхабын томчууд гэрт орцгоов. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) тэдэнд тэвчээртэй байхыг хэлээд: “Аяа, асхаб минь! Та нар бол хүн төрөлхтөний хамгийн дээд нь, хамгийн буянт хүмүүс билээ. Та нараас хойш хэн ч ирсэн гэлээ та нараас урьтаж диваажинд орохгүй. Шашиныг хөл дээр нь босгогч ариун судар Куран Керимийг өөрсдийн зүг чиг заагчаа болгоцгоо. Шашины зарлиг номлолыг суралцан дагацгаа” гэв. Дараа нь “Аяа, Аллах минь, би түгээж чадсан уу?” гээд ариун нүдээ анив. Маш их хөлөрчээ. Али асхабуудад гарах дохио өгөв.

Дараагаар нь гэггэн Айше (радиаллаху анха) ирж элчээс захиас хүсэв. Элч (салаллаху алейхи уа сальлам): “Аяа, Айше минь! Гэртээ сууж өөрийгөө хамгаал” гэв. Хорвоогийн энэрэлт элч уйлж байлаа. Тэнд байгсадын зүрх нь шатаж, элэ нь эмтэрч байлаа. Гэгээн Үммү Селеме эх: “Аяа, минь! Та юунд уйлна вэ?” гэхэд “Намайг дагалдагч мусульмануудад энэрэл өршөөл

үзүүлэгдхийн төлөө уйлж байна” гэв.

Нар орой дээр гарсан байсан. Цаг нь ойртсон байлаа. Хайрт пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) гэгээн Айше эхийн цээжийг түшин хэвтэнэ. Хорвоогийн энэрэлт элч амьдралынхаа сүүлчийн мөчүүдийг өнгөрөөж байлаа. Тэрээр: “Хичээцгээ, болгоцгоо, өөрийн боолууддаа энэрэнгүй хандацгаа. Тэднийг хувцаслацгаа, хооллоцгоо, тэдэнтэй зөөлөн ярьж, мөргөлөө битгий таслацгаа. Эхнэр ба боолуудынхаа төлөө Аллахаас айцгаа. Аяа, Аллах минь! Намайг уучил! Надад энэрэл хайраа илгээ. Намайг Рефик-и алаа (дээдийн суудал) бүлэгт хүргэ” хэмээн айлдаж байлаа. Гэгээн Фатима эхийн (радиаллаху анха) нулимс үер адил болжээ. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) түүнийг өөрийнхөө хажууд суулгаад: “Охин минь, жаахан тэвчээртэй бай. Эс бөгөөс мелекүүд (сахиусан тэнгэр) чамайг даган уйлцгаана” гэв. Фатима эх нулимсаа арчив. “Охин минь! Миний амь гарахын цагт “Инна лиллахи вэ инна илайхи ражиун” гэж хэл. Фатима охин минь! Ирсэн бүх зовлонгийн эсрэг буян заяа өгөгдөнө” гэж нүдээ аниад ахин хэсэг хэвтсэнээ “Энэ мөчөөс эхлэн надад гашуудал, бас харуусал (зовлон шаналал) байхгүй. Учир нь би өнгөрөгч хорвоо ба зовлонт газараас салж байна” гэв.

Элчийн сүүлийн амьсгалууд тоологдож байлаа... Аллах эзэн Азрайлд (алейхиссальлам) (үхэгсэдийн амыг авдаг сахиусан тэнгэр) “Хайрт элчийн минь өмнө гоё дүр төрхтөйгөөр оч! Хэрэв зөвшөөрвөл түүний амийг маш зөөлхөн, бас аярханаар ав” хэмээв. Азрайл (алейхиссальлам) элчийн хаалгыг тогшив. Тэрээр хамгийн гоё хүний төрхөөр ирсэн байлаа. “Эссаламу алейкүм, аяа, элчийн гэр бүл ээ, намайг дотогшоо орохыг зөвшөөрнө үү? Аллахын хайр энэрэл та нарыг бүрхэг” гэв.

Гэгээн Айше элчийн хажууд ирж суугаад Фатимад хандан: “Энэ ирсэн хүнийг чи буцаа” гэв. Фатима гашуудалд царайтайгаар хаалганы өмнө очоод: “Аяа, Аллахын боол минь! Аллахын элч маш хүндээр өвдсөн тул таныг одоо хүлээж авч чадахгүй нь! Уучилаарай” гэв. Азрайл (алейхиссальлам) нөгөө асуултаа ахин хэлж зөвшөөрөл гуйв. Фатима ч энэ хариултаа давтав. Азрайл (алейхиссальлам) ахин зөвшөөрөл гуйхад Фатима хариултаа өөрчилсөнгүй давтав. Азрайл (алейхиссальлам) энэ удаагаа заавал орох ёстойгоо чангаар хэлэхэд Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) сонсоод: “Фатима охин минь! Ирсэн хүн

хэн бэ?” гэж асуухад гэгээн Фатима: “Аяа, эцэг минь! Хэн нэгэн хүн орох зөвшөөрөл гуйж байна. Тэр намайг айлгачихлаа” гэв. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам): “Аяа, Фатима охин минь! Ирсэн хүнийг хэн болохыг чи мэдэх үү? Тэр бол жаргалаас хагацаагч, олны сүйтгэгч, эмэгтэйчүүдийг бэлэвсэн, хүүхдүүдийг өнчин үлдээх, үхлийн мелек (сахиусан тэнгэр) Азрайл (алейхиссальлам) юм. Азрайл, дотогшоо ор!” гэв. Фатима энэ үгийг сонсоод цурхиран уйлж эхлэв.

Жабрайл (алейхиссальлам) Мухаммед элчид: “Эссаламү алейкүм, аяа, Аллах эзэний элч минь! Миний бүхий л хүсэл зорилго бол чи билээ. Үүнээс хойш ахиж хэзээ ч дэлхийд ирэхгүй” хэмээн хагацалаа илэрхийлэв.

Хорвоогийн элчийн ариун сүнс дээшлэхэд гэгээн Фатима эх бүхий л ариун эхнэрүүд нь цурхиран уйлсаар байв.

Энэ үед үгүйгээс нэгэн дуу:

“Эссаламү алейкүм, аяа, эхл-и бейт! Ве рахметуллахи вэ Берекатүх (Аллахын мэнд та нарт хүргэе. Аяа, Мухаммедын гэр бүл, Аллахын энэрэл, буян хишигийг эдлэ)” хэмээн мэндлээд “Мэдэж авцгаа, бүхий л амьд бүхэн үхлийн амтыг амсах болно бас хойд ертөнцөд та бүхэнд хариуг чинь өгөх болно” гэх Али Имран сүрегийн 185 аетийг уншив.

Энэ үгийн тэнд байгсад цөм дуулж мэндийн хариуг өгчээ. Энэ үгийг хэлсэн хүн бол Хизир (алейхиссальлам) пайгамбар байлаа.

Элчийн хорвоогоос хальсан энэ гашуун мэдээг Үммү Еймен эх хүү Усамегээр хүмүүст зарлуулав. Гэгээн Омар ба Эбү Убейде нар энэ мэдээг дуулаад месжид небид иржээ. Айше эх ба бусад эзэгтэй нар уйлж эхлэхэд месжидэд цугласан асхабууд гайхацгаан тэрхэн хугацаанд юу болоод байгааг үл ойлгон зогсоно. Тэдний тархинд цус харвасан мэт болж нүүр нь хувхай цайжээ. Гэгээн Али үхсэн мэт дуугүй болж гөлийн, Османы хэл нь татаж уйлж чадахгүй болжээ. Энэ үед Эбү Бакир гэртээ байжээ. Энэ гашуудалт мэдээг дуулаад гүйсээр элчийн гэрт орж ирээд элчийн нүүрийг нь хучсан даавууг сөхөж үзэв. Элчийн (салаллаху алейхи уа сальлам) ариун царай нь гэрэлтэн туяарч байлаа. “Нас барах чинь амьд мэт ямар гоё юм бэ? Аяа, Расулуллах!” гэж хэлээд үнсэв. Маш их уйлж гашуудав. Гэгээн нүүрийг нь бүрхэж чимээгүй мэгшинэ. Дараагаар нь месжид-и небид ирэн минбер (индэр) дээр гараад тэнд байх бүх асхабуудад хандан үг хэлэв. “Мухаммед элчид

итгэсэн хүн бүр сонсоцгоо. Мухаммед (aleyхиссальлам) нас нөгчижээ. Аллах эзэндээ мөргөн залбирдаг хүн бүр сонсоцгоо. Тэр (Аллах) бол хайя (амьд) бас баки (үхэшгүй мөнх) юм” гэж хэлээд үгээ үргэлжлүүлэн: “Мухаммед (aleyхиссальлам) элч юм. Түүнээс өмнө ч элчүүд ирсэн. Тэр ч үхэх болно. Нас барвал эсвэл алуулвал та нар шашинаасаа гарцгаах уу? Шашинаасаа гарсан хүн байвал Аллах эзэнд хор хөнөөл учруулахгүй, өөртөө л хор хөнөөл учруулна. Шашинаасаа гараагүйчүүдэд Аллах буяг хишигээ хайрлана” гэх Али Имран сүрегийн 114-р аетийг уншив. Асхабуудад сургаал хэлж тэднийг тайвшруулав. Ийнхүү цөм Аллахын элч (салаллаху aлейхи ya cальлам) нас барсанд итгэцгээв. Гашуудал ба харуусал асхабуудын зүрхэнд зоогдсон чинжаал хутга мэт зовооно.

Асхабууд юун түрүүнд бүхий л ажил үүрэгийг захирч явуулах тэргүүнээ Эбү Бакирийг сонгов. Түүнд итгэн амлалтаа өгцгөөж, түүнийг дагахаар амлацгаав.

Мухаммед элч (салаллаху aлейхи ya cальлам) хижретиин (их нүүдэлийн) 11 дэхь жилд (манай эриний 632 онд) Реббий-л эввэл сарын 12нд даваа гаригийн өглөө таалал төгсжээ.

Элчийг гэгээн Али, гэгээн Аббас, гэгээн Фадил бин Аббас, гэгээн Кусем бин Аббас, гэгээн Усеме бин Зейд, гэгээн Салих нар (радиаллаху анхум) угаалга үйлдүүлэв. Угаах үед түүний ариун биенээс гоё үнэр тархсан бөгөөд одоог хүртэл тийм гоё үнэр байхгүй бизээ. Дараа нь кефенийг (согтосыг булшинд оршуулахад ороох давуу) нь өмсгөж, нэгэн дамнуурган дээр зөөн мeсжидэд авч ирэв. Хүн бүр мeсжидээс гадагш гарав. Мелек (сахиусан тэнгэр) бүлэг бүлэгээрээ ирцгээн намазыг (нас барсан хүнд хийгдэх шашины үйлдэл) нь уншив. Мелекүүд уншиж дууссаны дараагаар нэгэн дуу: “Орцгоо, элчийнхээ жаназа намазыг уншицгаа” гэв. Асхабууд дотор орж имамгүйгээр намазыг уншив. Асхабууд олон болохоор лхагва гаригийн орой л дуусацгаав.

Асхабууд пайгамбарын (салаллаху aлейхи ya cальлам) булшыг малтахдаа Эбү Бакирт хэлсэн нэгэн сургаал үгийг нь дагав: “Элчүүд амь тавьсан газартаа булшлагддаг” Эбү Талха-и Ансаригийн лахд хийн ухсан булшинд лхагва гаригийн орой оршуулав. Гэгээн Аббасын хүү Кусем булшны ажилыг дуусгаад хамгийн сүүлд гарав. Тэрээр: “Мухаммед элчийн ариун царайг хамгийн сүүлд үзсэн хүн бол би. Түүний ариун уруул нь үл ялиг хөлдсөн байлаа. Би толгой чихээ ойртуулан чагнахад: “Аяа, эзэн

минь! Дагалдагсад минь! Аяа эзэн минь! Дагалдагсад минь!..” хэмээн залбирч байлаа.

Элчийг хорвоогоос хальсан тэр өдөр Абдуллах бин Зейд: “Аяа, Аллах минь! Би энэ нүдийг чиний элчийг үзэж байхын тулд гуйсан билээ. Одоо тэр элч алга боллоо. Тиймээс надад одоо нүд хэрэггүй. Аллах минь нүдийг минь ав!” хэмээн залбиран сохор болжээ.

Шашинаасаа гарах үзэгдэл

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) нас барсаны дараагаар иртад (шашинаасаа гарах) үзэгдэл эхэлжээ. Ийм хүмүүс олширч эхлэхэд тэдэнтэй Эбү Бакир (радиаллаху анх) тэмцэж байлаа. Хэрэв ийм хүн байгаагүй бол Арабд энэ үзэгдэл газар авах байлаа. Гэгээн Айше: “Аллахын элч амь өргөсөний дараагаар арабууд шашинаасаа гарч эхэллээ. Эцэгийн минь (Эбү Бакир) нуруун дахь ачаа хэрэв уулан дээр буусан бол тэр уулууд эвдрэх байлаа” гэв.

Эбү Хурейре (радиаллаху анх): “Хэрвээ Эбү Бакир байгаагүй байсансан бол Мухаммедын дагалдагсад цөм гэсгээл хүртэн устах байлаа” гэв.

Гэгээн Айше (радиаллаху анха) ийн айлджээ: “Эцэг минь Эбү Бакир арабууд шашинаасаа гарч эхлэх өдөрүүдэд сэлэмээ сугалан мориндоо мордоход гэгээн Али хажууд нь очоод морьныхон цулбуураас нь барин аваад “Чамд Аллахын элч Ухуд дайнд хэлсэн үгийг хэлж байна. Сэлэмээ хуйдаа хий, өөрийгөө аюулд түлхэн биднийг зовлонд битгий унга! Амлан хэлье, чамд ямар нэгэн гай зовлон тохиолдвол, чамаас хойш ахиж исламын суурийг захих хүн гарахгүй” гэв.

Гэгээн Айше бас ийн айлджээ: “Аллахын элчийг хорвоогоос хальсаны дараагаар олон араб отог овгууд шашинаа орхиж эхэллээ. Жүүдүүд, христүүд, бас мунафик (хоёр нүүртэнүүд) олширч эхлэв.

Мусульманууд аадар бороонд туугдсан хонь мэт тархан одоцгооно. Тэр үед Мекке хотын олон хүмүүс шашинаасаа гархад бэлэн болсон байлаа. Сүхейл бин Амр Меккед Каабын өмнө зогсон мусульмануудад сургаалаа хэлэн тэднийг шашинаас гарахыг нь зогсоов. Тэр ийн хэлэв:

“Хөөе, Меккегийн ард аа! Та нар мусульман бологсодын

сүүлчийн хүмүүс билээ. Тийм болохоор шашинаасаа гарагсадын эхний хүмүүс битгий болцгоо! Алладын нэрээр амлая! Алладын элчийн сургасанчлан энэ шашин заавал хүчирхэгжинэ. Тэр айлдахдаа: “Надтай хамт Лаа илааха иллаллах гэж хэлцгээ. Та нарыг хараад бүх арабууд шашинд орж араб биш хүмүүс алба татвар төлцгөө! Алладын нэрээр амлая! Кисра ба Кайзер хотын эрдэнэсийн сан Алладын ариун шашины төлөө хэрэглэгдэх болно” хэмээн айлдсаныг та бүхэн сонссон билээ. Би Алладын нэрээр тангараглая! Нар мандаж бас жаргаж байгаа цагт энэ шашин унтрахгүй, үргэлжилсээр л байх болно. Та нарын дотороос муу санаат хүмүүст битгий хууртацгаа. Миний мэдэх зүйлийг тэд ч мэдэж байгаа.

Гэвч хүмүүсийг итгэл буцран нүдэнд нь урьдийн адил цог жавхаа харагдахаа больжээ. Энэ бүхэнийг харсан Сүхейл:

«Хөөе, хүмүүс ээ, би бол курейш овгийн толгой өвгөн билээ. Та нар надад итгэцгээ. Алладын нэрийг барьж зекетээ өгцгөө. Хэрвээ ислам шашин унтарвал би та нарын өргөлийг буцаан өгөхөө амлаж байна” гэж хэлээд уйлав.

Ийнхүү Меккегийн ард түмэн шашинаасаа гарах нь буруу үйл төдийгүй том нүгэл болохыг сая нэг ойлгов. Ингэж нэг Меккегийн хотын амбан захирагчаар Аттаб бин Есидийг томилов.

БУЛШИНЫ АМЬДРАЛ

Булшиндаа амьд байх нь

Элч (салаллаху алейхи уа сальлам) бидний мэдэхгүй нэгэн амьдралаар булшиндаа амьд юм. Шахид ба Эвлия (Алладын найз) нар ч мөн адил амьд. Үнэндээ тэд амьд юм. Имран сүре 169 аетэд ийн айлджээ. “Алладын ариун замд амиа өргөгсөдийг үхсэн гэж битгий бодоцгоо! Тэд эзэнийхээ хувьд бол амьд. Буян хишигээ хүртэгсэд” хэмээжээ.

Энэ ает бол шахидуудийг амьд байгааг мэдээлж байна. Элчүүд шахидуудаас аль ч талаараа дээд, урьд нь билээ. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) сүүлчийн удаа өвдөхдөө: “Хайбер дайнд идсэн хортой хоолны хор хөнөөл одоо болтол амтагдаж байна” хэмээжээ. Энэ үгнээс хархад Мухаммед элч ч шахид (Алладын замд амиа өгөгч) болсон нь мэдэгдэж байна.

Өөр нэгэн хадис шерифт (Мухаммед элчийн сургаал үг): “Аллах эзэн шороонд элчүүдийн цогцсыг залгихыг нь хориглосон юм” хэмээжээ.

Өөр нэгэн хадис шерифт (Мухаммед элчийн сургаал): “Надаас мэнд мэдэхийн цагт Аллах эзэн миний сүнснийг надад буцааж өгдөг бөгөөд би мэндэд нь хариулдаг” хэмээжээ.

Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) булшиндаа амьд болохыг мэдэгдсэн хадис шериф маш олон байгаа. Жишээ нь: “Миний булшны хажууд надад уншсан ерөөлийг би сонсдог. Харин холоос надад ерөөл уншигсадыг надад мэдэгддэг” хэмээжээ.

Абдуллах бин Аббасийн Ибн-и Эбуд Дуниягаас хүргэсэн хадис шерифт: “Хэн нэгэн хүн танилынхаа булшинд очоод мэндлэх юм бол цогцос түүнийг таниад бас мэндэд нь хариулдаг. Танихгүй цогцост мэндлэх юм бол тэр баярлаж, буян болно” хэмээжээ.

Ибрахим бин Бишар: “Би нэг удаа хаж мөргөлд явж ирчихээд Мединед байх элчийн булшыг эргэсэн юм. Элчийн булшинд ирээд мэндлэхэд “Уа алейкумуссалам” гээд мэндийг хариуг өгөхийг сонссон билээ” гэжээ.

Бекир бин Абдуллах Музенигийн бидэнд авч ирсэн хадист (Мухаммед элчийн сургаал) ийн айлджээ. “Миний амьд ахуй цаг та нарт буян юм. Надад ойлгуулж, би ч та нарт ойлгуулах болно. Намайг нас барахад үхэл маань ч гэсэн та нарт буян юм. Хэрэв та нар сайн үйлс хийвэл надад мэдэгдэнэ. Харин би Аллахдаа талархалаа илэрхийлнэ. Хэрвээ муу нүгэл хийвэл би та нарын төлөө Аллахдаа залбирна” хэмээжээ.

Аллахын элчийг харах нь

Аллахын элч (салаллаху алейхи уа сальлам) унтаж байхад эсвэл сэрүүн байхад харагдаж болно. Хэрвээ харвал яг тэр өөрөө мөн үү? Өөр хүн үү? Энэ талаар ислам эрдэмтэд янз янзын хариуг өгдөг.

Түүнийг булшиндаа амьд болохыг ислам эрдэмтэд цөм нэгэн дуугаар зөвшөөрсөний дараагаар түүнийг харагддаг болох талаар ч цөм айлджээ. Энэ нь үнэн болохыг хадис шерифээр (Мухаммед элчийн сургаал үг) бас батлаж болно. “Намайг зүүдэндээ үзсэн хүн зөв харжээ. Учир нь чөтгөр шулам миний

дүр төрхөнд орж чаддаггүй” хэмээжээ.

Ибрахим Лекайни ийн айлдаж байна: “Хадис эрдэмтэдийн ихэнх нь Мухаммед элчийг зүүдэндээ бус сэрүүн байхдаа ч гэсэн харагддаг, харсан талаар айлджээ. Иймэрхүү жишээнүүд ч маш олон бий:

Мүйнүддин-и Чашти гэх гэгээнтэн очсон газар болгоныхоо оршуулагын газар очиж тэнд үхэгсэдийг хойноос Куран судар уншиж залбирдаг байлаа. Тэнд очсон газараа олонд танигдаад ирэхийн цагт тэр газараасаа зугтаан оддог байв. Нэг удаа Меккед ирээд хаж мөргөлөө үйдсэний дараагаар Медине рүү очив. Мухаммед элчийн маань (салаллаху алейхи уа сальлам) булшинд очиж эргэхэд бунхнаас: “Мүйнүддин Чаштийг дууд” гэх нэгэн дуу гарав.

Энэ дууны дараа бүх бунханы ажилчид “Мүйнүддин” гээд орилож эхлэв. Би энэ дууг сонсоод: “Та аль Мүйнүддинийг хэлээд байна! Энд Мүйнүддин маш олон байна” гэхэд хоёр удаа “Мүйнүддин Чаштийг дууд” гэж хэлэв. Энэ дууг сонсоод Мүйнүддин Чашти маш их балмагдан сандрахын зэрэгцээгээр баярын нулимс унаган уйлж байлаа. Тэрээр салават (Мухаммед элчид мэнд ба залбирал хэлэх) уншиж хайрт элчийн бунханд ойртон очоод тоомоотойгоор хоёр гараа урдаа барин зогсов. Энэ үед “Хөөе, Кутб-и мешайх! (агуу эрдэмтэн) Дотогшоо ор!” гэж хэлэв.

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) ийн айлдав. “Чи миний шашинд зүтгэгч хүн. Чи Энэтхэг рүү явах ёстой. Тэнд Эжмир гэх нэгэн хот бий. Тэнд миний хүүхдүүд (үр хүүхдүүдээс минь) Сейд Хусейн гэх хүн бий. Тэр тийшээ дайн ба ялалтын төлөө явсан билээ. Тэр одоо шахид (амь үрэгдсэн) болсон. Эжмир кафирийн гарт орох гэж байна. Чамайг тийшээ очсоны буянаар ислам шашин тэнд дэлгэрэх болно. Мөн кафирууд аргаа барж хүчгүй болно” дараагаар нь нэг анар мод өгөв “Энэ анар руу сайн хар, явах зүг чигээ олж ав” хэмээв.

Мүйнүддин Чашти гэгээнтэн Мухаммед элчийн өгсөн анар модыг аваад зарлигласанчлан нар мандахаас нар жаргах хүртлэх газрыг харав.

Ислам шашины хамгийн том эрдэмтэн хоёр дахь мянган жилийн мүжеддиди Имам-и Раббани Ахмед Фарук Сэрхенди гэгээнтэн ийн айлджээ: “Рамазан (мацаг сар) сарын сүүлчийн 10 хоногт маш сайхан, юутай ч зүйрлэшгүй нэгэн гайхамшиг болов.

Би орондоо хэвтэж байлаа. Нүдээ анихад орон дээр хэн нэгэн хүн ирж суухыг мэдрэв. Намайг нүдээ нээхэд хорвоогийн сүүлчийн элч миний орон дээр сууж байлаа.

Тэр надад “Чамд зөвшөөрөлийн диплом бичихээр ирлээ. Чамаас өөр хэнд ч ийм зөвшөөрөл олгоогүй билээ” Би тэр зөвшөөрөлд энэ хорвоод хамаарагдах их хишиг, нөгөө талд нь хойд ертөнцөд хамаарагдах маш олон буян бичигдсэн байхыг харлаа”

Зүүдэндээ Мухаммед (алейхиссальлам) элчийг харсан хүн жинхэнэ тэрнийг л харсан нь гарцаагүй. Ягаад гэвэл чөтгөр түүний дүр төрхөнд орж эс чадна. Аллахын элчийг танихгүй хүн энэнийг ялгах нь амар биш.

Эбү Хурейре (радиаллаху анх) элчийн (салаллаху алейхи уа сальлам) нэгэн хадис-и шерифийг (Мухаммед элчийн сургаал үг) хэлжээ. “Хэн нэгэн хүн Жума өдөрийн орой (Пүрэв гараг) 2 рекать мөргөл үйлдвэл, рекать бүрт нэг Фатиха сүре ба Аят-ул күрси бас Ихлас сүрег 15 удаа уншвал, дараа нь намазын дараагаар 1000 удаа “Аллахүммэ салли алаа Мухаммеден небийл үм-мий” гэж хэлвэл ирэх Жума (баасан гараг) хүртэл намайг (Мухаммед элчийг) зүүдэндээ харах болно. Тэр хүний өнгөрсөн ба ирээдүйн бүх нүгэл нь наминчлагдана. Диваажин намайг харагсаад бий”

Зиярат (Энэрэлт элчийн булшинд очиж үзэх)

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) ийн айлджээ: “Хэн нэгэн миний үхэлээс хойш намайг эргэн ирэх юм бол, намайг амьд ахуйд минь эргэн ирсэнтэй адил” гэжээ. “Мират-и Медине” гэх номонд байх нэгэн хадис шерифт: “Миний булшийг эргэн ирэгсэдэд би хойд ертөнцөд шафагат хийх үүрэгтэй” хэмээжээ.

“Мүслим-и шериф” гэх хадисын номонд нэгэн хадис шериф бий: “Хэн нэгэн намайг эргэхээр ирвэл түүнд өөр ямар ч зорилго байхгүй бол, хойд ертөнцөд түүнд туслах тусламжийг минь олж авсан болно” хэмээжээ. Энэ бүх хадис-и шерифүүд (Мухаммед элчийн сургаал үг) элчийг эргэхээр Мединед ирсэн бүх хүнд пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) хойд ертөнцөд туслахыг харуулсан байна.

Тийм болохоор бүхий л исламын эрдэмтэд Меккед хажын үүрэг гүйцэтгэсэний дараагаар Мединед ирж элчийн бунханд

мөргөл үйлдэн залбирдаг уламжлалтай билээ. Одоо ч гэсэн хаж мөргөлд цөм энэн шиг заавал Мединед очин элчийн (салаллаху алейхи уа сальлам) бунханыг эргэдэг юм.

Аллахын элчийн бунханы шарилийг эргэхээр очсон хүн маш их салават (Мухаммед элчид мэнд ба залбирал хэлэх) хэлэх ёстой. Ингэж уншсан салават цөм Мухаммед элчид (салаллаху алейхи уа сальлам) хүрдэг болохыг олон хадист айлджээ.

Элчийн хот болох Медине хот холоос үзэгдэж эхлэхэд л салават (Мухаммед элчид мэнд ба залбирал хэлэх) уншиж эхлэх ёстой. Хот руу эсвэл Медине рүү орохоос өмнө бүх биений угаалга үйлдвэл өлзийтөй, тос үнэртэн түрхэж, цэвэр шинэ хувцас өмсөх нь буянтай үйл. Ягаад гэвэл энэ бол хүндэтгэлийн илэрхийлэл юм. Медине хот руу даруухан бас чимээгүй орох ёстой. “Бисмиллахи вэ алаа миллети Расулуллах” гэж хэлсэний дараагаар Ибра сүрегийн 80 дахь аетийг нь унших нь сайн. Тэрний дараагаар “Аллахүмме салли алаа Мухаммедин вэ алаа аали Мухаммед” гэнэ. Дараа нь Аллахын элчийн минберийн (индэр) хажууд хоёр рекать (үе) тахия-түл месжид буюу Месжидийн мэнд гэх намаз (мөргөл) үйлдэнэ. Минберийн (индэр) багана баруун мөр тус ирэхээр зогсоно.

Хайрт пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) энд намаз мөргөлөө үйлддэг байсан юм. Энэ газар бол элчийн булш ба минбер (индэр) хоёрын хоорондын хэсэг. Мухаммед элч нэгэн хадис-и шерифт (сургаал үгэндээ) “Миний булш ба минбер хоёрын хооронд диваажингийн цэцэрлэг бий. Миний минбер диваажингийн булагийн дээр оршдог” хэмээжээ. Ингээд энэ их буян хайрласанд залбирч мөргөх ёстой. Дараагаар нь Мухаммед элчийн булшны өмнөөс харж зогсох ёстой. Мухаммед элчээс 2м хэртэй зайтай зогсож Аллахын Куран сударт айлдсанчлан Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) амьд бас өмнө нь биеэрээ сууж байгаагаар төсөөлөн боловсон байдалаар зогсоно.

Элч (салаллаху алейхи уа сальлам) түүнийг харж, сонсож, мэндийг хариуг өгч чадна гэж бодох хэрэгтэй. Учир нь элч маань “Хэн миний булшний өмнө ирж надтай мэндлэх юм бол би түүнийг сонсдог” хэмээжээ. Дараа нь “Эссаламу алейка, яа расулуллах” гэж мэндэлнэ. Залбирч эхлэнэ.

Аяа, Расулуллах! Аллах чамайг хамгаас дээдийн газарт өргөг, намайг чиний жинхэнэ дагалдагсад болж, хойд ертөнцөд

чиний дапбааны доор цуглах үнэнч мусульмануудын дунд байлгаж хайрла, Аллах минь! Аяа, пайгамбар минь! Хойд ертөнцөд Аллахын өмнө бидэнд туслаач. Аяа, пайгамбар минь! Чи биднийг чиний шашинаар амьдарч, чиний шашинд байхдаа үхэхийг, хойд ертөнцөд чамтай хамт Махшарын талбайд байхыг, чиний уснаас ууж, чамтай хамт диваажинд орохыг хүсээч” хэмээн залбирах ёстой бас: “...Аяа эзэн минь, биднийг, бас биднээс өмнө өнгөрөгсөдийг уучилж нигүүлс, итгэгсэдийн зүрхийг битгий хиртүүл! Үнэндээ чи энэрэл бас өршөөлийн эзэн билээ!” гэх Хашр сүрегийн 10 дахь аетийг уншина.

Дараагаар нь элчийн шарилаас хагас метрийн зайд гэгээн Омарын шарил буй. Тэрний өмнө очоод “Эссэлэмү алейка, яа, Эмир-эл мүминин” гэж мэндлэх ёстой. “Аллах чамд дээдийн заяаг өгөг. Чи амьд ахуйдаа ч, нас барсаныхаа дараа ч мусульмануудад туслаж, зөв даруу хөтлөж байлаа. Аллах эзэний хайр энэрэл чамайг тойрон хүрээлэг” хэмээн түүний өмнө залбирна.

Дараагаар нь гэгээн Эбү Бакирийн шарил буй, түүний өмнө зогсоод бас л “Эссэлэмү алейка, яа, Эмир-эл мүминин” гэж мэндлээд тэрний төлөө Аллахт залбирна.

Дараагаар нь өөртөө, эцэг эхдээ, бас залбирахыг хүсэгчидэд, бүхий л мусульмануудад болон эх орныхоо төлөө залбирна. Дараагаар нь Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) минберийн (индэр) хажууд ирээд Эбү Лүбабе өөрийгөө хүлж, Аллахаас уучлал гуйсан тэр баганы хажууд хоёр рекать (үе) намаз (мөргөл) үйлдэнэ. Аллах эзэнээс энэрэл өршөөл гуйна. Дараагаар нь Равда-и Мутаххарад ирнэ. Энэ бол тэг дөрвөлжин газар юм. Энэ газар хүссэнээрээ намаз үйлдэж, залбирч тасбих (эрх) татаж болно.

Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) журамт эхнэрүүдийн өрөө нь Хүлие-и Сагдет Каабын зүгт нийлэх хэсэгхэн газар бий. Тэнд эргэхээр очигсод Каабын эсрэг зогсоход өмнө талд элчийн ариун гэргий нарын өрөө харагдана. Тийшээ харан мэндлэн бас залбирал үйлдэнэ.

Тауассул
(Пайгамбарыг маань хооронд тавьж
Аллахт залбирах)

Мухаммед элчид (салаллаху алейхи уа сальлам) үргэлж, бүтээгдхээс өмнө, бүтээгдсэнийх нь дараа хорвоо дахь амьдрал ба үхлээс нь хойш Берзах булшны амьдралд тауассул хийгдэнэ. Хойд ертөнцөд дахин амилуулсаных нь дараа Арасатын талбарт бас диваажинд тауассул хийх (өмгөөлөх) эрхтэй юм. Өмгөөлөх шалтгаан нь Аллах эзэний хажууд ойртох, буянаа арвижуулахын тулд учир шалтгаан болох зүйл юм.

Мухаммед элчид (салаллаху алейхи уа сальлам) найдан даатгах, өөрөөр хэлбэл, Аллахын элчээр дамжуулан Аллахын хувьд үнэ хүндлэл олж авах ба элчийн тусламж ба шафагатыг (өмгөөлөл) гуйж болно. Ингэж тусламж гуйхыг ямар ч мусульман эрдэмтэд муухайд тооцоогүй. Одоог хүртэл өөр буруу үзэлтнүүдээс гадна энэнийг хүлээн зөвшөөрөөгүй хүн хараагүй билээ.

Хүн төрөлхтөний эцэг Адам (aleyхиссальлам) пайгамбар дэлхийд залран ирэх үед Пайгамбарын маань (салаллаху алейхи уа сальлам) хүндэтгэлд гэж залбирсан. Энэнийг Мухаммед элч ийн айлдан тайлбарлажээ: “Адам (aleyхиссальлам) пайгамбарын газарт буухдаа, өөрөөр хэлбэл, диваажингаас хөөгдөхдөө: “Аяа, Аллах минь, намайг Мухаммедийн нэр үнэ хүндийг бодож уучлаач!” хэмээн залбирчээ. Аллах эзэн: “Аяа, Адам! Чи Мухаммедийг яаж мэдээв? Би түүнийг туурвиагүй байгаа” гэхэд Адам: “Аяа, Эзэн минь! Та намайг туурвиад, надад амь өгсөний дараагаар намайг нүдээ нээхэд өмнө маань “Лаа илааха иллаллах, Мухаммедүн расулуллах” гэсэн бичигийг харсан юм. Чиний хамгаас хайрлах хүн тэр мөн гэж ойлголоо” гэв. Аллах эзэн: “Тийм ээ, Адам минь! Бүхнийг туурвигсадаас хамгийн их хайрладаг хүн бол тэр. Тэрний нэрийг барин өршөөл гуйсан болохоор чинь өршөөлөө” хэмээжээ..

Энэнтэй холбоотой маш олон жишээ бий. Жишээ нь:

Хоёр нүд нь сохор нэгэн хүн хараатай болохыг хүсэн залбирчээ. Аллахын элч: “Хэрвээ чамайг хүсвэл би залбиръя. Гэхдээ чамд өлзийтэй нь тэвчээд энэ хэвэндээ үлдэх явдал” гэв. Тэр: “Надад тэвчих хүч алга, та залбираач” гэж гуйв. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам): “Тийм бол угаалга үйлдээд

энэ залбиралыг унш!” хэмээв. “Аллахүмэ инна эсэлүка вэ этевежжехү илайка би небиика Мухаммеден нэбийр рахмет-и. Яа, Мухаммед! Инни этевежжехү бика илаа Рабби фихажети литақдие Аллахүмма шефихү бика фийе”.

Тэрхүн энэ тарнийг уншин залбираад Аллах эзэн таалалдаа авч хараа орсон тухай хадис эрдэмтэд хэлж байна.

Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) өмгөөлөлийн талаар Осман бин Ханеф ийн айлдаж байна: “Гэгээн Осман бин Аффан халифе (мусульмануудын тэргүүн) байхдаа маш их гэр бүлийн зовлон гачигдалтай нэгэн хүн мусульмануудын тэргүүнд бараалхахдаа ичдэг байсан болохоор надад зовлонгоо тоочсон юм. Би түүнд одоохон угаалга үйлд, тэгээд дараа нь Мухаммед элчийн шарилд оч. Дээр нь бичигдсэн тарнийг уншаад хүсэлээ шивнэ” гэлээ.

Нөгөө хүн миний хэлсэнчлэн тарни уншсаныхаа дараагаар мусульмануудын тэргүүн байсан газрыг хайж олж ирэхэд тэргүүн Омар тэр хүнийг өрөөндөө авч асуудлыг нь сонсжээ. Нөгөөх хүний ажил ч амжилттай бүтсэнийг хараад даруйхан надад ирж “Аллах чамд баярлаг! Мусульманы тэргүүнд чи хэлээгүй байсан бол би зовлонгоосоо салж чадахгүй байлаа” гэв. Тэрээр намайг Омар тэргүүнтэй уулзсан гэж боджээ.

Исламын суут эрдэмтэн Эбү Абдуллах Мухаммед Мэракеши (683\1284) өөрийн «Мисбах-үз зүлам» гэдэг номондоо Мухаммед элчийг (салаллаху алейхи уа сальлам) дамжуулагч болгон залбирлал нь биелсэн тухай зөндөө жишээнүүдийг бичжээ. Жишээ нь: “Нэгэн хүн аавд минь 80 алтан зоосоо үлдээгээд дайнд явсан юм. “Эд нарыг хадгал! Маш их ядуу хүнд туслаж болно” гэж хэлсэн юм. Медине хотод тэр жил маш аймар ган гачиг болсон юм. Аав минь нөгөө алтуудыг өлсгөлөн хүмүүст тараасан юм. Гэтэл удалгүй алтны эзэн ирж хадгалуулсан алтаа асуулаа. Аав минь: “Нэг хоногийн дараа ир” гэж хойшлуулав. Үнэндээ тэрэнд өгөх ганц алтан зоос байхгүй байсан юм. Тэр орой аав минь элчийн шарилан дээр өглөө болтол Аллахын элчээс залбиран гуйж хоносон юм. Шөнө дунд нэг хүн гэрт ирээд надад “Гараа дэлгэ” гэлээ. Тэгээд надад нэг хүүдий алт өгөөд алга болов. Аав ирэхэд би нөгөө ууттай алтыг өгөхөд тоолж үзээд яг 80 ширхэг байхаар нь баярлаж тэр дороо эзэнд нь өгсөн юм.

Имам-и Эбү Бакир-и Мукри нэг өдөр Имам-и Табрани ба Эбү Шейхтай цуг месжидэд сууж байлаа. Тэд нар хэд хоног огт

юу ч идээгүй болохоор маш их өлсөж байв. Имам-и Эбү Бакир тэсэлгүй “Өлсөж байна, аяа, пайгамбар минь!” гэж хэлэв. Хэсэг хугацааны дараа хаалга онгойн Мухаммед элчийн үр удмын нэг хүн хоёр үйлчлэгчийн хамтаар гартаа том цар тавганд хийсэн хоол бариад орж ирээд: “Дүү минь! Миний өвөө Аллахын элчээс өлссөн болохоор тусламж гуйсан юм байна. Тэр надад та нарыг цатгахыг тушаалаа” гэв. Авч ирсэн хоолыг хамтдаа цадталаа идэцгээж үлдсэнийг нь тэндээ үлдээгээд оджээ.

Ахмед бин Мухаммед Суфий ийн өгүүлж байна. Нэг удаа би Хижаз цөлд явж байхдаа хамаг бүхэнээ алдаж хоосон хоцорсон юм. Маш их ядарч зүдэрч явсаар байгаад Медине хотод ирлээ. Элчийн бунханы хажууд ирээд ус уугаад ядарсандаа нэг баганыг түшээд унтчихсан байв. Зүүдэнд минь Аллахын элч хажууд минь ирээд “Ахиад ирээ юу? Алив алгаа тос” гэж хэлээд миний алганд дүүрэн алт тавилаа.

Имам-и Семхүүдий нэг өдөр гэрийнхээ түлхүүрийг гээчихжээ. Хайгаад хайгаад огт олж чадсангүй. Тэгээд элчийн бунхан дээр ирээд “Аяа, Расулуллах, би гэрийнхээ түлхүүрийг гээчихжээ” хэмээн залбирч дуусаагүй байхад нэг хүү гартаа түлхүүр барин орж ирээд “Энэнийг оллоо, таных биш биз?!” хэмээн зогсов.

Аббаси гүрний тэргүүн Эбү Жафер Менсур, Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) месжидийн дотор Имам-и Маликтай ярилцаж суулаа: “Аяа, Менсур! Энэ газар бол элчийн бунхан. Нам дуугаар ярь! Аллах эзэн Хужурет сүренд: “Та нар Аллахын элчийн хажууд ярихдаа дуугаа тэрнээс чангаар бүү ярь” хэмээн ардыг буруушаасан юм. “Аллахын элчийн хажууд нам дуугаар ярих ёстой” гэх аетээр нам дуугаар ярихийг магтсан юм.

Аллахын элч (салаллаху алейхи уа сальлам) “Нас барсаны дараа ч хүндлэл үзүүлэх нь амьд байхад нь хүндлэл үзүүлсэнтэй ижилхэн” гэв. Менсур толгой гудайлган “Аяа, Имам Малик! Би Кааб руу харж зогсох уу? Элч рүү харах уу?” гэж асуухад Имам-и Малик: “Аллахын элчээс нүүр битгий буруул! Хойд ертөнцөд шафагат хийх (өмгөөлөгч болох) тэр пайгамбар маань хойд ертөнцөд чиний авга эцэг Адам пайгамбард ч хүртэл өмгөөлөн туслах болно.

Элчийн (салаллаху алейхи уа сальлам) булш руу харж зогсоод Аллахын элчийн сүнсэнд хорогдон ийн хэл: “Өөрсдийгөө

нүгэлд унгаагаад чамд ирээд. Аллахын өршөөл хүсвэл, бас чамд хандан Аллагаас өршөөл гуйхыг хүсвэл Аллах эзэн тэдний нүгэлийг наминчлагч бас энэрэл үзүүлэгч байх болно” (Ниса сүрегийн 64-ает) гэв.

Ийнхүү Имам-и Маликийн халифе (тэргүүн) Менсурт хэлсэн энэ сургаал элчийн бурханы дэргэд байхдаа маш болгоомжтой байх ёстойг харуулж байна.

Туркийн Анадолу гэх бүс нутгийн нэгэн тосгоноос нэг хүн Мединед нүүн ирж олон жил амьдарчээ. Тэрээр элчийн сүмд ажилдаг байлаа. Нэг өдөр тэр маш хүндээр өвджээ. Халуун нь буухгүй хэцүү байсан болохоор зовлонг гэтлэх гэж нутгаа сангалзан дотроо: “Хэрэв би Анадолу тосгондоо байсансан бол нэг сайхан тараг уухсан” хэмээн бодолгоширжээ. Тэр шөнө пайгамбарын (салаллаху алейхи уа сальлам) месжидийн Имамын (хамба лам) зүүдэнд ирж нөгөө турк хүний ажлыг өөр хүнд даатган өгөөд, тэр хүнийг ажлаас нь суллахыг тушаав. Месжедийн имам “Аяа, Расулуллах, тэр ажлыг бол таны дагалдагсадаас ийм хүн хийж байгаа” гэхэд элч: “Тэр хүндээ очиж хэл! Тосгондоо очоод тарагаа ууг!” хэмээв.

Маргааш өдөр нь имам туркийг дуудаад энэ тушаалыг хэлэхэд нөгөө хүн таны хэлсэнээр болог гээд нутаг буцжээ.

Зөвхөн толгойдoo бодсон бодол ийм их хохирол учруулж байгаа юм чинь залбирахдаа бид Аллах эзэнтэй ярьдаг болохоор болохгүй үг, болохгүй хөдөлгөөнөөс өөрсдийгөө хамгаалж соёлтой байх нь маш чухал юм.

Салават-и шериф (Мухаммед элчид мэнд ба залбирал хэлэх) уншихын ач холбогдол, ашиг

Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) нэрийг сонсох эсвэл бичих үедээ түүнийг хүндэтгэж байхын бэлэгдэл болгон түүнд салават-и шариф хэлэх нь маш чухал үйлс юм. Куран сударт Азхаб сүрегийн 56-аетэд: “Үнэндээ Аллах эзэн ба Мелекүүд (сахиусан тэнгэр) элчид хандан салават хэлдэг. Тийм болохоор, хөөе, итгэгсэд ээ! Та нар ч мөн адил түүнд салават (мэнд ба залбирал хэлэх) уншицгаан бас түүнд сэтгэл зүрхээрээ өгөгдөхтүүн” хэмээжээ.

Тефсирийн (Куран тайлбарлал) эрдэмтэд энэ ает дахь “Салат” үгийн утгыг: Аллахын хувьд энэрэл, мелекийн хувьд

наминчлал, мусульманы хувьд залбирал гэсэн утгатай хэмээн тайлбарлажээ. Бүхий л ислам эрдэмтэд: “Гэгээн элчийн нэр дурьдагдахад, бичигдэхэд, эсвэл дуулахдаа салават (магтаал) хэлэх нь үүрэг” хэмээн хэлжээ.

Аллах эзэнээс нэг зүйл хүсэн залбирах хүн юун түрүүнд Аллахт хамд (талархал) хэлсэний дараагаар элчид хандан салават хэлэх нь зүй. Ингэж эхэлсэн нэгэн залбирал биелэлээ олоход маш дөхөм. Хоёр салават (залбирлийн эхэнд бас сүүлд хэлэгдэх) үйлдэгдсэн залбирал буцаалтгүй биелэгддэг.

Эбү Талха ийн өгүүлжээ: “Би гэгээн элчийн гэрт орсон юм. Тэрээр урьд өмнө байгаагүйгээр баяр хөөртэй инээж байлаа. Намайг учирьг нь асуухад: “Баярлахаас өөр яах билээ? Дөнгөж сая Жабрайл (aleyхиссальлам) ирж баярт мэдээ дуулгалаа. Аллах эзэн ингэж зарлиглажээ: “Миний дагалдагсадаас хэн нэгэн хүн чамд нэг салават хэлэх юм бол, Аллах эзэн түүний хариу болгон түүнд 10 салават хэлнэ” гэлээ”

Энэ талаар зарим хадис шарифт (сургаал үгс) ийн мэдээлжээ.

“Миний нэрийг сонссон хэрнээ надад салават (мэнд ба залбирал хэлэх) үл хэлэгсэд зовог. Рамазан (мацаг) сар ирэхэд нүглээ наминчлуулахгүйгээр сарыг өнгөрөөгчид зовог. Эцэг эх нь хөгширөхийн цагт тэднийг баярлуулан диваажинд эс орогсод ч зовог”

“Миний нэр дурдагдахад надад салават ба селам (салават ба мэнд амар) хэлээгүй хүн харамч”

Эбү Хумейд Эс-Сайди ийн өгүүлнэ: “Асхабууын зарим нь Аллахын элчээс ийн асуужээ. “Аяа, Расулуллах! Чамд бид хэрхэн салават ба селамыг (ерөөл ба мэндийг) хэлэх вэ?” гэхэд Элч (салаллаху алейхи уа сальлам): “Аллахүме салли алаа Мухаммедан вэ алаа алий Мухаммед” гэцгээ” гэв.

Зарим салаватууд:

“Алейхиссальлам”, “Салаллаху алейхи уа сальлам”, “Аллахүмма салли алаа сайидина Мухаммед”, “Аллахүмме салли алаа сайдина Мухаммеден вэ алаа аали Мухаммед, кемаа сальлайта алаа Ибрахийма вэ алаа аали Ибрахима...” “Аллахүмме салли алаа Мухаммед вэ алаа алихи вэ сахбиhi ажмаин”

Хадис-и шерифт: “Хэн надад нэг удаа салават хэлхэд Аллах түүнд 10 удаа салават (өршөөл) өгнө, түүний 10 нүгэлийг

наминчлан, бас зиндааг нь 10 удаа дээшлүүлнэ”

“Хойд ертөнцөд надад хамгийн ойр байх хүн, миний тусламь өмгөөлөлд хамгийн ойр хүн бол маш олон салават хэлсэн нь юм” хэмээн айлджээ.

Хойд ертөнцөд бүхий л үед надтай хамгийн ойр байх хүн бас, энэ ертөнцөд надад хамгийн их салават (ерөөл, магтаал) хэлэгсэд. Жума (Баасан гараг) өдөр надад 100 салават уншигсадад Аллах эзэн 100 ажилыг нь хөнгөвчлөн. Дараагаар нь Аллах эзэн нэг мелекээр (сахиусан тэнгэр) энэ салаватуудыг миний булшинд авч ирүүлнэ. Тэр мелек салават уншигчдын овог нэрийг надад хэлнэ. Миний хажууд байх цагаан хуудасанд түүнийг бичнэ. Би нас барсанахаа дараа мэдэх нь амьд ахуйдаа мэдэхтэй минь ижил.

Пүрэв гариг болход Аллах эзэн над руу мөнгөн дэвтэр ба алтан үзэг бүхий мелекийг илгээнэ. Пүрэв гарагийн өдөр ба Жумагийн (Баасан гараг) орой элчидээ олон салават уншигсадыг бичнэ.

Хайрт мусульманууд уулзаад нэг нэгнээ тэвэрч мэндлээд дараа нь элчидээ салават унших юм бол, тэр хоёр салж амжаагүй байхад урьдаж хийсэн бүх нүгэлүүд нь намичлагдана.

Та нараас хэн нэгэн мөсжидэд ороход салават унш, дараа нь Аллах минь намайг чөтгөрийн төөрөгдөлөөс хамгаал гэж хэл!”

Аллахын элч (салаллаху алейхи уа сальлам) ба түүний гэр бүлд салават (мэнд ба залбирал) уншаад залбирах юм бол залбирал ба тэнгэр хоёрын хоорондох хөшиг урагдан залбирал тэнгэр өөд гарах болно, эс уншвал хөшиг урагдахгүйгээр барахгүй залбирал буцаад бууна.

Чих нь дүгнэгсэд намайг бодоод надад салават уншиг.

Буянт нэгэн үйлсийг эхлэхдээ Аллахын нэр ба надад салават уншихгүй эхлэвэл тэр ажилын үр дүн нь муу бас буянгүй юм.

Селефийн эрдэмтэдээс нэг нь ийн айлдана: “Хамтдаа хадис (Мухаммедын (алейхиссальлам) сургаал үгс) сурсан нэг найз маань нас барлаа. Би зүүдэндээ түүнийг гэр туяа цацруулсан ногоон нөмрөг өмссөн аз жаргалтай байхыг харлаа. Учирыг нь асуухад: “Би үзсэн хадис болгондоо элчийн нэр таарахад “Салаллаху алейхи уа сальлам” гэж хэлдэг байсан юм. Энэ бол түүний ач буян” гэв.

Эбү Сүлейман Дарани ийн хэлжээ. “Би хадис бичих болгондоо элчийн нэрний ард “Саллалаху алейх” гэж бичээд “уа сальлам” гэдэг үгийг бичилгүй орхилоо. Нэг өдөр зүүдэндээ элчийг үзлээ. Тэр надад: “Хөөе, Эбү Сүлейман, хадист миний нэрийг бичихдээ салаваттай хамт “уа сальламыг” ч бас бич. Тэр бол 4 үсэгтэй үсэг болгонд 10 буян бий. Хэрвээ чи бичихгүй бол 40 буяныг хөсөр хаяж байна гэсэн үг” гэв.

Эбү Бакир Сиддик (радиаллаху анх) ийн айлджээ: “Мартах өвчинөөс айгсад Аллахын элчид олон салават уншиг”

Гэгээн эрдэмтэдээс Мухаммед бин Сайд бин Мутарриф хэлж байна. Би үдэш бүр унтахаар хэвтэхдээ Мухаммед элчид салават уншдаг байлаа. Нэг өдөр зүүдэнд минь Аллахын элч миний өрөөнд орж ирлээ. Өрөө минь гэрэл цацран туяарч байлаа. Элч над руу чиглэн ирээд “Алив, энэ надад олон салават уншиж байгаа хүнийг үнсье” гэлээ. Би айж эмээхийн зэрэгцээ баярлан духаа өгөхөд, элч гэгээн уруулаараа намайг үнссэн юм. Би нойрноосоо сэрхэд миний өрөөгөөр нэг маш гоё үнэр үнэртэж байв. 8 хоног тэр гоё үнэр миний өрөөнөөс гараагүй билээ.

Селеф эрдэмтэдийн нэг болох Халлад бин Кесир нас барсаны дараа түүний цогцсыг өргөхөд дэрэн доороос нь “Энэ Халлад бин Кесир тамын зовлонгоос үүрд чөлөөлөгдлөө. Энэ бол баталгаа гэсэн бичигтэй алтадмал цаас байхыг олон харцгаав. Учир начинийг нь асуухад Халлад Жума (баасан гараг) бүр элчид зориулж салават уншдаг байжээ.

Шейх Муса Дарири: “Биднийг далайд байхад далайн хар шуурга дэгдэв. Далайн давалгаа давалж бид маш их айн сандарч эхлэх тэр үед би өөрийн эрхгүй унтаж эхэллээ. Зүүдэнд элч ирж: “Хөлөг онгоцонд байгсадад хэл. 1000 удаа “Аллахүмме салли алаа саййдина Мухаммедин вэ алаа аали саййдина Мухаммед, салатан түнжина, мин жамигил эхваали вэл аафат вэ такди лана биха жамигал хаажат вэ түтаххируна биха мин жамис сайат вэ тарфауна биха индэкэ аглаа-д даражад вэ түбаллигуна биха акса-л гаят мин жамигил хайрати фил хаяти вэ багдал мамад иннака алаа күлли шайн кадийр” —ыг уншиг гэв. Бид 100 удаа ч уншиж амжаагүй байтал салхи намдаж, аюулаас аврагдсан юм. Энэ салават бүхий л чухал ажилууд бас аюул заналхийлэлд, газар хөдлөлт, байгалийн сүйрэл болоход уншихыг зөвлөсөн юм.

ХИЛИЕ-И САГДЕТ

Ариун нэр алдарууд нь

Хайрт пайгамбарын маань (салаллаху алейхи уа сальлам) хамгийн их дуурсагддаг, дуурдагддаг нэр нь “Мухаммед” юм. Энэ нь маш их дуурсагдан, магтагдсан гэсэн утгатай. Энэ нэрийг Куран сударт Али Имран, Азхаб, Фетих, ба Мухаммед сүрэнүүдийн бас дараалалаараа бол: 144, 40, 29, ба 22-аетуудад 4 удаа таардаг. Саф сүрегийн 6-аетэд гэгээн Исагийн дагалдагсадад “Аллах эзэнийг маш их магтан ерөөсөн” гэх утгатай “Ахмед” гэх нэрээр мэдэгдсэнээ айлдана. Куран сударт “Мухаммед” ба “Ахмед” нэрээс өөр: Махмуд, Расул, Неби, Шахид, Бешир, Незир, Мүбешшир, Мүнзир, Даи Иллаллах, Сиражүн Мүнир, Рауф, Рахим, Мусаддик, Мүзеккир, Мүддесир, Абдуллах, Керим, Хак, Мүнир, Нур, Хатемүн Небийн, Рахмет, Нимет, Хади, Таха, Ясин гэх мэт нэрлэгджээ. Энэнээс өөр нэрнүүдийн зарим нь Куранд, зарим нь хадис-и шерифт, зарим нь тэрнээс өмнө илгээгдсэн элчүүдийн ариун сударуудад дурдагджээ.

Элчийн (салаллаху алейхи уа сальлам) нэр алдар зарим хадис шерифт (элчийн сургаал үг) Мехи, Акив, Мукаффи, Неби-үр Рахме, Неби-үт Тевбэ, Неби-үл Мулахим, Каттал, Мутевеккил, Фатих, Хатем, Мустафа, Кусем гэх мэт нэрлэгдсэн байдаг.

Нэгэн хадис-и шерифт: “Надад харъяалагдах 5 нэр бий. Би Мухаммед юм. Би Ахмет юм. Би Махи нэртэй болохоор Аллах надаар бүх мухар сүсэгийг үгүй хийлгэнэ. Би Хашир нэртэй болохоор хойд ертөнцөд хүмүүс миний хажууд цугларах болно. Би Акиф нэртэй болохоор надаас хойш элч гэж үгүй” хэмээжээ.

Мухаммед элчийг (салаллаху алейхи уа сальлам) гэгээн Хадиже эхээс төрөөд бага насандаа эндсэн хүү Касимаас болоод “Эбү-л Касим” буюу Касимын эцэг гэж нэрлэх нь ч бий. Мөн тэрний үнэнч шударга зан чанараас нь болж Курейш овгийнхон “Ал-Амин” ба итгэлт хүн гэж хочилдог байжээ.

Аллахын элчийн (салаллаху алейхи уа сальлам) бас нэг содон нэр бол Куран сударын зүрх нь болох “Ясин” сүрений “Яасин” үг юм. Усемер бин Рашидин гэх эрдэмтэн ийн тайлбарлана: “Ясин, “Аяа, миний хайр энэрэлийн голын загасчин болсон хайрт элч минь” гэсэн үг” гэжээ.

Хилие-и сагдет

Хорвоогийн энэрэлт элчийн (салаллаху алейхи уа сальлам) үзэгдэх байр байдалыг ойлгуулан хэлэхийг Хилие-и Садет гэнэ.

Исламын эрдэмтэд элчийн харагдах байдал, зан авир, шинж төрх, шинж чанар, сайхан сэтгэл гэх мэт бүх зүйлийг өчүүхэн ч үлдээлгүй дэлгэрэнгүйгээр зураглан бичсэн байдаг. Энэ бүх мэдээлэлийг элчийн (салаллаху алейхи уа сальлам) өөрийн хэлсэн сургаал үг бас түүний асхабуудын тодорхойлсоноор олж авчээ.

Хадис шериф (элчийн сургаал үг) ба асхабуудын тодорхойлсончилэн элчийн (салаллаху алейхи уа сальлам) Хилие-и Садет ийм юм.

Энэрэлт элчийн (салаллаху алейхи уа сальлам) зүс царай ба бүхий л бие махбодь, дуу хоолой нь бүхий л хүмүүсийн царай зүс, бие махбодь, дуу хоолойноос хамгийн сайхан нь билээ. Гэгээн нүүр нь бөөрөнхий хэлбэртэй юм. Баярлах үед сар адил туяарч гэрэлтдэг билээ. Түүний баярласаныг нь ариун царайнаас нь мэдэгддэг байв. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) өдөр хэрхэн харагддаг бол шөнө ч мөн адил тийм харагддаг байлаа. Урдаа байгсадыг харсан шигээ хойноо байгаа бүх зүйлийг хардаг байлаа. Хажууруугаа эсвэл хойшоо харахдаа бүх биеээрээ эргэж хардаг байлаа. Газар луу тэнгэрээс илүү их хардаг байлаа. Ариун нүд нь том алаг ба урт сормуустай билээ. Ариун нүдэнд нь хэсэг улаан толбо байсан ба тас хар нүдтэй билээ. Оройгоор сүрмэ (нүдэнд түрхэгдэх эмийн үйлчилгээтэй будаг) түрхдэг байлаа. Пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) өргөн духтай, хоорондоо зайтай нарийхан хар хөмсөгтөй байсан. Хоёр хөмсөг дундах судас нь хилэгнэсэн үед нь тодорч гарч ирдэг байлаа. Хамар нь дундын бөгөөд босоо билээ. Ариун толгой нь том билээ. Ариун ам нь дундын юм. Ариун шүд нь цав цагаан ба шигүү биш юм. Тэрнийг ярьж эхлэхэд шүднүүдийн дундаас туяа цацаран урсах мэт. Аллахын боолуудын дундаас түүнээс илүү сайхан үг, амтат бол бурамын яриатай хүн үгүй билээ. Түүний үг яриа хурдан ойлгогдох ба зүрх сэтгэлийг уяраан татах увидастай билээ. Юм ярихдаа үгээ аяархан бас давхцуулалгүй сувд мэт жагсаана. Хэрвээ хэн нэгэн хэлсэн үг бүрийг тоолохыг хүсвэл тоологдохоор юм. Заримдаа сайн ойлгуулахын тулд 3 удаа давтан ярьдаг байлаа. Диваажинд

Мухаммед (салаллаху алейхи уа сальлам) шиг ярицгаах болно. Түүний дуу хоолой хэний ч дуу үл хүрэм газараас сонсогддог байсан.

Энэрэлт пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) инээмсэглэл гэрэлтсэн царайтай, инээмсэглэхэд түүний цагаан гантиг мэт шүд нь харагдана. Түүний уйлах нь хүртэл инээхтэйгээ адил зөөлхөн юм. Хөхөрч чанга дуугаар инээдэггүй, чанга дуугаар бахирч уйлдаггүй байв. Тэр уярах эсвэл гомдсон үед ариун нүднээс нулимс бөмбөрч, мэгшин уйлдаг байв. Дагалдагсадынхаа алдаа эндэгдэл ба нүгэлийг бодох үед, Аллах эзэнээс айх үедээ, заримдаа мөргөл үйлдэж байхдаа уйлдаг байлаа.

Элчийн (салаллаху алейхи уа сальлам) ариун гар нь бүдүүн бас булчинлаг юм. Гэгээн гарынх нь алга нь том, бүх биеийнх нь үнэр мискээс (гоё үнэртэн) ч гоё анхилуун билээ. Тэрний бие зөөлхөн бас хүчирхэг билээ.

Аллахын элч (салаллаху алейхи уа сальлам) маш өндөр нуруутай биш ч, намхан харагддаггүй байлаа. Түүний хажууд өндөр хүн ирэхэд тэрнээс өндөр харагдана. Дунд зэрэг биетэй хүмүүсийн дунд пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) арай л жаахан өндөр харагдана.

Сахал, үс нь долгиолсон буржгар, бас үсэрхэг байлаа. Үс нь урт юм. Урдаа сагмай тавьдаг байсанаа сүүлд хоёр хуваадаг болжээ. Үсээ заримдаа урт ургуулж, заримдаа тайрч богиносгодог байлаа. Үс сахалаа огт буддаггүй байв. Нас нөгчихөд үс сахал нь дахь цагаан үсүүд 20-оос бага байлаа. Живэр сахалаа богиносгож живэрийн урт нь хөмсөгтөй адил байлаа. Тэр өөрийн үсчинтэй байлаа. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) сам, мисвак (шүдний сойзын оронд хэрэглэдэг мод) хоёроо дандаа өөрөө авч явдаг байв. Үс сахалаа самнахдаа тольддог байлаа. Пайгамбар маань явахдаа урагш хараад хурдан алхална. Түүнийг яваад өнгөрсөнийг анхилуун үнэрээс нь тодхон мэдэж болно. Аллахын элч (салаллаху алейхи уа сальлам) араб хүн билээ. Улаан цоохор алчуур толгойдоо тавих нь өөрт нь юутай зохицоно вэ? Хэн нэгэн хүн элчийг Нигер (хар арьстан) гэж хэлбэл кафир болно. Өөрөөр хэлбэл, шашинаас гарна.

Араб сайхан гэсэн утгатай үг юм. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) Арабын нутагт төрсөн болохоор араб хүн мөн.

Хайрт элчийн (салаллаху алейхи уа сальлам) эцэг Абдуллах

сайхан царай зүсээрээ алдаршин Египетид хүртэл нэр цуурчжээ. Түүний магнай дахь энгийн туяаг хараад, түүнд дурлан эхнэр нь болохыг хүссэн 200-аад эмс хүүхэнүүд Мекке хотод иржээ. Гэвч Мухаммедийн (алейхиссальлам) туяа Амина эхэд ноогджээ.

Авга ах Аббасын хүү Абдуллах ч цагаан гэгээлэг царайтай нэгэн юм. Элчийн үр удам цөм хойд ертөнц хүртэл цагаан гэгээлэг байх юм.

Элчийн асхабууд (радиаллаху анхум) ч цагаан гэгээлэг царайтай байлаа. Гэгээн Осман шаргалдуу царайтай нэгэн. Расулуллахын (салаллаху алейхи уа сальлам) Ромын хаан Геркулес рүү илгсээсэн элч Дихие Келби маш царайлаг хүн юм. Түүнийг гудамжинд явах үед царайг нь харахыг хүссэн Ромын эмс хүүхэнүүд гудамжинд хуйлардаг байв. Жабрайл (алейхиссальлам) мелек ихэнхдээ Дихиегийн дүрээр элчид ирдэг байжээ.

Пайгамбарын (салаллаху алейхи уа сальлам) үр уудамыг хайрлан хүндлэх ба тоолох нь нэгэнт буян үйл билээ. Туркд ирсэн Хабеш хүмүүс өөрсдийгөө элчийн үр удам хэмээн зарлажээ. Тэд хар арьстанууд билээ. Гэвч туркууд тэднийг маш ихээр хайрлан хүндэлсэн юм. Үнэндээ хайр хүндэтгэл хар, цагаан гэж ялгагдахгүй болохоор арьс өнгөний ялгаа ч бас байхгүй билээ. Хар арьстай мусульман цагаан арьстай кафираас илүү дээд юм. Хүн хар арьтай байх нь итгэл үнэмшилд харшлахгүй.

Гэгээн Билал Хабаши ба элчийн хайртай асхаб Усаме нар (радиаллаху анхум) хар арьстанууд юм. Гэтэл хамгийн их нүгэлтэн Эбү Лехеб ба Эбү Жахил нар цагаан арьстан юм. Аллах эзэн хүмүүсийн арьс өнгөнд бус итгэл үнэмшил, үнэнч байдалд нь илүү хайртай билээ.

Аллахын элч бүхий л сайхан шинж чанар, зан аашыг өөртөө агуулжээ. Энэ зан аашыг Аллах өгсөн юм. Тэрээр хэзээ ч хэн нэгэн мусульманыг хараан зүхэж байгаагүй ба хэзээ ч хэн нэгэнийг долоовор хуруугаараа чичиж байгаагүй юм. Аллахын төлөө өшөө авч байв. Хэзээ ч өөрийнхөө эрх ашгийн төлөө өшөө авч дайтаж байгаагүй. Гэртээ маш зөөлхөн инээмсэглэсэн царайтай байдаг байв. Өвдөгсөдийг эргэн тойрч, нас барагсадын жаназе (оршуулгын намаз) мөргөлд оролцдог байв. Асхабуудынхаа ажилд тулаж, хүүхдүүдийг нь тэврэн эрхлүүлдэг байлаа. Түүний сүнс мелекүүдийн (сахиусан тэнгэр) ертөнцөд байдаг байлаа.

Элчийг (салаллаху алейхи уа сальлам) гэнэт харсан хүн

айж эмээдэг байлаа. Элч (салаллаху алейхи уа сальлам) өөрөө зөөлөн хандаагүй байхад элчийн дүрээс нь болон хажууд хүн суудаггүй байлаа. Үнэндээ элч маань хэнд ч ширүүн үг хэлдэггүй байлаа. Пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) хүмүүсээс хамгийн өглөгч нь юм. Түүнээс ямар нэгэн зүйл асуухад үгүй гэж хэлж байгаагүй удаатай. Гуйсан зүйл түүнд байвал өгнө, байхгүй бол хариу хэлдэггүй байлаа. Тэрээр бүхэнд туслаж, дэмжихийг үргэлж хүсдэг байсан юм. Гэхдээ өөрөө хэцүү байдалд дуртай байлаа. Хоол авч ир идмээр байна, эсвэл тэр хүн хоол хий гэж огт хэлж байсангүй. Өгсөнийг л иддэг байлаа. Өгсөн нь ямар ч жимс байсан хүлээн авдаг байв. Хоол идэхдээ заримдаа бага иддэг байв. Ус уухдаа сууж ууна. Бусадтай хоол идэхдээ бүхнээс сүүлд гараа авдаг байлаа. Бэлэг өгөгсөдөд хариу болгон илүү ихийг өгдөг байв.

Өөр өөр хувцас өмсөх нь заншил байв. Өөр газарууд руу явахдаа гоё ганган хувцас өмсөн инээмсэглэл дүүрэн царайтаагаар очно. Хар өнгөтөй эрдэнэсийн чулуу нь шигтгээтэй мөнгөн бөгжтөй бөгөөд түүнийгээ тамга болгон ашигладаг байв. Бөгжний шигтгээн дээр “Мухаммед Аллахын элч” гэсэн бичигтэй юм. Ор нь хурма модоор хийгдсэн агаад арьсан бүрээстэй байлаа. Заримдаа энэ орон дээрээ, заримдаа газар дэвссэн арьсан дээр, заримдаа хоосон шороон дээр хэвтэж амарна. Гарыг алгаа баруун шанаан дээр дэрлээд баруун талаараа хажуулдан хэвтээд унтдаг байлаа. Өргөл өгөгчдийн мал хөрөнгөнөөс авахгүй, түүхий сонгино, сармис хэзээ ч иддэггүй ба хэзээ ч шүлэг бичдэггүй уншдаггүй байлаа.

Түүний нүд нь унтсан ч зүрх нь үл унтана. Өлсгөлөн унтаад цатгалан сэрдэг, бас хэзээ ч эвшээдэггүй. Түүний бие гэрэл туяа цацрах агаад сүүдэр нь газар харагддаггүй байлаа. Хувцасанд нь ялаа шумуул ойртдоггүй ба шимэгч хорхойнууд огт харагддаггүй байв. Аллах түүнд элчийн үүрэг олгосон өдөрөөс эхлэн чөтгөр шулам ирээдүйг харж чадахаа болин, илбэч мэргэдэд туслахаа больжээ. Булшныхан хажууд нэг мелек (сахиусан тэнгэр) зогсоод хүмүүсийн хэлсэн Салават-и шериф элчид дамжуулан хэлдэг үүрэгтэй юм. Минбер (индэр) ба түүний булш хоёрын хоорондох зайг Равда-и Мутаххара гэж нэрлэдэг. Энэ газар бол диваажингийн цэцэрлэгүүдийн нэг юм. Түүний булшыг эргэн очих нь итгэн дагагсадын хамгийн том бас хамгийн буянтай үйл юм.

Элчийн (салаллаху алейхи уа сальлам) ариун дүр төрхийг

асхабууд ийн айлдсан байна. Эбү Хурейре «радиаллаху анх): “Аллахын элчээс илүү царайлаг, илүү сайхан хүнийг огт хараагүй билээ. Тэр сар мэт гэрэлтэж байдаг” хэмээжээ.

Ибн-и Эби Хале (радиаллаху анх): “Аллахын элчийн ариун царай бүтэн сар мэт гэрэлтэй билээ” гэжээ.

Гэгээн Али: “Түүнийг гэв гэнэт үзсэн хүн түүний сүр жавхлангаас айдаг бөгөөд ярилцаад гэгээн сургаалийг нь сонсоод хурдан дагаж түүнийг хайрлаж эхэлдэг”

Гэгээн Айше: “Аллахын элч нэг хүүхэдийн толгойг илэн эрхлүүлэх үед тэр хүүхэд бусад хүүхдүүдээс содон анхилуун үнэрээрээ ялгардаг байлаа.

Элчийн сайхан зүс царай

Гэгээн Эбү Бакир (радиаллаху анх) Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) ариун зүс царай ба дээдийн байдлыг хараад түүнд хайртай байжээ. Түүний элчээ гэх сэтгэл маш их болхоор өөр хэн ч тэрэн шиг болж чадаагүй бөлгөө. Тийм ч болохоор тэр хаашаа л харнав элчийн дүрийг үздэг байлаа. Нэг удаа “Аяа, пайгамбар минь, би хаашаа л харнав, та харагдах юм” гэжээ. Бас “Бий хийсэн бүх буянаа сахваар /тааны алдаагаар/ солиход бэлэн байна” хэмээжээ. Элчийн сайн сайхныг хамгийн сайн харж, хамгийн сайн ойлгож чадах гэгээн Айше эх юм. Тэрээр ийн айлджээ: «Нэг өдөр Мухаммед элч гутлынхаа утасыг тайлж байлаа. Харин би утас ээрэн сууж байсан юм. Элчийн гэгээн духнаас унсан хөлс гэрэлтэн туяархыг нь би хараад гайхан сууж байтал элч “Аяа, Айше минь, чи юунд ингэж гайхана вэ?” гэж асуув. “Аяа, Аллахын элч минь! Гэгээн магнайгаас чинь унсан дусал бүр гэрэл туяа цацруулах нь юутай гайхалтай вэ? гэжээ. Элч босож ирээд миний миний магнайг үнсэн “Аяа, Айше минь! Аллах эзэн чамд сайн сайханыг өгөг! Чи намайг баярлуулсан шиг би чамайг баярлуулаагүй билээ” гэв.

Асхабууд Аллахын элчээс (салаллаху алейхи уа сальлам) “Аяа, пайгамбар минь! Та илүү үзэсгэлэнтэй юу? Юсуф пайгамбар илүү үзэсгэлэнтэй юу?” гэж асуухад элч: “Юсуф элч надаас царайлаг, би тэрнээс илүү Аллахд хайрлагдсан, тэрний гадаад дүр төрх надаас илүү царайлаг” хэмээжээ.

Аллахын элч (салаллаху алейхи уа сальлам) нэг хадис-и шерифт “Аллах эзний илгээсэн бүх пайгамбарууд царайлаг бас

сайхан дуу хоолоотой. Харин та нарын элч Мухаммед бол тэднээс ч илүү царайлаг бас илүү сайхан дуу хоолойтой” хэмээжээ.

Элчийн (салаллаху алейхи уа сальлам) сайхныг өгүүлсэн шүлэг бас зохиолууд маш олон билээ. Энэ бүх зохиол шүлэгүүдийг бичэгсэд элчийг магтан дуулхаас бүрэн дүүрэн хүн хүргэх боломжгүй гэж бичсэн байдаг.

Нэг өдөр гэгээн Омар элчид: “Аяа, Аллахын элч минь! Андгайлъя, чи миний хувьд амьнаас минь гадна хамгийн их хайрлагдсан хүн” гэхэд Элч: “Би хэн нэгэнд амьнаас нь илүү хайртай болж чадах хүртэл тэр хүн бүрэн итгэлтэн болж эс чадна” хэмээжээ. Энэ үгийг сонссон Омар: “Аяа элч минь! Чамд Куран судрыг илгээсэн Аллахын нэрээр андгайлъя, би чамд амьнаасаа ч илүү хайртай” гэхэд пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам): “Омар минь, одоо (гүйцэт) боллоо” хэмээв.

Хэн нэгэн мусульман элчид ирээд: “Аяа, Расулуллах, киямет (дахин амилах өдөр) хэзээ болох вэ?” гэж асуухад элч: “Чи тэр кияметэд хэр бэлэн байна вэ?” гэж асуухад “Аяа, пайгамбар минь, би их намаз үйлдэж, мацаг барьж, зекет (мал хөрөнгөний өргөл барьц) өгч буян үйлдэж амжаагүй ч гэсэн Аллах ба түүний элчийг юу юунаас ч илүү их хайрладаг билээ” гэв. “Хүн хайрттайгаа хамт” хэмээн өгүүлжээ.

Элчийг (салаллаху алейхи уа сальлам) хайрлан хүндлэх нь бүх мусульманы ариун үүрэг билээ. Түүнийг хайрлах хайр хүнд нэг л өгөгдөх юм бол ислам шашиныг баримтлан итгэл үнэмшил ба исламын амтыг амтлах маш хялбар болно. Энэ хайраараа Аллах эзэний мөнхийн ба тоо тоймшгүй буян хишигийг хүртэх болно .

ЭРХЭМ ШИНЖ ЧАНАРУУД

Дээдийн зан авир

Аллах эзэн Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) сайхан зан авируудыг дурьдан түүнийг эрхлүүлэхдээ “Чи ямар их сайхан зан ааштай болгон бүтээгдэв ээ?!” хэмээжээ. Гэгээн Икреме (радиаллаху анх) ийн айлджээ: “Би нэг удаа гэгээн Аббасаас ийн сонссон юм: Нэг ает “Хулук-и Азим”, өөрөөр хэлбэл, сайхан зан авир нь Куран керим сударт тодорхойлсон зан чанар юм. Харин нэг аетэд “Чи (Мухаммед) Хулук Азимтай хүн” (Калем сүре, 4) гэжээ.

Түүний (Муххамед элч) (салаллаху алейхи уа сальлам) сайхан үгтэй болхоор сэтгэл татагдан хүнийг байлдан дагуулах увдистай юм. Тэрээр ухаалаг болхоор хатуу сэтгэлтэй ширүүн авиртай хүнтэй зөөлөн харьцаж, тэвчээртэй хүлээсний эцэст хүнийг өөрийхөө жинхэнэ итгэлтэн болгон байлдан дагуулж чаддаг байлаа. Тэр хүн шашины төлөө мал хөрөнгө, амь биеээ үл хайрлан тэмцдэг байлаа.

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) маш олон гайхамшигийг үзүүлжээ. Энэ гайхамшигуудыг найзууд, дайснууд нь цөм хэлдэг. Гэхдээ энэ гайхамшигуудын хамгийн дээд нь хэнд ч үл заяагдсан сайхан зан авир юм. Эбү Сайд-и Худри ийн хэлжээ: “Аллахын элч мал адуусыг хариулж, тэмээг уяж аргамжиж, гэрээ шүүрдэж, хонио сааж, гутал, хувцсаа өөрөө оёдог байсан. Ажилчидтайгаа хамт хооллож, ажилчин нь гар тээрмээр гурил тээрэмдэж байхдаа ядархад түүнд тусладаг байлаа. Баян ядуу, хөгшид, багачуудтай алинтай нь ч тааралдсан тэднээс урьтан мэндэлдэг байсан. Тэдэнтэй гар барилцахаар хамгийн түрүүнд гараа өгдөг байлаа. Тэрээр эзэн, боол, хар, цагаан гэж ангилдаггүй бүгдэнтэй нь эрх тэгш харьцдаг байсан. Хэн ч түүнийг урьж дуудвал заавал очдог байсан. Маш сайхан зан ааштай билээ. Буян үйлдэх дуртай, бүх хүнтэй эвтэй найрсаг байдаг байлаа. Инээмсэглэсэн царайтай сайхан үгстэй бөгөөд ярьж байхдаа инээмсэглэдэг байлаа. Хэнээс ч юу ч хүлээдэггүй байлаа. Жаргал амар амгаланг хүсэгч хүн тэрэн шиг болох ёстой.

Энес бин Малик (радиаллаху анх): “Би элчийн хажууд 10 жил ажилсан билээ. Энэ хугацаанд элчийг нэгч удаа “ёох” гэж байхыг сонсоогүй. Энэнийг ягаад хийсэнгүй вэ?, Энэнийг ягаад

хийв? гэж зэмлэхийг нь огт сонсоогүй билээ”.

Эбү Хурейра (радиаллаху анх): “Бид нэг дайнд элчээс тэдэнд хараал хийгээч гэж гуйсан юм. “Би хараал хийхийн тулд, хүмүүсийг гэсгээхийн тулд илгээгдээгүй. Би бүх хүнд тус хийхийн тулд бас хүмүүсийг аз жаргалд хүргэхийн тулд илгээгдсэн билээ” гэсэн юм. Аллах эзэн Энбия сүрегийн 102-аетэд “Бид чамайг хорвоод энэрэл ба сайн сайхны төлөө илгээлээ” хэмээжээ.

Эбү Саид Худри (радиаллаху анх) ийн хэлжээ “Элчийн ичгүүр ислам шашинтан онгон охидын ичгүүрээс ч илүү билээ” хэмээжээ

Жабир бин Сүмүре (радиаллаху анх): “Аллахын элч маш бага ярьдаг хүн байсан. Хэрэгүй газар хэрэггүй үг хэзээ ч ярьдаггүй, ямар нэг зүйл асуухад хариулдаг байлаа. Энэн шиг бүх мусульман хэрэггүй сул үг их ярьж эмэгтэй хүн мэт байх нь зүй бус.

Энэс бин Малик (радиаллаху анх): “Нэг жаахан охин элчийн гараас хөтлөн нэг тоглоом руугаа хөтөлхөд элч даган очдог байсан”.

Энэс бин Малик: “Пайгамбар маань өвдөгсөдийг эргэн тойрч, жаназед (оршуулгын намаз) заавал оролцож, илжиг хүртэл ундаг байсан. Би Хайбер дайнд элч илжиг унсан байхыг харсан юм.”

Жабир (радиаллаху анх) ийн өгүүлжээ: “Элчээс ямар нэг юм гуйхад үгүй гэж байсныг нь би хараагүй билээ.”

Гэгээн Айше эх (радиаллаху анха): “Аллахын элч хэн нэгнийг түүний дургүй зүйлээр огт нэрлэж хэлдэггүй байсан. Хэн нэгэн зүй бус зүйл хийсэн нь мэдэгдэх юм бол олны дунд нэрийг нь дурдахгүйгээр бүгдэнд нь хандан “Ягаад ийм зүйл хийж байна?” гэж хэлдэг байна. Ийнхүү тэр хүнийг хийж буй муу зүйлээс нь ангижруулдаг байлаа.

Түүнийг харахийг хүсэгсэдийг хэзээ ч хорьдоггүй байв. Асхабуудаа сураглан, ирээгүй хүмүүсийг асуудаг байсан. Тэдний хажууд сууж амтат сургаалаа айлдана.

Түүнд юм хэлэхээр ирсэн бүх хүнийг чих тавин анхааралтай сонсдог байна.

“Элч шиг сайхан зан авиртай хүнийг би үзээгүй билээ. Түүнийг асхабууд нь эсвэл гэр бүлээс нь хэн нэгэн дуудхад “Айлдагтун” гэж угтдаг байна.

Асхабуудаа тэдний дуртай сайхан нэрээр дуудаж, хэний

ч үгийг тасалж тэднийг үгээ хэлж дуусаагүй байхад босдоггүй байна.

Түүний энэрэлийн талаар Аллах эзэн: “Битгий шаналцгаа. Та нарын шаналж зовох нь түүнийг ч бас гомдоож зовоодог, учир нь тэр та нарт маш хайртай. Мүминүүдэд (итгэлтэн) энэрэлтэй. Тэдэнд дандаа сайн сайханыг хүсэгч билээ” хэмээжээ.

Хэлсэн үгээ биелүүлэхдээ пайгамбар (салаллаху алейхи уа сальлам) шиг хүн байхгүй биз ээ. Абдуллах бин Эб-ил Хамса ийн өгүүлжээ: “Мухаммедэд элчийн үүрэг өгөгдөөгүй байсан үед би тэрэнтэй нэг наймаа хийсэн юм. Мухаммедын мөнгө хүрэлцээгүй болхоор үлдсэнийг нь 3 хоногын дараа нэг газар өгөхөөр болж тохиролцоод салцгаалаа. Би 3 хоногын дараа болзсон газраа очихоо мартаж орхижээ. Тэгээд гүйсээр очтол өнөөх газар намайг 3 хоног хүлээжээ. Тэр: “Залуу минь! Чи намайг их ядраалаа. Би энд чамайг 3 хоног хүлээж байна” гэж хэлээд мөнгөө өгөөд явсан юм” хэмээжээ.

Мухаммед элчид (салаллаху алейхи уа сальлам) өөрийгөө өргөмжлөх дээгүүр үзэх зан огт үгүй билээ, тэр бүхнээс даруу нэгэн юм.

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) Айше эхэд ийн айлджээ. “Надад зориулж Мекке хотын бүх чулуу шороог алт болгоё гэж хэллээ. Би “Үгүй, Эзэнтэн минь!” гэлээ. Нэг өдөр өлсгөлөн, нэг өдөр цатгалан амьдаръя, өлсгөлөн байхдаа чамд залибиран гуйя, цатгалан байхдаа чамд баярлан талархана” гэлээ.

Гэгээн Айше эх: “Заримдаа бид нэг сараар хоол хийхийн тулд гал түлэх шаардалгагүй болдог байлаа. Учир нь хоол хийх зүйл алга байлаа. Бид зөвхөн замзам ус, хурма жимс л иддэг байлаа.

Ибн-и Аббас: “Аллахын элч ба тэдний гэр бүл маш олон удаа оройн хоол идэхгүйгээр унтдаг байсан учир нь идэх хоол байдаггүй байсан”

Айше эх: “Элч хэзээ ч цадталаа идэж байгаагүй, ийм байгаадаа ч хэнд ч гомддоггүй байв. Ядуу, баян болох нь түүний хувьд сайн зүйл байсан. Гэвч өлсөхдөө хөнжилдөө хөрвөж хонох нь өдөр мацаг барихыг нь болиулж чаддаггүй байлаа”

Хэрвээ тэр хүссэнсэн бол Аллах дэлхий дээрх бүхий л алт эрдэнэсийн орд, баялагийг тэрэнд өгч болох байсан. Би түүний энэ байдалыг хараад өрөвдөн уйлдаг байлаа.

Би: “Аяа, пайгамбар минь! Чамд хүч чадал өгөх зүйл энэ

дэлхийгээс гуйж болохгүй гэж үү? гэхэд тэр: “Аяа, Айше минь! Би эд баялагаар юу хийх юм? Маш олон элчүүд эндээс ч илүү хүнд хэцүү зовлонг үзсэн хэдий ч тэвчиж зовлонг сөрсөн юм. Тэр л янзаараа амьдарцаасан. Эзэнтэйгээ ч уулзсан юм. Тийм болохоор Аллах тэдэнд талархан нас барахыг нь маш сайхан болгосон юм. Их ч буян хайрласан. Би элбэг дэлбэг амьдралыг гуйхаасаа ичиж байна. Учир нь ийм амьдралаар амьдрах нь намайг тэднээс дорд болгоно. Миний хамгийн сайхан мөрөөдөл бол ахан дүүс, найз нартайгаа уулзах явдал юм” хэмээжээ.

Гэгээн Айше ийн өгүүлжээ: “Пайгамбар маань энэ үгийг хэлсэнээсээ нэг сарын дараа нас нөгчсөн юм”

Аллахын элч (салаллаху алейхи уа сальлам) өглөгч чанараараа хүн төрлөхтөнөөс хамгийн өглөгч нь юм.

Аллахын элчийн хөрш нэг хөгшин өөрийн охиноо элч рүү явуулж: “Намаз үйлдэхдээ өмсөж үйлдэх хувцас надад алга нэг хувцас өгөөч” гэж гуйлгажээ. Элч (салаллаху алейхи уа сальлам) өөрийнхөө өмсөж байсан ганц дан дээлээ тайлж түүнд өгч явуулжээ. Өөрөө цээж нүцгэн үлдсэн болхоор месжидэд намаз (мөргөл) үйлдхээр очиж чадалгүй гэртээ бүгэв. Асхабууд элчийн энэ явдалыг хараад гайхан шагширч: «Аллахын элч маш өглөгч болохоор өөрт байгаа хувцасаа хүмүүст өгөөд өөрөө нүцгэн байгаагийн улмаас мөргөлд ирж чадахгүй байна. Бид ч мөн адил байгаа зүйлээ ядууст тарааж өгцгөө» гэцгээв. Энэ үед Аллах эзэн Исра сүрегийн 29 дэхь аетыг буулгажээ: “Харамч зан битгий гарга, өглөгч зангаа гарга” гээд дараа нь: “Хэцүү байдалд орж эсвэл намаз хийж чадахгүйд хүрэх хүртэл, гомдох хүртлээ битгий тарааж өг! Өргөл барьцад дундыг барь” хэмээжээ.

Түүний зарим сайхан зан авирууд:

1-Аллахын элч (салаллаху алейхи уа сальлам) эрдэмтэй, ухаалаг, суут, ой тогтоолтой, өглөгч байдал, даруу зан тэвчээртэй байдал шударга зан, үнэнч зан, зоригт байдал хайрлан хүндлэх нь, цэцэн мэргэн нь ухаалаг зан, итгэлтэй зангаараа бусад бүх элчүүдээс илүү дээд нь юм. Найз ба дайснуудын хийсэн муу зүйл ба алдааг уучилдаг байлаа. Хэнд ч өшөө хорсол муу санддаггүй байсан. Ухуд дайнд кафирууд шүдийг нь хугалан эрүүг нь шархдуулж цус болгож байхад ч: “Аяа, Аллах минь! Эд нарыг өршөө. Тэд харанхуй бүдүүлгээс л ийм юм хийж байна” хэмээн зальбирч байжээ.

2-Өөрийгөө бусдаас дээр гэж боддоггүй байсан. Нэг удаа аян замд явж байхдаа хонь төхөөрч хоол хийх болов. Нэг найз

нь би “Хонь төхөөрөө” гэв. Нэг нь “Би хоол хийе” гэв. Харин элч: “Би түлээ түүе” гэхэд тэд: “Мухаммед элч минь! Та амар бид бүгдийг хийчихье” гэхэд: “Тийм ээ! Та нарыг бүгдийг нь хийж чадна гэдгийг чинь мэдэж байна. Гэхдээ бүх хүмүүс ажил хийж байхад хараад зүгээр сууж чадахгүй. Аллах эзэн найз нөхдөөсөө хойш суугсадыг хайралдаггүй” гээд түлээ түүхээр явжээ.

3-Асхабуудынхаа хажууд ирэхдээ хоймор луу суун гэж давшилдаггүй байсан хаан л сул газар байна тэнд л суудаг байлаа.

4-Ихэнхдээ өвдөг сөхрөн суудаг байлаа. Өвдгөө өргөн гараагаа бүслэн сууж байгаагүй ажээ. Хоол хийхэд ажил хийхдээ ажилчидаасаа ангид үлдэж байсангүй. Тэдэнд дандаа тусладаг байлаа. Хэн нэгнийг зодох юм уу, хатуу үг хэлэж байгаагүй билээ.

5-Өглөөний мөргөлийг үйлдэж дуусаад олон түмэн рүү харж суугаад: “Өвдсөн хүн байгаа юу? Эргэн очъё” гэнэ. Өвдөгсөд байхгүй бол “Нас барсан хүн байн уу? Тусъя” гэнэ. Хэрвээ хэн нэгэн нас барсан бол очиж туслана. Жаназа намазыг уншихад бүх зүйлийг хийдэг байлаа.

6-Зочид, асхабуудынхаа ажилыг гүйцэтгэдэг байлаа. “Нэг хамт олны хамгийн гол нь ажил хийж буй хүн нь” хэмээжээ.

7-Хэзээ ч дуу алдан хөхрөн инээж байгаагүй билээ. Чимээгүй инээмсэглэдэг байлаа. Заримдаа ингэхдээ үүдэн шүд нь харагдана.

8-Огт хэрэггүй, ашиггүй зүйлийг хэзээ ч ярьдаггүй байлаа. Ярихдаа богино бас үр өгөөжтэй. Хурдан ойлгомжтой ярьдаг байлаа. Заримдаа сайн ойлгож мартахгүйн тулд 3 удаа давтан хэлдэг байлаа.

9-Түүний сүр жавхлангаас болоод хэн ч эгцэлж харж чаддаггүй байлаа. Хэн нэгэн түүний өмнө чичрэн сандархад: “Битгий сандар би сахиусан тэнгэр биш, дайсан ч биш мах идэж ус уудаг нэг эмэгтэйн хүүхэд байна” гэнэ.

10-“Та нар дотроос Аллах эзэнийг хамгийн сайн ойлгож, түүнээс хамгийн их айдаг хүн бол би юм”, “Та нарыг миний үзсэнийг үзсэнсэн бол, бага инээж, их уйлах байлаа” хэмээжээ.

11-Тэр агуу их зоригтой байсан. Хунейндайнд мусульманууд тархан зайлхад өөрөө хэдэн цэрэгтэй ганцаараа үлдэн дайтсан юм. Энэ мэт маш олон удаа ганцаараа үлдэн байлдаж байв.

12-Гэр бүлдээ бас ажилчиддаа нэг жилийн арвай буудайгаа нөөцлөөд, үлдэсэнийг нь ядууст тараан өгдөг байлаа.

13-Маш өглөгч билээ. Маш олон тэмээ, хонь тараан өгч, өөрөө юу ч үгүй үлдсэн удаа олон юм. Олон кафирууд түүний энэ занг хараад исламд оржээ.

14-Идэх зүйлээс хониний мах, шөл, хонины толгой, амтатнууд, зөгийн бал, хурма жимс, сүү, өрөм, тарвас, үзэм, хулуунд дуртай байжээ.

15-Ус уухдаа аяархан тайванаар “Бисмилла” гэж хэлээд, 3 хувааж уудаг байлаа. Ууж дуусаад “Альхамдүлиллах” гэдэг байлаа.

16-Өмсөж болох нь зөвшөөрөгдсөн бүх хувцасыг өмсдөг байлаа.

17-Арабын ёс заншилаар үсээ чихнийхээ хагас хүртэл урт ургуулдаг байлаа. Үсэндээ тусгай тос ба үнэртэн түрхдэг байлаа.

18-Гарынхаа бугуй, нүүртээ миск (үнэртэн) эсвэл өөр анхилуун зүйл түрхдэг байлаа.

19-Ор нь хурмаа модны мөчирөөр дүрэгдсэн арьс байлаа. Арьсан хөнжилтэй байв. Түүнд зөөлхөн хөвөнтэй ор авж ирхэд хүлээн авсангүй. Тэрээр заримдаа газар хэвтдэг байлаа.

20-Орой болгон нүдэндээ гурван удаа сүрме (нүдний будаг) түрхдэг байв.

21-Гэрт нь толь, сам, сүрме ,хайч, зүй, утас үргэлж байдаг байлаа.

22-Шөнийн намазаас хойш шөнө дунд хүртэл унтаад үүрийн намаз хүртэл мөргөл залбирал хийдэг байлаа. Баруун хажуугаараа хэвтэж, баруун алгаа баруун шанааны доор дэрлэн унтдаг байв.

23-Сайханыг боддог байлаа. Өөрөөр хэлбэл, анх үзсэн зүйлээ сайхнаар боддог байлаа.

24-Бодолгошироход ч сахлаа имрэн суудаг байлаа.

25-Гомдол гашуудалын үед шууд намаз үйлддэг байлаа.

Пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) аллахаас айж, түүнд найдан дагах нь хэн хүнээс ч илүү билээ. Тэрээр хөлөө хавдтал шөнийн мөргөл үйлддэг байлаа. “Аяа, Расулуллах, таны бүхий л нүгэл уучлагдсаныг та мэдсэн хэрнээ ягаад өөрийгөө ингэж зовоон вэ? гэж асуухад “Би Аллах эзэндээ их талархдаг боол болохгүй гэж үү?” хэмээдэг байв.

Буян үйлсүүд нь

Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) дээд заяа буянт үйлсийн тухай бичигдсэн олон зүүн ном байх билээ. Түүний бусдаас дээд нь:

1-Бүхий л туурвигдагсадаас хамгийн түрүүлж Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) сүнс ба ариун туяа нь туурвигдажээ .

2-Аллах эзэн түүний нэрийг Аршд (7 давхар тэнгэр огторгуй дээрх суудал) бичжээ.

3-Энэтхэгт ургасан нэг цэцгийн дэлбээ дээр “Лаа илааха иллалах, Мухаммеддүн расуллалах” “Аллахаас өөр бурхан үгүй, Мухаммед түүний элч мөн” хэмээн бичигджээ.

4-Басра улсын голоос баригдсан загасны баруун талд нь “Аллах”, зүүн талд нь “Мухаммед” хэмээн бичигдсэн байжээ.

5-Зөвхөн Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) нэрийн дурдахаар бүтээгдсэн мелек (сахиусан тэнгэрүүд) бий.

6-Мелекүүд Адам алейхиссаламын өмнө сажде (магнайг газар тавьж мөргөхөөр) хийхээр зарлиг авсан нь Адамын магнайд Мухаммед алейхиссальламын туяа байсан учраас.

7-Аллах эзэн бүхий л элчүүддээ Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) ирэхийг нь бас өөрийн дагалдагсаддаа элч ирвэл итгэн дагахийг нь зарлиг болгожээ.

8-Түүнийг хорвоод мэндлэхэд маш их гайхмаар зүйлүүд болжээ.

9-Тэр хорвоод мэндлэхдээ хүйс нь таслагдсан, бас хөвч нь тасарсан төржээ.

10-Тэрнийг хорвоод мэндэлсэнээс хойш чөтгөр, шулам тэнгэр өөд гарч чадахаа больж, мелекүүдээс мэдээг нь хулгайлж чадхаа больжээ.

11-Тэрнийг мэндлэхэд дэлхий дээрх хичнээн л шавар бурхан байсан, цөм газар түрүүлгээ харан унажээ.

12-Түүний өлгийг мелек хөдөлгөн бүүвэйдэг байв.

13-Тэрээр өлгийд хэвтэж байхдаа тэнгэр дэх сартай ярилцдаг байжээ.

14-Тэрээр өлгийд байх цагаасаа ярьж эхэлжээ.

15-Түүний хүүхэд байхаас нь толгой дээр нь нэгэн хадаастай мэт үүл даган нүүж, түүнийг сүүдэрлэдэг байв.

16-Бүх элчүүдийн баруун гар дээр нь элчийн тамга /мэнгэ/

бий. Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) тамга нь ар нуруунд нь 2 дал мөрийнхөн хооронд байв.

17-Тэрээр урдахаа хардаг шигээ хойдхоо чбас хардаг байжээ.

18-Гэгээтэйд үздэг шигээ харанхуй шөнө ч тодоор үздэг байлаа

19-Түүний шүлс нь гашуун усыг амттай болгож шарх соривийг анагаах увдистай байв.

20-Түүний нүд анилдан унтаж байхад зүрх нь огт унтахгүй бүхий л элчүүд ийм байжээ.

21-Хэзээ ч эвшээддэггүй байлаа, бүх пайгамбарууд адилхан юм.

22-Түүний хөлс цэцэг мэт анхилуун үнэртдэг юм.

23-Дунд зэргийн өндөр атлаа өндөр хүмүүсийн дунд орхоороо тэднээс арай жаахан өндөр харагдана

24-Нар ба сарны гэрэлд явахад сүүдэр нь газарт тусддаггүй байжээ.

25-Түүний биед хувцасанд нь ялаа, шумуул бас бус хорхой шавьж суудаггүй байлаа.

26-Түүний хувцас нь огт хиртдэггүй байжээ.

27-Түүний хойноос мелекүүд даган явдаг байсан болхоор асхабуудаа урдаа явуулдаг, ар талыг нь мелекүүдэд үлдээдэг байжээ.

28-Тэр чулуун дээр гишгэхэд чулуунд хөлнийхөн мөр үлддэг байв. Харин элсэн дээр явхад огт мөр үлддэггүй байлаа.

29-Хүн төрөлхтөн ба сахиусан тэнгэрүүдийн дундаас хамгийн их эрдэм мэдлэг түүнд өгөгджээ. Тэр хэнээр ч юуч заалгаагүй атлаа Аллах эзэн түүнд бүхнийг сургажээ.

Түүний оюун ухаан хүмүүсийнхээс илүү их юм

30-Тэрээр хамаг дагалдагсадаа нэр ус ба царай зүсээр нь бүгдийг нь мэддэг байжээ.

32-Хүн төрөлхтөнд байх бүхийл сайхан зан авир түүнд ноогджээ.

33-Калима-и шахадатад (тангарагийн үг) азанд, каматад, намазд, тэшэхүдэд, олон тооний залбиралд (тарни), зарим мөргөлд айлдалд, хүнд хэцүү цагүед, булшинд, махшард (талбар), диваажинд бас бүхий л хүн төрлөхтний хэл ярианд Аллах эзэн түүний нэрийг өөрийнхөө нэрний хажууд дурдуулжээ.

34-Бүхий зүйлээс хамгийн дээд нь Мухаммед элч

(салаллаху алейхи уа сальлам) юм. Аллах эзэн түүнийг өөрийн найзаа болгож түүнийг бүр бүхнээс, бүх мелекүүдээс ч илүү хайрлажээ. “Ибрахиммийг Халил болгосон бол, чамайг өөртөө Хабиб (хайрт) болголоо” хэмээжээ.

35-“Чамд баярлах хүртэл (одоо болно гэх хүртэл) хүссэн бүхнийг чинь өгнө” (Духа сүре, 5) энэ аетын утга нь Аллах эзэн Мухаммед элчид (салаллаху алейхи уа сальлам) бүхий л эрдэм мэдлэг, бүхий л дээдийн заяа дайснууных нь эсрэг тус дэм, ялалт, хойд ертөнцийн бүхий л буян хишгийг харамгүй заяах юм.

36-Аллах эзэн Куран Керимд бүх элчүүдийг өөрийнх нь нэрээр дурдсан бол харин Мухаммед алейхиссальламыг “Аяа, элч минь, аяа, пайгамбар минь, аяа, Хабибим (хайрт элч минь)” гэж нэрийджээ.

37-Тэрээр Араб хэлийг түгдрэхгүйгээр бүхий л аялгуугаар нь ярьдаг байв. “Аллах эзэн намайг маш сайн сурган бэлдсэн” хэмээжээ.

38-Маш бага үгээр их зүйлийг ойлгуулдаг байв. 100000-аас их хадис шериф (сургааль үг) нь түүнийг агуу илтгэгч байсаныг батална.

39-Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) нүгэлгүй ба нүглээс ангид байлаа. Мэдсэн ч, мэдээгүй ч том жижиг бүхий л нүглийг хийгээгүй бөгөөд хийхийг завдаагүй юм.

40-Мусульманууд намаз (мөргөл) үйлдэж байхдаа “Эссаламү алейка эююухан набиюу вэ рахметуллах” хэмээн элчид мэнд дэвшүүлдэг юм. Мухаммед элчээс (салаллаху алейхи уа сальлам) өөр элчүүдэд намаз үйлдэж байхдаа мэнд дэвшүүлдэггүй юм.

41-“Хэрвээ чи байгаагүйсэн бол, би юу ч тууривахгүй байсан” гэжээ.

42-Бусад элчүүдэд хийсэн хорлолд кафируудын хорлолд тэд өөрсдөө хариулдаг байсан байна. Мухаммед элчид хийсэн хорлолд Аллах эзэн өөрөө хариуг нь өгдөг байжээ.

43-Мухаммед элчийг (салаллаху алейхи уа сальлам) дагалдагсадын тоо бусад элчүүдийн дагалдагсадын тооноос их юм. Бас тэднээс илүү дээд илүү буянтай юм: диваажинд орогсодоос гуравны хоёр нь Мухаммед элчийн дагалдагсад юм.

44-Мухаммед элчид (салаллаху алейхи уа сальлам) өгөгдсөн буян бусад пайгамбаруудад өгөгдөх буянаас их юм.

45-Түүнийг нэрээр дуудах, хажууд нь чанга дуугаар ярих холоос орилж дуудах, түүний замд хөндөлцөн, хөндлөн огтолж гарах нь харам (цээртэй) юм.

46-Тэрээр Жабрайлийг (алейхиссальлам) сахиусан тэнгэрийнхэн дүрээр 2 удаа харжээ. Түүн дээр Жабрайл (алейхиссальлам) 24000 удаа иржээ.

47-Аллах эзэнд Мухаммед элчийн нэрийг барин ам өгж болох бөгөөд бусад элчүүд болон мелекүүдийн нэрийг барьж болохгүй юм байна.

48-Мухаммед элчээс (салаллаху алейхи уа сальлам) хойш эхнэрүүдээ бусдын никахтай авах нь (гэрлэх нь) харам (цээртэй) юм .

49- Үр удам ба хүйн холбоогоор хамаатан садан бологсод хойд ертөнцөд ямар нэг тус дэмгүй. Гэхдээ элчийн хамаатнууд өөр юм .

50- Элчийн нэрээр нэрлэгдэх нь энэ хорвоо ба хойд ертөнцөд илүү ачтай юм. Энэ нэрийг авсан жинхэнэ мусульман тамд унахгүй бөлгөө.

51-Түүний хэлсэн хийсэн бүхэн нь зөв юм.

52-Түүнийг хайрлах нь хүн бүрийн үүрэг “Аллахыг хайрлагсад намайг хайрла” хэмээжээ.

53-Эхл-и бейтийг (элчийн гэр бүл) хайрлах нь үүрэг юм. “Эхл-и бейтэд дайсан бологсод Мунафик (хоёр нүүртэн) юм” хэмээжээ.

54-Түүний асхабуудыг ч хайрлах нь үүрэг “Надаас хойш миний асхабд битгий дайсан болцгоо! Тэднийг хайрлах нь намайг хайрласантай адил. Тэдний дайсан болох нь миний дайсан болохтой адил, тэднийг гомдоох нь намайг бас гомдоосонтой адил, харин намайг гомдоогсод Аллахыг гомдоосон мэт. Аллах эзэн өөрийг нь гомдоогсодыг гэсгээдэг” хэмээжээ.

55-Аллах эзэн Мухаммед элчид (салаллаху алейхи уа сальлам) тэнгэрт хоёр, газарт хоёр туслах өгчээ. Эд нар бол: Жабрайл, Микайл (алейхимуссальлам) ба Эбү Бакир ба Омар (радиаллаху анһум ажмаин) хоёр юм.

56-Эр эм, хөгшин, залуу хэн ч байсан нас бархад булшинд нь Мухаммед элчийг асуух болно. “Эзэн чинь хэн вэ?” гэсэн шиг “Элч чинь хэн бэ?” гэж асууна.

57-Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) хадис-и шерифүүдийг (сургаал үгс) нь унших нь нэгэн залбирал

мөргөл юм.

58-Түүний гэгээн сүнснийг нь (амийг нь) авахийн тулд Азрейл (амь авагч сахиусан тэнгэр) ирж дотогш орохын тулд зөвшөөрөл гуйжээ.

59-Түүний булшин дахь шороо нь бүх зүйлээс Каабаас, бас диваажингаас ч илүү юм.

60-Тэрээр булшинд бидний үл мэдэх нэгэн амьдралаар амьдардаг юм. Тэр булшинд Куран уншиж мөргөл үйлддэг байна.

61-Дэлхийд хаан ч байсан Аллахын элчид салават (пайгамбард мэнд ба залбирал хэлэх) уншсан хүний мэндийг мелекүүд элчид ирж мэдэгддэг. Түүний булшийг өдөр бүр мянга мянган мелекүүд эргэн тойрдог юм.

62-Тэрний дагалдагсадаас эрдэмтэд ба мөргөлчидийг өглөө бүр, өдөр бүр түүнд харуулна. Эднийг харж нүгэл хийгсэдийг өршөөгдөхийн төлөө залбирал үйлддэг юм.

63-Түүний булшийг эргэх нь эмэгтэйчүүдэд ч мустахаб (зөвшөөрөгдсөн) юм.

64-Тэрнийг амьд ахуйд нь байсан шиг нас барсаны дараа ч түүний нэрийг барьж залбирагсацийн залбиралийг Аллах биелүүлдэг.

65-Хойд ертөнц эхлэхэд хамгаас түрүүн Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) булшнаасаа өндийн гарах болжээ.

66-Зургаан газар шафагат (өмгөөлөл үзүүлэх) хийх болно. Нэгдэх нь, “Макам-и Махмуд” гэх өмгөөлөлөөрөө бүхий л хүмүүсийг махшер (талбарт) хүлээх зовлонгоос аврах болно. Хоёр дахь нь, өмгөөлөл их хүмүүсийг диваажинд оруулах болно. Гурав дахь нь, гэсгээл хүртэх ёстой хүмүүсийг гэсгээл тамлалаас нь аврах болно. Дөрөв дэх нь, нүгэл ихтэй мусульмануудийг тамаас гаргах болно. Тав дах нь, буян нүгэл нь тэнцсэн Араф гэх газар хүлээгсэдийг диваажинд оруулахаар өмгөөлөх болно. Зургаа дах нь, диваажинд орогсодын зиндааг дээшлүүлэхээр өмгөөлөх болно.

67-Аллахын элчийн (салаллаху алейхи уа сальлам) диваажинд байх зиндааг Весиле гэдэг. Энэ бол диваажингийн хамгийн дээд газар юм. Диваажинд байх хүмүүст нэг мөчир нь үзэгдэх Сидрет-үл Мүнтаха модны үндэс нь энэ газар юм. Диваажингийн буян хишиг энэ мөчирөөр өгөгдөх юм.

**Пайгамбарын маань дагалсадынхаа
төлөө хийсэн истигфар
(наминчлал)**

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) бүхий л бүтээгдэгсэдээс хамгийн дээд нь болсон адилаар Аллах эзэнийг хамгийн сайн таниж, түүнээс хамгийн их айдаг нь байлаа. Аллах эзэн түүний нүгэл хийхээс ангид болсон атал тэр огт зогсолтгүй залбирал мөргөлөө үйлддэг байв. Ибн-и Аббас ийн айлджээ: “Би нэг өдөр муминүүдийн эх гэгээн Меймүнегийн гэрт зочилсон юм. Аллахын элч шөнө дунд хүртэл унтаад дараагаар нь босон дарет (угаалга) үйлдээд Али-Имран сүрегийн сүүлийн 10 аетыг уншаад, дараагаар нь намаз (мөргөл) үйлдэхээр зогслоо. Бич мөн адил элчийн адилаар босон угаалга үйлдээд, элчийн хажууд мөргөхөөр зогслоо. Пайгамбар маань 2 рекать (үе) уншаад, дараа нь ахиад 2 рекать (үе) уншаад, ахиад 2 үе уншаад дараагаар нь Витир намаз үйлдэхээр зогсов. Энэ мөргөлийг өглөөний азан (намазын дуудлага) дуудах хүртэл хэсэг унтав. Дараагаар нь босоод ахиад 2 рекать (үе) үйлдээд үүрийн намазын фарзыг үйлдэхээр месжид рүү гарч явав.

“Мүслим” гэх номонд байх хадис- шерифт “Зүрхэнд минь сонин зүйлүүд бодогддог болхоор өдөр бүр би оройгоор 70 удаа Аллах Теалагаас өршөөл гуйнам” бас “Зүрхэнд минь (Аллахын туяа ирэхийг нь хаасан) хөшиг татагдан байна. Тийм болохоор өдөр бүр 70 удаа нүгэлээ наминчилж байна, бас өдөр бүр Аллагаас 100-удаа уучлал гуйж байна” хэмээжээ.

Расулаллах (салаллаху алейхи уа сальлам) Аллагаас маш их айдаг байсан болхоор элгээ хөштөл чангаар огт инээдэггүй байжээ.

Эбү Хурейрегийн (радиаллаху анх) авч ирсэн нэгэн хадис-и шерифт: “Хэн ч хийсэн сайн үйлээсээ болж диваажинд орохгүй” гэжээ. “Та ч бас уу?” гэж асуухад “Тийм ээ, намайг ч гэсэн сайн үйл диваажинд оруулахгүй, зөвхөн Аллахын хайр энэрэл л намайг бүрхэнэ” хэмээжээ

Ибн Омар (радиаллаху анх): “Аллахын элчтэй нэг удаа месжидэд сууж байхад элч “Аяа, Аллах минь, намайг уучил бас нүгэлийг минь наминчил. Чи бол нүгэл наминчлагч бас энэрэнгүй билээ “ гэж 100 удаа хэлхийг нь тоолж байсан юм.

Энэс бин Маликийн (радиаллаху анх) авч ирсэн нэгэн

хадист: «Пайгамбар маань үргэлж: “Аллахүмме мукаллиб аль кулуб, саббит калбий алаа диник” гэж хэлдэг байсан” хэмээжээ.

Шафагат (өмгөөлөл)

Аллахын элч (салаллаху алейхи уа сальлам) хойд ертөнцөд дагалдагсаддаа шафагат үзүүлэх болно. Өөрөөр хэлбэл, тэднийг хэцүү байдал, тамаас өмгөөлөн аврах болно. Нэгэн хадис-и шерифт: “Дагалдагсадаасаа талыг диваажинд оруулах ба өмгөөлөл хоёроос нэгийг нь сонго гэлээ. Би өмгөөлөлийг сонголоо. Ягаад гэвэл өмгөөлөл илүү ашигтай. Өмгөөлөл зөвхөн сайн мусальманчуудын хувьд биш, нүгэлтэй хүмүүст ч бас бий” гэсэн.

Эбү Хурейрагийн (радиаллаху анх) авч ирсэн нэгэн хадист пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам): “Миний шафагат (өмгөөлөл) зүрх сэтгэлээрээ шашинд итгэгчид ба чинь сэтгэлээрээ “Лаа илааха иллаллах” гэж хэлэгсэдэд байх болно” хэмээжээ.

Бусад хадис-и шерифт: “Дагалдагсадаас эхл-и бейт (Элчийн гэр бүлийг) хайрлагсадад шафагат (өмгөөлөл) бий”.

“Дагалдагсадаасаа том нүгэл хийгсэдийг өмгөөлнө”.

“Асхабуудыг минь муулагсадаас бусад бүхэнийг өмгөөлнө”.

“Дагалдагсадаасаа өөрийгөө хорлогсод бас өөрийн муу муухай тачаалд, ертөнцийн цэнгэл жаргалд хууртагсадад өмгөөлөл минь бий”.

“Хойд ертөнцөд хамгаас түрүүлж би өмгөөлөл хийнэ”.

“Миний өмгөөлөлд үл итгэгсэдэд түүнийг хүртээхгүй” хэмээжээ.

Киямет эхлэх дохио Сур үлээгдхэд маш аймшигт нэгэн дуу хорвоо ертөнцийг доргиоход, мусульман, кафир цөм махшарын (талбар) талбайд цуглацгаадаг. Энэ өдөр бол маш хүчтэй нэгэн тамлал юм.

Энэ үед хэн ч тэсэж үл чадах Аллах эзэний гэсгээлээс толгойнууд унжих болно. Хүн бүр айн сандарч байхдаа юу хийхээ үл ойлгон, өмгөөлөл туслах хүн хайх болно.

Элчүүд хүртэл айж гэгээнтнүүд ба шахидууд хүртэл

Аллах эзэний уур хилэнгээс айн чичэрцгээдэг болно. Энэ үед хүмүүс Аллахын элч болох Адамд (алейхиссальлам) очицгооно. “Аяа, Адам, (алейхиссальлам) чи эрхэм бас хүндтэй нэгэн пайгамбар билээ. Аллах эзэн анх чамайг туурвиж мелекүүдийг чамд мөргөхийг зарлигласан. Шүүлт эхлэхэд бидэнд шафага (өмгөөлөл) үзүүлэн тусал хэмээн гуйцгаана.

Адам алейхиссальлам ийн хэлнэ: Би Аллах эзэний хориглосон модноос жимс идсэн юм. Одоо Аллахаас ичиж байна. Та нар Нух пайгамбард (алейхиссальлам) очицгоо” гэв. Ийнхүү 1000 жил өнгөрчээ.

Дараагаар нь хүмүүс Нух пайгамбард (алейхиссальлам) очицгоов. “Бид маш их зовж байна. Бидний шүүлтийг минь хурдан болгож өнгөрөөхийн тулд биднийг өмгөөл. Энэ махшарас ангижирмаар байна” хэмээн гуйцгаана. Тэдэнд: “Би Аллах эзэндээ залбирсан юм. Ингэж залбирахдаа хорвоо дээр хичнээн хүн байна цөм усанд живж үхэцгээсэн юм. Тийм болохоор Аллах эзэнээсээ ичиж байна. Та нар Халиллуллах болсон Ибрахим пайгамбард (алейхиссальлам) очицгоо гэнэ. Мөн л 1000 жил хүмүүс махшарт зовно.

Тэд Ибрахим элчид очоцгооно: “Аяа, мусульманчуудын эцэг минь, чи бол Аллахын Халил хэмээн өргөмжлөгдсөн пайгамбар билээ. Бидэнд шафагат үзүүлэн энэ зовлонгоос аварч хайрла” хэмээн гуйна. Ибрахим (алейхиссальлам): “Би хорвоод 3 удаа ёгт учиртай үг хэлсэн юм. Энэ үгийг хэлээд шашины замд тэмцсэн билээ. Одоо би ахиж Аллахаас өмгөөлөх эрх асуухаасаа ичиж байна. Та нар Муса элчид очицгоо, тэр та нарыг өмгөөлж чадна” гэв.

Ахиад 1000 жил тэд махшарт зовжээ. Энэ үед махшарын тамын халуун улам ширүүсч маш давчуу болсон байна. Тэд Муса элчид (алейхиссальлам) очно. “Аяа, Ибн-и Имран! Чи бол Аллах эзэнтэй ярьсан, Таврат судрыг гардан авсан элч билээ. Биднийг шүүх цагт бидэнд өмгөөлөн тусла” хэмээн гуйцгаана. Муса: “Би Аллах эзэнээс ал-и Фараоныг гэсгээхийн тулд олон жил залбирал үйлдсэн юм. Бас хойч үед сургамж болог гэж хэлсэн юм. Одоо өмгөөлөл гуйхаасаа ичиж байна. Аллах энэрэлт эзэн билээ. Та нар Иса элчид (алейхиссальлам) очицгоо. Тэр та нарт өмгөөлөл үзүүлж магад” гэв.

Хүмүүс махшарын зовлонгоос аврагдхын тулд Исад (алейхиссальлам) очицгоон: “Чи Аллах эзэний руху ба келиме

гэж алдаршсан элч билээ. Аллах чамайг Куран сударт Али Имран сүренд: “Энэ хорвоо ба хойд насандаа маш хүндтэй” хэмээн магтан дуулсан билээ. Бидэнд шафагат (өмгөөлөл) үзүүлж хайрла” гэж гуйцгаана.

Иса (алейхиссальлам): “Миний дагагсад намайг бас эхийг минь Аллахтай хамт бурхан гэж хэлсэн юм. Тэд намайг шүтэн сүсэглэж, надад мөргөсөн юм. Би яаж Аллахаас шафагат (өмгөөлөл) гуйх вэ? Ичиж байна. Та нар элч нарын хамгийн дээд нь болсон Мухаммедэд очицгоо. Учир нь тэр уриа ба шафагатаа дагалдагсаддаа бэлэглэхээр үлдээсэн юм” гэв .

Хүмүүс нэн даруй Мухамед элчид (салаллаху алейхи уа сальлам) очицгооно: “Чи Хабибуллах (Аллахын хайрт) юм. Хабиб бол хамгийн ойр гэсэн үг билээ, бидэнд шафатат (өмгөөлөл) үзүүл! Биднийг зовлонгоос ангижируул, бидэнд одоо чамаас өөр туслах хэн ч үгүй” гэж гуйцгаана.

Аллахын элч Мухаммед (салаллаху алейхи уа сальлам): “Аллах эзэн зөвшөөрөл өгвөл шафагат (өмгөөлөл) үзүүлнэ” хэмээв .

Сурадикат-и жалелд, өөрөөр хэлбэл, жалел хөшгинд очоод Аллах эзэнээс шафагат (өмгөөлөл) үзүүлэх эрх гуйна. Өөрт нь зөвшөөрөл өгөгдсөний дараа хөшиг нээгдэв. Дараа нь Арши алад (дээд тэнгэр) очоод мөргөн залбирч эхлэнэ. 1000 жил газар мөргөнө (огт өндийлгүйгээр). Дараагаар нь Аллах эзэнийг магтан дуулна. Огт хэн ч, хэзээ ч ингэж магтаж байгаагүйгээрээ магтана.

Аллах эзэн “Аяа, Мухаммед, толгойгоо өргө, хэл! Сонсоно. Шафагат хий, зөвшөөрөгднө” хэмээнэ. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам): “Аяа, Аллах минь, боолуудаасаа сайн, муунуудыг нь ялгаач. Их хугацаа өнгөрч байна. Цөм хийсэн нүглээсээ болоод арасатын талбарт шившиг болж байна” гэв.

Аллах эзэн там ба диваажинийг авч ирүүлхийг тушаана. Тамыг ирэхэд түүний тэнгэрт хадан нүрэлгэх дуу орилон, шуугиан нь хүн сонсож тэвчишгүй аймшигт ажээ. Гал цацарсан халуун тогоонд лав буцалж түүнийг харсан хүн бүр айж сүрдэнэ.

Тэр бүү хэл элчүүд ч хүртэл өөрсдийгөө барьж үл дийлнэ. Арш-и алагаас барьж чичирцгээнэ. Ибрахим пайгамбар (алейхиссальлам) өөрийн хүү Исмайлийг мартана, Муса (алейхиссальлам) дүү Харуныг мартна. Иса (алейхиссальлам) эх Мариямийг мартана. Зөвхөн өөрсдийгөө бодоцгоож цөм: “Аяа,

Эзэн минь! Өнөөдөр биднийг өөрсдийг минь л авар” гэгцгээнэ.

Харин Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам): “Аяа, Эзэн минь! Дагалдагсадад минь мэнд амарыг өгч, зовлонгоос авраач” хэмээн залбирна. Тэнд энэнийг бодох хүн Мухаммед пайгамбараас (салаллаху алейхи уа сальлам) өөр үгүй билээ. Там: “Аяа, Мухаммед, замаас минь холд! Чи надад харам (хориотой) билээ. Би нүгэлтнүүдийг залгимаар байна” хэмээн орилно. Элч (салаллаху алейхи уа сальлам) тамын өмнө зогсоод “Юу ч авахгүй, хойшоогоо буц! Чамд орох нүгэлтэнүүд бүлэг бүлэгээрээ ирцгээг” гэв. Арш-и Алагаас (дээд тэнгэр) нэгэн дуу: “Хөөе, там! Мухаммед элчийн үгийг сонс, түүнийг дага!” гэж тушаав. Дараа нь Аллахын элч (салаллаху алейхи уа сальлам) тамыг чирч Арш-и Алагийн зүүн талд аваачина. Махшард байсан ард олон элчийн энэ энэрэл нигүүсэлийг нэг нэгэндээ дуу алдан хэлцгээн аймшиг нь түрч атугай сарнина. Анбия сүрегийн 107 дахь аетэд: “Чамайг хорвоогийн энэрэл болгон илгээв” гэх утгийг одоо л хүмүүс ойлгоно.

Товчлоод ярихад, Аллахын элч Мухаммед (салаллаху алейхи уа сальлам) 6 газар шафагат (өмгөөлөл) үзүүлэх юм. Нэг дэх нь, Макам-и Махмуд гэх шафагатаараа бүхий л хүмүүсийг махшер талбарын хүлээх зовлонгоос өмгөөлнө. Хоёр дах нь, маш олон хүнийг диваажинд оруулахад шафагат хийнэ. Гурав дахь нь, тамлагдах ёстой мусульмануудыг тамлалаас нь аврах болно. Дөрөв дэхь нь, нүгэл нь их мусульмануудыг тамын тогооноос аварна. Тав дахь нь, буян нүгэл хоёр нь тэнцүү болж, Араф гэх газар хүлээгсэдийг диваажинд оруулхад нь өмгөөлнө. Зургаа дахь нь, диваажинд орогсодыг зиндааг дээшлүүлэхээр өмгөөлөх болно.

МУГЖИЗЕНҮҮД (ГАЙХАМШИГУУД НЬ)

Хайрт пайгамбарын маань (салаллаху алейхи уа сальлам) Аллахын жинхэнэ элч болохыг батлах зүйл хэмжээлшгүй олон билээ. Аллах эзэн: “Хэрвээ чи байгаагүйсэн бол хорвоо ертөнцийг туурвихгүй байх байлаа” хэмээжээ. Бүхий л юмс Аллах эзэний буйг нь гэрчилдэг шиг Мухаммед элчийг элч болохыг бас түүний дээдийн нэгэн болохийг харуулна. Түүний дагалдагсадаас гэгээрэлд хүрэгсэдийн хийсэн гайхамшиг бол зөвхөн түүний гайхамшиг юм.

Элчийн (салаллаху алейхи уа сальлам) энэ мугжизенуудыг (гайхамшигуудыг) гурван үндсэн цаг хугацаанд хувааж болно. Нэг дэх нь, түүний гэгээн сүнс туурвигдсан өдрөөс эхлэн элчийн үүрэг өгөгдсөн, үе хүртэл. Хоёр дахь нь, элчийн үүрэг өгөгдсөн цагаас нас нөгчсөн үе хүртэл. Гурав дахь нь, нас нөгчсөнөөс эхлэн хойд ертөнц хүртэл юм. Элчийн (салаллаху алейхи уа сальлам) энэ гайхамшигүүдээс цухас дурьдвал:

1-Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) энэ гайхамшигуудын хамгийн том нь Куран керим судар юм. Өнөөдрийг хүртэл бүхий л зохиолчид, их ярууу найрагчид цөм Куран судрын үг, утга, хэвшмэл байдалыг нь хараад гайхан шагшигддаг билээ. Зөвхөн ганцхан аеттай төстэй шүлэг бичиж үл чаджээ. Түүний уран яруу хэллэг ба найраглал, үгийн санд хүний оюун ухаан хүрч үл чадна. Куран сударт өнгөрсөн ба ирээдүйд болох зүйлүүдийг айлдсан байдаг. Тэр сударыг сонсогсод, уншигчид амтанд нь ханаж үл чадна. Түүнийг уншиж сонсох нь маш олон гай гамшиг зовлон гэсгээлийг алга болгодог билээ. Маш олон хатуу зүрхт дайсанууд, буруу номтонууд Куран Керимыг сонсоод элэг нь дэвтэж итгэлээ олсон юм.

2-Нэг өдөр авга ах Аббасын гэрт ирээд түүнийг ба хүүхдүүдийг нь хажуудаа суулгаад тэднийг ихрамаар (мөргөлийн хувцас) бүрхээд: “Аяа, Эзэн минь, энэ авга ах ба түүний гэр бүлийг бүрхсэн шиг тамын галаас тэднийг хамгаал!” гэв. Гэнэт хаанаас 3 удаа Амин гэх дуу дуулдав.

3-Нэг өдөр гартаа шавар бурхан барьсан нэгэн хүнд “Наад бурхан чинь надтай ярьвал чи надад итгэх үү?” гэв. Нөгөө хүн: “Би энэ бурхандаа 50 жил мөргөж байна. Надад одоог хүртэл юу ч хэлээгүй. Чамд яаж хэлэх юм” гэв. Мухаммед элч (салаллаху

алейхи уа сальлам): “Хөөе, шавар бурхан, би хэн бэ?” гэж асуухад бурхан: “Чи бол Аллахын элч мөн” хэмээв. Нөгөө хүн даруйхан мусульман болжээ.

4-Аллахын элч (салаллаху алейхи уа сальлам) нэг удаа нуга газар явж байтал 3 удаа “Аяа, Аллахын элч минь!” гэх нь дуулдав. Тэр зүгт хартал нэгэн хүлээтэй буга байв. Түүний хажууд нэг хүн унтаж хэвтэнэ. Бугаас хүсэлтийг нь асуухад “Энэ анчин намайг агнаж барилаа, хажууд байх ууланд хоёр янзага минь бий. Намайг суллаач, би 2 янзагаа сүүгээр цатгаад хүрээд ирнэ” гэв. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам): “Хэлсэн үгэндээ хүрч ирнэ биз!” гэхэд буга: “Аллахын нэрийг барьж амлая” гэв. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) бугийг суллаав. Буга ч төдөлгүй эргээд иржээ. Энэ үед нөгөө анчин ч нойрноосоо сэрж элчийг хараад гайхан: “Аяа, Расулуллах! Надад тушаах зүйл байна уу?” гэв. Элч “Энэ бугийг суллаач” гэж гуйв. Анчин ч ёсоор болгон сулалхад буга: “Эшхадү эн лаа илаха иллалах, вэ эшхадү анна Мухаммед расулуллах” гээд давхин оджээ.

5-Хоёр нүд нь сохор нэгэн хүн элчид ирж “Аяа, Расулуллах! Хараа оруул гэж залибираач” гэж гуйв. Пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) түүнд сайн угаалга үйлдээд дараагаар нь: “Аяа, Эзэн минь, чамд мөргөн гуйж байна. Хайрт элч Мухаммедыг чинь барьж чамаас гуйя. Чиний хамгийн их хайрладаг элч бол гэгээн Мухаммед, би түүнээр өмгөөлүүлж чамд залбирч байна. Тэрний төлөө миний залбиралийг хүлээн зөвшөөрөөч. “Аяа, Эзэн минь, энэ агуу элчийг надад өмгөөлөл болго. Түүний хүндлэлд миний хүсэлтийг биелүүл” хэмээн залбирахийг зөвлөв. Нөгөө сохор түүний хэлсэнчлэн хийгээд хараа оржээ.

6-Нэг эмэгтэй элчид зөгийн бал бэлэг болгон өгчээ. Балыг аваад сул савыг нь буцаан явуулав. Аллах эзэний сүр хүчээр нөгөө сав нь дахиад балаар дүүрэн эзэндээ очижээ. Нөгөө эзэгтэй элчид ирээд “Аяа, Расулуллах, би юуг буруу хийсэн бэ? Та миний бэлгийг хүлээн авсангүй гэхэд “Чиний бэлгийг би авсан. Харин чиний үзсэн бал бол Аллахын чамд өгсөн буян хишиг юм” хэмээв.

7-Пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) өөрийн дагалдагсадаас олон хүмүүсийг далайн замаар дайнд очихыг, мөн тэд нарын дотор Үммү Хирам гэх эмэгтэй ч болохыг хэлжээ. Элчийг нас барсаны дараагаар Осман мусульманчуудын

хаан байх үед Кипрд очиж дайтлаа. Нөгөө эмэгтэй далайд амиа алдсан байна.

8-Гэгээн Муавиед “Хэзээ нэгэн цагт чи дагалдагсадад ноён болох юм бол сайн үйл хийгсэдийг урамшуул, муу үйл хийгсэдийг өршөө” хэмээжээ. Гэгээн Муавие Омар гэгээн Османы үед (радиаллаху анх) Шам хотод 20 жил амбан захирагч байгаад сүүлийн 20 жил мусульманчуудийн захирагч болжээ.

9-Абдуллах бин Аббасын эхэд хандаж “Чи нэг хүү төрүүлэх болно. Тэр хүүг төрсөний дараа надад авч ир” гэжээ. Нөгөө эзэгтэй хүүтэй болон, хүүгээ элчид авч ирэв. Түүний чихэнд азан дуудаад өөрийн шүлсээр хүүгийн уруулыг арчаад, нэрийг нь Абдуллах гэж өгөв. Хүүг эхэд нь өгөхөд “Амбан захирагчийн аавыг аваарай” гэв. Нэрээ ч сүүлд Аббасын үе ирхэд бүх амбан захирагчид Абдуллахын үр удамын хүн байжээ.

10-Авга ахынхаа хүү Абдуллахын магнайд гараа тавиад “Аяа, Аллах минь! Энэ хүүг шашинд гүн эрдэмтэн болго, Куран сударын эрдэмийг түүнд хайрла” хэмээжээ. Абдуллах бин Аббас энэнээс хойш үзсэн бүхнээ сурдаг хүү болон хувирч, бүхий л эрдэмийг гарамгай эзэмшжээ. Тэрээр тэфсир (Кураны тайлбарлал), хадис (элчийн хэлсэн үгс) эрдэмүүдийг эзэмшин тухайн үеийн гац ухаантан болжээ.

11-Өөрийн ажилчидаасаа Энэс бин Маликт: “Аяа, Аллах минь, энэ хүний мал баялагийг нь ихэсгэж үр хүүхдийг нь ч олшруулж урт наслуулж, нүглийг нь наминчлаач” хэмээн залбирчээ. Цаг хугацаа өнгөрөх тусам Энэсийн эд баялаг нь арвижиж, эдлэг газар орд харштай болжээ. Үр үүхэд нь ч гэсэн олон болжээ. Мөн 110 насалжээ. Насны эцэст тэрээр “Аяа, Аллах минь! Элчийн миний төлөө залбирсан 4 зүйлээс гурвыг нь биелүүлжээ. 4 дэхь нь болох нүгэл наминчилах нь юу болох вэ” гэхэд “4 дэхийг нь ч гэсэн биелүүлнэ” гэх дуу хаа нэгтэйгээс сонсогдов.

12-Хижрет (их нүүдлийн) 3 дахь жилд Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) Катфан дайнд нэгэн модны сүүдэрт сэрүүцэн хэвтэн байхад Дасур гэх нэгэн лагс биетэй кафир ирээд, сэлмээ сугалан “Чамайг миний гараас хэн аврах вэ” гэж хэлхэд Аллахын элч (салаллаху алейхи уа сальлам): “Аллах аварна” гэв. Энэ үед Жабрайл (алейхиссальлам) хүний дүрээр гарч ирээд Дасурийн цээжинд цохиж унгаав. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) түүний сэлмийг шүүрч аваад

“Одоо чамайг миний гараас хэн аврах юм бэ?” гэж асуухад Дасур намайг аврах буянтай хүн чамаас өөр байхгүй хэмээн амь хэлтэрүүлэхийг гуйжээ. Энэрэлт элч (салаллаху алейхи уа сальлам) тэрнийг сулалсанаар Дасур мусульман болжээ. Олонч хүнийг мусульман болгох шалтгаан болжээ.

13-Аллахын элч (салаллаху алейхи уа сальлам) угаалга үйлдэж дуусаад нэг гутлаа өмсөөд, нөгөө гутлаа өмсөхөөр гараа сунгахад нэгэн шувуу нисэж ирээд гуталыг нь урьтан шүүрээд агаарт сэгсэрхэд дотроос нь нэг хорт могой унжээ. Энэ мөчөөс эхлэн гутал өмсөхдөө сэгсэрэх нь элчийн сүннет болжээ.

14-Гэгээн Энес (радиаллаху анх) ийн өгүүлнэ: “Элчид нүүрээ арчдаг нэг даавуу байна. Энэ даавуугаараа үргэлж арчдаг, хиртсэн үед нь гал руу шатаадаг байна. Даавуу нь огт шатахгүй цэв цэвэрхэн болоход хир нь устаж алга болдог байлаа”

15-Ухуд дайнд Эбу Катадегийн (радиаллаху анх) өрөөсөн нүд нь аяганаасаа мултран гарч хацар дээр нь унжээ. Элчид нүдээ барьсаар ирэхэд элч (салаллаху алейхи уа сальлам) өөрийн гараараа нүдийг нь аяганд нь оруулахдаа “Аяа, Аллах минь, нүдийг нь улам сайхан болго” хэмээн залбирчээ. Тэр цагаас хойш нөгөө нүд нь урьдийхаасаа ч илүү сайн хардаг болжээ.

16-Аллахын элч (салаллаху алейхи уа сальлам) охин Фатимагийнхаа гэрт очиж бие байдлийг нь асуухад Фатима: “Аяа, эцэг минь, 3 хоног бид юу ч идсэнгүй. Идэх зүйл алга. Хасан ба Хусейн хөвгүүд минь зовж байна, би ч яахав” хэмээн зовлон тоочиход пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам): “Аяа, Фатима хайрт охин минь, би 4 хоног өлсгөлөн явна. Хэлэн дээрээ юу ч тавьсангүй” хэмээв. Өөрийн зээ нар болох Хасан ба Хусейн хоёроо өрөвдөж харлаа.

Эцэг гэгээн Али ажил хийж мөнгө олохоор явжээ. Медине хотоос гадагш гарахад нэг худагны хажууд тэмээнүүдээ услаж байгаа нэг хөдөөний хүнийг харав. Тэрний хажууд очоод “Хөөе, араб! Тэмээгээ услуулах ажилчин хэрэгтэй юу?” гэхэд нөгөөх нь “Тийм ээ, би тийм ажил хийх хүн хайж байна. Чи ажилламаар байвал ирээд ажилла, чиний татсан ховоо ус бүрт би 3 хурма жимс өгөө” гэв. Гэгээн Али зөвшөөрөөд, ус татаж тэмээгээ услаж эхлэв. 9 ховоо ус гарсаны дараагаар ховооны олс тасран худагны ёроолд унжээ. Энэнийг үзмэгц нөгөө хөдөөний хүн уурлан босож ирээд, гэгээн Алиг шанадан цохиж дараа нь ховоо унсаны төлөө 2 хурма жимс өгөв. Али энэ явдалд маш их гоморхожээ. Гэвч юу

ч хэлсэнгүй худаг руу гараа сунган ховоог нь аван худагний ирмэг чулуун дээр тавиад яваад өглөө.

Энэ бүхнийг анхааралтай харж суусан нөгөө хүн гайхширч хоцров. Тэрний гар ийм гүн худагний ёроолд яаж хүрэв ээ? Эсвэл энэ хүн нөгөө ирэх нь мэдэгдсэн сүүлчийн элчийн шашины төлөөлөгч юм болов уу? хэмээн бодож суусан хөдөөний хүн “Түүний элч нь жинхэнэ элч болоход нь итгэнэм” гэв.

Өглөө нь тэр хүнд гаргасан бүдүүлэг зангаасаа ичиж гэмшин “Ийм ариун явдалт хүнийг цохисон гар тайрагдан, яс нь өгрөг” гэж хэлээд сэлэмээ сугалан нөгөө гараараа цохисон гараа бугуйгаар нь тайрч орхив. Маш их өвдсөн боловч гэмшил нь арилан зүрх нь тайван болжээ. Тайрагдсан гараа нөгөө гараараа барин мөсжид-и Небид иржээ. Асхабуудаас элчийг сураглахад гэртээ харьсан гэж хэлэхэд нь Фатима эхийн гэрийг сурагласаар явж очив. Энэ үед пайгамбар (салаллаху алейхи уа сальлам) зээ хүүхэд нь болох Хасан ба Хусейнийг өвөр дээрээ суулгаад Алигийн авч ирсэн хумагаар хоолож сууна. Хөдөөний хүн хийсэн буруу үйлдэлээ бодхоор бачуурах шахам харуусан уйлж байв. Фатима эхийн хаалгийг тогшиход сар адил гэрэлтэх гэгээн элч хаалга онгойлгов. Хөдөөний хүн элчийг харсан даруйдаа “Би чамайг Аллахын элч гэдэгт итгэж байна, миний хийсэн буруу үйлдэлийг уучил элч минь” хэмээн гуйв.

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) “Гараа ягаад тайрав?” гэж асуухад “Чамд итгэсэн ариун хүний нүүрийг цохисон энэ бузар гараа харахаас цээрлэж тайрсан юм” гэв.

Энэрэлийн булаг болсон элч (салаллаху алейхи уа сальлам) түүнийг тайрагдсан гарийг барин “Бисмиллахиррахманиррахим” гэж хэлээд буцаан нийлүүлэхэд нэгэн гайхамшигаар гар урган хэвэндээ орон эдгэжээ. Аллах бол бүхнийг хийгч, бүхнээс хүчтэй билээ.

ЭХЛИ БЕЙТ (ЭЛЧИЙН ГЭР БҮЛ)

Аллахын элч маань (салаллаху алейхи уа сальлам) гэгээн Хадижэ эх таалал төгссөнөөс хойш 2 дахь эхнэр болох гэгээн Эбү Бакирийн охин Айшетэй гэрлэжээ. Энэ гэрлэлт Аллахын зарлигаар болсон юм. Нас нөхжих хүртлээ 8 жил түүнтэй хамт амьдарчээ.

Харин бусад гэрлэлтүүд нь цөм төрийн бодолго, энэрэлийн төлөө, эсвэл шашинаа түгээхийн төлөө байжээ. Элчийн эхнэрүүдийн цөм нь бэлэвсэрсэн эмэгтэйчүүд ба настай хүмүүс юм. Жишээ нь, гэгээн Омарын охин Хафса бэлэвсэрч хоцорчээ. Хижретийн (их нүүдэлийн) 3 дахь жилд Омар, Эбү Бакир ба Осман нарт “Миний охинийг аваач” гэж санал болгоход тэд: “Бид бодож үзье” гэхээс өөр шийд хэлсэнгүй. Нэг өдөр мөсжидэд Омарыг гомдонгуй суухыг нь анзаарсан Аллахын элч (салаллаху алейхи уа сальлам): “Аяа, Омар юунд гуниглаа вэ?” гэж асуухад болсон бүх явдалыг нуулгүй хэлэв. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) хамгийн их хайрладаг гурван асхабаа хооронд нь муудалцуулахыг хүсээгүй учираас “Аяа, Омар, чи охиноо Эбү Бакираас ч, Османаас ч илүү сайн хүнд өгөхийг хүсэж байна уу?” гэхэд Омар гайхжээ. Учир нь Эбү Бакир ба Османаас ч илүү сайн хүн зөвхөн элч юм. Омар “Тийм ээ, аяа, пайгамбар минь!” гэхэд “Омар минь, охиноо надад өг” хэмээн айлдсанаар гэгээн Хафса Эбү Бакирын бас Османы төдийгүй бүхий л мусульмануудын энэрэлт эх болон элчийн таалалд багтжээ. Энэ цагаас хойш Эбү бакир, Омар, Осман (радиаллаху анхум) гэх хайрт 3 асхаб нь улам их сайн найзууд болжээ.

Өөр нэгэн жишээ: Их нүүдэлийн 6 дахь жилд Бени Мусталак овогтой хийсэн дайнд зуугаад хүмүүс олзлогджээ. Энэ хүмүүс дунд овгийн ахлагч Харисын охин Жувейра байсан юм. Элч (салаллаху алейхи уа сальлам) түүнийг худалдан аваад гэрлэх ёслолоо батлуулахад олзологсодыг авсан мусульманууд: “Бид элчийн эхнэрийн хамаатан садануудыг өөрсдөндөө боол болгох нь зохисгүй” гэж хэлээд тэднийг суллан явуулж эхэлсэн нь энэ гэрлэлт олон хүнийг эрх чөлөөтэй болгох шалтгаан болжээ. Гэгээн Жувейра (радиаллаху анха) энэ явдалыг үе үе хэлж магтан суудаг байна. Гэгээн Айше: «Жувейра шиг буян заяатай эмэгтэй хараагүй билээ» гэж хэлдэг байсан.

Гэгээн эхнэрүүд нь

Гэгээн Айше (радиаллаху анха): Алладын элчийн (салаллаху алейхи уа сальлам) хоёр дахь гэргий, Эбү Бакир Сиддикийн (радиаллаху анха) охин юм. Ухаалаг эрдэмтэй, ариун явдалт, цэвэр цэмцгэр нэгэн юм. Цээжлэх нь маш сайн болохоор асхабууд маш олон зүйлийг түүнээс асууж сурдаг байлаа. Аллах түүнийг аетээр магтан дуулсан юм. Хижрет их нүүдлээс 8 жилийн өмнө хорвоод мэндэлж 57 дахь жилд ба 65 настайдаа таалал төгсжээ.

Севде бинти Зема (радиаллаху анха): Алладын элчийн (салаллаху алейхи уа сальлам) 3 дахь эхнэр нь юм. Өөрийн анхны нөхөртэйгөө итгэлтэн мусульман болоод Хабешстан (Етёп) руу нүүсэн юм.Тэд Меккед буцаж ирхэд нь нөхөр нь нас барж, бэлэвсэрч хоцорсон юм. Алладын элч (салаллаху алейхи уа сальлам) эхлээд гэгээн Айшетэй дараагаар нь гэгээн Севдетэй гэрлэх ёслол үйлджээ. Гэвч Севдетэй Мекке хотод, Айшетэй Медине хотод хуримаа хийжээ. Севде маш энэрэнгүй, ариун журамт нэгэн эзэгтэй байлаа. Тэрээр гэгээн Омар халифе (мусульмануудын захирагч) байх үед нас баржээ.

Зейнеф бинти Хузейме (радиаллаху анха): Тэр маш их мөргөл үйлддэг, шударга нэгэн юм. Өмнө нь Абдуллах бин Жахшийн (радиаллаху анх) эхнэр билээ. Нөхөр нь Ухуд дайнд шехид болж Алладын элчийн (салаллаху алейхи уа сальлам) гэргий болж, ивээлд орсоноор 8 сарын дараа нас баржээ.

Үммү Селеме (радиаллаху анха): Түүний нэр Хинди юм. Нөхөр Эбү Селеметэйгээ Хабешстан (Етёп) руу анх нүүгсэдийн дунд байв. Нөхөр Эбү Селеме нь Мединед хижретийн 4 дэхь жилд Ухуд дайнд амиа алджээ. Тэрээр Эбү Бакир ба Омарын (радиаллаху анхум) гэрлэхийг хүссэн саналыг хүлээн зөвшөөрсөнгүй. Элчийн гэрлэлтээр дээдлэгдсэн юм. Тэрээр 57 онд Медине хотод 84 настайдаа нас нөгчжээ. Элчийн (салаллаху алейхи уа сальлам) хамгийн сүүлд нас барсан эхнэр нь энэ юм.

Зейнеф бинти Жахш (радиаллаху анх): Тэрээр Алладын элчийн (салаллаху алейхи уа сальлам) авга охин дүү Үмейегийн охин нь юм. Абдуллах бин Жахшийн дүү нь юм. Эцгийнх нь нэр Верре байсан юм. Итгэлтэн болсноос хойш түүнийг Жахш гэж дууддаг болжээ. Алладын элч (салаллаху алейхи уа сальлам) Зейнефийг Зейд бин Харисетэй (радиаллаху анх) гэрлүүлжээ.

Зейд Зейннефтэй шударга бус байдгаас болж хижретийн 3 дахь жилд салцгаажээ. Элч (салаллаху алейхи уа сальлам) түүнтэй гэрлэхийг хүссэнийг дуулаад Зейнеф баярлан 2 рекать (үе) намаз (мөргөл) үйлдэн: “Аяа, Аллах минь, чиний хайрт элч чинь намайг хүсэж байна. Хэрвээ түүний ариун гэргийнүүдийн нэг болж хүндлэгдэх юм бол, намайг түүнд чи өөрөө өг” хэмээн залбирчээ. Түүний залбирал нь биелэгдэн Азхаб сүрегийн “Зейд түүний хувьд хүссэнээ хийсэний дараагаар (өөрөөр хэлбэл, Зейд түүнээс салсаны дараагаар) бид түүнийг чамд гэргий болголоо” гэх 37 дахь ает буужээ. Зейнефийн никахыг (гэрлэх ёсон) Аллах хийсэн болохоор, Аллахын элч (салаллаху алейхи уа сальлам) өөр гэрлэх ёслол хийгсэнгүй. Зейнеф (радиаллаху анха) энэ явдлаа үргэлж магтан: “Бүх охинийг эцэг нь гэрлүүлдэг, харин намайг Аллах гэрлүүллээ” хэмээдэг байв. Тэрээр тухайн үед 38 настай байв. Зейнеф их нүүдэлийн 20 дахь жилд 53 настайдаа нас баржээ. Буян үйлдэж өргөл өгөх маш их дуртай нэгэн байлаа. Үйлэнд уран юм. Гартаа юу л тааран ядууст тараан өгдөг өглөгч нэгэн юм. Гэгээн Айше эх (радиаллаху анха) энэ хүнийг маш их магтдаг байв: “Эхнэрүүдийн дундаас надтай хамгийн түрүүлж уулзах хүн бол өглөгч нэгэн” гэх хадис-и шерифийг (Мухаммед элчийн сургааль үг) хэлэх нь хамгийн түрүүлж нас барахыг нь мэдэгджээ. Зейнеф элчийн нас барснаас хойш хамгийн түрүүлж нас баржээ.

Гэгээн Сафие (радиаллаху анха): Хайвер жүүдүүдийн захирагч Хуей ибни Ахтабын охин нь юм. Хайберт нэгэн жүүдтэй сүй тавьсан байна. Дараагаар нь Кенана бин Хакик гэх баянтай гэрлэжээ. Хижретийн (их нүүдэлийн) 7 дахь жилд Хайвер дайнд ялалт авахад Сафие олзлогджээ. Тэрээр элчийн энэрэлээр эрх чөлөөт хүн болсон учраас шашинд орж мусульман болжээ. Аллахын элчийн (салаллаху алейхи уа сальлам) гэрлэх ёсоор дээдлэгдсэн хижрегийн 50 онд нас баржээ.

Гэгээн Меймуне (радиаллаху анха): Түүний жинхэнэ нэр нь Берре юм. Сүүлд элч (салаллаху алейхи уа сальлам) түүнийг Меймуне хэмээн өөрчилжээ. Хайверийн ялалтаас хойш мусульманууд Мекке рүү умре (хаж) явахад түүний нөхөр нь нас баржээ. Дараагаар нь элчийн гэрлэлтээр хүндлэгдэж, хижретийн 53 онд Мекке хотод хүнд өвчинд нэрвэгдсэн юм. “Намайг Меккегээс гарга. Учир нь Мухаммед элч намайг Меккегийн гадна нас барахыг минь хэлсэн юм” гэв. Түүнийг гаргахад тэрээр

пайгамбарын (салаллаху алейхи уа сальлам) гэрлэлтийн тэр газар байгаад нас баржээ.

Гэгээн Марие (радиаллаху анха): Тэрээр элчийн эмэгтэй боол байхдаа исламд орсон юм. Тийм болохоор элчийн гэрлэлтээр хүндлэгдэж Марие Египедийн Александрия гэх хотын ахмад захирагч Мукавкис бэлэг болгон илгээсэн бүсгүй юм. Үр удам ба төрсөн он сар өдөр нь мэдэгдээгүй юм. Гэгээн Марие эхээр пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) Ибрахим гэх хүүтэй болжээ. Марие эх маш даруу дөлгөөн зантай нэгэн юм. Тэрээр гэгээн Омарын халифе (мусульмануудын захирагч) байх үед 637 онд нас баржээ. Баки оршуулгын газар түүнийг оршуулжээ.

Гэгээн Рейхане (радиаллаху анха): Тэр ч мөн адил элчийн жарие (шивэгчин) байхад мусульман болсон юм. Медине хот дахь жүүдүүдийн Бени Курейза овгийн хүн юм. Тэрээр Мухаммед элчээс (салаллаху алейхи уа сальлам) өмнө 631онд Медине хотод нас баржээ.

Хадис шерифт (сургаал үгэнд) ийн айлджээ: “Миний бүх гэргийнүүдтэй гэрлэх нь бас охидоо хадамд гаргах нь цөм Жабрейлийн (алейхиссальлам) Аллахаас авч ирсэн зөвшөөрөлтэйгөөр үйлдэгдсэн юм”

Элчийн (салаллаху алейхи уа сальлам) олон эхнэр авахын хамгийн гол шалтгаан бол тэдний оролцоотойгоор ислам шашиныг түгээх, ислам шашин дахь эмэгтэйчүүдтэй холбоотой асуудалыг тэднээр дамжуулан сургах. Эмэгтэйчүүдийн хижаб (биеэ далдлан нуух) зарлиг ирэхээс өмнө тухайн үеийн эмэгтэйчүүд элчээс шууд сурч, ямар нэг асуух, мэдэх зүйл байвал ирж асуудаг. Элч (салаллаху алейхи уа сальлам) ч мөн адил тэдний гэрт очдог байлаа. Харин хижаб эмэгтэйчүүд бие эрхтэнээ далдалсан алчуур зүйх зарлиг ирэхэд элч өөрийн авсан эхнэрүүдээсээ, охидоосоо бусад ямар ч эмэгтэйтэй яриагүй билээ. Тэдний ирж асуух асуултанд цөмд нь Айше эх (радиаллаху анха) ирж үйлчлэх цаг зав гардаггүй байсан юм. Тиймээс эхнэрүүдээ зааж тэд сурсанаа бусад эмэгтэйчүүдэд сургадаг болжээ. Аллахын шашиныг бүрэн гүйцэд дэлгэрүүлэхийн тулд олон эхнэр авах үүргийг нуруундаа үүрчээ.

Хүүхдүүд нь

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) 3 эрэгтэй 4 эмэгтэй нийт 7 хүүхэдтэй болжээ. Энэ хүүхдүүд нь Фатима охиноос бусад нь цөм элчээс өмнө нас баржээ. Түүний зээ хөвгүүд болох гэгээн Хусейны үр удамыг сейд, гэгээн Хасаны үр удамыг шериф гэнэ. Сейдүүд ба шерифүүдэд хүндлэл үзүүлэх нь элчийг хүндэлсэн мэт юм. Шерифүүд ба сейдүүдийг хайрлан дээдлэх нь амьдралынхаа төгсгөлд итгэлтэйгээр нас барах гол шалтгаан болно.

Касим (радиаллаху анх): Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) ууган хүү нь юм. Тийм болохоор элчийг Эбүл Касим гэж нэрлэдэг. Касим элчийн үүрэг өгөгдөхөөс өмнө Мекке хотод мэндэлжээ. Эх нь Хадиже-түл-Күбра(радиаллаху анха) юм. 17сартайдаа энджээ.

Зейнеф (радиаллаху анха): Элчийн ууган охин. Элч 30 настай байхад хорвоод мэндэлжээ. Элчийн үүргээс өмнө Хадиже эхийн дүүгийнхэн хүү Эбүл Ас бин Ребитэй гэрлэжээ. Эбүл Ас итгэл олсонгүй ба Бедирийн дайнд олзлогдсон эхнэрээ Медине рүү явуулах болзолтойгоор суллагджээ. Нөхөр нь өөрийн дүүтэйгээ хамт явсан боловч кафирүүд Зейнефийг замаас нь буцаажээ. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) Зейд бин Харисийг (радиаллаху анх) Мекке рүү илгээн Зейнефийг шөнө Медине рүү хулгайлан авч иржээ. Эбүл Ас Худейбие дайны дараагаар мусульман болж Зейнефийг ахин өөртөө авчээ. Зейнеф (радиаллаху анха) хижретийн 8 дахь жилд 31 настайдаа нас нөгчжээ. Түүний хүү Али нь Мекке хотийг мусульманууд эзэлхэд элчийн тэмээний хойн сундалдан явж байлаа. Зейнефийн охин Умаметтэй гэгээн Али гэрлэжээ.

Рукайе (радиаллаху анха): Аллахын элчийн (салаллаху алейхи уа сальлам) 2 дахь охин юм. Тэрээр элчийг 33 настайд нь хорвоод мэндэлжээ. Маш царайлаг нэгэн юм. Эбү Лехебийн хүү Утбетей никах (ураг барилдсан) байжээ. “Теббэт ядаа” сүре ирэхэд Утбе хурим хийхээс өмнө гэрлэлтээ цуцлуулжээ. Аллахаас зарлиг ирж гэгээн Османтай (радиаллаху анх) хуримлуулжээ. Тэр хоёр хамт 2 удаа Хабешстан (Етёп) руу нүүжээ. 22 настайдаа Бедир дайны өмнө хүндээр өвдөж гэгээн Осман Бедир дайнд оролцолгүй гэргийгээ харж асрахаар үлджээ. Бедирийн ялалтын баярт мэдээ Мединед ирэх өдөр оршуулжээ.

Үммү Гүлсүм (радиаллаху анха): Тэрээр элчийн 3 дахь охин нь юм. Эбү Лехебийн хоёр дахь хүү Утейбетэй ураг барилдсан бөгөөд “Теббет” сүре ирсэний улмаас Утейбе хуримлахаасаа өмнө түүнтэй гэрлэлтээ цуцалжээ. Утейбе элчид (салаллаху алейхи уа сальлам) маш муухай үг хэлэн доромжилсон болохоор пайгамбар маань: “Аллах минь, энэнийг амьтадаар хөнөөлгө” хэмээн зальбирсан нь биелэлээ олж, Шам хот руу явах замд нь Утейбег нэг арслан ирж иджээ. Рукайе нас барсаны дараагаар Аллахаас уахи (мэдээ) бууж Үммү Гүлсүмийг (радиаллаху анха) ч гэгээн Османтай (радиаллаху анха): гэрлүүлжээ. Тэрээр хижретийн 9 дэх жилд нас баржээ. Жаназа намазыг нь элч өөрөө үйлдүүлэн оршуулсаны дараагаар харуусалын нулимсаар үджээ.

Фатима (радиаллаху анха): Аллахийн элчийн (салаллаху алейхи уа сальлам) отгон охин, гэгээн Алигийн эхнэр ба гэгээн Омарын хадам ээж. Ураг барилдахад тэрээр 15 настай байв. Түүний Мехир (инж) 400 мөнгөн зоос юм. Тэрэнтэй гэрлэхэд Гэгээн Али 25 настай байсан билээ. Али эхл-и бейт (элчийн гэр бүлийн удам) юм. Фатима цагаан царайтай маш үзэсгэлэнтэй нэгэн юм. Хижретээс 13 жилийн өмнө Меккед мэндэлжээ. Хижретийн 11 онд 24 настайдаа таалал төгсжээ. Хасан ба Хусейн, Мухсин нэртэй 3 хүү ба Үммү Гүлсүм, Зейнеф нэртэй хоёр охинтой байв. Аллахын элчийн үр удам Фатимагийн хүүхдүүдээр үргэлжилжээ. Зейнеф охин нь Абдуллах бин Жафер Таййартай гэрлэж, Али ба Үммү Гүлсүм гэх 2 хүүхэдтэй болжээ. Энэ хүүхдүүдийг “Шериф-и Жафер” хэмээн нэрлэгддэг.

Абдуллах (радиаллаху анх): Энэ бол элчийн Хадижэ-түл Кубрагаас гарсан отгон хүү юм. Элчийн үүрэг өгөгдсөний дараа хөхнөөс гараагүй байхад нь энджээ. Энэ хүүг Таййб ба Тахир ч гэж нэрлэдэг. Абдуллах нас барсаны дараагаар кафир Ас бин Вайл: “Мухаммед үр удамгүй боллоо”, өөрөөр хэлбэл, голомт залгах хүнгүй боллоо гэжээ. Аллах эзэн: “Инна атайна” сүрег буулгаж, Ас кафирт хариу барьжээ.

Ибрахим (радиаллаху анх): Аллахийн элчийн (салаллаху алейхи уа сальлам) хөвгүүдийн 3 дахь нь ба бүхий л хүүхдүүдээс отгон хүү нь юм. Египетийн амбан захирагч Мукабкисийн бэлэг болгон илгээсэн Марие эхийн хүү юм. Хижретийн 8 дахь жилд хорвоод мэндэлж нэг нас зургаан сартайдаа нас баржээ. Тэрнийг өвдөж байхад пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам)

түүнийг тэврээд мэгшин уйлдаг байв. Түүнийг нас барсаны дараа нар хиртсэн гэж яригдахад элч: “Сар ба нар Аллахыг оршин байдгийг харуулдаг хамгийн том тэмдэг юм. Хэн нэгнийг нас бархад эсвэл үхлээс хэлтэрсэний төлөө хиртдэггүй. Тэднийг хараад Аллахыг санцгаа” гэжээ. Ибрахимийг нас бархад “Аяа, Ибрахим, чиний нас барих чинь гашуудуулж, уйлуулж, зүрхийг шанлуулж байна. Гэхдээ эзэнээ гомдоох юм хэлэхгүй ээ” хэмээжээ.

Эхли бейт

Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) бүхий л гэр бүлийг Эхли бейт гэдэг. Гэгээн эхнэрүүд, охин Фатима (радиаллаху анха), гэгээн Али ба тэдний хүүхдүүд нь болох Хасан, Хусейн (радиаллаху анхума) ба тэд нарын үр удамыг бас Мухаммед элчийн ариун удам угсааны Хашимын хөвгүүд гэх овгоос гарагсадыг эхли бейт гэнэ.

Аллах эзэн эхли бейтүүдэд хандан Куран сударт: “Аллах эзэн та нарыг Рижси, өөрөөр хэлбэл, бүх өө сэв ба ариун бус байдлыг арилгахыг хүсэж, бас та нарыг жинхэнэ цэвэрээр ариусгахыг хүснэ”(Ахзаб сүре, 33)

Асхабууд нэгэнтээ: “Аяа, Расулуллах! Эхли бейт гэж хэнийг хэлэх вэ?” гэж асуулаа. Тэр үед гэгээн Али орж ирэв. Дараагаар нь гэгээн Фатима ирхэд араас нь Хасан ба Хусейн 2 орж ирцгээв. Элч (салаллаху алейхи уа сальлам) эд нарыг заан “Эд нар миний Эхли бейт мөн” гэв. Энэ хүмүүсийг Али Аба ба Али Расул ч гэдэг.

Эхли бейтийг хайрлах нь бүх мусульманы үүрэг юм. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) нэгэн хадис шерифт: “Эхли бейт минь Нух пайгамбарын хөлөг онгоц мэт юм. Тэднийг дагагсад энх амарыг олж, тэднээс хоцрогсад усдан үгүйрнэ”

Эхли бейтийн дээд заяа хүндэтгэл ба буян заяаг нь тоолж баршгүй их юм. Тэднийг магтахад үг үсэг үл хүрэлцэнэ. Тэдний үнэ цэн ба ихэмсэг байдал нь Аллахын аетаар мэдэгдэж байна.

Гэгээн Энэс (радиаллаху анх) ийн өгүүлнэ: “Аллахын элчээс “Эхли бейт дотроос хэнийг нь илүү хайрладаг вэ?” гэж асуухад “Хасан ба Хусейныг” хэмээжээ.

Гэгээн Эбү Хурейре (радиаллаху анх) ийн өгүүлнэ: “Нэг

удаа элчийн хажууд сууж байлаа. Хасан бидний хажууд ирхэд “Аяа, Аллах минь! Би энэнийг хайрладаг. Чи ч бас хайрла. Бас түүнийг хайрлагсдийг ч бас хайрла” гэжээ. Бас нэг удаа “Хасан ба Хусейн энэ хорвоод миний хамгийн гоё үнэртэн мөн” хэмээжээ”

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) бас нэгэн удаа ийн айлджээ. “Надаас хойш би та нарт хоёр зүйл үлдээж байна. Энэнийг хийх юм бол замаасаа хазайхгүй. Эхнийх нь дараагийнхаасаа илүү үнэтэй юм. Эхнийх нь, Аллах эзэний судар болох Куран-и Керим юм. Энэ нь тэнгэрээс газар луу унжих бат бэх нэгэн утас юм. Хоёр дахь нь, миний эхли бейт юм. Энэ хоёр нэг нэгнээсээ ангид бус энэ хоёрыг үл дагагсад миний шударга замаас гарах болно”.

Эбү Хурейре (радиаллаху анх) ийн айлдсан байна: “Пайгамбар маань: “Та нараас хамгийн их буянтай хүн бол эхли бейтэд тус хүргэгсэд”.

Имам-и Раббанигийн хүргэсэн нэг хадис-и шерифт: “Алиг хайрлагсад намайг хайрлажээ. Түүний дайсан бологсод миний ч дайсан мөн. Түүнийг гомдоогсод намайг бас гомдоосонтой бас адил. Харин намайг гомдоох нь Аллах эзэнийг гомдоосон мэт” гэсэн.

Бас нэг хадис-и шерифт “Фатима миний нэг жүз юм (өөрөөр хэлбэл, миний нэгэн хэсэг юм). Түүнийг гомдоогсод намайг гомдоосонтой адил” хэмээжээ.

Бас нэгэн хадис-и шерифт “Та нарт ислам шашиныг авч ирсэнийхээ төлөө ямар нэгэн зүйл хүсэхгүй. Гэхдээ надад ойр болох эхли бейтийг минь хүндлэж байхыг хүсье” гэсэн.

Ислам шашины агуу эрдэмтэн Имам-и Раббани өгүүлж байна: “Миний эцэг бүхий л эрдэмийг гарамгай сурсан гэгээнтэн юм. Тэрээр үргэлж эхли бейтийг хайрлаж хүндлэхийг хүн бүхэнд сургамжилдаг байлаа. Харин энэ хайр нь хүнийг сүүлчийн амьсгал хураах мөчид итгэлтэйгээр нас барах шалтгаан болдог гэдэг байв. Эцэг маань нас барахын өмнө түүнээс хэр байгааг нь асуулаа. Тэрээр би эхли бейтийн хайрын голд умбан шумбаж байна” гэв. Эхли бейтийн хайр нь эхли сүннетиин үр шим юм. Хойд ертөнцөд ч энэ үр жимсээрээ диваажинд залрах болно.

Аллахын элчийн асхабууд (Анхны мусульманууд)

Асхаб бол элчийн найз нөхдүүд, эрэгтэй, эмэгтэй, хүүхэд эсвэл хөгшин, ямарваа нэгэн мусульман хүн юм. Аллахын элчийг (салаллаху алейхи уа сальлам) нэг удаа боловч өөрийн нүдээрээ харсан бол, сохор хүмүүс нэг удаа ч болов түүнтэй ярьсан бол бас энэ хүмүүс итгэлтэйгээр нас барсан бол эд нарыг “Сахиб” эсвэл “Сахаби” гэнэ. Хэсэг хүмүүсийг “Асхаб” эсвэл “Сахаба” ба “Сахб” гэнэ.

Аллахийн элчийг (салаллаху алейхи уа сальлам) өөрөө кафир (буруу номтон) байхдаа хараад, элчийг нас барсаны дараагаар мусульман бологсод эсвэл элчийг харсан мусульман сүүлд мөртөд (шашинаасаа гарагсад) асхаб биш юм. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) бугуудад ч элч байсан болохоор харсан бугууд бас асхаб болно.

Асхабууд шашины хууль ёсонд маш гарамгай эрдэмтэд юм. Учир нь тэд Куран судар, шашины сургаал номлолыг элчээс өөрөөс нь сурч боловсрон, хожимоо хойч үедээ зааж сургагсад билээ.

Эхли сүннет эрдэмтэд асхабийг эзлэх байр сууриар нь гурван бүлэгт хуваажээ:

1-Мухажир. Мекке хот эзлэглэгдхээс өмнө Меккегээс эсвэл өөр нэг газраас нутаг ус, хамаатан саданаа орхин Медине хотод нүүж ирэгсэдийг хэлнэ. Эд нар элчийн хажууд итгэлтэн болсон эсвэл Меккед ирээд мусульман бологсод юм. Амр бин Ас эдний нэг юм.

2-Ансар. Медине хотод эсвэл энэ хотод ойр бүх Эвс, Хазреж овгийнхоны мусульмануудыг ансар гэнэ. Учир нь тэд элчид (салаллаху алейхи уа сальлам) бүх төрлийн тус дэм өгөхөө амлаж, тэр амлалтандаа хүрчээ.

3-Бусад асхаб-и кирам: Мекке хот эзлэгдсэний дараагаар Меккед эсвэл өөр нэгэн газар мусульман болгосод. Эд нарыг мухажир, ансар гэж нэрлэхгүй, зөвхөн сахаби гэнэ.

Асхаби кирамын хамгийн дээд нь элчийн дөрвөн халифе (элчээс хойш мусульмануудын толгойлогч бологсод) гэгээн Эбү Бакир, гэгээн Омар, гэгээн Осман, гэгээн Али нар (радиаллаху анхум) юм.

Эдний дараагаар Ашере-и мүбэшшере, өөрөөр хэлбэл,

диваажинд орохыг нь мэдээлсэн 10 хүнээс үлдсэн 6 хүн юм (Талха, Зүбейр бин Аввам, Абдуррахман бин Авф, Саад бин Эбу Ваккас, Сайд бин Зейд, Эбү Убейде бин Жеррах (радиаллаху анхум)) ба Хасан ба Хусейн нар.

Асхабуудаас хамгийн их буянт, дээд нь 4 халифе ба диваажинд орохыг нь мэдэгдсэн хүмүүс, бас анхны 40 мусульман бологсод юм. Дараагаар нь Бедир дайнд оролцсон 313 асхаб, дараагаар нь Ухуд дайнд оролцсон 700 асхаб, эдний дараагаар хижрет (их нүүдлийн) 6 дахь жилд модны доор Аллахын элчийн өмнө “Үхсэн ч эргэж буцахгүй” хэмээн тангараг өргөсөн 1400 асхаб. Энэ тангарагыг “Биат-и Ридван” гэнэ.

Асхабын тоо: Меккег эзлэхэд 10000, Тэбук дайнд 70000, хагацалын хаж мөргөлд 90000 ба элчийн нас нөгчихөд 124000-аас ч илүү асхаб байсан гэдэг.

Асхабуудаас хамгийн сүүлд нас барагсад: Абдуллах бин Эбфа (радиаллаху анх) 705(х.86) онд Куфед нас барсан, Абдуллах бин Ясир (радиаллаху анх) 706 (х.88)-онд Шам хотод нас барсан, Сехил бин Саад (радиаллаху анх) 709(х.91)-онд 100 настайдаа Мединед нас барсан, Энэс бин Малик (радиаллаху анх) 711 (х.93) онд Басра хотод, Эбү Туфейл Амр бин Василе (радиаллаху анх) 718 (х.100)-онд Меккед нас баржээ.

Элчийг нас нөгчсөний дараагаар 4 Халифегийн (залгамжлагч) үед ч гэсэн асхабууд ислам шашиныг түгээх, тэрний төлөө тэмцэх үгэндээ хүрсэн юм. Асхабууд цөм нэгэн зорилгоор эх орон, гэр бүлээ орхин, Араб нутагаа орхин гарсан юм. Явагсадын ихэнх нь буцаж ирэлгүй очсон газараа ислам шашиныг номлон түгээж, тэндээ нас барцгаасан юм. Ийнхүү маш бага хугацаанд олон улс орон ислам шашинтан болцгоосон юм.

Асхабууд цөм үнэнч шударга, исламыг хамтдаа түгээсэн юм. Куран Керим сударыг тэд эмхэлж, хадис-и шерифүүдийг (элчийн сургааль үгс) тэд уламжлан хэлсэн билээ.

Асхабууд энэ дагалдагсадын дундаас хамгийн дээд нь юм. Мухаммед (салаллаху алейхи уа сальлам) элч болоход нь итгэсэн хүн бүр түүний дагалдагсад билээ. Энэнд яс үндэс удам угсаа, арьс өнгө үл хамаарна.

Асхабуудыг магтан дуулсан аетэд ийн өгүүлнэ: “Та нар хамаг дагалдагсадаас илүү буянтай хүмүүс” (Али Имран, 110)

“Анх мусульман бологсод, мухажирүүд ба ансаруудаас түрүүч нь болох хүмүүс ба эднийг дагагсадад Аллах эзэн

баярлана. Бас эд ч мөн Аллахдаа баярлаж буй. Аллах эзэн эдний төлөө диваажинг бэлдсэн юм. Энэ диваажингийн доогуур гол горхиуд урсана. Эд нар диваажинд үүрд үлдэх болно”. (Тавбе суре, 100)

Асхабуудын талаарх зарим хадис-и шериф (Мухаммедын сургааль үгс):

“Асхабуудыг минь битгий муулцгаа! Асхабаас хойно ирсэн хэн нэгэн хүн уул адил алтаар өргөл өгсөн ч асхабуудын атга арвай буудай өгөөд авсан буянтай энэ тэнцэнэ.

Миний асхабууд тэнгэр дэх од шиг. Алинийг нь ч дагсан зөв замийг олох болно.

Миний асхабуудад дайсагнахаас айцгаа! Аллагаас эмээцгээ! Тэднийг хайрлагсад намайг хайрладаг болохоор тэр. Тэдэнтэй дайсагнагсад миний дайсан болсон юм. Тэднийг гомдоогсод намайг гомдоосонтой адил. Харин намайг гомдоогсод Аллахыг гомдоосон мэт.

Намайг дагагсадаас хамгийн сайн нь миний үед амьдрагсад юм. Тэдний дараагаар тэднийг үзэгсэд, түүний дараагаар хамгийн сайн нь дараагийн үе юм. Намайг харсан бас намайг харагсадыг харсан нэгэн мусульман тамын тогоонд унахгүй”.

АЛЛАХЫН ЭЛЧИЙН ЗАРИМ ЗЕВАЙД*¹⁰¹*

СҮННЕТҮҮД

Ариун сахал ба үс нь

Элчийн (салаллаху алейхи уа сальлам) ариун үсийн талаар Энес бин Маликаас “Элч ямархуу үстэй байсан бэ?” гэж асуухад гэгээн Энес (радиаллаху анх): “Дундын үстэй байсан. Буржгар ч биш, шулуун ч биш, хоёрын хооронд долгиолсон сахалтай байсан. Урт богины хувьд бол чих ба мөрийн хооронд байдаг байсан” гэжээ.

Ибни Аббас (радиаллаху анх): “Хорвоогийн энэрэлт элч сагмайныхаа үсийг урагш тавиад, сүүлд хоёр зааглан хагалдаг байсан” хэмээжээ.

Исламын эрдэмтэд: “Үсээ хоёр хагалж самнах нь элчийн 101 * Зевайд сүннет- Пайгамбарын маань мөргөлийн хувьд биш зуршил болгон үргэлж хийсэн үйлсийг хэлнэ. Зевайд сүннетүүдийг орхих нь макрух биш. Элчийн хувцаслалт, юм хийхэд баруун талаас эхлэх гэх мэт үйлсүүд зевайд сүннет болно.

сүннет (хийсэн үйл) юм. Урагшаа тэгш самнаж ч болно. Хоёр талдаа сул тавь ч болно. Харин хаглаж самнах нь сүннет юм.

Гэгээн Айше Сиддик (радиаллаху анха) ийн айлджээ: “Гэгээн пайгамбар маань мөрнөөс дээш, чихний гэдэснээс доош урттай үстэй байсан” хэмээжээ.

Кади Иаз гэх эрдэмтэн ийн өгүүлжээ: “Энэ хүмүүсийн өгсөн мэдээлэлийг нэгтгэн дүгнэх юм бол элчийн ариун үсний урт нь санчигнийх нь үс чихний гэдэс өнгөрөм, харин ар талын үс нь мөр өнгөрөм юм байна”.

Үммү Хани ийн өгүүлжээ: “Мухаммед элч нэг удаа Мекке хотод манайд ирсэн юм. Тэр үед элч үсээ 4 хуваасан байсан” хэмээжээ.

Хэв шинжийг нь хэлбэл, элчийн (салаллаху алейхи уа сальлам) үс их буржгар ч биш, шулуун ч биш долгиотой үстэй байлаа. Үс нь урт байсан бөгөөд урдуураа сагмай үс тавьдаг байсанаа сүүлд түүнийгээ хоёр хуваадаг болжээ. Үсээ заримдаа урт ургуулж, зарим үед богинсгодог байв.

Эрэгтэй хүмүүс үсээ хусуулах нь, ургуулаад хоёр хэсэг хуваах нь сүннет юм. Тухайн үеийн байдал цаг үетэйгээ зохицох хэрэгтэй. Үсээ албаар буржйилгаж (хийм хийлгэн) эсвэл сүлжих нь цээртэй юм.

Элчийн ариун сахалын шинж чанарын талаар гэгээн Энэс ийн айлдаж байна: “Элчийн гэгээн сахаланд нь цагаан сахал ховор юм. Түүний үс, сахаланд байх цагаан үс 17 эсвэл 18-аас хэтрэхгүй байлаа”

Тирмизи гэгээнтэний мэдээлсэн хадис-и шерифт Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам): “Сахалаа үл хусагсад манай хүн биш” хэмээжээ. Бас нэгэн өөр хадис-и шерифт: “Хуузаа сайн ургуулцгаа, харин ширвээ сахалаа авцгаа” хэмээжээ.

Ибн-и Абдул Хаким: “Ширвээ сахалаа сайн авах хэрэгтэй. Авах гэдэг нь хусаж хаях гэсэн утгатай үг биш” гэжээ.

Имам-и Небеви: “Ширвээ сахалыг авахдаа дээд уруулын хүрээг гартал нь захлах явдал юм” гэжээ.

Ибн-и Омар (радиаллаху анх) ийн айлджээ: “Аллахын элчид межузи (Бөө мөргөлтөн) хүмүүсийг тайлбарлаж өгсөн юм. Пайгамбар маань: “Тэд ширвээ сахалынхаа үзүүрийг уртасгаж, хууз сахалаа хуссан юм. Та нар тэдний эсрэгээр хийцгээ” гэлээ.

Эбү Үмеме (радиаллаху анх): “Аяа, пайгамбар минь! Китаб эхли (христ ба жүүд шашинтангууд) ширвээ сахалаа тавьж,

хуузаа хуссан байдаг” гэхэд элч: “Та нар ширвээ сахалынхаа үзүүрийг захиалж, хуузаа ургуулцгаа” гэсэн юм.

Эрдэмтэдийн дүгнэлт нь мусульман хүн ширвээ сахалаа нимгэлж, хөмсөгний дайтай болгоод, харин хууз сахалаа атгаж болох хэмжээнд ургуулах нь сүннет (элчийн хийсэн ариун үйл) юм.

Элчийн хэвтэх ба унтах нь

Аллахын элч (салаллаху алейхи уа сальлам) орондоо ороод унтах үедээ баруун хажуулдан хэвтээд, баруун гарынхаа алгыг баруун шанаандаа дэрлээд:

“Аллах минь! Би тань руугаа чиглэн, таньдаа өөрийгөө өглөө. Ажил хэрэгээ чамд даатгаж, нуруугаараа чамайг түшлээ. Би чиний гэсгээлээс айж, хайр энэрэлт чинь найднам. Чи хайр энэрэлээс чинь өөр найдах зүйл үгүй. Чиний гэсгээлээс өөр аймшиг үгүй.

Гагцхүү, чиний энэрэлт найдаж, гагцхүү чиний энэрэлээр аврагдана.

Би чиний илгээсэн судар, илгээсэн элчид чинь итгэнэм.

Аллах минь! Би чиний нэрээр үхэж, чиний нэрээр амилна. Биднийг ундаалж, бүхий л хэрэгцээг минь хангаж, биднийг хамгаалж, бидний шүтээн болсон Аллахдаа талархлаа! Аллах минь, боолуудаа өмнөө цуглуулах өдөр намайг хамгаал!” хэмээн залбираад унтдаг байлаа. Харин нойрноосоо сэрэхдээ:

“Биднийг амилуулсан Аллах эзэндээ баярлалаа, хойд ертөнцөд Түүн рүү буцаж очих болно” гэнэ.

Бера бин Азиб (радиаллаху анх) ийн айлдаж байна. Пайгамбар маань надад: “Орондоо орохоосоо өмнө мөргөлийн угаалга адил угаалга үйлд, дараа нь баруун талаараа хэвтээд: “Аллах минь! Өөрийгөө чамд даатгаж, царайгаа чам руу чиглүүллээ. Нуруугаараа чамайг түшиж байна. Би гэсгээлээс айж, хайр ивээлийг чинь найдан хүлээнэм. Чамд чиний энэрэлээс өөр найдах найдалга алга! Гагцхүү чиний л энэрэлд хорогдоно. Гагцхүү чиний энэрэлд найднам. Би чиний илгээсэн Куран судар ба гэгээн элчид чинь найдаж байна” гэж залбир. Хэрвээ чи тэр шөнө үхэх юм бол исламд итгэл үнэмшилтэйгээр үхэх болно” хэмээсэн юм.

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) элгээрээ

газар дэврэн, доош харан хэвтэж буй хүнийг хараад: “Энэ бол Аллахын хэзээ ч таалаагүй хэвтэх байрлал” хэмээжээ.

Пайгамбар маань даретгүйгээр явдаггүй байна.

Аллахын элч (салаллаху алейхи уа сальлам) жорлон ороод гарахдаа нэг ч удаа угаалга үйлдээгүй гараагүй билээ.

Элчийн суух ёсон

Ханзела бин Хизием: “Би элчид очоод ирлээ. Тэрээр завьлан сууж байхыг харлаа” гэжээ. Жабир бин Семүре: “Аллахын элч үүрийн мөргөл үйлдсэнийхээ дараагаар нар мандах хүртэл завьлан суудаг байсан” гэжээ.

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) хэзээ ч өмнөө байгаа хүн рүү хөлөө жийж суудаггүй байна.

Пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) газар суугаад хоол иддэг байлаа. “Би боол шиг сууж, боол шиг хоол иднэ. Би бол боол юм! Миний сүннети (хийсэн үйл) үл дагагсад миний хүн биш” хэмээжээ.

Нэг өдөр Жабрайлтэй (алейхиссальлам) хамт нэгэн мелек (сахиусан тэнгэр) элчид иржээ. Тэр Мелек: “Аллах эзэн чамд мэнд дамжуулж байна. Эзэн чамайг элч-хаан эсвэл элч-боол болох хоёр болзолын аль нэгийг нь сонго гэж байна. Чи хүсвэл элч-хаан, эсвэл элч-боол болж болно. Аль нэгийг нь сонго” гэв.

Жабрайл (алейхиссальлам) “даруу байг” хэмээн зангахад Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам): “Элч-боол болохыг сонгоё” гэв. Энэ цагаас хойш пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) хэзээ ч зогсоогоороо эсвэл нэг юм түшиж дэрлэн хоол идээгүй билээ.

Элчийн идэх ба уух нь

Эбү Жухайфе (радиаллаху анх) ийн айлджээ: Аллахын элч: “Би ямар нэгэн юм түшиж суугаад хоол иддэггүй” гэсэн. Түших нь 3 төрөл юм. Завьлан суух, түшлэгээ түших эсвэл нэг гараар газар тулан нөгөө гараар идэх.

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) хоол идэхдээ эрхий долоовор дунд гэсэн 3 хуруугаараа авч иддэг байлаа.

Элч айлдахдаа: “Хоолны буян хишиг нь: Хоолноос өмнө

угаалга үйлдэх, хоол идэж дууссаны дараа ч угаалга үйдэж, гараа угаах явал юм”

“Аливаа нэгэн гараа бас хоол идсэн аяга тавгаа үл угаан унтаад ямар нэгэн өвчин тусах юм бол өөрөөсөө өөр хэн нэгэнд битгий гомдог”

Омар бин Эбу Селеме (радиаллаху анх) ийн айлджээ: “Би Мухаммед элчийн хажууд өсөж торнисон түүний хүмүүжилээр хүмүүжсэн хүүхэд юм. Бид хамт хооллохоор суухад би тавган дотор гараа оруулан, энэ тэндээс нь савардаж эхлэхэд элч: “Хөөе, хүү минь! Бисмилла гэж хэл, өөрийн өмнөөс баруун гараараа ид!” гэсэн юм. Би энэ өдөрөөс хойш үргэлж ингэж идэх болсон юм”.

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) ямар ч хоолыг голж шилдэггүй байлаа.

Хоол идэхийг хүсвэл иднэ, харин эс хүсвэл чимээгүй холддог байлаа.

Өчүүхэн ч гэсэн хоолыг идэхдээ хүндэтгэл үзүүлэн баярладаг байлаа.

Хоол авч ирэх үед пайгамбар маань: “Аллахүмма барик лана фиймаа резактана вэ азабаннаар. Бисмиллах!” гэж залбираад идэж эхэлдэг байлаа.

Гэгээн Айше эх ийн өгүүлжээ: “Гэгээн элч нэгэнтээ: “Хэн нэгэн хүн хоол идэж эхлэхээсээ өмнө «Бисмиллах» гэж хэлэгтүн, ауга Аллахын нэрийг дурдацгаа. Хоол идэхээсээ өмнө энэ үгийг мартвал “Хоолны урд хойно нь зориулж «бисмиллах» гэж хэлэг” хэмээжээ.

Гэгээн пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) угаалга үйлдэх ба гусуль (их угаалга) үйлдэхдээ, гуталаа өмсөхдөө, үсээ самнахдаа, ер нь бүх зүйлийг хийж эхлэхдээ баруун талаасаа эхлэхийг маш их эрмэлздэг байна. Хэн нэгнээс юм авахдаа баруун гараараа авч, өгөхдөө ч баруун гараараа өгдөг байв.

“Та бүхэн гуталаа өмсөхдөө баруун талаасаа өмсөж эхэлцгээ. Гуталаа тайлахдаа зүүн хөлнөөс эхэлж тайлцгаа!” хэмээн айлджээ.

Абдуллах бин Омарын (радиаллаху анх) уламжилсанчлан пайгамбар маань(салаллаху алейхи уа сальлам): “Та бүхэн хоол идэхдээ баруун гараараа идэцгээ. Нэг зүйл уухдаа ч мөн адил баруун гараараа ууцгаа. Учир нь чөтгөр зүүн гараараа ууж иддэг юм” хэмээжээ. Селеме бин Эквагийн эцэг ийн айлджээ:

«Пайгамбар маань Эшжа гэх овгийн Бүсир бин Раиулир гэх хүн зүүн гараараа идэж байхыг хараад, “Баруун гараараа ид!” гэж хэлжээ. Нөгөө хүн “Би хүч хүрэхгүй болохоор зүүн гараараа идэж байна” гэж худал хэлжээ.

Аллахын элч: “Хүч чинь хүрэхгүй байг! Энэ хоолыг баруун гараараа идхэд их зан ба хайнга байдал л саад болж байна” гэв. Энэ цагаас хойш нөгөө хүн хэзээ ч гараа амандаа хүргэж чадахаа больжээ.

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам): “Энэрэлт хайрт Аллах эзэн аливаа хоол ундыг идэж уусаны дараагаар талархал хэлэгсэдэд их баярлах болно” хэмээжээ.

Эбү Сайдүл Худури: “Мухаммед элч маань хоол унд идэж уусаныхаа дараагаар ийн залбирдаг байна: “Алхамду лиллахиллазий атгамана вэ сакаана вэ жагалана минал мүслимин” (Биднийг хооллож ундаалж бас биднийш мусульман бологсон Аллахдаа талархалаа)” хэмээсэн.

Эбү Умамэтүл Бахилигийн айлдсанчлан пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) аливаа хоолны дараагаар ийн залбирдаг байлаа:

“Алхамду лиллахиллазий кефаана вэ эрваана гайри мекфиин вэлаа мекфурин” Биднийг цадтал идүүлж, биднийг үл буцаасан бас муу хүн болохоос хамгаалсан Аллахдаа гялаалаа”

Эбү Хурейрагийн (радиаллаху анх) уламжилсанчлан пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) хоол унд идэж дууссаны дараагаар гараа угаадаг байна.

Эбү Умамэтүл Бахилигийн (радиаллаху анх) уламжилсанчлан Аллахын элч “Агуа энэрэлт эзэн маань надад Меккегийн хотгор газарыг алтаар дүүргэн өгөхийг санал болгосон юм. “Өггүй ариун агуу эзэн минь! Би нэг өдөр цатгалан, нэг өдөр өлсгөлөн байя! Өлсгөлөн байх үедээ чамд залбирч, чамаас гуйя. Цатгалан байх үедээ таньдаа талархан, магтан дуулъя” хэмээжээ.

Энэрэлт элч (салаллаху алейхи уа сальлам) хэзээ ч тансаг сайхан хоол зооглож байгаагүй, өдөр тутмын иддэг хоол нь арвайн гурилаар хийсэн талх, хуурсан арвай буудай байсан ч энэ бүхэн нь хомсхон юм.

Тэрээр нас барахаасаа өмнөх хоёр хоногт гэр бүлээрээ зөвхөн арвайн гурилаар хийсэн гамбир идэж байжээ.

Сар болж өнгөрөх хугацаанд Мухаммед элчийн (салаллаху

алейхи уа сальлам) гэрт нэг ч талх, нэг ч тогоо дүүрэн хоол хийгдсэнгүй.

Бид хурма жимс, ус, цайнд цадах тэр үед хорвоогийн элч нас нөгчсөн байлаа.

Эбү Хурейре (радиаллаху анх) пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам): Аллах минь! Гэр бүлийг минь, Мухаммедын гэр бүлийг амь зогоох төдий хоолоор хоолол!" хэмээн залбирдагийг хүргэсэн.

Пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) ийм хоол хий, тийм хоол хий гэж хүсдэггүй байна. Ямар л байна гололгүй иддэг байлаа. Гэгээн Айше эх ийн тайлбарлажээ: Элч надад: "Идэх хоол бий юу?" гэж асуулаа. Би "Үгүй!" гэхэд "Тэгвэл өнөөдөр мацаг барья даа" гэдэг байв".

Энесбин Маликийн (радиаллаху анх) хэлсэнчлэн пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) хулуу ба хулуугаар хийсэн хоолонд их дуртай байжээ. Бас хонины нурууны мах бол хамгийн амттай мах гэж айлджээ.

Аллахын элч (салаллаху алейхи уа сальлам) тогоо тавагны ёроолд үлдсэн хоолонд дуртай байжээ. "Хэн нэгэн хүн хоол идсэн таваг, тогооныхоо ёроолыг арчиж идвэл, түүний нүгэлийг наминчлахын төлөө залбирах болно" хэмээжээ.

Пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) Эбү Зерд (радиаллаху анх) хандан: "Аяа, Эбү Зер! Чи мах чанасаныхаа дараагаар ус нэмэн шөлийг нь ихэсгээд хөршүүддээ тараан өг!"

"Хөрш нь өлсгөлөн байхад, өөрийн гэдэсээ цатгагсад жинхэнэ утгаараа мусульман биш"

"Аллахдаа мөргөн залбирцгаа! Өлсөгсөдийг цатгацгаа! Мэндийг түгээцгээ, ийнхүү диваажинд орцгоо"

"Нэг хүний хоол хоёр хүнд хүрнэ, 3 хүний хоол 4 хүнд хүрнэ, 4 хүний хоол 5 хүнд хүрэлцээтэй"

"Та нар ямар нэг зүйл идэхдээ баруун гараараа идэцгээ, уухдаа баруун гараараа ууцгаа, учир нь чөтгөр зүүн гараараа хооллодог билээ"

"Хэн нэгэн хүн юм уухдаа саван дотор нь битгий амьсгалцгаа" хэмээжээ. Идэж ууж буй зүйлийнхээ саван дотор амьсгалах нь цээртэй болсоны адилаар алт мөнгөн эдлэлээр хоол унд уух нь бас цээртэй юм.

Пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) ус уухдаа нэг аяга усанд хоёр, хоёр аяга усанд гурван удаа амьсгалж

амардаг байв, бас “Энэ нь илүү сайн бас илүү цангааг тайлдаг” хэмээжээ.

“Та нар нэг зүйл уухдаа ганц амьсгалаар битгий ууцгаа! Хоёр гурван амьсгаагаар яаралгүй ууцгаа. Ууж эхлэхээсээ өмнө “Бисмиллах” гэж хэлээд, уруулаа аяганаас авахдаа “Алхамдүлиллах” гэж хэлцгээ!” хэмээжээ.

Хооллохоосоо өмнө бас хойно нь гараа угаах нь элчийн заншил байлаа. Хоолны өмнө гараа угаахдаа эхлээд хөгшид эхлэн угаана.

Тавагтай хоолны захаас нь идэх, өөрийн өмнөхөө идэх, баруун хөлөө эгц барьж, зүүн хөлөө дарж суух нь элчийн сүннет юм. Маш халуун зүйл идэхгүй, үнэрлэхгүй байх хэрэгтэй. Хооллож байхдаа огт юу ч ярихгүй байхыг элч (салаллаху алейхи уа сальлам) зөв зүйл гэж боддоггүй байлаа. Энэ нь галд шүтэгсэдийн зан үйл юм. Хоолыг давсаар эхлэн, давсаар дуусгах нь элчийн сүннет юм.

Хоол идэж уух соёлыг сурах нь мөргөлийн соёлыг сурахаас илүү юм. Цадталаа идэх нь муу зүйл билээ. Өдөр бүр махан хоол идэх нь зүрхийг хүндрүүлдэг бөгөөд сахиусан тэнгэрүүд таалахгүй. Мах бага идэх нь хүний зан авирыг эвддэг юм. Идэх зүйлийгээ дэлгэн ширээ ба газар тавих нь сайн зүйл юм.

Имам-и Жафер Садик ийн өгүүлжээ. “Эд хөрөнгө ба үр удам нь их байхыг хүсвэл ургамал, ургамалын гаралтай хоол унд их хэргэлцгээ” гэжээ.

Пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам): “Сайн зүйлийн эхлэл бол өлсөх, муу зүйлийн эхлэл бол цатгалан байх” хэмээжээ. Хоолны амт шимт өлсөх үед илүү их болдог. Харин их цатгалан байх нь мартамхай байхад нөлөөлдөг ба зүрхийг сохолдог, харин өлсөх нь ухааныг хурцалж, зүрхийг тайвшруулдаг.

Идэх зүйлээ амандаа багтахуйцаар таслаж аваад сайн зажлаж идэх хэрэгтэй. Хоол идэж байхдаа ийш тийш харахгүй байх, амаа том онгойлгохгүй байх, хооллох үедээ гараа хувцасдаа толгойдоо хүргэхгүй байх хэрэгтэй. Найтаах, ханиах үедээ толгойгоо хойш эргүүлж хажуулдан найтаах.

Уригдаагүй ширээнд эс суух. Тэнд хамт хооллогсодоос илүү идэхгүй байх. Цадсаны дараагаар энэ хоолноос авсан эрч хүчээрээ нүгэл үйлдэхгүй байхын төлөө залбирах ёстой. Мөргөл залбирал хийхдээ шаардагдах хүч чадалыг авахын төлөө хоол

идэх ёстой. Өлссөн үедээ аяар аяархан идэх нь чухал. Эхлээд ахмадууд идэж эхлэх ёстой. Гурваас илүү удаа “Ид” гэж хэн нэгнийг хүчлэхгүй байх. Хамт идэж байхдаа зочиныг цадаагүй байхад идэхээ больж гараа татахгүй байх.

Пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) бага идэж, их хоолыг идэхдээ удаанаар иддэг байлаа. “Хүний зүрх тарианы талбай мэт юм, харин хоол бол бороо мэт. Их бороо талбай дахь ногоо ургамалыг ялзруулдаг шиг их хоол ч хүний зүрхийг харлуулдаг. “Их идэгсэдийг, их уугсадыг Аллах таалахгүй” хэмээжээ.

Аллахын элч (салаллаху алейхи уа сальлам) ходоодныхоо гуравны нэг хэсэгийг нь хоол, гуравны нэг хэсгийг ус, ундаа гуравны нэг хэсэгийг нь агаараар дүүргэхийг захижээ. Хамгийн дээд хүн бол бага идэж, бага унтдаг хүн юм. Их идэх нь бүх өвчинүүдийн эхлэл, харин бага идэх нь бүх өвчинүүдийн илааршлал юм. Зочин гэрийн эзэнээс талх давс хоёроос илүүд тансаг хоол хүсэхгүй байх ёстой.

Хоолны дараагаар шүдээ мисвакаар (шүд цэвэрлэгч мод) цэвэрлэх нь Аллахын элчийн бас нэг сүннет юм. Цэвэрч байх нь итгэл үнэмшилэлийг улам баталгаажуулна. Хоол идсэний дараагаар гэрийн эзэнд буян хишиг, наминчлал, энэрэлийн төлөө залбирах нь зүй.

Хоол идэж байхдаа аймаар бас цээрлэмээр зүйл ярихгүй байх. Нас барагсад ба өвчин зовлонг ярихгүй байх ёстой. Аман дахь зүйлээ зальгаагүй байж дараагийн идэх зүйлээ бэлдэхгүй байх. Хоол идэх үеэр ямарваа нэгэн ажил хийхээр, бүр мөргөл үйлдэхээр босохгүй байх. Мөргөлөө өмнө нь ба хойно нь үйлдэх ёстой. Зам дээр эсвэл явж байхдаа зогсоогоороо хоол идэж болохгүй.

Амандаа, гартаа хоолны үнэр байхад арилгахгүйгээр унтахаар хэвтэж болохгүй. Хүүхдүүдийнхээ гарыг ч угаах хэрэгтэй. Цатгалан хэвтэхгүй байх. Хоол байгаа савны тагийг таглах. Ямарваа нэгэн урсгал уснаас ус уухдаа амаараа шуул залгихгүй байх, саваар юм уу гараараа хутган авч уух ёстой.

Зуны цагт бүлээн ус уух. Пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) аливаа уух зүйлийг халуунаар бус бүлээнээр уух дуртай байжээ. Харин земзем усыг босоогоороо ууж болно. Аянчин хүн ямар ч усыг хөл босоогоороо ууж болно.

Хуурай үзэм, боргоцой, гүйлс идэх нь сүннет юм. Зөгийн

бал анагаах увидастай, 70 пайгамбар зөгийн балын хишгийн төлөө залбирчээ. Пайгамбар маань хурма жимсэнд маш их дуртай байсан юм.

Элчийн гэртээ ба гадаа байх байдал

Гэгээн Хусейн: «Би Мухаммед элч гэр дотороо юу хийж, хэрхэн байдаг талаар ааваасаа асуусан юм. Аав хэлэхдээ:

Мухаммед элч гэртээ орсон цагаас Аллахт мөргөхөд, гэр бүлийн ажилдаа туслахад мөн хувийн ажилдаа гэх мэт 3 хэсэг болгон цаг хугацаагаа хуваадаг байв. Хувийн ажиллах хугацаагаа өөрийн ба хүмүүсийн төлөө зориулна. Энэ хугацаанд тэрний хажууд зөвхөн сонгогдсон хүмүүс л орж уулздаг. Энэ үед хүмүүст шашины утга учир, асуудалыг шийддэг байв.

Элч (салаллаху алейхи уа сальлам) уулзсан хүмүүстэйгээ санал бодолоо солилцож тэдний асуултанд хариулж дараагаар нь: “Энэ сурсан мэдсэн зүйлээ энд байсан бас байгаагүй хүмүүст ч хүргэж, зааж сурга! Надад өөрөө ирж асуудалаа ойлгуулж амжаагүй хүний хэцүү асуудалыг та нар надад хэлцгээ. Үнэндээ ийн хийгсэдийн хөл хойд ертөнцөд сиратын гүүрэнд бат бөх байх болно” хэмээжээ.

Элчийн өмнө бараалхагсад маш олон асуудалтай ороод мэдлэг боловсролтой баталгаа нотолгоотой болоод тараадаг байлаа.

Гэгээн Хусейн эцгээсээ элч (салаллаху алейхи уа сальлам) гэрээсээ гарахаараа юу хийдэгийг нь асуулаа. Эцэг (Али) нь ийн ойлгуулав:

«Хорвоогийн энэрэлт элч гадуур явахдаа олон юм ярьдаггүй байлаа. Асхабууд нь үзэгдэхгүй бол тэднийг сураглаж, болж өнгөрсөн бүх зүйлийг асууж тайлбарлуулна. Түүний хажууд байгсад цөм асхабуудын дээд нь болсон эрдэмтэд мэргэд юм. Тэрний хувьд асхаб дагалдагсад нь хүн төрөлхтөний хамгийн сайн нь, хамгийн хүндтэй хүмүүс юм.

Цуглагсадын хажууд ирхэд өөрт нь зориулж хойморт зай тавьж өгөхийг огт хүсдэггүйгээр барахгүй дургүйцдэг байлаа. Хаана ч байсан сууж буй хэсэг хүмүүсийн хажууд очихдоо хаана л сул орон байна, тэнд суудаг байв.

Хэн нэгэн түүнээс юм гуйвал эсвэл юм асуувал өөрт нь байвал өгдөг байв. Эс байвал эелдэгээр ойлгуулаад буцаадаг

байв. Түүний сайхан зан авир нь бүхий л хүмүүсийг багтаам агуу юм.

Эргэн тойроныхонд энэрэлт эцэг нь болсон байлаа. Эрх чөлөөний хувьд бол бүх хүн түүнтэй эн тэнцүү юм. Элчийн хажууд байх уур амьсгал бол эрдэм мэдлэг, ичгүүр сонжуур, тэвчээр бас үнэнч байдалын уур амьсгал юм.

Түүний хажууд чанга дуугаар хэн ч ярихгүй бөгөөд бусдыг муулдаггүй ба хийсэн ямар нэгэн алдаа эндэгдэлийг задлан ярьдаггүй билээ.

Ихэс дээдэсийг хүндлэн ёсорхож, хүүхэд багачуудыг хайрлан энэрдэг билээ.

Аллахын элч үргэлж инээмсэглэсэн царайтай, сайхан ааш зантай байдаг байлаа. Хэнтэй ч муудалцаж хэнд ч орилож чанга дуугаар ярьдаггүй байлаа. Муу үг хэзээ ч хэлдэггүй байв. Тэрээр харамч биш, үл таалагдах зүйлтэй тулгарвал нүдээ анидаг байв. Гэгээн элч (салаллаху алейхи уа сальлам) 3 зүйлээс зайлс хийдэг байлаа:

Хүмүүстэй маргалдахаас,
Их ярихаас,
Хэрэггүй ашиггүй зүйл хийхээс.

Энэ гурван тохиолдолд хүмүүсийг өөрийнх нь зоргоор үлдээдэг байв:

Хэнийг ч нүүрэн дээр нь эсвэл хойгуур нь буруутгаж муулдаггүй байв.

Хэний ч муу тал ба алдааг олж харах гэж мэрийдэггүй байв.

Хэний ч тухай буянтай биш эсвэл муу муухай үг хэлдэггүй байлаа.

Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) хажууд байгсад огт хөдлөхгүйгээр түүнийг анхааралтай сонсдог бөгөөд түүнийг үгээ дууссаны дараагаар хэлэх асуух зүйлээ соёлтойгоор хэлж эхэлдэг байлаа. Түүний хажууд огт маргалдацгаадаггүй байв.

Түүний хажууд байгсад нэг зүйлд инээх юм бол тэр ч мөн адил дагаж инээнэ. Нэг зүйлд гайхацгаах юм бол тэр ч мөн адил гайхдаг байв.

Худал магтаалд дургүй бөгөөд таалдаггүй.

Пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) хэзээ ч “Үгүй” гэсэн хариултыг өгдөггүй байв. Түүний хийхийг хүсэн

асуухад “За” гэх бөгөөд эс хүссэн зүйлийг нь асуухад чимээгүй байдаг байлаа. Цаад хүн нь ч гэсэн хийхийг хүсэхгүй байгааг ойлгодог байв.

Хүн бүрийн мөнхийн жаргалын төлөө ажилдаг байв. Нэг дайнд кафируудад хараал хийхийг элчээс хүсэхэд: “Би хараал хийхийн тулд, хүмүүсийг тарчлан зовоохийн тулд илгээгдээгүй билээ. Би бүх хүнд буян болохын төлөө, хүмүүсийг амар амгаланд хүргэхийн төлөө илгээгдсэн юм” гэжээ.

Энбия сүрегийн 107 дахь аетэд: “Чамайг хорвоо ертөнцөд энэрэл хайр, буяны төлөө илгээлээ” хэмээжээ. Тийм болохоор хүн бүрийн сайн сайханы төлөө тэмцдэг байлаа.

Харахыг хүссэн тал руугаа харахдаа хамаг биеээрээ эргэж харна.

Газар луу харах нь тэнгэр лүү харахаас илүү их юм.

Явахдаа асхабуудынхаа араас явдаг байлаа.

Хэн нэгэндээ тааралдахдаа тэр түрүүлж өөрөө мэндэлдэг байлаа.

Энэс бин Малик ийн айлдаж байна: «Аллахын элч хэн нэгэнтэй тааралдан мэндлэхдээ гар барилцдаг байлаа. Тэр хүн гараа авах хүртэл гараа татдаггүй. Цаад хүн нь нүүрээ буруулах хүртэл нүүрээ буруулдаггүй байсан юм».

Нэг өдөр Энэс бин Малик элчээс “Аяа, Расууллаллах! Бид нэг нэгэндээ бөхийн мэндэлвэл болох уу? гэж асуув. Элч: “Үгүй, болохгүй!” гэв. Энэс “Тэгвэл тэврэлдэж мэндлэж болох уу?” гэхэд Элч “Үгүй! Зөвхөн гар барилцаж болно” гэв.

Бера бин Азибийн уламжилсан элчийн нэгэн хадис-и шерифт: “Хоёр мусульман уулзаад хоорондоо мэндлээд гар барих юм бол, тэр хоёр салж яваагүй байхад нүгэл нь наминчлаглах болно” хэмээжээ.

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) ихэнхдээ бодолгоширон чимээгүй байдаг байлаа. Түүний ярих нь дуугүй байхаасаа бага билээ. Огт хэрэггүй зүйл ярьдаггүй бөгөөд ярьж эхлэхдээ бас дуусгахдаа Аллахын нэрээр дуусгадаг байв.

Ярихдаа товч бөгөөд тодорхой үгээр ярьна. Мусульман хүн бүр пайгамбарын маань (салаллаху алейхи уа сальлам) сайхан зан авирийг өвлөн авч сургамж болгох ёстой юм. Аллахын хүссэн зан авиртай болох нь бүх мусульманы үүрэг билээ. Учир нь Расууллаллах (салаллаху алейхи уа сальлам): “Аллахын зан авираар аврагдцгаа” хэмээжээ.

Жишээ нь, Аллах эзэний шинж тэмдэгийн нэг бол “Сеттар” юм. Өөрөөр хэлбэл, нүгэлийг халхлагч юм. Мусульман хүмүүс ч мөн адил шашин нэгт ахан дүүсийнхээ ичгүүрийг далдалж байх ёстой. Аллах эзэн бол боолуудынхаа нүгэлийг өршөөдөг билээ. Мусульманууд ч мөн адил бусдын алдаа эндэгдэлийг уучилж өршөөх ёстой.

Элчийн (салаллаху алейхи уа сальлам) сайхан ааш зан маш их билээ. Бүх мусульман энэ ааш авирийг сурч хэрэгжүүлэх хэрэгтэй. Ийнхүү энэ хорвоо ба хойд ертөнцөд тохиох муу муухайгаас хоёр ертөнцийн ноён болсон элчийн хайр ивээлд багтана.

Аллахын элчийн өмсдөг хувцас

Аллахын элч (салаллаху алейхи уа сальлам) ганцхан хибере хувцастай байв. Хибере – ноосон утсаар нэхэгдсэн хөвөнтөй цамц юм. Емен хотын даавуугаар хийсэн хувцасыг Хибере гэнэ. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) энэ хувцасаа өмсөх дуртай байв.

Элч (салаллаху алейхи уа сальлам) мөн хоёр изартай байв. Бэлхүүснээс доош өмсөх өмд маягийн хувцасыг изар гэнэ.

Эбү Будре: “Бид элчийн гэр бүлийг эргэж очиход гэгээн Айше эх бидэнд мүллеббедде гэж нэрлэгдсэн нэгэн хуучин нөмрөг ба Емен хотод хийгдсэн нэг изар (өмд) хоёрыг гарган үзүүлээд “Аллахын элч амьсгал хураахдаа өмсөж байсан хувцас энэ” гэж үзүүлсэн юм”

Пайгамбар маань эрчүүдийн өмсөх изар нь зөвхөн хөлийн шилбэ хүртэл эсвэл шагай нь хүртэл урт байж болох талаар айлджээ.

Элч (салаллаху алейхи уа сальлам) хар ажилд өмсдөг хоёр цамцтай байв. Энэ цамцыг сухар гэж хэлнэ. Сухар тосгонд хийгдсэн болохоор тэр. Элчийн хамгийн их өмсөх дуртай хувцас нь камис (цамц) байв.

Элч (салаллаху алейхи уа сальлам) дан ганц ноосоор нэхэгдсэн нэг цамцтай байв. Аллахын элч (салаллаху алейхи уа сальлам) мөн цагаан дээлтэй байв. “Цагаан хувцас өмсцгөө! Амьд хүмүүс цагаан хувцас, нар барагсадад цагаан кефен (нөмрөг) өмсгө! Учир нь тэр цагаан хувцас буян хишигийн шинж юм” хэмээжээ.

Пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) мөн ногоон хувцас ч өмсдөг байжээ. Эбү Римсе пайгамбар (салаллаху алейхи уа сальлам) нэг өдөр ногоон өмд цамц өмсөн сууж байхыг харсанаа хэлжээ. Пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) мөн улаан өнгийн хуллe (Арабуудын толгойд нэмнэх алчуур) өмсдөг байлаа. Бера бин Азиб “Улаан өнгийн хуллe өмссөн хүмүүсээс элчээс өөр хэнд ч тийм сайхан зохисоныг хараагүй билээ” гэжээ. Элчид (салаллаху алейхи уа сальлам) жума (баасан гаригийн их мөргөл) ба тахилийн баяраар өмсөх улаан өнгийн дээлтэй байлаа. Бас Емений дээлтэй байв.

Нэг удаа атлас гэх үнэт торгоор хийгдсэн, эмжээр нь алтаар бүрэгдсэн товч нь алтаар хийгдсэн үнэт дээл элчид бэлэг болгон өгчээ. Пайгамбар маань тэр дээлийг өмсөөд индэр дээрээ гарч хэсэг суусанаа юу ч ярилгүй буужээ. Мусульманууд тэр дээлийг барьж, илж шагшин магтацгаалаа. Элч (салаллаху алейхи уа сальлам): “Та нар энэ дээлийн сайханд гайхаж байна уу? Энэ дээл та нарт таалагддаг уу?” хэмээн асуухад “Бид амьдралдаа үүнээс илүү гоёмсог хувцас үзээгүй билээ” гэгцгээв.

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам): “Хорвоо ертөнцийг өөрийн эрхэнд байлгадаг Аллахын нэрээр амлая. Саад бин Муазын диваажин дахь дан дээл нь та нарын харж буй энэ хувцаснаас илүү гоёмсог билээ” хэмээжээ.

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) энэ хувцасаа өмсөөд намаз (мөргөл) үйлджээ. Мөргөл үйлдэж дуусаад маш их цээрлэсэн аятай нөгөө дээлийг тайлав.

“Энэдээл муттакичуудад (тахилч боолууд) зохихгүй” гэв. Энэ дээлээ гэгээн Омарт өгчээ. Омар (радиаллаху анх): “Пайгамбар минь, ягаад энэ дээлийг ийм хурдан тайлав?” гэхэд Аллахын элч (салаллаху алейхи уа сальлам): “Жабрайл (алейхиссальлам) (сахиусан тэнгэр) энэ хувцасыг өмсөхийг хориглосон юм” гэв. Омар: “Пайгамбар минь, та надад өмсөхийг хүсээгүй зүйлээ өглөө. Би энэнийг одоо яах вэ?” гэхэд Расулуллах (салаллаху алейхи уа сальлам): “Би энэ дээлийг чамд өмс гэж өгөөгүй, зар гэж өглөө” хэмээжээ. Омар энэ дээлийг 2000 дирхемаар (алтан зоос) заржээ.

Ромын хааны Мухаммед элчид (салаллаху алейхи уа сальлам) бэлэг болгон илгээсэн бас нэгэн дээл бол алтаар имжлэгдсэн, эрдэнийн чулуугаар товч хадагдсан үнэт торгоор оёгдсон гоёмсог дээл байлаа. Тэр дээлийг харагсад: “Аяа,

Аллахын элч минь! Энэ дээлийг таньд тэнгэрээс буулгаа юу?” гэцгээнэ.

Элч (салаллаху алейхи уа сальлам): “Энэ дээл та нарт их таалагдаж байна уу? Хорвоо дэлхийг эзэгнэгч Аллахын нэрээр амлая. Саад бин Муазын диваажин дахь өмсгөл нь энэ дээлнээс илүү сайхан, илүү гоёмсог билээ” хэмээжээ.

Дараагаар нь нөгөө дээлээ Жафер бин Эбу Талибт өгөөд “Энэ дээлийг Нежаши (Этөпийн мусульман болсон хаан) рүү илгээ” гэжээ.

Пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) заримдаа Айше эхийн нэхсэн хар ноосон цамцыг өмсдөг байлаа. Энэ цамцыг өмсөөд хөрхөд ноосоны үнэр гарахад нь тайлж хаяв. Учир нь тэр зөвхөн өөрийн үнэрийг таалдаг байв.

Кааб бин Зүхейрт бэлэглэсэн дээл

Аллахын элч (салаллаху алейхи уа сальлам) Тебукийн дайнд Эйле овгийнхонд нэг Еман Ферманы бичин өгсөн өдөр амар тайваны баталгаа болгон нэгэн дээл өгчээ.

Эбүл Аббас Абдуллах бин Мухаммед энэ дээлийг тэднээс 300 динараар (алтан зоос) худалдан авчээ. Аббасын хөвгүүд энэ дээлийг Селеф гүрний хаадын өмсгөл болгожээ.

Хаадууд баярын өдөр энэ дээлийг өмсөөд, элчийн барьж байсан таягийг барьж гоёдог байв. Энэ үед бусад отог овгууд айн сандарцгаадаг байлаа.

Арабын алдарт яруу найрагч Кааб бин Зүбейр уучлал гуйхаар мөн мусульман болохоор элчид бараалхан: “Эргэлзээгүй элч бас чин үнэнийг харуулагч туяа, муу муухайг үлдэн хөөгч Аллахын хурц сэлэм юм!” гэх энэ шүлэгийг сонсоод Аллахын элч (салаллаху алейхи уа сальлам) маш их баярлан өөрийн өмсөж байсан сайхан дээлээ түүнд өгчээ.

Гэгээн Муавие халифа Кааб бин Зүбейрт “Элчийн дээлийг надад зар” хэмээн түүнд 10000 алтан зоос санал болгожээ.

Кааб бин Зүбейр: “Би элчийн энэ дээлийг өмсөх нь зөвхөн надад зохино гэж бодож байна” хэмээн гэгээн Муавиегийн саналыг хүлээж авсангүй.

Кааб бин Зүбейр нас барсаны дараагаар Муавие тэр дээлийг түүний хөвгүүдээс 20000 дирхемээр (алтан зоосоор) худалдан авчээ. Энэ дээл хойч хойчын халифаануудын өмсгөл

болон уламжлагдсаар иржээ.

Халифа (толгойлогч) нар энэ дээлийг зөвхөн баяр ёслолын үед өмсөн гоёдог байв. Сүүлд Муктедир халихфа нас барсаны дараагаар цусанд будагдан хиртжээ. Ийнхүү Аббас гүрнийхэн Египедэд ирэхдээ энэ дээлийг авч иржээ. Туркийн их хаан Явуз Султан Селим Египедийг эзлэж авсанахаа дараагаар хүндэт эд зүйлсийн дотор ариун дээл ч мөн адилаар Истамбул хотод хүргэгдэн иржээ.

Одоо энэ дээл Истамбул дахь Топкап музейд хадгалагдаж байдаг. Хүн бүр энэ хүндэт ариун дээлийг харахыг зол заяа гэж үздэг юм. Энэ дээл нь 1.24 см өргөн уужим ханцуйтай хар торгоор нэхэгдсэн дээл юм.

Дээлний дотор нь бор өнгийн даавуу юм. Урд тал ба баруун тал нь 0.23х0.30 хэмжээтэй дутуу юм. Баруун ханцуй нь ч гэсэн дутуу юм. Энэ дээл он цагийн аясаар элэгджээ. Олон давхар ороогдон алтан хайрцаганд хадгалагдаж буй.

Нежаши хааны бэлэглэсэн алтан бөгж

Хабешстаны (Етён) хаан Нежаши Асхамын Мухаммед элчид илгээсэн бэлэг сэлтэн дотор эрдэнийн чулуу нь шигтгээтэй алтан бөгж байв. Пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам): Эбүл Асын охины охин нь болох Үмамег дуудаад “Охин минь! Чи үүнийг зүү!” гэв.

Эрчүүд зөвхөн мөнгөн эдлэл зүүж болно. Алт буюу алтадсан эд зүйлсийг зүүх нь цээртэй болохыг мэдэгджээ. Пайгамбар маань нас барах хүртэлээ зөвхөн мөнгөн бөгж зүүдэг байлаа.

Элч (салаллаху алейхи уа сальлам) бөгжөө баруун гартаа зүүдэг байв. Хааяа хааяа зүүн гартаа ч зүүнэ. Тэрээр бөгжөө чигчий ба ядам хуруундаа зүүдэг байв. Бөгжийг гайхуулахын тулд зүүх нь харам (цээртэй) юм.

Нэг өдөр Нуман бин Бешир алтан бөгж зүүгээд элчийн хажууд иржээ. Элч (салаллаху алейхи уа сальлам): “Диваажинд орхоосоо өмнө диваажингийн гоёлыг юунд зүгээв?” гэжээ. Нуман төмөр бөгж зүүж эхэлээ. Энэнийг харсан элч: “Чи юунд тамын бэлэгдэл болсон бөгж зүүгээв” гэв. Тэрээр энэ удаа хүрэл бөгж зүүж эхлэхэд “Ягаад чи буруу номтонуудын зүүдэг бөгж зүүж байна?!” гэжээ. Тэр: “Би ямар бөгж зүүвэл болох вэ?” гэж асуухад: “Мөнгөн бөгж зүү нэг мискаалаас (4.8 гр) илүү хүнд байх ёсгүй.

Мөн баруун гартаа зүү” хэмээв.

Пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) гадаадын хаанд, Ромын хаанд, мөн Етёпын Нежаши хаанд захиа бичүүлжээ. Бичээч нь:

“Аяа, Расулуллах! Тэд ямарваа нэгэн захиаг тамгагүй бол уншдаггүй юм” гэв.

Энэ үеээс хойш пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) мөнгөн “Аллахын элч Мухаммед” гэсэн бөгж хийлгэжээ.

Энэ тамга болох бөгжний бичиг нь доороосоо дээш нь 3 мөр:

- “Мухаммед” нэг мөр,
- “Элч” нэг мөр,
- “Аллах” нэг мөр юм.

Элчийн мөнгөн бөгжний чулуу Етёпын мөнгөн чулуу юм.

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) нас нөгчих хүртэлээ энэ бөгжийг зүүжээ. Пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) жорлонд бөгжөө авч тавьдаг байлаа. Түүний энэ тамгатай бөгжийг нь нас барсаныхан дараагаар гэгээн Эбу Бакир авчээ. Түүний дараа гэгээн Омар, гэгээн Осман нар (радиаллаху анхум) уламжлан авч зүүжээ.

Сүүлд гэгээн Осман нэгэн худагны хажууд суугаад энэ бөгжөө гарган эргүүлж тойруулан харж суутал гэнэт алдан, бөгжөө худганд унжээ.

Худагны бүх усыг шавхан 3 хоног хайсан боловч бөгж олдсонгүй алга болсон юм.

Бөгжний чулуун дээрхи бичиг бичих нь элчээс хойш уламжлал болон үргэлжилжээ. Гэгээн Эбу Бакирын бөгжин дээр “Нимел кадир Аллах” (Аллахын хүч бүх зүйлд юутай сайн хүрнэ вэ?), гэгээн Омарын бөгжин дээр “Кефа бил-мевт изан яа, Омар” (сургамж болоход үхэл хүрэлцээтэй), гэгээн Алигийн бөгжин дээр “Эл-мүлкү лиллах” (Баялаг бүхэн Аллахых) Гэгээн Хасаны бөгжин дээр “Эл-иззетү лиллах” (цуу алдар Аллахых), гэгээн Муавиегийн бөгжин дээр “Раббигфирли” (Эзэн минь, уучил) Ибни Эбу Лейлагийн бөгжин дээр “Эд-дүнйа гарарун” (Хорвоо хуурамч, худалч юм) Имам агзам Эбу Ханифегийн бөгжин дээр “Кул-ил хайр вэ илла фескут” (Нэг бол сайн үг хэл, нэг бол дуугүй бай), имам-и Эбу Юсуфын бөгжин дээр “Мен амиле би-рейхи недиме” (Өөрийнхөөрөө шийдэгсэд харамсдаг), Имам-и

Мухаммедийн бөгжин дээр “Мен сабера зафере” (Тэвчээртэй хүмүүс ялдаг), Имам-и Шафигийн бөгжин дээр “Эл-берекетү фил канаа” (буяг хишиг баярлан дагагсадад буй) гэх мэт бичигүүд байдаг. Энэ бөгжөө тамга болгон ашигладаг байлаа.

Элчийн ор

Аллахын элчийн (салаллаху алейхи уа сальлам) унтдаг байсан дэр нь арьсан юм. Дэрэн доторхыг хурма модны үртэсээр дүүргэжээ.

Гэгээн Айше эх ийн тайлбарлажээ: “Манайд ансараас нэгэн эмэгтэй ирэхдээ элчийн орийг хараад гэрээсээ элчид зориулан дотор нь ноосоор бүрсэн тансаг ор, хөнжил илгээсэн юм. Аллахын элч энэ хөнжилийг хараад “Энэ юу вэ?” гэж асуулаа. Би: “Аяа, пайгамбар минь, ансараас ийм нэг эмэгтэй ирээд таны орийг хараад өрөвдөн таньд энэ хөнжилийг өглөө” гэлээ. “Энэнийг одоохон түүнд буцааж өг” гэлээ. Гэвч би энэ гоёмсог орыг буцаахыг хүсээгүй учираас гэртээ үлдээв. Элчийн урьдын үгээ 3 удаа давтан хэлээд “Аллахын нэрээр ангайлъя! Аяа, Айше минь! Хэрвээ би хүссэн бол Аллах надад алт мөнгөөр бүрсэн ор өгөх байсан” хэмээв. Элчийн унтах ор дээрээ нөмөрч, доороо дэвсэх хоёр ноосон нөмрөг байлаа.

Гэгээн Айше эх өгүүлсэн нь: “Мекке хотод ор дээр хэвтэх шиг сайхан зүйл байдаггүй байлаа. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) Медине хотод ирээд Эбү Эйубын гэрт буудлахдаа түүнээс: “Эбү Эйуб минь! Танайд ор дэвсгэр байхгүй юм уу?” гэж асуухад Эйуб: “Үнэндээ манайд байхгүй ээ” гэж хариулав.

Ансаруудаас Саад бин Зурере энэ байдалыг дуулаад элчид торгон эмжээртэй дотор нь ноосоор чихсэн нэгэн дэвсгэр илгээжээ.

Элч (салаллаху алейхи уа сальлам) шинэ гэртээ орох хүртэлээ, тэр бүү хэл нас барах хүртэлээ тэр дэвсгэр дээр унтжээ. Пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) энэ дэвсгэр дээрээ шөнө нь намазаа үйлдээд өдөр нь дэлгэн суудаг байлаа.

Элчийн таяг

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) индэр дээр гарч илтгэл сургаалаа айлдахдаа таягаа эсвэл нэг нум тулдаг байв. Харин аян замд явахдаа нумаа тулж явдаг байв.

Пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) таягийг тулах нь пайгамбарын шинж тэмдэг хэмээн хэлдэг байв. Өөрөө ч гэсэн таяг тулж, мөн бусдад таяг тулахыг санал болгодог байв.

Нэг удаа Абдуллах бин Үнейс элчийг мөсжидээс гэрт нь хүргэж очив. Элч (салаллаху алейхи уа сальлам) түүнд нэг таяг өгөөд “Энэ таягийг хадгалж яв, Абдуллах” гэв.

Абдуллах бин Үнейс тэр таягаа барин найзуудынхаа дунд очиход найзууд нь “Энэ таягийг хэн өгөв?” гэж асууцгаалаа. Абдуллах “Энэ таягийг элч надад хадгалж яв гэж өглөө” гэв. Найзууд нь: “Чи Аллахын элчид буцаж очоод энэ таягийг юуны тулд өгсөнийг асуу” гэгцгээв. Абдуллах бин Үнейс элчид ирээд: “Аяа, Аллахын элч! Та энэ таягийг надад юуны тулд өгөөв?” гэж асуухад элч (салаллаху алейхи уа сальлам): “Энэ бол хойд ертөнцөд бид хоёрын хоорондох нэг тэмдэг юм. Тэр үед таяг тулсан хүмүүс маш бага байх болно. Чи энэ таягийг диваажинд түшиж яв” хэмээв.

Энэ цагаас хойш Абдуллах бин Үнейс энэ таягаа сэлэмтэйгээ хамт өөрөөсөө огтхон ч холдуулдаггүй байлаа. Нас барахдаа ч энэ таягийг булшинд хамт оршуулахыг хүсжээ.

Элчийн үргэлж өөртөө авч явдаг байсан долоон зүйл

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) нэг метр шахам урттай нэг саваа модтой байв. Пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) холоос Каабыг тойрон мөргөх үед тэр модоороо Каабыг илэх мэт зангадаг байлаа.

Аллахын элч (салаллаху алейхи уа сальлам) үргэлж хажуудаа сам, толь, мисвак (шүд цэвэрлэдэг мод) цэцгийн тос, сүрме (зовхины будаг) ба хайч авч явдаг байлаа.

Гэгээн Айше (радиаллаху анха): “Дайнд бэлдэхэд би элчийн цэцгийн тос, сүрме (зовхины будаг), хоёр хайч, сам, толь, мөн мисвак (шүд цэвэрлэдэг мод) нарыг нь бэлддэг байсан юм”

Мөн гэгээн Айше эх: “Пайгамбар маань үргэлж энэ 7

зүйлийг өөртөө авч явдаг байсан юм:

1. Цэцгийн тос 2. Сам 3. Толь 4. Сүрме (зовхины будаг) 5. Мисвак (шүд цэвэрлэдэг мод) 6. Хоёр хайч 7. Үс хагалдаг яс. Энэ долоон зүйлийг огт хаядаггүй байсан” хэмээжээ.

Пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) өдөр бүр сахалаа хоёр удаа самнадаг байсан.

Энэс бин Малик: “Аллахын элч үе үе цэцгийн тос түрхэж сахалаа услан самнадаг байсан” гэжээ.

Тэрээр эмх цэгцийг маш их эрхэмлэдэг байсан

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) цэвэрч нямбай байдалд маш их анхаардаг байлаа. “Хүн бүр өөрийн үсээ сайн арчилж хамгаалцгаа” хэмээжээ. Нэг удаа элч мөсжидэд байхдаа үс гээг нь арзайж үс нь ургасан хүнийг хараад “Энэ хүнд үсээ самнах сам тослох тос байхгүй гэж үү?!” хэмээгээд гадагш гарсаныхаа дараагаар түүнийг үсээ самнаж арчлахыг гараараа занган ойлгуулав. Тэр хүн үсээ янзлаад ирэхэд элч (салаллаху алейхи уа сальлам): “Та нар үсээ арчлах нь сайхан харагдах уу? Эсвэл чөтгөр мэт арзайгаад явж байх нь сайхан харагдах уу?” хэмээжээ.

Пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) сахалаа хажуу шанаанаас нь бас уртаас нь тайрч богинсгодог байв. Мөн жума (баасан гарагийг их мөргөл) мөргөлд очихоосоо өмнө, ширвээ сахалаа хусаж хумсаа авдаг заншилтай байжээ. Мусульмануудад ч гэсэн хумсаа авахыг зөвлөдөг байв.

Аллахын элч толинд харах болгондоо: “Аллах минь! Чамайг царайлаг болгосон адилаар миний сэтгэл зүрхийг ч сайхан болго” хэмээн залбирдаг байв.

Аллахын элч (салаллаху алейхи уа сальлам) орой бүр унтахаасаа өмнө нүдэндээ 3 удаа сүрмэ (зовхины будаг) түрхдэг байлаа. Сүрмэг баруун нүдэндээ 3, зүүн нүдэндээ хоёр удаа түрхэн: “Сүрме түрхэцгээ, тэр бол нүдийг өнгөлөг болгож сормуусыг өтгөрүүлдэг юм” гэжээ.

Ислам шашинд эрчүүд сүрме (зовхины будаг) түрхэх нь зөвшөөрөгдсөн бөгөөд гангараа болгон түрхэх нь хориотой юм.

Аллахын элч (салаллаху алейхи уа сальлам) мисвакыг (шүд цэвэрлэдэг мод) маш их хэрэглэхийг анхаардаг байлаа. Үргэлж өөртөө мисвак авч явдаг байв.

Пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам): “Эрак модны мөчирөөр мисвак хийцгээ!” хэмээжээ. Энэ мод маш гоё үнэртэй. “Мисвак бол миний бас надаас өмнөх элчүүдийн сүннет юм” хэмээжээ.

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам): “Хэрвээ миний дагалдагсадад хэцүү байгаагүйсэн бол мөргөл болгоны өмнө мисвакыг хэрэглэхийг захиx байлаа”

“Мисвак бол амны цэвэрлэгээ бас Аллахын таалал юм” хэмээжээ.

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) гэртээ орохдоо хийдэг хамгийн анхны ажил нь мисвакаар шүдээ цэвэрлэх явдал юм.

Гэгээн Айше эх: “Мухаммед элч унтахдаа заавал угаалга үйлддэг байсан бөгөөд угаалга үйлдэх болгондоо мисвак хэрэглэдэг байсан” хэмээжээ.

Элчийн сэлмүүд

Мухаммед элчид (салаллаху алейхи уа сальлам) 9 сэлэм байсан. Эцэгээс нь өвлөн үлдсэн бас Масур гэж алдаршсан сэлэм гэх мэт. Энэ сэлэм нь элчийг Медине рүү нүүхдээ авч очжээ.

Абд нэртэй сэлэм: Энэ сэлмийг элчид Саад бин Убаде бэлэглэжээ. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) энэ сэлмийг Бедир дайнд барьжээ.

Зүлфикар сэлэм: Курейшийн мүшрикүүдийн нэг болох Мүнеббих бих Хажжаж эсвэл Ас бин Мүнеббихийн сэлэм юм. Энэ сэлэм Бедирийн дайны олз юм. Пайгамбар маань Зүлфикар сэлмийг гэгээн Алид бэлэглэжээ. Бариулынхан толгой ба хуй нь мөнгөн юм.

Энэ сэлэмийг элч (салаллаху алейхи уа сальлам) нас нөгчсөний дараагаар гэгээн Аббас Эбү Бакиртэй бараалхан гэгээн Алигаас авахыг хүссэнд гэгээн Эбү Бакир:

“Би энэ сэлэмийг үргэлж Алигийн гарт байхыг үзсэн юм. Тийм болохоор түүнээс авах нь зүй бус” гэв. Гэгээн Аббас ч тэр сэлэмийг Алид үлдээжээ.

Аллахын элчийн жад нь: Элчид Бени Кайнука гэх овгийн жүүдүүдийн 3 жад дайны олз болжээ. Мухаммед элчийн жадуудын нэгнийх нь нэр Мүсви, бусдынхан нэр Мүсна юм.

Элчийн нум сум ба бамбай

Аллахын элч (салаллаху алейхи уа сальлам) 6 нум сумтай байв. Эд нараас Ревха, Бейза, Шафра гэсэн нэртэй гурван нум сум бол Бени Кайнука жүүдүүдээс үлдсэн олз юм. Сафра кетум гэх нум нь Неб гэх маш бат бөх модоор хийгджээ. Энэ Кетум нум Ухуд дайны олз бөгөөд Катаде бин Нуманы нум байжээ. Мөн Седад, Зевра нэртэй нум ч бий.

Элчид 3 бамбай байлаа. Зелук нэртэй бамбай нь дээрээ хонины толгой сийлсэн байна. Энэ бамбайг элчид бэлэглэжээ. Гэхдээ Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) энэ бамбай дээрээ зурагтай болохоор таашаадаггүй байлаа. Өглөө болоход Аллах бамбай дээрх тэр зургийг алга болгосон байлаа.

Элчид долоон хуяг дуулага байлаа.

Нэг нь Затулфудул нэртэй юм. Үүнийг Саад бин Убаде элчид Бедир дайнд морьдохын өмнө бэлэглэжээ. Мөн Садие, Фидда нэртэй хуяг Бени Кайнука жүүдүүдээс олзлосон дайны олз юм.

Пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) Ухуд дайнд Фудус ба Фидда гэх хоёр хуягаа давхарлан өмсжээ.

Элчийн хуягийн өмнө ба ар талд нь мөнгөн цагирагтай юм. Түүний Садие гэх хуяг нь гэгээн Давуд элчийн Жаалут гэх кафиртай дайтахдаа өмссөн түүхтэй хуяг юм.

Элч (салаллаху алейхи уа сальлам) нас барахаасаа өмсөн нэг хуягаа Бени Заферлер гэх овгийн Эбүшшахм нэртэй жүүд хүнд барьцаа болгон 30 кило арвай буудай авчээ. Энэ хуягийг Затулфудул гэдэг байв.

Үлдсэн хуягууд нь Затулвишан, Затулхаваш, Бетраа, Хирмик нар юм.

Пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) Затулфудул ба Садие гэх хуягаа Хунейн дайнд оролцохдоо өмсжээ.

Элчийн дуулга нь: Нэг дэхь нь Мешбуг нэртэй хуяг дуулга. Ухуд дайнд Мигфер нэртэй дуулга нь цуурч хажуу хамгаалалд цагираг нь элчийн эрүүнд шигдсэн юм. Аллахын элч (салаллаху алейхи уа сальлам) Мекке хотыг эзлэхээр очихдоо мигферийг өмссөн байсан юм.

Элчийн туг далбаанууд

Аллахын элчийн (салаллаху алейхи уа сальлам) туг нь хар, далбаа нь цагаан билээ.

Пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) тугаа гэгээн Алид атгуулдаг байлаа. Элч Хайбер дайнд: “Би тугаа нэгэн баатард атгуулах болно. Тэр Аллах ба түүний элчийг хайрладаг, Аллах ба элч ч түүнийг хайрладаг билээ” хэмээгээд исламын тугыг гэгээн Алид атгуулжээ.

Тиймээс ч агуу Аллах Хайбер дайны ялалтыг Алид өгчээ. Элчийн энэ туган дээр “Лаа илаха иллаллах, Мухаммедүр расулуллах” (Аллахаас өөр бурхан үгүй, Мухаммед Аллахын элч мөн) гэсэн бичигтэй юм.

Пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) Харрар дайнд морьдох Саад бин Эби Ваккасд цагаан далбаа хийж өгчээ.

Далбааг зөвхөн цэргийн дарга л барьдаг байлаа.

Эбва ба Веддан дайнд элчийн туг далбааг гэгээн Хамза, Буват дайнд Саад бин Эби Ваккас, Курз бин Сабирул Фахирийг үлдэн хөөхөд гэгээн Али, Зүлүсейра дайнд гэгээн Хамза нар байжээ.

Аллахын элч (салаллаху алейхи уа сальлам) Бедир дайнд морьдохдоо тугийг Мусаб бин Умейр барьжээ. Харин Али элчийн өмнө хар далбааг барьж явжээ.

Элч (салаллаху алейхи уа сальлам) Мекке хотыг цагаан далбаагаар эзлэн авчээ.

Тебук дайнд хамгийн том тугыг гэгээн Эбү Бакир, харин хамгийн том далбааг Зүбейр бин Аввам нар барьжээ.

Элчийн хүлгүүд

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) Медине хотод Вени Фезарилер гэх овгийн нэг хоньчиноос 10 уут мөнгөн зоосоор нэг морь худалдан аваад Секиб нэр өгсөн нь түүний анхны морь байлаа. Элч (салаллаху алейхи уа сальлам) энэ хүлгээ Ухуд дайнд унжээ. Секиб урууландаа цагаантай морь байлаа. Явдал нь ус мэт зөөлхөн юм. Мүртежиз нэртэй морио элч Бени Мүрре гэх овгийн нэг малчинаас худалдаж авчээ. Мүртежиз маш биерхүү хурдан хүлэг юм.

Лизез нэртэй морийг Александрийн хаан Мукавкис элчид бэлэглэжээ. Зариб нэртэй морийг элчид Ферве бин Умейр элчид бэлгэнд өгчээ. Зариб маш хүчтэй жинхэнэ дайны морь юм.

Лахиф нэртэй морийг элчид Ребия бин Бераул Келби бэлэглэжээ. Лахиф урт сүүлтэй агаад сүүл нь газар шүргэдэг байлаа. Харин Ясуб нэртэй морь нь элчийн аргамагуудын хамгийн дээд нь байлаа. Муравих гэх уралдааны хүлгийг Убейд бин Ясир Тебук дайнд элчид бэлэглэжээ. Муравих салхи мэт хурдан хүлэг юм.

Мирвах: Энэ морийг Мединед ирсэн Бени Реха овгийн толгойлогч Мирвахи элчид бэлэгэнд өгчээ. Мирвахийг элч унаж үзээд маш их таалжээ.

Верд: Энэ морийг элчид Темим-и Дари бэлэглэжээ. Берд ботгон бор өнгөтэй ажээ. Элч (салаллаху алейхи уа сальлам) энэ морио гэгээн Омарт өгчээ. Гэгээн энэ морио унаад Аллахын шашины төлөө байлджээ. Элч (салаллаху алейхи уа сальлам) гурван морио уралдаанд уралдуулдаг байлаа. Лизаз, Зариб, Секиб нэртэй гурван хурдан хүлэгтэй байв. Уралдааны гурван түрүүг элчийн энэ гурван хүлэг авдаг байв.

Мөн пайгамбард маань (салаллаху алейхи уа сальлам) илжиг луус ч байлаа. Элчид нэг луус бэлэглэсэн юм. Энэ луусийг дулдул гэдэг байлаа. Дулдул цав цагаан өнгөтэй луус байлаа. Элч энэ луусыг Хайберийн дайнд унжээ. Хунейн дайнд өөр нэг цагаан луусаа унжээ.

Элчийн нас барсаны дараагаар дулдулыг Али өвлөн авчээ. Али (радиаллаху анх) нас барсаны дараа гэгээн Хасан дараагаар гэгээн Хусейн сүүлд гэгээн Мухаммед бин Ханафие унаж байжээ. Дулдул гэгээн Муавиегийн үе хүртэл амьдарчээ.

Элчийн тэмээнүүд

Кусва тэмээ: Энэ тэмээг Бени Кушейр бин Кааб бин Ребия бин Амираас гэгээн Эбү Бакир 400 дирхемээр (мөнгөн зоос) худалдан аваад, яг тэр үнээрээ элчид өгчээ.

Зарим яриагаар бол энэ тэмээг элчид бэлэглэсэн гэх нь бий. Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) Медине рүү Кусва тэмээгээрээ нүүжээ. Худейбие умред очихдоо энэ тэмээгээ унаж очжээ. Мекке хотыг эзлэн авахдаа энэ тэмээгээ унсан юм. Элчийн энэ тэмээтэй уралдсан ямар ч тэмээ түрүүлдэггүй байлаа.

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) хагацалын хаж мөргөлөө үйлдэхдээ Арафат толгодод байхдаа Кусва тэмээн дээрээ суугаад салах ёсны сургаалаа айлджээ. Кусва тэмээ гэгээн Эбү Бакир халифе байх үед Баки оршуулгийн газар луу явууллаа. Тэнд бэлчиж байгаад үхжээ.

Эбү Жахилээс олзлосон тэмээ:

Пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) Бедир дайнд Эбү Жахилын алдартай тэмээг толгойлогчийн хувь болгон авчээ.

Худейбиегийн Умре хаж хүртэл энэ тэмээгээ ундаг байв.

Энэ тэмээг тахил болгохоор шийджээ. Мүшрикүүд 100 тэмээгээр энэ тэмээг нь солихийг санал болгосон юм.

Пайгамбар (салаллаху алейхи уа сальлам): “Хэрвээ би энэ тэмээг тахил өргөхөөр тэмдэг тавиаггүй бол та нарын хүсэлтийг биелүүлэх байлаа” гэжээ.

Ингэн тэмээнүүд:

Элчид Ханна, Семра, Урейс, Садие, Бегум, Есире, Дебба нэртэй долоон ингэн тэмээ саадаг байлаа. Энэ тэмээнийхээ сүүгээр гэр бүлээ тэжээдэг байв.

Харин элчийг нас барихаас өмнө энэ тэмээнүүд үхэж дуусчээ.

Элчийн өлзийтэй гэрүүд

Пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) Медине хотод мөсжид (сүм) бариулахад хажууд нь тосгоор хоёр өрөө гэр бариулжээ. Дээвэрийг нь хурма модны мөчирөөр битүүлжээ.

Гэгээн Айшегийн өрөөний хаалга нь мөсжид рүү очих замд юм. Гэгээн Севде эхийн өрөөний хаалга нь мөсжидийн гурав дахь хаалга бөгөөд Османы гэр бүлийн хаалганы харалдаа юм.

Аллахын элч (салаллаху алейхи уа сальлам) бусад эхнэрүүдээ авч ирэхэд өрөөнүүдийн тоо нэмэгджээ. Энэ өрөөнүүдийг заримыг нь тоосгоор заримыг нь чулуугаар барьжээ. Зарим нь хурма модоор баригдсан агаад шавараар шаварджээ.

Имам-и Бухаригийн хэлсэнчлэн элчийн гэрийн хаалгыг тогших төмөр цагираг байгаагүй болохоор нумын үзүүрээр цохьдог байна.

Гэгээн Севде өрөөгөө Айше эхэд өвлүүлэн үлдээжээ. Гэгээн Сафие өрөөгөө нас барах хүртэл амьдрах нөхцөлтөйгөөр

төрхөмдөө 180 ба 200 дирхемээр (алтан зоос) Муавие бин Эбу Сүфиянд заржээ.

Халифе Абдулмелик элчийн гэр бүлийн хүмүүсийн энэ өрөөнүүдийг эвдэн мөсжидэд хольж, томосгох утга агуулсан албан бичигийг уншин зарлахад сонсогсод цөм нулимсаа барьж үл дийлэн Мединегийнхэн элчийг нас бархад хэрхэн уйлсан адилаар уйлцгаажээ.

Саид бин Мүсейб: “Үнэндээ элчийн гэргийнүүдийн өрөөнүүдийг байгаа хэвээр нь үлдээхийг их гуйсан боловч бүтсэнгүй. Медине хотод шинээр исламд орогсод элчийн энэ хомсхон ядуу гэр орныг хараад сургамж аван, эд баялагаас зайлсхийх байсан болов уу? хэмээн гомдолоо илэрхийлжээ.

Элчийн сан хөмрөгт хийсэн эд хөрөнгө

Исламын сан хөмрөг бол Ухуд дайнд амь үрэгдсэн жүүд эрдэмтэн ба баян хүн болох Мухайрикийн үхсэний дараа элчид өг гэж гэрээслэсэн 1.Мисэб, 2.Сафие, 3.Делал, 4.Хусна, 5.Бурка, 6.Аваф, 7.Мешребе гэх долоон цэцэрлэг юм.

Мухаммед элчийн (салаллаху алейхи уа сальлам) Медине хот дахь сан хөмрөгийн ихэнх нь Мухайрикийн гэрээслэсэн хөрөнгө юм.

Амр бин Мухажир ийн айлджээ:

“Элчийн үлдээсэн эд зүйлс Омар бин Абдулазизийн өрөөнд байдаг байлаа. Омар өдөр бүр энэ зүйлсүүдээ хардаг байлаа. Курейшуудаас ирсэн хүмүүсийн байх энэ өрөөнд суухдаа “Энэ бол Аллах та бүхэнд пайгамбар болгон илгээсэн агуу хүний үлдээсэн гэрээс юм!” гэнэ.

1. Нэг ширхэг Хурма модны мөчирөөр хийсэн наар
2. Нэг ширхэг арьсан гадартай хурманы үрдэс дүүрэгсэн дэр
3. Нэг ширхэг том төмпөн
4. Нэг ширхэг усны аяга
5. Нэг ширхэг хувцас
6. Нэг ширхэг гар тээрэм
7. Нэг ширхэг сумны сав
8. Нэг ширхэг нөмрөг

Энэ нөмрөг элчийн үнэр шингэсэн болохоор анхилуун үнэртэй юм.

Омар бин Абдулазиз өвдсөн үедээ энэ нөмрөгийг угаасан усаар биеэ угаахад дорхноо илааршдаг байжээ. Омар бин Абдулазиз халифе маш их даруу төлөв хийгээд жинхэнэ үнэнч боол байжээ.

Имам-и Шафий: “Хулефе-и Рашидин (Пайгамбарын залгамжлагч) тав юм. 1.Эбү Бакир, 2.Омар, 3.Осман, 4.Али, 5.Омар бин Абдулазиз” гэдэг байв.

ИСЛАМ ШАШИН

Аллах эзэний Жабрайл гэх сахиусан тэнгэрээр зуучлан Мухаммедэд (aleyхиссальлам) илгээсэн, хүн төрөлхтөнийг энэ хорвоо хийгээд хойд ертөнцөд жаргал ба энх тайванд хүргэхийг зорих нэгэн хууль дүрэмүүд юм. Бүхий дээдийн зүйлсүүд ба хэрэгтэй зүйлс ислам шашинд буй. Урьд өмнөх шашинуудын бүхий л сайн сайханыг ислам шашин өөртөө агуулжээ. Ислам шашин ухаантай бас шударга хүмүүс сонгодог нэгэн зам юм.

Ариунаар хорвоод мэндлэгсэд исламыг үгүйсгэхгүй, цээрлэхгүй юм. Исламын дотор ямар ч муу муухай зүйл, гадна ямар ч ашиг хонжоо байхгүй. Ислам шашин улс орныг энх амгалан, хүн бүрийг эв найрамдалтай байхыг номлодог юм. Аллах эзэний хайр энэрэлийг хүндэтгэн амьд амьтадыг энэрэн хайрлахыг номлодог.

Ислам шашин газар тариаланг, шударга наймаа хийхийг, бас эрдэм мэдлэгээ дээшлүүлэхийг зарлигладаг. Зөв мэдлэг боловсролыг олгоход маш их анхаардаг. Хүмүүс нэг нэгэндээ туслаж дэмжихийг номлодог.

Ислам шашин бол хүний сэтгэлийн ба эд баялагийн үнэ цэнийг зөв мэдрүүлж мөн хүний хийх ариун үйлийг нэг бүрчлэн зааж сургана. Товчхондоо ислам шашины иман (итгэл үнэмшил), ибадет (мөргөл залбирал), мүнaкexaт (гэрлэх ёс), муaмeлaт (зан үйл), укубaт (ял шийтгэл) гэх цөмтэй.

Иман (итгэл үнэмшил)

Иман нь гэгээн пайгамбарын маань (салаллаху aлейхи уa cальaм) Аллахын жинхэнэ элч болоход нь, мөн түүний сонгосон нэгэн мэдээ дамжуулагч боол болохыг нь итгэж түүнийгээ хэлэх бөгөөд келиме-и шахадаатыг (тангарагийн үг) итгэн хэлэх явдал

юм.

Итгэл үнэмшлийн 6 шаардлага бий: Нэгдүгээрт, Аллах эзэн байгаа бөгөөд энэ хорвоо ертөнцийг туурвигч гэдэгт итгэх. Энэ хорвоо ба хойд ертөнцийн бүх зүйлийг үгүйгээс бий болгосон гэдэгт магадгүй итгэх юм. Бүх зүйлийн эзэн нь тэр юм. Түүнийг захирах эзэн байхгүй. Бүхий л дээдийн шинж чанар нь түүнийх бөгөөд тэрээр ямар ч мөхөс дутуу дульмаг чанар үгүй. Тэрээр хүссэнээ гүйцэлдүүдэг. Түүний бүтээсэн зүйл нь өөрийнх эсвэл бусдын эрх ашгийн төлөө биш юм. Ямар нэгэн хариу нэхдэггүй. Мөн түүний бүх хийсэн зүйлд нууц, буян, учир шалтгаан бөгөөд уялдаа холбоо бий.

Өөрийн боолууддаа сайн сайханыг хийн, тэдний эрх ашигийг бодож эсвэл тэднийг гэсгээх албагүй. Чин үнэнч итгэлт мусульмануудаа диваажинд оруулж, хэмжээлшгүй бастөгсгөлгүй мөнхийн аз жаргал өгөхөө, харин үл итгэгсэдэд ба кафируудыг мөнхийн тамд гэсгээхээ мэдэгджээ. Тэр хэлсэн үгнээсээ буцдаггүй шударга билээ. Бүх хүмүүс түүнд итгэн сүсэглэсэн ч Аллахд ямар ч ашиг нэмэр үгүй. Бүх хүн төрөлхтөн буруу номтон болсон ч түүнд ямар ч хохирол үгүй. Ширк ба куфирлэлээс өөр ямар ч нүгэл хийгсэд наминчилалгүй үхсэн ч Аллах хүсвэл түүнийг уучилна. Кафир (буруу номтон) мөртөд (шашинаасаа гарагсад) нарыг хэзээ ч уучлахгүй. Тэднийг мөнхийн гэсгээлээр тамлах болно.

Нүгэлт мусульманууд болон өөр урсгалд автагч мусульман нас бараад хийсэн нүглийнхээ төлөө цээрлэл хүлээх боловч мөнх тамд үлдэхгүй.

Аллах эзэнийг өөрийн нүдээр харж болох ч өдий хүртэл хэн ч үзээгүй билээ. Аллах эзэний хувьд цаг хугацаа гэж үгүй билээ. Учир нь тэр мөнх юм. Аллах эзэн огт өөрчлөгдөхгүй болохоор урьд өмнө ба ирээдүйд ийм байна гэж хэлэх боломжгүй. Аллах эзэн юутай ч адил, бус юутай ч зүйрлэшгүй билээ. Мөн юунд ч хамаарагдахгүй. Түүний эсрэг туслагч, хамтрагч, хамгаалагч гэж байхгүй. Мөн түүнд эцэг эх, үр хүүхэд, эхнэр гэж үгүй. Тэрээр бүхий л хугацаанд бүх хүнтэй хамт байж, бүхнийг нэг дор харж ажиглаж буй.

Аллах эзэний нэр алдар нь тоо тоймшгүй их юм. Өөрийн ариун нэр алдарийнхаа 1001 ширхэгийг хүмүүст заасан бөгөөд Мухаммед элчийн шашинд зөвхөн 99 нэр алдараа илчилжээ. Энэнийг Эсме-и Хусна гэнэ.

Иманы 6 шаардалгын хоёр дахь нь мелек буюу сахиусан тэнгэрүүдэд итгэх. Мелек бол ариун гэгээлэг, туяалаг, амьд бодьгаалс юм. Мелекүүд хүссэн дүр төрхөндөө орж хувирч чаддаг. Сахиусан тэнгэрүүд бол ариун хүмүүсийн сүнс огтоос биш юм. Христийн шашинтанууд сахиусан тэнгэрийг ийм сүнс гэж үздэг.

Мелек гэдэг нь элч, мэдээ дамжуулагч, хүч тэнхээ гэсэн утгатай. Мелекүүд бүхий л амьд амьтадаас өмнө туурвигджээ. Тийм болохоор, судар номуудад итгэхээс өмнө мелекүүдэд итгэх ёстой гэжээ. Куран сударт итгэх ёстой зүйл энэ зарчимаар бичигджээ.

Мелекүүдэд ийн итгэх ёстой: Тэд бол Аллахын боолууд юм. Охид нь биш. Аллах эзэн бүхий л мелекүүдэд талархан соёрхдог. Тэд огт Аллахын зарлигаас гардаггүй. Эр эм гэж ялгардаггүй. Идэж уухаар гачигдаггүй, ядарч туйлдахгүй юм. Аллахын туурвигсадаас хамгийн олон тоотой нь мелекүүд юм. Эдний тоог Аллагаас өөр хэн ч үл мэднэ. Тэнгэр огторгуйд мелекүүдийн мөргөн залбирдаггүй сул орон зай үгүй юм. Тэд зөвхөн Аллахын зарлигыг гүйцэтгэж амьдардаг. Тэд Аллах эзэн ба бусад амьд биетүүдийн хооронд холбогч юм. Зарим нь бусад мелекүүдийн толгойлогч юм. Зарим нь элчүүдэд мэдээ хүргэгч, зарим нь хүмүүсийн сэтгэлд сайн санааг төрүүлэгч юм. Бүх мелекүүдэд өөр өөрийн үүрэг бий. Диваажингийн мелек тамын мелек гэж байдаг. Диваажингийн мелекүүдийн толгойлогчийг Ридван гэнэ. Тамын мелекүүдийг Зебани гэнэ. Зебаничүүдийн толгойлогчийг нь Малик гэнэ. Тамын мелекүүд тамын тогоог халаах гэсгээлийг явуулдаг үүрэгтэй юм.

Хүн бүрийн амьд ахуйдаа хийсэн сайхан муухай үйлдлүүдийг хувь заяаны дэвтэрт бичиж хөдөлдөг хоёр мелек бий. Тэднийг Кирамен катибин ба Хафаза гэж нэрлэнэ. Баруун мөрөн дээрхи мелек буянт үйлсийг зүүн мөрөн дээрхи мелек нүгэл алдааг бичдэг юм.

Булшинд кафируудыг мөн нүгэлт мусульмануудыг гэсгээн цээрлүүлдэг бас шүүлт явуулдаг мелекүүд ч бас бий. Асуулт асуух мелекүүдийг Мүнкер ба Некир гэнэ. Мусульмануудаас асуулт асуух Мелекийг Мүбешшир ба Бешир гэнэ.

Мөн мелекүүд нэг нэгнээсээ дээд байдаг. Хамгийн дээд мелекүүд нь 4 байдаг. Эдний эхнийх нь Жабрайл алейхиссальтам юм. Энэ мелек пайгамбаруудад Аллахын зарлиг, цээрлэл

айлдалыг дамжуулдаг үүрэгтэй. Хоёр дахь нь, Сур гэх бүрээг үлээх үүрэгтэй Исрафил алейхиссальлам юм. Энэ мелек сурыг хоёр удаа үлээнэ. Эхний удаа үлээхэд Аллахаас бусад бүхий л амьд зүйлс үхэх болно. Хоёр дахь удаагаа үлээхэд бүхий л үхэгсэд эргэж амилах болно. Гурав дахь нь Микайл алейхиссальлам юм. Энэ мелек бороо, цас, ган гачиг гэх мэт байгаль дэлхийн үзэгдлийг хариуцан удирддаг үүрэгтэй юм. Дөрөв дэхь нь Азрейл алейхиссальлам юм. Энэ мелек үхэх цаг нь бологсодын амийг нь авагч мелек юм.

Иманы 6 шаардалгын гурав дахь нь, Аллах эзэний илгээсэн судар номуудад итгэх. Аллах эзэн энэ судар номуудыг зарим элчүүдэд мелекээр дамжуулан зарим нэгэнд нь цаасаар буулгаад, заримд нь мелекгүйгээр шууд хэлэн илгээжээ. Энэ судар номууд бол цөм Аллахын үг хэл юм. Энэ судар мелекүүдийн эсвэл элчүүдийн үг биш юм.

Куран Керим судар бол бүхий л ариун сударуудыг өөртөө агуулсан эмхэтгэл юм. Куран судар хойд ертөнц хүртэл огт өөрчлөгдөхгүй, огт хувирахгүй юм. Өнгөрсөн ба ирээдүйн бүхий л эрдэм мэдлэг Куран сударт бий. Аллахын элч Мухаммедын (салаллаху алейхи уа сальлам) хамгийн том гайхамшиг бол куран судар юм.

Аллахаас илгээсэн судар номууд ба хуудаснууд нийлээд 104 юм. 10 хуйлмал Адам (алейхиссальлам)пайгамбард, 50 хуйлмал Шит (алейхиссальлам)пайгамбард, 30 хуйлмал Идрис (алейхиссальлам)пайгамбард, 10 хуйлмал Ибрахим (алейхиссальлам)пайгамбард өгөгджээ. Энэ бүх хуйлмал нийлээд 100 юм. 4 их хөлгөн судар илгээгдэн ирсэн нь: Теврат судар Муса (алейхиссальлам) элчид, Зебүр судар Давуд (алейхиссальлам) элчид, Инжил судар Иса (алейхиссальлам) элчид, Куран-керим нь Мухаммед (салаллаху алейхи уа сальлам) элчид тус тус илгээгдэн иржээ.

Иманы 6 шаардалгын 4 дэхь нь Аллахын элчүүдэд итгэх явдал юм. Элчүүд бол Аллахын таалсан ариун замд хүмүүсийг уриалан оруулахын тулд илгээгджээ. Зан авир нэр хүнд ба царай зүсээрээ тухайн цаг үед амьдарч байсан хүмүүсээс дээд нь юм. Тэдэнд огт муу зан ба үл нийцэх авир үгүй юм. Элчүүдэд Ислет шинж чанар бий. Өөрөөр хэлбэл, тэд элч болохоосоо өмнө ба хойно ч өчүүхэн ч төдий нүгэл үл хийгсэд юм. Мөн тэд сохор, дүлий гэх мэт ямар нэгэн эд эрхтэний гажиг дутагдал үгүй юм.

Шинэ шашин авч ирсэн пайгамбарыг Расул гэж хэлдэг. Харин шинэ шашин авч ирэлгүй урьдын шашиныг сэргээн дэлгэрүүлэх үүрэгтэй элчийг Неби гэнэ. Үүрэг ба Аллахын зарлигийг биелүүлэхдээ Неби ба Расул хоёрын хооронд ялгаа үгүй юм.

Пайгамбарын үүрэг: Энэ үүрэг нь их хичээсэнээр, хөдөлмөрлөсөнөөр, өлсөж зовсоноор олж авдаг зүйл биш юм. Зөвхөн Аллах эзэн сонгон үүрэг болгосон зүйл л элчийн үүрэг билээ. Хүн төрөлхтөнийг энэ хорвоод амьдрахдаа үнэнч, шударга, цэвэрч, ариун хүний ёсоор амьдарч нүгэл бага буян их үйлдэн хойд ертөнцөд очихдоо ч аз жаргалд хүрэхийн төлөө элчүүдээр дамжуулан шашинуудаа илгээжээ. Тэд бүхий л зовлон гэтлэн шашинаа түгээдэг юм. Аллах тэдний үнэн шударгыг баталгаажуулахаар Мугжизегээр (ид шидийн гайхамшиг) хүчирхэгжүүлсэн. Элчид итгэн сүсэгтэн бологсодыг тэр элчийн үммет буюу дагалдагсад гэнэ. Тэд хойд ертөнцөд дагалдагсадынхаа нүгэл их хүмүүст нь өмгөөлөл тусламжаа өгөхийн тулд зөвшөөрөл өгөдөнө. Хорвоод илгээгдсэн элчүүдийн тоо тодорхой биш юм. 124000 хүртэл пайгамбар ирсэн гэгддэг. Харин Куран керимд зөвхөн 28 элчийн нэр дурдагдсан байдаг.

Энэ бүх элчүүдийн хамгийн сүүлчийн бас хамгийн дээд нь Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) юм. Түүнийг Хабибуллах гэж нэрийддэгийн утга нь Аллахын хайрт элч гэсэн үг юм. Тэрээр хойд ертөнцөд бүхнээс урьтаж булшнаасаа амилан босох хүн юм. Диваажинд бас хамгийн түрүүнд орох хүн юм.

Хойд ертөнцөд хамаг элчүүд түүний туг далбааны доор цугларцгаах болно. Аллах эзэн бүх элчүүддээ хэрвээ та нарыг амьд ахуйд Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) ирэх юм бол түүнийг дагцгаа, түүнд итгэцгээ гэж зарлиглажээ. Учир нь Мухаммед элч Хатемү-л Энбия юм. Өөрөөр хэлбэл, түүнээс хойш нэг ч элч ирэхгүй.

Иманы 6 шаардалгын 5 дахь нь хойд ертөнцийн амьдралд итгэх.

Киямет (хойд ертөнцийн эхлэл) бол хүн нас барсанаас эхлэнэ. Хойд ертөнцийн эхлэх үе ба хэзээ болох нь мэдэгддэггүй байна. Гэхдээ пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) хойд ертөнцийн өдрийн ирэх цагийн шинж тэмдэгийг цөмийг нь хэлжээ.

Ив ил нүгэл хийсэн мусульмануудыг фасик (алдсан

мусульман) гэнэ. Фасикууд ба бүх кафируудад (буруу номтон) булшинд гэсгээл буй. Булшинд Мункир ба Накир гэгч хоёр сахиусан тэнгэр гэсгээл өгөх юм. Тэд мөн булшны асуулт асуухыг нь хадис-и шерифт (сургаал үг) тодоор илтгэсэн байна. Булшны асуулт бол: “Эзэн чинь хэн бэ?, Шашин чинь юу вэ?, Хэний дагалдагсад бэ?, Ном чинь аль вэ?” гэх мэт асуултууд юм. Энэ асуултанд бүдрэлгүй хариулагчид булшны цээрлэл үгүй. Харин асуултанд хариулж чадаагүй хүмүүст булш нь тамын тогоо мэт болж, залхаан цээрлүүлэх ажил эхлэх юм.

Үхсэнээс хойш ахин амилахад ч итгэх хэрэгтэй. Хүний цогцосыг яг хэвэнд нь оруулж амилуулаад сүнсийг нь буцаан өгөх болно. Цөм булшнаасаа өндийн босож эхлэх тэр цагийг Киямет гэх ба дахин амилах өдөр юм.

Бүхий л амьд амьтад Махшар гэх том талбарт цуглацааж хүн бүрийн амьд ахуйдаа хийсэн үйлийн дэвтэр нь өөр өөрт нь олгогдох болно. Энэ бүхэнийг хорвоо ертөнцийг туурвигч эгнэшгүй хүчит Аллах хийх болно.

Сайн үйлсийн эзэдийн үйл үйлсийн дэвтэр нь баруун ба өмнө талаас нь, харин муу муухай нүгэл хийгсэдийн дэвтэр нь зүүн ба ар талаас нь өгөгдөнө. Энэ дэвтэрт амьд ахуйдаа үйлдсэн өчүүхэн төдий хийсэн бүхий л зүйл цаг хугацаагаараа бичигдсэн байдаг билээ. Хүн энэ дэвтэрээрээ шүүлтэнд орох юм. Аллах мелекүүдээс “Тэнгэр газарт ямар үйл хийцгээсэн бэ?”, элчүүдээс “Аллах эзэний зарлигыг (шашин) хэрхэн түгээн дэлгэрүүлсэн бэ?”, хүн бүрээс “Пайгамбардаа хэрхэн итгэж, өгсөн үүрэг даалгаварыг хэрхэн биелүүлж, хоорондын өр авлагаа хэрхэн цэгнэсэн бэ?” хэмээн асуух болно. Махшарын талбайд шүүлтэнд ороод бас сайн санаат бас буян их хураахсадад аврал ба энэрэл бий. Харин муу санаатанууд ба нүгэлт хүмүүст гэсгээл цээрлэл хүртээх юм.

Аллах эзэн шударга болохоор зарим нүгэлтнүүдийг цээрлүүлнэ. Харин зарим энэрэл хүртэх ёстой хүмүүсийн нүгэлийг өршөөн уучлах юм. Буруу номтонууд, өөрөөр хэлбэл, Мухаммед элчид үл итгэгсэдийг мөнхийн тамд хаяж залхаан цээрлүүлэх болно.

Энэ өдөр хүний хийсэн сайн муу үйлүүдийг дэнслэх юм. Нүгэл буян дэнслэгдсэний дараагаар Сират гэх гүүрээр гарах юм. Энэ гүүр бол Аллахын зарлигаар там дээгүүр татагдсан гүүр юм. Хүн бүр энэ гүүрээр гарах нь зарлиг юм. Энэ аймшигт өдөр

элчүүд “Аяа, авралт эзэн минь! Энх амгаланг өгөөч!” хэмээн уйлан чичрэх болно. Диваажинд орох хувьтай хүмүүс гүүрээр амархан өнгөрнө. Зарим нь аянга цахилгаан мэт, зарим нь салхи мэт, зарим нь давхиж буй морь мэт хурдаар гүүрийг туулах болно. Сират гүүр бол хялгаснаас нарийнхан сэлэмнээс хурц гүүр юм. Харин тамд унах хувьтай хүмүүс гүүрээр гарч чадалгүй тамд унах болно.

Элчид өөрт нь ноогдсон Кевсэр булаг бий. Энэ булгийн өргөн нь нэг сарын зам юм. Булгийн ус нь сүүнээс ч цагаан, анхилуун үнэртэй юм. Энэ уснаас уухад огт ангаж цангахын зовлон амсахгүй билээ.

Шафагат (өмгөөлөл) нь үнэн юм. Нүгэлтэй мусульманууд нүгэлээ уучлуулахдаа өмгөөлүүлэхээр элчүүд гэгээнтнүүд, эрдэмтэнүүд, шахидүүдээс (Исламын төлөө амиа өргөгсөд) тусламж гуйна. Аллах эзэний зөвшөөрсөн хүмүүст л өмгөөлөл үзүүлэх болно.

Диваажин ба там одоо ч байгаа. 8 диваажин, 7 там байдаг. Диваажин бүх нарнаас том, там ч мөн адил нарнаас ч том.

Иманы 6 шаардалгын 6 дахь нь хувь заяандаа итгэх явдал юм. Хүний амьдралд тохиолдох сайн сайхан, муу муухай, баярт, гунигт, ашигтай, ашиггүй бүх зүйлс Аллахын тааллаар болох юм. Энэ хорвоо дахь болж өнгөрсөн хийгээд хойшид болох бүхий л зүйлсийг, бүхий л юмс үзэгдлийг Аллах эзэн урьд өмнө мэдэж байсан төдийгүй энэ мэдлэгээрээ бүхнийг туурвижээ. Хүний сайн, муухай бүхий л үйлсийг хэн нь мусульман болохыг, хэн нь кафир болохыг мэддэг байсан болохоор ийн тууригжээ. Бүх юмыг бүтээгч зөвхөн Аллах юм. Учир шалтгааныг нь бүтээсэн нь ч тэр юм. Бүх зүйл ямар нэг учир шалтгаантай. Жишээ нь, гал шатаадаг. Үнэндээ шатаагч нь Аллах юм. Харин гал түлш шатахтай огт холбоогүй юм. Зөвхөн шалтгаан нь болгожээ. Харин шатаах шалтаг болгосон нь Аллах эзэн билээ. Аллах хэрэв хүсвэл галгүйгээр ч шатааж түлж чадна. Гэвч галаар түлэх нь нэг ёсны дүрэм мэт болжээ. Ибрахим пайгамбарыг гал шатаагаагүй билээ. Гал түүнд хайртай байсан болохоор дүрэмээ эвдэн шатаагаагүй юм.

Аллах хэрвээ хүссэн бол бүх зүйлийг учир шалтгаангүйгээр туурвиж чадах байсан. Идүүлэхгүйгээр цатгаж, галгүйгээр шатааж болох байсан. Гэвч боолууддаа сайн сайханыг хүсэн бүхнийг учир шалтгаантай хамт туурвижээ.

Хэрвээ Аллах шалтгаангүйгээр бүхнийг туурвисан бол хэн ч хэнд хамаарагдахгүй, харъялагдахгүй байх байсан. Бүх хүн бүхнийг Аллах эзэнээс гуйж авч болох байлаа. Ийм болчихвол хүн төрөлхтөн дунд эзэн, ажилчин, багш, сурагч, мөн бусад мэргэжил болон өөрийгөө хөгжүүлэх ухаан үл дэлгэрэх байлаа.

Ислам шашин мусульмануудаас пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) хэрхэн итгэж сүсэглэсэний адилаар итгэхийг хүсдэг. Элч зөвхөн итгэлийн утгийг л ойлгуулж номложээ. Асхабууд цөм тэрэн шиг Аллахт эргэлт буцалтгүй итгэцгээжээ. Элч нас барсаны дараагаар ч хүмүүс исламыг түүний асхабууд, дагалдагсадаас асууж, сурч мэдэх боломжтой юм. Тэд бүгд нэг адил итгэлийг заасан юм.

Мөргөл залбирал

Нэг: Болзол ба ёс жаягийг нь бүрэн гүйцэлдүүлэн нэг өдөрт цаг тухайд нь 5 удаа намаз (мөргөл) үйлдэх явдал юм. Намазуудыгаа фарз (зарлиг), важиб, сүннет (Мухаммед элчийн хийсэн үйл) гэх мэт хамаарлаар нь маш анхааран, сэтгэл зүрхээ Аллахдаа төвлөрүүлэн үйлдэх ёстой. Куран сударт намазыг “Салат” гэж нэрлэдэг. Салат гэдэг нь боолуудын залбирал, мелекүүдийн уучлал гуйлт, Аллахын энэрэл гэсэн утгатай үг юм. Намаз наминчлалаар эхлэдэг юм. Өөрөөр хэлбэл “Аллаху Акбар” гэж хэлэн гараа чихэн тус өргөөд хүйсэн доороо гараа барихаас эхлээд сүүлчийн суултад хоёр мөр лүүгээ харан мэндлэсэнээр мөргөл дуусдаг.

Хоёр: Мал эд хөрөнгийнхөө зекетийг өгөх. Энэ өргөлийн гол утга нь цэвэрлэгээ, ариусгал юм. Ислам шашинд зекет нь эд хөрөнгө нь тодорхой нэгэн тоо толгойг олсон тохиолдолд тэр хөрөнгөнөөсөө тодорхой хувийг Куран сударт заан тусгасан хүмүүст эргэлт буцалтгүй буян болгон өгөх явдал юм. Зекет 8 төрөлийн хүнд өгнө. Зекетийг дөрвөн төрлийн эд хөрөнгөөс өгнө. Алт, мөнгө, ба наймаа хонжооны, малны өргөл барьц, газраас гарах ургамлын зекет.

Гурав: Рамазан (сар) ирэхэд нэг сар мацаг барих явдал. Исламд болзол шаардалгыг хангаж, Рамазан (мацаг барих сар) сард өдөр бүр 3 зүйлээс зайлсхийх хэрэгтэй. Энэ гурван зүйл нь: идэж уух ба бэлгийн харьцаанд орохгүй байх. Энэ сар тухайн сарын анхны сар гарсанаар эхэлдэг. Цаг тооны бичигээр эхлэх

нь зүй бус юм.

Дөрөв: Боломжтой шаардалга хангасан хүн амьдралдаа нэг удаа хаж явах явдал. Зам нь аюулгүй бас эрүүл мэнд нь сайтай хүн Мекке-и Мүкерреме хотод очоод ирэх хүртэл ард үлдсэн гэр бүл нь амьдралын бололцоог хангах эд хөрөнгөтөй хүн өөрийн хөрөнгөөр Мекке хотод байгаа Каабд очин мөргөл үйлдэх ёсыг Хаж гэнэ. Хажын шаардалга нь ариун Каабыг таваф (эргэн мөргөх), Арафат ууланд зогсох үйлээс бүтдэг юм.

Тав: Аллах эзэний шашиныг түгээн дэлгэрүүлэхийн төлөө тэмцэх, хөдөлмөрлөх, бэлдэх нь бас нэгэн мөргөл залбирал юм.

Мүнекахат: Гэр бүл болох, салах, амьжиргааны хэрэгсэл гэх мэт бүлэгтэй юм.

Муамелат: Арилжаа, наймаа, хөлс түрээс, өр зээл, хүү, гэрээслэл гэх мэт бүлэгтэй юм.

Укубат: Ял өгөх ёсон. Энэ нь 5 бүлэгтэй. Кисас (цаазаар авах), сиркат (хулгай дээрэмийн ял), зина (завхай явдалын ял), казф (гүтгэлэгийн ял), риддет, өөрөөр хэлбэл муртед (шашинаас гарагсадын ял) гэх мэт.

Зан авир

Ислам шашин сайхан зан авиртай болохыг, муухай аашаа хаяж, сэтгэл зүрхээ ариусган аль ч талаараа ичгүүртэй ариун явдалтай байхыг номлодог юм. Энэ мэдлэг боловсролыг олгодог эрдэмийг Тасавуф гэдэг.

Эрүүл мэндийн мэдлэгийг анагаах ухаан заадагтай адилаар зүрх сэтгэлийн муухай араншинг арилгах эрдэмийг тасавуф эрдэм олгодог. Энэ нь сэтгэлийг ариусган Аллахын таалалд нийцэн амьдрах ухааныг олгоно.

Ислам шашинд эхлээд эрдэм сурахыг дараагаар нь энэ эрдэмээ амьдралдаа хэрэгжүүлэхийг, гэхдээ энэ бүх хөдөлмөрөө зөвхөн Аллахын таалалд нийцэхийн тулд хийхийг товчхондоо эрдэм, ажил үйл, чин үнэн сэтгэл, зүрхний үйлийг сургамжилдаг. Хүн ариусган гэгээрэх нь мөн итгэл үнэмшил нь батжин бэхжих нь нэгэн хөлөг онгоцонд тооцвол итгэл ба залбирал мөргөл нь онгоцны мотор юм. Харин энэ моторыг ажилуулагч шатахуун нь тасавуф эрдэмийг сурах ба энэ энергийн хүч юм. Зорисон газартаа хүрэхийн тулд хөлөг онгоц заавал хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, итгэл үнэмшил ба залбирал мөргөл хэрэгтэй. Хөдөлгүүрээ хөдөлгөхийн тулд тасавуф зарчмыг мөрдөх нь чухал.

Мухаммед элчид итгэн дагах , захирагдах

Мухаммед элчийг дагах нь түүнд итгэх, өөрөөр хэлбэл, түүний явсан замаар замнах явдал. Түүний зам бол Куран сударын үзүүлсэн зам юм. Энэ замыг Ислам шашин гэнэ. Энэ замд орохын тулд юун түрүүнд итгэх мусульман хүн ямар байх ёстойг маш сайн сурах шаардалгатай. Дараагаар нь зарлигуудыг гүйцэтгүүлж цээрлэлүүдээс зугтаан зайлсхийх хэрэгтэй.

Итгэн сүсэглэх нь элчийг дагаж эхлэх ба ариун үйлсийн хаалгыг татах гэсэн утгатай юм. Аллах эзэн Мухаммед элчийг (салаллаху алейхи уа сальлам) хорвоо дахь бүхий л хүмүүсийг ариун үйлсэд уриалан дуудуулахаар илгээжээ. Себе сүре (бүлэгийн) 28 дахь аетэд (өгүүлбэр) “Аяа, хайрт элч минь, чамайг хорвоо дахь бүх хүмүүсийг сайн сайханд уриалах мөн ариун замыг заахын тулд илгээлээ” хэмээжээ.

Жишээ нь, Түүнд итгэн дагасан нэг хүний өдөрт хэсэгхэн унтах нь үл итгэсэн хүн өдөржин мөргөл үйлдэхээс хэд дахин илүү дээдийн буян юм. Энэ зүйл л итгэл үнэмшил ислам шашинд ямар үнэ цэнтэй болохыг харуулж байна.

Куран Керим сударт Имран сүрегийн 31 аетэд “Аяа, хайрт элч минь, тэр хүмүүст хэл. Хэрвээ та нар Аллах эзэнийг хайрладаг бол мөн Аллах эзэн ч та нарыг хайрлахыг хүсэж байвал надад итгэн дагацгаа, Аллах намайг дагагсадыг хайрладаг” хэмээжээ. Мухаммед элчийг (салаллаху алейхи уа сальлам) итгэн дагах нь исламын хууль зан үйлийг хүлээн зөвшөөрч дуулгавартайгаар даган мөрдөх гэсэн үг юм. Мөн исламд дээдлэн хүндэлдэг бүх зүйлийг хүндэлж, эрдэмтэн мэргэдийнхээ үгийг сонсон сурч исламд орохыг хүсэгчидийг уриалан дуудаж эс итгэгчидийг цээрлэн эсэргүүцэх явдал юм.

Исламын итгэл үнэмшилд үл нийцэх зүйлийг Аллах эзэн ч мөн адил таалан хүндлэхгүй үл таалсан зүйлд ч буян хишиг ч өгөхгүй харин ч эсрэгээрээ гэсгээл хүртээх болно.

Хоёр ертөнцөд аз жаргалд хүрэх нь зөвхөн Мухаммед элчид (салаллаху алейхи уа сальлам) итгэн дагасанаар болно. Итгэн дагах нь исламаа сурч жинхэнэ утгаараа даган мөрдөх явдал юм.

Мухаммед элчид (салаллаху алейхи уа сальлам) жинхэнэ утгаараа итгэн дагах нь түүнийг чин сэтгэлээрээ хайрлан хүндлэхтэй холбоотой. Ингэхийн нэг шинж тэмдэг нь ч түүний

дайсан буруу номтонуудаас хол байх явдал.

Энэ хорвоо дээрхи бүх зүйл өнгөрөгч бас хуурагч юм. Мөнх зүйл үгүй, энэ өдөрт гарт байх зүйл маргааш хэн нэгнийх болно. Хойд ертөнц бол үнэн бас мөнхийн юм. Энэ хорвоо тоотой хэдхэн хоногийн амьдрал юм. Хэрвээ хойд ертөнцийн хамгийн нэр хүндтэй хүн болох Мухаммед элчид (салаллаху алейхи уа сальлам) итгэн дагаж амьдарваас тэр мөнхийн аз жаргалын түлхүүрийг гардан авах нь үнэн юм. Эс бөгөөс, өөрөөр хэлбэл, түүнд итгэн дагаагүй хүний бүх зүйл хоосон хуурамч. Тэр хүний хийсэн бүх сайхан үйл энэ хорвоодоо л үлдэнэ. Хойд ертөнцөд юу ч ноогдохгүй.

Түүнд итгэн сүсэглэх өчүүхэн төдий ч итгэл бүхий хорвоо ертөнц ба хойчийн амьдралаас илүү дээдийн заяа юм.

Энэ тухай Аллах эзэн Куран судард:

“Тийм болохоор Аллах эзэндээ мөн түүний хайрт элчид итгэцгээ, түүнийг дагацгаа, ингэснээр та нар зөв замыг олох болно” (Аграф сүре, 158)

“Хэн Аллах эзэндээ мөн түүний элчид үл итгэвээс, үнэндээ бид тэр кафируудад аймшигт тамын гал бэлдсэн” гэжээ.

Мухаммед элч (салаллаху алейхи уа сальлам) ийн айлджээ: “Аллахаас өөр бурхан үгүйд итгэн мөн миний айлдсан ислам шашинд үл итгэгсэдтэй дайтах нь надад тушаасан зүйл тэд итгэн дагасанаараа мусульманы эрхээ олж, өөрийн эд хөрөнгө, эрх ашигаа бас амиа аврах болно, (далд зүйлсийн) тооцоог Аллах өөрөө хийнэ”

“Надад хэн итгэн дагавал Аллахт итгэсэнтэй адил, хэн надад дайсан болвол Аллахтай дайсагнасантай адил. Хэн миний даалгасан ажилыг биелүүлвэл Аллахын даалгасан ажилыг биелүүлсэнтэй адил”

“Миний сүннети (ариун үйл) мөн надаас хойш Хулефа-и Рашидинуудын (өв залгамжлагч халифенууд) сүннети (ариун үйл) дэгдээ. Хамаг хүч сэтгэл зүрхээрээ мэрийцгээ. Шашинд сүүлд нэмэгдсэн зүйлээс зайлсхийцгээ. Учир нь (шашинд) сүүлд нэмэгдсэн зүйлүүд Бидгат юм. Битгат бүхэн төөрөгдөл билээ”

Энэс бин Маликийн уламжилсан элчийн нэгэн хадис-и шерифт: “Хэн миний мартагдсан сүннети (ариун үйл) амьдруулах бол (сүннети (ариун үйл) дэгдвэл) намайг амилуулсан мэт (намайг дээдэлж сургаалийг минь хүндэлсэн болно), намайг ийн амилуулсан хүн диваажинд надтай цуг юм”.

Пайгамбар маань (салаллаху алейхи уа сальлам) Билал Хабашид ийн айлджээ: “Хэн нэг хүн ислам шашинд сүннетиийг (элчийн хийсэн үйл) минь үйлдвэл энэнийхээ буяныг, мөн энэнийг хийгсэдийн буяныг эдлэх болно. Хэн нэгэн хүн исламын сүннетиийг муулж, хил хязгаарийг өнгөрвөл энэнийхээ нүгэл ба энэнийг хийгсэдийн бүх нүгэлийг өөрөө үүрэх болно”.

Омар бин Абдулазиз ийн айлджээ: “Аллахын элч сайхан зам нээж өгсөн түүний дараагаар халифе нар нь бас сайхан зам нээсэн. Элчийн (салаллаху алейхи уа сальлам) сүннетиийг үйлдэн дагагсад жинхэнэ утгаараа Куранд заасанчлан амьдарч байна гэсэн үг. Аллахт мөн түүний элчийг даган сүсэглэх нь Аллахын шашиныг хүчирхэгжүүлсэнтэй ижил. Ислам шашиныг хэн ч өөрчилж эвдэх эрх байхгүй. Сүннетиийг үл үйлдэгч хүний үгийг дагах нь том нүгэл юм.

Ахмед бин Ханбел гэгээнтэн айлдана:

“Нэг өдөр би хэсэг хүмүүстэй хамт байсан юм. Тэд чармай нүцэглээд усанд орж эхэллээ. Харин би “Хэн Аллах эзэнд хойд ертөнцөд итгэдэг бол (сауна, халуун ус гэх мэт газар ичгүүр газараа далдлахгүйгээр) битгий очиг” гэх сургаал үгийг даган хувцасаа тайлаагүй юм. Тэр шөнө зүүдэнд маань нэг хүн “Аяа, Ахмед! Чамд баяр хүргэе, Аллах эзэн элчийнхээ сүннетиийг үйлдсэн болохоор чамайг уучиллаа. Чамайг Имам (хамба лам) болголоо. Хүмүүс чамайг дагах болно” гэлээ. Би: “Та хэн бэ?” гэж асуухад: “Би бол Жабрайл (сахиусан тэнгэр) гэсэн юм.

Хэн нэгэн хүн хийсэн үйл болгондоо Аллахын элчийг (салаллаху алейхи уа сальлам) даган эс үйлдвээс жинхэнэ утгаараар мусульман болж чадахгүй. Түүнийг өөрийн аминаасаа ч илүү хайрлаж эс чадвал төгс итгэлтэн болж чадахгүй. Тэрээр бүхий л хүн төрөлхтөн ба бугуудын элч юм.

Бүхий л зуунд амьдарч буй бүх ард түмэн түүнд итгэн дагах нь үүрэг юм. Мусульман хүн бүр түүний шашинд туслаж түүний зан авираар заншиж, түүний ариун нэр алдарыг олон хэлж нэрийг ярихдаа эсвэл сонсохдоо хайр энэрэлээр салават (мэнд ба залбирал) хэлж түүний ариун царайг зүүдэндээ ч атугай харахыг мөрөөдөж, авч ирсэн Куран Керим сударыг бас шашиныг хайрлан мөрдөн дагах үүрэгтэй билээ.

Элчийгээ магтхуй

Энэрэлийн элч нэгэндээ: «Надаас хойш
Асхабууд минь дээдэс гэлээ.

Тэдний шинжийг үзсэн нэгэн

Элчийн дүрийг харсантай адил.

Хайр ивээлийг минь үзсэн болохоор

Хамаг сайханд минь татагдан дурлагсад

Дүрийг минь үзэхийг хүсэж гэмээнэ.

Дүүргэ зүрхээ миний хайраар.

Ингэвээс тэр тамаас аврагдан

Ивээлт эзэн минь диваажинг бэлэглэнэ.

Тиймд түүнийг нүцгэн амилуулахгүй

Тэнгэрийн ивээл энэ бус уу?!

Элчийн ариун чанаруудыг бичих

Эрхэм тэр хүмүүнийг

Замбуулингийн эзэн аюулаас хамгаална.

Зовлонгийнхон үүдийг хааж хаацайлан,

Өвчин эмгэг түүнээс ангижирч,

Үхтэл түүнийг юу ч үл зовооно.

Гэм нүгэл үйлдсэн ч өршөөгдөнө.

Гэсгээлт тамд үл орно.

Энэ хүн гэсгээлээс ангижирч,

Эргэх хорвоогийн жаргалд умбахуйд

Энэрэл, ивээлийн цондон болгож

Элчийг үзсэн буянтангуудтай учруулна»

Элчийг магтах ийм буянтай болохоор,

Эхлэхийг хүснэм би магтаалаа.

Өршөөл хайрыг эзнээсээ хүснэж

Өчүүхэн барлаг би магтаалаа эхлэе.

Бүхий л дагалдагсад нэгэн дуугаар

Элчийн дүрийг ийнхүү магтжээ:

Ариун царай нь хасын цагаан

Атрын цэцэг шиг улаа бутарсан.

Сувд адил түүний хөлс нь

Илүү чимэгтэй болгоно царайг нь.

Гэгээн элчийн хөлрөх нь хүртэл

Гэрэлтэх давалгааны долгиоо мэт.

Мэлмийгээ үргэлж сүрмэгээр гоёх нь

Мүминүүдийн зүрх сэтгэлийг татна.
 Түнэр харанхуй түүнд гэгээтэй
 Тэртээх холын газар ч ойр юм.
 Хасын цагаан царайтай элчээ
 Хайрт эзэн нь аетээр магтан дуулжээ.
 Гэрэл цацруулсан дүрэлгэр хар нүдтэй
 Гэгээн татуулсан хасын цагаан царайтай.
 Тунгалаг ухаан, холч бодол нь Мустафагийн
 Түнэр харанхуйг гийгүүлэх гэрэл мэт.
 Хаа нэгтэй рүү харахыг хүсэхдээ
 Хамаг биеээрээ эргэдэг байлаа.
 Бие махбодоо тэргүүндээ захируулахыг
 Бүхий л үед захидаг байлаа.
 Хамгаас сайхан, хайр татам биетэй расул
 Хорвоогийн эзэний хайрт нь болсон расул!
 Малик ба Эбү Хал нарын хэлсэнчлэн
 Хавирган сар мэт хөмсөгтөй байв.
 Хоёр хөмсөгнийхөн дундах зай нь
 Мөнгөн товруу мэт тодрон байв.
 Ариун царай нь бөөрхийдүү агаад
 Арьс нь толигор гэгээ татуулжээ.
 Хар хөмсөг нь михраб мэт ч
 Хорвоо ертөнцийн Кибле байлаа
 Харин түүний хамрынх нь гануу
 Ялгүй товгор агаад өөрт нь зохижээ.
 Үгээр дүрслэн, үсгээр бичимгүй
 Үнэнхүү түүнд зохисон хамартай.
 Гантиг цагаан шүднүүд нь
 Сувдан хэлхээ мэт үзэсгэлэнтэй.
 Гадагшилан цацрах туяа мэт
 Гялалзан харагдах нь гайхамшигтай.
 Хорвоогийн элч инээмсэглэхэд
 Хоёр ертөнцийг уяраах мэт.
 Үүдэн шүд нь энэ үед
 Үзэгдэх нь энэрлийн цондон юм.
 Ибн Аббасын өгүүлсэнээр элч маань
 Инээхдээ звөхөн мишээдэг байлаа.
 Тачигнатал инээж ер харагдаагүй
 Тийм л соёлтой шашины тэргүүн.

Уяхан бас эелдэг нь Аллахын элчийн
 Үргэлжийн нэгэн дүр төрх юм.
Царай нь бүтэн сар лугаа адил
Тодоос тод бурханы элч болохыг гэрчилнэм.
 Гэрэл туяа цацруулсан элчийн ариун царайг
 Нүд гялбам харахад хэцүү.
Замбуулингийн элчид өөрийн эрхгүй татагдсан
Зуун мянган Сахаба байв
 Ганцхан удаа түүнийг зүүдэндээ харагсад
 Гагцхүү энэнээс илүү жаргал үгүй гэцгээв.
Ойроос таних түүний андууд нь
Илүү махгүй дундийн биетэй хүн гэцгээв.
 Цагаан царайтай, өргөн духтай тууригдсан нь
 Цаглашгүй мөнхийн эзэн түүнд хайртайгийнх
Үргэлж түүний хүзүүнээс цацрах туяа
Үснийхэн дундаас тодрох нь гайхамаар.
 Ариухан сахалнаас нь
 Арван долоо нь үс бууралтжээ.
Богинохон бас долгиотой үстэй
Бүхий л бие нь тэгш сайхан билээ.
 Цээж нь ариун болсон элч маань
 Цагаан царайтай, тунгалаг нүдтэй юм
Асхабууд нь түүний талаар
Гүзээгүй тэгш цээжтэй хэмээсэн юм
 Элчийн ярих нь ухаарал хайрласан
 Эрдмийн булаг болон ундарна.
Өргөн цээжтэй байсан нь
Өнгөт хорвоогийн эрдэмийг түүнд ивээжээ
 Тунгалаг цагаахан болохоор
 Түүнийг гэрэлт сартай зүйрлэнэ.
Зүрхнээс нь ундрах хайрын дөл
Зүг бүрийг гэрэлтүүлэн байдаг.
 Ертөнцийн элчийн бүхий л сайханыг
 Ерөөс бид магтаад барамгүй.
Буян заяа эд хөрөнгөтэй
Аллахын элч маань өглөгч нэгэн билээ.
 Мөнгөн бөгжийн товруу нь дээр
 Мухаммед элч тамгатай байв.
Ар нуруун дахь элчийн тэмдэг нь

Арай баруунтайд нь байрлажээ
Энэ тэмдэгийг харагсад тайлбарлахдаа
Элч болохыг гэрчилсэн мэнгэ гэв.
Шаравтар өнгөтэй энэ мэнгэ нь
Тагтааны үүр мэт том юм.
Дээдийн заяат элчийг тайлбарлагсад
Дал мөр нь уужим гэв.
Том чөмөг ястай
Тулаанч хүнд заяам бие цогцостой.
Бие эрхтэн бүхэн нь
Өөрт нь зохицсон чимэгтэй.
Бүхий л зүйлсийг түүнд
Өршөөлт эзэн нь харамгүй хайрлажээ
Элчид заяагдсан гар хөл нь
Энгүй нэгэн бадмаараг гэлтэй
Шинхэн ургасан цэцэгийн дэлбээтэй
Зүйрлэх нь үнэнхүү тохирох болов уу?!

Ариухан мутар нь дэнсний
Алдааг ч шударга шүүдэг билээ.
Хэн нэгэнтэй мэндлэхдээ
Хэзээний инээмсэглэх нь түүний зан
Ганц хоёр хоног өнгөрсөн ч
Тэр бүү хэл сарын дараагаар ч
Гэгээн элчийн анхилуун үнэр
Тэрхэн хавиасаа үнэртсээр байдаг.
Ийм л ариухан нэгэн болохоор
Илүү юугаар магтвал зохилтой вэ?
Найзыгаа харахдаа гэгээн элч маань
Нүдээ бус бүх бие сэтгэлээ нээдэг.
Байгаа бүх зүйлээрээ
Бүрэн төгс зохицсон элчид
Ангир цээж гэдсэнд нь
Үс хялгас үгүй билээ.
Гэвч түүний цээжнээс доош
Ганцхан эгнээ мэт үс ургажээ.
Сарны хүрээ мэт энэ үс нь
Сайхан түүнд гайхалтай зохижээ.
Идэр насныхан бие цогцос
Энэ л хэвээрээ өтөлсөн ч өөрчдлөгдсөнгүй

Он жилүүд өнгөрөх тусам
Өнөөх л залуу хэвээрээ мэт.
Тив ертөнцийн ноён элчийг
Тарган нэгэн гэж бүү бод
Туранхай ч биш, тарган ч биш
Тийм л дундаж биетэй ч хүчирхэг
Илүү махгүй болохоор элч маань
Ийм л байхыг дагалдагсаддаа захижээ.
Итидал буюу бүрэн зохицсон болохоор
Итгэлт олондоо гайхагдан магтагджээ
Дундаж өндөртэй байсан тэр элч
Дайсанууддаа сүржин харагддаг байв.
Энэ гайхамшигийг үзсэн зон олон
Эгнэшгүй хүчит Аллахт сүсэглэнэ.
Бие мах бодь, нүүр царай, ур ухаан
Бүхий л зүйлс нь сайханаар чимэгдсэн
Бас сайхан сэтгэлтэй ийм хүнийг
Бид огтоос үзээгүй хэмээн шагшицгаана.
Дундын өндөртэй хэрнээ элч маань
Түүнээс ч нуруулаг хүмүүсийн хажууд
Дандаа өндөр харагдах нь
Тэнгэр эзэний хишиг юм.
Өөрөөсөө нуруулаг хүмүүсээс
Төө өндөр харагддаг шигээ
Холын замд гарахдаа
Хажуудхаасаа хурдан явдаг увидастай.
Үл ялиг бөхийж явах нь
Үнэнхүү түүний нэг шинж юм.

ГАРЧИГ

ЭЛЧИЙН АРИУН ТУЯА

Ариун туяа нь туурвигдахуй	6
Магнай дахь туяа ариун удам угсаагаар	7
дамжин ирэх нь	7
Хазрети (гэгээн) Абдулмутталиб өвөө	9
Абдуллахаар тахил өргүүлэхийг хүссэн нь	12
Гэгээн Абдуллах эцэг	14
Мухаммедийн туяа эхэд нь өгөгдсөн нь	16
Фил (заан) түүх	16
Баярт мэдээнүүд	18
Харанхуй бүдүүлэг цаг үе	19

ХОРВООД МОРИЛСОН НЬ (Мэндлэх нь)

Мэндлэх үед болсон гайхамшигууд	24
Мевлид өдөр буюу пайгамбарын төрсөн өдөр	26
Сүүн эхэд нь өгөгдхүй	26
Ариун цээж нь задрахуй	30
Гэгээн эхээсээ хагацсан нь	32
Өвөөгийн өвөрт	32
Нежраны пастр (хамба лам)	33
Өвөөгийнх нь үхэл	34
Эбу Талибын асрамжинд	35
Бахире пастр	35

ЗАЛУУ НАС БА ХУРИМАА ХИЙСЭН НЬ

Арилжаа наймаа хийж эхэлсэн нь	39
Гэгээн Хадижетэй гэрлэсэн нь	43
Зейд бин Харисе	45
Ариун Кааб сүмд шүүгч	47

БИЕСЕТ (ЭЛЧИЙН ҮҮРЭГ) БА УРИЛГА

Анхы уахи (Аллахаас ирсэн мэдээ)	50
Шашин түгээх ариун үүрэг авсан нь	52
Анхны мусульманууд	53
Хамаатан саднаа исламд уриалах нь	57
Нарыг баруун гарт минь атгуулсан ч...	61
Шударга бусаар дарлан зовоосон нь	63

Сахбы кирамуудыг (анхдагч мусульманууд)	
дарлан зовоосон нь	71
Ухаанаа алдтал тамласан нь...	75
Дар-ул Эркам (Эркамын гэр)	76
Анхны шахид (Итгэл үнэмшлийнхээ төлөө амиа өгөгсөд)	78
Эбү Зерри Гифаригийн мусульман болсон нь	79
Анх удаа ариун Каабд Куран судар уншигдсан нь	82
Түфэйл бин Амирийн мусульман болсон нь	83
Яармаг худалдаанд ирэгсэдийг исламд уриалах нь	86
Мүшрикүүдийн Куран судрыг сонссон нь	89
Халид бин Сайдын итгэл үнэмшил	93
Мусаб бин Үмейр (радиаллаху анх) мусульман болсон нь	95
ХАБЕШТАН (ЭТӨП) РУУ НҮҮСЭН НЬ	
Гэгээн Хамзаа мусульман болсон нь	97
Гэгээн Омар мусульман болсон нь	99
Хабештан (Этөп) руу хоёр дахь удаагаа нүүсэн нь	105
Уй гашуудалт жилүүд	107
Бэхлэлт	107
Сар хоёр хуваагдсан нь	111
Эзэн маань та нарыг ч зөв замд оруулаг!..	113
Гашуудалт жилүүд	114
Гэгээн Хадиже эхийн үхэл	116
Гар нь хөдөлгөөнгүй болсон нь	117
Тайф тосгоныг исламд уриалсан нь	118
“Лаа илааха иллаллах” гэж хэлээд аврагдацгаа...	120
МИГРАЖ	
ХИЖРЭТ	
Анхны Акабе гэрээ хэлэлцээр ба Мединед	
мандсан нар	135
Хоёр дахь Акабе (гэрээ)	136
Хижрет (их нүүдэл)	138
Сурака бин Малик	142
Баярт мэдээ! Баярт мэдээ! Хорвоогийн	
энэрэлийн элч ирж асуй!..	143
МЕДИНЕ МҮНЕВБЕРЕ ҮЕ	
Ансар ба мухажир ахан дүүсийн барилдлага	146

Месжид-и Неби (Элчийн сүм)	148
Хурма мод уйлсан нь	149
Гэгээн Айшетэй гэрлэсэн нь	149
Анхны азан (Намазын дуудлага)	150
Асхабуудыг сургаж эхэлсэн нь	151
Асхаб-и суффе	152
Жиблийн түүх	153
Селман-и Фарисийн мусульман болсон нь	155
Сахиусан тэнгэрүүд түүнийг сонсохоор ирдэг байлаа	158
Медине дахь анхны жилд болсон зарим үйл явдалууд	160
Аяа, хайрт элч минь, битгий гунихар!..	161
Анхны цэргийн нэгдэл	163
Месжид-и Киблетейн (Хоёр зүгт месжид)	164
БЕДИР ГАЗИ (дайн)	
Сахиусан тэнгэрүүдийн туслахаар ирсэн нь	168
Эбү Жахилын үхэл	174
Ялалт	175
Гэгээн Али ба Гэгээн Фатима хоёрын хурим	178
Кааб бин Эшрефын үхэл	182
Бени Кайнукагийн жүүдүүд	184
УХУД ДАЙН	
Гэгээн Алигийн баатарлаг явдал	194
Талха бин Убейдуллахын эр зориг	197
Хамра-үл Эсэд рүү явсан нь	204
Режигийн явдал	205
Бир-и Мауне түүх	209
Бени Надирын Жүүдүүд	210
Фатима бинти Эсэдийн үхэл	211
Бени Мусталик дайн	212
ХЕНДЕК ДАЙН	
Бени Курейза жүүдүүд	226
Саад бин Муаз шахид болсон нь	229
ХУДЕЙБИЕ ЭНХ ТАЙВАНЫ ГЭРЭЭ	
Ридвани Биат (тангараг)	235
Намайг авраач, Аллахын элч минь!..	237
УРИАЛСАН ЗАХИА	
Хаадуудад илгээсэн захиа	241

ХАЙБЕР ХОТЫГ ЭЗЭЛЭХ НЬ	
Гэгээн Алигийн баатарлаг явдал	253
УМРЕТ-ҮЛ КАЗА АЯН	
МУТЕ ДАЙН	
МЕККЕ ХОТЫГ ЭЗЭЛСЭН НЬ	
Хэн Месжид-и Харамд хорогдвол...	268
Шударга үнэн дийлж, худал хуурмаг сарнин одов	272
ХҮНЕЙН ДАЙН	
ТАЙФ РУУ ОЧИСОН НЬ	
ТЕБУК РУУ ОЧСОН НЬ	
Занга	281
Дирар Месжид	282
ХАГАЦАХ ХАЖ	
ХАГАЦАЛЫН ИЛТГЭЛ	
ХОРВООГООС ХАЛЬСАН НЬ	
Шашинаасаа гарах үзэгдэл	297
Булшиндаа амьд байх нь	298
Аллахын элчийг харах нь	299
Зиярат (Энэрэлт элчийн булшинд очиж үзэх)	301
Тауассул	304
(Пайгамбарыг маань хооронд тавьж Аллахт залбирах)	304
Салават-и шериф (Мухаммед элчид мэнд ба залбирал хэлэх) уншихын ач холбогдол, ашиг	307
ХИЛИЕ-И САГДЕТ	
Ариун нэр алдарууд нь	311
Хилие-и сагдет	312
Элчийн сайхан зүс царай	316
Дээдийн зан авир	318
Буян үйлсүүд нь	324
Пайгамбарын маань дагалсадынхаа төлөө хийсэн истигфар (намичлал)	329
Шафагат (өмгөөлөл)	330
МУГЖИЗЕНҮҮД (ГАЙХАМШИГУУД НЬ)	
ЭХЛИ БЕЙТ (ЭЛЧИЙН ГЭР БҮЛ)	
Гэгээн эхнэрүүд нь	340
Хүүхдүүд нь	343
Эхли бейт	345

Аллахын элчийн асхабууд (Анхны мусульманууд)	347
АЛЛАХЫН ЭЛЧИЙН ЗАРИМ ЗЕВАЙД СҮННЕТҮҮД	
Ариун сахал ба үс нь	349
Элчийн хэвтэх ба унтах нь	351
Элчийн суух ёсон	352
Элчийн идэх ба уух нь	352
Элчийн гэртээ ба гадаа байх байдал	358
Аллахын элчийн өмсдөг хувцас	361
Кааб бин Зүхейрт бэлэглэсэн дээл	363
Нежаши хааны бэлэглэсэн алтан бөгж	364
Элчийн ор	366
Элчийн таяг	367
Элчийн үргэлж өөртөө авч явдаг байсан долоон зүйл	367
Тэрээр эмх цэгцийг маш их эрхэмлэдэг байсан	368
Элчийн нум сум ба бамбай	370
Элчийн туг далбаанууд	371
Элчийн хүлгүүд	371
Элчийн тэмээнүүд	372
Элчийн өлзийтэй гэрүүд	373
Элчийн сан хөмрөгт хийсэн эд хөрөнгө	374
ИСЛАМ ШАШИН	
Иман (итгэл үнэмшил)	375
Мөргөл залбирал	382
Зан авир	383
Мухаммед элчид итгэн дагах , захирагдах	384

ХЯНАЛТ

- 571 Гэгээн Мухаммед (а.с) хорвоод мэндэлсэн нь (Рабби үл-эввэл сарын 12-ны өдөр, 571 оны 4-р сарын 20) Сүүн эх Халимед өгөгдсөн нь
- 574 Сүүн эх нь Мекке хот төрсөн ээж Аминед авч ирж даатган өгсөн нь
- 575 Эх нь нас нөгчив
Өвөө нь үрчилж авав
- 577 Абдулмутталиб өвөө нь нас барж, авга ах Эбү Талибын асрамжинд шилжив
- 578 Авга ах Эбү Талибын хамтаар Сири улсруу аялсан нь
- 583 Авга ах Эбү Талибын хамтаар Сири улсруу аялсан ба Бусра хотод Бахира пастр түүнийг сүүлчийн элч болохыг нь мэдсэн нь
- 588 Авга ах Зүбейрийн хамт Емийн хотруу аялсан нь
- 595 Гэгээн Хадижегийн жингийн цувааг толгойлон Шам хотруу аялсан нь
- 596 Гэгээн Хадижетэй гэр бүл болсон нь
- 606 Ариун Кабег сэргээн засварлахад Хажер-үл Эсвадыг байрлуулсан нь
- 610 Хира агуйд анхны лүндэн буусан нь
- 613 Гурван жил нууцаар шашинаа номлосоны дараагаар анх Сафа толгодод гарч ил тодоор Исламд уриалж эхэлсэн нь
- 615 Мусульманууд Хабешстанруу нүүсэн нь
- 616 Гэгээн Хамза мусульман болсон Гэгээн Омар мусульман болсон нь
- 619 Гэгээн Хадиже ба Эбү Талиб нарын үхэл
- 620 Мираж-д гарсан нь
- 621 Хоёр дахь Акабе хэлэлцээр
- 622 Меккегээс Мединерүү нүүсэн нь

- 623 Бедир дайн Кибле Месжид-и Аксагаас Кабе-и Муаззамаруу
солигдсон нь
Месжидын урд ядуусыг орогнуулах “Суффа нэртэй байр
бариулсан нь
Гэгээн Айшетэй гэр бүл болосн нь
- 624 Охин нь болох гэгээн Рүкия нас нөгчив.
Гэгээн Фатиматай Гэгээн Али гэр бүл болсон нь
- 625 Ухуд дайн
Гэгээн Хамза шахид болов
Гэгээн Хасан мэндлэв (Рамазан сард)
Гэгээн Хусейн мэндлэв (Шагбан сард)
Гэгээн Омарын охин гэгээн Хафсатай хуримлав
- 627 Хэндэк дайн
- 628 Худейбие гэрээ хэлэлцээр
Хаад ба Амбан захирагчидад Исламд уриалсан захиа
илгээсэн нь
Хайбер хотыг эзэлсэн нь
- 629 Муте дайн ба ялалт
- 630 Меккег эзэлсэн нь
Охин болох гэгээн Зейнеб нас нөгчив
Хүү гэгээн Ибрахим нь мэндлэв
Гэгээн Ибрахим хүүгийнх үхэл
Тебүк дайн
- 632 Хагацалын сургааль буюу илтгэлээ зуун мянгаас хол
давсан Асхаб-и Кирам (дагалдагсад)-ууддаа айлдсан нь
Женнет- үл Баки шарилын газрыг эргэн очсон нь
Хорвоогоос хальсан нь (Зурдугаар сарын 8-нд Мягмар гараг)

ЭХ АВСАН НОМЫН ЖАГСААЛТ

- Куран-и Керим (судар)
- Тефсир-и Мазхари – Сенауллах-и Панипутти
- Тефсир-и Куртуби – Имам Куртуби
- Тефсир-и Бейдави – Кади Бейдави
- Тефсир-и Кебир – Фахруддын-и Рази
- Тефсир-и Хазин – Алауддин-и Багдади
- Руху-л Баян- Исмайл Хакки Буфевн
- Сахих-и Бухари - Имам-и Бухари
- Сахих-и Мүслим – Имам Мүслим
- Сүннен-и Тирмизи – Имам-и Тирмизи
- Муватта – Имам Малик
- Мүснад – Имам Ахмед бин Ханбел
- Эл- Мүжемү-с сагир- Имам Теберани
- Эл-Мүсаннеф- Имам ибни Эби Шейбе
- Эл Мүсаннеф- Имам Абдурреззек
- Эс Сиретүн Небиевие- Ибн-и Хишам
- Сиретүн Неби- Ахмед бин Зейни Дахлан
- Эс-Сиерүл-Кебир-Имам Мухаммед
- Шерхус- Сиери-л Кебир- Имам Шерахси
- Шифа-и Шериф -Кади Лиад
- Шемайл-и Шериф -Имам Тирмизи
- Делайлүн – Нүбүвве – Эбү Нуайм Исфакхани
- Шевахидүн – Нүбүвве – Мевлана Абдурахман Жами
- Меарижүн – Нүбүвве – орчуулга- Астипармак Мухаммед Эфенди
- Кисас-и Энбия – Ахмед Жевзар Паша
- Мират-и Кайнат- Нишанжизаде Мухаммед Эфенди
- Мевлид-и Шериф (Весилетүн-нежат)-Сүлеймен Челеби
- Исбатүн – Нүбүввие – Имам-и Раббани
- Мектубат-и Масумие – Мухаммед Масум Фаруки
- Итикаднамие – Мевлана Халид-и Багдади
- Жалиетүл – экдар – Мевлана Халид-и Багдади
- Ихяу улумуддин – Имам-и Газали
- Эт – Табакатүл – Күбра – Абдулвеххаб-и Шарани
- Тарихул – Ислам – Имам Зехеби

**Хоёр ертөнцийн гэгээ болсон
МУХАММЕД -ЫН (Алейхиссалам)
АМЬДРАЛЫН
ЗАМНАЛ**

Хэвлэлийн хуудас: 25 х/х
Хэвлэсэн тоо: 5000 ш
Цаасны хэмжээ: А5

“КИТАБ” ХХК-д хэвлэв.
Улаанбаатар 2021 он

